

**БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИ**

**ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ,  
ХАРХОРИН ХОТЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨВ,  
АРХИТЕКТУР, ХОТ ТӨЛӨВЛӨЛТ**

Улаанбаатар хот 2012 он

## ГАРЧИГ

<b>РЕФЕРАТ</b> .....	<b>7</b>
<b>ОРШИЛ</b> .....	<b>9</b>
Тайлангийн үндсэн агууллага.....	15
<b>ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХАРХОРИНЫ ИРЭЭДҮЙН ТӨЛӨВ АРХИТЕКТУР, ХОТ ТӨЛӨВЛӨЛТ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ</b> .....	<b>18</b>
<b>НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДАХ ҮНДСЭН АСУУДЛУУД, ГАРАХ ҮР ДҮН</b> .....	<b>18</b>
Хоёр. Судалгааны онол, арга зүйн үндэс.....	20
Гурав. Хот суурины төлөвлөлт, архитектурын талаар судлагдсан байдал....	45
Дөрөв. Хангайн бүсийн хот, суурины үүрэг, зэрэглэл, хөгжлийн судлах судалгааны аргачлал.....	51
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ</b> .....	<b>57</b>
<b>НЭГ. ХОТ СУУРИНЫ БҮТЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ, АСУУДАЛ</b> .....	<b>57</b>
I.1.1 Монгол Улсын эдийн засгийн бүс нутгийн бодлого, тогтвортой хөгжлийн асуудал.....	57
I.1.2 Хот суурин, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн асуудлууд.....	62
I.1.3 Монгол Улсын хүн ам зүйн асуудал.....	71
I.1.4 Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, зарим үр дүн.....	80
I.1.5 Бүс нутаг, аймаг хотуудад бизнесийн орчинг сайжруулах арга зам.....	94
I.1.6 Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох арга зам.....	95
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БҮСҮҮДИЙН ХҮРЭЭН ДЭХЬ ХАНГАЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИН ХЭТИЙН ТӨЛӨВ</b> .....	<b>101</b>
I.2.1 Хангайн бүсийн хөгжлийн түвшин, хэтийн төлөв.....	101
I.2.2 Хангайн бүсийн шинэ хотын бүтээн байгуулалттай	



уялдуулан хөгжүүлэх стратеги.....	114
I.2.3 Хангайн бүсийн засаг захиргаа-нутаг дэвсгэрийн зохион байгуулалт бүтэц.....	125
I.2.4 Шинэ хотын бүтээн байгуулалттай Хангайн бүсийн ашигт малтмалын үйлдвэрлэлийг уялдуулах асуудал.....	156
Дүнгэлт.....	165
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТАД НӨЛӨӨЛӨХ БАЙГАЛЬ ЦАГ УУР, ЭКОЛОГИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД.....</b>	<b>167</b>
<b>НЭГ. ХОТ СУУРИНЫ, АРХИТЕКТУРТ НӨЛӨӨЛӨХ БАЙГАЛЬ ЦАГ УУР ЭКОЛОГИ, ГАЗАРЗҮЙ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ.....</b>	<b>167</b>
II.1.1 Дэлхийн болон Монгол орны уур амьсгалын өөрчлөлт.....	167
II.1.2 Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай.....	169
II.1.3 XXI зууны уур амьсгалын өөрчлөлтийн хандлага.....	170
II.1.4 Монгол орны уур амьсгалын өнөөгийн өөрчлөлт.....	171
<b>ХОЁР. ХОТ, СУМ, СУУРИНГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЭКОЛОГИ ГАЗАР ЗҮЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНДЭСЛЭЛ.....</b>	<b>176</b>
II.2.1 Судлагдсан байдал.....	176
II.2.2 Хангайн бүсийн хот суурины экологи газарзүйн нөлөөлөл.....	180
II.2.3 Хангайн бүс нутгийн гадаргын ус гол мөрний цэвэрших чадавхийн үнэлгээ.....	191
II.2.4 Хангайн бүсийн хөрсний нөмрөгийн антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхийн үнэлгээ.....	197
II.2.5 Хангайн бүсийн байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ, бүсчлэл.....	201
<b>ГУРАВ. ХАНГАЙН БҮСИЙН ХОТ БАЙГУУЛАЛТАНД НӨЛӨӨЛӨХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ.....</b>	<b>211</b>
II.3.1 Эдийн засгийн чадавхиар нь Хангайн бүсийн хотуудыг ангилах.....	211
II.3.2 Хангайн бүсийн хот байгуулалтад нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлийн үнэлгээ.....	219

II.3.3 Төв байршлын хүрээллээр Хангайн бүсийн хот сууринг ангилах.....	224
<b>ДӨРӨВ. ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИНЫ ЭДЭЛБЭР ГАЗРЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ ХӨРСНИЙ ШИНЖ ЧАНАР.....</b>	<b>235</b>
II.4.1 Хангайн бүсийн хот суурины инженер геологийн нөхцөл.....	235
II.4.2 Хангайн бүсийн нутгийн газар хөдлөлийн үйлчлэл ба геотехникийн нөхцөл.....	238
II.4.3 Хангайн бүсийн хот, суурины инженер геологийн нөхцөл, ул хөрсний геотехникийн шинж чанар.....	241
II.4.4 Хангайн бүсийн нутгийн геотехникийн нөхцөл.....	245
Дүгнэлт.....	262
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТЫН АРХИТЕКТУР, ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ.....</b>	<b>265</b>
<b>НЭГ. ХАР ХОРИН ХОТЫГ ХӨГЖҮҮЛЖ, ШИНЭ ХОТ БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ.....</b>	<b>265</b>
III.1 Бүсийн тулгуур төв хот байгуулах үндэслэл.....	265
III.1.2 Шинэ хотын архитектур хот төлөвлөлтийг шийдэхэд баримталсан тулгуур зарчим.....	286
III.1.3 Шинэ хотын архитектур, орон зайн төлөвлөлтийн үндсэн зарчим.....	290
III.1.4 Хотын суурьшлын бүсийн төлөвлөлт.....	345
III.1.5 Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэр архитектур төлөвлөлт.....	367
III.1.6 Дагуул хот, тосгодын хөгжлийн төсөөлөл.....	374
III.1.7 Хотын тээврийн хэтийн нөхцөл байдал.....	389
III.1.8 Хотын ногоон байгууламжийн төлөвлөлт.....	413
<b>НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ.....</b>	<b>425</b>
<b>НОМ ЗҮЙ .....</b>	<b>441</b>
Хавсралтууд.....	453
Архангай аймгийн нийгэм эдийн засаг, хот байгуулалтын хөгжлийн асуудал.....	455
Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засаг, хот байгуулалтын хөгжлийн асуудал.....	471

Булган аймгийн нийгэм эдийн засаг хот байгуулалтын асуудал.....	509
Орхон аймгийн нийгэм эдийн засаг хот байгуулалтын асуудал.....	545
Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого.....	571
Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын асуудал.....	591

Тайлангийн нэр	Хуудас	Хүснэгт	Зураг бичсэн он сар	Өмчлөгч
Хангайн бүсийн тулгуур төв Хар Хорины ирээдүйн төлөв, архитектур, хот төлөвлөлт	614	29	174	Д.Хайсамбуу

## РЕФЕРАТ

Барилга, Хот байгуулалтын Яам, БСШУЯ-ны ШУТ-н Сантай 2010 оны 03-р сарын 30-ны өдөр байгуулсан 25/10 тоот гэрээний дагуу Хархорин сумыг өргөжүүлж бүсийн тулгуур төв Шинэ хот болгох архитектур, хот байгуулалтийн үндсэн зарчмыг тогтоосон шинжлэх ухаан технологийн төслийг 2010-2012 оны хооронд гүйцэтгэлээ.

Төслийн хүрээнд Хангайн бүсийн тулгуур төв шинэ хот төлөвлөхөд үндэслэл материал болох бүсийн аймаг, сумдын нийгэм эдийн засгийн бодит байдал, хүрсэн түвшин, онцлого хэтийн төлөвийг судлан боловсруулж үнэлэлт дүгнэлт өглөө. Мөн бүсийн хот суурины архитектур, хот байгуулалтын хүрсэн түвшин онцлогыг тогтоож, нутаг дэвсгэрийх нь байгаль цаг уур, инженер геологийн тогтоц тэдгээрийн хот суурин байгуулалтад нөлөөлөх хүчин зүйлийн асуудалд иж бүрэн үнэлгээ өгч боловсруулалт хийлээ.

Бүсийн эрдэс түүхий эдийн нөөцийн судалгааг үндэслэн түүний хот суурины хөгжил архитектурт нөлөөлөх асуудлыг тооцож дүгнэлт гаргалаа. Хангайн бүсийн нийгэм эдийн засаг, теник технологийн энэ цогц асуудалууд нь бүсийн тулгуур төв Шинэ хот төлөвлөх үндсэн тулгуур материал болж байна.

Төслийн хүрээнд эдийн засгийн Хангайн бүсийн тулгуур төв хотын архитектур орон зайн төлөвлөлтийн үндсэн зарчмыг хот төлөвлөлтийн норм дүрэм, бусад холбогдох баримт бичиг зах зээлийн хууль эрх зүйн бодлогтой уялдуулан боловсруулалт хийлээ.

Хангайн бүсийн хүн амын нутагшилт суурьшил, хот суурины архитектур орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдлыг шинээр байгуулах хотын нутаг дэвсгэр бүтэц зохион байгуулалт, үүргийн бүсчлэл, ашиглалтын зориулалттай уялдуулсаны

үндсэнд бүсийн нутагшилт суурьшлын нэгдсэн зарчмыг тогтоолоо. Энэ үндсэндээр тэнд байх суурьшлын бүсүүдийн байршил, тэдгээрийн хоорондын уялдаа таталцлалын хэлбэр, онцлог, хотын хүн ам, нийгэм эдийн засгийн байдлын хүчин зүйл асуудлуудыг тодорхойлон тогтоолоо.

Хотын нийгмийн мөн үйлдвэрлэл үйлчилгээний объектуудын байршил, хамрах хүрээ, хотын гудамж замын сүлжээний төлөвлөлт, инженерийн барилга байгууламжийг цогцоор нь авч үзэн төлөвлөлтийн зохих түвшний шийдэлийг гаргалаа. Үүний үр дүнд бүсийн тулгуур төв хотын архитектур орон зайн төлөвлөлтийн үндсэн зарчим ямар байх жишиг зарчмыг тогтоож Шинэ хотын архитектурыг боловсруулав. Ингэснээр техникийн даалгаварт заасан асуудал шийдэгдэж төслийн зорилт хангагдаж байна.

Төслийн үндсэн боловсруулалт нь хэдийгээр бага зардлаар хийгдсэнч зах зээлийн үеийн бүсийн тулгуур төв хотын архитектур орон зайн бүтэц, тогтолцоо (загварын хотын түвшинд боловсруулсан) улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжил, ирээдүйн хөгжлийн цогц бодлогтой хэрхэн уялдаж өөрийн хүрээний нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжил, ирээдүйн хөгжлийн цогц бодлогтой хэрхэн уялдаж өөрийн хүрээний нийгэм эдийн засгийн үйл ажиллагаагаа бие даан явуулах нөхцөл боломжийг авч үзсэн гэж болно.

**Түлхүүр үг:** Бүс нутаг, бүс нутгийн хот суурин, бүсийн тулгуур төв хотын архитектурын орон зайн төлөвлөлтийн шийдэл бүсийн хотын загвар.



## ОРШИЛ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого бол дэд бүтэц улмаар орчин үеийн технологид суурилсан дэвшлийн шинэ чиглэл мөн.

Өнөөдөр манай улсын аль ч бүс нутагт ард түмний аж амьдрал хүндэвтэр, ядуурал, ажилгүйдэл нэлээд газар авсан, зам тээвэр, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжил сул дорой, хөгжил удаашралтай байна.

Бүсчилсэн хөгжлийн эцсийн зорилт бол нийгэм эдийн засгийн энэ хоцрогдлыг арилгах үүднээс бүс нутгуудыг харьцангуй бие даасан байдал, тэдгээрийн харилцан уялдааг хангах үндсэн дээр монгол орны нийт үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх асуудал юм.

Монгол Улсын их хурал 2003 онд Монгол Улсыг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн 5 бүсээр бүсчлэн хөгжүүлэхээр анх удаа тогтсон. Энэ шийдвэрт 1. Баруун бүсэд - Ховд, Улиастай, 2. Хангайн бүсэд - Хар хорин, Эрдэнэт хот 3. Төвийн бүсэд - Зуунмод, Дархан хот 4. Зүүн бүсэд – Чойбалсан, Өндөрхаан хотуудыг бүсийн тулгуур төв хот болгохоор тус тус заасан. Энэ шийдвэрийн хүрээнд бүсүүдэд эдийн засгийн паркуудыг байгуулах үндсэн чиглэлийг баталсаны дотор Хангайн бүсэд экспортын үйлдвэрлэлийн “Эрдэнэт” үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар тогтсон нь тэнд мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох зорилтыг агуулсан шийдвэр болсон.

Тэгэхээр бид **“Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын ирээдүйн төлөв, архитектур, хот төлөвлөлт”** шинжлэх ухаан технологийн энэхүү баримт бичгийн хүрээнд хангайн бүсийн тулгуур төв шинэ хотын архитектурыг бичих зорилт тавьсан.

Бүсийн тулгуур төв шинэ хот байгуулахаар төлөвлөөд байгаа Орхоны хөндий болох энэ нутаг орон маань төв Азийн цээжинд нутагтай малаа даган нүүдэллэдэг Монголчуудын эртний нийслэл Хар Хорум хотын туйрын ойролцоо орон нутгийн байгаль, түүхийн онцлог шинжийг хадгалсан, ирээдүйд хүний ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн хот байгуулалтын чиг хандлагад нийцсэн нутаг дэвсгэр



билээ. Нөгөө талаасаа Энд орчин үеийн төлөвлөлт бүхий Монголжуу маягийн хот байгуулах чиг баримжаатай жишиг хот болгон хөгжүүлэхээр Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санал санаачилгаар бүр тусдаа хөтөлбөр боловсрогдоод явж байгаатай дүйцэж байгаа хэрэг. Тэгээд ч Хархорин сумын орчинд шинэ хот байгуулъяа гэж бүх Монголчууд мөрөөддөг гэхэд хэлсдэхгүй.

Шинэ хот байгуулах энэ газар нутаг маань Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Хотонт, Хашаат сумуудын нутаг дэвсгэрийг хамарсан Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газар бөгөөд Төв Азийн нүүдэлчид түүний дотор монгол үндэстний буй болгосон нүүдлийн соёл иргэншил, түүний гарал үүсэл, хөгжлийг археологи, түүх соёлын баялаг дурсгалтайг нотлон харуулж байгаа дэлхийд данстай гайхамшигт түүхэн нутаг юм.

Хархорин сум байрласан Орхоны хөндий гэдэг нутаг маань Мойлтын ам, Орхоны долоогийн бууцан дахь хуучин чулуун болон хүрэл, төмрийн зэвсгийн үеийн эртний хүмүүсийн оромж, хот суурины балгас, Түрэгийн үеийн хаадын тахил шүтээний алдарт гэрэлт хөшөөнүүд, Уйгарын эзэнт гүрний нийслэл Хар балгас хотын туйр, Чингис хааны 1220 онд үндэслэсэн Монгол эзэнт гүрний нийслэл Хар Хорум хотын туйр, Монгол дахь Бурханы шашны болон Уламжлалт анагаах ухааны төв болсон Эрдэнэ-Зуу, Төвхөн хийд, Шанхийн их номын баруун хүрээ зэрэг түүх, соёлын хөшөө дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудыг хамарсан 120 гаруй мянган га өргөн уудам газар нутаг дэвсгэр билээ. Иймээс ч энэ утгаар нь эдгээр дурсгалт газруудыг дэлхийн соёлын өвд бүртгэн авч баталгаажуулсан юм. Тэгэхээр Хархорин сумыг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа энэ төслийн хот байгуулалтыг Орхоны хөндийтэй уялдуулан улам нарийвчлан авч үзэх шаардлагатай болсон.

Иймээс одоогийн Хар хорин сумын төвийг өргөтгөн Хангайн бүсийн тулгуур төв болгон хөгжүүлэх хот байгуулалт, төлөвлөлтийн сонгон авсан нутаг дэвсгэрийг тэлж, “Орхоны хөндий” гэж төсөлд тусгагдсан нэрээр нэрлэж байгаа хэрэг.

Одоогийн Хархорин сумын төв байгаа газар нь Орхоны хөндийн түүхийн дурсгалт газрын дэлхийн өвд бүртгэлтэй хамгаалалтын бүсээр хүрээлэгдсэн учир



энэ газарт ирээдүйд том хот болон өргөжин тэлэх орон зай, талбай муутай юм. Иймээс шинэ хот байгуулах газар нутгийг сумын төвөөс 20-иод км-ийн зайд орших Хөгшин Орхон голын хөндийн тэгшивтэр талбайг сонгон тогтоох болсон нь Орхоны хөндийтэй холбох шаардлагын үндэслэл юм. Энэ нь ч оновчтой сонголт болж байгаа хэрэг. Харин одоогийн Хархорин сумын архитектурыг нь хэвээр хадгалж сумын төв нутаг дэвсгэрийг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх замаар шинээр байгуулах хотын дагавар хот маягаар түүхийн дурсгал, байгалийн музейн цогцолбор, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх нь хамгийн зохимжтой гэж үзсэн.

Шинэ байршил нь Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан улсын хөгжлийн гол хэвтээ тэнхлэг болох мянганы зам болон Хангайн бүсийн хөгжлийн босоо тэнхлэгтэй огтлолцох стратегийн чухал ач холбогдолтой цэгт ойрхон очиж энэ утгаараа ч улс орны нийгэм эдийн засгийн зүй ёсны шаардлагатай нийцэж байгаа юм.

Одоогийн Хар хорин сумын төв 13 мянга гаруй хүн амтай 2000 гаруй га эдэлбэр газартай, Улаанбаатар хотоос баруун зүгт 343 км алсад оршдог. Сумын хойд хэсэг болон Зүүн талаараа нэлээд талархаг, хөгшин Орхон голын тэгшивтэр Баянзүрх уул, түүнээс хойш Хангайн овоо, урд зүгт Вангийн овоо, Мэлхий толгой зэрэг уулархаг тогтоцтой.

Хар хорин сумын нутаг дэвсгэр нь чийглэг, сэрүүвтэр зунтай, өвөлдөө хүйтэн, жилийн хамгийн хүйтэн үе нь 1 дүгээр сар бөгөөд дундажаар 14,5°C хүйтэн, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар дундажаар 16°C дулаан байдаг. Нийт унах тундасны 85 хувь нь дулааны улиралд, 15 хувь нь өвлийн улиралд тус тус унадаг онцлогтой.

Шинэ хотын хот байгуулалтын төслийг боловсруулахдаа нутаг дэвсгэрийнх нь байгаль, экологийн даацын судалгаа шинжилгээ хийх, хот байгуулалтын урьдчилсан үнэлгээ гаргах, зориулалтын бүсчлэл, архитектур төлөвлөлт, барилгажилт, зам тээврийн сүлжээ, инженерийн дэд бүтцийн хангамж, ландшафт төлөвлөлт зэрэг монголын уламжлалт хот төлөвлөлтийн арга хэрэгслүүдийг авч





хэрэгжүүлснээс гадна олон улсын хот байгуулалтын практикт түгээмэл хэрэглэж байгаа төлөвлөлтийн зарим чиг хандлага, барилга-хот байгуулалтын уламжлалт бус арга технологи, стандартыг тооцож хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Тухайлбал нийгмийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах үүднээс жишиг хотын гудамж, замуудыг урсгал тусгаарласан тусгай зорчих зурвастай байхаар төлөвлөх, чөлөөт орон зай сайтай гудамж замын норм стандартыг бий болгох, суурьшлын бүсийн зохистой байршлуудыг тодорхойлох нийтийн болон тусгай зориулалттай түр зуурын хийгээд удаан хугацааны авто машины зогсоолуудыг төлөвлөх, цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийг нормын түвшинд байлгах зэрэг хот байгуулалтын олон улсын болон үндэсний норм дүрмийн шаардлагуудыг хот байгуулах төслийн шатанд нь аль болохоор түлхүү тусгаж өгөхийг хичээсэн. Энэ ч утгаараа орон сууц, хот төлөвлөлтийн шинэ нормын нэг үндсэн тулгуур материал болж байгаа юм.

Шинэ хотын суурьшлын бүсийг төлөвлөхдөө нэг маягийн барилгажилт, нийтийн орон сууцны төлөвлөлтөөс аль болох татгалзах, өөрийн гэсэн өнгө төрхтэй, бие даасан бичил орчин үүсгэх хувийн орон сууцны хороолол хэлбэрээр төлөвлөх зарчим баримтлах, хороолол болгонд амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх парк, цэцэрлэг бүхий эрүүлжүүлэх, бялдаржуулах төвүүдийг төлөвлөх, хорооллын болон дүүргийн чанартай худалдаа, үйлчилгээний газруудыг суурьшлын бүсэд ойр, орон сууцны хорооллоос тусад нь иж бүрэн үйлчилгээний төв маягаар төлөвлөх зэрэг хот байгуулалтын үндсэн чиг үүрэгт нийцэх хандлагатай болсон.

Ер нь хотжих үйл явц дэлхий нийтийн соёл иргэншлийн орчин үеийн түгээмэл хандлага боллоо. Хотын хүн амын өсөлт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө урьд үзэгдээгүй түвшинд хүрч, цаашид хотын хөгжлийг зүй зохистойгоор залах асуудал олон улсын хэмжээний тулгамдсан зорилтын нэг болоод байна.

Хотжих үйл явц нь нийгэм эдийн засгийн хөгжлийн хурдац, шинжлэх ухаан техник, технологийн дэвшил, орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч хот байгуулалтын харилцан уялдаатай олон талын асуудлыг хэтийн хараатай чиглэсэн бодлогоор



зохицуулагдах бол ямар сөрөг үр дагавар гардгийг дэлхийн олон улс хүлээн зөвшөөрч хот байгуулалтын оновчтой бодлого, үндэсний чиг баримтлал боловсруулж хэрэгжүүлэх талаар ихээхэн анхаарч байна. Хот байгуулалтын зөв бодлого нь тухайн улс, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогт нийцүүлэн зохицуулах асуудлын гол нь амьдралын зохиомол орчин болон байгаль орчны харилцан шүтэлцээ, хотжих үйл явцас үүсэх үр дагавар, үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлахад оршино гэж үзэж байна. Энэ чиглэлээр олон улсын хэмжээнд тухайлбал НҮБ-ын шугамаар түүнчлэн тив, бүсийн нутгийн түвшинд ихээхэн анхаарч олон чухал баримт бичиг гарсныг аль ч улс орон төрийн бодлогын түвшинд авч үзэж Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлдэг түгээмэл хандлагад ороод байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комисс /ЭСКАП/-оос 1993 оны аравдугаар сард Тайландын Банкок хотноо “Ази Номхон далайн бүс нутгийн хотжилтын байдал” сэдэвт онолын бага хурал хот байгуулалтын асуудал эрхэлдэг сайд нарын зөвлөгөөн болж “... Хот сууринг байгаль орчинд хоргүй тэнцвэртэй хөгжүүлэн удирдах нь тус бүс нутгийн хот байгуулалтын стратеги мөн...” гэж нэгэнт тодорхойлон чиглэлийг эрчимжүүлэх зорилгоор олон чухал асуудлыг авч хэлэлцсэн хэрэгжүүлэх асуудлыг дэлхийн олон улс оронд зөвлөсөөр байгаа.

Энэ зөвлөгөөнөөс сүүлийн гучин жилд тус бүс нутгийн хотын хүн ам гурав дахин өссөн бөгөөд энэ үйл явц үргэлжилж 2020 он гэхэд 1.5 тэрбум хүнээр нэмэгдэж хотжилтын түвшин 55 хувьд хүрэх төлөвтэй байна гэдгийг ч тогтоосон.

Энэ бүс нутгийн хотжилтын үйл явцын хурдаас үүдэн хот байгуулалтын багтаамж хомсдож, хөрс ус, агаар, бохирдож амьдрах орчны орон зайн ядууралд орох хандлагыг хязгаарлаж цаашид оновчтой чиглэлийг баталгаажуулах талаар НҮБ болон Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комисс ихээхэн чармайлт гаргаж байна.

Бүсийн бага хурлаас Сайд нарын тунхаглал бүсийн хэмжээнд 2020 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг хэд хэдэн баримт бичиг гарсан. Сайд нарын



тунхаглалын зорилго нь хот байгуулалтын асуудлаар урьд гаргасан баримт бичгүүдтэй нягт уялдаатайгаар эдийн засгийн үр ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй, нийгмийн хувьд шударга, соёлын хангалуун нөхцөл буй болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино гэж үзсэн.

Энэхүү тунхаглалд хот байгуулалтын оновчтой шийдэл улс орны эдийн засагт чухал хөдөлгөгч хүч мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, бүсийн орнуудад хотын хөгжилд ихээхэн анхаарал тавьж, бодит үүрэг гүйцэтгэх талаар тодорхой алхам хийхийн чухлыг заагаад бүсийн орнуудын Засгийн газарт хандаж гаргасан юм. Уриалгад:

- Хот байгуулалтын үндэсний чиг баримтлал боловсруулж, бодит төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлэх:
- НҮБ болон олон улс, хоёр талын хамтын ажиллагааны шугамаар үзүүлдэг санхүүгийн туслалцааг нэмэгдүүлэх түүнчлэн энэ чиглэлийн арга хэмжээний зохицуулалтыг сайжруулах.
- Хот байгуулалтын бүсийн хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар тухайн орнуудын Засгийн газар, олон улсын болон хамтын ажиллагааны байгууллагууд хандивлагч орнууд бүсийн хэмжээнд болон тухайн орныхоо түвшинд бүх талын дэмжлэг үзүүлэхийг заасан.

Гэтэл өнөөгийн манай ганц том хот болох нийслэл маань агаар, ус, хөрсний бохирдол, дагуул хот, тосгодын хөгжлийн хоцрогдол, хууль эрх зүйн орчин, институцийн уялдаа холбоо муу, тодорхойгүй байдал, хотын санхүүжилтын сул чадавхи, гэр хороолол болон хотын газар нутгийн хяналт зохицуулалтгүй тэлэлт, зүй зохисгүй ашиглалт авто зам, нийтийн тээврийн хангалтгүй байдал, инженерийн дэд бүтцийн нийлүүлэлтийн хомсдол, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамжийн дутагдал, бүсүүдийн тэнцвэргүй хөгжил, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, хот байгуулалт газрын харилцааны сул тогтолцоо, зохисгүй төвлөрөл бий болсноор хүн амын амьдрах орчин эрсдэлтэй түвшинд хүрсэн зэрэг шалтгаанаас хотын орон зайн орчин алдагджээ.



Иймээс бид бүсийн хэмжээний хот байгуулалтын энэхүү бодлогын хүрээнд Монгол үндэсний хот байгуулалтын чиглэлийг хэрхэн уялдуулах, бүсийн үйл ажиллагаанд оролцох чиглэлийг тогтоох, бүсийн мэдээллийн сүлжээнд оролцох зэрэг асуудалд гол анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзсэн.

Монгол орны тухайд гэвэл газарзүйн байршил, байгаль цаг уурын нөхцөл, соёл иргэншлийн уламжлал, нийгэм эдийн засгийн тогтолцоо, хотжилтын түвшин зэрэг нь нэлээд онцлогтойг энэ төсөөлөлдөө харгалзан үзэхийг хичээсэн.

Олон улсын болон тив, бүс нутгийн хот байгуулалтын нийтлэг энэхүү хандлагыг үндэслэн Монгол орны өвөрмөц онцлогт тохирсон, зах зээлийн харилцааны нөхцөлд нийцсэн хэтийн хараатай цагийн аясыг даахуйц хот байгуулах төсөөлөл бичих асуудал энэхүү төслийн үндсэн зорилт оршиж байгаа юм.

Иймээс энэхүү Шинэ хотын бүтээн байгуулалтад дэлхийн түүний дотор Азийн бүс нутагт өрнөж байгаа энэ хүчин зүйл асуудлыг тооцож үзэхийг чухлыг анхаарч бүхий л талаасаа чармайсныг энд дурьдах нь зүйтэй санагдана.

### **ТАЙЛАНГИЙН ҮНДСЭН АГУУЛЛАГА**

**Нэг.** Монгол оронд хотжих үйл явц хөгжлийнхөө шинэ хэлбэр интеграцийн шатанд шилжиж байгаа онцлогуудыг тогтоож улмаар түүнийг нь Хангайн бүс нутгийн хөгжлийн хүрээнд авч үзсэн факторуудтай нь уялдуулан дараах хүчин зүйл асуудалтай холбон үзсэн, судалаж боловсруулалт хийлээ. Үүнд: **1.** Хангайн бүсийн нийгэм эдийн засгийн байгууламжийн өөрчлөлт, шинэчлэлт, хөгжил, бодит нөхцөл байдал, хэтийн төлөв эдгээрийн хот суурин байгуулалтад нөлөөлөх хүчин зүйл асуудал. **2.** Хангайн бүсийн хүн ам оршин суух хот суурин газар тэдгээрийн интеграцийн үйл явцын хүрээнд хамрагдах нийгмийн зүй тогтол; **3.** Интеграцийн үзэл баримтлалын хүрээнд бүсүүдийн хот хөдөөгийн суурин хоорондын нийгмийн хөгжлийн ялгааг багасгах болон хот хөдөөгийн хүн амын нутагшилтын аль нэг хэв шинж давамгайлах үйл явцыг арилгах нөхцөл байдал; **4.** Улс орны болон Хангайн бүсийн нийгэм эдийн засгийн хөгжлийг шинжлэх ухаан техникийн орчин үеийн дэвшилтэй нягт холбох бодит зүй тогтол; **5.** Манай улсын болон Хангайн бүийн хот



суурингийн хөгжлийн түвшин цаашдын нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага; **6.** Монгол Улсын болон Хангайн бүсийн хүн амын нутагшлын систем хэтийн төлөв түүний хот байгуулалтад нөлөөлөх хүчин зайн асуудал; **7.** Монголын хот суурины төлөвлөлт, бүтцийн хөгжилд гарсан үндсэн өөрчлөлтүүд, түүний мөн чанар, хот байгуулалтын шинжлэх ухааны үндэслэлтэй өөрчлөлт хийхэд шийдвэрлэвэл зохих үндсэн асуудлууд

**Хоёр.** Бүс нутагт нэгэнт бүрэлдэж тогтсон суурин хэвшлийн амьдралыг тухайн бүс нутгийн хот суурин газрыг хөгжүүлэх үндэс болгохын тулд дараах асуудалтай нягт уялдуулан судалаж боловсруулалт хийлээ. Үүнд: **1.** Бүсийн хот суурингийн хүн амыг бүлэглэн, бүс нутгийн тогтолцооны нэгдсэн системтэй уялдуулах; **2.** Бүс нутагт байгаа хуучин болон шинээр байгуулагдах хот, тосгон, хөдөө аж ахуйн суурингуудын харилцан уялдаатай хөгжих зүй тогтол болон цаашид Хангайн бүс нутгийн нутагшилтын бүтцэд гарах хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн жижиг сүлжээг хөгжүүлэх асуудал; **3.** Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бүс нутагт, хувийн хэвшлийн үйлдвэр хөдөө аж ахуйн цогцолборуудыг хэлбэршүүлэн хөгжүүлэх үндсэн зарчим, түүний нийгэм эдийн засгийн үндэс, бүтэц, хөгжлийн чиг хандлага

**Гурав.** Хангайн бүс нутгийн нийгмийн хөгжлийн шаардлагад зохицуулан бүсийн тулгуур төв шинэ хотыг хөгжүүлэх үндэслэлийг дараах асуудлуудтай уялдуулан судалаж боловсруулалт хийв. Үүнд: **1.** Хөдөө аж ахуйд хувийн аж ахуйтан бий болж, мал аж ахуйн, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн хувьцаат компанийн хэлбэрт шилжиж байгаа онцлог; **2.** Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх хувийн өмчийн хэлбэрүүд; **3.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх нийгмийн үүрэг шаардлага; **4.** Бүс нутагт байгаа манай хөдөөгийн суурин газар нь нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө хот, төв, суурин газраас дэндүү хоцрогдмол байгаа шалтгаан; **5.** Хот хөдөөгийн хүн амын өсөлт, өсөлтийн явц, шилжих хөдөлгөөний шинж чанар; **6.** Хүн ам хөдөөгөөс хот суурин шилжих хөдөлгөөний онцлог, түүний хэтийн төлөв, хотын нийт хүн амд хот маягийн жижиг суурингуудын хүн амын эзлэх хувь; **7.** Хүн ам хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнийг зохицуулах, түүнд нөлөөлөх нийгмийн чанартай шийдвэрлэх гол асуудлууд; **8.** Бүс



нутгийн хот суурин газрыг үүргээр нь ангилах, онцлог **9**. Бүс нутагт нийгмийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улам бүр нарийсан гүнзгийрч байгаа байдал.

**Дөрөв.** Үндэсний уламжлалыг хадгалах замаар шинэ хотын архитектур орон зайн бүтцийг өновчтой тогтоох нь суурин газар оршин тогтнох нэг талын үндэс гэж үзэж шинэ хот барих орчны түүхийн дурсгалт хот суурингуудын онцлог, үүнтэй холбогдож шийдвэрлэвэл зохих гол зангилаа асуудлыг хот, суурины шинэ, хуучин орон зайн зохиомжийн харилцан үйлчлэлийн төлөв байдалтай уялдуулан судлаж боловсруулалт хийх.

**Тав.** Бүсийн хот тосгоны хөгжлийг удирдах ерөнхий чиг хандлагыг дараах асуудалтай уялдуулан судалаж боловсруулалт хийх. Үүнд: **1.** Хангайн бүсийн хүн амын нутагшил, хот, тосгон, хөдөө аж ахуйн суурингуудын хөгжлийг боловсронгуй болгох үндсэн чиглэл; **2.** Хангайн бүсэд хот суурин хөгжүүлэх бодит нөхцөл байдал; **3.** Нийгмийн хөгжлийн эрэмбэ тэдгээрийн өөрчлөгдөх үе шатууд; **4.** Шинэ хот суурины хөгжилтэй холбогдон өөрчлөгдөх үндсэн объектууд; **5.** Хангайн бүсийн хүн амын нутагшилт тогтворжих хандлага. Энэ бүлгийн судалгаанд үнэлэлт өгч нэгдсэн дүгнэлт гаргах, **6.** Хангайн бүсийн тулгуур төв Шинэ хотын загвар архитектур орон зайн шийдэл.



**ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХАРХОРИНЫ  
ИРЭЭДҮЙН ТӨЛӨВ АРХИТЕКТУР, ХОТ ТӨЛӨВЛӨЛТ  
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

**НЭГ. СУДАЛГААНД ХАМРАГДАХ ҮНДСЭН АСУУДЛУУД, ГАРАХ ҮР ДҮН**

1.1 Хангайн Бүс нутгийн газар зүй, нийгэм эдийн засгийн онцлог түүнд тохирсон Хархорин хотын хот байгуулалтын бодлого, төлөвлөлтийн үндсэн зарчим” төслийн хүрээнд дараах асуудлуудыг судлана. Үүнд:

1.1.1 Монгол улсын Хангайн бүсийн аймаг, сум суурингийн нийгэм эдийн засгийн хүрсэн түвшин, хөгжлийн төлөв тулгамдсан асуудлууд,

1.1.2 Хангайн бүс хот суурины ангилал зэрэглэл нутаг дэвсгэрийн байгаль, газар зүй, экологийн иж бүрэн үнэлгээ. Үүнд:

**А. Байгаль экологийн хүчин зүйлийн үнэлгээ**

- Нутаг дэвсгэрийн инженер геологийн нөхцөл
- Барилгын уур амьсгалын онцлог
- Эдэлбэр газрын гадаргуугын тогтоц
- Үер, ус салхи шуурга, элсний нөлөөний үзүүлэлт
- Газар чичирхийллийн баллын бүсчлэл

**Б. Нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийн үнэлгээ**

- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, үр дүн
- Бүсийн аймаг сумдын нийгэм эдийн засгийн үнэлгээ, хүрсэн түвшин.
- Бүсийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв түүний хот төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйл асуудлууд.



- Хангайн бүс нутгийн өнөөгийн болон төлөвлөлтийн хугацааны хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, шинээр бий болох ажлын байрны магадлал.
- Хангайн бүсийн хот суурины хүн ам, хөдөлмөрийн түвшин, хүн ам, хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлт, хүн амын амьжиргааны түвшин, дэд бүтцийн сүлжээний хангамжийн түвшин.

**В. Хот, хот орчмын бүсийн хот байгуулалт, архитектур, орон зайн төлөвлөлт, ландшафтын хүчин зүйлсийн үнэлгээ**

- Хот, хот орчмын бүтэц, нутаг дэвсгэр, ландшафтын шинж байдал
- Хот суурины нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, барилгажилтын түвшин
- Хот, хот орчмын рекреацийн бүс, тэдгээрийн хоорондын уялдаа, дэд бүтцийн хангамжийн түвшин
- Хотын тогтвортой хөгжлийн үндэс, архитектурын орон зайн зохиомж төлөвлөлт, барилгажилтын чанар, онцлог
- Цэцэрлэгжилт, зам талбайн тохижилтын түвшин
- Хот суурины нутаг дэвсгэрийн тэнхлэг, гудамж замын сүлжээ, хот сууринг дайран өнгөрдөг улсын чанартай болон орон нутгийн чанартай авто зам, төмөр зам, бусад тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, шинж чанар, хангамжийн түвшин
- Хот суурины төвийн хэсгийн зохиомж архитектур, орон зайн төлөвлөлтийн онцлог

1.1.3 Хангайн бүс нутгийн хот суурингуудын байршил, орон зайн уялдаа, тэдгээрийн гадаад дотоод харилцаа, хоорондын таталцлал, дэд бүтцийн хөгжлийн хүрсэн түвшин

1.1.4 Хангайн бүс нутгийн хотуудыг ойрын ирээдүйд хөгжүүлэх онолын хүчин зүйл асуудлууд





1.2 Дээр дурьдсан асуудлуудыг судалснаар дараах үр дүн гарна. Үүнд:

- Бүс нутгийн хот, суурины хэв шинж, нэр төрөл, зэрэглэл,
- Хангайн бүс нутгийн хотуудын орон зайн хоорондын хамаарлын онцлог,
- Хангайн бүс нутгийн хот суурины эдэлбэр газар, архитектур, хот төлөвлөлтөд хот байгуулалтын болон байгаль, газар зүй, экологийн үнэлгээ
- Хангайн бүс нутагт барих барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн үндсэн зарчим
- Хангайн бүсийн Шинэ хотын хот байгуулалтын загвар, төлөвлөлтийн тооцоо, үндэслэл

## **ХОЁР. СУДАЛГААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС**

**2.1 Хангайн бүсийн түвшиний хот суурин газрын үүрэг, зэрэглэл, гүйцэтгэх үүрэг, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг судлах онол, арга зүйн үндэс**

Өнөө үед бүс нутгийн онцлогт тохирсон хот байгуулалтын бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд дэлхий дахинд ихээхэн анхаарах болсон байна. Энэ нь юуны өмнө аливаа нэг хотын орон зайд бий болсон тулгамдсан асуудлууд (ажилгүйдэл, ядуурал, орон сууцны хомсдол, экологийн асуудлууд г.м) буюу уул хот оршиж байгаа бүс нутгийн бусад хотуудын хөгжлийн түвшний, асуудлуудтай шууд холбоотой байдаг бодит зүй тогтлоос үүдэлтэй юм.

Эл зүй тогтолд тулгуурласан аливаа хот нь тухайн бүс нутгийн бусад хотуудтай шүтэлцээтэй хөгжих орон зайн нэгдсэн системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн гэж үзэж болно. Нөгөө талаар хот өөрөө бас дотроо үүргийн бүсүүдтэй, бөгөөд үүнийг нь дээр дурьдсан орон зайн нэгдсэн системийн салшгүй хэсэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл бүс нутгийн хотуудын, эсвэл тодорхой нэг хотын судалгааны аль алинд нь хот байгуулалтын цогцолбор системийн хандлагаар хандах зүй ёсны шаардлага ноёлох болжээ.



Олон судлаачид үүнийг /Корбюзе.Л, Гензде Танге, Адамс.Ж. (1986), Гусейн-Заде С.М. (1988), Перцик Е.Н (1991) г.м./ орчин үеийн бүс нутгийн хот байгуулалтын судалгаанд ноёлж буй онол, арга зүйн үндсэн хандлагын нэг гэж үзэж байна.

Бүс нутгийн хот байгуулалтын холбогдолтой аливаа судалгааг явуулахдаа судлаачид дараах хэд хэдэн асуудлуудад гол (үүнийг Хангайн бүсийн түвшинд авч үзэв) анхаарлаа хандуулж байна. Үүнд:

- Хангайн бүс нутгийн хотуудын болон бүс нутгийн сүлжээнд хамрагдах бусад хотуудын төлөвлөлтийн асуудлыг хүн амын нутагшилт, суурьшлын хөгжилтэй уялдуулах бодлого,
- Хангайн бүс нутаг, аймаг орон нутгийн нутаг дэвсгэрийн ойрын ирээдүйн хөгжлийг тэнд байх бүлэг суурины тогтолцоотой уялдуулах асуудлууд,
- Хангайн бүс нутгийн хот суурины нутаг дэвсгэр орон зайн багтаамж, тогтвортой хөгжлийн бодлого тухайн орон нутгийн байгаль орчны нөхцөл байдал, экологийн даац,
- Хангайн бүс нутгийн сүлжээнд хамрагдах хот болон хот орчмын бүсийн хүн амын нутагшилт, хотын орон зайн тогтолцоо, хот бүрдүүлэгч элементүүдийн хоорондын уялдаа, гүйцэтгэх үүрэг, барилгажилт, инженерийн шугам сүлжээний хангамж, цэцэрлэгжилт, архитектурын хүрсэн түвшин,
- Хангайн бүсийн хот суурины ангилал, хүн амын нутагшилт үндсэн хэв шинж, төрөл, бүтэц, хот суурины нутаг дэвсгэрийн хэмжээ, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл, хүн амын бүтцийн үзүүлэлт, шилжилт хөдөлгөөний шинж чанар.
- Хангайн бүс нутгийн үндсэн элемент болох хот суурингийн нэгдсэн сүлжээ нутаг дэвсгэрийн дэд бүтцийн хөгжил үндсэн тэнхлэгүүдийн байдал,



### 2.1.1 Бүс нутгийн хот, суурин газруудын зохион байгуулалтын судалгаа

**Бүс нутгийн хотжилтын зохион байгуулалт, зэрэглэл (иерархи)-ийн талаар.** Өнөөдрийг хүтэл манай оронд бүс нутгийн бодлогын хүрээнд хот суурины гүйцэтгэх үүрэг тэдгээрийн хоорондын уялдаа, зах зээлийн шаардлагад тавигдах асуудлууд үндсэндээ туйлын бага судлагдсан. Энэ үүднээс бид бүс нутгийн зарчмаар хөгжиж, хөгжлийн өндөр түвшинд хүрсэн гадны орны туршлагыг судалж өөрийн орны нөхцөлд зохистой нутагшуулан суурьшуулах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Бүс нутгийн хот суурин газруудын ангилал, зэрэглэлийг судлан загварчилах нь янз бүрийн орны судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байсан, одоо ч татсаар байна. /Кристаллер В.(1933), Хагет П.(1979), Мерлен П.(1977), Гусейн-Заде С.М (1980) г.м/. Энд **“Бүс нутгийн хот суурин газрууд нь орон зайн тархалт, байршлын хувьд ямар нэгэн зүй тогтол, шатлал эрэмбэтэй байдаг уу”** гэсэн асуултанд хариулт өгөх, явдал онцгой ач холбогдолтой байдаг байна. Учир нь эл асуултанд хэр зэрэг оновчтой хариулт өгч чадсанаас тухайн улс хот суурин газруудынхаа зэрэглэлийг оновчтой тогтоож энэ талаар явуулах бодлогоо зөв тодорхойлох боломжтой болдог аж.

Германы эрдэмтэн В.Кристаллер “Өмнөд Герман дахь төв байршил” номондоо (1933 он) энэ талын авууштай нэг гол санааг (гипотез) дэвшүүлжээ. В.Кристаллерийн энэ санааг одоо **“Төв байршлын онол”** гэж нэрлэж байна үүний **Гол агуулга** нь “Хэрэв хүн амын нягтшилт, зам тээврийн нөхцөл, байгалийн нөхцөл, нөөц, хүн амын худалдан авах чадвар зэрэг нь тодорхой нутаг дэвсгэр дээр жигд үзүүлэлтүүдтэй, өөрөөр хэлбэл ялгаа байхгүй байна гэж хийсвэрлэн авч үзвэл тийм нутагт байгаа суурин газрууд нь тодорхой зүй тогтлын дагуу байршсан байх ёстой” (Christall W. (1966)) гэж үзсэн байна.

Энэ эрдэмтэн “..... Гол төв болох суурин газар (хот г.м) нь 6 өнцөгт торны төвд байх бөгөөд уул гол суурин газрын нөлөөлөл дор байдаг 6 суурин газар (төв) нь торны 6 өнцөгт байршилтай байх зүй тогтол байна гэж үзэж байгаа юм.



Түүнчлэн ийм 6 өнцөгт тус бүр нь 7 суурин /1гол төв орсон/ газрынхаа хамт бүс нутгийн хот суурингийн сүлжээг буюу 49 (7x7) суурин газар бүхий сүлжээг бүрдүүлэх зүй тогтолтой гэж үзсэн байна. Ингэхдээ төвийн буюу анхны 6 өнцөгтийн гол төв суурин газар /хот/ нь уул бүсийн хэмжээний үндсэн төв нь бас байх болно гэж тогтоожээ.

### Суурин газруудын /хот, тосгон г.м./ түвшин /В.Кристаллер/

1 дүгээр хүснэгт

Зэрэглэлийн түвшин /иерархи/, /буурах дарааллаар/	Хүн амын тоо	Суурин газрын хоорондын зай /км/	Нөлөөллийн хүрээ /км/
1	500000	187	35000
2	100000	109	11650
3	30000	69	3880
4	10000	36	1243
5	4000	21	414
6	3000	13	140
7	1000	7	47

Байгалийн нөхцөл, нөөц, хүн амын нягтшилт, зам тээврийн боломж, хүмүүсийн нийгмийн үйлдвэрлэл үйлчилгээтэй харьцах чадвар зэрэг нь тухайн бүсийн хэмжээнд ямарч ялгаваргүй жигд байх тохиолдол амьдрал дээр байдаггүй учир онолын энэ санаа нь утга учиргүй зүйл гэж болох юм. **Гэвч Кристаллерийн энэ санаа нь хүн ам, хот суурины орон зайн зохион байгуулалт, үйлчиллийн хүрээг илрүүлэх судалгаанд онцгой эерэг нөлөөлөл үзүүлжээ.**

В.Кристаллерийн төв байршлын онолыг Германы эрдэмтэн А.Лёш, Америкийн энэ талын нэрт эрдэмтэн У.Изард нар дэмжиж зарим бүтээлүүддээ шинэ шинэ санаагаар баяжуулсан байна. В.Кристаллерийн төв байршлын онол нь хэвтээ (горизонталь) чиглэлээр хот суурины оновчтой байршлыг тодорхойлоход чиглэгдэж байгаа юм.

Монгол улсын хувьд өөрийн орны өвөрмөц байдлыг тооцон макро бүс (Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс), аймгуудын хот суурин газруудын зэрэглэлийг



хэвтээ чиглэлээр тодорхойлохдоо энэхүү онолд зарим талаар тулгуурлах боломжтой гэж үзэж байна.

Сүүлийн үед **босоо** (вертикаль) чиглэлээр хот суурины эрэмбэ дараалал, “байр суурийг оновчтой илрүүлэн” загварчлах талаар судлаачид зарим үр дүнд хүрч байна. Тухайлбал, **Ципфийн “дүрэм”** хэмээх онолын энэ арга судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байгаа болно. **Гол агуулга нь** “ямарч хотын хүн амын тоо нь тухайн нутгийн хамгийн том хотын хүн амын тоог уул хотын зэрэглэлийн дугаарт харьцуулсан утгатай тэнцүү болохоор өсч (тэмүүлж) байдаг” гэсэн дүгнэлтээр илэрч байгаа юм. Үүнийг томъёолбол дараах байдалтай байна. Үүнд:

$$P_r = \frac{P}{R_b} \quad (1)$$

$P_r$  – тухайн хотын хүн ам

$R$  – тухайн хотын зэрэглэл

$b$  – тухайн нөхцлөөс хамаарсан коэффициент

Ципфийн арга нь нутагшилтын системийг судлахад тохиромжтой гэж судлаачид үзэж байгаа юм. Ингэхдээ тухайн хотын хэмжээ хүн амын хувьд хэр зэрэг том болон зэрэглэл хоёрын хоорондын хамаарлыг илрүүлэхэд их тохиромжтой байдаг байна.

Манай улсын болон макро бүсүүдийн түвшинд босоо (вертикаль) чиглэлээр хот суурин газруудын зэрэглэлийг тодорхойлоход Ципфийн “дүрэм”-ийг хэрэглэх бас боломжтой юм.

**Бүс нутгийн хотжсон системийн нэг гол онцлог уул систем дотроо орон зайн хувьд жигд бус байдаг явдал юм.** Эл шинж чанарыг загварчлах явдалд эрдэмтэд, судлаачид бас их анхаарах болжээ. Сүүлийн үед судлаачид энэ талын олон тооны загварыг боловсруулсан байна.

Бүс нутгийн хот суурины системийн орон зайн жигд бус байдлыг харуулж байдаг үзүүлэлтүүд нь хүн амын байршилт, нутагшилтын жигд бус байдал, газрын үнийн ялгаа г.м олон үзүүлэлтээр илэрч байдаг гэж үздэг байна. Америкийн



эрдэмтэн Кларк хотуудын дотор хүн амын нягшилт жигд бус байдаг нийтлэг зүй тогтол дээр үндэслэн **Кларкийн загвар** гэж нийтэд алдаршсан загварыг боловсруулжээ. Эл загвар нь судлаачдын анхаарлыг илүү татаж байгаа юм.

Кларк, хотуудын хүн амын нягшилт нь хотын төвөөс алслах тутам буурч байдаг зүй тогтолд тулгуурлан дараах томъёоллыг боловсруулжээ. Үүнд:

$$P_{(x)} = C_e^{-a..r} \quad (2)$$


$r$  – хотын нутаг дэвсгэрийн захаас төв хүрэх зай

$C_e$  болон  $a$  – тухайн хотод л хамаатай тогтмол үзүүлэлтүүд


Сүүлийн үед судлаачид эл загварт зай ( $r$ )-г биш харин тухайн хотын нутаг дэвсгэрийн  $X$  цэгээс төвд нь очиход зарцуулж буй хугацааг авч үзэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Энэхүү загварыг хотжсон системийн орон зайн жигд бус байдлыг үзэж байгаа юм. Энэхүү загварыг хотжсон системийн орон зайн жигд бус байдлыг илрүүлэх онол, аргазүйн гол үндэслэл гэж үзэж болох юм. Тухайлбал энэ загвараар хотуудын нутаг дэвсгэрт газрын үнэ орон зайн хувьд яаж өөрчлөгдөж байгааг судлахад их анхаарах болсон байна.

Хотуудын орон зайн жигд бус байдлыг загварчлах онол аргазүйн үндэс нь дараах 3 загвараар илэрч байна гэж үзэж болно. **Эдгээрт:**

Е.Баружеегийн тодорхойлсноор төвөөс тойрог байдлаар орон зайн жигд бус байдал илрэх (концентрическая модель) загвар (1 дүгээр зураг), Х.Хойтын салбарын (секторная модель) загвар (2 дугаар зураг), Ч.Гаррис, Е.Ульман нарын олон цөмт (многоядерная модель) загвар (3 дугаар зураг)-ыг тус, тус хамааруулж байгаа юм. Эдгээр загваруудад хотуудын нутаг дэвсгэрийн орон зайн бүтцийг (орон сууцны, албан байгууллагын, үйлдвэрийн дүүрэг г.м) тодорхойлсон байдаг. Эдгээр загваруудаас эхнийх нь буюу төвөөс тойрог байдлаар орон зайн жигд бус байдал илрэх загвар (концентрическая модель)-ыг үндсэн загвар гэж хэлж болох юм. Бусад 2 загвар нь эхний загварын тодотгосон хувилбар мөн гэж судлаачид үзэж байна.



1 дүгээр зураг



2 дугаар зураг



3 дугаар зураг

Сүүлийн үед хотуудын доторхи орон зайн жигд бус байдлыг судлахдаа шалтаг шалтгааны хүчин зүйлсийн дүн шинжилгээг их хэрэглэх болсон байна. Жишээлбэл тухайн хотын оршин суугчид өөрийн хотынхоо орон зайн зохион байгуулалтын талаар ямар санал бодолтой байгааг судлаж хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, төсөлд тусгах явдалд их анхаарч байна.


**Хотууд хоорондын болон хот доторхи харилцан үйлчлэлийн орон зайн загвар.** Өнөө хүртэл хот, суурин газруудын хоорондын харилцан үйлчлэл /хүмүүсийн хөдөлгөөн, ачаа урсгал, мэдээллийн солилцоо г.м/-ийн зүй тогтлыг илрүүлж, уул үйл явцыг оновчтой удирдах явдал эрдэмтэд судлаачдын анхаарлыг ихээхэн татсаар байна. Энэ талаар судлаачдын хийсэн онолын дүгнэлтүүд нь эцсийн дүндээ дараах гол санаанд суурилсан байгаа юм.

Судлаачид аливаа хотуудын хоорондын харилцан үйлчлэлийн зүй тогтол “хоёр бие нь хоорондоо тэдгээрийн масстай шууд пропорцианаль, харин тэдгээрийн хоорондын зайн квадраттай урвуу пропорцианаль хамааралтай хүчээр таталцаж байдаг” гэж үздэг бүх дэлхийн таталцлын хуулиар илэрч байна гэж үзэж байна. Энд масс гэсэн ойлголтонд ихэвчлэн тухайн хотын хүн амын тоог авч үздэг аж. Онол арга зүйн энэ байдалтай Монголын хот суурины байрлал (4, 5, 6, 7 дугаар зураг) үндсэндээ тохирч байгаа юм.






### ЭДИЙН ЗАСГИЙН ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИН ГАЗРУУДЫН СҮЛЖЭЭНИЙ БҮТЦИЙН СХЕМ



4 дүгээр зураг

### ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВИЙН БҮСИЙН ХОТ СУУРИН ГАЗРУУДЫН СҮЛЖЭЭНИЙ БҮТЦИЙН СХЕМ




5 дугаар зураг






### ЭДИЙН ЗАСГИЙН БАРУУН БҮСИЙН ХОТ СУУРИН ГАЗРУУДЫН СҮЛЖЭЭНИЙ БҮТЦИЙН СХЕМ



6 дугаар зураг

### ЭДИЙН ЗАСГИЙН БАРУУН БҮСИЙН ХОТ СУУРИН ГАЗРУУДЫН СҮЛЖЭЭНИЙ БҮТЦИЙН СХЕМ



7 дугаар зураг



Шведийн эрдэмтэд (Т.Хаерстранд, Г.Тронквист) дээрхи санаанд тулгуурлан хотуудын харилцан үйлчлэлийн итгэлцүүр (коэффициент)-ийг тооцоолон гаргасан байна. Стокольмын энэ дагуул хотууд 80-90, Гётеберг-78, Кируна-36 гэсэн итгэлцүүртэй байгаа юм.

**Динамик загвар.** Хотуудын хөгжлийн үндэс болж байдаг зарим үйл явц (аж үйлдвэрийн өсөлт г.м) уул үйл явцтай шууд холбоотой бусад үйл явц (хүн амын өсөлт, үйлчилгээний өсөлт г.м)-ыг тоон үзүүлэлтээр илэрхийлж загварчлахад динамик загваруудын мөн чанар оршиж байгаа юм.

### **2.1.2 Хотуудын энгийн ангилал (классификацич) болон хэв шинж (типология)-ийн ангилалын судалгаа**

Хотуудын болон хотуудын системийн ангилал, хэв шинжийг илрүүлэх нь тухайн хотын, түүнчилэн тухайн хотуудын системийн хөгжлийн хэтийн төлөвийг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг байна. Үүнээс энэ талын судалгаа нь онолын болон практикийн багагүй ач холбогдолтой байдаг гэсэн дүгнэлт хийж болно.

Энэ нь хотуудын энгийн ангилал болон хэв шинжийн ангилал хоёрын хоорондын ялгааг зөв тодорхойлох шаардлагатай. Ихэнх эрдэмтдийн үзэж байгаагаар тухайн хотын болон хотуудын системийн энгийн ангилал нь тэдгээрийн зөвхөн нэг болон хэд хэдэн шинжид тулгуурладаг аж. Харин хэв шинжийн ангилал нь тухайн хотын болон хотуудын системийн бүх шинжийг нэгдмэл байдалд нь цогцолбороор авч үздэг бөгөөд уул ангилалд тулгуурлан тэдгээрийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлдог байна.

### **2.1.3 Хотуудыг хүн амын тоогоор нь ангилаж буй үзүүлэлтийн судалгаа**

Хотуудын хүн амын тоо нь тэдгээрийг хот гэж хэлэх эсэхийг тодорхойлдог үндсэн үзүүлэлтүүдийн нэг юм. Жишээлбэл: Дани улсад 250-иас дээш оршин суугчидтай суурин газрыг хот гэж нэрлэж байхад Японд 30 мянгаас дээш оршин суугчидтай байвал хот мөн гэж үзэж байна. НҮБ-ын тоо бүртгэлийн мэдээллүүдээс



үзэхэд хотын талаар “үндэсний” болон “тоон” гэсэн хоёр шалгуурыг баримталж байна. Үндэсний шалгуурт 5 мянгаас илүү оршин суугчидтай байвал, харин тоон гэсэн шалгуурын үүднээс 20 мянгаас дээш оршин суугчидтай байвал хот гэж үзнэ гэж /НҮБ-ын/ тус тус тодорхойлжээ.

ОХУ-д хот байгуулалтын практикт жижиг /20 мян хүртэл оршин суугчидтай/, дунд /20-100 мян орчим суугчидтай/, том /100-500 мян оршин суугчидтай/, томоохон /500 мянгаас дээш оршин суугчидтай/ хот гэсэн хот суурины энгийн ангиллыг мөрдөж байгаа юм.

Хүн ам, хот суурин газар цөөнтэй манай улсад өөрийн орны өвөрмөц байдалд нийцсэн ангилал боловсруулан мөрдөх шаардлагатай байна. Харин манайд хотуудыг үндэслэл муутай ч гэсэн зөвхөн хүн амын тоогоор нь ангилж ирсэн юм.

#### **2.1.4 Хотуудын эдийн засгийн газарзүйн байршилд нь суурилсан ангилалын судалгаа**

а) Эдийн засаг газарзүйн байрлалд нь тулгуурласан ангилал. Хотын хэв шинжийг эдийн засгийн газарзүйн байрлалд нь тулгуурлан илрүүлснээр уул хотын хөгжлийн хэтийн төлвийг зөвхөн тэр хотын хувьд түлхүү илэрч байгаа онцлого ерөнхий шинж байдлынх нь үүднээс тодорхойлох боломжтой болдог байна. Судлаачид эдийн засгийн газар зүйн байрлалд нь дүн шинжилгээ хийсний дээр дараах хэв шинжийн хотууд байдаг болохыг илрүүлээд байна. Үүнд:

- Төрөл бүрийн замын огтолцол /зангилаанд/-д байршилтай хот.
- Ашигт малтмал эрчимтэй олборлолтын бүс нутгуудад байрлалтай хот.
- Томоохон боловсруулах үйлдвэрүүдийн бүс нутгуудад байрлалтай хот.
- Хөдөө аж ахуй зонхилсон бүс нутагт байрлалтай хот.

Өнөө үед судалаачид аливаа хотыг хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлохдоо эдийн засгийн газарзүйн байрлалд нь нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд их анхаарч байна. Учир нь дэлхийн томоохон хотууд бараг бүгд



л эдийн засгийн газарзүйн тохиромжтой байрлалдаа тулгуурлан түргэн хурдацтай хөгжиж ирсэн юм. Жишээлбэл: Францийн төв хэсэгт хойт болон зүүн хойт зүгт Ла-Манш, Зүүн өмнө зүгт Газар дундын тэнгис чиглэсэн их замуудын уулзварт оршдог Париж, Оросын тал нутгийн төв хэсэгт олон замын уулзварт оршдог Москва зэрэг хотын хөгжилд эдийн засгийн газарзүйн байрлал нь чухал үүрэг гүйцэтгэжээ.

Аливаа хотын эдийн засгийн газар зүйн байрлалыг үнэлэхдээ энэ талын олон тооны үзүүлэлтүүдийг баллан нэгдсэн үнэлгээг гаргах аргыг их хэрэглэж байна. Сүүлийн үед Ципфийн загвар /өмнө авч үзсэн/-ыг хэрэглэх нь зүйтэй гэж үздэг эрдэмтэд ч цөөнгүй гарч байна.

Монгол улсын хувьд эдийн засгийн макро бүс /Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс/-ийн хот суурин газрын эдийн засгийн газарзүйн байрлалыг нарийвчлан тоон үзүүлэлтээр үнэлж тодорхойлох явдал чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

#### **2.1.5 Хотуудын үүрэг /функци/-т нь тулгуурлан энгийн болон хэв шинжийн ангилал боловсруулж буй байдал.**

Өнөө үед тодорхой улсын болон тухайн бүс нутгийн хотуудын улс орныхоо эсвэл, уул бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэгт нь тулгуурлан энгийн /классификаци/ болон хэв шинжийн /типологи/ ангилал боловсруулах явдал судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байна. Учир нь ийм чиглэлээр боловсруулсан ангилалууд нь бусад ангилалуудтай харьцуулахад харьцангуй цогцолбор /синтетистк/ шинжтэй байдаг.

Одоогийн байдлаар хотуудыг үүргийнх нь хувьд олонхи судлаачдын үзэж байгаагаар дараах 5 хэв шинжид ангилж байна. Үүнд:

- **Олон үүрэгтэй хотууд.** Ийм хэв шинжийн хотууд нь засаг захиргааны, эдийн засгийн, соёлын гэх мэт олон үүрэгтэй байдаг бөгөөд эдгээр хотуудад аж үйлдвэр харьцангуй илүү хөгжсөн байдаг аж. Өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас авч үзэхэд улсын нийслэл, муж улсуудын нийслэл, эдийн засгийн



макро бүсийн хөгжлийн тулгуур төвүүд г.м хотууд ихэнхи тохиолдолд ийм үүрэгтэй байдаг байна.

- **Аж үйлдвэрийн болон тээврийн үүрэг нь давамгайлсан хотууд.** Эдгээр хотуудыг дотор нь давамгайлж байгаа үүргээр нь аж үйлдвэрийн, аж үйлдвэр-тээврийн, гэж ангилж болдог аж.

- **Аж үйлдвэрийн үүрэгтэй хотуудад.** Аж үйлдвэрийн олон салбар ихэвчлэн зэрэг хөгжсөн байдаг бөгөөд үйлдвэрлэлийн үйл явц /процесс/ нь эцсийн бэлэн бүтээгдэхүүн гаргах байдлаараа онцлогтой байдаг байна. Ийм хотууд нь харьцангуй хөгжилтэй бус нутгуудад түгээмэл байдаг. Мөн аж үйлдвэрийн салбарын хувьд төрөлжсөн хотууд ч байдаг. Жишээлбэл: машин үйлдвэрлэлийн, химийн үйлдвэрлэлийн г.м төв болсон төрөлжсөн үүрэгтэй хотууд байгаа юм.

- **Аж үйлдвэрийн болон зам тээврийн үүргээс бусад үүрэг нь давамгайлсан хотууд.** Ийм үүрэгтэй хотуудад орон нутгийн засаг захиргааны төв болсон жижиг хот, хот хэвшлийн суурингуудыг хамруулдаг байна.

- **Амралт сувилал, аялал жуулчлалын үүрэгтэй хотууд.** Ийм хотууд рашаан ус, үзэсгэлэнт байгаль, түүх дурсгалын цогцолборууд зэрэгт түшиглэж оршин тогтнож хөгжиж байдаг байна.

- Сүүлийн жилүүдэд хөгжилтэй орнуудад **эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэлийн үүрэгтэй хотуудыг** байгуулах явдал түгээмэл байна.

Монгол улсын хувьд өөрийн орныхоо өвөрмөц нөхцөл байдалд нийцүүлэн хотуудын үүргийг тодорхойлж өгөх явдал онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

### **2.1.6 Бүс нутгийн хөгжил дэх хотуудын үүрэг оролцоог тодорхойлж буй чиглэл**

Бүс нутгийн хөгжилд хотууд нь янз бүрийн үүрэг, оролцоотой байдаг байна. Зарим хотууд нь орон нутгийн бага хэмжээний нутаг дэвсгэрт нөлөөлж байхад, зарим нь улсын болон томоохон бүс нутгийн эсвэл, олон улсын түвшинд тус, тус



нөлөөтэй байдаг. Энэ үүрэг, оролцооны өнөөгийн байдлыг судлаж хэтийн төлөвийг нь оновчтой тодорхойлох явдал ихээхэн ач холбогдолтой юм.

Энд өмнө авч үзсэн хотуудын системийн загварчлал, хотуудын энгийн ангилал (классификация) болон хэв шинж (типология)-ийн ангилал эдийн засгийн газарзүйн байрлалын чадавхи, байгалийн нөхцөл нөөц, эдийн засаг нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшин, чадавхи, зэрэг олон хүчин зүйлийг тооцож үнэлгээ өгөх чиглэл давамгайлж байгаа юм. Ингэхдээ нэгдсэн тоон (количественный) үнэлгээг өгөх явдалд судлаачид их анхаарч байна. Ийм үнэлгээ нь баллаар болон итгэлцүүр (коэффициент)-ээр үнэлгээ өгдгөөрөө онцлог юм.

Бүс нутгуудын түвшинд хот суурин газруудын үндсэн үүрэг, зэрэглэл, хөгжлийн асуудлуудыг судлах онол, арга зүйн үндэслэлийн талаар товч дурьдахад ийм байна.

Дээр авч үзсэн онолын болон арга зүйн шинжтэй судалгааны тогтолцоонууд нь Хангайн бүсийн хот сууринг хөгжүүлэх энэхүү төслийн хүрээнд судалгааны тодорхой шийдлүүдийг гаргахад тулгуур үндэслэл болох учиртай гэж үзлээ.

## **2.2 Хангайн бүсийн Шинэ хотын орон зайн загвар, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийх онол, аргазүйн үндэс**

### **2.2.1 Хангайн бүс нутгийн онцлогт зохицсон хотын орон зайн загвар боловсруулах онол, аргазүйн үндэс**

Орчин үед хотжих үйл явц хөгжлийнхөө шинэ хэлбэр интерграцийн шатанд шилжиж байна. Үүнийг Хангайн бүс нутгийн хөгжлийн хүрээнд авч үзэх ёстой бөгөөд ингэснээр нутагшлын системийн шинэ үе шат эхэлж байна гэж үзэж болно. Үүний үр дүнд: **нэгд.** Аливаа улс орны нийгэм эдийн засгийн байгууламжийн өөрчлөлт, хөгжил, бодит нөхцөлд байдал, хэтийн төлөв биелэлээ олох, **хоёрт.** Хүн ам оршин суух суурин газар интеграцын үйл явцын хүрээнд хамрагдах нийгмийн зүй тогтол хэрэгжих, **гуравт.** Интеграцийн үзэл баримтлалын мөн чанар нь хот хөдөөгийн суурин хоорондын нийгмийн хөгжлийн ялгааг багасган, хот хөдөөгийн хүн амын нутагшилтын аль нэг хэв шинж давамгайлах үйл явцыг





арилгахад нөлөөлөх, **дөрөвт**. Улс орны нийгэм эдийн засгийн байгууламжийн хөгжлийг орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшилттэй нягт холбох бодит зүй тогтол бүрэн биелэгдэх, **тавд**. Хангайн бүсийн хот, суурингийн хөгжлийн цаашдын нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага тодорхой болно.

Интеграцийн онолыг Хангайн бүсийн хүн амын нутагшлын системийн нутаг дэвсгэр, орон зайн бүтцийн хэтийн төлөвийг тодорхойлох үндэс гэж үзлээ. Ингэснээр Хангайн бүсийн хот суурины төлөвлөлт, бүтцийн хөгжилд гарсан үндсэн өөрчлөлтүүд, түүний мөн чанар, хот байгуулалтын шинжлэх ухааны үндэслэлтэй өөрчлөлт хийхэд шийдвэрлэвэл зохих гол асуудлуудыг судална.

**Интеграцийн онолын агуулга, шинж чанар нь: нэгд**. Хангайн бүсийн хот хөдөөгийн суурингийн хөгжил ойртох зүй тогтол, **хоёрт**. Интеграци хэрэгжих үе шат, **гуравт**. Бүс нутгийн нутагшлын систем төлөвшин тогтох арга зам, бүтэц,

**Хангайн бүсийн хот сууринг олон төрлийн ангилал, хэв шинжид хамааруулан бүс нутгийн хүрээнд хөгжүүлэхэд зайлшгүй анхаарах нийтлэг болон өвөрмөц онцлогууд: нэгд**. Нутаг дэвсгэрийг цогцолбороор ашиглах боломж, **хоёрт**. Хот суурингийн зэрэглэл нь хүн ам оршин суух аливаа цэгийг нутаг дэвсгэр, орон зайн хувьд хэлбэршүүлэх урьдчилсан нөхцөл болох, **гуравт**. Хүн амын нутагшилтын хэв шинж онцлог байдал, **дөрөвт**. Хүн ам оршин суух суурин цэгүүдийг Хангайн бүс нутгийн системийн үндсэн элемент болгох нөхцөл байдал, **тавд**. Хангайн бүс нутгийн хүн амыг хүнсээр, үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах засгийн газрын программ, үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх нийгмийн зорилт зэрэг болно.

**Хот сууринг хөгжүүлэх Хангайн бүс нутгийн онцлог.**

**Нэгд**. - бүс нутгийн онцлог нь

- нийгэм эдийн засгийн,
- экологийн байгаль цаг уурын,
- хот орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн гэсэн бүтэцтэй байна,



**Хоёрт.** Хангайн бүс нутаг нь хот суурингийн зохистой сүлжээг хөгжүүлэх таатай орчин байх.

**Хангайн бүс нутгийн нутагшилтын системийг хөгжүүлэх үндэслэл:**

**Нэгд.** Нутагшилтын тархай бутархай хэлбэр тогтсон нийгмийн шалтгаан, үр дагавар, түүний мөн чанарыг судлан тодорхойлох, **хоёрт.** Бүс нутгийн суурин цэгүүдийн сүлжээг ижилсгэх, томсгох, алга болох, чиглэлийг тогтоох, **гуравт.** Дэд бүтэц, замын сүлжээг бүс нутгийн хот суурины дотоод бүтцийг хөгжүүлэхэд ашиглах боломжийг тодорхойлох, **дөрөвт.** Бүс нутгийн нутагшилтын зэрэглэлийг тогтоох,

**Хангайн бүсийн нутаг дэвсгэрт нутагшлын системийг хэлбэршүүлэн хөгжүүлэх үндэслэл, нэгд.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явагдаж байгаа бүсийн нутаг дэвсгэрт байрласан аж ахуйн нэгжүүдийн хүрээнд хүн ам нутагших өвөрмөц онцлог, үндсэн хэв шинжүүдийг тодорхойлох, **хоёрт.** Бүс нутгийн нөлөөллийн эрчимтэй бүс дэх хүн амын нутагшлын системийн тулгуур төв, түүний хамрах хүрээ, шинж чанарыг тодорхойлох, **гуравт.** Бүс нутаг дахь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг хөдөөгийн хүн амыг үйлдвэрлэл эрхэлж байгаа онцлогоор нь бүсчлэн ялгавартай авч үзэх, **дөрөвт.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг бүс нутгийн хүрээн дэх хүн ам төвлөрлийн үндсэн шалтгаан, мөн чанарыг тогтоох.

Хангайн бүс нутгийн хүн амын нутагшилтын хэв шинж, түүний хөгжлийн өрнөлтийг улс орны нийгэм эдийн засгийн байгууламжийн өөрчлөлттэй нягт уялдуулан орчин үеийн нийгэм, техникийн дэвшлийн хүрээнд зохицуулах. Ингэхдээ хүн оршин суугаа хот суурин газрын хөгжлийн төлөв байдлыг хөгжиж ирээдүйтэй, ирээдүйгүй, эрчимтэй хөгжих хэтийн төлөвтэй гэж үнэлэх.

**Бүс нутгийн хот, сууринг интеграцчиллын онолоор хөгжүүлэхдээ хот суурины харилцан уялдах сүлжээг түлхүү хөгжүүлэх зорилт тавина.**

Үүнд: **нэгд.** Бүс нутгийн төв, хот суурингийн зэрэглэл, тогтоох, **хоёрт.** Хүн амын нутагшилтын тодорхой системүүдийг бүс нутгийн төв. Хот суурингуудын хүрээнд





нөлөөлж, хөгжүүлэх чиглэл боловсруулах, **зуравт**. Бүсийн төв, хот суурингуудын хэв шинжийг тогтоох. Энэ зорилтын хүрээнд:

**А.** Дээд зэрэглэлийн буюу бүс нутгийн Шинэ хот бусад хотуудын сүлжээг хөгжлийн төлөв байдлыг тодорхойлох.

**Б.** Хангайн бүс нутгийн хүрээн дэх дунд зэрэглэлийн хотын сүлжээ хөгжлийн төлөв байдлыг тодорхойлох.

**В.** Хангайн бүс нутгийн доод зэрэглэлд хамаарагдах төв суурингуудын сүлжээг хөгжүүлнэ. Үүний тулд: **нэгд**. Бүс нутгийн жижиг суурингуудын зэрэглэлийг тогтоож сүлжээг хөгжүүлэх, **хоёрт**. Бүс нутагт байх хот маягийн суурингуудын баазад түшиглэн орон нутгийн суурингуудын нэгдсэн сүлжээг хөгжүүлэх.

**Хангайн бүс нутагт нэгэнт бүрэлдэж тогтсон суурин хэвшлийн амьдрал нь бүс нутгийн хот суурин газрыг хөгжүүлэх үндэс болно.** Иймээс **нэгд**. Хот суурингийн хүн амыг бүлэглэн, бүс нутгийн тогтолцооны системтэй уялдаатай хөгжүүлэх, **хоёрт**. Бүс нутагт байгаа хуучин болон шинээр байгуулагдах хот, тосгон, хөдөө аж ахуйн суурингуудыг харилцан уялдаатай хөгжих зүй тогтлыг тодорхойлох.

Хангайн бүс нутгийн нутагшилтын бүтцэд гарсан эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт нь цаашид хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн жижиг сүлжээг дагуул хотуудын түвшинд хөгжүүлэх үндсэн хүчин зүйл болно. Тухайлбал:

- 1. Фермерийн аж ахуй**
- 2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хоршоолол /комплекс/**
- 3. Хот, суурины нутаг дэвсгэрт байх үйлдвэрлэлийн жижиг цогцолбор.**

Үүнтэй уялдуулж зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бүс нутагт хөдөө аж ахуйн, хувийн хэвшлийн аж үйлдвэрийн цогцолборуудыг хэлбэршүүлэн хөгжүүлэх үндсэн зарчим, түүний нийгэм эдийн засгийн үндэс, бүтэц, хөгжлийн чиг хандлага, хөгжлийнх нь интеграцын онол, нутаг дэвсгэрийн хэлбэрүүдийг нь тодорхойлно.



**Хангайн бүс нутгийн хот суурин газрын үүрэг, зорилт, удирдах үйл ажиллагааг эрхлэх онцлог: нэгд.** Бүс нутгийн хот суурин газрыг үүргээр нь ангилах, тэдгээрийн хэв шинж, хэмжээг тогтоох, **хоёрт.** Бүсийн хот суурин газрын хөгжлийг илэрхийлэгч гол хүчин зүйлүүдийг тодорхойлж, хөгжлийн үндсэн хэв шинж, үйл ажиллагааг явуулах цар хүрээ, чиглэлийг нь тогтоох, **гуравт.** Бүс нутагт нийгмийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэх нь улам бүр нарийсан гүнзгийрч байгааг судалж хүн ам оршин суугаа газрын үүрэг, зориулалт, тэдгээрийн үйл ажиллагааны ялгавар хүчтэй болох зүй тогтлыг боловсруулах.

**Хангайн бүс нутагт байгаа манай хөдөөгийн суурин газар нь нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө хот, төв суурин газраас дэндүү хоцрогдмол байгаа нь хүн ам, хөдөлмөрийн нөөцийг тэнд байршуулахад сөрөг нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болж байгаа юм.** Иймээс: **нэгд.** Хот хөдөөгийн хүн амын өсөлт, өсөлтийн явц, шилжих хөдөлгөөний шинж чанарыг нарийвчлан тогтоох, **хоёрт.** Хүн ам хөдөөгөөс хот сууринд шилжих хөдөлгөөний онцлог, түүний хэтийн төлөвийг судалж, хотын нийт хүн амд хот маягийн жижиг суурингуудын хүн амын эзлэх хувь буурах хандлагыг тодорхойлох, **гуравт.** Хүн ам хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнийг зохицуулах, түүнд нөлөөлөх нийгмийн чанартай шийдвэрлэх гол асуудлыг судалж, хүн ам зүйн бүтэц, шинж чанарыг нь тогтоон, нутаг дэвсгэрийн ялгааг нь тодорхой болгох.

**Хангайн бүс нутгийн нийгмийн хөгжилд гарч байгаа өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд хот сууринг хөгжүүлэх үндэслэл: нэгд.** Хөдөө аж ахуйд хувийн аж ахуйтан бий болж, мал аж ахуйн, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн хувьцаат компанийн хэлбэрт шилжих, **хоёрт.** Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх хувийн өмчийн хэлбэрүүд үүсэж бий болох, **гуравт.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх нийгмийн үүрэг шаардлага өндөржих, **дөрөвт.** Хотын нийгэм, эдийн засаг төлөвшиж, өгөөж нь дээшлэх.

**Хангайн бүсийн хот суурины үндэсний уламжлалыг хадгалах хотын архитектур орон зайн бүтцийг шинэчлэх нь суурин газар оршин тогтнох нэг талын үндэс гэж үзнэ.** Үүний тулд түүхийн дурсгалт хот суурингуудын онцлог, үүнтэй холбогдож шийдвэрлэвэл зохих гол зангилаа асуудлыг судлан



Хангайн бүсийг хот, суурины шинэ, хуучин хэв шинжийн харилцан үйлчлэлийн төлөв байдлыг тодорхойлох.

**Хангайн бүсийн хот тосгоны хөгжлийг удирдах ерөнхий чиг хандлага. нэгд.** Хүн амын нутагшил, хот, тосгон, хөдөө аж ахуйн суурингуудын хөгжлийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг тогтоох, **хоёрт.** Хот суурин хөгжүүлэх бодит нөхцөл байдлыг судлах, **гуравт.** Хөгжлийн эрэмбэ өөрчлөгдөх үе шатуудыг тогтоох, **дөрөвт.** Хөгжилтэй холбогдон өөрчлөх үндсэн объектуудыг тогтоох, **тавд.** Хүн амын нутагшлын өөрчлөгдөх хандлагыг гаргаж тавих.

**Хангайн бүсийн хотын орон зайн бүрэлдэн тогтох онолын үндэслэл.** Хот төлөвлөгч нар зах зээлийн үйлдвэрлэлийн нийгэм эдийн засгийн энэ өсөлтөнд зохицуулан хотын орон зайг тодорхойлж амжаагүй байтал хотуудад хүн амын бөөгнөрлийн хямрал гарч эхлэв. Үүний уршгаар хотын барилга байгууламж, барилгажилт хотын зах, хаяа руу тэлсээр урьд өмнө үзэгдээгүй том хот суурины бөөгнөрөл үүсч суурьшлын том, том бүлгэлсэн систем (агломерация) үүсэн бий болж байна.

Хотын орон зайн зохиомж ийнхүү зайлшгүй өөрчлөгдөх болж байгаа нөхцөлд, энэ талаар урьд мөрдсөөр ирсэн ёс жаяг (канон) ийн тухай ярих ч хэрэггүй бөгөөд харин хотын өсөлт хөгжлийн энэхүү үйл явдлын өрнөлтийг загварчлах үндсэн дээр хотын орон зайн байгуулалтын шинэ шийдлийн төсөөллийг урьдчилан тодорхойлох талаар ярих нь амьдралд илүү ойр асуудал болж байна.

Хотын орон зайн байгуулалтын олон зүйл асуудал дотроос ирээдүйд зонхилох үндсэн чиглэлийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга замыг сонгож чадвал нийгмийн хөгжлийн энэ ээдрээтэй процесс ая таатай шийдвэрлэгдэх билээ.

Уран барилгачид, хот байгуулагчид өөрийнхөө бүтээлийг ямагт энэ асуудалтай холбон олон зүйл ажил хийсэн боловч нийгэм эдийн засгийн шинэчлэлтийн энэ хурдацыг гүйцэж хотын орон зайн байгуулалтын хэтийн төлөвийг нь урьдчилан харсан оновчтой загвар одоогоор бий болгож чадаагүй



байна. Иймд хотын архитектур, орон зайн орчны шинэ загварчлалын тухай ойлголт руу түргэн нэвтэх явдал урьдын адил амин чухал асуудал хэвээр байсаар байна.

Хотын орон зайн байгуулалт нь хотын архитектур, орон зайн ирээдүйтэй хэв маягийг эрэн сурвалжлах шинэ төрх байдлыг тодорхойлоход улам бүр чиглэгдэж байна. Энэ үүднээс Хангайн бүсийн хотын орон зайн орчинд хүн амын суурьшил, үйлдвэрлэл, байгаль ашиглалтын элементүүдийг юуны түрүүн оруулах ёстой. Хот байгуулалтын хувьд бидний баримталж ирсэн “Хэсэглэн хуваагаад судлах” арга нь хотын архитектурын орон зайн зохиомжид иж бүрэн хандах асуудлыг үндсэндээ орхигдуулж цаашдын хөгжлийг бодитой тодорхойлох боломжийг алдагдуулж байна. Харин эл асуудлыг бүхлээр нь авч үзсэнээр хот байгуулалтын талаарх олон талт аливаа нөхцөл байдал архитектурын бодит тогтолцоог тогтвортой шийдвэрлэх дотоод чанар нь юуны өмнө илрэн гардаг. Ингэснээр “Ямар учраас” гэдэг уламжлалт асуудал дээр “Ямар зорилготой юуны төлөө тэрхүү бодит чанар нь хадгалагдаж байна вэ?” гэсэн асуудал нэмэгдэнэ. Энэ нь Хангайн бүсийн хотын орон зайн оновчтой орчинг бүрдүүлэх онолын нэг үндсэн хэсэг мөн.

Нөгөө талаар хотын орон зайд урьд өмнө давамгайлж байсан үйлдвэрүүд нийгэм эдийн засгийн шинэчлэлтийн нөлөөгөөр уналтанд орж, орчин үеийн үйлдвэрлэлд цохигдон дараачийн үеийн бүр шинэ үйдвэрлэлд байраа тавьж өгөх замаар шинжлэх ухаан техникийн дэвшил явагдаж эхэллээ. Үүний нөлөөгөөр хүн амын хөдөлмөрийн харьцаанд шинэчлэлт гарч тэр утгаараа хотын хүн амын амьдралын хэв маягт өөрчлөлт оруулна. Үүнтэй зэрэгцэн нийгмийн дэд бүтцэд өөрчлөлт гарч, хотын хүн амын орон сууц нийгмийн үйлчилгээний хүрээ, амралт чөлөөт цагийг өнгөрөөх хэлбэр, шинэчлэгдэнэ.

Ингэж хотын иргэд өмнөхөөсөө илүү үр бүтээл далайцтай бүтээлч хөдөлмөрт орохын тулд нийгмийн хангамжийн нарийн системтэй амьдралын онцгой дэглэмд дадах хэрэгтэй болно. Хотын хүн амын амьдралын энэ шинэ хэв маяг нь Хангайн бүсийн хотын доторхи орон зайн үйл ажиллагааны шинэчлэлд харагдана.



Хүн амын бүтэц дэх энэхүү өрнөлтийн улмаас хүн амын суурьшил үйлдвэрлэлийн хөгжлөө даган бүс нутгийн тогтолцооны зэрэглэлд арга буюу шилжинэ. Чухам ийм зарчмаар Хангайн бүс нутгийн хэмжээнд хотууд хөгжих нь олон талын ач холбогдол бүхий үр дагавартай. Энэ олон талын үр дагавар нь эцэстээ хотын орон зайн нутаг дэвсгэрийн зохиомжид гадны нөлөөлөл болон үйлчилдэг.

Бүс нутгийн хүрээн дэх нутаг дэвсгэр, хотын орон зайн шинэчлэлт нь тэнд байгаа хотуудын хөгжлийн орон зайн зохиомжийн онцлогыг тодотгож өгдөг. Ингэж хотын загварчлалыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж хэрэгжүүлэх нь давуутай байдлыг харуулж байна. Ер нь Хангайн бүсийн хотын загварчлалыг боловсруулахдаа эгэл биетийн эмх замбараагүй хөдөлгөөн, термодинамикийн тодорхой хуулинд захирагддаг гэдгийг тооцоолох учиртай. Иймд термодинамикийн хууль ёсоор шийдэгдсэн хотын орон зайн зохиомжид гарах чанарын өөрчлөлтийг тодорхойлсон орчин үеийн хот байгуулалтын ололтууд нь хот суурин бүхий бүс нутгийн төлөвлөлтийг шийдвэрлэх эхний цэг, үндэслэл болдог.

Энэ эхлэх цэг гэдэг нь тухайн хотын нутаг дэвсгэрт холбогдолгүйгээр барахгүй харин түүний хэлбэр агуулга нь ирээдүйд бүс нутагтай холбоотойгоор хачин маягаар өөрчлөгддөг л хамаг учир нь байдаг. Энэ нь уг чанартаа өөрийн гэсэн тодорхой хэлбэрийн тогтворыг хадгалсан тийм орон зайн нутаг дэвсгэрийн хүчин зүйл асуудал байдаг.

Хотын орон зайн зохиомж нь Хангайн бүс нутгийн холбогдолтой болоод ирэхээр (гол төлөв хүн амыг хот өөртөө татах замаар) нутаг дэвсгэр төлөвлөлт орон зайн архитектурын хувьд өөр хэв шинжийг бий болгоно. Өөрөөр хэлбэл орон зайн шинэчлэлт нь хотын архитектур зохиомжийн янз бүрийн эхлэлтийн урьдчилсан нөхцөлд нутаг дэвсгэрийн тогтвортой байдлын нөхцөл байдал ирээдүйг тодорхойлно. Энэ урьдчилсан нөхцөл нь оршин суугчид, хүн амыг өөртөө татдаг хотын объектууд, нутаг дэвсгэрт төвлөрсөн байрлахдаа орон зайн хувьсгалын нэг чиглэлийн траектори болсон мэтээр төвлөрсөн байх үзүүлэлт юм.



Хангайн бүсийн хотын орон зайн төлөвлөлтийн энэхүү үндсэн зарчмыг уламжлан хэргэлэх нь шинжлэх ухааны аргын хувьд дараах алхам хийх боломжийг өгч байна. Энэ нь бүс нутгийн хөгжлийн ерөнхий дүгнэлтээс хийсэн тодорхойлолтыг үндэслэн орон зайн зохиомжоороо адил төстэй нэг төвтэй хотын гадна байгаа орон зайн орчин гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөлтийг боловсруулна гэсэн хэрэг. Ингэснээрээ хот нь орон зайн хөгжлийн нэгдмэл орчин биш харин “Бүс нутаг-хот-төв” гэсэн харилцан холбоотой суурин газрын нутаг дэвсгэр орон зайн нэгдмэл систем болно.

Шинэ том хотын орон зайг харьцангуй бие даасан байдалд загварчлахаас бүс нутагт хамааралтай суурин газрын нэгдсэн системд оруулж шийдэх нь зөв байдаг энэ нь хотуудын нутаг дэвсгэрийн бүсчилсэн төлөвлөлтийн зарчмыг хайхрахгүй орхино гэсэн хэрэг биш. Харин том хот гэдэг нь хэзээд бүс нутгийн төлөвлөлтийн нэгэн адил олон жижиг суурин газруудын системүүдийн нэгдсэн төв мөн гэдгийг тооцож байх учиртай.

Шинэ хот нь бүс нутгийн хөгжлийн дотоод, гадаад бүхий л шинж чанар, үйл ажиллагааг хадгалж байдаг. Ийм учраас бүс нутгийн төв болон том хот бүхий суурин цэгүүдийн төлөвлөлтийг нэгдсэн ерөнхий зарчимтай болгох нь эцэстээ тэдгээрийн хоорондын харилцан уялдааг хангасан оновчтой шийдэл юм.

Бүс нутгийн хүрээнд байгаа жижиг хот суурины бүтцийг ялгаж тодорхойлоход бэрхтэй. Харин том хотын орон зайн бүтцийн нэгдмэл чанар нь дэд бүс нутгийн цагираг хэлбэрээр оршин тогтнодог. Том хот төвтэй орон зайн ийм нутаг дэвсгэрт хилийн бүтэц л зонхилох элемент болдог байна.

Бүс нутгийн хот суурины хүрээлэлийг орон зайн бүтцийн нэгдмэл байдал нь хотын орон зайн зохиомжийг нутаг дэвсгэрийн тухайн онцлогт нь тохируулан харьцангуй уян байдлаар загварчлах боломж олгоно.

Бүс нутгийн хотын орон зайн орчин нэгдэж бүсэд байрлах хотуудын орон зайн бүтцийг үүсгэдэг. Бүсийн хотуудын орон зайн бүтцийн хөгжил нь нийгэм, эдийн засгийн процессыг хотын орон зайд зохицуулан зохион байгуулж байршуулах хэлбэрээр илэрдэг. Үүнд: хотын өсөлт, түүний орон зайн



дифференциаци, үүрэгчлэл, интеграци зэрэг хамрагдана. Хотын орон зайн бүтэц ерөнхий байдлаараа орон сууцны, үйлдвэрийн зэрэг олон талт хүчин зүйл объектууд цувран хотын орон зайн үүрэгчлэлийн тэнхлэгийн дагуу байрлах, эсвэл хотын төвийн орчинтой хослон байрласан хэлбэрээр байж болно.

Хотын хөгжлийн явцад ийнхүү нөлөөлөх төвийн хэсгийн шинэчлэл төлөвлөлтийн чиглэлд тодорхойлсонтойгоо нэгэн адил тогтвортой байна.

Өөрчлөн байгуулалтын үе шат улам бүр ач холбогдолтой болж, хотын нутаг дэвсгэр тэлэхийн хэрээр хотын бүсийн хязгаар төвөөс зугтах мэтээр эрчимтэй шилжиж байна. Шинэ барилга байгуулалтын дүүргийг төлөвлөхөд /барилга барих дараалал, бөөгнөрөл/ нийгмийн захиалгад тулгуурлах нь чухал байдаг. Харин үүний зэрэгцээ хуучин барилга байгууламжийг сэргээн засварлах асуудал зайлшгүй нь тодорхой, мөн хот байгуулалтын явцад хуучин барилга байгууламжийг шинэ шалтгаанаар шинэчлэнэ. Үүнээс үүсэх генетикийн кодыг нь ойлгохын тулд нөхцөл байдалд нь тохируулж шинэчлэн сайжруулах, сэлбэн шинэтгэх тусам ихээхэн бэрхшээл учирах болж байгааг анхаарч ойлгон хандах нь чухал.

Шинэ хотын архитектур нь үндэсний өвөрмөц хэллэгтэй үндэсний уран сайхны дүр бүтээх өөрийн арга хэрэглүүртэй байх ёстой. Манай архитекторуудын туурвисан хотын архитектурын бүх бүтээлүүд нь орон зайн байгууламж Монгол хүний үйл ажиллагаагаар бий болсон зохиомол орчин болох бөгөөд энд: **нэгд**. Хот бүрдүүлэгч барилга байгууламжууд, **хоёрт**. Сайтар зохион байгуулагдсан нээлттэй орон зай, **гуравт**. Тухайн орон зайг зохион байгуулахад идэвхитэй оролцож буй байгууламжууд орчны ландшафт бүгд хамрагдана.

Иймд Хангайн бүсийн шинэ Монгол хотын зохион байгуулалтыг илэрхийлэх гол дүрслэх хэрэгсэл нь Монгол үндэсний байгууламжийн тогтолцоо, түүний цар хэмжээ, эзэлхүүн, орон зайн хэлбэр байх ёстой. Хангайн бүсэд шинээр барих Монгол хотын архитектурын байгууламж, цогцолборын хэмжээ, эзэлхүүн өөрийн гэсэн бараа сүүдэр онцлог хэлбэртэй байна. Иймд энэ хотын архитектур орон зайн





төлөвлөлтийн онол арга зүйн зохион байгуулалт уран сайхны хэлбэрээрээ дараах хэд хэдэн зарчмаар илэрхийлэгдэнэ гэж үзэж байна. Үүнд:

**Нэгд.** Хот суурины барилга байгууламжийн архитектурын зохиомж болох барилгын ерөнхий эзэлхүүн, хэлбэр хэмжээ, орон зай, түүний цулын байгууламж, хэлбэр нь (төвийн хэсэг нь) үндэсний төрхтэй байна.

**Хоёрт.** Шинэ хотын архитектурын зохиомжийн засал, гоёл чимэглэл нь уран хийцийн үндэсний утгыг илэрхийлэхээр байх ёстой. Энэ утгаараа гоёл чимэглэл нь Монгол архитектурын зохиомжийг улам төгөлдөржүүлэн, тодотгож түүний дүрийг улам яруу тод, шинжтэй болгон масштаб хэмжээг нь илэрхийлнэ. Энэ нь түүний бараа сүүдэр /силуэт/, айзам хэмжээгээр /пропорц/ хэмжигдэнэ.

**Гуравт.** Шинэ хотын орон зайн зохиомж нь байгалийн бүрэн хараат байдлаас ангижирсан Монгол хүний үйл ажиллагаагаар бий болж хотжсон амьд байгаль барилга байгууламжийн харьцаагаар илэрхийлэгдсэн урлаг уран сайхны зохиомол орчин байна.

Шинэ хот байгуулалтын үр дүн нь архитектурын орчин үеийн зохиомжийг бий болгох ёстой. Онолын энэ үндсийг баримтлан Шинэ хот суурины оршин тогтнох үндсийн үндэс учир нөхцлийг тооцоолон архитектурынх нь хөгжлийн чиглэлийг сонгоно. Ингэснээр Шинэ хотын архитектурт шинэ чиглэл, шинэ хийц бүтээц бий болгоход нөлөөлнө. Шинэ хотын орон зайн зохиомжид зөвхөн архитектурын хэлбэр биш, тэрхүү хэлбэрийн эзэлхүүн, тэгш хэмнэл, айзам хэмнэл харьцаа, зохиомж зэрэг дүрслэлийн утга, үзэгдэх шинжийг тодорхойлох бодлиг биет байдал хамрагдана гэж тооцоолно.

Шинэ хотын архитектур тоо хэмжээний харьцаа тэгш хэмээр илэрхийлэгдэх ёстой. Үүний үр дүнд Шинэ хот сууринд байх барилгын цул биеийг бодлиг тэгш сайхан болгож төгсгөлгүй үргэлжлэх хөдөлгөөнийг үгүйсгэж улмаар хөдөлбөргүй бат тогтвор суурьшлыг бий болгоно. Гэхдээ энэ нь маш уян хатан байх учиртай.

Ингэснээрээ Шинэ архитектур гоо сайхны эх булаг болж, уран цогцос, гоо сайхны зохист чанарыг бүрдүүлнэ гэж үзнэ. Гэхдээ Монгол архитектурт тэгш





хэмийн хуулийг баримтлахгүй байж болно. Ингэснээр Шинэ хотын архитектурын байгууламжийг ер бусын чөлөөтэй, хөдлөлтэй болгож, орон зай, байгаль, орчинтой уялдуулах нөхцлийг хангаж чадна гэж үзэж байна.

Шинэ хот суурины архитектурын хэмнэл /ритм/ нь тухайн байгууламж барилгыг улам бодлиг, сэтгэл татахуйц болгохоор байна. Тэгснээр Монголын үндэсний онцлогыг уран сайхнаар тусгаж, төлөвлөлтийн тэгш хэмийн хууль буюу бодит байдалд зохицуулан үндэсний хэлбэртэй архитектурын байгууламжийг бүрдүүлж хотын архитектурын чуулбарыг /ансамблийг/ бий болгоно.

Үүний үр дүнд Монгол архитектурын чуулбараас, бүрдсэн бүхэл бүтэн хотын зохиомж нь сая нэгдмэл амьд бие махбодь болно. Хот бүрдүүлэгч бүх хэсгүүд нь өөр хоорондоо зохицсон айзам хэмнэлтэй байх болно.

Үүний үр дүнд Шинэ хотын архитектурын харьцаа, айзам хэмнэл нь үндэсний архитектурын дүрийг бүтээсэн чухал хэрэглүүр болж чадна.

Шинэ хотын архитектурын хийц, бүтээцийн холбоо, цогц дүрийг илэрхийлэх айзам хэмнэлийг тогтоохдоо монгол хүний биеийн өндрийн харьцааг байшин барилгын хэмжээнд шилжүүлэн тодорхойлох ёстой. Тэгснээр Монгол архитектурын шинэ хэлбэрийг бий болгох, монгол барилга байгууламжийн эх бие, цулын тогтолцоо, уран барилгын хэв шинж бүрэлдэн тогтох нөхцлийг бүрэлдүүлнэ.

### **Шинэ хотын хот байгуулалтын судалгааг гурван төвшнөөр ангилж үзнэ.**

**Нэгдүгээрт:** Сонгосон төслийн шийдлийг тодорхойлж бодит нөхцөлд тулгуурлах.

**Хоёрдугаарт:** Монголын үндэсний хотын хөгжлийн чиглэл хэв шинжийн шийдлийг үндэс болгож, хот байгуулалтын орон зайн зохион байгуулалтын ерөнхий зүй тогтлыг гаргах.

**Гуравдугаарт:** Хот байгуулалтын маш өндөр түвшинд зохион байгуулах хотын загвар, арга зүйг тогтоох.



## **ГУРАВ. ХОТ СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТ, АРХИТЕКТУРЫН ТАЛААР СУДЛАГДСАН БАЙДАЛ.**

### **3.1. Монгол улсын бүс нутгуудын түвшинд хот суурин газруудын ангилал, зэрэглэл, хөгжлийн асуудлыг судалсан байдал**

Өнөөдрийг хүртэл Монгол улсын хот суурин газруудыг бүс нутгийн түвшинд тэдгээрийн уялдаа холбоонд нь, системийн хандлагад тулгуурлан цогцолбор байдлаар судалсан судалгаа шинжилгээний ажлын үр дүнд нэн ховор байна. Харин хот суурины эртний болон өнөөгийн түүх, архитектурын судалгааны холбогдолтой бүтээлүүд /Пэрлээ Х. /1961//, Майдар Д. /1970/, Хайсамбуу Д./2001/, Даажав.Б, Жаргалсайхан Р. /1994/, Төмөрбаатар Д./1971/ зонхилж байгаа юм. Тухайлвал Х.Пэрлээ /1961/ эртний түүхийн уг сурвалжууд болон сүүлийн үеийн археологийн судалгааны материалд үндэслэн Монголын эртний ба дундат зууны үеийн археологийн судалгааны материалд үндэслэн Моголын эртний ба дундад зууны үеийн хот суурин газруудын тухай үнэ цэнэтэй дүгнэлтүүдийг хийсэн байна. Д.Майдар /1970/ хувьсгалын өмнөх суурин газрууд, тэдгээрийн байршил болон эрт дээр үеэс эдүгээ хүртэлх монголын архитектур хот байгуулалтын түүх өвөрмөц онцлогийг тодорхойлжээ. Р.Жаргалсайхан монголын хотжилтын үйл явцыг 1).1911-1934 оны үе, 2).1934-1960 оны үе, 3).1960-1990 оны үе, 4). 1990 оноос хойш гэсэн 4 үед хувааж үе тус бүрийн тодорхойлолтыг өгсөн байна.

Үүний зэрэгцээ тодорхой нэг хот суурин газрын тухай зарим бүтээл Пүрэвжав С. /1961/, Дүгэрсүрэн Л./1968/ хэвлэгдсэн байна.

Дээр дурьдсан бүтээлүүдийг бүхэлд нь авч үзвэл манай улсын хот суурин газруудын түүх, архитектурын онцлог болон тодорхой зарим нэг хотын хөгжлийн асуудлуудыг түлхүү авч үзсэн байна гэсэн дүгнэлтийг хийж болно.

Бүс нутгийн хот суурин газруудын холбогдолтой цөөн ч гэсэн судалгааны ажил хийгдсэнийг бас дурьдах нь зүйтэй юм. Тухайлбал М.Баянтөр “БНМАУ-ын хот суурингийн газар зүй” /1973/ бүтээлдээ тухайн үеийн Монгол улсын хот суурингийн хэмжээний ангилал, үүргийн бүтэц ба хэв шинжийн ангилал, газар зүйн байрлалын ангилал зэргийг анх удаа харьцангуй цогцолбор байдлаар хөндсөн



байна. Энэ эрдэмтэн манай улсын хот суурин газруудын хүн амын 1956-1969 оны хоорондох өсөлтөнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тэдгээрийг бага хот /10 мян хүртэл хүн амтай/, дунд зэргийн хот /10-100 мян.хүн амтай/, том хот /100 мянгаас олон хүн амтай/ гэж 3 ангилсан байна. /Баянтөр М./1986//

Академич Б.Гунгаадаш Монгол улсны хот суурин газруудыг том хот /100 мянгаас олон хүн амтай/, томхон хот /20-100 мянган хүн амтай/, жижиг хот /10-10 мянган хүн амтай/, гэж ангилж тодорхойлолт өгсөн байна. /Гунгаадаш Б. /1986//.

Дэд бүтцийн хөгжлийн яамны Зураг төсөл, судалгааны үндэсний төвөөс боловсруулсан “Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөл”-д манай улсын хот тогоны газрын ангилал, томоохон хотуудын хөгжлийн хэтийн төлөвийг бүлэг суурингийн тогтолцоонд үндэслэн тодорхойлсон байна /Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөл, Улаанбаатар 1996, Х. 108-139/. ЗХУ /хуучин нэрээр/-д 1960-аад оноос район төлөвлөлт, хот байгуулалтын холбогдолтой судалгаа шинжилгээний ажил, ном бүтээлүүдэд /Районная планировка. Справочник проектировщика, 1986. гм/ хот суурины сүлжээг бүлэг суурингийн тогтолцоонд тулгуурлан ангилах хандлага байв. Гэвч цөөнгүй судлаачид бүлэг суурингийн тогтолцоо нь хот суурин газруудын чанарын ялгааг тооцдоггүй учир дутагдалтай /Питюренко Е.Н /1984/ бусад/ гэж үзэж байсан одоо ч хэвээрээ байгаа юм. Нөгөө талаар Мянганы зам тавих болсонтой уялдаж Ховд, Улиастай, Арвайхээр, Улаабаатар, Чойбалсан гэсэн 5 томоохон төв байхаар хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөлд тусгасан зорилтыг дахин хянаж үзэх шаардлага ч гарч байна.


Сүүлийн жилүүдэд Барилга-Архитектур Корпорацид шинжлэх ухааны доктор Д.Хайсамбуугийн удирдлагаар хэрэгжүүлсэн “Архитектур хот байгуулалт-1”, “Архитектур хот байгуулалт-2”, төслийн хүрээнд Монгол улсын хот суурины үүсэл хөгжил тэдгээрийн үе шатууд, хот суурины архитектур орон зайн төлөвлөлтийн бүтэц, нэр төрөл, хэв шинжийн ангиллыг судалснаас гадна Монгол улсын хүн амын нутагшилтын тогтолцоон дахь хот суурины байршил, үүрэг, нөлөөллийг судалсан байна.



**Судалгаанаас үзэхэд:** Бүс нутаг төлөвлөлт, газар ашиглалт, хот суурин байгуулалт, байгаль газар зүйн онцлог, хүн амын бөөгнөрөл, барилгын материал, түүхий эд, улс орны нийгэм эдийн засгийн хөгжил зэргээс шууд хамааралтайгаар Монгол улсын хүн амын нутагшилтын өнөөдөр байгаа бодит тогтолцоо биелэлээ олж иржээ гэдэг нь харагдаж байна.

Монгол улсын хүн амын өнөөгийн нутагшилт нь Монгол орны газар нутаг, байгалийн нөхцөл, нөөцтэй уялдсан хүний ажиллах (8 дугаар зураг) амьдрах хэвийн орчин боломжийн түвшинд бүрдсэн хүн амын уламжлалт нүүдлийн болон суурин соёл иргэншлийн хэвшлийн амьдралын зохистой харьцаа бүхий орон нутагт хот суурингаас бүрдэж байна.

### МОНГОЛЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТЫН СИСТЕМ



8 дугаар зураг.



**Монгол улсын хот байгуулалтын хөгжлийн үе шат:** Үндэсний нийт орлогын 90 хувийг нүүдлийн мал аж ахуйд тулгуурлан үйлдвэрлэдэг байсан хувьсгалын өмнөх 1920 онд монгол оронд шашин, хурал номын болон орон нутгийн хошууны засаг захиргааны удирдлага, худалдаа арилжаа, төвлөрсөн цөөн хүн амтай хүрээ маягийн суурингууд байсан бөгөөд тэдгээрийн эрхэлдэг хот байгуулалтын үйл ажиллагаа нь нэгд. Нийгэм улс төрийн , хоёрд. Шашны, гуравд. Худалдаа арилжааны, дөрөвд. Цэрэг хамгаалалтын үүрэг зориулалттай өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн бус үйл ажиллагааг явуулдаг байжээ.

Хувьсгалын өмнөх монгол улсын нутаг дэвгэр дээр оршиж байсан суурьшмал амьдралтай эдгээр суурингуудыг судалгаанд тулгуулан дараах хэв шинжид хамааруулан үзэж байна. Үүнд:

**Нэг.** Богд хаант монгол улсын нийгэм-улс төр, шашны төв бөгөөд 1639 онд Өргөө нэртэйгээр Өвөрхангай аймгийн Ширээ Цагаан нуур гэдэг газар тэр үеийн монгол улсын шашин, нийгэм улс төрийн төв болон хүрээ зохион байгуулалттай баригдсан Их хүрээ, Да хүрээ, Богдын хүрээ Нийслэл хүрээ /1911/ гэж нэрлэгдэж ирсэн Их хүрээ. Их хүрээ нь хүн амын тоо тус орны нийгэм-улс төрийн амьдралд эзлэх байр сууриараа онцгой үүрэгтэй байсан.

**Хоёр.** Цэрэг – нийгэм –улс төр – худалдааны төвлөрсөн суурин буюу Цайз бэхлэлт –худалдааны хот. /Ховд, Улиастай, Эрдэнэ-зуу/

**Гурав.** Шашин, нийгэм –улс төр соёлын төв болон шашны хурал номын 750 гаруй том жижиг Сүм-хийд /Хархорин, Амарбаясгалант, Тариатын хүрээ, Бэрээвэн хийд г.м/

**Дөрөв.** Аймаг хошуу нутгийн засаг захиргааны удирдлага гадаадын худалдаачид, томоохон сүм хийдүүд төвлөрсөн Хүрээ-суурин эдгээр болно.



Манай улсад суурьшмал соёл иргэншлийн үндсэн хэв шинж хот суурин хөгжиж ирсэн үе шатыг дараах үечлэлээр тогтоож байна. Үүнд:

Нэгдүгээр үе 1911-1934

Хоёрдугаар үе 1934-1960

Гуравдугаар үе 1960-аас хойш

**Нэгдүгээр үе буюу 1911-1934 он.** Тусгаар тогтносон Богд хаант монгол улс байгуулагдсан 1911 оноос 1921 оны ардын хувьсгал хүртэл манай улсад Их хүрээ, Цэрэг нийгэм –улс төр, худалдаа төвлөрсөн цайз бэхлэлт худалдааны **Ховд, Улиастай, Эрдэнэ Зуу, Хиагт хот**, Шашин, Нийгэм Улстөр соёлын томоохон төв **Хархорин, Амарбаясгалант хийд, Тариалтын хүрээ, Бэрээвэн хийд** зэрэг хот суурин байсан.

**Хоёрдугаар үе шат буюу 1934-1960 он.** Манай улсын хот байгуулалтын хөгжлийн дараагийн үе шат нь 1934-1960 оныг хамрах бөгөөд энэ үеийн гол онцлог нь манай үндэсний аж үйлдвэрийн суурь анх тавигдсан Улаанбаатар хотод аж үйлдвэрийн ууган комбинат, нэгдүгээр цахилгаан станц, Хатгалын ноос угаах фабрик зэрэг түүхэн барилга байгууламжууд баригдсан нь үндэсний ажилчин анги үүсэж бий болж тэдний соёл боловсрол, орон сууц, ахуй хангамж нийтийн үйлчилгээг орчин үеийн хот байгуулалтын төвшинд шийдвэрлэн нутаг дэвсгэрийн орон зайд шинэ бүтэц материаллаг өвөрмөц орчныг бий болгох шинэ зорилт тулгарснаар манай улсын хот байгуулалтын хөгжилтөд чанарын бас нэг цоо шинэ үе эхэлснийг тодорхойлсон юм.

Манай улсын хот байгуулалтын түүхэнд 1934-1960 оны хооронд хөнгөн хүнсний болон уул уурхайн аж үйлдвэр хөгжсөн улсын зэрэглэлтэй томоохон хот суурингууд шинээр бий болоогүй бөгөөд энэ нь манай улсын эдийн засаг үйлдвэрлэх хүчний хөгжлийн төвшинг илэрхийлсэн манай орны нийгэм улс төрийн дотоод үйл ажиллагааны онцлогтой холбоотой.

**Гуравдугаар үе буюу 1960-1994 он.** 1960 оноос хойш манай улсын хот байгуулалтын хөгжилд 1960 оноос гарсан нэг чухал үйл явц бол хотжилт юм. Энэ





үе 1960 онд манай улсад социалист үйлдвэрлэлийн харьцаа бүрэн тогтсоноор улс орныг хөдөө аж ахуйн орноос ХАА –Аж үйлдвэрийн улмаар Аж үйлдвэр –ХАА орон болгон хөгжүүлэх чухал зорилт тавигдсан түүхэн үеийн хот байгуулалт хотжилтын хөгжлийн онцлог үе юм.

Манай улсад хот суурин газруудыг хэтийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр системтэй хөгжүүлэх асуудал үндсэндээ 1950-иад оны дунд үеэс эхэлсэн байна. 1958-1962 оны хооронд хот суурин бүрийн барилгажилтын баримжаалсан тойм зураг зохиожээ. 1965 оноос энэ ажлын хоёрдогч үе шат эхэлж хот суурины ерөнхий төлөвлөгөөг геологи, геодезийн хайгуул, эдийн засгийн тооцоо судалгааны үндсэн дээр боловсруулах болж зохион байгуулалт боловсон хүчний хувьд нэлээд бэхэжсэн байна. Үүний үр дүнд өнөөдөр манай Улаанбаатар хот болон аж үйлдвэрийн томоохон хотууд аймгийн төв, хотууд, нийтдээ харин сум хот маягийн суурин газрын 85 орчим хувь нь ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж байна. Эдгээр ерөнхий төлөвлөгөөг зохиохдоо 1958 оноос хойш боловсруулсан хот байгуулалтын онолын норматив баримт бичигт тулгуурласан юм.

Хот суурингийн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажуулах үйл ажиллагаа манай оронд ийнхүү идэвхжиж эхэлснээр хотын хүн ам байнга аж төрдөг суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийг сургууль, цэцэрлэг, соёл ахуй үйлчилгээний хамт орон сууцны хорооллын системээр барилгажуулах хот байгуулалтын зарчмыг хэрэгжүүлэх үндэс суурь тавигдаж улмаар Улаанбаатар хотын орон сууцны анхны хорооллууд 40,50 мянгат /1956-1962/, 12, 15, 19-р хороолол /1962-1967/, 1, 3, 4, 5, 6, 10, 11, 13-р хороолол зэрэг орон сууцны нийт 17 хороолол барьж байгуулсан байна.

Дархан, Чойбалсан хотуудад 5-9 давхар барилгатай орон сууцны иж бүрэн 13 хороолол, Зайсан дахь Зөвлөлтийн дайчдын хөшөө, Лениний музей, Хувьсгалын музейн цогцолбор, Шинжлэх ухаан техникийн ордон, Үйлдвэрчний эвлэлүүдийн ордон, Хүүхдийн театр, Пионерийн ордон, Идэр техникчдын ордон, Гэрлэх ёслолын ордон, Хүүхдийн төв цэцэрлэгт хүрээлэн, Зөвлөлтийн шинжлэх ухаан техникийн ордон зэрэг олон зуун барилга объект баригдаж ашиглалтад орсон байна.



Энэ хугацаанд Өмнөговийн Гурван тэс, Төв аймгийн Өндөрширээт, Булганы Улаантолгойт, Сансарын сангийн аж ахуй зэрэг 160 гаруй сум, суурин газар Монгол улсын хот байгуулалт, Архитектурын түүхэнд бодитой байр суурь эзэлдэг Дархан хот, уул уурхайн үйлдвэрийн Эрдэнэт, Багануур хотууд олон улсын тусламжаар баригдаж ашиглалтад орсон байна.

## **ДӨРӨВ. ХАНГАЙН БҮСИЙН ХОТ, СУУРИНЫ ҮҮРЭГ, ЗЭРЭГЛЭЛ, ХӨГЖЛИЙГ СУДЛАХ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ**

### **4.1. Анхдагч мэдээ материал бүрдүүлэх талаар**

Хангайн бүсийн түвшинд хот суурин газруудын ангилал, зэрэглэл, хөгжлийн асуудлуудыг судлах талаар олонхи эрдэмтэд судлаачдын баримталж буй онол арга зүйн хандлага, түүнчлэн бүс нутгийн хот суурин газруудын хөгжил барйшлын өвөрмөц байдал зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг тооцож дүн шинжилгээ хийж үзэхэд дараах аргачлалаар судлах нь зүйтэй байгаа юм. Үүнд:

- Монгол Улсын нийт хот суурины ангилал зэрэглэлтэй уялдсан Хангайн бүсийн хот суурины байршил, хэв шинж, ангилал зэрэглэл, судалгаа боловсруулалт (2010.XII)
- Хангайн бүсийн нийгэм эдийн засгийн өнөөгийн бодит байдал цаашдын хөгжлийн чиг хандлагын судалгаа, боловсруулалт (2010.XII)
- Хангайн бүсийн хот суурины хот байгуулалт, төлөвлөлтийн хүрсэн түвшинд тулгуурлан бүсийн тулгуур төв “Хар хорин” хотыг барьж байгуулах үндэслэл арга технологи, судалгаа (2011.VI)
- Хангайн бүсийн хот суурины хот байгуулалт, төлөвлөлтийн хүрсэн түвшинд тулгуурлан бүсийн тулгуур төв “Хар хорин” хотыг барьж байгуулах үндэслэл арга технологи, судалгаа (2011.VI)
- Эдийн засгийн Хангайн бүсийн нутаг дэвсгэр, байгаль газар зүйн түвшний үнэлгээ судалгаа, дүгнэлт (2011.VIII)





- Эдийн засгийн Хангайн бүсийн хот суурины төлөвлөлт, байгуулалт барилгажилтын түвшний үнэлгээ, дүгнэлт судалгаа, (2011.XII)
- Эдийн засгийн Хангайн бүсийн эрдэс түүхий эдийн нөөцийн судалгаа, үнэлгээ (2011.XII)
- Хангайн бүсийн эрдэс түүхий эдийг хот суурины хөгжилд ашиглах судалгаа, боловсруулалт (2011.XII)
- Хар хорин хотыг хөгжүүлж, Орхоны хөндийд улсын зэрэглэлтэй бүсийн тулгуур шинэ төв хот байгуулах хот төлөвлөлтийн монгол загвар, түүнийг боловсруулах үндэсний норм, зураг схем, тооцоо (2012.XII)

1. Хангайн бүсийн хот суурин газруудын ангилал зэрэглэл, хөгжлийн асуудлуудыг судлахад шаардлагатай дараах анхдагч мэдээ материалыг 2010 оны IY-XII сард бүрдүүлнэ. Үүнд:

- Хангайн бүсийн хот суурины нутаг дэвсгэрийн байгаль экологийн хүчин зүйл асуудлууд
- Хангайн бүсийн хот суурины нийгэм эдийн засгийн хүчин зүйл асуудлууд
- Хангайн бүсийн хот, хот орчмын бүсийн хот байгуулалт архитектур орон зайн төлөвлөлт, ландшафтын хүчин зүйл асуудлууд

Дээрх мэдээ материалыг суурин аргаар шинэ хотод холбогдох Яамд газрууд болон номын сан, архивуудад, судалгааны аргаар судлан бүрдүүлэх болно.

#### **4.2. Анхдагч мэдээ материал боловсруулах талаар**

Бүрдүүлсэн анхдагч мэдээ материалын зарим хэсгийг дараах байдлаар боловсруулна. Үүнд:

**А.** Хангайн бүсийн хот суурин газруудын энгийн ангилал боловсруулах зорилгоор анхдагч мэдээ материалд дараах байдлаар боловсруулалт хийнэ.



1. Бүсийн хот суурин газруудын хүн амын тоог хүн амын өсөлтийн прогноз хийдэг аргыг хэрэглэн боловсруулж ойрын 20 жилд Хангайн бүсийн хот суурин газруудын хүн амын тооны боломжит өсөлтийг тодорхойлно.

Үүний дараа бүс бүрийн хүн амын байршил, бөөгнөрлийг тоон утгаар илэрхийлнэ. Ингэхдээ дараах томъёог хэрэглэнэ. Үүнд:

$$K = \frac{П_U}{П} \quad (3)$$

$K$  - бөөгнөрлийн коэффициент

$П_U$  - хүн амын нягтшитын хамгийн их утга

$П$  - тухайн бүсийн хүн амын нягтшилт

Хот суурин газруудын хүн амын өсөлтийн хэтийн төлөв, /прогноз/ болон бүс бүрийн хүн амын бөөгнөрлийн коэффициентийг ашиглан зураг зохиож тайлбар бичнэ.

Мөн хүн амын хувьд тэргүүлэх үүрэгтэй байгаа хот суурин газрыг тодорхойлно. Ингэхдээ дараах томъёог хэргэлэнэ. Үүнд:

$$U_T = \frac{P_m}{\sum P_i} \quad (4)$$

$U_T$  - тэргүүлэх зэргийн хотын индекс

$P_T$  - том хотын хүн ам

$P_i$  - хотын хүн ам

2. Бүсийн хот суурин газрууд тус бүрийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгнө. Ингэхдээ тухайн хот суурин газрын аж үйлдвэрийн хөгжлийн коэффициентийг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$K_U = \frac{П_б}{П_c} \quad (5)$$

$K_U$  – аж үйлдвэрийн хөгжлийн коэффициент

$П_б$  – бүсийн аж үйлдвэрт тухайн салбарын эзлэх хувь



$P_c$  – улсын хэмжээнд тухайн салбарын эзлэх хувь

Аж үйлдвэрийн тухайн салбарын хөгжлийн коэффициент 1-ээс их утгатай байвал уул салбарыг уул хот суурин газрын тэргүүлэх салбарт тооцно.

3. Хангайн бүсийн хот суурин газруудын үйлдвэрлэлийн дэд бүтцийн /эрчим хүч, зам тээвэр г.м/ хөгжлийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, хэтийн төлөвийг тодорхойлно. **Ингэхдээ дараах тооцооллыг хийнэ. Үүнд:**

**А.** Цахилгаан дамжуулах шугамтай холбогдсон байдал, эрчим хүчний эх үүсвэр, мөн тэдгээрээс алслагдсан байдлыг хот суурин газар бүрт зориулан баллаар эсвэл коэффициентоор үнэлнэ. Тайлбар бичлэг хийнэ.

**Б.** Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийг дараах томъёогоор илрүүлнэ. Үүнд:

$$D_x = \frac{L}{\sqrt[3]{SPQ}} \quad (6)$$

$D_x$  - төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн коэффициент

$L$  - төрөл бүрийн замын шилжүүлсэн урт /шилжүүлсэн уртыг тооцохдоо 1 км сайн хатуу хучилттай авто замыг 0,45 км төмөр замтай, 1 км ердийн хатуу хучилттай авто замыг 0,15 км төмөр замтай, 1 км хөрсөн замыг 0,01 км төмөр замтай, 1 км жижиг голын усан замыг 0,01 км төмөр замтай тус тус тэнцэнэ гэж үзнэ/

$S$  - Нутаг дэвсгэрийн талбай

$P$  - Хүн амын тоо

$Q$  - үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ

Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээг бүсийн аймаг, бичил бүсүүдээр илрүүлнэ.

УИХ-аар баталсан дэд бүтцийн үндсэн /мянганы зам г.м/ болон салбар тэнхлэгүүд тухайн хот суурин газрын байршлыг харьцуулан чанарын /бичлэгээр/ үнэлгээ өгнө.



4. Хангайн бүсийн хот суурин газруудын нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээний объектуудын хөгжлийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, хэтийн төлөвийг нь тодорхойлно. Ингэхдээ хүн амын тоо, насны бүтцийн өөрчлөлт, өсөлт зэрэгт тулгуурлан эрүүл мэнд, боловсрол, соёл г.м үйлчилгээний хэрэгцээг коэффициентлон үнэлнэ.

5. МАА-н гаралтай түүхий эд бэлтгэлийн чадавхийг аймаг сумдаар тооцоолон гаргаж коэффициентлон үнэлнэ. МАА-н гаралтай түүхий эдэд суурилсан жижиг дунд үйлдвэр хөгжих боломжоор хот суурин газрыг ангилан коэффициентлож, тодорхойлолт өгч бичлэг хийнэ.

6. Хангайн бүсийн эрдэс түүхий эдийн нөөц, байршилд аймгуудын түвшинд үнэлгээ өгч, хот суурин газруудын хөгжлийн хэтийн төлөвт нөлөөлөх байдлыг нь тодорхойлно. Шинээр хот суурин газрууд бий болох боломжийг үнэлнэ. Эрдэс түүхий эд ашиглах боломжийг бүсчлэн илрүүлж, бичил бүс бүрийн боломжийг тоон утгаар /коэффициентоор/ илрүүлнэ.

7. Хангайн бүсийн хот суурин газруудын инженер геологийн нөхцөлд үнэлгээ өгнө. Ингэхдээ хот хот суурин газар тус бүрийн нутаг дэвсгэрийн хөрсөн бүрхэвч, агаар хөдлөлтийн байдал, усан хангамж, геоморфологийн нөхцөл, хот сууринг өргөтгөх боломж зэргийг баллан үнэлж тодорхойлолт өгч бичлэг хийнэ.

8. Хангайн бүсийн хот суурин газрууд тус бүрийн түүх соёлын ач холбогдлыг үнэлж тайлбар бичлэг хийнэ. **Ингэхдээ дараах томъёог хэрэглэнэ. Үүнд:**

$$K = \frac{\sum \Pi}{S_{tu}} \quad (7)$$

$K$ -түүх соёлын ач холбогдлын коэффициент

$\Pi$ - бүх хэв шинжийн түүх-соёлын дурсгалт зүйлсийн нийлбэр

$S_{tu}$ -хот суурин газрын талбай/түүхэн хил хязгаараар км<sup>2</sup>/

9. Хангайн бүсийн хот суурин газруудын гадаад хамтын ажиллагааны ач холбогдлыг үнэлж тайлбар бичлэг хийнэ. Ингэхдээ аймгийн төв, томоохон суурин газруудын экспорт, импортын үйл ажиллагааны тодорхойлолтыг өгнө. Улсын



хилийн боомт, гарцуудын нэг жилийн хугацаанд оруулж гаргасан бараа таваар, түүхий эдийн нэр төрөл, хэмжээг харьцуулж тодорхой итгэлцүүр /коэффициентоор/ үнэлж хэтийн төлөвийг нь тодорхойлно.

**В.** Хангайн бүсийн хот суурин газруудын хэв шинжийн ангиллыг боловсруулна. Ингэхдээ хот суурин газрууд тус бүрийн хүн ам, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтэц, эрдэс түүхий эд, инженер геологийн нөхцөл зэргийн үнэлгээг коэффициентоор эсвэл баллаар/ нэгтгэж иж бүрэн үнэлгээ /коэффициентоор/ боловсруулна. Бүсийн хот суурин газруудын хэв шинжийн ангилалд тулгуурлан хот суурин газруудын тулгуур төвүүдийг зурагт буулгаж үндэслэл тодорхойлолт бичнэ.

**Г.** Хангайн бүсийн хот суурин газруудын зэрэглэлийн зураг схем, тайлбар зөвлөмжийг боловсруулна.

**Д.** Судалгааны үр дүнг тусгасан эрдэм шинжилгээний тайланг 2012 оны XII сард бичнэ.



## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ

### НЭГ. ХОТ СУУРИНЫ БҮТЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ, АСУУДАЛ


**I.1.1 Монгол Улсын эдийн засгийн бүс нутгийн бодлого, тогтвортой хөгжлийн асуудал.** Монгол Улсад хот байгуулалтыг нэгдсэн бодлогод оруулахын тулд өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэйн зэрэгцээ хүн амын тодорхой хэсэг нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн нэлээд таруу байршин нутагладаг онцлогтой иймд манай улсын бүс нутгуудын хэмжээнд өөрөөр хэлбэл хот суурин аймгуудын оновчтой хамтын ажиллагаанд тулгуурлан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлага улам бүр өсч байна.

Сүүлийн жилүүдэд Улсын Их Хурал, Засгийн газраас явуулж байгаа бүсчилсэн хөгжлийн бодлогын дүнд бүс нутгуудын хөгжилд нааштай зарим үр дүн гарч байна. Тухайлбал, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн Хангайн бүсэд 20,5%, Зүүн бүсэд 15,4%, Төвийн бүсэд 6,5%-иар өссөний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин Зүүн бүсэд 37%-иар, Баруун бүсэд 35%-иар, Төвийн бүсэд 20%-иар, Хангайн бүсэд 7%-иар тус тус буурчээ. Мөн “Мянганы зам” төслийн хүрээнд Засгийн газраас 16 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, олон зуун км зам, гүүрийг засварлах, барих ажил өрнөж, зөвхөн 2008-2010 онд 948 хүн ажилтай болж, 805 хүн ямар нэгэн хэмжээгээр энэ бүтээн байгуулалтад оролцожээ. Бүсийн тулгуур төв хотууд болон аймгийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ сэргэж, цаашид тогтвортой хөгжих таатай орчин бүрдэж эхлээд байна. Гэвч нэн түрүүнд анхаарч одооноос шийдвэрлэж эхлэх шаардлагатай асуудлууд нэлээд байгаа ажээ.

Монгол Улсын Их Хурал 2001 оны 6 дугаар сард “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд уг үзэл баримтлалд Монгол улсыг **Баруун** /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг/, **Хангайн** /Архангай, Булган, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг/, **Төвийн** /Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг/, **Зүүн** /Дорнод, Сүхбаатар,



Хэнтий аймаг/ гэсэн 4 бүсээр хөгжүүлэх, мөн Улаанбаатар хотыг бүсчилсэн зохион байгуулалтаар (9а, 9б дүгээр зураг) хөгжүүлэхээр тусгасан. Энэ нь хот байгуулалтын (10, 11 дүгээр зураг) нэгдсэн бодлогын нэгэн тулгуур материал болох юм. Энэ үзэл баримтлалд эдгээр хот суурин бүсүүдийн хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Иймд юуны өмнө эдгээр бүсүүд хотуудын тогтвортой хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.



9а дугаар зураг.

**Бүс нутаг, хотуудын хүн амын нийгмийн тогтвортой хөгжлийн асуудлууд.** Судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд манай эдийн засгийн бүсүүдэд ихээхэн буурчээ.


Сүүлийн арваад жилд Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт 3% байхад Баруун, Зүүн бүсэд энэ үзүүлэлт зөвхөн 0,2%, Төвийн бүсэд 0,4%, Хангайн бүсэд 1,3% байв. Энэ хугацаанд манай улсын нийт хүн амын жилийн дундаж өсөлт 1,4% байсантай харьцуулж үзвэл Баруун, Зүүн, Хангайн, Төвийн бүсэд энэ үзүүлэлт улсын дунджаас үлэмж бага байгаа нь тодорхой байна. Хэрэв энэ хугацаанд хүн амын ердийн цэвэр өсөлт улсын хэмжээнд бараг 2 дахин





буурсны дотор Улаанбаатар хотод 59,2%-иар, Хангайн бүсэд 52,2%-иар, Зүүн бүсэд 51%-иар, Төвийн бүсэд 50,5%-иар, Баруун бүсэд 32,6-иар тус тус буурсныг тооцвол Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт харьцангуй өндөр /3%/ байхад нөлөөлсөн гол хүчин зүйл нь шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй механик өсөлт мөн гэж дүгнэж болох юм. Өөрөөр хэлбэл орон нутгийн хот суурин, бүс нутгуудаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөн хэт өндөр, хэвийн бус байна гэж үзэж байна.

УЛААНБААТАРЫН БҮСИЙН ЭРЧИМТЭЙ ТАТАЛЦАЛ НӨЛӨӨЛЛИЙН БҮС БҮС



9б дүгээр зураг

Бүс нутгууд хооронд ажилгүйдлийн түвшний ялгаа их байна. Жишээлбэл ажилгүйдлийн түвшин Зүүн бүсэд Төвийн бүсийн энэ үзүүлэлтээс 1,8 дахин, Хангайн бүсийн энэ үзүүлэлтээс 1,7 дахин, Баруун бүсийн энэ үзүүлэлтээс 1,4 дахин өндөр байна. Мөн ажилгүйдлийн түвшин улсын дунджаас Зүүн бүсэд 1,8 дахин, Баруун бүсэд 1,3 дахин өндөр байгаа юм. Үүний зэрэгцээ манай эдийн





засгийн 4 макро бүс тус бүрийн ажилгүйдлийн түвшин Улаанбаатар хотын энэ үзүүлэлтээс үлэмж өндөр байна.


**Хүн амын эрүүл мэндийн** үйлчилгээний хүртээмж, чанар ч эдгээр хот суурин бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байгаа юм. Зөвхөн нэг жишээ татахад Улаанбаатар, Орхон, Говьсүмбэр, Дархан-Уул зэрэг аймаг, хотод нэг их эмчид ногдож байгаа хүний тоо харьцангуй цөөн байхад Завхан Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Хөвсгөл зэрэг аймгуудад харьцангуй олон байна. Завхан аймагт нэг их эмчид ногдож байгаа хүний тоо Улаанбаатарынхаас бараг 4 дахин олон байгаа юм. нэг их эмчид ногдож байгаа хүний тоо олон байгаа нь эмнэлгийн үзлэг, үйлчилгээний чанарт муугаар нөлөөлж байна. Үүний дээр манай зарим аймаг, хөдөө орон нутагт хот сууринд ихэнх тохиолдолд нарийн тоног төхөөрөмж шаардсан оношилгоо, эмчилгээ хийх боломж дутмаг байгааг хэлэх хэрэгтэй. Үүнээс үүдэн манай иргэд зах хязгаар нутгийн аймгууд хот сууринаас Улаанбаатарт ирж өвчин эмгэгээ оношлуулах, эмчлүүлэх зэргээр ихээхэн зардал гаргаж байна. Энэ нь эцсийн дүндээ зах хязгаар нутгийн иргэдийн амьдрал ахуйд сөргөөр нөлөөлж байдаг.

Эдгээр хот сууринд хүн амын хүнс, тэжээлийн хангамж, хүнсний аюулгүй байдлын түвшин ч аймаг, хот, бүс нутгуудаар өөр хоорондоо багагүй ялгаатай байна.


**Боловсролын** үйлчилгээний хүртээмж чанар ч аймаг, хот, бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Ялангуяа ерөнхий боловсролын системийн хөгжлийн түвшин аймаг, хот бүс нутгуудаар багагүй ялгаатай байгаа юм. Төвөөс алслагдсан сул хөгжилтэй бүс нутгуудад дунд сургуулиудын хичээлийн байр цөөнгүй тохиолдолд шаардлага хангахгүй болсон байна. Эдгээр хот суурин бүс нутгуудад багшлах боловсон хүчний чанар, хангамж ч харьцангуй доогуур түвшинд байна.



### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БҮС



10 дугаар зураг.



11 дүгээр зураг



**Мэдээллийн** үйлчилгээний хүртээмж чанар аймаг, хот, суурин бүс нутгуудын хувьд харилцан адилгүй байна. Аймаг, сумдад олонхи мэдээллийн үйлчилгээний чанар, хүртээмжийг ихээхэн сайжруулах хэрэгтэй байна.

Дээр дурьдсан жишээнээс үзэхэд, өнөөгийн монгол улсад ажилгүйдлийн түвшин, орлого, орон сууцны нөхцөл, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, мэдээллийн үйлчилгээний хүртээмж, чанар зэрэг хүн амын амьдралын түвшинг илэрхийлж байдаг гол үзүүлэлтүүд аймаг, хот, бүс нутгуудаар хэт их ялгаатай болжээ.

**I.1.2 Хот суурин, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн асуудлууд.** Хот суурин, бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур байна. Юуны өмнө эдийн засгийн бүтцийн хувьд бүс нутгууд харьцангуй доогуур түвшинд байгаа юм. 2008 оны байдлаар Орхон, Дархан-Уул аймгийг тооцохгүйгээр эдийн засгийн макро бүсүүдийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ойролцоогоор 70 гаруй хувь ХАА-н салбарт, 7 хувь худалдаа үйлчилгээний салбарт, 3% аж үйлдвэрийн салбарт, 2 орчим хувь тээвэр, холбооны салбарт, 0,5% барилгын салбарт, 3,9% бусад салбарт тус тус ногдож байна. ХАА-н салбарт байгалиас хараат бэлчээрийн мал аж ахуй тэргүүлэх үүрэгтэй байгаа өнөөгийн нөхцөл байдлыг тооцвол бүс нутгуудын эдийн засгийн бүтэц оновчтой биш байна.

Эдийн засгийн өсөлт бага, бүтцийн өөрчлөлт удаан байгаа нь хот суурин, бүсүүдийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь хэт бага байх нөхцлийг бий болгож байна. Жишээлбэл 2008 оны байдлаар манай ихэнх аймгууд төсвийн зарлагынхаа 20-25 хувийг л орлогоороо бүрдүүлж байна. Үүнээс үүдэн татаас шилжүүлэгч өсөх болов. Төсвийн татаас 2008 онд 2007 онтой харьцуулбал 20 орчим хувиар өссөн байна.

Иймд макро бүсүүдийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, улмаар экосистемийн тэнцвэрт байдалд зохицсон, эдийн засгийн оновчтой бүтцийг бий болгох шаардлагатай байна. Энэ бүгд тогтвортой хөгжлийн асуудалд шууд сөргөөр нөлөөлж байна.



**Аж үйлдвэрийн** хөгжлийн түвшин хот суурин бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Энэ нь манай улсын боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд бүс нутгуудын оруулж байгаа хувь нэмрээс тодорхой харагддаг. Өнөөгийн байдлаар боловсруулах аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 82,9 хувь нь Улаанбаатар хотод 8,3 хувь нь Төвийн бүсэд, 6,1 хувь нь Хангайн бүсэд, 1,8 хувь нь Баруун бүсэд, 0,8 хувь нь Зүүн бүсэд тус тус ногдож байна. Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын ялгаа ч дээрхтэй ойролцоо байгаа юм. нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт Хангайн бүс болон Улаанбаатар хотод хамгийн их байна.

Эндээс ялангуяа Баруун болон Зүүн бүсэд аж үйлдвэрийн салбарыг, түүний дотор жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар анхаарах цаг болсон нь харагдаж байна.

**Үйлдвэрлэлийн дэд бүтэц** /төрөл бүрийн зам, эрчим хүч, харилцаа холбооны сүлжээ г.м/-ийн хөгжлийн (12, 13 дугаар зураг) түвшний ялгаа мөн их байна. Жишээ болгон төрөл бүрийн замын сүлжээний хангамжийг аймаг, бүс нутгуудаар авч үзье. (2 дугаар хүснэгт)

**Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээ,  
эдийн засгийн бүсүүдээр**

*2 дугаар хүснэгт*


	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн
Коэффициент	0,21	0,91	1,72	0,60

Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн хувьд Завхан, Баян-Өлгий зэрэг аймагт энэ үзүүлэлт Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийнхаас олон дахин доогуур байна. Манай олонхи аймгуудад (14 дүгээр зураг) сайн чанарын замын сүлжээ бүрдээгүй байгаа нь тээвэрлэлтийн зардлыг өсгөж тэдгээрт үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжихөд ихээхэн саад болж байна.






МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ



12 дугаар зураг



ДЭД БҮТЦИЙН БҮСИЙН ТЭНХЛЭГҮҮД ХӨРШ ОРНУУДЫН ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДОХ НЬ



13 дугаар зураг





Эрчим хүчний сүлжээний хангамжийн байдал ч аймаг, хот, бүс нутгуудаар ихээхэн ялгаатай (15, 16, 17, 18, 19, 20 дүгээр зураг) байна. Ялангуяа Баруун, Зүүн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбох шаардлага гарч байна. Нөгөө талаар манай ихэнх аймгуудын нийт өрхийн ойролцоогоор 50 хувийг эзэлдэг малчин өрхийг эрчим хүчний бага оврын эх үүсвэрийг ашиглан цахилгаанаар хангах шаардлагатай байна.

Дээр дурьдсан шалтгаанаар, эдийн засгийн хөгжлийн ерөнхий түвшин аймаг, хот, бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна.

Бид нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, боловсролын байдал, хүн амын дундаж наслалт, ажилгүйдлийн түвшин, эрчим хүчний хангамж, төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн коэффициент, хүний хөгжлийн индекс зэрэг шалгуур үзүүлэлтийг тооцон аймаг, хот, бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний нэгдсэн үнэлгээг боловсруулсан байдлаас үзэхэд. Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд, аймгийн хөгжлийн ерөнхий түвшин Улаанбаатар хот, Орхон аймгийнхаас ойролцоогоор 9 дахин, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийнхаас 3-4 дахин доогуур байна. Булган, Дундговь, Дорнод аймгийн хөгжлийн ерөнхий түвшин Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд, аймгийнхаас дунджаар 2 дахин дээгүүр, харин Улаанбаатар хот, Орхон аймгийн энэ үзүүлэлтээс 4 дахин доогуур байна. Эдийн засгийн (3 дугаар хүснэгт) бүсүүдийн хооронд ч хөгжлийн ерөнхий түвшний ялгаа их байгаа билээ.



**Эдийн засгийн макро бүсүүдийн хөгжлийн түвшний  
харьцуулсан үнэлгээ**

3 дугаар хүснэгт

Бүсийн нэр	Баруун	Зүүн	Хангайн	Төвийн	Улаанбаатар
Үнэлгээний коэффициент	1,00	1,50	2,40	2,80	7,50



МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭ



**ТАНИХ ТЭМДЭГ**

- Улсын хил
- Бүсийн хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Баруун бүс
- Хангайн бүс
- Төвийн бүс
- Зүүн бүс

- Улаанбаатар хот
- Төлөвлөж буй хот
- Хангайн бүсийн тулгуур төв
- Аймгийн төв

- Сумын төв
- Одоо байгаа төмөр зам

**Шинээр барих төмөр замын суурь бүтэц**

- 1-р ээлжинд баригдах төмөр зам
- 2-р ээлжинд баригдах төмөр зам
- 3-р ээлжинд баригдах төмөр зам


**Төлөвлөж буй төмөр зам**

- ХУВИЛБАР 1
- ХУВИЛБАР 2






МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН СИСТЕМ



15 дугаар зураг.


МОНГОЛ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ ХАНГАМЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ /сумдын түвшингээр/



16 дугаар зураг.




МОНГОЛ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДООГҮЙ СУМДЫН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ БОЛОМЖИЙГ ТООЦСОН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ



17 дугаар зураг

МОНГОЛ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ХОЛБОГДООГҮЙ СУМДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ /1 хүнд ногдох дизель цахилгаан станцын хүчин чадал/




18 дугаар зураг





БАРУУН БҮСИЙН  
ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ  
ХАНГАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




ҮНЭЛГЭЭ /коэффициентоор/

- I 2.5 хүртэлх
- II 2.5 - 5
- III 5.1 - 7.6
- IV 7.7 - 10.2
- V 10.3-аас их
- төвлөрсөн эрчим хүчий сүлжээнд холбогдоогүй сум

ТАНИХ ТЭМДЭГ

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ТӨВИЙН БҮСИЙН  
ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ  
ХАНГАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



ҮНЭЛГЭЭ /коэффициентоор/

- I 2.5 хүртэлх
- II 2.5 - 5
- III 5.1 - 7.6
- IV 7.7 - 10.2
- V 10.3-аас их
- төвлөрсөн эрчим хүчий сүлжээнд холбогдоогүй сум

ТАНИХ ТЭМДЭГ

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

19 дүгээр зураг.

ХАНГАЙН БҮСИЙН  
ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ  
ХАНГАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




ҮНЭЛГЭЭ /коэффициентоор/

- I 2.5 хүртэлх
- II 2.5 - 5
- III 5.1 - 7.6
- IV 7.7 - 10.2
- V 10.3-аас их
- төвлөрсөн эрчим хүчий сүлжээнд холбогдоогүй сум

ТАНИХ ТЭМДЭГ

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ЗҮҮН БҮСИЙН  
ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ  
ХАНГАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



ҮНЭЛГЭЭ /коэффициентоор/

- I 2.5 хүртэлх
- II 2.5 - 5
- III 5.1 - 7.6
- IV 7.7 - 10.2
- V 10.3-аас их
- төвлөрсөн эрчим хүчий сүлжээнд холбогдоогүй сум

ТАНИХ ТЭМДЭГ

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ТАЙЛБАР: УБ хот, Орхон, Дархан уул, Говьсүмбэр аймгийг оруулсангүй

20 дугаар зураг.



Дээр дурьдсан бүгдийг нэгтгэн дүгнэж үзвэл өнөөгийн Монгол улсад нийгмийн хөгжлийн хүрээнд ч эдийн засгийн хөгжлийн хүрээнд ч аймаг, хот бүс нутгууд хооронд ихээхэн ялгаа гарсан байна гэж хэлж болох байна. Энэ байдал Улаанбаатар болон Төвийн бүс рүү чиглэсэн “их нүүдэл” өргөжиж улмаар манай улсын төв хэсэг, Улаанбаатар хотын ойролцоо бэлчээрийн даац хэтрэх, экологийн тэнцвэрт байдал алдагдах, бусад бүс нутагт хүн ам хэт цөөрч нутаг орон эзгүйрэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгож байна. Жишээлбэл, 2005-2010 оны хооронд эдийн засгийн 4 макро бүсээс шилжин явагчдын тоо нь тэдгээрт шилжин ирэгчдийн тооноос үлэмж өндөр байна.

Гэтэл Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн тоо нь шилжин явагчдын тооноос бараг 5 дахин их байна. Үүнээс үзэхэд 4 бүс бүрээс Улаанбаатар руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хандлага зонхилж байна.

Судалгаанаас үзэхэд эдийн засгийн макро бүсүүдээс шилжин явж байгаа хүмүүсийн үндсэн шалтгаан нь ажил эрхлэх, зах зээлд ойртох, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, боловсрол эзэмших нөхцлөө сайжруулах зэрэг байгаа юм. Макро бүсүүдээс шилжин явагчдын насны бүтцийг авч үзвэл 15-25 насныхан зонхилж байна.

Зөвхөн Увс аймгаас нэг жил-ийн дотор 540 өрх, 3675 хүн Төвийн бүс рүү шилжиж ирсэн байна. Өөрөөр хэлбэл нэг сумын хүн амтай тэнцэх тооны хүн шилжин иржээ.

Иймд бүсүүдийн нөөц, чадавхид түшиглэн эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн түвшний нутаг дэвсгэрийн хэт ялгааг багасгах явдал үндэсний эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

**I.1.3 Монгол Улсын хүн ам зүйн асуудал.** Аливаа улс орны хөгжлийн төлөвлөлтөд хүний хүчин зүйлийг тусгахгүйгээр амжилт олоход бэрхшээлтэй байдаг. 1990-ээд оны эхэн үеэс Монгол орны улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд төдийгүй хүн ам зүйн хөгжилд ихээхэн өөрчлөлт, эргэлт гарсан байна. Тогтвортой хөгжлийн асуудал эрчимтэйгээр хөндөгдөх болсноос гадна хүн амын өсөлт болон бүтцэд гарч буй өөрчлөлт, хотжилт, гадаад дотоод шилжих



хөдөлгөөний идэвхжил, ажилгүйдэл, ядуурал гэх мэт хүн амын олон асуудлууд төр олон нийтийн анхаарлын төвд тавигдах болжээ.

***Бүс нутгийн хүн ам зүйн өнөөгийн байдал. Хүн амын өсөлт, байршил.***

2006 оны эхэн үеийн байдлаар Монгол улс 2385,5 мянган хүн амтай гэж тоологдсон ба нийт хүн амын 42 хувь нь нийслэлд, 18 хувь нь Баруун, 13 хувь нь Хангайн, 19 хувь нь Төвийн, 8 хувь нь Зүүн бүс нутгуудад тус тус суурин амьдарч байлаа. Хүн ам хамгийн ихтэй аймгуудад Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгууд багтаж байхад хүн ам цөөтэй нутаг дэвсгэрт Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд орж байна.

Монгол улсын тооллого хоорондын хүн амын өсөлтийн хурд нь тухайн үеийн улс төр, нийгмийн байдалтай салшгүй холбоотой байсан ба 1989-2000 оны хооронд жилд дунджаар 2,5 хувьтай байсан бол 2005-2006 оны хооронд 1,4 хувь болж буурчээ. Хүн амын өсөлтийн хурд бүс нутгуудад харилцан адилгүй байна. Сүүлийн арваад жилийн дунджаар, Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд улсын дундаж (1,4%)-иас бараг 2,6 дахин өндөр байхад зүүн болон баруун бүсэд хүн ам жилд дунджаар дөнгөж 0,2 хувиар өссөн байна. Гэхдээ үүнээс ч илүү анхаарал татахуйц нэг зүйл бол зарим аймгуудад тухайлбал, Дорноговь, Дорнод, Хэнтий аймгуудад дээрх хугацаанд хүн амын тоо нь жилд дунджаар 0,36-1,1 хувиар буурчээ. Харин Хангайн бүсийн хүн амын өсөлт (1,3%) улсын дундажтай ойролцоо байна.

Ийнхүү нийт хүн амын өсөлтийн хувь буурч байгаад хүн амын ердийн цэвэр өсөлт, тэр дундаа сүүлийн арав гаруй жилийн хугацаан дахь төрөлтийн түвшний огцом бууралт өндөр нөлөө үзүүлж байна. Гадаад шилжих хөдөлгөөний тооцохгүйгээр, 2006 онд Монголын хүн ам жилд дунджаар 1000 хүн тутамд 33 хүнээр нэмэгдэж байсан бол 2009 он гэхэд 4 дүгээр хүснэгт энэ тоо 38,2 хувиар буурч 15,0 болжээ.



**1000 хүнд ногдох хүн амын бүртгэгдсэн төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, бүс нутгаар, 1999, 2009 онд**

Бүс нутаг	Төрөлт		Нас баралт		Ердийн цэвэр өсөлт		4 дүгээр хүснэгт 1999-2009 оны ердийн цэвэр өсөлтийн өөрчлөлт /%/
	1999	2009	1999	2009	1999	2009	
Улаанбаатар	30,4	15,0	9,3	6,4	21,1	8,6	-59,2
Зүүн бүс	36,3	20,2	9,3	7,0	26,9	13,2	-50,1
Төвийн бүс	35,9	20,6	8,0	6,8	27,9	13,8	-50,5
Хангайн бүс	42,2	22,1	9,3	6,4	32,9	15,7	-52,2
Баруун бүс	39,8	27,2	8,2	5,8	31,6	21,3	-32,6
Монгол	38,0	21,6	7,9	6,0	30,1	15,6	-48,2

Бүх бүсүүдийн хэмжээнд 1999 онд 1000 хүнд ногдох хүн амын ердийн цэвэр өсөлтөөрөө хангайн болон баруун бүс (тус бүр 32,9 ба 31,6) улсын дундаж (30,1)-аас дээгүүр байсан бол 10 гаруй жилийн дараа зөвхөн баруун бүс л энэ ангилалд багтах болжээ. Гэхдээ дээрх хугацаанд бүх бүс нутгуудад хүн амын ердийн цэвэр өсөлт гуравны нэгээс дээш хувиар буурсан ба үүн дотор Улаанбаатар хот болон Хангайн бүсийн хүн амын ердийн цэвэр өсөлт тус тус хамгийн өндөр хувиар (59,2 болон 52,2) буурсан ажээ.

Нийт бүс нутагт 1000 хүнд ногдох төрөлтийн бүсүүдэд бараг 2 дахин буюу 12,6-20,1 пунктээр буурсан байхад нас баралт 1,2-2,9 пунктээр л буурсан байгаа нь ердийн цэвэр өсөлтийн бууралтад төрөлтийн түвшний бууралтын үзүүлсэн нөлөө харьцангуй өндөр байсныг харуулж байна. Хэдийгээр төрөөс төрөлтийг дэмжих бодлого барьж байгаа хэдий ч шилжилтийн үеэс хойшхи хүн амын амьжиргааны түвшний доройтол, эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр оролцооны түвшний дээшлэлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгслийг өргөнөөр хэрэглэх болсон, түүнчлэн үр хөндөлтийг чөлөөтэй болгосон зэрэг олон хүчин зүйлүүд хүн амын төрөлтийн түвшин буурахад голлон нөлөөлжээ.

Хүн амын өсөлт, өөрчлөлтийг тодорхойлогч өөр нэг чухал хүчин зүйл нь хүн амын шилжилт хөдөлгөөн байдаг байна. Сүүлийн жилүүдэд хүн амын гадаад,



дотоод шилжих хөдөлгөөн эрчимжиж байгаа нь улсын болон бүс нутгуудын хүн амын өсөлтөд үзүүлэх механик өсөлтийн нөлөөг эрс нэмэгдүүлж байна.

Сүүлийн үед бүс нутгуудын хүн амын ердийн цэвэр өсөлтийг механик өсөлттэй харьцуулан авч үзвэл, төвийн бүсээс бусад бүх бүсэд хүн амын өсөлтөд үзүүлэх дотоод шилжих хөдөлгөөний нөлөө нь хүн амын ердийн хөдөлгөөн буюу төрөлт, нас баралтын нөлөөллөөс өндөр байна. Гэхдээ Улаанбаатараас бусад бүсүүдэд хүн амын механик өсөлт нь нийт цэвэр өсөлтдөө сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа ажээ. Тухайлбал, 2000 оны байдлаар Улаанбаатарт 1000 хүнд ногдох хүн амын ердийн цэвэр өсөлт 11,4 байхад 1000 хүнд ногдох цэвэр шилжилт 43,0 байгаа нь нийслэлийн хүн амын өндөр өсөлтийн гол шалтгаан бол шилжин ирэх хөдөлгөөн гэдгийг харуулж байна. Харин баруун бүсийн хүн ам төрөлт, нас баралтаас хамааран 1000 хүн тутамд 21 хүнээр нэмэгдсэн боловч шилжих хөдөлгөөнөөс хамааран 1000 хүн тутамд 35 хүнээр цөөрчээ.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түвшинг тооллогын өмнөх 5 жилийн хугацаагаар авч үзвэл Монгол улсын 11 хүн тутмын нэг нь шилжих хөдөлгөөнд оролцжээ. Бүс нутгийн хувьд Баруун болон Төвийн бүсийнхэн хамгийн ихээр шилжилтэд оролцож байгаа ба үнэмлэхүй тоогоор авч үзвэл дээрх 2 бүсийн дараа гуравдугаарт нь Хангайн бүс, дараа нь Зүүн бүсийнхэн орж байгаа юм. Энэ бүгд нь хот суурины бүтэц зохион байгуулалт алдагдахад хүрчээ.

Харин шилжих хөдөлгөөний коэффициентээр авч үзвэл Баруун болон Төвийн бүс шилжих хөдөлгөөнд хамгийн их өртөж, Зүүн бүс удаалжээ.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатараас бусад бүх бүс нутагт шилжин явсан хүн ам нь шилжин ирснээсээ эрс их байгаа ба Баруун болон Төвийн бүсээс хамгийн олон хүн (тус бүр 35,8-45,2 мянга) шилжин явж, Улаанбаатарт хамгийн олон хүн (90,4 мянга) шилжин иржээ.

Баруун бүс нутагт сууж байсан хүн амын 10 гаруй хувь нь одоо өөр газарт сууж байна. Энэ үзүүлэлт Төвийн бүсэд 9,0%, Зүүн бүсэд 8,0%, харин Хангайн бүсэд хамгийн бага буюу 6,0% байна. Эдгээрээс харахад Хангайн бүсийнхэний бүс



нутагтаа тогтвортой суух байдал нь бусад бүсээс (Улаанбаатарыг оруулахгүйгээр) илүү байна.

Шилжих хөдөлгөөний урсгалыг авч үзвэл, 2005-2010 оны байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын 8 нь Улаанбаатар болон Төвийн бүсэд шилжин суурьшжээ. Тодруулбал дээрх хугацаанд 90,4 мянга гаруй хүн буюу нийт шилжигсдийн 65% Улаанбаатарт шилжин суурьшсан нь эдүгээ нийслэлийн хүн амын 14 хувийг бүрдүүлж байна. Нөгөө талаас Төвийн бүсэд шилжин ирэгсдийн хувь өндөр байдаг ч тус бүсээс Улаанбаатар руу чиглэсэн шилжилт мөн их байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, Төвийн бүс нутаг нь Улаанбаатар руу шилжих хөдөлгөөний дамжлага шат болж байна. Харин нийслэл болон Төвийн бүсийн дараагаар орох, хүн ам ихээр шилжин ирж буй бүс нь Хангайн бүс бөгөөд тэнд дээрх хугацаанд нийт 17000 орчим хүн шилжин иржээ тооцоо гарч байна.

Шилжих хөдөлгөөний дотор гэр бүлийн шилжилт зонхилж байна тухайлбал Улаанбаатар, Дархан-Уул, Төв аймагт шилжин ирэгсдийн 42,6-53,7% нь гэр бүлээрээ шилжин ирсэн ба шилжигсдийн шинж байдлын бусад онцлог зүйлийг авч үзвэл, хүйсийн хувьд эрэгтэй, насны хувьд залуу хүмүүс илүүтэйгээр бүс нутгаас төв суурин руу шилждэг ажээ. Шилжигсдийн дотор 15-29 насныхан хамгийн өндөр хувьтай /эрэгтэйчүүдийн 52,9%, эмэгтэйчүүдийн 47,1%/ байгаа ба тэдний доторх эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байга нь судалгаанаас харагдаж байна.

Мөн нийт хүмүүсийн боловсролын дундаж түвшинтэй харьцуулахад өндөр боловсролтой хүмүүс илүүтэй шилжилтэд оролцож байна. 2009 оны тооллогын үндсэн үр дүнгээс харахад 2000-2009 онд нийт хүн амын дотор бүрэн дундаас дээш боловсролтой хүмүүс 40 хувийг эзэлж байхад шилжилтэд оролцсон нийт хүмүүсийн хувьд уг үзүүлэлт 51 хувь байна. Эндээс дүгнэхэд уугуул газар нь нутаг усаа хөгжүүлэх илүү чадвар бүхий хүмүүсээ гадагш алдаж байгаа ажээ.

Хүн амын шилжилтэд оролцож буй үндсэн шалтгаанууд дотор аль ч бүсэд ялгаагүй ажил эрхлэх, зах зээлд ойртох, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, боловсрол эзэмших зэрэг шалтгаанууд зонхилж байна. Гэхдээ ажил эрхлэхээр





шилжилтэд оролцсон эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдээс 7,4-11,2 пунктээр илүү байхад, суралцах зорилгоор шилжсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 2,1-12,9 пунктээр илүү байгаа ажээ. Түүнээс гадна гадагш шилжих хөдөлгөөн их байгаа уугуул нутгийнханд тодорхой бэрхшээлтэй тулгарахад түүнийгээ шийдвэрлэх боломж маш хомс байдаг байна. Тухайлбал, ямар нэг бэрхшээл тохиолдоход уугуул нутгийнхан тусламж авахаар ихэвчлэн орон нутгийнхаа засаг захиргаанд ханддаг боловч дийлэнх нь (69,9-93,9%) ямар ч тусламж авч чаддаггүй ажээ. Ийнхүү хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж буйн үндсэн шалтгаан нь хот, хөдөө дэх эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн ялгавартай байдалтай нэн тэргүүнд холбоотой болох нь харагдаж байна.

Хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдэж буй нь хотын хүн амын өсөлтөд механик өсөлтийн үзүүлэх нөлөөллийг эрс нэмэгдүүлээд зогсохгүй хотжилтын түвшинд нөлөөлж байна.

Нийт хүн амын дунд хотод амьдарч буй хүн амын эзлэх хувь жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 1998 оны байдлаар хот сууринд нийт хүн амын 49,6% нь амьдарч байсан бол хоёрхон жилийн дараа гэхэд 56,6% болж нэмэгдсэн төдийгүй үүний 32 хувь нь дангаараа нийслэлд харьяалагдаж байна. Хотжилтын үзүүлэлтийг бүс нутгаар авч үзвэл, төвийн бүсэд хамгийн олон хот суурин газар байдаг боловч хотын хүн амын эзлэх хувиараа Улаанбаатарын дараа Зүүн бүс (41,8%) ордог нь харагдаж байна. Энэхүү Зүүн бүсэд багтах Чойбалсан хот нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудын дараа ордог томоохон хот болжээ.

**Бүс нутгуудын хүн амын нас, хүйсийн бүтэц.** Монголын хүн ам зүйн түүхийн онцлог нөхцөл байдлаас үүдэн сүүлийн арав гаруй жилийн хугацаанд насны бүтцэд тодорхой өөрчлөлт оржээ. 1999 онд хүн амын тал хувь нь 18,7-оос доош насныхан, үлдсэн хувь нь түүнээс дээш насныхан байсан бол 2010 онд уг голч нас 21,9 болж өсчээ. Хүн ам насны бүтцийнхээ хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа боловч уг залуужилтыг тодорхойлж буй бүлгийн доторх 10 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь 10-аад жилийн өмнөхтэй харьцуулахад эрс буураад байгаа нь харагдаж байна. Харин хүн амын хүйсийн бүтэц харьцангуй тогтвортой (1999-2010 онд 100 эмэгтэй хүн тутамд 99,7-98,3 эрэгтэй хүн) байна.



Хүн амын залуужилтыг 2010 оны байдлаар 10-39 насныхан, ялангуяа 10-24 насны өсвөр үеийнхэн ба шинээр хөдөлмөрийн эгнээнд орох насныхан тодорхойлох хандлагатай болжээ. Түүнчлэн хэрэв төрөлтийн түвшинд дээшлэлт гарахгүй л бол хүн ам цаашид насны бүтцийн хувьд идэрших хандлага руу ойртож байгааг хүн амын судалгаануудаас харж болох байна.

Бүс нутгуудаар авч үзвэл, бүсүүдийн хүн амын нас хүйсийн бүтэц харьцангуй ойролцоо хандлагатай, хүн ам нь залуу бүтэцтэй байна. Бусадтай харьцуулахад баруун бүсэд 10 хүртэлх насны хүн амын хувь их байгаа нь тус бүсэд бусад бүс, хотуудаас орой төрөлтийн бууралт явагдаж эхэлснийг харуулж байна.

Насны бүтцэд гарч буй дээрх өөрчлөлтөөс үүдэн нийт хүн амын дунд эзлэх хөдөлмөрийн насны хүн амын хувь 2010 онд 10 жилийн өмнөхөөс 6,7 пунктээр нэмэгдэж 60,8 хувь болсон ба 0-14 насны хүүхэд болон 65-аас дээш насны өндөр настнуудын хувь тус бүр 6,1 ба 0,6 пунктээр буурч нийт хүн амын 35,8 ба 3,4 хувийг эзлэх боллоо. Хүн амын одоогийн насны бүтцийг бүс нутгаар авч үзвэл Улаанбаатар болон Төвийн бүс дэх хөдөлмөрийн насны хүн амын нийт дүнд эзлэх хувь бусад бүстэй харьцуулахад (тус бүр 66,6 ба 59,6%) хамгийн өндөр, харин 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь (30,1-36,7%) хамгийн бага байгаа юм байна.

Энэ нь үндсэндээ дээрх хот, бүс дэх хүн амын өмнөх үеийн өсөлт өөрчлөлтийн хандлага, төрөлт, нас баралтын үзүүлэлтүүдтэй холбоотой ч гэсэн нөгөө талаас үүнд Улаанбаатар болон төвийн бүс рүү чиглэсэн хөдөлмөрийн насны хүн амын их шилжин ирэлт нөлөөлж байж болох талтай байна.

Сүүлийн 10 гаруй жилд Монгол улсын хүн ам насны бүтцийн хувьд эдийн засагт үзүүлж болох нөлөөлөөрөө харьцангуй ашигтай гэж болох түвшинд хүрчээ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн амын хувь ихээхэн нэмэгдэж, хүүхэд, өндөр настнуудын хувь багасч байгаа үзэгдлийг ажлын байр болон эдийн засгийн өндөр өсөлттэй зэрэгцүүлж чадвал улс орны нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлуудад эерэг үр дүн гарах боломжтой нь харагдаж байна.



**Хүн ам зүйн хэтийн төлөв.** Монгол улсын Хүн ам, Орон сууцны 2000 оны тооллогод үндэслэн ҮСГ-аас хийж буй Хүн амын хэтийн тооцооны урьдчилсан дүнгээр (5 дугаар хүснэгт) Монголын хүн ам ирэх 25 жилд 2000 оныхоос 1,3-1,4 дахин өсч 3,082,603-3,29,573 орчим болох төлөвтэй байна.

### Монгол Улсын хүн амын 2000-2025 оны хэтийн тооцооны хувилбарууд

5 дугаар хүснэгт

Хувилбарууд	2000	2005	2010	2015	2020	2025
Дээд	2389661	2572650	2763702	2965608	3159990	3329573
Дунд	2389661	2551837	2719818	2883532	3038893	3168084
Доод	2389661	2530994	2675114	2825828	2968046	3082603
4 дэх	2389661	2562261	2741774	2918624	3087048	3229996

Эх сурвалж ҮСГ, МУ-ын хүн амын хэтийн тооцооны урьдчилсан дүн

Нийт хүн амын нийслэлийн хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж хэтийн тооцооны эцэс гэхэд 2009 оноос (32,1%) 10,77 пунктээр нэмэгдэх ба бусад бүх бүс нутгийн хүн амын нийт дүнд эзлэх хувь буурахаар байна. Гэхдээ хүн амын эзлэх хувиараа Улаанбаатар хотын дараа Хангай болон Төвийн бүс орж байгаа байдал хэвээр байх төлөвтэй байна.

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд хэтийн тооцооны дунд хувилбараар 0,83 байх ба Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн хурд (1,63) бусад бүх бүс нутгийнхаас өндөр хэвээр байхаар байна.

Хүн амын насны бүтцийг авч үзвэл, ирэх 25 жилд 15 хүртэлх насны хүүхдүүдийн нийт дүнд эзлэх хувь тогтвортой буурч 22 хувь болох ба харин өндөр насны хүн амын хувь нэмэгдэж 6,4 хувь болох төлөвтэй. Сүүлийн 20 гаруй жилд өсөн нэмэгдэж буй хөдөлмөрийн насны хүн амын өсөлт 2010 онд оргил үедээ хүрч (жилийн дундаж өсөлт 2,5%) түүнээс цааш жил тутам хөдөлмөрийн зах зээлд элсэн орох хүний тоо буурах хандлага ажиглагдаж байна.

Бүс нутгаар авч үзвэл 2000 онд Улаанбаатар болон Төвийн бүс дэх хөдөлмөрийн насны хүн амын нийт дүнд эзлэх хувь бусад бүстэй харьцуулахад (тус бүр 66,6 ба 59,6%) хамгийн өндөр байсан бол 2010 оноос хойш дээрх



үзүүлэлтээр Улаанбаатар болон Зүүн бүс тэргүүлэх хандлагатай байна. Харин 15 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь дээрх хугацаанаас хойш мөн л Улаанбаатар болон Зүүн бүсийн аймгуудад хамгийн бага байх бололтой. Энэ нь үндсэндээ дээрх хот, бүс дэх хүн амын өнөөгийн төрөлт, өсөлтийн доогуур түвшин, шилжилт хөдөлгөөний гадагш чиглэсэн их урсгалтай холбоотойгоор тайлбарлагдаж болох юм. Ийнхүү 2025 он гэхэд хүн ам насны бүтцийн хувьд одоогийнхоос (6 дугаар хүснэгт) илт идэршсэн байх төлөвтэй.

**Монгол Улсын бүс нутгийн хүн амын 2000-2025 оны үеийн  
насны бүтцийн хэтийн тооцооны хувилбар**

6 дугаар хүснэгт

Бүс нутаг	2000	2005	2010	2015	2020	2025
<b>Баруун</b>						
0-14	40,5	36,5	32,6	30,0	28,2	26,1
15-64	56,3	60,0	63,5	66,1	67,6	67,9
65+	3,2	3,5	3,9	3,9	4,2	6,0
<b>Хангай</b>						
15-64	58,0	64,3	68,1	70,4	70,6	70,8
65+	3,5	3,5	4,2	4,1	4,8	6,0
<b>Төв</b>						
0-14	36,7	30,2	26,5	25,0	24,3	22,9
15-64	59,6	65,8	69,4	70,7	70,9	71,0
65+	3,7	4,0	4,1	4,3	4,8	6,1
<b>Зүүн</b>						
0-14	37,7	31,0	26,4	24,3	23,3	21,3
15-64	58,3	65,0	69,5	71,6	71,7	71,4
65+	4,0	4,0	4,1	4,1	5,0	7,3
<b>Улаанбаатар</b>						
0-14	30,1	26,2	24,4	23,8	21,9	19,9
15-64	66,6	70,4	71,8	71,9	73,0	73,4
65+	3,3	3,4	3,8	4,3	5,1	6,7

Эх сурвалж: ҮСГ, МУ-ын хүн амын хэтийн тооцооны урьдчилсан дүн

Шилжих хөдөлгөөний цаашдын хандлагыг авч үзвэл, уугуул нутгийн хүн амын 30 орчим хувь нь ирээдүйд шилжихийг хүсч байгаа бөгөөд тэдний гуравны



хоёроос илүү нь нийслэл рүү шилжихээр төлөвлөж байхад, Улаанбаатараас ирээдүйд шилжихийг хүсэгчдийн бараг тал хувь нь гадаадад гарч ажиллахыг хүсч байгаа ажээ. Ирээдүйд шилжих сонирхолтой хүмүүсийн дотор эрэгтэй, хөдөлмөрийн насны, боловсрол өндөртэй хүмүүс бусад бүлгийн хүмүүсээс илүүтэй байгаа нь тэд тодорхой хугацааны дараа гэр бүлээ татаж авах хүсэлтэй байна. Үндсэндээ тэд зах зээлд ойртож, ажиллах бололцоо хайх, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, нийгэм оюуны хэрэгцээгээ илүүтэй хангах зэрэг шалтгаанаар ирээдүйд шилжихийг хүсч байгаа нь харагдаж байна.

Хангай, Баруун, Зүүн, Төвийн бүсүүдэд амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй байгаа ч, мал маллаж амьжиргаагаа залгуулж байгаа байдлыг аж байдлын талаас нь авч үзвэл харилцан адилгүй байна. Ядуу хүмүүс нь чинээлэг айлд хөлсний ажил хийж орлого олохоос гадна тэтгэвэр тэтгэмж зэрэг нь ядуу хүмүүсийн орлогын ганц эх үүсвэр болж байна. Ядуучуудын амьжиргааны эх үүсвэр нь бүсүүдийн газар зүйн байршил, байгаль цаг уурын онцлогоос шалтгаалан ялгаатай байна. Тухайлбал, Хангайн бүсийн хувьд хүмүүсийн амьжиргаанд загас барих, жижиг гар урлал, жимс түүж зарах, газар тарианы ажил зэрэг баруун бүсэд гар урлал, ноолуур, тариа будаа, хүнсний ногоо ургуулах гэх мэт, төвийн бүсийн жуулчдад тэмээ морь унуулах, хурдны морь уях, газар тариалан гэх мэт, зүүн бүсэд ан агнуур, дархан, оёдол, Улаанбаатарт хөлсөөр ажил хийх, хувиараа машин угаах, самар зарах, тамхи ширхэгээр зарах гэх мэтээр амьжиргаагаа залгуулдаг байна. Хөдөөд амьжиргааны эх үүсвэр, худалдаа наймаа болон түр зуурын ажил эрхлэлт нь ихэвчлэн улирлын чанартай, найдвартай бус байна. Ийнхүү амьжиргааны тогтмол орлогын эх үүсвэргүй байдал нь ядуурал гүнзгийрэх бас нэг гол шалтгаан болж байна. Бүс нутгуудын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит байдал хэтийн төлөвийн энэ бүх асуудал нь Шинэ хотын бүтээн байгуулалтын тооцож тогтоох үндсэн үзүүлэлт болж байна.

**I.1.4. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, зарим үр дүн.** Хүн төрлөхтний хөгжлийн түүхэн замналаас үзэхэд аливаа улсад харьцангуй илүү хөгжсөн бүс нутаг байхад бас харьцангуй сул хөгжсөн бүс нутаг байдаг ажээ. Ийм үзэгдэл одоо ч олонхи оронд байсаар байна. Аль нэг улсын дотоодод, цаашилбал



дэлхийн түвшинд хүн амын амьдралын түвшний ялгаа газар авснаар тухайн улсын болон даян дэлхийн тогтвортой хөгжилд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Дэлхийн хөгжиж буй олон оронтой харьцуулбал манай улсад сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудын хамрах хүрээ өргөн, энэ талын тулгамдсан асуудлууд олон байсаар ирсэн, одоо ч байсаар байна. Энэ нь юуны өмнө өргөн уудам нутаг дэвсгэр дээр харьцангуй цөөн хүн амын багагүй хэсэг нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн ихээхэн таруу байршин нутагладаг онцлогтой шууд холбоотой ажээ. Судалгаанаас үзэхэд өнөөдөр улсын нийт хүн амын ойролцоогоор 40 орчим хувийн амьдрал ахуйд таруу байршилтай бэлчээрийн МАА голлох үүрэгтэй байна. иймд манай улсад хөгжлийн холбогдолтой аливаа асуудлыг шийдвэрлэхийн өмнө юуны өмнө орон зайн буюу бүсчилсэн хөгжлийн хандлагыг оновчтой баримталж байх хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч байна.

Монгол улс эдийн засгийн шинэ тогтолцоог сонгон авсан тэр үед бүсчилсэн хөгжлийн холбогдолтой олон асуудлууд хуримтлагдсан байжээ. Энд хот хөдөөгийн хөгжлийн төвшний ялгаа улам бүр ихсэж, хөдөө орон нутагт оршин сууж буй иргэдийн орлого эрс багасч, ажилгүйдэл, ядуурал өсч, тэдэнд үзүүлдэг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, тэдээллийн зэрэг төрийн үндсэн үйлчилгээ чанарын хувьд ч, хүртээмжийн хувьд ч ихээхэн буурсан байв. Эл байдлаас үүдэн хөдөөнөөс төвийн хэсэг болон нийслэл хотруу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн ихсэж, гол төмөр замын дагуух бүс нутагт экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж, нийслэл хотын ачаалал хирээс хэтрэх болно.

Эдгээр асуудлуудыг бидний сонгон авсан шинэ тогтолцооны буюу зах зээлийн тогтолцооны нийтлэг жишигт нийцсэн бөгөөд манай улсын хувьд шинэ гэж хэлж болох бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай болжээ. Зах зээлийн тогтолцоот орнуудын нийтлэг жишигт нийцсэн, манай улсын хувьд шинэ гэж хэлж болох бүсчилсэн хөгжлийн бодлоготой болохын тулд юуны өмнө эдийн засгийн хөгжлийн талаар баримталж байсан онол, аргазүйн хандлагаа үндсээр нь өөрчлөх шаардлага гарчээ.



Тэр үед олон улсын тавцанд бүсчилсэн хөгжлийн талаар онолын өөр хоорондоо зарчмын ялгаатай **үндсэн 2 хандлага ноёлж** байв. **Нэгдүгээрх** нь тухайн үеийн ЗХУ, Зүүн Европ, Азийн социалист хэмээн нэрлэгдэж байсан орнуудад, түүний дотор манай улсад 1990 он гартал баримталж байсан байна. Үүний гол агуулга нь социализмын үед социалист эдийн засгийн хуулиудын дагуу хөдөлмөрийн нутаг дэвсгэрийн оновчтой хуваарь бий болж, бүс нутгуудыг өмчийн эзэн төрийн хөрөнгө оруулалтаар жигд хөгжүүлж болно гэж үздэгт байжээ. Гэтэл удалгүй Социалист гэгдэж байсан орнуудад улс төрийн тогтолцоо үндсэндээ өөрчлөгдсөнтэй уялдаж энэхүү хандлага ач холбогдлоо алдсан гэж үзэж болхоор байна. **Хоёрдахь хандлага нь** хувийн өмч тэргүүлэх үүрэгтэй, зах зээлийн эдийн засагт суурилсан ардчилсан тогтолцоот, өнөөгийн өндөр болон дундаж хөгжилтэй орнуудад зонхилж байсан чиглэл ажээ. Үүний үндсэн агуулга нь хүн амын орлого, ажилгүйдэл, орон сууцны нөхцөл, бүх шатны боловсрол эзэмших бололцоо, эмнэлэг, соёл урлаг, мэдээллийн үйлчилгээний хүртээмж, чанар, экологийн цэвэр орчинд амьдрах боломж зэрэгт бий болсон бүс нутгийн ялгаанаас үүдэлтэй асуудлыг санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бизнесийн орчинг сайжруулах, төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох зэрэг төрийн зохицуулалтын хөшүүргүүдийг хэрэглэн шийдвэрлэж болно гэж үздэгт ажээ. Онолын энэхүү хандлагын үзэл санаа анх Монгол Улсын шинэ Үндсэн хууль /1992 оны/-д тусгалаа олсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд “... бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх...” гэсэн заалт тусгагдсан нь манай төр, засгаас шинэ нөхцөлд бүс нутгийн хөгжлийн талаар эрч далайцтай бодлого боловсруулан хэрэгжүүлэх эрхзүйн үндэс тавигдсан гэж үзэж болно.

УИХ-аар 1994 онд батлагдсан **“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д** бүсчилсэн хөгжлийн холбогдолтой зарим зохицуулалтыг тусгасан байдаг. Тухайлбал, “... Эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох дотоод хүчин зүйлүүдэд: экологийн бодлого алдагдаж, ус, ой мод, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ багасах, бүс нутгийн хөгжлийн ялгаа гүнзгийрэх, эдийн засгийн тэнцвэр алдагдах ...” зэргийг хамруулжээ. Дараа нь Монгол Улсын Их Хурал 1995 оны 87-р тогтоолоор **“Монгол улсад эдийн**





**засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг** баталсан. Энэ үзэл баримтлалд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах гол зорилгыг “... тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газарзүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Иймээс ч Монгол Улсын Их Хурал 1996 оны 23-р тогтоолоороо **“Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”-ыг** батлан гаргасан билээ. Энэхүү үзэл баримтлалын тавдугаар зүйлд: “... нутаг дэвсгэрийг бүсчилэн хөгжүүлэх, дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, үүний дотор улсын хөндлөн гол тэнхлэгийг эхэлж байгуулах, зарим бүс нутагт эдийн засаг, худалдааны чөлөөт бүс бий болгон хөгжүүлэх”, “... бүс нутгийг дотоод, гадаад зах зээлтэй дэд бүтцийн сүлжээгээр холбож, нутаг дэвсгэрийн хөгжлийн таталцлын төв, тэнхлэгүүдийг бий болгох”, “... бүс нутгийн аймгуудыг эдийн засгийн талаар биеийг нь даалган хөгжүүлж, нутаг дэвсгэрийн харьцангуй жигд хөгжлийг хангах гэж манай төрөөс бүс нутгийн хөгжлийн талаар баримтлах бодлогын ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон.

Засгийн газраас НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар **“Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг** боловсруулан гаргасан нь аймаг, орон нутгийг даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийцүүлэн хөгжүүлэх чиглэлээр хийсэн анхны алхам болсон.

УИХ-ын 2001 оны 09-р тогтоолоор Монгол Улс хөрш зэргэлдээ болон бүс нутгийн орнуудтай хамгийн дөт замаар харьцах, далайд гарцтай болох боломж бүрдүүлэх, дотоодын дэд бүтцийн нэгдмэл сүлжээ бий болгохоор зааж, улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг, дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлүүдийг баталсан нь бүс нутгуудад дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох чиглэлээр гаргасан нэг чухал шийдвэр болсон билээ.

Гэвч дэлхийн олон оронд төрийн эрх барих дээд байгууллагын түвшинд батлан хэрэгжүүлж байдаг бүсчилсэн хөгжлийн цогц бодлого 1992 оноос 2001 оны эхэн үе хүртэл манай улсад байхгүй байв. Харин дээр дурьдсанчилан улс орны





хөгжлийн холбогдолтой бусад харилцааг шинэ нөхцөлд зохицуулах эрхзүйн үндсийг бүрдүүлэхдээ бүсчилсэн хөгжлийн холбогдолтой зарим зохицуулалтыг л авч үзэж байсан юм.

Улсын Их Хурал 2001 оны 6-р сард **“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг** батлан гаргасан нь манай улсад шинэ нөхцөлд, онол, аргазүйн шинэ хандлагын үүднээс бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлох чиглэлээр хийсэн шинэчлэлийн шинжтэй хамгийн том алхам болсон юм. Үзэл баримтлалд бүсчилсэн хөгжлийн эрхэм зорилтыг “Тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц , оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчнийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон. Мөн үзэл баримтлалд Монгол Улсыг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн 5 бүсээр бүсчилэн хөгжүүлэхээр анх удаа тусгасан нь энэ чиглэлээр хийсэн томоохон практик алхам болсон.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 1-р сарын 2-ны өдрийн 01-ээр тогтоолоор 1) Баруун бүсэд Ховд, Улиастай хот; 2) Хангайн бүсэд Хархорин, Эрдэнэт хот; 3) Төвийн бүсэд Зуунмод, Дархан хот; 4) Зүүн бүсэд Чойбалсан, Өндөрхаан хотуудыг бүсийн тулгуур төв хотууд болгохоор шийдвэрлэсэн. Энэ шийдвэрийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан чухал ач холбогдолтой шийдвэр гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)-ийг УИХ-аас 2003 онд батлан гаргасан. Уг баримт бичигт монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн стратегийн зорилтуудыг тодорхойлсон юм. Ингэснээр эдийн засгийн 4 бүсийн хөгжлийн бодлогыг харьцангуй нарийвчлан тодорхойлж, улмаар тодорхой практик арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байх эрхзүйн харьцангуй таатай орчин бүрдсэн гэж үздэг. УИХ-ын 2003 оны 5-р сарын



30-ны өдөр **“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”-ийг** баталсан билээ. Энэхүү хуулийн зорилтыг “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх эрхзүйн үндэсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс эхний ээлжинд өөрийн оронд **үйлдвэрлэл, технологийн паркуудыг** байгуулах ажил эрчимтэй өрнөж Төвийн бүсэд экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн “Дархан” үйлдвэрлэл, технологийн парк, “Зуунмод” хөгжлийн парк, Улаанбаатар хотын Налайх дүүрэгт өрхийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжих “Налайх” бизнесийн инкубатор парк, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Сэлэнгэ” үйлдвэрлэл, технологийн парк, үйлчилгээний худалдааны экспортын “Багахангай Эйрсервис” парк, Чойр хотод “Алтанговь” хөгжлийн парк, Зүүн бүсэд экспортын үйлдвэрлэлийн “Дорнод” үйлдвэрлэл, технологийн парк, Хангайн бүсэд экспортын үйлдвэрлэлийн “Эрдэнэт” үйлдвэрлэл, технологийн парк, Баруун бүсэд холимог үйлдвэрлэлийн “Ховд”, “Улиастай” үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулах ажлууд хийгдэж байна. Ингэснээр бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох алхмын эхлэл болж байна.

Энэ ажлууд **Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдэд** ч тусгалаа олж хэрэгжиж байна. Ийнхүү Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгааллын асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэхэд чиглэсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг тухайн бүсийн хөгжлийн давуу болон сул талуудад нарийвчлан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 2006-2010он, 2011-2015 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүний дүнд өнөөгийн Монгол Улс бүсчилсэн хөгжлийн цогц бодлоготой болж, Үндсэн хуулийн дээр дурьдсан заалтыг хэрэгжүүлэх нэн таатай орчин бүрдэж байна.



**“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д** Монгол улсын хөгжлийн зургаан тэргүүлэх чиглэлийг тодорхойлсоны дотор “Бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн төвшний ялгааг багасгана” гэсэн тэргүүлэх чиглэл орсон. Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх нэгдүгээр үе шатанд буюу 2007-2015 онд 1) Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгуудын хөгжлийг түргэсгэнэ, 2) Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. “Хөдөөгийн хөгжил” үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ, 3) Бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсэн суурийг тавина, хоёрдугаар үе шатанд буюу 2016-2021 онд хот хөдөөгийн хөгжлийн төвшний ялгааг эрс багасгаж, бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлнэ гэсэн стратегийн зорилтуудыг дэвшүүлсэн байна. Ингэж бүсчилсэн хөгжлийн бодлогыг улс орны урт хугацааны хөгжлийн цогц бодлоготой уялдуулан авч үзэж стратегийн зорилтуудыг тодотгон дэвшүүлсэн нь дунд болон богино хугацаанд энэ талын бодлогын хэрэгжилтийг түргэсгэхэд ихээхэн түлхэц болж байгаа юм.

Энэ бүгдийг нэгтгэн дүгнэж үзвэл өнөөгийн Монгол Улс үзэл баримтлалаас эхлээд дунд хугацааны стратеги, түүнчлэн бүс нутгуудын хөгжлийн тодорхой хөтөлбөрүүдийг агуулсан бүсчилсэн хөгжлийн цогц бодлоготой болж хэрэгжиж байна гэж хэлж болохоор байна.

Ер нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр зарим нааштай үр дүн ч гарч байна. Судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд бүс нутгуудад оруулсан төсвийн хөрөнгө оруулалт өсч эхэлсэн байна. Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг Засгийн газар 2005-2006 онд баталсаны дараа буюу 2006-2007 онд бүс нутгуудад оруулсан төсвийн хөрөнгө оруулалт бүр эрс өссөн байна. Баруун бүсэд 2005 онд 5,6 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийж байсан бол 2007 онд 74,8 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийж 13 дахин өссөн байна. Бусад бүсүүдэд оруулсан



төсвийн хөрөнгө оруулалт ч энэ мэтчилэн өссөн. Энэ үед манай улсын экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өсч, төсвийн орлого нэмэгдэж, төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн нь шийдвэрлэх ач холбогдолтой байсан хэдий ч, бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөрүүд батлагдаж ямар бүсэд, ямар аймагт, ямар хотод хаана, ямар салбарт эхний ээлжинд хөрөнгө оруулах талаар Засгийн газрын бодлого нэгэнт тодорхой болсон байсан нь хөрөнгө оруулалтыг хугацаа алдалгүй хийх таатай нөхцлийг бүрдүүлсэн байна.

Бүс нутгуудыг хөгжүүлэх төрийн бодлого тодорхой болж, төсвийн хөрөнгө оруулалт өсч эхэлсэнтэй холбоотойгоор манай иргэдийн үзэл бодолд ч зарим эерэг өөрчлөлт гарч Улаанбаатар хот болон Төвийн бүсийг зорьсон “Их нүүлэл” ямар нэгэн хэмжээгээр саарч байна. Хөдөөнөөс нийслэл хотруу 1992 онд шилжин явж байсан хүний тоо 2010 онд Баруун бүсэд 40 хувиар, Зүүн бүсэд 73 хувиар, Хангайн бүсэд 95 хувиар, Төвийн бүсэд 96 хувиар тус тус буурсан байна. Баруун бүсээс 1998 онд шилжин явж байсан хүний тоог 2010 оныхтой харьцуулбал даруй 21 хувиар буурчээ.

Сүүлийн гурван жилийн дунджаар дийлэнх бүс нутаг, аймгуудад хүн амын жилийн дундаж өсөлт ч эерэг үзүүлэлттэй гарч байна. Өнөөдөр манай аймгуудын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр, ИТХ-аас гаргаж байгаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн холбогдолтой олон шийдвэрүүд нь үндсэндээ дээр дурьдсан бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдэд тулгуурлаж байна.


**Бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлууд.** Хэдийгээр дээр дурьдсанчилан зарим нааштай үр дүн гарч байгаа боловч улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин бүхэлдээ харьцангуй доогуур, үүнтэй холбоотойгоор бүс нутгуудын хөгжлийг дэмжих эдийн засаг, санхүүгийн боломж хязгаарлагдмал, түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаа зарим талаар учир дутагдалтай зэрэг цөөнгүй хүчин зүйлсээс хамааралтай тулгамдсан асуудлууд олон байна. Эдгээр асуудлуудаас зарим томоохныг нь дараах байдлаар товчхон тодорхойлж болох юм. **Үүнд:**



**Эдийн засгийн хүрээний томоохон тулгамдсан асуудлууд.** Өнөөгийн байдлаар бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур байна. Нэг хүнд ноогдох ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн) улсын дундажтай харьцуулбал Баруун бүсэд 52 хувиар, Төвийн бүсэд 38 хувиар, Зүүн бүсэд 26 хувиар тус тус бага байгаагаас үүнийг тодорхой харж болохоор байна.

Мөн бүс нутгуудын эдийн засгийн салбарын бүтэц ч харьцангуй ихээхэн хоцрогдсон хэвээр байна. Жишээлбэл, 2008 оны байдлаар Баруун бүсийн ДНБ-ий 69,8 хувийг бэлчээрийн МАА-д суурилсан ХАА-н салбарт, 27,8 хувийг бөөний болон жижиглэн худалдаа зонхилсон үйлчилгээний салбарт, зөвхөн 2,4 хувийг аж үйлдвэр, барилгын (21 дугаар зураг) салбарт үйлдвэрлэж байна.

**Бүсүүдийн ДНБ – ийн салбарын бүтэц, 2008 он**



21 дүгээр зураг.

Гэтэл улсын дунджаар ДНБ-ий 18,8 хувийг ХАА-н салбарт, 38,5 хувийг аж үйлдвэр, барилгын салбарт, 42,7 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэж байна.

Бүс нутгуудад түүний дотор хот суурины дэд бүтцийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур байна. Тухайн бүс хот суурин, аймгийн төрөл бүрийн замын



шилжүүлсэн нийлбэр урт, нутаг дэвсгэрийн талбай, ДНБ-ний хэмжээ, хүн амын тоо зэрэг үзүүлэлтүүдийг тооцон хийсэн энэхүү үнэлгээний дүнгээс үзэхэд Баруун болон Зүүн бүсэд төрөл бүрийн замын сүлжээний хангамж ихээхэн доогуур байна. Тухайлбал төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн түвшин Баруун бүсийн Завхан аймагт Төвийн бүсийн Сэлэнгэ аймгаас 18,3 дахин, Төв аймгаас 11,4 дахин доогуур байна. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэл, үйлчилгээний тээврийн зардал хэт өндөр байна. Эрчим хүчний дэд бүтцийн хувьд ч шийдвэрлэх шаардлагатай асуудлууд цөөнгүй байна. Өнөөгийн байдлаар баруун бүсийн Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний хангамжийг эрс сайжруулах шаардлагатай байна. Сум, багийн түвшинд эрчим хүчний хангамж, мэдээлэл холбооны үйлчилгээг орчин үеийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагын түвшинд хүргэх шаардлагатай байна.

**Нийгмийн хүрээний тулгамдсан асуудлууд.** Манай бүс нутгуудад **ядуурал** харьцангуй их байна. Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны дүнгээс ядуурлын хамралтын хүрээ 2007-2008 онд улсын дунджаар 35,2 хувьтай байхад Баруун бүсэд 47,1 хувь, Хангайн бүсэд 48,5, Улаанбаатарт 21,9 хувь байна. Төвөөс алслагдсан сул хөгжилтэй бүс нутгуудад, тухайлбал, Баруун бүсэд ядуурал хамгийн их байна. Ядуурлын гол шалтгаан нь эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур байгаатай холбоотойгоор бүс нутгуудад, ялангуяа сул хөгжилтэй бүс нутгуудад ажлын байр хэт ховор байгаатай холбоотой ажээ. Өнөөгийн байдлаар аймаг сумд, хот суурины төвд ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, засаг даргын тамгын газар зэрэг төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны байгууллагуудад хязгаарлагмал тооны ажлын байр байгаа юм байна. Эдгээр ажлын байр нь тооны хувьд эрс өсөн нэмэгдэж байдаг ажлын байр биш юмаа. Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломж хязгаарлагмал байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын тооны өсөлтийг дагаж ажлын байрны тоо өсөх нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Ажилгүйдэл их байгаа нь ядуурал тууштай буурахгүй байхын үндсэн шалтгаан ажээ.

Бүс нутгуудын ядууралтай холбоотой онцгой анхаарах шаардлагатай нэг асуудал бол сүүлийн жилүүдэд аймаг, сумдын төвтэй харьцуулбал **хөдөө нутагт**



**ядуурал өсөх хандлагатай байгаа явдал мөн.** Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны дүнгээс үзэхэд хөдөө нутагт ядуурал дунджаар 49,7 хувьтай байна. Энэ нь юуны өмнө ган, зудтай жил малын жил малын хорогдол эрс өсч малчид малгүй болж, улмаар ядуучуудын эгнээнд олноороо шилжин ордогтой холбоотой ажээ.

**Байгалийн нөөцийн ашиглалт, байгаль хамгааллын холбогдолтой асуудлууд.** Өнөөгийн Монгол улсад экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал ч бас улам бүр бүс нутгийн шинж чанартай болж байна. Энэ нь юуны өмнө бүс нутгуудын хооронд эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний ялгаа ихсэж зарим бүс нутгуудад хүн, мал, үйлдвэрлэл хэт бөөгнөрч байгаатай холбоотой. Төвийн бүс нутагт 1990 оноос хойш хүн, мал хэт бөөгнөрөн нутаг дэвсгэрийн даац, ачаалал хэтэрч, экологийн тэнцвэрт байдал ихээхэн алдагдаж байгаагаас гадна ашигт малтмал олборлолт өсч, мал сүргийн бүтэц эрс муудаж байна.

Монгол улсад экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал нь ус, агаарын бохирдол, хөрсний эвдрэл, бэлчээрийн даац хэтрэлт, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөн дор бий болсон цөлжилтийн үйл явц зэргээр илэрч байна. Судлаачдын үзэж байгаагаар төвийн бүс нутагт, томоохон хотуудын ойр орчимд гадаргын болон гүний усны бохирдол ихсэх хандлагатай болж байна. Ялангуяа, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сүхбаатар зэрэг хотуудын орчимд Туул, Хараа, Орхон, Хангал голуудын урсац багасч, усны нөөц бохирдож, эрдэсжилтийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс байнга давах болжээ.

Манай улсын томоохон хотуудын дулааны цахилгаан станц, гэр хороолол, тээврийн хэрэгслийн утаа, элэгдэл эвдрэлд орсон газрын гадаргуунаас босдог тоос шороотой холбоотойгоор агаар дахь хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ ), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) –ийн хэмжээ ихсэж, агаар ихээхэн бохирдсон, эдгээр нь хүн амын амьсгалын замын өвчин ихсэхэд нөлөөлж байна.

Газар тариалангийн гол бүс нутаг болох Орхон-Сэлэнгийн сав нутагт нийт эргэлтийн талбайн 50 орчим хувь ямар нэгэн хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орсон





байна. Бэлчээрийн даац ашиглалтанд гарсан гажуудал, түүнчлэн дэлхийн уур амьсгалын дулаарлаас үүдэн манай орны янз бүрийн бүс нутагт бэлчээр ихээхэн талхлагдаж, цөлжилт нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 72 хувь их, бага ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөд өртөөд байна.

Сүүлийн жилүүдэд манай бараг бүх аймагт ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолтын хэмжээ өссөнтэй холбогдож, хөрс эвдэрч, ургамал нөмрөгийн байдал ихээхэн муудах хандлагатай болов. Жилд ойролцоогоор 800 мянган шоо метр хөрс хуулж байна. Биологийн зарим төрөл зүйл зарим бүс нутгуудад устаж алга болох аюул ч нүүрлэж байна.

Дээр дурьдсанаас үзэхэд манай бүс нутаг, аймаг, хотуудын хэмжээнд байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах ажлыг сайжруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах явдал онцгой ач холбогдолтой болж байна.

**Бүсчилсэн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх зарим арга зам.** Манай улсад бүсчилсэн хөгжлийн холбогдолтой асуудлуудыг амжилттай шийдвэрлэхийн тулд юуны өмнө энэ талын бодлогын хэрэгжилтийг түргэсгэх шаардагтай байна. Өнөөдөр шинэ тогтолцоонд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлого байв ч хэрэгжилт нь удаан байна. Аливаа бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тодорхой арга хэрэгслүүдийг хэрэглэдэг нийтлэг жишиг байдгийг та бид сайн мэднэ. Зах зээлийн эдийн засагт суурилсан ардчилсан тогтолцоот орнуудад бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж сул хөгжилтэй бүс нутгуудын хөгжлийг дэмжихдээ **1) санхүүгийн дэмжлэг үзүүлэх, 2) бизнесийн орчинг сайжруулах, 3) төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох** гэсэн үндсэн гурван чиглэлийн арга хэрэгслүүдийг өргөн хэрэглэж байна. Манай улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон өмнө дурьдсан бусад баримт бичгүүдэд эдгээр арга хэрэгслүүдийг хэрэглэх үндсэн чиглэл нэгэнт тусгалаа олсон. Харамсалтай нь эдгээрийг хэрэглэх явдал өнөөгийн шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Иймд өнөөдөр эдгээр арга хэрэгслийг оновчтой хэрэглэх талаар эрдэмтэд зарим саналыг дэвшүүлж байна. **Үүнд:**





**Үйлдвэрлэл, үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга зам.**

Санхүүгийн дэмжлэгийг зах зээлийн тогтолцоот орнуудын нийтлэг жишгээр улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөнгөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, ажлын байр шинээр бий болгосны урамшуулал олгох зэрэгт түлхүү чиглүүлэх шаардлагатай байна. Энэ чиглэлээр эхний ээлжинд дараах арга хэмжээг авч болох гэж үзэж байна. **Үүнд:**

**Бүс нутаг, аймаг хотуудад улсын хөрөнгө оруулалтаар илүү оновчтой дэмжих.** Эхний ээлжинд бүсийн тулгуур төв хотуудад байгуулах, үйлдвэрлэл, технологийн паркуудыг улсын хөрөнгө оруулалтаар дэмжих. Юуны өмнө эдгээр паркуудын дэд бүтэц (усан хангамж, эрчим хүч г.м.)-ийг улсын хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин сайжруулах хэрэгтэй ажээ. УИХ 2009 оны 12 дугаар сард “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль” – ийг батлан гаргаж энэ талын эрх зүйн таатай орчин бүрдээд байна. Үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулан ажиллуулснаар манай бүс нутаг, аймгуудад мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах болон хүнсний үйлдвэрлэл орон нутгийн хотуудад эрс өсөх нь дамжиггүй. Үүнтэй холбоотойгоор бүс нутаг аймгуудын эдийн засгийн салбарын бүтэц сайжирч, ажлын байрны хангамж нэмэгдэж ядуурал буурах нөхцөл бүрдэх ажээ. Мөн экспортын баримжаатай бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үндэс суурь бий болж МАА-н түүхий эдийн үнэ ханш тогтвортой өндөр байх нөхцөл бүрдэж, улмаар малчдын орлого өсч байх таатай орчин бүрдэх ажээ. Энэ нь малчдыг ядууралд өртөхөөс хамгаалах чухал арга хэмжээ болох юм байна.

**Бүс нутаг, аймгуудыг үйлдвэрлэл, үйлчилгээг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих.** Арилжааны банкуудын санхүүгийн боломж хязгаарлагдмал байгаа өнөөгийн нөхцөлд “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тусгагдан байгуулагдсан “Хөгжлийн банк”-ийг хүчтэй болгож эхний ээлжинд энэ банк улсын төсөв, гадаадын зээл тусламжаас, түүнчлэн Оюу толгойн, Таван толгойн зэрэг стратегийн ач холбогдолтой ордуудыг ашигласнаар олох орлогоос бүс нутаг, аймгуудад үйлдвэрлэл, үйлчилгээг урт хугацааны бага хүүтэй зээлээр дэмжих



учиртай гэж үзэжээ. Тухайн үедээ Япон, Өмнөд Солонгос зэрэг хэд хэдэн оронд төрийн мэдлийн төрөлжсөн банкуудыг байгуулан ажиллуулж амжилт олж байжээ. Солонгос улс Солонгосын хөгжлийн банк, Солонгосын экспорт, импортын банк зэрэг төрийн банкуудыг байгуулан ажиллуулж дунд болон урт хугацааны зээл, хөрөнгө оруулалтыг эрс өсгөж ихээхэн амжилт олж байсан байна.

***Сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудын эдийн засгийг татварын ялгавартай бодлогоор дэмжих.*** Өнөөгийн байдлаар манай улсын татварын багц хуулинд ийм дэмжлэг тусгагдаагүй байна. Амьдрал дээр манай олонх бүс нутаг, аймгуудад аж ахуйн нэгжээс бүрдүүлж байгаа татварын орлого хэт бага байна. Үүний зэрэгцээ татвар төлөгч томоохон аж ахуйн нэгжүүдийн төлж байгаа татварын хэмжээ сүүлийн 3 жилийн байдлаар зарим бүс нутагт буурах хандлагатай байна. Ганцхан жишээ татахад баруун бүсийн Завхан аймагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлж байгаа татварын хэмжээ нь 2010 оны байдлаар аймгийн татварын нийт орлогын дөнгөж 10,7 хувийг эзэлж байна. ийм нөхцөлд манай харьцангуй сул хөгжилтэй бүс нутгуудын аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, эсвэл тодорхой хугацаагаар татвараас чөлөөлж байж татварын бааз суурийг нь өргөтгөж, улмаар татварын орлогыг нь нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж үзжээ.

Бидэнд энэ зорилгоор ашиглаж болох судалгааны зарим үр дүн ч байна. Тухайлбал, манай улсын бүс нутаг, аймгуудын хөгжлийн түвшний нэгдсэн индексийг тооцоолжээ. Ингэснээр эдгээр индексийн утгуудыг хэрэглэн бүсийн ялгавартай татварын бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж болох ажээ.

***Сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудын аж ахуйн нэгжүүдэд ажлын байр шинээр бий болгосны урамшуулал олгож байх.*** Тухайн үедээ Англи улсад хэрэглэж багагүй амжилт олж байсан энэ аргыг манай харьцангуй сул хөгжилтэй бүс нутгуудад хэрэглэж болох байна. Ажлын байр шинээр бий болгосны урамшуулал олгож эхлэх нь бүс нутаг, аймгуудад бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, ядуурал буурахад багагүй эерэг нөлөөлөл үзүүлэх болно гэж үзсэн байна.



### **1.1.5 Бүс нутаг, аймаг хотуудад бизнесийн орчинг сайжруулах арга зам.**

Сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудад бизнесийн орчинг сайжруулах зорилгоор **үйлдвэрлэлийн** (эрчим хүч, төрөл бүрийн зам, харилцаа холбоо г.м) дэд бүтэц, банк санхүүгийн тогтолцоо, төрөл бүрийн бирж, мэдээллийн сүлжээ зэргийг боловсронгуй болгох, сайжруулах шаардлагатай байна. Засгийн газраас энэ жилийг бизнесийн орчинг сайжруулах жил болгон зарлаж тодорхой арга хэмжээ авч байгаа нь сайшаалтай. Эхний ээлжинд дор дурьдсан чиглэлээр түлхүү анхаарах нь чухал гэж үзэжээ. **Үүнд:**

**Бүс нутгуудад төрөл бүрийн замын болон эрчим хүчний сүлжээг эрс сайжруулах.** Энэ чиглэлээр юуны өмнө Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан “Мянганы зам”-ын хэвтээ, босоо тэнхлэгийг барьж дуусгах түүнчлэн 2015 оноос наана бүсийн болон аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх. Жишээлбэл, Баруун бүсийг яаралтай холбох хэрэгтэй ажээ. Үүний дүнд сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудад үйлдвэрлэл, үйлчилгээний өөрийн өртөг буурч үйлдвэрлэл өсөх хандлагатай байна. Экспортын бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх таатай орчин бүрдэх боломж нэмэгдэнэ гэж үзэжээ.

**Сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудын боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийг хурдасгах.** Энэ зорилтын дагуу төсвийн хөрөнгө оруулалтыг бүсийн болон аймгийн төв, түүнчлэн аймаг, дотоодын бичил бүсүүдийн төвүүдээр тодорхой ялгавартай, оновчтой, нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Бүс нутаг, аймгуудад стандартын шаардагыг хангасан хувийн хэвшлийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудыг тууштай дэмжих нь чухал байна. Мэргэжилтэй ажилчдыг бэлтгэхэд ихээхэн анхаарах шаардлагатай байна. Одоо ажиллаж байгаа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжихийн зэрэгцээ зарим тулгуур төвүүдэд шинээр Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулан ажиллуулах шаардлагатай ажээ.

**Сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудад зах зээлийн дэд бүтцийг сонгодог агуулгаар нь бий болгох.** Энэ зорилгын хүрээнд санхүү зээлийн, эдийн засаг- мэдээллийн, эдийн засаг- эрх зүйн, худалдаа- зуучлалын гэх мэт зах



зээлийн дэд бүтцийг сонгодог агуулгаар нь бий болгон хөгжүүлэх тодорхой бодлогыг төрөөс дэвшүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэснээр бизнесийн орчин сайжирч, эдийн засаг ихээхэн идэвхжиж таатай нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

**I.1.6 Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох арга зам.** Бүс нутаг, аймгуудад бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг дараах байдлаар сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Баруун, Хангайн, Зүүн, Төвийн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.** Энэ зорилгын хүрээнд Үндэсний хөгжлийн цогц бодлогод тодотгон дэвшүүлсэн стратегийн зорилтуудтай уялдуулан бүс, аймгуудын хөгжлийн цогц бодлогыг боловсруулах ажил эхэлсэн ч улам эрчимжүүлэх. Ингэснээр Монгол Улсынхаа хөгжилд аймгуудын оруулах хувь нэмэр өсч, улсын татаас харан суудаг өнөөгийн муу зуршил арилах нөхцөл бүрдэх ажээ. Нилээд олонх аймгууд урт хугацааны буюу 5-аас олон жилийн алсыг харсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегигүй байна. Урт хугацааны алсыг харсан хөгжлийн бодлогогүй байгаа нөхцөлд дунд хугацааны буюу 5 хүртэлх жилийн, богино хугацааны буюу 1-2 жилийн хөгжлийн бодлогыг бодит байдалд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох боломжгүй юм. Бүс, аймгуудын хөгжлийн цогц бодлогод дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн цөөнгүй асуудлуудыг шийдвэрлэхэд ч онцгой анхаарах шаардлагатай болж байна. Өнөөгийн байдлаар Хангайн бүсийн аймгуудаас гадна Говь-Алтай, Завхан, Дархан-Уул, Дорнод зэрэг хэд хэдэн аймаг Үндэсний хөгжлийн цогц бодлого болон тухайн бүсийнхээ хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан аймгийнхаа хөгжлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

**Үйлдвэрлэл, технологийн парк, цогцолборуудыг байгуулах ажлыг яаралтай эхлүүлэх.** Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Сүмбэр, Дорнод, Орхон, Ховд, Завхан аймаг, Хархоринд үйлдвэрлэл, технологийн парк, цогцолборуудыг байгуулснаар юуны өмнө МАА-н гаралтай түүхий эдийг өндөр технологи хэрэглэн бүрэн боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд гаргаж ихээхэн ашиг олох



нөхцөл бүрдэх юм. Ялангуяа хөрш зэргэлдээ БНХАУ –ын болон ОХУ –ын дэлхийд томоохонд ордог зах зээлд ийм чиглэлийн бэлэн бүтээгдэхүүний хэрэгцээ тогтмол өсч байна.

**Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг байгуулах ажлыг хурдасгах.** Замын –Үүд, Алтанбулаг, Цагаан нуурын эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдийг байгуулах ажлыг (22, 23, 24 дүгээр зураг) эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах талаар Засгийн газар, холбогдох яамд, аймгуудын түвшинд идэвхитэй ажиллах хэрэгтэй байна.

### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСҮҮД




22 дугаар зураг.





“Замын-Үүд”-ийн ЭЗЧБ-ийн ерөнхий төлөвлөгөө



- Таних тэмдэг**
- Чөлөөт худалдааг дэмжих бүс
  - Амралт, зугаалгын бүс
  - Үйлдвэр, агуулахын бүс
  - Суурьшлын бүс
  - Иргэнийн дэд бугац, зам тээврийн бүс


“Замын-Үүд”-ийн үндсэн бүсчлэл



“Замын-Үүд”-ийн замын сүлжээ



“Замын-Үүд”-ийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг 5. Газар ашиглалтын бүсчлэл

- |                                |                                |                               |
|--------------------------------|--------------------------------|-------------------------------|
| <b>Таних тэмдэг</b>            | Орон сууцны бүс                | Улирлын дэд бүтэц             |
| Үйлдвэр, агуулахын бүс         | Худалдаа бизнесийн бүс         | Амралт зугаалгын бүс, казино  |
| Худалдаа бизнесийн бүс         | Ногоон бүс                     | Төмөр замын бүс               |
| Ногоон бүс                     | Шинжлэх ухаан технологийн парк | Авто вокзал                   |
| Шинжлэх ухаан технологийн парк | Чөлөөт худалдааны бүс          | Хил гаалийн шалган нэвтрүүлэх |
| Чөлөөт худалдааны бүс          | Холлимог бүс                   | Мэдээлэл технологийн парк     |
| Холлимог бүс                   | Засаг захиргааны бүс           | Агуулахын бүс                 |
| Засаг захиргааны бүс           | Олон улсын ажил хэргийн бүс    | Төмөр замын вокзал            |
| Олон улсын ажил хэргийн бүс    | ШТС                            | Ачаа тээврийн терминал        |
| ШТС                            |                                |                               |

23 дугаар зураг.

Боловсруулсан материалгаас шууд авааг





24 дүгээр зураг





**Сум бүрийн хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.** Өнөөгийн байдлаар аймгуудын нэгэн адил олонхи сум урт хугацааны буюу 5-аас олон жилийн алсыг харсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегигүй байна. Сум бүр хөгжлийн стратегиа тодорхойлон хэрэгжүүлснээр аймгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах учиртайг тооцох нь зүйтэй.

**“Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөр” –ийг гарган хэрэгжүүлэх.** Манай бүс нутгуудад дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай ган, зуд зэрэг байгалийн гамшиг үзэгдлийн давтамж ойртож, ард түмний амьдрал ахуйд ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Иймд энэхүү өөрчлөлтөөс үүдэн бий болж байгаа хүндрэл бэрхшээлийг даван туулах төрийн бодлогыг хугацаа алдалгүй тодорхойлж хэрэгжүүлэх нь хойшлуулшгүй зорилт мөн.

**Улсын төсөвт бүсчилсэн хөгжлийн зорилтуудыг сайтар тусгаж байх.** Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон жил бүрийн төсөвт бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд УИХ-аас тодорхойлсон зорилтуудыг бүрэн тусгаж чадахгүй байна. Өнөөгийн байдлаар улсын төсвийн төслийг боловсруулахдаа өнгөрсөн жилүүдийнхтэй нь харьцуулах хандлага давамгайлж, ирээдүйгээ харж хөрөнгө зардлыг төсөвлөх явдал дутагдаж байна. Ер нь хөгжлийн төлөвлөлтөд индикатив төлөвлөлтийн арга зүйг хэрэглэх талаар ихээхэн анхаарах нь зүйтэй санагдна.

**Үндэсний болон бүс нутгийн, түүнчилэн салбарын хэмжээний кластеруудыг манай улсад бий болгох бодлогыг хугацаа алдалгүй тодорхойлж хэрэгжүүлэх.** Харвардын их сургуулийн профессор Майкл Порторын дэвшүүлсэн эдийн засгийн өрсөдөх чадварыг кластерийн хандлагаар сайжруулах бодлогыг АНУ, Англи, Канад, Франц, Финлянд, Швеци, Өмнөд Солонгос, Японд амжилттай хэрэгжүүлж байна. Мөн ОХУ-д ч амжилттай хэрэгжүүлж байна. Кластерийн хандлагын гол агуулга нь газарзүйн байршлын хувьд нэг дор оршдог толгой компани болон түүнийг дагасан бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ төрөлжсөн компаниудын хамтын ажиллагааг цогц байдлаар авч үзэж оновчтой дэмжихэд оршиж байгаа юм. Кластерийн хандлагыг 3 түвшинд



пирамид хэлбэрээр авч үзэн төсөөлж болох юм. Үүнийг Финляндийн Nokia компанийн туршлагаас тодорхой харж болно. Хэльсинк хотод байршилтай толгой компани буюу Nokia компани нь пирамидын дээд хэсэгт буюу эхний түвшинд үйл ажиллагаа явуулж байдаг. Хоёрдох түвшинд буюу пирамидын дунд хэсэгт толгой компани болох Nokia компанид зориулан гар утасны тодорхой хэсгүүдийг нийлүүлж байдаг мянга гаруй компани ажиллаж байдаг байна. Харин бидний төсөөлж буй пирамидын суурь буюу доод хэсэгт толгой компанид санхүүгийн, хүний нөөцийн, дэд бүтцийн зэрэг үйлчилгээг үзүүлж байдаг олон тооны компаниуд ажиллаж байдаг байна. Ийм байдлаар хамтран ажиллан Nokia компани өрсөлдөх чадвараа сайжруулж, гар утасны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэх компанийн нэг болжээ. Өрсөлдөх чадвар султай манай компаниудын хувьд дэлхийн зах зээлд найдвартай байр суурь эзлэх гол арга зам нь энэ хандлага гэж үзэж байна. Иймд юуны өмнө манай бүс нутгуудад МАА-н гаралтай түүхий эдийг боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнчлэн экспортлох зориулалттай төрөлжсөн кластеруудыг бий болгон хөгжүүлэх талаар төрөөс онцгой анхаарч дэмжих шаардлагатай байна.

***Алслагдсан бүс нутаг, сул хөгжилтэй аймгуудын төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх шаардлагатай байна.*** Энэ хүрээнд сул хөгжилтэй бүс нутаг, аймгуудыг өндөр мэдлэг чадвартай боловсон хүчнээр хангахын тулд орон сууцны дэмжлэг үзүүлж, бүс нутгийн ялгавартай цалин, эсвэл бүсийн нэмэгдэл олгодог системд шилжих хэрэгтэй байна.

***Бүсчилсэн хөгжлийн хууль эрх зүйн орчинг ч сайжруулах шаардлагатай байна.*** Өнөөгийн байдлаар “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдагын тухай хууль”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн тухайн хууль”, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухайн хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Татварын ерөнхий хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухайн хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Хөдөлмөрийн хууль”, “Эрүүгийн хууль”, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль” зэрэг нийт 10 гаруй хуульд энэ чиглэлийн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.



## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БҮСҮҮДИЙН ХҮРЭЭН ДЭХЬ ХАНГАЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИН ХЭТИЙН ТӨЛӨВ.**

**I.2.1 Хангайн бүсийн хөгжлийн түвшин, хэтийн төлөв.** Хангайн бүс бусад бүсүүдийн нэгэн адил эдийн засгийн хөгжлийн түвшингээр доогуур, тухайлбал Орхон аймгаас бусад бүсийн аймгуудын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ улсын дунджаас 2.0-2.7 дахин бага ажээ.

Хангайн бүсийн хүн амын тоо 552.5 мянга буюу улсын нийт хүн амын 21.8 хувь нь энэ бүсэд амьдарч байна. Тус бүсэд хүн амын өсөлт бусад бүсүүдийн адил сүүлийн жилүүдэд буурч байгаа боловч улсын дундажтай ойролцоо байна. Хүний хөгжлийн индекс энэ бүсэд 0.638 байгаа нь улсын дундаж болон бусад бүсүүдээс доогуур байна.

Хангайн бүсэд ажилгүйдэл, ядуурал харьцангуй их байна. Тус бүсийн ажилгүйдлийн түвшин улсын дундаж (3.5)-аас 1.6 дахин өндөр байгаатай холбоотойгоор ядуурал ч бас их байна.

Хүн амын боловсрол, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлууд олон байна. Тухайлбал, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж болон хүн амд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, хүн амын хүнс тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх явдал энэ бүсэд чухал байна.

Хангайн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 27.8 хувийг хөдөө аж ахуй, 55.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 16.9 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна. Гэвч Орхон аймгаас бусад аймгуудад хөдөө аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувийг эзэлж байна. Иймд бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшинг дээшлүүлж, бүтцийг нь шинэчлэх шаардлагатай болж байна.

Тус бүсэд аж үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ харилцан адилгүй хөгжсөн байна. Энэ бүсэд уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрээс өөр улсын хэмжээний томоохон үйлдвэр байхгүй байна.



Бүсийн аймгуудад урьд өмнө нь ажиллаж байсан үйлдвэрийн газрууд бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй, зарим нь татан буугдаж үйл ажиллагаагаа зогсоожээ.

Хангайн бүс нь мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх ихээхэн нөөц боломжтой бөгөөд улсын нийт мал сүргийн 32.3 хувь нь энэ бүсэд ногдож байна. Гэвч тус бүс энэхүү нөөцөө бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа ажээ. Иймд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг олноор бий болгох, хүн амын орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрийг түшиглэн зэс, молибдений үйлдвэр байгуулах, мөн Хөвсгөлийн фосфорит, Эрдэнэтийн зэсийг хими-технологийн аргаар хослон ашиглах нь тус бүсийн төдийгүй манай улсын эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж байна.

Хангайн бүсэд харьцангуй сайн судлагдсан байгалийн эрдэс түүхий эдийн нөөц цөөнгүй байна. Тухайлбал, нөөц нь тогтоогдсон Тавтын алтны орд, Сайхан голын төмөр-манганы орд, Бүрэнхааны фосфоритын орд, Дөшийн гол, Өвөр мараатын хөнгөн цагааны орд зэргийг дурдаж болох байна. Эдгээр орд газруудыг түшиглэсэн судалгаа, туршилтыг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, боловсруулах үйлдвэр байгуулах нь тус бүс нутаг эдийн засгийн хувьд бие даах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой ажээ.

Хангайн бүсэд төрөл бүрийн замын сүлжээг, түүний дотор сайн чанарын авто замын сүлжээг өргөтгөх явдал тулгамдсан асуудлын нэг болж байна.

Одоогийн байдлаар бүсийн аймгийн төвүүд эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон боловч сумдын 40 орчим хувь нь төвийн эрчим хүчний системд хамрагдаагүй байна. Иймд бүсийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, ялангуяа бүсийн нийт өрхийн 51.9 хувийг эзэлдэг малчин өрхийг эрчим хүчний эх үүсвэртэй болгох шаардлагатай байна.



Тус бүсийн цахилгаан холбооны суурь сүлжээг иж бүрнээр нь тоон технологид шилжүүлж, орчин үеийн мэдээллийн сүлжээнд сумдын төвийг бүрэн холбох хэрэгцээ гарч байна.

Хангайн бүсийн эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлага ч байна. Юуны өмнө хилийн гарц, боомтуудыг тохижуулах, худалдааны чөлөөт бүс байгуулахад анхаарах шаардлагатай юм.

Сүүлийн жилүүдэд хүний сөрөг үйл ажиллагаа болон байгаль, цаг уурын өөрчлөлтөөс үүдэн Хангайн бүсэд амьтан, ургамлын төрөл зүйл ховордох, бэлчээр талхлагдах, хөрсний элэгдэл эвдрэл нэмэгдэх, цөлжилтийн үйл явц эрчимжих, усны нөөц багасах, бохирдолт нь ихсэх зэрэг олон сөрөг нөлөөлөл бий болж байна. Иймээс байгалийн баялагийн нөөцийг судалж, эдийн засгийн нэгдсэн үнэлгээ тогтоох, тэдгээрийн экологийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

Хангайн бүсийн ой, ан амьтан, цэнгэг ус, эрдсийн нөөц баялаг, мал аж ахуйн түүхий эд, газар тариалан эрхлэх харьцангуй таатай нөхцөл боломж, рашаан сувилал, аялал жуулчлалын арвин нөөц, тэдгээрийг ашиглаж ирсэн туршлага, үйлдвэрлэлийн чадавхийг сэргээн ашиглах явдал цаашдын хөгжлийн гол гарц гэж ойлгож байна.

Бүсийн төв хот болон сум сууринд ядуурал, ажилгүйдлийн түвшин төдийлэн дорвитой буурахгүй байгаа, дэд бүтцийн хөгжил сул, мэдээллийн технологи бүрэн нэвтрээгүй, зах зээлийн багтаамж бага, төсөв санхүүгийн чадавхи дорой байна.

Иймээс хөгжлийн үндэс болсон дэд бүтцийн асуудлыг бүс нутгийн хүрээнд зохистой шийдвэрлэх хэрэгтэй байна.

Хангайн бүсийн хувьд мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт сувилал, жижиг, дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх явдлыг тус бүсийн хөгжлийн ойрын зорилт болгох шаардлагатай байна.



Хангайн бүсийн босоо тэнхлэгийн замыг барьж байгуулах, эхний шатанд Булган, Хархорины хооронд хатуу хучилттай замыг барих ажлыг ойрын хугацаанд шийдэх нь энэ бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх, Эрдэнэтийн хөнгөн үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, улмаар бүс дотроо аж ахуйн хэлхээ холбоо үүсэн бүрэлдэх, үйлдвэрлэл, худалдааны сүлжээ бий болох.

Өнөөгийн байдлаар Хөвсгөл, Архангай, Булган аймгийн аж ахуйн нэгж, иргэдийн зах зээлд хандсан урсгал хөдөлгөөн Эрдэнэт рүү зохих хэмжээгээр чиглэж байна. Хархорин хотыг Хангайн бүсийн тулгуур төвийн нэг болгон хөгжүүлснээр Өвөрхангай, Баянхонгор аймаг, Архангай аймгийн урд сумдын худалдаа, бизнесийн төв болох юм. Эрдэнэт хот Хангайн бүсийн үйлдвэр, худалдааны гол төв, Мөрөн, Хатгал, Хархорин, Цэцэрлэг хотууд аялал жуулчлалын төв, Ханх нь хилийн худалдааны төв болон хөгжих боломжтой байна.

Бүсийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн бүсийн аймгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх, Архангай аймагт сарлагийн хөөвөр, хялгас боловсруулах, барилгын модон болон хүрмэн чулуун материал үйлдвэрлэх, Баянхонгорт тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах, рашаан сувилал хөгжүүлэх, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангайд усалгаатай газар тариалан эрхлэх, төв, суурин газрын дэргэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, бүсийн тулгуур төвүүдэд мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, хүчин чадлыг нь бүрэн ашиглах, бүсийн хэмжээгээр эрдэс баялгийн нөөцөд тулгуурласан олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх. Ингэснээр бүсийн хэмжээнд эдийн засгийг тэтгэх чадвартай түшиц аж ахуйн нэгжүүд бий болох бүрэн боломж байна.

Манай Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 оны байдлаар Орхон аймгаас бусад бүсийн аймгуудын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 278.1-374.1 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 2.0-2.7 дахин бага байна.





Хангайн бүсийн Орхон аймгаас бусад аймгууд төсвийн зарлагынхаа 50 хүрэхгүй хувийг нь орлогоороо бүрдүүлж, 40-50 хувийг нь улсын төсвөөс олгосон татаасаар нөхөж байна. Энэ нь эдгээр аймгуудад татвар төлөх томоохон аж ахуйн нэгж байхгүй, жижиг, дунд үйлдвэрүүд хөгжөөгүйтэй холбоотой ажээ. Цаашид бүсийн аймгууд бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх алхмыг шийдэх нь тус бүсийн нэн тулгамдсан асуудал болж байна.

Хангайн бүсийн хөгжлийн түвшний нэгдсэн индекс нь 0251 байгаа нь Улаанбаатарын бүсээс 2.1 дахин бага, Төвийн бүсээс 18.2 хувиар бага, улсын дунджаас 26.0 хувиар доогуур байна. Энэ нь Хангайн бүсийн аймгуудын хөгжлийн түвшин харьцангуй доогуур байгааг харуулж байна. Түүнчлэн Хангайн бүс дотроо аймгуудын хөгжлийн түвшний ялгаа их байна. Тухайлбал, 2004 оны байдлаар Баянхонгор аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ Орхон аймгийнхаас 13.2 дахин, улсын дунджаас 2.7 дахин доогуур байна.

Хангайн бүсийн эдийн засгийн бүтэц оновчтой биш, үр ашиг багатай байна. Тухайлбал, улсын нийт боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний дөнгөж 10 орчим хувь нь л энэ бүсэд ногдож байна. Харин уул уурхай, олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүний 60 гаруй хувь, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын бүтээгдэхүүний 30 гаруй хувь нь тус бүсэд ногдож байна.

Тус бүсийн Орхоноос бусад аймгийн эдийн засагт хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн салбар зонхилж байна. Тухайлбал, Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Булган аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 68.6-78.3 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Мөн Орхон аймгаас бусад аймагт аж үйлдвэр, барилгын салбар бага хувийг эзэлж байна.

Иймд Хангайн бүсийн эдийн засгийг тогтвортой түргэн хөгжүүлэх, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Өвөрхангай аймаг дахь Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн 2008 оны төсвийг өмнөх онтой нь харьцуулахад 24,3 хувиар (7 дугаар хүснэгт) нэмэгдсэн байна.

**Эмчилгээ оншилгооны зарим үндсэн үзүүлэлтүүд**

7 дугаар хүснэгт

Үзүүлэлт	2009 он	2010он
Дундаж ор хоног	10,2	10,6
Орны эргэлт	29,2	28,1
Нас баралтын хувь	1,1	1,4
Хоног болоогүй нас баралтын хувь: Нийт	32,2	18,5
Эмнэлэгт ирснээс хойш 8-24 цагийн дотор	75	40
Эмчлэгдсэн өвчтөний тоо	5876	5475
Үүнээс бусад аймгуудаас ирж эмчлэгдсэн өвчтөний эзлэх хувь	-	307
Мэс заслын дараах хүндрэлийн хувь	0,2	0,9
Задлан шинжилгээний хувь	91,9	95,2
Үндсэн оношийн зөрөөний хувь	7,0	3,8

**Хангайн бүсийн замын сүлжээний хангамжийн байдал.** Хангайн бүс нь төрөл бүрийн замын сүлжээний (25 дугаар зураг авто зам) хангамжийн үнэлгээгээр /0,89/ Төвийн бүсийн дараа ордог. Тус бүс Төвийн бүсийн энэ үзүүлэлтээс 1,8 дахин бага, харин Зүүн бүсээс 1,41 дахин, Баруун бүсээс 6,8 дахин их байна.



ХАНГАЙН БҮСИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ

M1:4500000

Зурал 25



- Дашинчилэн Булган чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-121км
- Булганы Хутаг-Өндөр-Тэшиг-Бага Илэнх чиглэлийн хатуу хучилттай зам-135км
- Тариалан-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-171км
- Өвүн нуур-Балдасгал-Их тамир чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-104км
- Баянхонгор-Байрагийн гүүр чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-128км
- Байрагийн гүүр-Атай чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-141км
- Баянхонгор-Баянги чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-212км
- Баянги-Гуравтэс чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-293км
- Баянхонгор-Баянбулаг чиглэлийн хатуу хучилттай зам барих төсөл-237км







Хангайн бүсийн аймгууд нь энэ үзүүлэлтээр хоорондоо нэлээд ялгаатай бөгөөд Орхон аймаг /4,0/ бүсдээ эхний байрыг эзэлдэг ажээ. Дархан-Эрдэнэтийн төмөр зам болон авто зам нь бүсийн зорчигч, ачаа эргэлтэд чухал ач холбогдолтой байдаг байна. Мөн Мянганы замын зэрэгцээ Улаанбаатар-Мөрөн-Улаангом, Улаанбаатар-Арвайхээр-Баянхонгор-Ховдын чиглэлийн улсын чанартай авто зам тус бүсийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг байна.

**Хангайн бүсийн эрчим хүчний хангамж.** Хангайн бүсэд нийт 3103,72 гаруй км урт цахилгаан дулааны шугам байгаа нь улсын (26 дугаар зураг Улсын эрчим хүч хангамж) нийт цахилгаан дулаан шугамын 27,76% болж байна.

Үүнээс улсын 220 кВ-ын цахилгаан дулаан шугамын 8,9%, 110кВ-ын цахилгаан дулаан шугамын 21,9%, 35кВ-ын цахилгаан дулаан шугамын 11,2% орчмын Хангайн бүсэд байна.

Баянхонгор аймаг бүхэлдээ ТЭХС-д холбогдоогүй тул цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамжаар бүсдээ доогуур байдаг ажээ. Орхон аймаг ТЭХС-ийн Эрдэнэт Булганы хэсгийн зангилаа болдог учир бүсдээ хамгийн сайн цахилгаан эрчим хүчний хангамжтай байна. Хөвсгөл аймгийн гуравхан сум ТЭХС-д холбогдсон тул цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамжаар бүсдээ доороосоо хоёрдугаарт /Баянхонгор аймгийн дараа/ ордог байна. Булган аймгийн нэгээс бусад сум ТЭХС-д холбогдсон бөгөөд бүсдээ цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамжаар хоёрдугаарт /Орхоны дараа ордог. Архангай аймгийн 2 сумаас бусад бүх сум ТЭХС-д холбогдсон ба цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамжаар бүсдээ гуравдугаарт /Орхон Булганы дараа/ орж байна.


Өвөрхангай аймгийн 6 сумаас бусад бүх сум ТЭХС-д холбогдсон ба бүсийн дундаж цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамжаас арай дээгүүр хангамжтай байна. Ер нь хангайн бүсийн цахилгаан эрчим хүчний сүлжээний хангамж улсын дундаж орчимд байдаг ажээ. Харин Баруун бүсээс цахилгаан эрчим хүчний сүлжээний /төвлөрсөн эрчим хүчний системд хамрагдсан хүн ам, сум, цахилгаан дулааны шугамын урт/ хангамжаар бараг 2,6 дахин өндөр байна. Бүсийн эрчим хүчний хамгийн их хүчин чадал нь 66300 N кВт, хамгийн бага хүчин чадал нь 150 N кВт байна. Хангайн бүсийн салхины эрчим хүчний нөөц нь дунджаар 50000-75000000 гвт байна.



ХАНГАЙН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ

M1:450000

Зураг 26





Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон гэсэн 6 аймаг, эдгээрийн 100 гаруй сумыг хамрагдаж байна. Энэ бүсэд Монгол Улсын хүн амын 22% нутаг дэвсгэрийн 24,6%, ойн нөөцийн 41,8%, гадаргын усны 33,2%, газрын доорхи ашиглах боломжит усны 50,5% нь ногдож байна. 2008 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 17,8%-ийг Хангайн бүсэд үйлдвэрлэсэн байна. Энэ бол гаднах ерөнхий дүр зураг. Энэ системийн ерөнхий төлөв байдал ямар байна вэ гэдэгт үнэлгээ өгөх нь Шинэ хот байгуулахад шууд нөлөөлөх чухал ач холбогдолтой болж байна.

Монгол улсын бүс нутгийн хөгжлийн индексийг хөгжлийн түвшний индекс, хөгжлийн нөөцийн индекс гэсэн 2 ангиллаар боловсруулан тооцсон судалгаанаас үзэхэд хөгжлийн түвшний нэгдсэн индексийн үзүүлэлтээр Хангайн бүс нь (0.251) Улаанбаатар, Төвийн бүсийн дараагаар орж байгаа боловч улсын дундаж (0.339)-аас доогуур байна. Аймгууд хөгжлийн (27, 28 дугаар зураг) түвшнээр жигд бус бөгөөд улсын хэмжээнд энэ үзүүлэлтээр Баянхонгор аймаг хамгийн доогуур, Хөвсгөл, Өвөрхангай аймаг доогуур, Архангай аймаг аймгуудын дундаж түвшинд байна.

Энэ нь Шинэ хот байгуулахын тулд Хангайн бүсийн хөгжлийн хөгжлийн түвшинг дээшлүүлэх, бүс доторх аймгуудын хөгжлийн түвшинг жигдрүүлэхэд нэр их далайцтай ажил өрнүүлэх шаардлагатай болж байгаа хэрэг.

Хангайн бүс хүн ам олонтой. Гэвч хүн ам зүйн үндсэн үзүүлэлтээр сайнгүй байна. 1999 оныг 2010 онтой харьцуулахад 1000 хүнд ногдох төрөлт 2,3 дахин, 1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт 2,7 дахин буурчээ. Хүн амын өсөлт энэ бүсэд сүүлийн арван жилийн байдлаар 1,3 хувь буюу улсын дундажтай ойролцоо байна. Хүний хөгжлийн индекс энэ бүсэд 0,638 байгаа нь улсын дундаж болон бусад бүсүүдээс доогуур байна. Хүний хөгжлийн индекс нь эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой тул Хангайн бүсийн хөгжлийн асуудлыг Шинэ хот байгуулахтай уялдуулах цогц байдлаар авч үзэх нь зайлшгүй чухлыг дээрх баримт илэрхийлж байна.


Хангайн бүсэд ажилгүйдэл, ядуурал харьцангуй өндөр байна. Тус бүсийн ажилгүйдлийн түвшин улсын дундаж (3.5)-аас 1,6 дахин их, Булган аймагт 9,7 буюу 2,8, Баянхонгор аймагт 7,4 буюу 2,1, Орхон аймагт 4,9 буюу 1,4 дахин өндөр байна. Үүүнтэй холбоотойгоор ядуурал ч бас харьцангуй их байна.






ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ТҮВШНИЙ ХАРЬЦУУЛСАН  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ

Зураг 28



БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ТҮВШНИЙ ХАРЬЦУУЛСАН  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ

Зураг 27





Өнөөгийн өндөр хөгжилд хүрсэн орнууд түүхэн хөгжлийн богино биш замыг туулахдаа тухайн бүс нутаг дахь ажилгүйдлийн түвшин улсынхаа дунджаас зөвхөн 10 хувиар л өндөр болоход улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, улс төрийн тогтвортой байдалд аюул занал учруулах болно гэж үзэж уул бүс нутаг тэнд байгаа хот сууринг хөгжүүлэх талаар онцгойлон анхаарч тодорхой бодлого хэрэгжүүлдэг туршлага байна. Иймд ажилгүйдлийн түвшин дээр хэлсэнчлэн улсын дунджаас 60 гаруй хувиар өндөр байгаа нь энэ бүс нутгийг хөгжүүлэх талаар онцгой анхаарал тавих нь чухал болж байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн Хангайн бүсэд улсын дундажтай ойролцоо байгаа боловч Орхон аймгийн нөлөөллийг хасаж тооцоход улсын дунджаас бараг 2 дахин доогуур байна. Хангайн бүсийн ДНБ-ний 41,0%-ийг хөдөө аж ахуй, 34,6%-ийг үйлдвэр, барилгын салбар, 24,4%-ийг үйлчилгээний салбар эзэлж байна. Орхоноос бусад аймагт хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин 60 гаруй хувьд хүрчээ. Мөн Хангайн бүсэд улсын нийт төсвийн орлогын 19,9%, төсвийн зарлагын 20,1%, төсөвт олгосон татаасын 31,4% ногдох ба Орхоноос бусад бүх аймаг улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр оршин тогтнож байна.

Энэ бүхэн нь ДНБ-ний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтцийг сайжруулах, төсвийн баазыг өргөжүүлэх талаар ихээхэн зүйл хийх хэрэгтэй гэдгийг нотлох баримт гэж ойлгож байна.

Орхон аймгийг эс тооцвол тус бүсэд орчин үеийн үйлдвэр үндсэндээ алга байна. Үйлдвэрүүдэд техник, технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах нь зайлшгүй юм.

Энэ бүсэд одоогийн байдлаар улсын нийт мал сүргийн 32,3% байна. Мал аж ахуйгаас их хэмжээний түүхий эд бэлтгэгдэж байна. Энэ их нөөцийн багаахан хэсэг Орхон аймаг дахь ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт очиж, дийлэнх нь хил худалдаагаар арилжаалагддаг ажээ. Энэ байдал нь олон турбум төгрөгийн ашиг, олон зуун ажлын байр алдаж байгаа хэрэг.



Дээрх баримтуудаас тус бүсэд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаа үйлдвэрүүдийн техник технологийг сайжруулах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүс дотроо боловсруулах чадавхийг бүрдүүлэх нь чухал гэж үзэж байна. Үүнийг Шинэ хотын хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатай.

Хангайн бүсэд харьцангуй сайн судлагдсан байгалийн эрдэс, түүхий эдийн нөөц цөөнгүй байдаг ажээ. Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, цөөн тооны алт, нүүрс олборлох үйлдвэрийг эс тооцвол энэ их баялгийг ашиглаж чадалгүй өдий хүрлээ. Энэ их нөөцийг Шинэ хотын бүтээн байгуулалттай уялдуулж эдийн засгийн чадавхаа дээшлүүлэх зорилгоор ашиглах нь тус бүс нутгийн бас нэг шийдэх асуудал мөн.

Газар тариалангийн үйлдвэрлэлд нэн даруй шийдвэрлэх олон асуудал хуримтлагджээ. Усалгаатай тариалан эрхлэх нь чухал байгаа ч ашиглаж буй услалтын систем огт алга. Малын үүлдэр, угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, Фермерийн аж ахуй хөгжүүлэх, бэлчээрийг зах зээлийн зарчимд нийцүүлэн зүй зохистой ашиглах, бага оврын услалтын систем бүхий тариалан эрхлэх талаар ихийг хийх шаардлагатай байна. Энэ асуудлыг бүс бие даан шийдэх боломж бий ажээ. Нөгөө талаар Шинэ хот байгуулахтай уялдаатай шийдэх нь зүйтэй юм.

Хангайн бүс дэд бүтцийн хөгжлөөрөө бусад бүстэй харьцуулахад харьцангуй боломжийн түвшинд байна. Баянхонгор аймаг, хэдэн аймгийн цөөн сумыг төвийн эрчим хүчний системд холбосноор цахилгаан эрчим хүчний асуудал зохих түвшинд шийдэгдэж байна. Энэ бүс одоогоор Монголдоо хамгийн сайн авто замын сүлжээнд холбогдсон байна Дэд бүтцийн салбарт дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу цахилгаан холбооны суурь сүлжээг иж бүрнээр нь тоон технологид шилжүүлж, орчин үеийн мэдээллийн сүлжээнд сумдын төвийг бүрэн холбох асуудлыг тус бүсийн тулгамдсан хэрэгцээ болж байна.

Хангайн бүсийн эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлага ч их байна. Одоогоор Орхоноос бусад аймагт энэ талаар бага анхаарч



байна. Юуны өмнө хилийн гарц, боомтуудыг тохижуулах, худалдааны чөлөөт бүс байгуулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Энэ бүс байгалийн баялаг, ан амьтан, ой модны нөөц сайтай. Түүнчлэн загас, ан агнуурын, түүх соёлын, угсаатны, шашин, бөө мөргөлийн гэх мэт олон чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлэх боломж их байна. Энэ боломжийг сайн ашиглахын тулд Байгаль орчныг хамгаалах бодлоготой уялдуулах нь зүйтэй.

Байгалийн баялагийн нөөцийг судалж, эдийн засгийн нэгдсэн үнэлгээ тогтоох, тэдгээрийн экологийн аюулгүй байдлыг хангаж, зохистой ашиглах, байгаль орчны менежментийг боловсронгуй болгох, аялал жуулчлалын арвин их нөөцийг зүй зохистой, үр дүнтэй ашиглах нь эн тэргүүний зорилт болох учиртай.

Тус бүсийн давын өмнө шийдвэрлэвэл зохих тулгамдсан олон асуудлаас цөөн зүйлийг дурьдахад ийм байна. Дээр дурьдсан бэрхшээл, тулгамдсан асуудлууд байгаа боловч түүнийг шийдэх цөөн боломж тус бүс нутагт бас байна. Иймд ойрын ирээдүйд Хангайн бүсийг хөгжүүлэх талаар эхний ээлжинд анхаарах нь чухал байна. Үүнийг Шинэ хот байгуулахтай уялдуулах тавигдах учиртай.

**1.2.2 Хангайн бүсийг шинэ хотын бүтээн байгуулалттай уялдуулан хөгжүүлэх стратеги.** Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн стратегид тодорхойлсноор Хангайн бүсийн хөгжлийн стратеги нь тус улсын нутаг дэвсгэрийн нийгэм, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн нөхцлийг бүрдүүлэх үндсэн дээр үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх зорилгод чиглэнэ гэсэн хэрэг.

Энэхүү зорилгын хүрээнд хот суурин газрын тогтвортой хөгжлийг хангах үүднээс үндэсний болон бүсийн нийтлэг ач холбогдол бүхий дараах асуудлыг шийдэх. Үүнд:

-Хүн мын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны доройтлыг хязгаарлах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах;



-Байгаль орчинд зохицон дотоод гадаад зах зээлд өрсөлдөн хөгжих ирээдүйтэй тэргүүлэх салбарыг тогтоож, бүсүүдийн хооронд үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт, дагналтыг бий болгож хөгжүүлэх;

-Бүсүүдийг хооронд нь болон гадаад зах зээлтэй зохистой холбож чадахуйц хот байгуулалт, дэд бүтцийн тогтолцоог бүрдүүлэх;

-Эдийн засгийг тэтгэх чадвартай хувийн хэвшлийн түшиц компани, хоршоо, хөгжлийн бүс нутгийг тогтоон хөгжүүлэх;

-Орон нутгийн цогцолбор хөгжлийг тэтгэх эдийн засаг, санхүүгийн чадавхи буюу дотоодын хуримтлалыг бий болгох;

-Гадаадын шууд хөрөнгө оруулалт “байрших” боломжийг нэмэгдүүлэх;

-Хүн амын нутагшилт, суурьшлыг зохистой болгох нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний харьцангуй жигд нөхцлийг бүрдүүлэх зэрэг гол зорилтыг хэрэгжүүлэх.

Монгол Улсын зах зээлийн эрэлт хэрэгцээ, тус бүсийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан Хангайн бүсэд бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэрийг тэргүүлэх чиглэлтэй хөгжүүлэх нь стратегийн зорилгыг хангах үндэс суурь болох байна. Мөн энэ асуудалд мэдээллийн технологийн давуу талыг ашиглах, оюуны үйлдвэрлэлийг багтаан үзэх нь зүйтэй.

Энэхүү үндэс суурийг стратеги хэрэгжих үе шатны онцлог, зах зээлийн эрэлт хэрэгцээ, бизнесийн сонирхол зэргийг тооцож Шинэ хот байгуулах хөтөлбөр, төсөл арга хэмжээгээр дэмжин бүрдүүлвэл зохино.

Хангайн бүсийн хувьд хөгжлийн ирээдүй сайтай байрлал, бусад хүчин зүйлийг харгалзан хөгжлийн тулгуур төвөөр сонгосон Хархорин, Эрдэнэтийг шинэчлэн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, бусад аймгийн төв хотуудыг орон нутгийн хөгжлийн төв хотын жишгээр хөгжүүлэх, хөдөө орон



нутагт сум дундын төвүүдийг үүсгэн байгуулах зах зээл өргөжин хөгжих хот байгуулалтын таатай орчин бүрэлдэх суурийг Шинэ хотын байгуулалттай уялдуулан тавих нь зүйтэй.

Бүсүүдийн хөгжлийн стратегид тодорхойлсноор Бүсийн хөгжлийн тулгуур төвийн дэд бүтцийн таталцлын чадавхид түшиглэн аймаг, сум, хот, тосгон хоорондын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, нийгэм, соёлын уялдааг хөгжүүлэхэд чиглэсэн дор дурьдсан нийтлэг зорилтыг тавьж хэрэгжүүлэх нь чухал гэж үзжээ.

**1.** Эдийн засаг, дэд бүтцийн салбарт улс орон, бүсийн хөгжилд эн түргүүнд үр ашгаа өгөх салбар, бүс нутагт хөрөнгө санхүүгийн нөөцийг төвлөрүүлэх замаар нийт бүсийн дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн, бие даан хөгжих эдийн засаг, дэд бүтцийн чадавхийг дээшлүүлэх.

**2.** Нийгмийн салбарт аймаг, сум, хот тосгон хоорондын хамтын ажиллагааны хүч нөөцөд тулгуурлан хүн амын боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг тухайн бүс дотроо бие даан шийдвэрлэх боломжийг өргөжүүлэх.

**3.** Хүн ам уугуул нутагтаа амьдрах хэрэгцээ, бусад газарт чөлөөтэй шилжин суух сонирхол зэргийг харгалзсан нутагшилт, суурьшилтын олон хэв маяг бүхий бүсчилсэн тогтолцоог бүрдүүлэх зорилт тавин ажиллах.

**4.** Байгаль орчны тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах шаардлагыг харгалзан Хангайн бүсийн экосистемийн өвөрмөц байдал, орон нутгийн нөөцөд түшиглэсэн байгаль орчны ашиглалт, хамгаалалтын менежментийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх.

Хангайн бүсэд гадаад эдийн засгийн хамтын ажиллагаа ихээхэн үгүйлэгдэж байгааг харгалзан олон улсын жишгийн дагуу чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркийг зохистой төрөл, чиглэлээр байгуулан гадаадын шууд хөрөнгө оруулалт байрших нөхцлийг хангаж, орчин үеийн дэвшилтэт технологи, оюуны багтаамж ихтэй экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэн дэлхийн зах зээлд





Монгол Улсын өрсөлдөх маркетингийн бололцоо, нөхцлийг дээшлүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах нь чухал ажээ. Мөн дээрх асуудлын хүрээнд ОХУ-тай хил залгаа Бага-Илэнх (Булган), Ханх (Хөвсгөл), БНХАУ-тай хил залгаа Шивээхүрэн (Өмнөговь)-ийн боомт, гарцыг эхний ээлжинд тохижуулж, ОХУ, БНХАУ-ын хил зэргэлдээ муж улс, өөртөө засах орнуудтай харилцан дэмжиж хамтдаа түргэн хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх.

Бүсийн хэмжээнд болон тодорхой хот суурин бүс нутгийн эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх зорилгод иргэний нийгмийн бүх талуудын хамтын оролцоо, дэмжлэг, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлж чадахуйц эдийн засаг, зохион байгуулалтын арга механизм, оюун санааны шижим түлхцүүдийг бий болгох явдлыг хөгжлийн стратегийг хангах гол арга зам гэж үзжээ.

Энэ арга замын хүрээнд бүс нутгийн хөгжлийг дэмжихэд шинэ хот байгуулахад чиглэсэн дараах асуудлыг шийдвэрлэхэд онцлон анхаарах. Үүнд:

-Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт бодитой зохион байгуулах,

-Бүсчилсэн хөгжлийн зорилт, арга хэмжээг улсын хөгжлийн нэгдсэн бодлоготой уялдуулж, салбар, бүс хоорондын зохицуулалтыг хэрэгжүүлэх,

-Бүсүүдийн хүрээнд үндэсний болон бүс нутгийн нийтлэг ач холбогдолтой дэд бүтцийн үндсэн сүлжээг бүрдүүлэх,

-Орон нутгийн төвүүдийн хөгжлийн зохистой чиглэлийг тогтоож, бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх,

-Бүсийн хамтын гэрээ, хэлэлцээрийн дагуу бүс бүс нутгийг хөгжүүлэх иж бүрэн хөтөлбөр хэрэгжүүлэхээд гадаадын хөрөнгө оруулагчдад газрыг урт хугацаагаар түрээслэх, хуулиар тогтоосон баталгаанаас илүү гааль, татварын хөнгөлөлттэй нөхцөл олгох.



-Хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр тэтгэмж, даатгалын сангийн эх үүсвэрийг орон нутгийн мэдэлд дэс дараатай шилжүүлэх замаар нийгэм, хамт олны хүч нөөцөд тулгуурлан хүн амын ажилгүйдэл, ажилгүйдэл, ядуурал, нийгмийн хамгааллын асуудлыг аймаг сумдад тухайн бүс дотроо бие даан шийдвэрлэх бололцоог өргөжүүлэх,

-Бүс нутгийн эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зориулалтаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс зохих хуримтлал бий болгож, бүс нутгийн хөгжлийг дэмжих санг байгуулан ажиллуулах,

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хот суурин, аймаг, сумдын хоорондын зохистой харьцаа, хамаарлыг тогтоох, бие дааж хөгжих чадвар султай сумдыг зэргэлдээх сумтай нь хоршин нэгтгэж, орон нутгийн чадавхийг дээшлүүлэх, Бүсийн зөвлөлүүд, нутгийн удирдлагын байгууллагуудын харилцан дэмжлэгийг хөгжүүлэх замаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын харилцан уялдаа, эдийн засгийн нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн эрэмбэ дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх,

Дээрх нийтлэг зорилтыг хэрэгжүүлснээр Хангайн бүсийн хот суурины нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтад дор дурдсан нааштай хандлага бий болно гэж үзэж байна.

Тухайлбал бүсийн тулгуур төв хот, чөлөөт бүс, эрчимжсэн мал аж ахуй, тариалангийн бүс нутаг, аялал жуулчлалын бүс гэх мэт хөгжлийн бүс нутгуудын эдийн засаг, дэд бүтцийн таталцлын чадавхид түшиглэн хот, хөдөөгийн. Үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийгэм, соёлын уялдаа холбоо сайжирч, аймаг, сумууд бүс дотроо аж ахуйн талаар хоршин хөгжих зохистой чиглэл, дүр төрхөө олж эхлэнэ гэж үзжээ.

Энэ асуудлыг Шинэ хотын бүтээн байгуулалттай уялдуулснаар сум суманд ихээхэн хөрөнгийг тарамдуулан цацах байдал арилж улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэгийг үндэсний ач холбогдолтой тэргүүлэх салбар, бүс нутагт түлхүү чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх нөхцөл бүрдэж,



улмаар улсын эдийн засагт бүсийн оруулах хувь нэмрийг өндөржүүлэх удирдлага, зохицуулалтын үндэс сайжирах ажээ.

Хот хөдөөгийн хүн амын бөөгнөрөл, шилжих хөдөлгөөний зохистой хүрээгээр эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа, мэдээлэл, ахуйн үйлчилгээний чанар, хүртээм сайжирч, аймаг, сумд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг бүс дотроо шийдвэрлэх боломж нэмэгдэн, хүн амын амьжиргааны бүс нутгийн ялгаа аажмаар буурах хандлага бий болох байна.

Бүсийн хөгжлийн тулгуур төв, хот орон нутгийн хөгжлийн төв, тосгон сум дундын төвүүдийн зах зээлд хөдөө нутгууд татагдан хөгжих зохистой хүрээ, чиглэл томорч, үүнд түшиглэн тус улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн бүтэц, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн зарчимд ойртуулан боловсронгуй болгох эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдэнэ гэж төсөөлж байна.

Хангайн бүсэд Шинэ хот байгуулах стратегийн ойрын ирээдүйн зорилтын хүрээнд дор дурдсан суурь зорилтуудыг тавьж хэрэгжүүлэх. Үүнд:

**Нэгдүгээрт.** Бүсийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрчим хүч, уул уурхайн олборлох, боловсруулах салбар, мал аж ахуй, түүний түүхий эдийг бэлтгэн боловсруулах жижиг, дунд үйлдвэр, ой мод бэлтгэн боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, амралт, рашаан сувилал, газар тариалангийн үйлдвэрлэл, цэнгэг ус, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, ой, ан агнуурын нөөцийн гах мэт байгаль орчны менежментийн хөгжил, байршлын зохистой хүрээ, чиг хандлагыг тодорхойлох. Үүнд:

**Нэг:** Чаргайт, Эгийн гол (Хөвсгөл), Орхон гол (Булган) дээр усан цахилгаан станц байгуулах боломжийг бүрдүүлэх, Баянхонгорын чиглэлд эрчим хүчний шинэ хүч чадлыг суурилуулах, бүсийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх үүднээс Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, “Эрдмин” үйлдвэрийн баазад түшиглэн катодын зэс, цэвэр зэс үйлдвэрлэн экспортлож, тус улсын дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг чухалчлах, Хөвсгөлийн фосфор, Эрдэнэтийн



зэсийг хими-технологийн аргаар хослон ашиглах, Баянхонгорын алтны үндсэн орд, Архангайн үнэт металлын ордыг орчинд ивээлтэй ашиглах;

**Хоёр:** Мах, сүүний чиглэлийн үхэр, нутгийн сарлаг, Тамир, Дархад, Байдраг хонь, Эрчимийн хар, Залаа, Жинстийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлж сайжруулагчаар ашиглан Хангайн бүсийн хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах;

**Гурав:** Эрдэнэтийн хивсний чанар, дизайныг сайжруулах сайжруулах, уг үйлдвэрийн дэргэд нэхмэлийн үйлдвэр байгуулж, сайн чанарын бүтээгдэхүүн экспортлох боломжийг өргөжүүлэхийн хамт, бөөний худалдааны сүлжээнд түшиглэн бусад аймагт мах, ноос, ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, тэдгээрийг дотоодын үйлдвэрүүдтэй хоршин боловсруулах чиглэлийн жижиг дунд үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг нь дотоод, гадаад зах зээлд борлуулах маркетингийн асуудлыг улсын томоохон үйлдвэрүүдийн эрэлт, хэрэгцээтэй холбон зохистой шийдвэрлэх;

**Дөрөв:** Бүсийн аймгууд ялангуяа Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангайд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх замаар үр тариа, төмс, хүнсний ногооны бүсийн дотоод хэрэгцээг хангах, хүлэмжийн аж ахуй байгуулах бодлого баримталж, зарим нарийн ногоо тариалж байгаа иргэд, байгууллагын санаачлагыг дэмжиж дэлгэрүүлэх;

**Тав:** Олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын менежментийг бүрдүүлэн Хөвсгөл орчимд байгалийн шинжлэл, спортын болон өвөрмөц сонирхлын Эрдэнэт, Булганд бизнес, амралт сувилал, морин аялал /нүүдлийн/-ын, Архангай, Өвөрхангайд түүх, соёл иргэншил, байгаль судлал, морин аялал /нүүдлийн/-ын, Баянхонгорт сувилал, спорт аялалыг түлхүү хөгжүүлэх чиг барьж, эхний ээлжинд Харихорин-Хужирт, Хөвсгөл нуурын орчимд аялал жуулчлалын цогцолбор (аялалын чиглэл, замын тэмдэгжүүлэлт, амралтын түр буудал, үйлчилгээний цэгүүд бүхий)-ын үндсийг тавихын хамт, аялал жуулчлалын бүс нутгуудыг ОХУ-ын Байгаль нуур орчим, БНХАУ-ын Өвөр Монголын нутгийг дамжин өнгөрч буй аялал жуулчлалын чадавхийг их урсгалтай зохистой холбон бүсийн



аялал жуулчлалын чадавхийг бүрэн өгөөжтэй ашиглах улс хоорондын сүлжээ бүрдүүлэх;

**Зургаа:** Амралт, рашаан сувиллын нөөцийг төрөлжүүлэн ашиглах боломжийг харгалзан Архангай, Булганд (Шивэрт, Хадат, Хануй г.м) хүйтэн рашаан Баянхонгор, Өвөрхангайд (Шаргалжуут, Хужирт г.м) халуун хүйтэн рашаанд түшиглэсэн эмчилгээ сувиллын бүс нутгуудыг түлхүү хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, тэдгээрийг аялал жуулчлалын чиглэлтэй холбон ашиглах нэгдсэн сүлжээг бүрдүүлэх,

**Долоо:** Уулархаг ба тал хээр нутгийн экосистемийн онцлог, Хангай, Хөвсгөл, говийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд зохицсон байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтын өвөрмөц менежментийг бүрдүүлэх үндсэн дээр экологийн аялал жуулчлал, агро-үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хэлбэрүүдийн оновчтой хослолд түшиглэн байгаль орчноо хамгаалж чадсан байдлаараа дотоод, гадаадын жуулчид, зорчигчдын сонирхлыг татсан тогтвортой хөгжлийн бүс нутаг болгох;

**Найм:** Хангай, Хөвсгөл орчмын цэнгэг уст гол, мөрөн, рашаан ус, чоно зэрэг элбэгшиж байгаа ан амьтны нөөцийг зах зээлд бүрэн ашигтай ашиглах боломжийг нарийвчлан тогтоож, цэнгэг усны нөөцийг савлаж экспортлох, элбэг ан амьтны түүхий эдийг стандартын дагуу бэлтгэн боловсруулж, нэгдсэн журмаар зах зээлд борлуулах;

**Ес:** Уул тал, хээр, говь нутгийн хүн амын нутагшил, суурьшлын онцлог хэв шинжүүд, тэдгээрийн хоорондын уялдаа, хамаарлыг шинэчлэн тогтооход нутаг дэвсгэр, зохион байгуулалтын ажлыг чиглүүлж, энэ үндсэн дээр шинээр байгуулах хоттой аймгийн төв, хөдөөгийн суурингийн харилцан уялдсан тогтолцоо бүрдүүлэх, Эрдэнэт, Хархориныг улсын болон бүсийн хөгжлийн тулгуур төв хөгжүүлэх бүсчлэл-хот байгуулалтын нэгдсэн бодлого явуулах;

**Арав:** Оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, интернэт, мэдээллийн технологийг ашиглах үндсэн сүлжээг бүрдүүлэх,



**Хоёрдугаарт.** Бүсийн хэмжээнд, хүн амын нутагшил, суурьшил, аймаг, сум, хот, тосгоны хоорондын нийгэм, соёлын уялдаа холбооны зохистой чиглэлийг тогтоож, эрүүл мэнд, боловсрол, соёл, ахуйн үйлчилгээний цэг, салбарын байршил, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх. Үүнд:

**Нэг:** Арвайхээр хотын бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн техник хангамж, мэргэжлийн түвшин, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, Эрдэнэтэд Хангайн бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг шинээр байгуулах, Булган, Хөвсгөл аймгийн зарим сумдын хүн амд үзүүлэх эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх, аймаг сумдын төвийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг төрөлжүүлэн чанаржуулах, амралт, рашаан сувиллын бүс нутгуудад ардын болон орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудыг хослон хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх хандлагаар бүсийн хэмжээн дэх эрүүл мэндийн салбарын тогтолцоог шинэчлэх;

**Хоёр:** Бүс нутгуудын хүн ам зүйн байдал, зах зээлийн эрэлтийн онцлогийг харгалзан боловсролын үйлчилгээг баг-сум, сум дунд, сум-аймаг, аймаг дундын гэсэн шатлалаар төрөлжүүлэн хөгжүүлэх, Эрдэнэт-Хархорин-Цэцэрлэгийн хоршилт холбоонд түшиглэн Хангайн бүсийн хүн амын оюуны чадавхи, дадлага, туршлагыг бүрэн нээж, зохистой ашиглаж чадахуйц их, дээд, тусгай мэргэжлийн сургууль- ШУМТ-үйлдвэрлэлийн нэгдэл /төв/-ийг байгуулан, түүний бүрдэл хэсгүүдийг үндэсний болон бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээнд нийлүүлэн тоо хэмжээ, төрлөөр нь оновчтой сонгон байршуулах;

**Гурав:** Бүсийн болон бүс нутгийн төвийн зах зээлд таталцуулан хөдөөгийн хүн амыг зохистой үйлчлэх хүрээгээр ахуй соёл, нийтийн аж ахуйн үйлчилгээний газруудын хүч чадал, байршилтыг оновчилж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нь дээшлүүлэх, энэхүү зорилгоор иргэд, аж ахуйн нэгжүүд, урлаг соёлын хамтлаг, хоршоо байгуулах.

**Гуравдугаарт.** Бүсийн хот суурин хөгжлийн тулгуур төвүүдийг дотоод, гадаад зах зээлтэй холбох, аймаг, бүс нутгийн хүн амын нийгэм, соёлын үйлчилгээний хүртээмж, уялдаа холбоог сайжруулах.





**Дөрөвдүгээрт.** Эрдсийн баялаг, мал аж ахуйн түүхий эд, газар, ус, ой мод, аялал жуулчлалын нөөцийг байгаль орчны даац, чадавхид зохицуулан бүрэн зохистой, хоршин ашиглахад дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг байршуулах, үйлдвэрлэлийн өсөлт, үр ашигтай ажил эрхлэлтийг урамшуулах, хүн амын орлогын хуваарилалтыг оновчтой болгох, хөдөлмөрийн идэвхжил, хамтран ажиллах сонирхлыг дээшлүүлэхэд төрийн дэмжлэг, зохицуулалтыг чиглүүлэх. Үүнд:

**Нэг:** Хамтарч хоршсон үйлдвэрлэл үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагын зээлээр дэмжих;

**Хоёр:** Уулархаг бүсэд “нутагшсан” хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуйд нарийн ногоо ургуулах;

**Гурав:** Аялал жуулчлал, амралт рашаан сувиллын газрыг олон улсын жишгийн дагуу зохион байгуулах;

**Дөрөв:** Бартаа ихтэй Хөвсгөл, Сэлэнгэ мөрний эхний ой тайгыг цэвэрлэх, байгаль хамгаалах зорилгоор мод бэлтгэж, бүтээгдэхүүнээ дотоод зах зээл дээр борлуулж буй аж ахуйн нэгжийг улсын төсвийн зээл тусламжид хамруулах;

**Тав:** Баг, сум, аймаг дундын ач холбогдолтой нийтийг хамарсан арга хэмжээ тухайлбал хамтын эзэмшлийн ой байгуулах, ойжуулах, ойн хортон шавьж устгах, отрын бүс нутаг байгуулах, бэлчээр усжуулах, давааны зам гүүр засах, шинээр барих;

**Зургаа:** Мах, ноос, ноолуур, арьс ширийг бүс дотроо боловсруулж, эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох зорилготой байгуулагдсан аж ахуйн нэгжийн технологийн тоног төхөөрөмж, түүхий эд, материалыг импортын татвараас хөнгөлөх;

**Долоо:** Баянхонгорын болон бусад аймгийн алтны үндсэн ордыг ашиглаж буй аж ахуйн нэгжид ногдуулах албан татварыг бусад шороон орд эзэмшиж буй алтны үйлдвэрээс ялгавартай тогтоох боломж бүрдүүлэх;



**Найм:** Аялал жуулчлал, амралт сувиллын үндсэн бүс нутгуудад газрыг дотоод, гадаадын мэргэжлийн, хувийн хэвшлийн байгууллагад урт хугацаагаар түрээслэх;

**Ес:** Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Бүрэнхааны фосфорын үйлдвэрийн орчин дахь эвдэрсэн газрыг экологийн хиймэл цэвэр орчин (нуур тогтоож загас үржүүлэх, хөрсжүүлэх, ойжуулах г.м) болгох.

Эдгээр стратегийг Шинээр байгуулах хоттой уялдуулснаар Хангайн бүсийн хөгжилд аймаг, орон нутгийн хүн амын нийгмийн үйлчилгээний хүртээмж сайжирч, орлогын хэмжээ харьцангуй жигд дээшлэх хандлага бий болох; дэд бүтцийн сүлжээнд түшиглэсэн бүсийн дотоод, гадаад уялдаа сайжирч, хөдөөгийн хүн ам, үйлдвэрлэгчид зах зээлийн харилцаанд жигд оролцох нөхцөл бүрэлдэнэ. Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах уламжлалт арга технологи сэргэж, амьдралаа дэмжих бизнесийн төрлүүд олшрох; аялал жуулчлал, уул уурхай, мод бэлтгэлийн салбарын бүтэц, зохион байгуулалт, байршил сайжирч, тэдгээрийн зах зээлд өрсөлдөх боломж өргөжих; оюуны үйлдвэрлэл хөгжих ая таатай нөхцөл бүрдэх, иргэд, байгууллагын харилцан дэмжлэг сайжирч нийгмийн идэвхжил аажмаар дээшлэх, нааштай хандлага бий болно гэж тооцож байна.

Дээр дурдсан стратегийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол улсын бүлэг суурины төвүүдийн шинэ тогтолцоог боловсруулж шийдвэрлүүлэх, Эрдэнэт, Хархорин хотыг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, шинэ ерөнхий төлөвлөгөөг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн хүн амын байршилт, шилжих хөдөлгөөнийг оновчтой зохицуулах эдийн засгийн хөшүүргийг судлан тогтоох, Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх, Улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв хотуудын зорилтот хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхүү хуваарилах, арга хөшүүргийг судлан тогтоож, хэрэгжүүлэх. Мөн бүсчилсэн хөгжлийн нэгдсэн стратегитэй уялдуулан бүсүүдийн эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл холбооны хангамжийн үндсэн сүлжээг үргэлжлүүлэн байгуулах зорилт арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган, гадаад орны зээл тусламжаар дэмжин хэрэгжүүлэх, Хархорин болон Шинээр байгуулах хотын дагуул суурингуудыг жижиг хот болгон хөгжүүлэх.



**I.2.3 Хангайн бүсийн засаг захиргаа-нутаг дэвсгэрийн зохион байгуулалт бүтэц.** Эдийн засгийн Хангайн бүс 384393 км кв нутаг дэвсгэр эзлэх бөгөөд газар орны байдлын хувьд төв болон хойд хэсэг нь хангай, бүсийн өмнөд хэсэг нь цөлөрхөг хээр, цөл юм. Бүсийн хойд хэсгээр Хөвсгөлийн уулс, дунд хэсгийг Хангайн нуруу, өмнөд хэсгийг Олон нуурын хөндий, Төвийн Алтайн баруун хэсэг, Алтайн цаад хэсэг, Говийн зүүн сэжүүр, хойноос урагш дэс дараалсан байрлалтай байдаг.

Хангайн бүсэд нийт 4778,2 мян.га талбайг эзэлсэн 11 тусгай хамгаалалттай газар нутаг байгаа нь хангайн бүсийн нийт нутаг дэвсгэрийн 12,4%-ийг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 23,3%-ийг тус тус эзэлдэг бөгөөд манай улсын нийт ойн сангийн 49,8% нь ногдож байгаагаас Хөвсгөл, Булган аймагт түгээмэл тархалттай.

Эдийн засгийн Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон гэсэн 6 аймаг, (29 дүгээр зураг) тэдгээрийн 100 сум хамрагдаж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрийн (30, 31 дүгээр зураг) 24.6 хувь, ойн нөөцийн 41.8 хувь, гадаргын усны 33.2 хувь, газрын доорхи ашиглах боломжит усны 50.5 хувь нь энэ бүсэд хамаарч байна. 2010 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20.5 хувийг Хангайн бүсэд үйлдвэрлэсэн байна.





ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИНЫ БАЙРШИЛ

Зураг 29








ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИН ХООРОНДЫН УЯЛДАА


M1:4500000





ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИН ХООРОНДЫН ЗАЙ ХЭМЖЭЭ

M1: 4500000







Хангайн бүс Монгол орны дунд зэргийн нутаг дэвсгэр бүхий Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор гэсэн 5 аймаг, Эрдэнэт хотыг харьяалсан Орхон аймгийг хамрах бөгөөд бүгд 99 сумтай. Энэ нь Монгол улсын бүх сумын 29,5% нь бөгөөд нэг сум дунджаар 388 мянган га нутаг дэвсгэртэй байгаа нь улсын дундажтай харьцуулахад 16% бага юм. Энэ бүсийн сумдын нутаг дэвсгэрийн дундаж хэмжээнд нөлөөлж байгаа нийгэм газарзүйн хоёр нөхцөл байдаг.


**Хүн амын нутагшилт, хот байгуулалт.** Хангайн бүсэд өнөөгийн байдлаар манай улсын нийт хүн амын 22,0%, өрхийн 24,2% оршин сууж байна. Бүсийн хүн амын 36,0% нь хот суурин газарт, 64,0% нь хөдөө орон нутагт амьдарч байна. 1000 хүнд ногдох төрөлт 1989 оны энэ үзүүлэлттэй харьцуулбал 2004 онд 2,1 дахин, 1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт 1989 оны энэ үзүүлэлттэй харьцуулбал 2004 онд 2,7 дахин тус тус буурчээ. Бүсийн хүн амын 38,2%-ийг 0-14 насны хүүхэд, 58,2%-ийг 15-65 насны хүмүүс, 3,6%-ийг 65-аас дээш насны хүмүүс тус тус эзэлдэг. Шилжин явагчийн тоогоороо хамгийн идэвхтэй бүсэд багтдаг. Гэхдээ шилжих хөдөлгөөн бүс дотроо буюу Орхон аймагт зонхилно.

Монголын гурван том хотын нэг Эрдэнэтийг харьяалсан жижиг нутагтай хоёр сум, Баянхонгор аймгийн нутгийн өмнөд хэсгийн цөлөрхөг хээр, цөлийн бүсийг харьяалдаг хэд хэдэн сум байрладаг.

Байгаль газарзүйн энэ хэсэгт орших сумд нь уртрагийн дагуу 268 орчим км сунасан нутагтай. Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын хүрээн дэх (32, 33, 34, 35, 36 дугаар зураг) Хангайн бүсийн нутагшил суурьшлын тогтолцооны үндсэн хэв маяг нь аймгийн төв-хот, сумын төв-тосгон (суурин) болж байгаа юм. Хөвсгөл аймгийн нутаг дахь Хатгал тосгон, Булганы нутаг дахь Хялганат сууриныг эс тооцвол төв суурин газрууд нь аймаг, сумын төвийн үүрэг гүйцэтгэдэг




МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТЫН СИСТЕМ





### ЭДИЙН ЗАСГИЙН БАРУУН БҮСИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛТЫН СИСТЕМ






#### ТАНИХ ТЭМДЭГ

##### ХИЛ

-  Нутагшилтын бүс дэд бүсийн хил
-  Улсын хил
-  Аймгийн хил
-  Сумын хил


##### ХОТ СУУРИН

-  Нийслэл хот
-  Аймгийн төв



II-B

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Монгол Алтайн өндөр уулын бүслүүрийн бөөгнөрөх хандлагатай нутагшилтын дэд бүс



III-B

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Завхан-Тэсийн ойт хээр, хуурай хээр, говийн таруу нутагшилтын дэд бүс



IV-B

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Говийн, Алтай-Хангайн өврийн уулын хээр, говь цөлийн бүсийн нэн таруу нутагшилтын дэд бүс



IV-E


Говийн их дархан цаазат газрын хязгаарлагдмал нутагшилтын дэд бүс

33 дүгээр зураг.





ЭДИЙН ЗАСГИЙН ХАНГАЙН БҮСИЙН ХҮН АМЫН  
НУТАГШИЛТЫН СИСТЕМ



ТАНИХ ТЭМДЭГ

ХИЛ

- Нутагшилтын бүс дэд бүсийн хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ХОТ СУУРИН


- Нийслэл хот
- Аймгийн төв

- I-A** Нийслэл хот, аймгийн төвийн нөлөөлөл ихтэй Орхон-Сэлэнгийн ойт хээрийн бүсийн бөөгнөрсөн нутагшилтын дэд бүс
- II-A** Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Орхон-Тамирын ойт хээр, хуурай хээрийн бүсийн бөөгнөрөх хандлагатай нутагшилтын дэд бүс
- III-B** Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Завхан-Тэсийн ойт хээр, хуурай хээр, говийн таруу нутагшилтын дэд бүс
- IV-B** Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Даланзадгад-Мандалговийн хуурай хээр, говь цөлийн бүсийн таруу нутагшилтын дэд бүс
- IV-B** Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Говийн, Алтай-Хангайн өврийн уулын хээр, говь цөлийн бүсийн нэн таруу нутагшилтын дэд бүс
- IV-G** Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Хөвсгөлийн тайгын бүслүүрийн дэд бүс
- IV-E** Говийн их дархан цаазат газрын хязгаарлагдмал нутагшилтын дэд бүс

34 дүгээр зураг.



ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВИЙН БҮСИЙН ХҮН АМЫН  
НУТАГШИЛТЫН СИСТЕМ



ТАНИХ ТЭМДЭГ

ХИЛ

- Нутагшилтын бүс дэд бүсийн хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ХОТ СУУРИН

- Нийслэл хот
- Аймгийн төв

I-A

Нийслэл хот, аймгийн төвийн нөлөөлөл ихтэй Орхон-Сэлэнгийн ойт хээрийн бүсийн бөөгнөрсөн нутагшилтын дэд бүс

I-B

Аймгийн төв, төмөр замын дагуух суурин газруудын нөлөөлөл ихтэй Чойр-Замын үүдийн хуурай хээр, говь цөлийн бүсийн харьцангуй бөөгнөрсөн нутагшилтын дэд бүс

II-A

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Орхон-Тамирын ойт хээр, хуурай хээрийн бүсийн бөөгнөрөх хандлагатай нутагшилтын дэд бүс

III-A

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Онон-Хэрлэнгийн ойт хээр, хуурай хээрийн бүсийн таруу нутагшилтын дэд бүс

IV-A

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Дорнод талын хуурай хээрийн таруу нутагшилтын дэд бүс

IV-B

Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Даланзадгад-Мандалговийн хуурай хээр, говь цөлийн бүсийн таруу нутагшилтын дэд бүс

IV-D


Хан Хэнтийн дархан цаазат газрын хязгаарлагдмал нутагшилтын дэд бүс

35 дугаар зураг.





ЭДИЙН ЗАСГИЙН ЗҮҮН БҮСИЙН ХҮН АМЫН  
НУТАГШИЛТЫН СИСТЕМ




ТАНИХ ТЭМДЭГ

ХИЛ

- Нутагшилтын бүс дэд бүсийн хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

ХОТ СУУРИН

- Нийслэл хот
- Аймгийн төв




I-Б Аймгийн төв, төмөр замын дагуух суурин газруудын нөлөөлөл ихтэй Чойр-Замын үүдийн хуурай хээр, говь цөлийн бүсийн харьцангуй бөөгнөрсөн нутагшилтын дэд бүс



III-A Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Онон-Хэрлэнгийн ойт хээр, хуурай хээрийн бүсийн таруу нутагшилтын дэд бүс



IV-A Аймаг, сумдын төвийн нөлөөлөл ихтэй Дорнод талын хуурай хээрийн таруу нутагшилтын дэд бүс



IV-D Хан Хэнтийн дархан цаазат газрын хязгаарлагдмал нутагшилтын дэд бүс

36 дугаар зураг



Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийг түшиглэн бүрэлдэж эхэлсэн суурин хөгжин хөгжсөөр одоогийн Эрдэнэт хот болж түүнд Улаантолгойн сүүний аж ахуйн нутаг дэвсгэрийг хамруулан Орхон аймгийг 1993 онд байгуулсан нь энэ бүсийн нутаг дэвсгэрийн хуваарьт гарсан хамгийн том өөрчлөлт юм. 1980-аад оны дунд үед шинээр байгуулагдсан газар тариалангийн аж ахуйг түшиглэн Сансар сум Булган аймагт, Хайрхан сум Архангай аймагт шинээр байгуулагдснаас гадна мөн аймагт 1970-ад оны эхээр татан буулгасан Цахир сумыг нэгтгэснээс хойшхи 20-оод жилд хуучин Цахир сумын малчдын нутагшил суурьшилд үндсэн өөрчлөлт гарч, олон айл өрх Тариат сумын баруун хэсгээр суурьшжээ. Гэвч Цахир сумыг дахин сэргээн байгуулахад тэдгээр айл өрх Тариат сумын уугуул нутгаас авч Цахир сумандаа орох боломжгүй тул Тариат сумын харьяат хэвээр явж иржээ. Ингэснээр Цахир сумын шинэ төв нь хоёр сумын торгон хил дээр байрлалтай болж нутаг дэвсгэрийн нэгэн шинэ бэрхшээлт асуудал буй болжээ.

**Хангайн бүсийн газрын сан:** зориулалт, бүтэц, ашиглалт. Эдийн засгийн Хангайн бүс 38439 мянган га буюу улсын бүх газрын сангийн 24,6 хувьтай тэнцэх газар нутагтай. Энэ нь монголын дунд зэргийн нутаг дэвсгэртэйд тооцогдох Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор болон Орхон аймгийн нутгийг хамарч байна. Хангайн бүсийн газрын сангийн ангиллын дотор хөдөө аж ахуйн газар, ойн сангийн газар их хувийн жин эзэлдэг. Энэ хоёр ангиллын газар Хангайн бүсийн нийт нутгийн бараг 99 хувийг (8 дугаар хүснэгт) эзэлдэг байна.

**Хангайн бүс** нь өргөргийн 44-50<sup>0</sup>, зүүн уртрагийн 98-104<sup>0</sup>-ийн хооронд сунаж тогтсон ерөнхийдөө далайн төвшнөөс дээш 800-2800 метр өндөрт өргөгдсөн байршилтай.

Монгол орны нутаг дэвсгэрийн 38502,5 мян. Га буюу 24,59 хувь нь Хангайн бүсэд ногдож байна. Үүний 29559,7 мян. га газар нутаг нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар бөгөөд үүнээс 29053,3722 мян. га талбайг бэлчээр, 239,0378 мян. га талбайг хадлан, 107258,1 га талбайг тариалан тус тус эзэлдэг ажээ.

Хангайн бүсийн хот, тосгон бусад суурин газар 81,0447 мян га, ойн сан бүхий газар 7795,7418 мян га, усан сан бүхий газар 478,1234 мян га, нөөц газар



542,6466 мян га газрыг тус тус эзэлж байна. Бэлчээрийн 96,9% их, бага ямар нэгэн хэмжээгээр талхлагдсан байна.

### Эдийн засгийн хангайн бүсийн газрын сангийн зориулалт, бүтэц

8 дугаар хүснэгт

Газрын зориулалт	Нийт талбай, мян.га	Дүнд эзлэх хувь
1. Хөдөө аж ахуйн газар	29912,3	77,8
2. Ойн сан бүхий газар	7468,9	19,4
3. Усны сан бүхий газар	478,3	1,2
4. Хот суурины газар	107,0	0,3
5. Зам, шугам сүлжээний газар	78,3	0,2
6. Нөөц болон ашиглахад тохиромжгүй газар		
<b>Бүгд</b>	<b>38439,2</b>	<b>100</b>

Энэ бүсийн нутагт Монголын бүх ойн сангийн газрын 41 хувь, заг бүхий газрыг оруулахгүй бол ердийн ойн сангийн 47,4 хувь нь байрлаж байна. Энэ бүсийн ойн сангийн газрын 7,3 хувь буюу 550 мянган га-г Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутагт тархсан заг эзэлдэг.

**Хангайн бүсэд** Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг Говь-Алтайн зарим салбар уулс хамрагдана. Хангай, Хөвсгөлийн уулархаг нутагт голуудын сүлжээ харьцангуй сайн хөгжсөн, олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжлэн ба тасалданги тархснаас гадна бусад нутгийг бодвол агаар мандлын чийгшил, мэдэгдэхүйц их, уур амьсгалын эх газарлаг шинж арай бага байдгаараа онцлог юм.

Хөвсгөл орчмын мужид өндөр уулын ян сарьдаг, хаг-хөвдөт тундрын ландшафт түгээмэл байна. Тэр нь дундаж өндөр уулст уулын тармаг ойн ландшафт болон цэвдэгт тайгын, (37 дугаар зураг ) ширэгт тайгын хөрстэй шинэс,



хуш-шинэсэн ой бүхий дундад ба өмнөд тайгын ландшафтаар солигдоно. Хотгор газраар нугат хээрийн, нугын ландшафт тархана.

Хангайн бүсэд Хангайн нуруу бүхлээрээ багтахаас гадна Орхон-Туулын савын дундаж уулс хамрагдана. Хангайн нуруу бол Монгол орны байгалийн ерөнхий тэнцвэр, зохидолгоог хадгалж улмаар ой, тайга, говь, цөлийн аль алины тархалтын хүрээг хязгаарлаж байдаг онцлогтой. Хангайн нуруу, тэдгээрийн салбар уулсын хажуу гол төлөв (38 дугаар зураг) налуу, орой нь бөмбөгөр буюу ихээхэн элэгдэж мөлийсөн шинжтэй юм. Хангайн нуруу нь нийтдээ өндөр өргөгдсөний улмаас эндхийн ландшафтад мөстлийн үеийнхтэй төстэй байгалийн нөхцөлд бүрэлдэн тогтсон цэвдэгт-хуурайсаг маягийн өндөр уулын бушизат нугын ландшафт уулын хээрийн ландшафттай хослон орших нь элбэг. Хангайн гол нурууны баруун хойт томоохон салбар болох Булнай, Тарвагатайн нуруу түүний орчмын нутаг бол жинхэнэ уулт ойт хээрийн бүс юм. Энд ой хээр хоёр талбайн хувьд бараг тэнцүү тархалттай ажээ.

Өндөр уулын хэв шинжийн рельефд 3000-4000м өргөгдсөн Хагай, Хөвсгөлийн уулс, 2000-2700 м хүртэл өргөгдсөн Хэнтийн уулс хамаарагдана. Эдгээр уулсын өндөр нь ойн дээд захаас дээш гарсан байдаг тул нүцгэн, ерөнхийдөө тэгш хадан оройтой, эгц хажуутай байдаг. Эндэхийн уулсын хормой хажуу, бэлээр чулуулгын нуранги, асга ихээхэн талбайг эзлэн үлэмж зузаантай тархана.

Бэсрэг уулын хэв шинж нь Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс орчмоор уулсынхаа захын хэсгээр тэдгээрийг хүрээлэн оршдог. 1700-2500 м хүртэл өндөртэй, бөмбөгөр оройтой, налуу хажуутай, гадаргын усны үйл ажиллагаанд идэвхтэй орсон, янз бүрийн хэмжээний гуу жалгаар хэрчигдсэн байдаг.


Говь маягийн уулсын хэв шинж нь 2000-3000 м-ийн өндөртэй Говь-Алтай, Говь Тян-Шаны салбар уулсууд хамаарагддаг. Усны идэх, эвдэх үйл ажиллагаа, цөлийн өгөршилд хүчтэй орсноос шовх оройтой, эгц хажуутай болсон байх бөгөөд уулын бэл хормойгоор олон 10 м-ийн зузаантай харьцангуй жижиг ширхэгтэй хушуурсан туугдасууд үүссэн байдаг.





ХАНГАЙН БҮС, ХОТГОР ГҮДГЭРИЙН ҮНДСЭН ХЭВ ШИНЖ

M1:450000








ХАНГАЙН БҮС, ФИЗИК ГАЗАРЗҮЙН МУЖЛАЛ

M1:4500000





Цав толгодын хэв шинжит рельеф нь Говийн хэсэг, Их нууруудын хотгороор томоохон талбайд, Хангай, Хэнтийн нурууны зах хэсгээр багавтар газарт тохиолдоно. Толгодуудын үнэмлэхүй өндөр 1000-1500 м харьцах өндөр 20-100 м хүрдэг. Мөлгөр оройтой, налуу хажуутай өвс ургамлаар хучигдсан байдалтай. Ганц нэгээрээ салангид оршихоос гадна зарим газар хэсэг бүлгэрээ бөөгнөрөн оршиж, намхан дэл, шилийг үүсгэсэн байдаг.

Хөвсгөл амйгийн нутаг дахь ойн бүсийн бүх ой модтой газрын 48 хувийг Булган аймгийн ой 26 хувийг эзлэх бөгөөд Архангай, Өвөрхангай аймгийн ойтой газар 1,3-3,3 хувийг эзэлдэг байна. Эдийн засгийн Хангайн бүсэд Монгол орны ойн нөөцийн 49,8 хувь нь ногдож буйг үзвэл энэ бүсийн эдийн засгийн хөгжлийн чадавхид модыг эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх явдал чухал байр эзэлж болох юм.

Тус бүсийн ойн сан бүхий газар улсын нийт ойн сан бүхий газар нутгийн 41,8%-ийг эзэлдэг. Сүүлийн үед ойн түймэр их гарч байгаагаас ой ширгэж, ингэснээр ургамалын зүйлийн бүтээгдэхүүнд өөрчлөлт гарч байна.

Зарим судалгаанаас үзэхэд тухайн бүс нутгийн ойт хээрийн бүсэд газрын хэвгийг дагаж хагалсан уриншийн талбайн 1 га тутмаас 40592 кг тарималтай талбайгаас 1563,7 кг хөрс жилд угаагдан алга болдог бөгөөд 4 градусын хэвгийг тариалангийн газрын хөрсний угаагдал жилд дунджаар 3,5 тн/га түүнээс дээшхи хэвгийг 5 тн/га хүрдэг байна.

Энэ бүс Монгол орны байгалийн ил задгай усны объект хамгийн их байрласан нутаг юм. Иймээс ч энэ бүсийн усны (39 40 41 дүгээр зураг) сангийн газар Монголын бүх усны сангийн газрын 29 хувийг эзлэх бөгөөд бүсийнх нь бүх нутгийн 1,2 хувь нь гол мөрөн, нуур тойром, горхи булгийн усны дор байгаа гэсэн үг юм. Энэ бүсийн аймгуудаас Хөвсгөл, Байнхонгор аймаг усны сангийн газраар хамгийн ихтэй юм.


Монголын 3800 гаруй гол горхины 65,6 хувь нь, 1200-гаад томхон нуур тойрмын 42,6 хувь нь, 6000-аад булаг шандны 38 хувь нь энэ бүсэд байрлан байна.





ХАНГАЙН БҮС, ГАДАРГЫН УСНЫ МУЖЛАЛ

M1:4500000








ХАНГАЙН БҮС, ХӨРСӨН ДООРХ УСНЫ МУЖЛАЛ

M1:4500000








ХАНГАЙН БҮСИЙН УСНЫ САВ ГАЗАР

M1:4500000







Хангайн бүсийн гадаргын урсац болох гол мөрөн нь дэлхийн ус хагалбарын томоохон хоёр ай савд багтана. Умард мөсөн далайн ай савд Сэлэнгэ, Шишхид, Дэлгэрмөрөн, Чулуут, Хануй, Урд тамир, Хойд тамир, Орхон голууд харин Таац, Түй, Байдраг зэрэг гол мөрөн Төв азийн гадагш урсацгүй ай савд тус тус багтана. Хангайн нурууны өмнө зүг рүү чиглэсэн голууд нь Монголын говийг тэтгэх гол эх үүсвэр болдог.

Хангайн бүсэд манай орны гадаргын усны 33,2%, ашиглаж болох гадаргын усны 31,7%, газрын доорх ул хөрсний усны 35,4%, ашиглах боломжит газрын доорхи усны 50,54% тус тус ногдож байна. Тус бүсэд газрын доорхи усны хамгийн их нөөцтэй район бол Хөвсгөл аймаг, дараа нь Архангай, Баянхонгор аймгууд ордог.

Хангайн бүсийн хамгийн газрын доорхи усны нөөцтэй район нь Архангай аймаг, дараа нь Хөвсгөл аймаг, хамгийн бага нөөцтэй нь Өвөрхангай аймаг ордог.

Хангайн бүсэд Хойт мөсөн далайн ай савд багтдаг манай орны томоохон гол мөрнүүд байрладаг. Тэдгээрээс зарим томоохон голуудыг нэрлэж зарим шинж чанарыг нь дурьдвал:

**Сэлэнгэ мөрөн.** Сэлэнгэ мөрөн манай орны гол мөрний үндсэн усан сүлжээг бүрдүүлдэг бөгөөд бүх цутгал голуудынхаа хамт усан сүлжээний нийт урт 20000 км буюу Монгол орны гол мөрний нийт уртын 40 гаруй хувь нь энэ сүлжээнд хамаарагддаг. Сэлэнгэ мөрний өөрийнх нь нийт урт 992 км бөгөөд үүнээс 593 км нь Монгол улсын нутагт оршдог. Ус цуглуулах талбайн хэмжээ 447000км<sup>2</sup> бөгөөд үүнээс 55% нь буюу 282000 км<sup>2</sup> нь манай нутагт тус тус байдаг. Урсгалын хурд эхэн хэсэгтээ 7,2-9,0 км/цаг адаг хэсэгтээ 3,6-4,0 км/цаг бөгөөд голын өргөн 80-150м, дундаж гүн нь 0,5-1,5 м, цээл цүнхэлдээ 2,5-3,0м, зарим газартаа 4-5м хүрдэг. Сэлэнгэ мөрөнд монгол орны томоохон голууд болох Дэлгэрмөрөн, Идэр, Хануй, Эг, Орхон голууд цутгадаг ажээ.

**Идэрийн гол.** Хангайн нуруунаас эх авч Булнай, Тарвагатайн нурууны дундуур давчуу хөндий даган урсдаг. Голын урт 452 км, ус цуглуулах талбайн хэмжээ 24555 км<sup>2</sup>, усны унал 353 м, голын өргөн 40-60м, гүн нь 0,7-2,0 м боловч



хамгийн гүн хэсэгтээ 3,0-3,5м хүрдэг. Тус гол нь уулын гол учраас ширүүн урсгалтай, урсгалын хурд эхэн хэсэгтээ 7,2-10,8 км/цаг, адагтаа 2,0-2,5 км/цаг болдог. Усны эрдэсжилт 150-190 мг/л, гидрокарбонат-натрийн төрлийн ус бөгөөд цэнгэг цэвэр усны төрөлд багтдаг байна.

**Чулуут гол.** Голын нийт урт 415 км бөгөөд ус хураах талбай нь 10750 км<sup>2</sup>, Хангайн нурууны хамгийн өндөр хэсгээс эх авдаг тул унал ихтэй 1км тутамд 5м-ийн уналтай, түргэн урсгалтай гол юм. Голын өргөн эхэн хэсэгтээ 20-30м, дуунд хэсэгтээ 20-60м, адагтаа 70-80 болдог. Голын эхэн хэсгээр мөстлөгийн гаралтай моренууд элбэг тохиолддог ажээ. Химийн найрлагын хувьд гидрокарбонатын төрөлд хамаарагдаж байна.

**Дэлгэр мөрөн.** Улаан тайгын нуруунаас эх авах бөгөөд голын нийт урт 445 км, ус хураах талбай 26640 км<sup>2</sup>, усны унал 2200 м байдаг. Голын хөндий ерөнхийдөө давчуу, голын өргөн эхэн хэсэгтээ 25-40м, адаг хэсэгтээ 50-100м болдог. Усны гүн 0,5-2,5м, урсгалын хурд 0,2-2,0 м/сек, жилд 126-173 хоног мөсөөр хучигдадаг байна.

**Орхон гол.** Сэлэнгэ мөрний үндсэн цутгал төдийгүй, уртаараа Монголын хамгийн том гол юм. Хангайн гол нурууны Суварга хайрхан уулаас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Голын нийт урт 1124км, ус цуглуулах талбай 132835 км<sup>2</sup>, голын өргөн харилцан адилгүй бөгөөд дунджаар 10-60м, адагтаа 120-150м хүрдэг. Голын дундаж гүн 0,5-1,5м боловч гүн хэсэгтээ 2,5-4,0 м байдаг байна.

Хангайн уулархаг нутагт давчуу хадан хавцлууд зонхилдог бол хээр тал газраар өргөн нь эрс нэмэгдэж уужирч энэ хэсэгт голын татам, дэнж зэрэг голын хөндийн үндсэн элементүүд тод ялгардаг юм байна. Мөсөн бүрхүүлтэй байх хугацаа 141-169 хоног, мөсөн бүрхүүлийн зузаан 1,0-1,2м байна. Голын ус цэнгэг цэвэр усны төрөлд багтах тул ундны хэрэглээнд тохиромжтой.

**Туул гол.** Орхон голын баруун гарын үндсэн цутгал бөгөөд Хэнтийн гол нуруунаас эх авч Орхон голд цутгадаг. Голын нийт урт 819км, ус цуглуулах талбай 50400км<sup>2</sup>, голын өргөн харилцан адилгүй, дунджаар 8-60м, адагтаа 100-120 м хүрдэг байна. Голын дундаж гүн 0,5-1,5м боловч гүн хэсэгтээ 2,2-3,3 м байдаг.



Жилийн бүх тэжээгдлийн ихэнх хувийг бороо, цас, хөрсний усаар авдаг. Мөсөн бүрхүүлтэй байх хугацаа 138-164 хоног, мөсөн бүрхүүлийн зузаан 2,0-2,5м байна. Голын ус цэнгэг цэвэр усны төрөлд багтах тул ундны хэрэглээнд тохиромжтой.

**Тамирын гол.** Орхон голын үндсэн цутгал болдог. Хойт урд нэртэй 2 салаалж урсана. Хойт Тамирын урт 180 км, урд Тамирын урт 165 км, ус цуглуулах талбай 13100 км<sup>2</sup>. Хангайн гол нуруунаас эх авч урсдаг. Голын өргөн харилцан адилгүй бөгөөд дунджаар 40-70м, голын хөндийн өргөн 3-4 км, голын дундаж гүн 2,5-3,0 м. Мөсөн бүрхүүлтэй байх хугацаа 130-158 хоног, Голын ус цэнгэг цэвэр усны төрөлд багтах тул ундны хэрэглээнд тохиромжтой.

Энэ бүгдээс гадна Хангайн бүсэд Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөл нуурас эх авсан Хараа, Ерөө, Эг зэрэг голууд байдаг мөн. Төв азийн гадагш гарах урсгалгүй Байдраг, Түйн гол, таац, Онги, Булган голууд мөн бүсийн усан сүлжээнд хамаарагдаж байна.

Хангайн бүсэд Хөвсгөл, Сангийн далай, Бөөнцагаан, Баянцагаан, Орог, Улаан нуур зэрэг манай улсын томоохон нуурууд оршдог.

Хөвсгөл нуур нь Хангайн бүсийн төдийгүй манай орны хамгийн томоохон цэнгэг нууруудын нэг юм. эргэн тойрондоо 3000-3500м өндөр өргөгдсөн өндөр уул нуруудаар хүрээлэгдэн оршдог. Нуурын урт нь 133,4 км, өргөн нь 39,5 км, гадаргын нийт талбай нь 2612 км<sup>2</sup>, хамгийн гүн газар нь уг нуурт байдаг хүйс арлын орчимд 245,7 м гэж тогтоожээ. Тус нуурт нийт 47 том жижиг гол горхиуд цутгадаг бөгөөд тэдгээрийн усжуулах талбай 5300км<sup>2</sup> болдог. Хөвсгөл нуураас эх авч урсдаг ганц гол нь Эгийн гол юм. Өндөр уул нуруудаар хүрээлэгдсэн эгц эрэг зонхилох тул нуурын эргэс 1,2 км явахад нуурын усны гүн 100-200м хүрч эхэлдэг. Нуурын усны эрдэсжилт маш бага зөөлөн байгалийн нэн цэвэр усны төрөлд багтдаг.

Гидрогеологийн мужлалаар Увс нуурын, Хөвсгөл орчмын, Хангайн, Сэлэнгийн, Нууруудын хөндийн мужуудыг дамнан байрладаг. Инженер-геологийн хувьд Хөвсгөл-Сэлэнгийн, Их уулын, Булнайн, Хангайн-Тарвагатайн, Орхон-Сэлэнгийн, Өндөршилийн мужуудад багтдаг.



Бүсийн хэмжээнд дээд палеозой, доод мезозойн настай базальт, трахи-базальт, трахи-андезит зэрэг бялхмал чулуулгын төрөл, мөн насны гранит, лейкограни, гранодиорит, сиенит зэрэг гүний чулуулагууд түгээмэл тархалттай.

Олон жилийн цэвдэгийн хувьд үргэлжилсэн ба тасалданги, элбэг болон ховор алаг цоог тархалттай хөрс зонхилно. Эдгээр хөрс нь уулын ар хажуу, гол мөрний хөндий ёроол орчмоор 100-500м-ийн зузаантай, 1,5-3,5 град, уул нуруудын хөндий хонхор хотосуудаар дунджаар 50-100 м зарим хэсэгтээ 400-800м-ийн зузаантай 0,5-/-1,5/ град-ын температуртай.

Хангайн бүсийн гадаргын усны бохирдлын эх үүсвэр нь Эрдэнэт, Мөрөн, Арвайхээр, Байнхонгор, Цэцэрлэг зэрэг томоохон хотууд бөгөөд тэдгээр нь Дэлгэрмөрөн, Ачуут, Хангал, Түйн голыг бохирдуулах гол шалтгаан болдог. Ялангуяа Хангал, Орхон гол шар усны үертэй байхад үйлдвэрийн хаягдлын усан сан хальж голын усанд нийлдэг байна. Уг голын усанд нийлж байгаа бохир ус нь эрдэсжилт, хүнд металлын агууламж ихтэй болох нь нэгэт шинжилгээгээр тогтоогдсон. Мөн хүний үйл ажиллагаа болон байгалийн нөлөөллөөс болж Байдраг, Түйн голын түвшин доошлох хандлагатай боллоо.

Хангайн бүсэд нийт 29 гаруй сумыг хамарсан 2336,11 мян га газрыг эзэлсэн 10 тусгай хамгаалалттай газар нутаг байгаа нь Улсын нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 11,14%-ийг эзэлж байна. 2001-2005 оны хооронд нийтдээ 3465 мян га, 2006-2015 онд 1540 мян га газрыг тус тус Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж байна.

Эдийн засгийн Хангайн бүсэд төв суурин газрын сүлжээ сул хөгжсөн учир хот суурины газар бүсийн нийт нутгийн 0,3 хувийг эзлэх бөгөөд энэ нь улсын хэмжээний ийм ангиллын газрын 26 хувийг эзэлж байна. Хот суурин газрын 84 хувь нь амйгийн төв-хот, сумын төв-тосгон (суурины)-ы нутаг дэвсгэр юм.

Хангайн бүсийн газрын сангийн ангиллуудын дотор хамгийн их хувийн жинг хөдөө аж ахуйн газар эзэлдэг. Энэ бүсийн хэмжээгээр хөдөө аж ахуйн газар 29912 мянган га буюу бүсийнхээ нийт нутгийн 78 хувийг эзэлж байна. Эдийн засгийн Төв болон Зүүн бүстэй харьцуулахад хөдөө аж ахуйн газрын хувийн жин нэлээд бага



харин Баруун бүсийнхтэй нэг түвшинд байна. Одоо мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу хөдөө аж ахуйн газрыг 6 төрөлд хувааж үзэхэд бэлчээрийн газар 98 орчим хувийг эзэлж тариалан, хадлангийн газар тус бүртээ 0,4-0,8 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн Хангайн бүс 1990 онд нийт 251 мянган га эргэлтийн талбай, албан ёсоор зөвшөөрсөн 48 мянган га атаржсан газартай байсан боловч 2001 оны байдлаар 107,6 мянган га талбайтай, 153,3 мянган га атаржсан газартай болжээ. Бүс дотроо Булган аймаг хамгийн их тариалангийн буюу бүсийн нийт тариалангийн газрын 72 хувь нь энд байдаг. 1990-ээд оноос өмнө Ингэттолгой, Магсаржав, Сансар зэрэг тариалангийн томоохон сангийн аж ахуйнууд энэ аймагт байснаас гадна хуучин хөдөө аж ахуйн нэгдлүүд ч гэсэн газар тариалан эрхэлдэг уламжлалтай байсан учир одоо ч энэ аймаг манай газар тариалангийн нэг гол аймаг байсаар байна.

Энэ бүсийн Архангай, Хөвсгөл, Өвөрхангай аймгууд ижлэвтэр 40-50 мянган га тариалангийн газартай юм. Тариалан нь Хөвсгөл, Баянхонгор аймагт үр тариалалтын тэжээл, бусад аймагт үр тарианы төрөлжилттэй ажээ. Нийт тариалангийн талбайн 2,7 хувь нь усалгаатай тариаланд ашиглагддаг байна. Энэ бүсэд нийт 6854 га бүхий 25 услалтын систем улсын хөрөнгө оруулалтаар баригдсан /1990 он/ байлаа. Нэг услалтын системийн дундаж хэмжээ 851 га боловч хархорины буюу Монголын хамгийн том услалтын системийг хасаж тооцвол Хөвсгөл, Булган, Баянхонгор аймгуудын услалтын систем нь жижиг услалтын системийн тоонд орно. Энэ аймгуудын нэг услалтын систем дунджаар 59-88 га талбайтай байна. Газар тариалангийн нэг гол дутагдал нь хөрсний элэгдэл юм. Улсын хэмжээгээр 49,4 мянган га талбайн хөрс нэн хүчтэй элэгдэж эвдэрсэн байхад түүний 16,3 мянган га нь эдийн засгийн Хангайн бүсэд ногдож байна. Ялангуяа Булган, Архангай аймагт нэн хүчтэй элэгдсэн хөрс их байдаг.

Эдийн засгийн Хангайн бүсэд байгалийн хадлангийн талбай төдий л их бус. Улсын нийт зураг-бүртгэлтэй хадлангийн газрын 14 хувь нь энд байдаг ажээ. Улсын хэмжээний байнга ашиглагддаг хадлангийн талбайд харьцуулбал 17,2 хувь болж байна.





Бүс дотроо хадлангийн талбайгаар нэлээд элбэгтэй нь Булган аймаг бөгөөд бүсийн хадлангийн 50 хувийг эзэмшдэг байна. Байгалийн хадлан нь энэ бүсийн бэлчээрийн мал аж ахуйг өвөл, хаврын хахир хатуу цагт авч гарахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг “маш чухал” нөөц баялгийн нэг ажээ. Гэвч хадлангийн талбайг хадгалан хамгаалах, бололцооны хирээр өргөтгөх, байгаа талбайг услах, өтөг бууцаар бордох, малд идүүлэхээс хамгаалах зэрэг арга хэмжээ авах талаар энэ бүсэд хуримтлуулсан дадлага туршлага бараг үгүй байна.

Эдийн засгийн Хангайн бүсийн газрын нөөцийн бараг 98 хувь нь байгалийн бэлчээрийн хэлбэрээр ашиглагдаж байна. (9 дүгээр хүснэгт) Бэлчээр нь хэв шинж болон төрлийн хувьд нэн олон янз. Өндөр уулын, уулын нугархаг хээрийн, уулын хээрийн, уулын нугат, тал хөндийн, хээрийн голын хөндийн татмын, нам хотсын нугын, цөлөрхөг хээрийн, цөлийн бэлчээрийн хэв шинжийн аль аль энэ бүсэд байдаг ажээ.

### Хангайн бүсийн хөдөө аж ахуйн бүтэц

9 дүгээр хүснэгт

Газрын зориулалт	Нийт талбай мянган га	Эзлэх хувь
1. Тариалангийн газар	107,6	0,4
2. Атаршсан газар	153,3	0,5
3. Таримал жимс, жимсгэний талбай	0,05	-
4. Хадлангийн талбай	240,4	0,8
5. Бэлчээрийн газар	29402,7	98,3
6. ХАА-н барилга байгууламжийн доорхи газар	8,2	0,02
Бүгд	29912,3	100,0

Бэлчээрийн дундаж ургацын хувьд 2,5-4,2 цн/га бөгөөд цөл, цөлөрхөг хээрийн хэв шинжийн бэлчээр зонхилсон Өвөрхангай, Баянхонгор аймгийн мал 1995 оноос эхлэн 2 саяас дээш гарчээ. Энэ бүсийн нийт малыг хонин толгойд шилжүүлбэл 22 сая гаруй байна. Улсын дунджаар 100 га бэлчээрт хонин толгойд шилжүүлсэн 51 мал ногдож байхад Хангайн бүсийн дунджаар 78 мал, Булган,




Архангай, өвөрхангай зэрэг аймагт 100 га бэлчээрт 95-101 мал ногдож байна. Иймээс улсын дунджаар нэг хонин толгойд 1,9 га бэлчээр ногдож байхад дээрх аймгуудад 1 га бэлчээр оногдож байна.

Орхон аймаг нутаг дэвсгэр бага, томоохон хотын хаяа бараадаж мал бөөгнөрсөн зэргээс болж нэг хонинд 0,2 га бэлчээр оногдож байна. Энэ бүхэн нь эдийн засгийн Хангайн бүсэд бэлчээр малын харьцаа зохистой хэмжээнээс хэтэрсэн, улмаар мал жилийн турш бэлчээрээс олж идэх ёстой физиологийн нормт хэмжээний тэжээл авч чадахгүй байгааг харуулж байна. Жилийн турш бэлчээрт шүтсэн мал дутуу дулимаг хоолтой байгаа нь малын тарга тэвээрэг, дундаж жин, ашиг шимийн гарцад муугаар нөлөөлөхөөс гадна бэлчээрийн талхагдалыг ихэсгэж улмаар экологийн аюултай байдалд хүргэж болзошгүй байна.

Хангайн бүсэд хамрагддаг Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг нийлээд нийтдээ 384 мян.км<sup>2</sup> талбайтай. Үүнээс уулын хөрс 212,6 мян.км<sup>2</sup> /55,38%, ухаа толгод нам уулын хөрс 36,3 мян.км<sup>2</sup> /9,46%, тал хөндийн хөрс 130,9 мян.км<sup>2</sup> /34,08% талбайг тус тус эзэлнэ. Энэ бүсэд ерөнхийдөө уулархаг нутаг зонхилох /64,8%/ тул хөрсний нөөцийн хувьд бусад бүсүүдээс ялгарах гол онцлог нь уулын ой-тайгын хөрсний талбай /179,4 мян.км<sup>2</sup>/ хавьгүй их байна. Өөрөөр хэлбэл манай орны ойн нөөцийн ихэнх нь Хангайн бүсэд оршдог. Бусад бүсүүдийн адил энд хуурай хээрийн хүрэн хөрс уул, толгод, тал хөндийг хамарч хамгийн өргөн тархалттай /109,6 мян.км<sup>2</sup>/ байх бөгөөд харин дотор нь ялгаж үзвэл хархүрэн (42 дугаар зураг хөрс) хөрс /59,4 мян.км<sup>2</sup>/ илт давамгайлж жинхэнэ хүрэн /22,6 мян.км<sup>2</sup>/, цайвар хүрэн /27,6 мян.км<sup>2</sup>/ хөрс хоёр харьцангуй бага талбайг хамарна. Хар шороон хөрсний тархалт тийм ч бага биш /36,1 мян.км<sup>2</sup>/ боловч голдуу /32,4 мян.км<sup>2</sup>/ уулархаг газраар байрлана. Заримдаг цөлийн бор хөрс зөвхөн Баянхонгор, Өвөрхангай, аймгийн нутагт /52,8 мян.км<sup>2</sup>/ байдаг бол цөлийн хөрс бараг ганцхан Баянхонгор аймгийн урд талаар тархжээ. Тэхдээ цөлийн бор саарал хөрс зонхилж /22,4 мян.км<sup>2</sup>/, хэт гандуу цөлийн борзон хөрс багаахан талбайг /5,8 мян.км<sup>2</sup>/ эзэлдэг. Нугын ба нугат-намгийн чийглэг хөрс голдуу олон жилийн цэвдэг чулуулаг дээр байрлах бөгөөд талбайн хувьд тийм ч бага биш /13,4 мян.км<sup>2</sup>/ юм. Гол мөрдийн хөндий, татам дагуу оршдог нугархаг



хөрсний талбай 7,3 мян.км<sup>2</sup> орчим байна. Хужир, мараа, шал тойром бүхий давсархаг хөрсний нийлбэр талбай 5,8 мян.км<sup>2</sup> хүрдэг бол элс харин бага /1,3 мян.км<sup>2</sup> тархжээ. Элстэй газар зөвхөн Баянхонгор, Өвөрхангай аймагт л нууруудын хотгорт тааралддаг байна. Уулын тундрын хөрс /16,6 мян.км<sup>2</sup>/ гол төлөв Хөвсгөл орчмын ян сарьдгуудын оройгоор тархдаг бол өндөр уулын нугын ба нугат-хээрийн хөрс /28,0 мян.км<sup>2</sup>/ Хангай, (10 дугаар хүснэгт) Хөвсгөлийн уулс төдийгүй Говь-Алтайн нуруунд ч байна.





**Хангайн бүсийн аймгуудын хөрсний нөөцийн нэгдсэн дүн**

10 дугаар хүснэгт

Хөрсний нэр		Архангай		Баянхонгор		Булган		Өвөрхангай		Хөвсгөл		Дүн	
		км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%
А		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>1. Уулын хөрс</b>													
1	Уулын тундрын									16590	16,43	16590	4,32
2	Өндөр уулын нугын ба нугат хээрийн	11520	20,95	8580	7,40			920	1,46	7000	6,93	28020	7,30
3	Өндөр уулын хээрийн	240	0,44	10	0,01							250	0,07
4	Уулын цэвдэгт тайгын, ширэгт тайгын ойн бараан	12680	23,05			24260	49,5	1590	2,52	40880	40,48	79410	20,68
5	Уулын хар шороон Уулын хар хүрэн	10720	19,49	360	0,31	4560	9,31	1270	2,02	10810	10,70	27720	7,22
6	Уулын хүрэн	7740	14,07	10530	9,08	4350	8,88	12580	20	3350	3,32	38550	10,04
7	Уулын цайвар хүрэн			3270	2,82			4300	6,83			7570	1,97
8	Уулын цөлөрхөг хээрийн бор			4400	3,79			1920	3,05			6320	1,65
9	Уулын цөлийн бор саарал			6590	5,68			250	0,40			6840	1,78
10				1390	1,20							1390	0,36
<b>ДҮН</b>		<b>42900</b>	<b>78,0</b>	<b>35130</b>	<b>30,28</b>	<b>33170</b>	<b>67,7</b>	<b>22630</b>	<b>36,2</b>	<b>78630</b>	<b>77,85</b>	<b>212660</b>	<b>55,38</b>
<b>2. Ухаа, гүвээ, нам уул толгодын хөрс</b>													
11	Хар шороон	560	1,02			1960	4,00			2200	2,18	4720	1,23
12	Хар хүрэн	1050	1,91	80	0,07	2120	4,33			1450	1,44	4700	1,22
13	Хүрэн			2100	1,81			5400	8,57			7500	1,95
14	Цайвар хүрэн			5850	5,04			2770	4,40			8620	2,24
15	Цөлөрхөг хээрийн бор			4480	3,86			850	1,35			5330	1,39
16	Цөлийн бор саарал			5460	4,71							5460	1,42
<b>ДҮН</b>		<b>1610</b>	<b>2,03</b>	<b>17970</b>	<b>15,49</b>	<b>4080</b>	<b>8,33</b>	<b>9020</b>	<b>14,32</b>	<b>3650</b>	<b>3,61</b>	<b>36330</b>	<b>9,46</b>



3. Тал хөндийн хөрс													
17	Сул чандруулаг элсэн/нарсан ой/					30	0,06					30	0,01
18	Хар шороон ба нугат хар шороон	570	1,04			1270	2,59	60	0,13	1790	1,77	3710	0,97
19	Хар хүрэн	4580	8,33	140	0,12	5680	11,59	2880	4,57	2870	2,84	16150	4,21
20	Хүрэн			3230	2,76			4280	6,79			7510	1,96
21	Цайвар хүрэн	350	0,64	6070	5,23	110	0,22	5790	9,19	100	0,10	12420	3,23
22	Цөлөрхөг хээрийн бор			26140	22,53			14550	23,10			40690	10,60
23	Цөлийн бор саарал			15930	13,73			20	0,03			15950	4,15
24	Хэт хуурай цөлийн борзон			5820	5,02			30	0,05			5850	1,52
25	Нугын ба нугат намгийн цэвдэг	2270	4,13	530	0,46	2150	4,39	440	0,70	8470	8,39	13860	3,61
26	Хужир, марз, мараа, шал	290	0,53	3030	2,61	1110	2,27	1360	2,16			5790	1,51
27	Элс			870	0,75			470	0,75			1340	0,35
28	Голын татмын нугат намгийн	2210	4,02	590	0,51	1120	2,29	1230	1,95	2190	2,17	7340	1,91
<b>ДҮН</b>		<b>10270</b>	<b>18,67</b>	<b>62350</b>	<b>53,75</b>	<b>11710</b>	<b>23,90</b>	<b>31130</b>	<b>49,41</b>	<b>15420</b>	<b>15,27</b>	<b>130880</b>	<b>34,08</b>
	Нуурын усны талыай	220	0,40	550	0,47	40	0,08	20	0,03	3300	3,27	4130	1,08
	Хангайн бүсийн дүн	55000	100,0	116000	100,0	49000	100,0	63000	100,0	101000	100,0	384000	100,0

Хөрсний нөөц хэмжээг Хангайн бүсийн дотор нь харьцуулж үзвэл нийт нутгийн 28,4% нь хуурай хээрийн хүрэн /хар хүрэн 15,47, жинхэнэ хүрэн 5,88, цайвар хүрэн 7,12/, 20,68% нь уулын ой-тайгын, 9,42% нь хар шороон, 13,77% нь заримдаг цөлийн бор, 5,93% нь цөлийн бор саарал, 1,52% нь хэт хуурай цөлийн борзон, 3,61% нь нугын ба нугат намгийн, 1,51% нь хужир, марз, мараа бүхий давсархаг, 1,91% нь голын татмын нугархаг, 4,32% нь уулын тундрын, 7,3% нь өндөр уулын нугын ба нугат- хээрийн хөрстэй. Элсний тархалт нийт нутгийн 0,35%-ийг хамар ч байна. Эдгээр хөрсүүдээс мөн л 70 гауй хувь нь малын бэлчээрт ашиглагдах боловч хадлан авах боломжтой газар багагүй байна.





Уулсын хоорондох хөндий, хотгор, гол мөрдийн дагуух харшороон, нугархаг харшороон, хархүрэн, нугархаг хүрэн, нугын хөрстэй газраар тариаланд тохиромжтой газрын нөөц хангалттай бий бөгөөд тэдгээрийг түшиглэж үр тариа, ногооны аж ахуй нэлээд хөгжжээ. 299,6 мянган га хүрч байсан бол 2001 онд 262,6 мянган га болж 37,0 мянган га-гаар буурчээ. 2001 оны байдлаар нийт хагалсан талбайнхаа 42,8%-ийг /112,4 мян.га/ тариаланд ашиглаж үлдсэн 57,2%-ийг /150,2 мян.га/ нь атаршуулсан байна. 1994 онд хийсэн тариалангийн газрын эвдрэлийн судалгаанаас үзэхэд 50 орчим мян.га талбайн хөрс дунд зэрэг ба хүчтэй эвдэрч үржил шим нь эрс доройтсон байв. Ер нь эвдрэлд нэрвэгдсэн талбай гэвэл тэр үед нийтдээ 126,1 мян.га хүрч байжээ. Иймээс эвдрэлд орсон талбайн хөрсний үржил шимийг нөхөн сэргээх асуудалд анхаарах учиртай.

Тариалан эрхлэлтийн байдлыг авч үзвэл 2005 онд Булган аймагт 76,9 мян.га, Хөвсгөл аймагт 16,9 мян.га талбайг тариаланд ашигласан нь бусад аймгуудаас илүү нөөцтэйг харуулж байна. Энэ бүсэд одоогийнхоос 2 дахин их талбайд тариалалт явуулах боломж бий бөгөөд цаашдаа ч тариалангийн талбайг тэлж өргөтгөх сайн чанарын хөрс бүхий атар газрын нөөц хангалттай байна.

Хангайн бүс нь амьтны аймгаар баялаг, ялангуяа ой, хээр, говь, цөлийн амьтад бүгд хөршлөн оршино. Энд сүүгээр бойжигч 28 зүйл, газар уснаа явагч, хоёр нутагтан 3 зүйл, шувууны 74 зүйл, загасны 10 гаруй зүйл, мөлхөгчид 5 зүйл, шавьжны 1000 гаруй зүйл байдаг.

Энэ бүсэд Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн 21 зүйл хөхтөн, 19 зүйл шувуу, 2 зүйл мөлхөгч, 2 зүйл хоёр нутагтан, 3 зүйл загас, 7 зүйл шавьж, 53 зүйл дээд ургамал, 2 зүйл хөвд, 8 зүйл хаг, 2 зүйл мөөг ургадаг байна.

Устах аюулд ороод байгаа цөөвөр чоно, ирвэс, голын халиу, хавтгай зэрэг амьтдын тоо цөөрч байна. Хангайн бүсэд агнуурын чухал ач холбогдолтой олон зүйлийн амьтад байдаг ажээ. Тэдгээр амьтны арьс, мах, тос, эвэр, заар зэрэг түүхий эдийг монголчууд амьдрал ахуйдаа болон эмчилгээнд хэрэглэж ирсэн уламжлалтай. Зах зээлд шилжих үеэс эхлэн байгалийн нөөцийг хууль бусаар



ашиглах хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас зарим амьтны тоо эрс цөөрч, тэдгээрийн тархац нутаг ихээхэн хумигдаж байна.

Нэлээд олон биологи-газарзүйн мужууд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаагүй байгаа боловч бүсийн экосистем болон ургамал, амьтны аймгийн зүйлийг бүрэн хамгаалж чадахуйц тооны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээтэй байх нь чухал асуудал болж байна. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, зүй зохистой ашиглах шаардлагын дагуу ялангуяа хамгаалалттай газар нутаг, орчны бүс нутаг дахь суурин газруудад хүн амын төвлөрлийг багасгаж, оновчтой байрлуулах төлөвлөгөө, байршлын ерөнхий схем боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ бүсэд байгалийн, загас агнуурын, ан агнуурын, түүх соёлын, угсаатны, шашин, бөө мөргөлийн, спорт, уулын болон усан аялал жуулчлал хөгжүүлэх бүрэн боломжтой байна.

Экологи- эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр аж ахуйн чухал ач холбогдолтой ургамал, амьтдын ашиглалтын хэлбэр, зохион байгуулалтыг сайжруулах хэрэгтэй юм. Байгалийн баялгийн нөөцийн хэмжээг судалж, эдийн засгийн нэгдсэн үнэлгээ тогтоох, тэдгээрийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийг байгаль орчны даац чадавхид зохицуулан тогтвортой хөгжих нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх нь чухал байна. Бүсэд агнуурын үндсэн хөхтөн амьтдын тооллого хийх, тархалтыг тогтоох, томоохон гол мөрнүүдийн загасны нөөцийн судалгааг хийх шаардлагатай ажээ. Ховордсон амьтдыг дахин нутагшуулах, устаж болзошгүй төрөл, зүйлийг хамгаалах, байгаль хамгаалагчдын мэдлэгийг дээшлүүлж техник, хэрэгслээр хангах төсөл хэрэгжүүлэх нь чухал байна.

Бүх зүйлүүдийн тархалт, амьдрах орчны талаарх биологийн мэдээллийг сайжруулах шаардлагатай. Одоогийн байдлаар олон зүйлийн тархалт, популяци нь судлагдаагүй байна. Хамгийн тэргүүн ээлжинд унаган ба ховордсон төрөл зүйлийг тодорхойлох шаардлагатай байгаа юм.



**1.2.4 Шинэ хотын бүтээн байгуулалттай Хангайн бүсийн ашигт малтмлын үйлдвэрлэлийг уялдуулах асуудал.** Хангайн бүс олон төрлийн ашигт малтмалын тогтоогдсон ихээхэн нөөцтэй төдийгүй цаашдын судалгаагаар нөөцийг нь өсгөх хэтийн төлөвтэй учраас манай улсын эдийн засгийн хүчин чадлыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй бүс нутаг юм. Иймээс Шинээр байгуулах хоттой энэ баялагийг уялдуулахын тулд тус бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг эрдэс түүхий эдийн энэ их нөөц, ашигт малтмалын ордуудын байршлтай зайлшгүй уялдуулах шаардлагатай.

Хангайн бүсийн хэмжээнд нийт 15 төрлийн ашигт малтмалын 328 объект байгаагаас 89 нь 9 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Үүнд: алтны 46, алт-мөнгө-зэсийн 1, зэс-молибдений 1, төмрийн 2, төмөр-мангааны 1, хайлуур жоншны 1, фосфоритын 22 ба нүүрсний 15 орд тус тус судлагджээ.

Эдгээр ордуудад 12,4 тонн алт (80,0%), 173,3 мян.тн молибден (44,5), 69,3 сая тн нүүрс (1,0%), 258,9 сая тн фосфорит (89.0) агуулагддаг ажээ.

Ашигт малтмалыг батлагдсан нөөцөөр авч үзвэл тус бүсэд зэс 7308,3 мян.тн /Орхон/ байгаа нь улсын нөөцийн ихэнхийг бүрдүүлдэг. Молибден 229,8 мян.тн /Орхон/, алт 30,5 мян.тн, фосфорит 265,9 сая тн буюу улсын нөөцийн 100% эзэлдэг ажээ.

Тус бүс нутгийн Орхон аймаг дахь зэс, молибдений орд газар нь улсдаа томоохонд тооцогддог байна. Эдгээр орд газрыг орчин үеийн техник технологийн тусламжтайгаар эцсийн бүтээгдэхүүн гаргаж, байгаль орчинд халгүйгээр ашиглах нь тус бүсийн хөгжилд ихээхэн хөшүүрэг болох юм. Бүсийн хөгжилд эрчим хүч ихээхэн нөлөөтэй. Сэргээгдэх эрчим хүчийг зохих хэмжээгээр ашиглаж, бүс нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх боломжтой.

Хөвсгөл, Архангай, Орхон, Булган, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын нутгийг хамарсан Хангайн бүсийн нийт нутаг ерөнхийдөө дунд масштабын геологийн эрэл-зураглал, эрэл-хайгуулаар сайн судлагдсан бөгөөд голлох ашигт малтмал нь хөнгөн цагаан, фосфор, алт мөнгө давамгайлсан холимог металл, алт, цагаан алт байна. Хангайн бүсэд Хөвсгөл, Завханы фосфоритын сав газрууд,



Хөвсгөл-Соёны хөнгөн цагааны хүдрийн металлогенийн бүсүүд, түүнчлэн Байдраг-Өлзийт, Уянга, Өлт, Цэнхэр, Тавтын алтын хүдрийн зангилгаанууд, Эрдэнэтийн Овооны зэс-молибдены орд тус тус байрлаж байна.

Судалгаанаас үзэхэд Хангайн бүсийн хэмжээнд нийт 15 төрлийн ашигт малтмалын 330 шахам объект тогтоогдсоноос 90 нь 9 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Үүнд алтны 46, алт-мөнгө-зэсийн 1, төмрийн 2, төмөр-манганы 1, хайлуур жоншны 1, фосфоритын 22, нүүрсний 15 ордод нарийвчилсан хайгуул хийгдэж нөөцийг нь тогтоожээ. Эдгээр ордуудад 124 тоонн алт (улсын нийт алтны нөөцийн 8.0%), 6174.5 мян.тн зэс (80.0%) 173.3 мян.тн молибден (44.5%), 69.3 сая.тн нүүрс (1.0%), 258,9 сая.тн фосфорит (89.0%) нөөц батлагдсан байна. Тухайлбал, Эрдэнэтийн Овооны орд 6.2 сая.тн зэс, 173.3 мян.тн молибдены нөөцтэй, Тавтын алт-мөнгө-зэсийн ордын үйлдвэрлэлийн зэргээр бэлтэгдсэн нөөц 11.9 тн байгаа ба хайгуулын ажлаар нөөц нь тогтоогдсон фосфоритын 23 ордын 22 нь Хөвсгөлийн фосфоритын сав газарт оршдог бөгөөд үйлдвэрлэлийн (11 дүгээр хүснэгт) зэрэглэлээр бодогдсон 258.9 сая.тн фосфорын ислийн нөөцтэй ажээ.

**Хангайн бүсийн зонхилох ашигт малтмалын нөөц**

11 дүгээр хүснэгт

Ашигт малтмалын төрөл	Нөөцийн үнэлгээ /мян.тн/				
	A	B	C	P <sub>1</sub>	P <sub>2</sub>
Нүүрс	4843.7	13835.6	50571,4	34453,7	263269,2
Зэс	1194.7	4961.4	18,4	2425,5	4069,4
Хөнгөнцагаан	0.0	0.0	0,0	0,0	1349808,0
Холимог металл	0,0	0,0	0,4	4843,7	13835,6
Молибден	31,0	141,9	0,0	1194,7	4961,4
Цагаан тугалга	0,0	0,0	0,0	0,0	0,0
Гянтболд	0,0	0,0	0,0	0,0	22936.2
Төмөр	0,0	0,0	0,0	100760,0	79028.9
Мангаан	0,0	0,0	0,0	65600,0	61341.5
Хром	0,0	0,0	0,0	0,0	10.9
Газрын ховор элемент	0,0	0,0	0,0	0,0	Ta1.7 Nb 17.4
Алт /кг/	144,7	5637,4	6664,4	29363,3	943686.8
Мөнгө /тн/	0,0	0,0	11,9	95,4	10463.7
Хайлуур жонш	0,0	0,0	175,2	519,0	617.1
Фосфорит	0,0	7880,0	250989,0	132962,7	47987.8

Архангай аймгийн Хотонт сумын нутаг Цагаан сүмийн гол орчим цагаан тугалганы  $78.4\text{г}/\text{м}^3$  агуулгатай шороон орд, Хангайн Хэц уулын гянт, төмрийн нөөцийг /C<sub>2</sub> зэргээр/ 57-60 сая.тн гэж тогтоосон байна. Сүүлийн жилүүдэд Жаргалант, Өлзийт, Чулуут, Цэнхэр сумын нутагт хийгдсэн 1:50000-ын масштаын геологийн эрэл-зураглалын ажлаар Жаргалантын Их-Элэгдэй шороон ордод /P<sub>2</sub>/





зэрэглэлээр алтны нөөцийг 60 кг-аар тогтоосон ба Цэнхэрийн ордод нарийвчилсан эрэл-хайгуулын ажил хийгдэж байна. Тариат сумын өнгөлгөөний болон гоёл чимэглэлийн чулууны ордын анар /C<sub>2</sub> зэргээр/ 144.7 мян.тн, саран чулуу /хризолит/ C<sub>2</sub> зэрэглэлээрм/ 24 мян.тн, Ихтамирын Мөнгөтийн мөнгөний заараг одын нөөц /P<sub>2</sub> зэргээр/ 800 кг-аар тус тус тогтоогджээ Өгийнуур сумын нутагт нүүрс, каолины батлагдсан нөөцтэй ордууд нээгдсэн бөгөөд элс, шохойн чулуу, хайрга, галт уулын шаарга зэргийг барилга, замын байгууллагууд ашиглаж байна.

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн геологи-хайгуулын судалгаагаар нийтдээ алтны шороон орд 4, илрэл 10, чулуун нүүрсний орд 1, илрэл 3, зэсийн илрэл 4, гянт (вольфрам)-ын илрэл 6, гоёл чимэглэлийн чулууны орд 6, илрэл 9 тогтоогдсон хэдий ч нөөц, хүдрийн агуулга нь бүрэн тогтоогдоогүй байна. Уянга, Бат-Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт сумдын нутагт 1:50000-ын масштабын гцеологийн эрэл-зураглал, 4 илрэлд нарийвчилсан эрэл-үнэлгээний ажил тус тус хийгдсэний гадна алтны 2 ордод олборлолт, нүүрсний 1 орд, барилгын материалын 3 ордод тус тус ашиглалт хийгдэж байна.

Булган аймгийн нутагт алтын шороон орд 6, илрэл 4, гянтын илрэл 1, гоёл чимэглэлийн чулууны илрэл 2, шохойн орд 3-ыг эрэл, хайгуулын урьдчилсан үнэлгээгээр тогтоогоод байна. Одоогийн байдлаар тус аймагт 30 гаруй төрлийн ашигт малтмалын 40 гаруй орд тогтоогдсоноос үйлдвэрийн аргаар ашиглах боломжтой, эдийн засгийн хувьд үр ашигтай 2 алтны ордыг ашиглаж эхлээд байна. Туул голын ай сав дахь алтны ордын нөөц 20 тн, Баянголын ордын нөөц 13 тн, Тосонгийн ордын нөөц 17 тн Тэшиг сумын Эрээн-Тавтын алтны ордын нөөц 60 тн-оор тус тус тогтоогджээ.

Баянхонгор аймгийн нутаг Хангайн бүсийн бусад аймгуудаас илүү эрдэс байялагтайд тооцогддог. Тухайлбал, энд Хатан суудлын нурууны 20 км. өргөн, 220 гаруй км. урт сунасан заараг алтны бүс, Баянговийн алтны хүдрийн зангилаа, Саран уул, Ширт, Хондлойн алт, зэс, цайр, хар тугалганы хүдрийн бүлэг орд, Байдраг-Өлзийт, Гурван булаг, Эрдэнэцогтын алтны дүүргүүд байршдаг учраас олон уурхай алт олборлож байна.



Хөвсгөл аймгийн нутаг фосфоритын томоохон сав газартайгаас гадна полиметалл, хөнгөнцагааны хүдэржилтийн томоохон бүсүүдтэй, мөн түүгээрч зогсохгүй уран, нефть олдож болох геологийн өвөрмөц тогтоцтой. Энд бас Дорнод Соёны колчеданы хүдрийн бүсийн үргэлжлэл байршдаг байна.

Тус аймгийн нутагт бас фосфоритоос илүү их нөөцтэй, хаягдалгүй ашиглах технологиор цувимал хөнгөнцагаан, хөнгөнцагааны исэл, будаг, цагаан цемент, шилэн эдлэл, шаазан ваар, тусгаарлагч, фортланд, поташ, шингэн фосфор, ус цэвэршүүлэгч, идээлэгч, бэхжүүлэгч, калийн ба натрийн шүлт, сод, бордоо зэрэг 30 гаруй нэрийн бүтээгдэхүүн гарган авч болох 26%-ийн хөнгөнцагааны ислийн агуулгатай, 200 гаруй сая/тн. хүдрийн нөөцтэй Өвөрмараатын хөнгөн цагааны орд байршдаг байна. Сүүлийн жилүүдэд Өвөрмараатын ордыг судлах төслийг хэрэгжүүлснээр тус ордын нөөцийг тогтоож, улмаар ТЭЗҮ, технологийг нь тус тус боловсруулжээ. Эдгээр судалгаагаар 80 гаруй орд илрэлтэй Хөвсгөл-Соёны хөнгөнцагааны хүдэржилт бүхий металлогенийн томоохон бүсийг шинээр ялгаж, Өвөр мараат, Бэлтэс, Ужигийн голын орчимд илэрсэн шүлтлэг чулуулгийн массивууд нь 21-26%-ийн хөнгөнцагаан исэл агуулсан 4 тэрбум гаруй тн. хүдрийн таамаг нөөцтэй 15 ордтой байж болохыг тогтоогоод байна.

Бидний өмнөх судалгаагаар бас Хөвсгөл-Булганы нутгийг дамнасан алт, мөнгө давамгайлсан зэс, цайр, хар тугалгын хүдэржилт бүхий металлогенийн шинэ бүс байгааг илрүүлсэн байна.

Энд дурьдсан 3 төрлийн ашигт малтмалд эрэл хайгуул хийж нөөцийг тогтооход төр засаг болон бүс нутгийн удирдлага онцгой анхаарч гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлж геологичид, эрдэмтэдтэй хамтран хийх нь үр дүнтэй болно.

Хангайн бүсэд ороогоор сайн судлагдаагүй боловч дэлхийн зах зээлд өндөр үнэтэй цагаан алт, осми, иридийн төрлийн бүлэг металлын ихээхэн нөөц байх магадлалтай гэнэ. Энэ бүлэг металл Архангайн Батцэнгэл сумын Оорцог уул, Хойт Тэрх-Оройхын даваа ормын хангайн суурилаг чулуулгийн массивууд болон



Баянхонгорын офиолыг эвшлийн хэт суурилаг чулуулагтай гарал үүслийн холбоотой байх шинж тэмдгүүд тогтоогдсон байна.

Геотерм Хангайн бүсэд Монголын газрын гүний дулааны зонхилох нөөц байршсан нь Шинэ хотын бүтээн байгуулалттай холбосон үйлдвэрүүд байгуулж тус бүсийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй ажээ. Тухайлбал, манай оронд 48 халуун рашаан байдгаас Архангай, Баянхонгор аймгуудын нутагт 20 орчим нь байршдаг тул геотермийн станцууд байгуулах замаар Шинэ хотыг хангах эрчим хүчний нэмэлт эх үүсвэрийг бий болгох ихээхэн боломж байгаа юм. Энэ талаар төр засгаас анхаарсны үр дүнд Исланд улсад хэд хэдэн залуу судлаачийг явуулж сургалтад хамруулснаар одоогоор 6 хүнтэй геотермийн судалгааны мэргэшсэн баг бүрдэж Исландын засгийн газар, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Архангай аймгийн Шивэртийн рашааны орчимд геотермийн судалгаа хийж эхлээд байна.

Хангайн бүсийн ашигт малтмалын олборлолтын үр дүнг хот суурины бүтээн байгуулалтад шууд ашиглаж байна. Тухайлбал Булган аймгийн нутаг дахь алтны ордуудаас 7 аж ауйн нэгж жилд 640 гаруй кг алт олборлож Сайхан суманд Сайхан-Овоогийн нүүрсний уурхай, Орхон суманд Мааньтийн шохой олборлох үйлдвэр тус тус байгуулан ажиллаж байна. Олборлолтын энэ ажилтай холбогдож газрын нэгдсэн ангилал, бүртгэлийг шинэчлэх, газар зохион байгуулалтыг ажил хийх шаардлагатай гэж үзэж байна.

Баянхонгор аймгийн Галуут, Заг, Баян-Овоо, Гурванбулаг, Бөмбөгөр зэрэг сумдын уурхай эдэлбэрийн газарт 30 гаруй аж ахуйн нэгж 5069 га талбайг алт олборлолтын зориулалтаар ашиглаж, үйлдвэр байгуулж ашигт малтмалын хайгуулын 250 шахам аж ахуй нэгж 3 сая шахам га газарт хайгуул явуулж байна. Улмаар хот суурины бүтээн байгуулалтад үр дүнг нь шууд ашиглаж байна.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Бүрэнхааны орд нь фосфоритийн баялаг нөөцтэй бөгөөд Бүрэнхаан-Эрдэнэтийн хооронд төмөр зам барьж ордыг ашиглах тохиолдолд эхний ээлжинд 1,2 сая.тн хүдэр олборлон баяжуулах үйлдвэр байгуулах бүрэн боломжтой байна. Баяжуулах үйлдвэрээс гарсан ихээхэн хэмжээний фосфоритийн баяжмалыг Эрдэнэт хотын үйлдвэрийн



районд байгуулах бордооны үйлдвэрт хүхрийн хүчлээр боловсруулж өндөр чанарын олон мянган тн фосфорын давхар бордоо үйлдвэрлэн экспортлох боломжтой гэнэ. Энэ судалгааг зах зээлийн хэрэгцээтэй уялдан үйлдвэрийн хүч чадлыг нэмэх боломжтой байна. Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалыг гидрометаллургийн аргаар боловсруулахад их хэмжээний хүхрийн хүчил гарах боломжтой байна. Үүнийг фосфорыг давхар бордоо үйлдвэрлэх үйлдвэр болгон ашиглаж болно.

Хангайн бүсийн хэмжээнд алт, зэс, молибден, төмөр-мангаан, фосфорит, нүүрс зэрэг ашигт малтмалуудын олборлолт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой байна. Тухайлбал, Эрдэнэтийн үйлдвэрийн технологийн шинэчлэлтийг хийж зэс хайлуулах үйлдвэртэй хамт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех байгуулах замаар үйлдвэрийн үр ашгийг эрс дээшлүүлэх үндэслэлтэй юм. Мөн гидрометаллургийн аргаар ядуу агуулгатай хүдрийг боловсруулах үйлдвэрийг Эрдэнэтийн үйлдвэрийн дэргэд байгуулан бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг эцсийн бүтээгдэхүүн (99,9%-ийн агуулгатай катодын зэс) хэлбэрээр үйлдвэрлэх, катодын зэс үйлдвэрлэдэг Эрдмин үйлдвэрийг өргөтгөх замаар нэгдсэн шат системтэй үйлдвэр байгуулж болох байна.

Хангайн бүсийн аймгуудад нийт 10,9 сая.га талбайг хайгуулын болон ашиглалтын лицензээр аж ахуйн нэгж, хүмүүст олгосон байна. Энэ нь улсын нийт лицензээр олгосон талбайн 21,5%, олгосон нийт лицензийн 22,4% нь Хангайн бүсийн аймгуудад ногдож байна. Үүнийг Шинэ хотын бүтээн байгуулалтад бодлогын хэмжээнд ашиглаж болох байна.

Хангайн бүсийн хэмжээнд алт, зэс, молибден, төмөр-мангаан, фосфорит, нүүрс зэрэг ашигт малтмалуудыг ашиглан хөгжих ирээдүй байна. Үүнийг Шинэ хотын бүтээн байгуулалттай шууд уялдуулах Тухайлбал:

**Нэг:** Эрдэнэт үйлдвэрийн технологийн шинэчлэлийг хийж, зэс хайлуулах үйлдвэртэй хамт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех бий болгох замаар үйлдвэрийн үр ашгийг эрс дээшлүүлэх нөхцөл бололцоог бий болгох, гидрометаллургийн аргаар ядуу агуулгатай хүдрийг боловсруулах үйлдвэрийг



Эрдэнэт үйлдвэрийн дэргэд байгуулан, бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг эцсийн бүтээгдэхүүн /99,9%-ийн агуулгатай катодын зэс/ хэлбэрээр үйлдвэрлэх, катодын зэс үйлдвэрлэдэг Монгол –Америкийн хамтарсан Эрдмин үйлдвэрийг өргөтгөх,

**Хоёр:** Нөөц нь бэлтгэгдсэн Тавтын алтны хүдрийн ордыг ашиглах уул уурхайн үйлдвэр байгуулах

**Гурав:** Алтны нөөцийг нэмэгдүүлэх потенциал өндөртэй байдлаа ашиглан хөрөнгө оруулагчдыг дэмжих, нөөц өсгөлт, олборлолтыг нэмэгдүүлэх замаар үйлдвэрүүд байгуулах.

**Дөрөв:** Сайхан голын төмөр-мангааны орд зэрэг ирээдүй бүхий объектуудыг цогцолбороор ашиглах асуудлыг бодлогын хүрээнд тавьж шийдвэрлэх, замаар хангайн бүсэд бага оврын баяжуулах уул уурхайн үйлдвэр байгуулах,

**Тав:** Хөвсгөл нуураас урагш 80 км зайд орших Бүрэнхааны фосфоритын ордыг байгаль орчинд сөрөг нөлөө багатай ашиглах асуудлыг шийдвэрлэж ингэснээр Эрдэнэт үйлдвэрийн бүтээгдэхүүнийг боловсруулах зэс хайлуулах үйлдвэрийн хүхрийн хүчилтэй хамтад нь боловсруулж, фосфорын бордоо үйлдвэрлэх технологитой химийн үйлдвэрлэл зохион байгуулах, үүний үр дүнд үйлдвэрийг жилд олон мянган тн фосфорын бордоо үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байгуулах

**Зургаа:** Манай улсын хувьд хөнгөн цагааны бэлтгэгдсэн нөөц байхгүйг харгалзан хөнгөн цагааны ислийн бараг тэрбум тоннын таамагласан эрдсийн баялаг бүхий хэтийн төлөв сайтай нефелин сиенитийн бүлэг илрэлүүд /Дөшийн гол, Өвөр мараат, Дунд хэм гол, Бэлтэсийн гол зэрэг/ байгааг түшиглэж судалгаа туршилтыг өргөжүүлэх замаар түүхий эдийг нь олборлон, иж бүрэн боловсруулах үйлдвэр байгуулж болох байна.

**Долоо:** Цагаан алт, хромитын орд илрэлийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, Шинэ хоттой хамт үйлдвэрийг нь босгох бүрэн боломж байна.





Монгол Улсын газар түүхий эдийн баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг оюуны чадамждаа тулгуурлан, байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах замаар хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн хэт бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх явдлыг бүсчилсэн хөгжлийн эрхэм зорилго мөн гэж тодорхойлсон Шинэ хот байгуулах асуудал энэ зорилттой шууд холбоотой.

Үүнийг хэрэгжүүлэхэд Хангайн бүсийн хөгжил онцгой үүрэгтэй байх болно. Хангайн бүсийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, ашиглах нөөц боломж, давуу болон сул тал, бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегид нийцүүлэн бүсийн хөгжлийн аль үе шатанд ямар ямар зорилт дэвшүүлэн тавих, ямар үйл ажиллагаа явуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга, механизм ямар байх, түүнийг хэрхэн бүрдүүлэх зэрэг олон асуудлыг Шинэ хотын бүтээн байгуулалттай шууд уялдуулан авч үзэх учиртай.



### Дүгнэлт

1. Монгол Улсын их хурал 2003 онд Монгол Улсыг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн 5 бүсээр бүсчлэн хөгжүүлэхээр анх удаа тогтоож шийдвэртээ 1. Баруун бүсэд - Ховд, Улиастай, 2. Хангайн бүсэд - Хар хорин, Эрдэнэт хот 3. Төвийн бүсэд - Зуунмод, Дархан хот 4. Зүүн бүсэд – Чойбалсан, Өндөрхаан хотуудыг бүсийн тулгуур төв хот болгохоор заажээ. Шийдвэрийнхээ хүрээнд бүсүүдэд эдийн засгийн паркуудыг байгуулах үндсэн чиглэлийг баталсаны дотор Хангайн бүсэд экспортын үйлдвэрлэлийн “Эрдэнэт” үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар тогтсон нь тэнд мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох зорилтыг агуулсан шийдвэр болжээ.

2. Шинэ хот байгуулах энэ газар нутаг маань Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Хотонт, Хашаат сумуудын нутаг дэвсгэрийг хамарсан Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газар бөгөөд Төв Азийн нүүдэлчид түүний дотор монгол үндэстний буй болгосон нүүдлийн соёл иргэншил, түүний гарал үүсэл, хөгжлийг археологи, түүх соёлын баялаг дурсгалтайг нотлон харуулж байгаа дэлхийд данстай гайхамшигт түүхэн нутаг ажээ.

3. Богд хаант монгол улсын нийгэм-улс төр, шашны төв бөгөөд 1639 онд Өргөө нэртэйгээр Өвөрхангай аймгийн Ширээ Цагаан нуур гэдэг газар тэр үеийн монгол улсын шашин, нийгэм улс төрийн төв болон хүрээ зохион байгуулалттай баригдсан, Да хүрээ, Богдын хүрээ Нийслэл хүрээ /1911/ гэж нэрлэгдэж ирсэн Их хүрээ. Их хүрээ нь хүн амын тоо тус орны нийгэм-улс төрийн амьдралд эзлэх байр сууриараа онцгой үүрэгтэй байжээ.

4. Монгол Улсад цэрэг – нийгэм –улс төр – худалдааны төвлөрсөн суурин буюу Цайз бэхлэлт –худалдааны хот. /Ховд, Улиастай, Эрдэнэ-зуу/, шашин, нийгэм –улс төр соёлын төв болон шашны хурал номын 750 гаруй том жижиг Сүм-хийд /Хархорин, Амарбаясгалант, Тариатын хүрээ, Бэрээвэн хийд аймаг хошуу нутгийн засаг захиргааны удирдлага гадаадын худалдаачид, томоохон сүм хийдүүд төвлөрсөн Хүрээ-суурин зэрэг худалдаа, арилжаа, үйлчилгээ төр нийгэм эдийн засаг зонхилсон хот нэртэй хүрээ мягийн суурингууд байжээ.



5. Монгол улсад суурьшмал соёл иргэншлийн үндсэн хэв шинж хот суурин хөгжиж ирсэн үе шатыг дараах үечлэлээр тогтоож байна. Үүнд:

Нэгдүгээр үе 1911-1934

Хоёрдугаар үе 1934-1960

Гуравдугаар үе 1960-аас хойш гэж тус тус ангилаж байна.

6. Тусгаар тогтносон Богд хаант монгол улс байгуулагдсан 1911 оноос 1921 оны ардын хувьсгал хүртэл манай улсад Их хүрээ, Цэрэг нийгэм –улс төр, худалдаа төвлөрсөн цайз бэхлэлт худалдааны **Ховд, Улиастай, Эрдэнэ Зуу, Хиагт хот**, Шашин, Нийгэм Улстөр соёлын томоохон төв **Хархорин, Амарбаясгалант хийд, Тариалтын хүрээ, Бэрээвэн хийд** зэрэг хот суурин байжээ.

7. Тэр үеийн хот сууринд эдийн засгийн өсөлт бага, бүтцийн өөрчлөлт удаан байгаа нь хот суурин, бүсүүдийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь хэт бага байх нөхцлийг бий болгож байжээ. Тухайлбал XIX зууний сүүлийн хагас жилийн байдлаар манай ихэнх аймгууд төсвийн зарлагынхаа 20-25 хувийг л орлогоороо бүрдүүлж байсан байна. Үүнээс үүдэн татаас шилжүүлэгч өсөх болж. Төсвийн татаас XIX зууны сүүлийн хагаст 20 орчим хувиар өсөж байжээ.

8. Монгол улсын бүс нутгийн хөгжлийн индексийг хөгжлийн түвшний индекс, хөгжлийн нөөцийн индекс гэсэн 2 ангиллаар боловсруулан тооцсон судалгаанаас үзэхэд хөгжлийн түвшний нэгдсэн индексийн үзүүлэлтээр Хангайн бүс нь (0.251) Улаанбаатар, Төвийн бүсийн дараагаар орж байгаа боловч улсын дундаж (0.339)-аас доогуур байжээ. Аймгуудын хөгжлийн (27, 28 дугаар зураг) түвшнээр жигд бус бөгөөд улсын хэмжээнд энэ үзүүлэлтээр Баянхонгор аймаг хамгийн доогуур, Хөвсгөл, Өвөрхангай аймаг доогуур, Архангай аймаг аймгуудын дундач түвшинд байсан байна.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТАД НӨЛӨӨЛӨХ БАЙГАЛЬ ЦАГ  
УУР, ЭКОЛОГИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД**

**НЭГ. ХОТ СУУРИНЫ, АРХИТЕКТУРТ НӨЛӨӨЛӨХ БАЙГАЛЬ ЦАГ УУР ЭКОЛОГИ,  
ГАЗАРЗҮЙ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ.**

**II.1.1 Дэлхийн болон Монгол орны уур амьсгалын өөрчлөлт.** Сүүлийн арав гаруйхан жилийн дотор уур амьсгалын өөрчлөлт шинжлэх ухааны таамаглалаас бодит үнэн болж хувирлаа. Уур амьсгалын цаашдын өөрчлөлтийг хязгаарлаж чадах эсэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож чадах эсэхээс тодорхой улс орны төдийгүй соёл иргэншлийн цаашдын хувь заяа хамаарч болзошгүй байдалтай боллоо. Өнөө үед уур амьсгалын өөрчлөлтийн асуудал яагаад онцгой хурц тавигдах болов гэдгийг дараах хэдэн учир шалтгаанаар тайлбарлаж болох юм. Үүнд:

1. Байгаль, нийгэм эдийн засгийн түүн дотор хүн амын суурин тогтолцоо тухайн газар орныхоо уур амьсгалын тоддорхой нөхцөлд л зохицсон байдаг учраас олон арван жилийн доторхи уур амьсгалын өөрчлөлт төдийгүй түүний өчүүхэн бага хувиралт ч гэсэн байгаль нийгмийн нэгэнт хэвшин тогтсон горимд зохисгүй нөлөө үзүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрийн хэмжээгээр жил тутам 20 тэрбум орчим ам.долларын хохирол гарна гэж UNEP-ээс тооцоолсон байна. Нийгмийн баялагийн хуримтлал асар их болсон энэ үед уур амьсгалын хувиралт, уур амьсгалын эрс /экстремаль/ нөхцлөөс нийгэмд учирдаг хохирол ихээхэн нэмэгдэж байна. ХХ зууны тавиад оноос хойш агаар мандлын гаралтай байгалийн гамшгаас дэлхий дахинд учирч байгаа хохирол 14 дахин өссөн байна.

2. Дэлхийн түүхэнд болон соёл иргэншил үүссэн цагаас хойшхи үеийн уур амьсгалын өөрчлөлт сүүлийн зуугаад жилийг эс тооцвол дан ганц байгалийн хүчин зүйлийн үйлчлэл дор явагдаж ирсэн бол өдгөө цагт хүний үйл ажиллагааны цар хүрээ эрс өсч уур амьсгалын системд нөлөөлөх бас нэг хүчин зүйл болж байна. Цаашид энэ талын нөлөөллийг хязгаарлах тодорхой арга хэмжээ авахгүй бол



дэлхийн уур амьсгалын систем эргэлт буцалтгүй шинжтэй өөрчлөгдөх, санаанд оромгүй эрс өөрчлөлт гарч мэдэх боллоо.

3. Уур амьсгалын одоо явагдаж байгаа өөрчлөлт дэлхийн түүхэнд тохиолдож байсан уур амьсгалын хувьсгал маягийн өөрчлөлттэй жишихэд ахар богино хугацаанд явагдаж байгаа учраас амь мандал /бибофер/-ийн олон бүрдэл хэсэг энэ өөрчлөлтийн хурдын аригийг тэсвэрлэж чадахгүйд хүрэх буюу “экологийн сүйрэл”-д хүргэж болзошгүй байна.

4. Хэдийгээр шинжлэх ухааны хувьд олон зүйл тодорхойгүй хэвээрээ байгаа боловч уур амьсгалын өөрчлөлтийн хурдыг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг алгуурлах, хойш тавих явдал байгаль, нийгэм эдийн засгийн системд учирч болох хохирлыг үлэмж нэмэгдүүлж болзошгүй гэж үзэх үндэслэл байна.

5. Сав шим тогтолцоонд уур амьсгалын нөхцөл хөтлөгч үүрэгтэй уур амьсгалын өөрчлөлтөөс уламжлаад усны нөөц, хөрсний үржил шим, байгалийн бүс бүслүүр улмаар экосистем бүхэлдээ хувиран өөрчлөгдөх боллоо.

Чухам ийм учраас шинэ зуунд улс орон, бүс нутаг, хот суурин, дэлхий дахины тогтвортой хөгжлийн асуудлыг уур амьсгалын өөрчлөлт түүнийг сааруулах, нийгэм эдийн засаг, удирдлагатай байгалийн системээ уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан хөгжүүлэх асуудалтай зайлшгүй холбон үзэх шаардлагатай боллоо. Монгол орны газарзүйн байршил, тогтолцоо зэргийг харвал уур амьсгалын өөрчлөлтөд тун эмзэг. Уур амьсгал ерөнхийдөө дулаарч байгаа нь манай орон шиг эрс тэс уур амьсгалтай улс орнуудын хувьд уур амьсгалын хатуу ширүүн байдал зөөлөрч, амьдрах гадаад орчны хувьд аятай таатай нөхцлийг зарим талаар бүрдүүлж болох юм. Гэвч дэлхийн уур амьсгалын систем бүхэлдээ өөрчлөлтөд орж байгаа тул уур амьсгал ерөнхийдөө дулаараад зогсохгүй түүний чийг дулааны горим, амь мандал дахь бодисын эргэлт, тэнцвэр, цаг агаарын үзэгдэл явцын горим, эрчим, ажиглагдах давтамжид гүнзгий өөрчлөлт орно. Энэ нь манай орны хувьд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл давамгайлж болзошгүй гэсэн үг юм. иймд нэг талаар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бий болох сөрөг





нөлөөллийг багасгах, бууруулах, уур амьсгалын системд гарах өөрчлөлтөд аж ахуйн үйл ажиллагааны техник технологи, эдийн засгийн бүтцээ зохицуулах асуудлыг хэр цаг алдалгүй, зүй зохистойгоор шийдвэрлэснээс ус орны тогтвортой хөгжлийн баталгаа ямар нэгэн байдлаар хангагдана. Өөрөөр хэлбэл хот суурин бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ багаль, нийгэм, эдийн засгийн салбар бүрт уур амьсгал өөрчлөлт хэрхэн нөлөлөөх, энэхүү өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох асуудлыг зайлшгүй тооцож шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Иймээс улс орны түүн дотроо хот суурин, бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалд уур амьсгалын систем түүнээс уламжлан байгаль экологийн тогтолцоонд гарах хувиралт өөрчлөлтийг тусгах нь зайлшгүй анхаарах асуудал болох талаар дараах байдлаар хандан тавьж байна.

**II.1.2 Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай.** Сүүлийн зуу гаруйхан жилийн дотор дэлхийн газар орчмын агаарын дундаж температур /цаашид дэлхийн дундаж температур гэнэ/  $0,6^{\circ}\text{C}$  орчмоор дулаарч далайн дундаж түвшин 15 см-ээр нэмэгджээ. Энэ дулааралт 1950-иад оноос хойш улам ч тод илэрч одоо цагт сүүлийн 1000 жилдээ хамгийн дулаан үе үргэлжилж байх юм. Үүнийг батлах нэг үзүүлэлт бол цаг уурын тогтмол ажиглалт хийж эхэлсэн 1961 оноос хойшхи хугацаанд ажиглагдсан хамгийн халуун байсан 9 жил нь 1990 оноос хойшхи хугацаанд ажиглагдсан явдал ажээ. (Climate Statement of 2001,WMO, 2002) Дулааралт бөмбөрцгийн хойд хагаст өмнөд хагасаас, дунд дээд өргөрөгт нам өргөргөөс жилийн хүйтэн хагаст дулаан улирлыг бодвол бүр ч эрчимтэй явагдаж байна. Дулааралтын улмаас өндөр уулын мөнх цас, хойд мөсөн далайн мөс хайлж, жараад оноос хойш цасан бүрхүүлийн талбай 10 хувиар хорогдож, гол мөрөн, нуурын мөсөн бүрхүүлтэй байдаг хугацаа 2 долл хоногоор багасч, ургамал ургалтын хугацаа сүүлийн 40 жилийн дотор 10 жил тутам 1-4 хоногоор уртасжээ. (Climate Change 2001,IPCC report) Хур тунадасны хэмжээ бөмбөрцгийн хойд хагасын дунд, дээд өргөрөгүүдийн ихэнх нутагт XX зууны туршид 10 жил тутам 0,5-1%-ийн хурдтай өсч байгаагийн дээр XX зууны 2 дугаар хагаст эрчимтэй хур тунадасны давтагдал өсч байна. Тропикийн бүсэд /хойд өмнөд өргөргийн  $10^{\circ}$ -ийн хооронд/ XX зуунд хур борооны хэмжээ арван жил тутамд 0,2-0,3 хувиар өссөн авч



сүүлийн хэдэн арван жилийн дотор энэ өсөлт бараг харагдахгүй байна. Бөмбөрцгийн хойд хагасын субтропикийн бүсэд /10-30<sup>0</sup>-ийн хооронд/ ХХ зууны туршид хур борооны хэмжээ арван жил тутам 3%-иар буурч байжээ. ХХ зууны хоёрдугаар хагаст эх газар дээр их хүйтэн үеийн давтагдал буурч, их халуун байх давтагдал өсч байна. Дэлхийн дулааралтын улмаас усны эргэлт идэвхжиж агаар мандлын гаралтай байгалийн гамшгийн давтагдал нэмэгдэж байна. 1950-иад оноос хойш Эль-Ниногийн үзэгдэл өмнөх 100 жилд үзэгдээгүй олон, илүү эрчимтэй ажиглагдах болов. Сүүлийн 50 жилд агаар мандлын гаралтай байгалийн томоохон гамшгийн давтагдал бараг 10 дахин нэмэгджээ. Дэлхийн дулааралт өмнөд хагасын далайн зарим бүс нутаг, Антарктидад бараг илрэхгүй байгаа ажээ.

**II.1.3 ХХI зууны уур амьсгалын өөрчлөлтийн хандлага.** Дэлхийн нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлтийг тооцсон байдлаас үндэслэн хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн хэмжээг тооцоолон гаргаж дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн 2100 онд хүртэлх үнэлгээг 1990-ээд оноос хойш 3 удаа нарийвчлан гаргаад байна. Хамгийн сүүлчийн /2001 он/ үнэлгээгээр дэлхийн дундаж температур 1990 оны байдлаас 2025 онд 0,4-1,1<sup>0</sup>С-ээр, 2050 онд 0,8-2,6<sup>0</sup>С-ээр, 2100 онд 1,4-5,8<sup>0</sup>С-ээр тус тус дулаарна гэж тооцоолжээ. Энэ нь ХХ зууны дулааралтын эрчмээс 3-10 дахин их байжээ. Дулааралтын улмаас дэлхийн далайн түвшний өсөлт ХХ зууныхаас 2,4 дахин их байна. Энэ бол сүүлчийн мөстлөгийн үеэс хойш гараагүй өөрчлөлт болно гэсэн үг. Бөмбөрцгийн хойд хагасын дунд, дээд өргөрөгт дулааралтын эрчим дэлхийн дунджаас 40% илүү байх ажээ. Эх газрууд халуун өдрийн тоо үргэлжлэн нэмэгдэж, хүйтэн өдрийн тоо буурхаар байна. Томоохон эх газруудын төв хэсгээр зуны гандуу байдал нэмэгдэх ба дунд, дээд өргөрөгүүдэд өвлийн хур тунадас нэмэгдэх нь байна. Дэлхийн усны эргэлт улм идэвхжиж дундад өргөрөгт хүчтэй шуурганы давтагдал нэмэгдэж болзошгүй байна. Хур тунадасны эрчим өсөн байна. Бөмбөрцгийн хойд хасагт цас мөсний талбай үргэлжлэн буурах хандлагатай болжээ.

Уур амьсгалын энэхүү өөрчлөлт нь дэлхийн экологийн тогтолцоонд дараах бодит нөлөөг үзүүлж болохыг эрдэмтэд тогтоосон байна. Үүнд:



XXI зуунд уур амьсгалын дулааралт дэлхийн ойн нөөцийн гуравны нэг орчимд хүчтэй нөлөөлж ойн төрөл зүйлд үндсэн өөрчлөлт гарахнээ. Судалгаагаар ургамлын янз бүрийн төрөл зүйл илүү тохиромжтой нутаг руу нэг жилд 0,04-2 км хүртэл зайд нүүн шилжих нь харагдаж байна гэжээ. Гэвч илүү хурдан (жилд 1,5-5,5 км хүртэл) нүүн шилжихийг шаардах нь байна. Гэтэл олон төрөл зүйлийн ургамал ийм хурдан нүүн шилжиж чадахгүй мөхөж болзошгүй байна.

Цаашид уур амьсгалын өөрчлөлтөд илүү өртөгдөх бүс нутаг, ялангуяа хойд өргөрөгийн ой зэрэг хуучин ургамлууд мөхөж, оронд нь хурдан ургадаг унаган биш ургамал ургах шаардлагатай байна.

Хогийн болон хортой ургамал, өвчин, хортны тархалт нэмэгдэж болзошгүй нь агаар мандалд нэмэгдсэн нүүрсхүчлийн хий нь олон ургамлын фотосинтезийн процессийн боломжийг нэмэгдүүлэх боловч экосистемийн бүрэлдэхүүнд үзүүлэх нийлбэр нөлөөлөл, ялангуяа агаарын өндөр температур эсвэл хөрсний чийгшлийн хязгаарлагдмал нөхцөлтэй хавсрахаараа ямар байх нь одоогоор бүрэн тодорхойгүй байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөгдөх экосистем нь хойд зүгийн хуурай буюу тундр зэрэг өндөр өргөрөгийн төрөл зүйлс, мөн бэлчээр ойтой хиллэж буй нутаг эсвэл ой альпийн ургамалд шилжиж байгаа тэр хэсэг зэрэг олон төрлийн ургамал холилдон орших систем байхнээ.

Эдгээр экосистемийн олонх нь хүний үйл ажиллагааны нөлөөнд нь эрт өртөж эхэлсэн бөгөөд ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эдгээрийн хэмжээ болон бүрэлдэхүүн нь мэдэгдэхүйц өөрчлөгдөх буюу багасч болзошгүй юм байна.

**II.1.4 Монгол орны уур амьсгалын өнөөгийн өөрчлөлт.** Монгол оронд цаг уурын байнгын ажиглалт хийж байгаа сүүлийн 60 гаруй жилийн хэмжилтийн мэдээнээс үзвэл нийт нутгийн жилийн дуундаж агаарын температур  $1,66^{\circ}\text{C}$  (1940-2002 оны хооронд) –аар, үүний дотор (43 дугаар зураг) өвлийн улиралд  $3,61^{\circ}\text{C}$ -аар, хавар намар  $1,4-1,5^{\circ}\text{C}$ -аар, зуны улиралд  $0,3^{\circ}\text{C}$ -аар дулаарсан байна. Өнөөдөр ийм үзүүлэлт хот суурин барилгажилтад нөлөөлж байна




Жилийн хүйтэн улирлын эрчимтэй дулааралт бүх нутгийг хамарч байгаа авч өндөр уулс, уулс хоорондын хотгорт өөрөөр хэлбэл хангай талдаа илүү эрчимтэй, говь, тал хээртээ сулхан, харин зуны сэрүүсэлт говь цөлийн бүсэд бараг илрэхгүй байгаа нь тогтоогджээ.

Их хүйтэн өдрийн тоо ( $-25^{\circ}\text{C}$ -аас хүйтэн) 1940 оноос хойш 10-15 өдрөөр цөөрсөн, газар тариалангийн төв бүсэд 7 дугаар сард сүүлийн 40 жилийн дотор  $30^{\circ}\text{C}$ -аас халуун өдрийн тоо 2,- өдрөөр нэмэгдсэн байна.

Сүүлийн 40 жилийн дотор газар тариалангийн төв бүсэд  $10^{\circ}\text{C}$ -аас дээш температурын нийлбэр  $17^{\circ}\text{C}$ -аар нэмэгдэв. Уур амьсгалын эл өөрчлөлт хөрс хөлдөх, гэсэх хугацаа тогтвортой цасан бүрхүүл ханзрах хугацаа, хөрсний гүний температур, гол мөрний мөсөн бүрхүүл байх хугацаа, мөсний зузаан гол мөрний урсацын улирлын доторхи хувиарлалт зэрэг олон үзэгдэлд илрэлээ олж байна.

Дулааралтын улмаас ургамал бүрхэвчийн ууршуулах чадвар (ууршиц) 7-12%-иар нэмэгдэв. Уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны хам нөлөөллийн улмаас байгалийн ихэнх бүсэд бэлчээрийн зун намрын их ургац 20-30%-иар буурч бэлчээрийн багтаамж бараг гуравны нэгээр буурсан байх юм. Булган аймгийн Орхон суманд зоо цаг уурын станц дээр 1980 оноос хойш

Орон сууц, олон нийт, иргэний барилгын төлөвлөлтөд мөрдөх уур амьсгалын бүсчилэл



43 дугаар зураг.



**Íðíí ñóóöны áàðèèäüí ò°è°äè°èòèéí óóð àìüñäèüí  
áçñ÷èýèèí çíäñýí ççççèýèòççä**

12 äóääàð хүснэгт

Óóð àìüñäèüí áçñ	Óóð àìüñäèüí äýä áçñ	Áçñççäèèí óóð àìüñäèüí çíäñýí ççççèýèò					Áçñççäèèí óóð àìüñäèüí òííòííü ççççèýèò						Áàðèèäüí áíñíí ääääðää äýýðò	Áàíòèçèèèèí ííòèíä	Íðíí ñóóö, íèíí íèèòèèéí áàðèèäüí ò°è°äè°èòèéí øääðäèäüä òíäíðòíèèíò äàèääèü, òää óóðüí ççççèýèòççä		
		1 áçäýð ñàðüí ääääðüíäíäèè òäííäðòò, °Ñ	°äèèéí 3 ñàðüí ñàèòèíü äííäèè òóðä, í/ñäè	7 äóääàð çàðüí äãààðын äííäèè òäííäðòò, °Ñ	Æèèèéí äííäèèè òäðüòäíäóé -èéä, %	Ó°ðñ°íä òýä äðäàðñ ýä÷-èò äçí, ñí	Ñàèòèíü øäðäò, èäí²	Äóèääí äèääèèò								Галлаганы хугацаа, (хоног)	Халаалтын улирлын хэм, хоног
								1 ñàðüí äóèäääí äóðääääè, °Ñ/í²	Ñóóäýð òäè, °Ñ/í²	Òäðäðäèèí çèè÷-èýè, °Ñ/í²	Ñàèòèíü çèè÷-èýè, °Ñ/í²	VII ñàðüí äóèäääíü èèççäýè °Ñ/í²					
I	I	-20-25	0.5-1.0	9-15	60-75	400	25-30	40-45	250-260	130	5	10-12	250-260	7500-9000	<25	1900-2200	<p>Öýääýä ò°ðñíèé òäðòäèò ò°äè°èòèéí 6-9 äàèè</p> <p>ðäýèæèèñýí òäðèð òçèòýí °ä°èòýè, ñýðççí ÷èèäèýä çíóäèè. Áàðèèäüä àèü äíèíòííð ò°äè°ðñíí ò°è°äè°èòèéí, äääðäð äííòòíè, òäííí äóèääí äèäääèèüä ñàéí òííòíè ò°è°äè°èò, íðòüä ò°äè°ðççèýèò äðää òýíäýý äääò</p>





ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТ

II	II a	19-36	0.8-1.5	15-18	59-71	350-400	30-40	40-50	200-265	150	6-10	16-21	230-250	6500-7500	25-50	2200-2300	Àèàà õïñà òàðòõàí ì°íõ òýààýàò ò°ðñ°íà èõ õýìæýýíèé õé õ°ðñíèé õéèðèýí ã¿í õ°èà°èòòýé, ì°ñæèèòòýé, ààçàð õ°äè°èòèéí 7-10 áàèè	Íýí ò¿èòýí °à°èòýé, ñýð¿¿ ÷èèäèýà çóíòàé. Ñàèòèíý òàìàààèàèòýà ñàéí õïñòíæ, ààðèèàýà ò°è°àè°òà°ò òàìààð àèààò áóèààíýà ñàéí õïñòíæ, °àèèéí ì°òò°èà ìàðíý òàèààèòýà èàýàðæ¿¿ýõ ò°è°àè°èò òèéõ
	II á	-25-27	0.7-1.6	18-19	65-70	300-350	25-30	40-45	220-250	135	5	13-16	210-230	6200-6500	50-75	2000-2200		
III	III a	-15-23	2.5-3.7	15-19	51-60	250-300	30-40	35-45	230-250	142	11-20	16-29	210-230	6200-6500	75-100	2200-2400	Óè õ°ðñíèé õéèðèýí õ°èà°èòòýé, ààçàð õ°äè°èòèéí 6-9 áàèè	°à°è òàààð íý ò¿èòýí, õóóðàé òàèóóí çóíòàé. Ààðèèàà ìàðíý òààèò ò°è°àè°æ áíèí. Õàøèààà á¿òýýòèéí õïñòíà ñàéí òèéæ, ààààðæóóèàèòýà ìíà÷-òíé õïñòíõ
	III á	-13-25	0.8-3.0	14-17	53-56	200-250	40-50	35-40	200-250	140	11-20	13-20	230-250	6000-6500	25-50	2300-2500		
IV	IV à	-15-20	0.5-1.5	19-24	55-65	200-300	50-60	35-40	170-200	146	4-10	24-26	195-200	4800-6200	<25	2500-2700	Óèèðèýí òàðòýàíàóé áààà õ°èà°èòòýé, ààçàð õ°äè°èòèéí 6-9 áàèè	Ç°è°àò°ð ò¿èòýí °à°èòýé, õýò òàèóóí õóóðàé çóíòàé, Ààðèèàýí ìàòàðèàèýí òàøèààà á¿òýýòèéí çóçààíýà òàìàèéí áààààð õïñòíõ, ààààðæóóèàèòýí áóèàíàèéí áíèí íýàò ñèñòàìòýé ò°è°àè°ò, ìàðíý òààèò ò°è°àè°ò àýðàòèèà õïñòíõ
	IV á	-17-25	2.0-5.3	18-21	54-64	190-250	50-60	40-45	200-250	147	20-28	16-22	210-230	5000-6200	100-150	2400-2600		
	IV ä	12-17	2.2-5.3	22-26	45-55	160-220	65-75	35-40	160-200	155	15-25	23-27	195-210	3760-5335	25-50	2500-2800		



хийсэн хэмжилтээр энэ нутагт бэлчээрийн ургац бараг 2 дахин буурч үүнийг дагаад хонь, ямаа, үхрийн амьдын жин ба ноос ноолуурын гарц буурах явц илэрхий ажиглагдаж байна.

Хуурайшилт нэмэгдэж, цөлжилт идэвхжиж байгаагийн бас нэг баримт бол шороо хийсдэг өдрийн тоо жараад оноос хойш нийт нутгаар 3-4 дахин ихэссэн явдал ажиглагджээ.

1940-2002 оны хооронд хамгийн дулаан байсан 10 жилийн 7 нь 1990 оноос хойш тохиолдсоны дотор 1998, 1997, 1999, 1995, 2002 онуудад хамгийн дулаахан байв. Мөн энэ хугацааны хамгийн дулаан 14 өвлийн 7 нь 1990 оноос хойш тохиолдсон бол хамгийн хүйтэн байсан 10 өвөл цөм 1976-1977 оноос өмнө тохиолджээ. Хамгийн халуун 11 зуны 5 нь 1991-2000 оны хооронд тохиолдов. Монгол орны хэмжээгээр дунджилсан жилийн нийлбэр хур тунадас сүүлийн 60 жилийн дотор ерөнхийдөө буурах хандлагатай байна.

Дөчөөд оны дунд үе, наяд он, хоёр мянгаад оны үед хур тунадас таруу, тавиад оноос жараад он гартал, ерээд оны үест хур бороорхуу, хамгийн хуртай 10 жил нь 1959, 1994, 1964, 1990, 1955, 1993, 1958, 1954, 1998, 1953 онд, хамгийн хуурай 10 жил нь 1944, 1942, 1978, 1980, 2000, 1972, 2001, 1965, 1941, 2002 онуудад тохиолдсон, 1944-1947, 1979-1983, 1999-2002 онуудад үргэлжилсэн хуурай үе тохиолдсоны хамгийн эрчимтэй хуурай үе нь 1999-2002 онд тохиолдсон байх юм. Модны цагирагийн жилийн өсөлтөөр өнөө үе бол сүүлийн 1700-гаад жилийн доторхи хамгийн дулаан үе юм. Үүнээс үзэхэд 2002 он бол 1940 оноос хойш манай төвийн бүсэнд тохиолдсон хамгийн хуурай жилийн нэг /1944/ оны гангийн дараа орох /байжээ.

**Монгол орны уур амьсгалын XXI зууны эхний хагасын өөрчлөлтийн төлөв.** Орчин үеийн шинжлэх ухааны үнэлгээгээр XXI зуунд уур амьсгалын дулааралт хугацаа хойшлох тутам улам эрчимжинэ. Монгол орны нутаг дэвсгэр дээр энэ зууны эхний 25 жилд жилийн дундаж температур 1,8-2,8<sup>0</sup>С-ээр, үүнээс өвлийн улиралд 1,4-3,6<sup>0</sup>С-ээр, зундаа 1,0-3,0<sup>0</sup>С-ээр дулаарах ба дараагийн 25 жилд дулааралтын эрчим бараг хоёр дахин нэмэгдэх төлөвтэй. Хур тунадасны



хэмжээ жилийн дүнгээр онц өөрчлөгдөхгүй (-4%-иас +8,1%) боловч өвлийн улиралд бараг 2 дахин ихсэх төлөвтэй. Зуны улирлын хур борооны хэмжээ 2025 оны түвшинд өөрчлөгдөхгүй атал (+4%) агаарын температур 2<sup>0</sup>С орчмоор нэмэгдэхэд ургамлын ууршицыг 100-110 мм-ээр нэмэгдүүлэх учир XXI зууны эхний 25-50 жилд Монгол нутагт хуурайшилт улам эрчимжинэ гэж үзэхэд хүргэж байна. Иймээс Монгол Улсын хот суурин байгуулалт, барилга байгууламж барихад уур амьсгалын энэ онцлогыг заавал тооцох учиртай.

## **ХОЁР. ХОТ, СУМ, СУУРИНГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЭКОЛОГИ ГАЗАР ЗҮЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНДЭСЛЭЛ**

**II.2.1 Судлагдсан байдал:** Монгол оронд хот, суурин байгуулалтанд нөлөөлөх байгаль-экологи, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлийг тооцох, үнэлэх талаар судлаачдын бүтээлд нэлээд өргөн хүрээтэй тусгагдсан байна. Нутаг дэвсгэр хот байгуулалтын шинжлэх ухааны үндсэн чиглэлийн хувьд Д.Майдар, (1971, 1972, 1983)-ын хотын инженерийн барилга байгууламжийн, С.Доржсүрэн (1975)-ийн бүтээлүүдэд хот суурин байгуулахад нутаг дэвсгэрийн нөлөөлөлд үнэлгээ өгөх асуудал нэлээд хөндөгдсний зэрэгцээ хот суурин байгууламжийн инженер-геологи, хөрс, цэвдэг, газар хөдлөл, геологийн тогтцын талаар олон тооны эрдэмтдийн бүтээлд тусгалаа олсон байна. Тухайлбал Э.М.Мурзаев. (1952, 1971), Ш.Цэгмид (1992, 1964, 1969), И.А.Маринова (1971), Б.Гунгаадаш (1985, 1986), С.Жигж (1979), Д.Доржготов нарын бүтээл нь Монголын байгалийн нөхцөл, нөөцийг үнэлэх ажилд чиглэгдэж байв. Эрдэмтэн Н.Лонжид, Д.Төмөрбаатар нар хот байгуулалтанд нөлөөлөх олон жилийн цэвдгийн нөлөөллийг авч үзэн Монгол нутаг дэвсгэрийг мужилжээ. Үүнд олон жилийн цэвдгийн 6 бүсийг тогтоосон нь шинжлэх ухаан, практикийн чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

Доктор Г.Намхайжанцан агаарын температурын алдагдлын мужлал, барилгажилтын норм, дүрмийг зохиож. Агаарын температурыг 4 район болгон хуваасан байна.



Харин 1994 онд Г.Намхайжанцын зохиосон БНБД-ийн уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт нь 350 гаруй хот сууринг хамарснаараа хот суурингийн ерөнхий төлөвлөгөө зохиох, бүс нутаг төлөвлөлт барилга, байгууламжийн зураг төсөл зохиоход энэхүү уур амьсгалын нөхцлийг хэрэглэх болсон нь нэлээд дэвшил болсон юм.

Мөн Зөвлөлин эрдэмтэн Т.В.Звонкова (1970), Н.Г.Герасимова (1952) нарын бүтээл Монгол орны хот суурин байгуулалтын байгалийн хүчин зүйлсийн салбарт ашиглагдаж байна.

Инженер И.Балжинням Хот байгуулалтанд зориулсан газар чичирхийллийн мужлалыг зохиосон. Тэр Монгол улс Төв Азийн чичирхийллийн хойд хэсэг Монгол-Байгалийн чичирхийллийн бүсэд хамрагддаг бөгөөд. Энэ бүс нь газар чичирхийллийн идэвхитэй бүс гэдгийг тогтоожээ.

Дээрхи эрдэмтний мужлалын зурагт газар чичирхийллийг нутаг дэвсгэрийн 5 бүлэгт хуваажээ. Үүнд: 5, 6, 7, 8, 9-ээс дээш шатлалын газар хөдлөл бүхий нутаг дэвсгэр гэж тодруулсан байна.

Ардын хувьсгалын дараа Шинжлэх ухааны хороо байгуулагдаж 1926-1940 онуудад физик газарзүйн мужлалын анхны бүдүүвч, газарзүйн атласууд зохиогджээ.

Эрдэмтэн Т.Хоролжав анх удаа хот байгуулалтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн үнэлгээг хийхдээ инженер геоморфологийн нөхцөл, инженер геологийн нөхцөл, геодинамикийн процесс, усан хангамжийн эх үүсвэр, уур амьсгалын хүчин зүйлүүд, ландшафт, ургамалжилтын нөхцөл, хот байгуулалтанд зориулсан байгалийн нөхцлийн зураглалуудад дүн шинжилгээ хийсэн байна.

Судалгааны үр дүнд манай орны нийт нутаг дэвсгэрийн 18,6 хувь мөнх цэвдгийн тархалтайг тогтоон, 56 хот сууринд дээрхи үнэлгээг өгсөн байна.

Судалгаагаар геодинамикийн процессын хувьд Монголын 2 хот 9 баллын бүсэд, 5 хот суурин 8 балл, 9 хот суурин 7 балл, үлдсэн хотууд нь чичирхийллийн 6 баллд хамрагдсан байна. Тэр хот болон хөдөөгийн суурингуудын хувьд 18.3 хувь



нь 9 баллын бүсэд, 26.6 хувь нь 8 баллд, 28.2 хувь нь 7 балл, 19.3 хувь нь 6 баллын бүсэд оршиж байна гэжээ.

Инженер геоморфологийн нөхцөлийг тооцохдоо гадаргын байдал, цас элсний хуралт, бичил рельефийн элементүүд, хэрчигдэл, рельефэд нөлөөлөх хүний үйл ажиллагаа зэргийг чухалчлан авч үзжээ. Мөн гулгас, намагшлын асуудалд анализ хийсэн бөгөөд нийт суурингуудын 22 буюу 7.9 хувь нь намагтай талбайд оршиж байна. Эдгээр суурингууд нь голын эрэг дээр эсвэл голын хөндийн байрласан байдаг байгааг тогтоожээ. Эрдэмтэн Т.Хоролжав хот суурингуудын усан хангамжийн эх үүсвэрийг 3 групп болгон хуваажээ. Үүнд:

1. Усан хангамжийн эх үүсвэртэй суурингууд,
2. Усан хангамжийн эх үүсвэр тодорхойгүй суурингууд
  - а/ Усан хангамжийн эх үүсвэртэй ч цэвэршүүлэх шаардлагатай
  - б/ Усан хангамжийн эх үүсвэр тодорхойгүй. Усны эх үүсвэрийг нээх, эсвэл уурхайн худаг гаргах шаардлагатай суурингууд.
3. Усан хангамжийн эх үүсвэртэй суурингууд: Нийт 26 суурин буюу өөрөөр хэлбэл нийт суурингийн 11.4 хувь энд хамрагдсан байна.

Доктор, архитектор Д.Сарантуяа “Монголын онцлог хүчин зүйлсийг харгалзан зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хот, хөдөөгийн суурьшлын төлөвлөлтийг боловсронгуй болгох нь” сэдэвт бүтээлдээ зах зээлд шилжих үеийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн явцад хүн амын суурьшлын экологи, тогтвортой хөгжлийг зарчмын шүтэлцээтэй уялдаж, нутаг дэвсгэрт, зохион байгуулалт, хот байгуулалтын гүйцэтгэх үүргийг үндсээр нь өөрчлөх шаардлагатай болсон нөхцлийг тогтоосон байна.

**Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн үнэлгээний чиглэлээр** ЗХУ-ын (хуучин нэрээр) эрдэмтэн, зөвлөлтийн эдийн засгийн газарзүйг үндэслэгч Н.Н.Баранский хот суурин газрыг хотын үүссэн үе, эдийн засгийн газарзүйн байрлал, хотын гүйцэтгэж байгаа үүрэг (функц), хотын хэм хэмжээ (хүн амын тоо,





нутаг дэвсгэрээр), хотын нөлөөллийн хүрээ тархаж буй таталцааны бүс гэсэн 5 хэв шинжээр ангилжээ.

Эрдэмтэн М.Баянтөр “БНМАУ-ын хот суурингийн газарзүй” бүтээлдээ хот, хот маягийн суурингийн ангиллыг тогтоожээ. Тэрээр уг бүтээлдээ хотуудын түүхчилсэн судалгааг хийж, тус улсын хот суурингийн хөгжилд тодорхойлолт өгч, хот суурингийн хэм хэмжээний ангилал, хот суурингийн газарзүйн байрлалын ангилал, хот суурингийн үүргийн бүтэц хэв шинжийн ангилал, хот суурингийн үүсэл хувьсалын ангилал зэргийг тогтоосон байна. Мөн хот суурингийн хэм хэмжээ ба хотуудын нутаг дэвсгэрийн ялгаврыг тодруулсан байна.

Эрдэмтэд Т.Сандагдорж Монгол орны төв хэсэг (1955), Д.Баасанжав Дорнод муж (1958), Б.Гунгаадаш Хангайн мужийн эдийн засгийн газарзүйн цогцолбор тодорхойлолтуудад хот суурингийн хөгжил, хүн ам зүйн талаархи судалгаанууд хийжээ. Эрдэмтэн Б.Гунгаадаш манай орны улсын хотыг 5, хот маягийн сууринг 2 бүлэг болгон ангилах саналыг дэвшүүлсэн байна.

Мөн Б.Гунгаадашийн “БНМАУ-ын эдийн засгийн газарзүй” (1963) “БНМАУ-ын хүн ам” зэрэг бүтээлд хот суурин газрууд ба түүний хүн амын өсөлт зэрэг зарим чухал мэдээлэл нэлээд дэлгэрэнгүй тусгагджээ.

Монголын хот суурингийн тухай системтэй судалгаа 1921 оны Ардын хувьсгалын дараа явагдаж эхэлсэн юм. Энэ жилүүдэд эрдэмтэн М.Баянтөр ЗХУ (хуучин нэрээ)-ын эрдэмтдийн хамт өөрийн орны хөгжлийн тухайн цаг үед зохицуулан БНМАУ-ын хот суурин газруудыг, 1. Хотын хэм хэмжээ буюу хүн амын тоогоор, 2. Хотын эдийн засгийн газарзүйн байрлалын онцлогоор, 3. Улс орны хэмжээнд хотын гүйцэтгэж байгаа үүргийн хэв шинжээр, 4. Хотын үүсэл, хувьсгалын үндсэн үеэр тус тус ангилсан байна.

Доктор Д.Майдар “Хувьсгалын өмнөх суурин газрууд, түүний дотор хотын байршил, эрт дээр үеэс эдүгээ хүртэлх Монголын архитектур болон хот байгуулалтын олон зуун жилийн түүх, түүний өвөрмөц онцлог”-ийг тодорхойлсон томоохон бүтээл нийтлүүлсэн юм.



Дэд бүтцийн хөгжлийн яамнаас боловсруулсан Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөл, түүний хүрээнд хийгдсэн Өрнөд, Төв, Дорнод, Завхан-Хөвсгөлийн бүс нутгийг хөгжүүлэх төслүүд нь тодорхой бүтээлүүд болсон юм. Эрдэмтэн Л.Цэдэндамба хэд хэдэн орны бүсчлэл тогтоодог аргачлалыг ашиглан өөрийн орны бүсчлэлийг боловсруулсан юм. Тэрээр:

- Тухайн бүсэд хамаарагдаж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн (манай нөхцөлд аймаг, хот, сум) бүх талын хамтын ажиллагааг харьцангуй бага зардлаар богино хугацаанд хөгжүүлэх орон зайн (бүс нутаг) таатай орчинг бүрдүүлэх,

- Нэгэнт бий болгосон эдийн засаг, нийгмийн хөгжлийн чадавхи, дэд бүтцийн сүлжээг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хөгжлийг түргэтгэх үүднээс хэрхэн оновчтой ашиглах,

- Хэт төвлөрлийг сааруулж зарим хотуудын ачааллыг багасаж экологийн асуудлыг шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх,

- Хотуудын гадаад хамтын ажиллагааг цаашид өргөтгөх таатай нөхцөлийг бий болгох асуудлуудыг тус тус хөндөж тавьжээ.

**II.2.2 Хангайн бүсийн хот суурины экологи газарзүйн нөлөөлөл агаарын бохирдолт.** Монгол орны байгалийн бохирдлын өнөөгийн төлөв байдлыг үнэлж дүгнэх зорилгоор техноген нөлөөлөл хамгийн хүчтэй илэрсэн, орчны бохирдлын хянах ажиглалт судалгаа харьцангуй тогтворжсон Хангайн бүсийн томоохон хот суурингуудын орчмын агаар, ус хөрс гэсэн 3 орчны бохирдолттой холбогдох материалуудад дүн шинжилгээ хийлээ. Агаарын бохирдлын хорт хийн, тоосжилтын радиацын, биологийн, шуугианы зэрэг олон хэлбэрүүд дотроос Хангайн бүсийн Эрдэнэт, Дархан хотын агаарын азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), хүхэрлэг хий, тоосжилт зэрэг бохирдуулагч бодисуудад хяналт явуулжээ. Эдгээр хотын агаар дахь бохирдуулагчийн агууламж, түүний олон жилийн болон жил, улирал, сар, хоногийн горим, өөрчлөлтийг тодорхойлж, хоногийн дундаж болон нэг удаагийн зөвшөөрөгдөх хамгийн их агууламжтай жишсэн байна. Ер нь азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), тоос болон угаарын хийн нэг удаагийн ба



хоногийн хамгийн их агууламжийн зөвшөөрөгдөх хэмжээг 13-дугаар хүснэгтэд үзүүлэв.

**Том хотын агаар дахь зарим бохирдуулагч бодисын  
зөвшөөрөгдөх агууламж**

13 дугаар хүснэгт

д/д	Бохирдуулах бодис	Нэг удаагийн хамгийн зөвөөшөрхүйц агууламж	Хоногийн дундаж зөвшөөрөхүйц агууламж (мг/м)
1	Азотын давхар исэл ( $\text{NO}_2$ )	0.085	0.040
2	Хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )	0.5	0.05
3	Тоос	0.5	0.15
4	Угаарын хий	5.0	3.0

Энэ зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулахад Эрдэнэт хотын хувьд агаар дахь бохирдуулах бодис нэг удаагийн агуулалтаас давж бохирдох тохиолдол ажиглагдаагүй байна. Энэ судалгааг агаарын бохирдолт эрс ихэсдэг өвлийн улиралд онцлогийг харгалзан агаар дахь бохирдуулах бодисын өвлийн улирлын дундаж агууламжийг 14-дүгээр хүснэгтээр бохирдсон агаарын зөөгдлийн утгыг 14-дүгээр хүснэгтээр тус тус тодорхойлжээ. Судалгаанаас харахад агаар дахь хүхэрлэг хийн агууламж Дархан хотод  $\text{NO}_2$ -ийн агууламж Эрдэнэт хотод, тоосжилт харьцангуй их байна. Дээрхи байдал нь агаар дахь бохирдуулах (44 дүгээр зураг) агууламж тухайн хот суурины үйлдвэржилтийн онцлог, үйлдвэрлэлийн бүтэц, цаг уурын нөхцөлтэй (15 дугаар хүснэгт) шууд холбоотойг харуулж байна.


**Хангайн бүсийн Эрдэнэт Дархан хотын агаар дахь бохирдуулах бодисын  
өвлийн дундаж агууламж**

14 дүгээр хүснэгт

Хот суурин	$\text{SO}_2$	$\text{NO}_2$	$\text{CO}_2$	Тоос
	мкг/м	мг/м	мг/м	мкг/м
Дархан	17	28	-	-
Эрдэнэт	7	47	1.05	50



Эдгээр хотуудын агаар дахь  $SO_2$ ,  $NO_2$ -ын хэмжээнээс үзвэл агаарын бохирдлын түвшин ерөнхийдөө өөр хоорондоо ойролцоо бөгөөд хүлцэх хэмжээнээс доогуур байна.



44 дүгээр зураг

**Хангайн бүсийн хот суурины агаарын зөөгдлийн чиглэл ба үнэмлэхүй утга**

15 дугаар хүснэгт

Д/д	Станцуудын нэр	Чиглэл (сая м <sup>2</sup> )								Нийт (сая м <sup>2</sup> )
		Б	БХ	Х	ЗХ	З	ЗӨ	Ө	БӨ	
0	А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Арвайхээр	19	48	31	9	1	12	13	18	146
2	Байтаг	52	31	1	1	9	4	1	3	102
3	Баянхонгор	7	23	10	27	3	3	3	3	79
4	Булган	4	40	14	4	3	7	2	1	75
5	Галуут	11	21	25	7	2		5	6	78
6	Мөрөн	25	14	3	8	20	3	1	1	75
7	Өндөрхаан	10	13	23	23	3	2	7	33	114
8	Цэцэрлэг	52	38	7	1	6	5	1	12	84



Судалгаагаар агаарыг бохирдуулах бодис  $\text{NO}_2$ ,  $\text{SO}_2$ ,  $\text{CO}_2$ , тоосны хэмжээ Улаанбаатар хотод жилээс жилд ихсэж байна. Харин Эрдэнэт хотод  $\text{NO}_2$ -ын хэмжээ харьцангуй тогтвортой гэж үзэж болно. Гэхдээ хүн ам нягт суурьшсан аж үйлдвэрийн газрууд төвлөрсөн Эрдэнэт, Дархан, Мөрөн зэрэг хотын агаар дахь бохирдуулах бодис нь нэг удаагийн зөвшөөрөгдөх агууламжаас давж бохирдох явдал хэд хэдэн удаа ажиглагдаж байжээ.

Энэ хүснэгтээс харахад агаар дахь хүхэрлэг хийн агууламж Дархан, Эрдэнэт хотуудад,  $\text{NO}_2$ - болон  $\text{CO}_2$ -ийн агууламж Эрдэнэт хотод тоосжилт мөн Эрдэнэт хотод харьцангуй их байна.

Агаарын хийн үндсэн бүрэлдэхүүнд ордоггүй хатуу шингэн эгэл бие, тоосонцор, агаар мандалд орж тархсаныг агаарын бохирдол гэдэг байна. Тухайлбал: байгалийн дотоод хувирал (хүчтэй шороон шуурга, галт уулсын дэлбэрэлт, газар хөдлөл, ган салхигүй байх гэх мэт)-ын дүнд агаар бохирдохыг хотын агаарын байгалийн бохирдол гэдэг. Харин хүний үйл ажиллагааны нөлөөгөөр (эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, авто тээвэр, барилгын гэх мэт) бохирдохыг хүний үйл ажиллагааны буюу антропоген бохирдолт гэдэг. Агаарын физик химийн шинж өөрчлөгдсөнөөс хотын иргэдийн биеийн эрүүл мэнд, ажиллах чадвар, урт удаан наслахад эсрэг үйлчилж байх төдийгүй зарим өвчний нян тархах нөхцөл бүрэлддэг ажээ.

Агаарын бохирдолтыг дэлхий дахины болон орон нутгийн чанартай гэж ангилдаг. Үүнд:

- Хүний болон байгалийн үйл ажиллагаанаас үүссэн хорт хий, эгэл хэсгүүд нь тодорхой газар нутгийн агаар орчинд тархсаныг орон нутгийн агаарын бохирдол гэдэг.
- Агаар мандлын дээд давхаргын (тухайлбал давхраат мандлын) агаарт тархсан эгэл хэсэг тоосонцор нь агаар мандлын орчил урсгалаар бүхэлдээ тив дэлхий дайжин тархахыг бөмбөрцгийн буюу дэлхий дахин агаарын бохирдол гэдэг ажээ.






Агаар мандлын бохирдлын байгалийн потенциал гэж байдаг ажээ. Энэ нь агаарын бохирдлоос цэвэршүүлэх чадварыг тодорхойлж байгаа байгалийн процессуудын цогцос юм байна. Эдгээр процессууд нь агаарын бохирдлыг ихэсгэх эсвэл багасгах зэрэг харилцан адилгүй үйлчилгээ үзүүлж байдаг байна.

Судалгаагаар эерэг, сөрөг 2 зүйлсийн үйлчлэлийг тус бүрээр нь Хангайн бүсийн нутаг дэвсгэрийн хүрээлэлд ландшафт, физик газарзүйн шинж чанараар нь ялган гаргаж дүгнэсэн.


Ер нь агаарын орчин нь техноген бохирдолтонд хамгийн түрүүн өртөж ус, хөрс бусад орчны бохирдолтонд нөлөөлдөг учир агаарын бохирдлын байгалийн потенциал нь байгалийн бохирдлын цогцолбор потенциалын бүрэлдэхүүн хэсэг болдог байна. Ийм ч учраас агаарын бохирдлын байгалийн потенциалын судалгааны техноген бохирдлоос урьдчилан сэргийлэх газарзүйн чухал үндэслэл хэмээн сонгон авсан юм.

Хангайн бүсэд нөлөөлөх нутаг дэвсгэрийг хамруулан Хангайн бүсийг агаарын бохирдлоор нь нутаг дэвсгэрийн 5 бүлэг болгож ангилан газрын хэрчигдлийн шигүү бөгөөд хамгийн их хэрчигдэлтэй (45 дугаар зураг) (1000 м-ээс багаг) мужуудыг нь бохирдох онцгой аюултай, хамгийн бага хэрчигдэлтэй (4000 м-ээс дээш) мужуудыг бохирдох аюул багатай хэмээн нийт 5 бүлэг болгон үзэж. (46 дугаар зураг).

Хангайн бүсийн бохирдлын шинж чанарыг нь тус бүрд нь тодорхойлж үзүүлснийг 15 дугаар хүснэгтээр үзүүллээ. Үүнд: 1. Онц аюултай буюу агаарын цэвэрших (16 дугаар хүснэгт) чадавхи маш сул, а. Их нууруудын хотгор, б. Баруун хуурайн хотгор 2. Их аюултай буюу агаарын цэвэрших чадавхи сул, а. Монгол Алтай, б. Говийн Алтай, в. Хөвсгөлийн нутаг дэвсгэр.



45 дугаар зураг



46 дугаар зураг



**Хангайн бүсийн агаарын цэвэрших чадавхин үнэлгээ, бүсчлэл**

16 дугаар хүснэгт

		Агаарын бохирдлыг багасгагч хүчин зүйл						Агаарын бохирдлыг ихэсгэгч хүчин зүйл		
Физик газар зүйн мужийн нэр	Ландшацтын муж, дэд мужийн нэр	Агаарын зөөгдөл	Хур тунадас	Нийлбэр цацраг	Аянгатай өдрийн тоо	Жилийн агаарын дундаж $t^0$	Гадаргын хэрчигдлийн шигүү	Шороон шуургатай өдрийн тоо	Хүчтэй салхитай өдрийн тоо	Гангийн давтагдал
Монгол Алтай	Монгол Алтайн төв хэсгийн уулын нугын дэд муж	50-90	400-500	1200-с доош	15-25	-2 - /-6/	500-1000	10-с доош	10-с доош	20-25
	Монгол Алтайн зүүн хэсэг	50-90	250-300	1200-1300	5-15	0-/-2/	500-1000	10-20	10-20	25-30
	Монгол Алтайн өмнөд хэсэг	50-90	300-400	1300-1500	5-15	-2 /-4/	500-1000	10-30	10-20	30-35
Говийн Алтайн их муж	Говь-Алтайн баруун хэсэг	50-90	150-250	1300-1500	5-15	-2 - 0	500-1000	10-30	10-30	30-35
	Говь-Алтайн зүүн хэсэг, заримдаг цөлийн муж	50-90	100-200	1300-1400	5-15	-2 - /+2/	1000-2000	20-40	20-40	25-30



ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТ

	Хангайн уулт өндөрлөгийн зүүн хэсэг умард хуурай хээрийн дэд муж	50-90	200-400	1300-1400	15-25	-2 - /-4/	1000-2000	10-с доош 20 хүртэл	10-с доош 20 хүртэл	25-30
	Хангайн өмнөд бэгэлцэг, цөлжүү хээрийн дэд муж	50-90	150-250	1400-1500	15-25	0 - /-2/	3000-4000	10-20	10-30	20-30
Орхон Сэлэнгийн сав нутаг	Сэлэнгэ мөрний ойт хээрийн дэд муж	50-90	150-250	1400-1500	15-25	0 - /-2/	3000-4000	10-20	10-30	20-30
	Орхон туулын сав газрын хуурай хээрийн дэд мужж	50-90	300-500	1300-1000-с доош	5-15	0	500-1000	10-с доош 20 хүртэл	10-с доош	20-25
Хөвсгөл уулсын их муж	Хөвсгөл нуурын баруун тал ян сарьдагийн дэд муж	50-90	400-500-с дээш	1200-с доош	25-с их	-8 - /-6/	500-с доош	Шороон шуурга ажиглагда агүй нутаг 10-с доош	10-с доош	20-с доош



ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТ

	Сенгелийн хөмбөн цулдам уулын ар хажуугийн дэд муж	50-90	300-500	1200-с доош	25-с их	-4 - /-2/	500-1000	10-с доош	10-с доош	20-с доош
Хангайн уулархаг орон	Хан хөхийн уулын ар хажуугийн ойн дэд муж	50-90	150-300	1300-1500	5-25	-4 – 0	1000-2000	10-с доош 20 хүртэл	10-с доош 20 хүртэл	20-с бага 20-25
	Хангайн уулын баруун тал, ар хажуугийн ойн дэд муж	50-90	200-400	1400-1500	15-25	-4 – 0	500-1000	10-20	10-20	20-25
	Тэс, Дэлгэр мөрний сав умард хуурай хээр, ойн дэд муж	50-90	250-500	1300-1200-с доош	15-25	-4 - /-6/	500-с дээш	10-с доош	10-с доош	20-с бага
	Хангайн уулсын уулт өндөрлөгийн хойд талын тайгийн дэд муж	50-90	400-500	1200-1400	25-с их	0 - /-4/	500-1000	10-с доош шороон шуурга ажиглагддаггүй	10-с доош	25-30





ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТ

	Хангайн уулын төв хэсэг ян сарьдагийн дэд муж	50-90	400-500	1500-1200-с доош	25-с их	-8 - /-6/	500-1000	10-с доош шороон шуурга ажиглагдаггүй	10-с доош	20-с бага
Талын халхын тал их нууруудын хөндий	Монголын төв хэсгийн суурьт өндөрлөг тал, хуурай хээрийн цөлжүү хээрийн дэд муж	170-с их	150-250	1400-1500	5-15	0-2	2000-3000	20-30	50-с дээш	30-35
	Говийн хойт хэсгийн суурьт өндөрлөг тал умард цөлийн дэд муж	170-с их	50-150	1500-с дээш	15-25	-0 /-2/	2000-3000	10-20	10-30	35-с дээш
	Бөөн цагаан Орог нуурын хотгор заримдаг цөлийн муж	90-130	100-250	1400-1500	5-15	-2 - /4/	1000-2000	10-30	20-40	35-с дээш



3. Дунд зэргийн аюултай буюу агаарын цэвэрших чадавхи сулавтар, а. Алтайн өвөр говь, 4. Аюултай буюу агаарын цэвэрших чадавхи сулавтараас дунд зэрэг, а. Орхон-Сэлэнгийн сав газар, 5. Аюул багатай буюу агаарын цэвэрших чадавхи дунд зэрэг, а. Төв халхын тал, б. Нууруудын хөндий. Энэхүү муж тус бүрийг товч тодорхойлбол :

**Нэг.** Гадаргын хэрчигдлийн шигүү, хүчтэй салхитай өдрийн тоо, нийлбэр цацраг зэргээс бусад хүчин зүйлүүд нь агаарын бохирдлын байгалийн онцгой аюултай нөхцөл бүрдүүлж байна. Түүнийн зэрэгцээ инверсийн эрчим асар ихтэй, эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн, өвлийн цагт антициклон ноёрхдогтой холбоотой байдаг. Эдгээр нутгийн агаарын цэвэрших чадавхи маш сул байдаг байна.

**Хоёр.** Энэ мужид агаарын цэвэрших чадавхид нөлөөлөгч гол хүчин зүйлс, түүнчлэн хур тунадас, хүчтэй ба шороон шуурганы бусад нэмэлт хүчин зүйлүүдийн утга нь техноген нөлөөлөлд агаар бохирдох ихээхэн аюултай нөхцөл бүрдүүлж байна. Мөн хүйтний төдийгүй дулааны улиралд ч инверсийн нөлөө илэрдэг байна.

**Гурав.** Агаарын цэвэрших чадавхийн сулавтар чадавхитай их мужид нөлөөлөгч гол хүчин зүйлс болон нийлбэр цацраг, жилийн дундаж температур зэрэг бусад хүчин зүйлс техноген нөлөөлөлд агаар хамгийн бага бохирдох нөхцөл бүрдүүлэх боловч хур тунадас хамгийн бага, ган болон хүчтэй шороон шуурганы давтагдал эрс их байдаг нь агаарын бохирдлын шинж их болохыг үзүүлж байгаа ажээ.

**Дөрөв.** Аюултай буюу агаарын цэвэрших чадавхи сулавтараас дунд зэрэг гэсэн ангилалд Орхон-Сэлэнгийн сав нутаг хамрагдаж байна.

**Тав.** Агаарын цэвэрших чадавхийн аюул багатай потенциал бүхий энэ мужид гол хүчин зүйлсийн хамгийн бага, бохирдох нөхцөл бүрэлдэх ба бусад хүчин зүйлс нь дундаж шинжтэй хур тунадас бага, гангийн болон экстерменал шинжтэй салхины давтагдал харьцангуй ихээр ялгагддаг байна.



**II.2.3 Хангайн бүс нутгийн гадаргын ус гол мөрний цэвэрших чадавхийн үнэлгээ:** Хангайн бүсийн гадаргын ус гол мөрдийн цэвэрших чадавхид нөлөөлөх гол хүчин зүйлс болох голын усны сүлжээний нягтшил, гол мөрний (47, 48 дугаар зураг) нийлбэр урсан, газар нутгийн нийт чийгшил зэрэг үзүүлэлтүүдийг авч үзэхэд гадаргын усны цэвэршүүлэх чадавхи харьцангуй өндөр, сулавтараас дунд зэрэг, (17 дугаар хүснэгт) сул, сулаас маш сул, маш сул гэсэн ангилал гарч байна. Харьцангуй өндөр чадавхитай гэсэн ангилалд голын сүлжээний нягтшил 0.05-0.10 км<sup>2</sup>, гол мөрний нийлбэр урсац 5-25мм, газрын доорхи урсац нь 5-10мм, газар нутгийн нийт чийгшил 200-250 мм байна. Энд ландшафтын мужлалаар Хангайн бүсэд нөлөөлөх Орхон Сэлэнгийн сав, Говь-Алтайн уулс, Хангайн бүсийн гол нуурууд хамрагдаж байна. Гадаргын усны цэвэрших чадавхид өндөр гэсэн ангилалд голын сүлжээний нягтшил 0.15-0.25 км/км<sup>2</sup>, гол мөрний нийлбэр урсац 50-100 мм, газрын доорхи урсац 5-10 мм, газар нутгийн нийт чийгшил 50-100 мм байгаа ба энэ ангилалд ландшафтын мужлалаар Хангайн бүс нутагт хамааралтай Монгол Алтайн нол нуруу, түүний салбар уулс, Хангайн нуруу, Ханхөхий нуруу түүний дундаж уулс, Хөвсгөлийн уулс, хамрагдаж байна. Гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх чадавхиар сул гэсэн ангилалд голын усны сүлжээний нягтшил 0.01-0.05, гол мөрний нийлбэр урсац 5 мм-ээс доош, газрын доорхи урсац 0-5 мм, газар нутгийн нийт чийгшил 100-150 мм зэрэг үзүүлэлтээр нууруудын хөндий, сулаас маш сул ангилалд Хангайн бүсийн нутагт нөлөөлөх Төв Монголын тал, Маш сул гэсэн ангилалд Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор тус тус орж байна.








ХАНГАЙН БҮСИЙН УСНЫ САВ ГАЗАР

M1:4500000







**Хангайн бүсийн гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх үнэлгээ, бүсчлэл**

17 дугаар хүснэгт

Ландшафтын муж, дэд муж	Голын сүлжээний нягтшил /км/км <sup>2</sup> /	Гол мөрний нилбэр урсац /мм/	Газрын доорхи урсац /мм/	Газар нутгийн нийт чийгшил /мм/	Гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
<b>1. Орхон-Сэлэнгэ</b>					Харьцангуй өндөр
1.1 Орхон Туул	0.05-0.10	5-25	5-10	200-500	Харьцангуй өндөр
1.2 Орхон-Сэлэнгийн	0.10-0.15	5-25	10-25	200-250	Харьцангуй өндөр
1.3 Дундаж уулс	0.15-0.20	25-50	10-25	200 хүртэл	Өндөр
<b>2. Монгол –Алтай</b>					Харьцангуй өндөр
2.1 Салбар уулс	0.15-0.25	50-100	5-10	50-100	Харьцангуй өндөр
2.2 Гол нуруу	0.25-0.35	100-300	10-25	50-100	Өндөр
<b>3. Говь-Алтай</b>					Дунд зэрэг
3.1 Салбар уулс	0.05-0.10	25-50	5-10	100 хүртэл	Сулавтар
3.2 Гол нуруу	0.01-0.05	50-100	10	100 хүртэл	Дунд
<b>4. Хангай</b>					Өндөр
4.1 Салбар уулс	0.05-0.15	50-100	5-10	100 хүртэл	Харьцангуй өндөр
4.2 Дундаж уулс	0.20-0.35	100-200	10-25	100-200	Өндөр
4.3 Өндөр уулс	0.35-аас дээш	300-аас дээш	25-аас дээш	200-250	Маш өндөр
<b>5. Хөвсгөл</b>					Өндөр
5.1 Бэсрэг уулс	0.15-0.30	100-200	10-25	200 хүртэл	Өндөр
5.2 Өндөр уулс	0.20-0.35	300-аас дээш	25-аас дээш	100-200	Өндөр
<b>6. Төв Монголын тал</b>					Сул
6.1 Умард хээр	0.10-0.15	5 хүртэл	0-5	150-200	Сул
6.2 Өмнөд хээр	0.01-0.5	5	5 хүртэл	100-150	Маш сул
6.3 Заримдаг цөл	0.01-ээс доош	5-аас доош	5 хүртэл	50-100	Маш сул
<b>7. Нууруудын хөндий</b>					Сул
7.1 Нууруудын хөндий	0.01-0.05	5-аас доош	0-5	100-15	Сул
<b>8. Алтайн өвөр говь</b>					Маш сул
8.1 Баруун хуурай	0.01-ээс доош	5-аас доош	0-5	100 хүртэл	Маш сул
8.2 Өмнө говь	0.01-ээс доош	5-аас доош	5-аас доош	100-150	Маш сул
<b>9. Их нууруудын хотгор</b>					Сул
9.1 Их нууруудын хотгор	0.01-0.05	5 хүртэл	5 хүртэл	50-100	Сул



Гадаргын усны эрдэсжилттэй шууд хамааралтайгаар усны хатуулаг чанар өөрчлөгдөх тул Хангайн бүсийн усны бохирдлыг дараахи байдлаар ангилж байна. Үүнд:

-Ахуйн болон үйлдвэрийн бохир усыг цэвэрлэхгүй хаях.

-Цэвэрлэх байгууламжуудын эвдрэл, гэмтэл, технологийн горим зөрчсөнөөс бохир усыг шаардлагын түвшинд хүртэл цэвэрлэж чадахгүй байх,

-Усан хангамжийн эх булгийн хамгаалалтын бүсийн дүрэм зөрчих,

-Хуурай хог хаягдлыг заасан цэгт хаяхгүй, химийн хорт бодис, бордоог технологийн дагуу хэрэглэхгүй байх,

Гол мөрөн нуурын усанд аж үйлдвэр, хотын аж ахуйн бохир ус, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын угаагдал, цэвэрлээгүй ба дутуу цэвэрлэсэн хаягдал ус, хог хаягдал орж усны чанарыг доройтуулдаг ажээ.

Байгаль орчны шинжилгээний төв лаборатори гадаргын усны чанарыг хянах харуулуудыг усны объектын том жижиг, аж ахуйн ач холбогдол, хүний үйл ажиллагааны нөлөөлөлд хир автсан зэрэг хүчин зүйлүүдийг үндэслэн 1-3 зэрэглэлд хамааруулж тусгай хөтөлбөрөөр усны сорьц авч, 30 гаруй үзүүлэлтээр усны чанар, найрлагыг тогтмол тодорхойлж байна. Жишээлбэл: Эрдэнэт хотод 2 үндсэн харуул байнга ажилладаг байна. Үүнд: физик шинж чанар, температур, хөвүүр бодис, ууссан хийнүүд, давсны ионууд болон зарим микроэлементүүд багтаж байна.

Хангайн бүсэд нөлөөлөх зарим гол мөрний усны 1988-1994 оны химийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд Хангайн бүсийн томоохон хот орчмоор дайран (18 дугаар хүснэгт) өнгөрөх голуудын бохирдол их байгаа нь тодорхой байна.

Усны бохирдлын үзүүлэлтийн өөрчлөлтийн судалгаагаар фосфор, маргенц, амоны азот химийн бодисуудын хэмжээ хот орчимд жилээс жилд нэмэгдэх



хандлагатай, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч ихээхэн хэлбэлзэлтэй байдаг байна.

### Хангайн бүсэд нөлөөлөх зарим голын усны бохирдол

18 дугаар хүснэгт

Голын нэр	Бохирдлын индекс	Он					
		1988	1989	1990	1991	1992	1993
Сэлэнгэ Сүхбаатар	P	0.039	0.046	0.022	0.032	0.047	0.053
	БХХ	1.2	3.3	1.8	1.7	2.2	2.3
	Mn	0.41	0.42	0.30	0.09	0.24	0.08
	NH <sub>4</sub>	-	0.12	0.25	0.22	0.27	0.29
Орхон Сүхбаатар	P	0.058	0.069	0.035	0.048	0.64	0.078
	БХХ	1.3	3.2	3.0	1.9	23.8	2.7
	Mn	0.15	0.17	0.18	0.06	0.18	0.12
	NH <sub>4</sub>	0.22	0.322	0.56	0.36	0.32	0.43
Хангал Эрдэнэт	P	0.216	0.280	0.195	0.230	-	-
	БХХ	-	3.7	3.7	4.5	-	-
	Mn	0.21	-	-	-	0.06	0.09
	NH <sub>4</sub>	1.26	0.64	3.57	1.07	1.92	0.40

Усны бохирдлын индексийг (O<sub>2</sub>, БХХ, NH<sub>4</sub>, NO<sub>2</sub>) зэрэг үзүүлэлтээр нийт харуулуудаар бодож усны чанарын зэргийн тогтоож, 6 ангиллаар үнэлгээ өгснөөс үзвэл Хангайн бүсэд нөлөөтэй Хангал, Эрдэнэт орчимд ус “бохирдолттой” (IV зэрэг), энэ нь Сэлэнгэ мөрөн болоод улмаар Байгаль далайг бохирдуулж болох талтай харагдаж байна. Мөн Орхон-Туул, Орхон-Сүхбаатар, Хараа, Дархан, Ачуут-Булган голын ус бага бохирдолттой (III зэрэг) ангилалд багтаж байна. Эдгээр гол



дахь  $\text{NH}_4$ ,  $\text{NO}_2$ ,  $\text{Mn}$ , БХХ зэрэг бодисын дундаж нь хэвийн агууламжаас 1.2-2.5 дахин их байна. II зэргийн чанарын “цэвэр” ангилалд хамрагдаж байгаа голуудыг бохирдоогүй гэж үзэх үндэсгүй. Учир нь жилдээ 1-2 удаа шар усны болон цасны үерийн үед биоидэвхт болон органик бодисоор зөвшөөрөгдөх агууламжаас давж бохирдох тохиодол ихэнхи голууд дээр ажиглагддаг. I зэргийн чанарын “маш цэвэр” ангилалд ихэнхи голуудын эх, Хөвсгөл нуурын ус орж байна. Дээрхи үзүүлэлтээр аж үйлдвэрийн байршилтай Эрдэнэт, Цэцэрлэг, Мөрөн зэрэг нутаг дэвсгэр, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг, хүн ам харьцангуй шигүү суурьшсан Орхоны сав газрын гадаргын ус бохирдож чанар нь харьцангуй буурсан байна. Ялангуяа урсац багатай өвлийн улирал болон өвлийн турш хуримтлагдан бохирдсон цас мөс хайлж урсах хаврын улиралд бохирдлын түвшин эрс ихсэж байна. Сүүлийн 30 гаруй жилд хүний зохисгүй үйл ажиллагаанаас Хангайн бүсийн томоохон гол мөрний усны хэмжээ 17.0-30.0 хувиар багассан байна.

**II.2.4 Хангайн бүсийн хөрсний нөмрөгийн антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхийн үнэлгээ:** Хөрсний цэвэрших чадавхид тухайн хөрсний физик хими биогеохимийн олон хүчин зүйлс хамрагдах бөгөөд энэ чиглэлээр судлаач эрдэмтэн Д.Доржготовын боловсруулсан Монгол орны хөрсний эвдрэл, антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхийн судалгааны материалыг ашигласан болно. Эндээс үзвэл Хангайн бүсийн хангай, Хөвсгөл, Орхон, Сэлэнгийн сав дахь уулс хоорондын байнгын урсацтай гол мөрөн бүхий уулс хоорондын харьцангуй өргөн хөндийд байрлах татмын хөрсүүд зөвхөн эвдрэх аюул багатай гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд бусад нутаг дэвсгэр бүхэлдээ антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхиар туйлын эмзэг болох нь тогтоогдож байна. Иймээс Хангайн бүс нутгийн хот байгуулалтын ажиллагаанд хөрс хамгаалалт сайжруулалт онцгой ач холбогдолтой болж байна. Бид энэхүү судалгаандаа өмнө өгүүлсэн байгалийн цэвэрших чадавхи, гадаргын усны гол мөрдийн цэвэрших чадавхийн бүсчлэлийн бүс, дэд бүс болгонд хамрагдах хөрсний эвдрэлийн зэрэг антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхийн хэмжээг тодорхойлж ингэснээр Хангайн бүсийг байгалийн цэвэрших чадавхийн эрчмээр нь (19 дугаар хүснэгт) дараах нэгдсэн бүсчлэлд хамруулж байна.



Байгаль орчны шинжилгээний төв лаборатори 1980-аад оны сүүлчээс эхлэн Дархан, Эрдэнэт, Мөрөн хот орчмын хөрсний бохирдол буюу гадаргууд агуулагдаж байгаа ( $\text{SO}_2$ ), нитратын азот ( $\text{NO}_2$ ), фосфорын агууламж, хөрсний PH-ийг химийн аргаар, хүнд (19 дүгээр хүснэгт) металлын агууламжийг солонгон задралын аргаар тус тус судлан шинэжилсэн байна.

### Хангайн бүсийн хот, суурин газрын хөрсний химийн зарим үзүүлэлт

19 дүгээр хүснэгт

Хотуудын нэр	PH <sub>4</sub>	NO <sub>2</sub>	SO <sub>2</sub>	P <sub>2</sub> O <sub>5</sub>
Эрдэнэт	7.6	6.1	0.28	1.88
Дархан	8.0	8.3	0.27	1.01
Мөрөн	7.8	7.9	0.21	2.35

Хөрсний өнгөн хэсэг дэх нитратын азотын ( $\text{NO}$ ) хэмжээ Эрдэнэт, Дархан, Мөрөн хот орчмын хөрсөнд 0.21-0.26 гр/кг. Энэ нь хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан бохирдолтой холбоотой байна.

Хөрсөн дэх фосфорын хэмжээ Дархан, Эрдэнэт хот орчим 1.01-4.36 мг/кг байна. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийг том хот орчимд (20 дугаар хүснэгт) тоймлон судалсан дүнг үзүүллээ. Хүснэгтээс үзвэл бүх төрлийн хүнд металлын тархах агууламжаар Эрдэнэт хот орчмын хөрс бусад хот, суурингийнхаас илүү байна. Эрдэнэт хотын хөрсөнд хар тугалга (15.2), зэс (33.1) зэрэг хүнд металл ихээхэн тархжээ. Харин Дархан хот орчмын хөрс хүнд металлын агууламжаар харьцангуй бага байна.





**Хангайн бүсийн том хотуудын хөрсөн дэх хүнд металлийн  
агууламж (дундаж, хамгийн их)**

20 дугаар хүснэгт

Хотуудын нэр	Pb	Mn	Sn	Ni	Gr	Mo	Cu	V
Эрдэнэт	15.5	545	-	25.8	-	4.1	33	-
	46.0	1800	-	45.0	-	12.2	155	-
Дархан	1.9	179	2.5	1.9	1.4	1.2	2.2	1.4
	2.4	631	3.7	2.4	2.6	2.1	3.8	1.8
Мөрөн	3.3	222	4.9	2.8	5.3	1.4	6.9	1.3
	5.1	955	6.2	4.1	6.5	1.9	43.7	5.1

**Хөрсний бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь:** Хөрс бол бохир, шингэн, хатуу хаягдлыг эргэж ашиглах, усгүйжүүлэхэд их ач холбогдолтой. Энэ процесст хөрсний асар олон бичил организм, энгийн олон эс болон бусад амьтад оролцдог. Тэдгээрийн амьдралын үйл ажиллагаагаар хөрсөн дэх органик бодист хүнд хоргүй, ургамалд, эрдэс давс, нүүрс хүчил ус болж задрах үзэгдэл явагддаг байна. Үүний хамт бичил организмын үйл ажиллагаагаар ургацын чанарыг дээшлүүлэхэд өндөр ач холбогдолтой, онцгой органик бодис болох ялзмаг 21 дүгээр хүснэгт (гумус) хөрсөндүүсдэг.



**Хангайн бүс нутагт хамрах хөрсний антропоген нөлөөллийг  
тэсвэрлэх чадавхийн үнэлгээ, бүсчлэл**

21 дүгээр хүснэгт

Ландшафтын муж, дэд муж	Хөрсний хэв шинж, эвдрэлийн зэрэг	Хөрсний антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхийн үнэлгээ
А	1	2
<b>1. Орхон –Сэлэнгэ</b>		1. Эвдрэх аюул багатай
1.1 Туул	Эвдрэл алаг цоог илэрсэн	
1.2 Орхон-Сэлэнгийн нам ба бэсрэг уулс	Эвдрэх аюул багатай хөрс	
1.3 Дундаж уулс	Эвдрэл алаг цоог тархсан	
<b>2. Монгол –Алтай</b>		2. Эвдрэх аюул дунд зэрэг
2.1 Салбар уулс	Хийсэх аюул бүхий сайрын аюултай	
2.2 Гол нуруу	Эвдэрсэн ба эвдрэх аюултай	
<b>3. Говь-Алтай</b>		3. Эвдрэх аюултай
3.1 Салбар уулс	Хийсэх аюултай сайрын	
3.2 Гол нуруу	Эвдэрсэн ба эвдрэх аюултай	
<b>4. Хангай</b>		4. Эвдрэх аюул дунд зэрэг
<b>5. Хөвсгөл</b>		5. Эвдрэх аюул дунд зэрэг
1.1 Бэсрэг уулс	Эвдрэл алаг цоог илэрсэн	
а. Өндөр уулс	Эвдэрсэн ба эвдрэх аюултай	
<b>6. Төв Монголын тал</b>		6. Эвдрэх аюултай
6.1 Умард хээр		
6.2 Өндөр хээр	Зарим газраа эвдэрсэн ус салхинд эвдрэх аюултай	
6.3 Заримдаг цөл	Зарим газраа эвдэрсэн ус салхинд эвдрэх аюултай	7. Эвдрэх аюултай
<b>8. Нууруудын хөндий</b>	Хүчтэй хийсэх аюултай	8. Эвдрэх маш их аюултай
<b>9. Алтайн өвөр говь</b>	Зарим газраа эвдэрсэн ус салхинд эвдрэх аюултай	
а. Баруун хуурай		
<b>10. Их нууруудын хотгор</b>	Хүчтэй элэгдсэн газар	10. Эвдрэх маш их аюултай

Иймээс хөрсний өөрөө цэвэрших үйл явц манай гараг дээрхи хөрсний найрлага, уур амьсгалын нөхцөл, хаягдлаар бохирдож байгаа шинж, хүрээнээс хамаарна. Тодорхой тааламжгүй нөхцөлд хөрсний өөрөө цэвэрших явц алдагддаг байна. Тэгвэл бохирдлын бүс хотод болон авто замын дагуу их байна. Засмал



замын 1 кг хөрсөнд 700.0 мл/гр хар тугалга, цагт 2000-аас дээш машин нэвтрүүлдэг замын дагуу хааш хаашаагаа 300 м газрын хаалт хэрэглэдэг байна. Кадми бага хэмжээгээр хотын оршин суугчдад байдаг байна. Хүний цусан дахь сахарыг тогтоодог, цусны даралтыг хэвийн байлгах, хэтэрсэн тохиолдолд хортойгоор нөлөөлөн ясыг хэврэгжүүлж, бөөр элгийг муутгадаг ажээ. Мөнгөн ус, хар тугалганы хөрсөн дэх хэмжээ ихэдвэл ургамал, амьтны микроэлементийг устгадаг ба бага хордуулдаг, хүнд хатуу идэш тэжээлээр дажин хортойгоор нөлөөлдөг ажээ. Фторыг химин болон машины үйлдвэрт ихээр хэрэглэдэг байна. Фтор зохих хэмжээтэй байх үед хүний бие организмд ашигтай байдаг байна. Цусанд байх фторын агууламж ихэсвэл яс хатуурч, шүд цоорч, судасны хана нимгэрч, хатуурдаг гэх мэтчилэн дан дангаараа хорт нөлөө үзүүлдэг ажээ.

**II.2.5 Хангайн бүсийн байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ, бүсчлэл:** Энэ хэсэгт хот байгуулалтад нөлөөлөх байгаль-экологийн хүчин зүйлсийн нөлөөллийн хам шинжийг үндэслэн Хангайн бүсэд хамааралтай нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлж ялгасан бүс, дэд бүс, бичил бүс (сектор) тус бүрийн тодорхойлолтыг өгч бүсийн сум суурингуудын потенциалыг илрүүлэх оролдлого хийв.

Хот байгуулалтанд нөлөөлөх, байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхи харьцангуй өндөр бүс: Энэ бүсэд байгаль ландшафтын мужлалаарх Хангайн бүсэд нөлөөлөлтөй Орхон-Сэлэнгийн сав гэсэн муж хамрагдана. Энэ муж нь агаар мандал, гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх чадавхи хөрсний буферность зэрэг үзүүлэлтээр хоорондоо ялгаатай боловч тэдгээрийн хам үйлчлэлийн шинж болж илрэх байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхиар өндөр үзүүлэлттэй (22 дугаар хүснэгт) гарч байгаа учир харьцангуй өндөр чадавхтай бүсд нэгтгэж үзлээ.

**Нэг. Орхон-Сэлэнгийн дэд бүс.** Энэ бүс нь агаар мандлын өөрийгөө цэвэршүүлэх макро чадавхиар дунд зэргийн аюултай бүсэд хамрагдана. Энэ дэд бүсэд агаарын зөөгдөл, хур тунадас, гадаргын хүчин зүйлс зэрэг нь манай орны дундажтай ойролцоо буюу эерэг нөлөөллийн хувьд ялимгүй дээгүүр байгаа юм. Харин энэ дэд бүсэд хот суурин байгуулагдаж, барилгажих талбай нь үндсэндээ томоохон гол мөрний хөндий бөгөөд гадаргын хэсэгчлэлий шигүү ихтэй учир



хүйтний улирал удаан үргэлжилдгийг тооцвол агаарын даралтын мезо ба макро тонгоруу удаан хугацаанд (250-260 хоног) үргэлжлэн тогтнож агаар мандлын өөрийгөө цэвэршүүлэх чадавхируугаа сөрөг нөлөөлөх тул энд байгуулагдсан суурин газрууд агаарын бохирдол ихтэй байх нөхцөл бүрдүүлж байна.

Энэ дэд бүсэд гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх чадавхид нөлөөлөх бүх л хүчин зүйлсийн утга эерэг нөлөөллөөрөө зөвхөн уулархаг нутгийн дараа орох үзүүлэлттэй тул гадаргын усны өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн нийлбэр үнэлгээгээр харьцангуй чадавхи сайтай бүлэгт хамрагдаж байна.

**Хангайн бүсэд хамааралтай нутаг дэвсгэрийн байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ, бүсчлэл**

Ландшафтын муж, дэд муж	Агаарын өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ	Гадаргын усны цэвэрших чадавхийн үнэлгээ	Хөрсний эвдрэлийн зэргээрх үнэлгээ	22 дугаар хүснэгт Байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн үнэлгээ	
				Дэд бүс	Бүс
1. Орхон - Сэлэнгэ	Сулавтараас дунд зэрэг	Харьцангуй өндөр	Эвдрэх аюул багатай	Харьцангуй өндөр	Харьцангуй өндөр
2. Монгол –Алтай	Сул	Өндөр	Эвдрэх аюултай	Дунд зэрэг	Дунд зэрэг
3. Говь-Алтай	Сул	Харьцангуй өндөр	Эвдрэх аюултай	Дунд зэрэг	
4. Хангай	Сул	Өндөр	Эвдрэх аюул дунд зэрэг	Дунд зэрэг	
5. Хөвсгөл	Сул	Өндөр	Эвдрэх аюул дунд зэрэг	Дунд зэрэг	
6. Төв Монголын тал	Дунд зэрэг	Сулаас маш сул	Эвдрэх аюултай	Сулавтар	Сулавтар
7. Нууруудын хөндий	Дунд зэрэг	Сулаас маш сул	Эвдрэх аюултай	Сулавтар	
8. Алтайн өвөр говь	Сулавтар	Маш сул	Эвдрэх аюул маш их аюултай	Сул	
9. Их нууруудын хотгор	Маш сул	Маш сул	Эвдрэх аюул маш их аюултай	Маш сул	Маш сул

Хөрсний эвдрэлийн зэрэг нь уг дэд бүсийн хэмжээнд зонхилон эвдрэл алаг цоог илэрсэн үнэлгээтэй байгаа боловч Хангайн бүсийн ихэнх хот суурингууд нь гол мөрдийн хөндийд байрлах учир татмын эвдрэл багатай хөрсний ангилалд багтааж байна.



Энэ дэд бүсэд манай улсын ихэнх томоохон, тухайлбал улсын чанартай 2, орон нутгийн чанартай 6 сум, нэлээд хэдэн жижиг суурин тосгон хамрагдаж, хот суурин харьцангуй нягтшилтай тогтолцоо бүрэлдсэнийг дараах байдлаар тодорхойлов.

**Хоёр. Барилгажилтад зориулсан байгалийн хүчин зүйлсийн үнэлгээний Орхон-Туулын бичил бүс:** Энд нам уулс, цав толгодын хэв шинжит хотгор, гүдгэр зонхилж Хангайн бүсэд хамрах тус бүсийн гол мөрөнд цутгах Орхон, Туул Хараа, Ерөө, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрдийн өргөн хөндийнүүдээр ихэнх суурингууд байршина. Тэдгээр хот суурингуудын инженерийн барилга байгууламжид нөлөөлөх байгалийн хүчин зүйлүүд дараах онцлогтой байна. Газар хөдлөлийн балл 7, олон жилийн цэвдэг чулууллаг алаг цоог, тархалтай, гүний усны түвшин гол төлөв доор, гадаргын хэвгийн  $3-6^0$ , хэрчигдлийн шигүү  $2-3 \text{ км/км}^2$ , тооцооны температур  $-30^0-35^0$ , харьцангуй чийгшлийн дундаж 50-60 хувь, тохиолдож болох салхины дээд хурд 20-35 м/сек зэрэг байгаагаас үзэхэд энэхүү сектор нь Орхон-Сэлэнгийн дэд бүсдээ барилгажилтын байгалийн хүчин зүйлсийн хамгийн таатай нөхцөлтэй болох нь тодорхой байна. Гэхдээ хүйтний улирлын үргэлжлэх хугацаа урт, даралтын тонгоруугийн эрчим хүчтэй давтагдал их учир агаарын бохирдол ихсэх аюултай юм.

**Гурав. Байгалийн цэвэрших чадавхи дунд зэрэг бүс:** Энэ бүсэд манай орны уулархаг нутаг бүхэлдээ хамрагдах бөгөөд Хангайн бүсэд хамрах Монгол-Алтай, Говь-Алтай, Хангай, Хөвсгөлийн уулсын (ландшафтын мужлалаар) мужууд хамрагдана. Эдгээр мужууд энэ бүсийн дотоод ялгааг илэрхийлэх дэд бүсүүдийг төлөөлж зохих ялгааг агуулж байгаа бөгөөд үүнийг ерөнхий шинжүүдээр нь нэгтгэн авч үзлээ.

Энэ бүсэд агаарын цэвэрших чадавхид нөлөөлөх гол хүчин зүйлс, түүнчлэн хур тунадас, хүчтэй ба шороон шуурганаас бусад нэмэлт хүчин зүйлүүдийн утга нь техноген нөлөөллөөр агаар бохирдох аюултай нөхцөл бүрдүүлж байна. Эдгээр районд хот суурин байгуулагдах, барилгажих талбай нь ихэвчлэн уулс хоорондын хөндий болох учраас хүйтний төдийгүй дулааны улирлын агаарын температур, агаарын даралтын тонгоруугийн нөлөө хүчтэй илэрч байдаг тул эндэх хот





суурингуудын агаар бохирдох агаар өөрийгөө цэвэршүүлэх чадавхи сул байх нөхцөл бүрдэж байна.

Гадаргын усны цэвэрших чадавхийн хувьд энэхүү бүс нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа юм. Хөрсний антропоген нөлөөллийг тэсвэрлэх чадавхиар дунд зэрэгтэй гэсэн үнэлгээний ангилалд багтаж байна. Байгалийн цэвэрших чадавхиар энэ бүс нь дунд зэргийн чадавхитай бүс гэж тооцогдож болох бөгөөд гэхдээ дэд бүс тус бүрээр онцлог ялгаа илэрч байна. Энэхүү бүсийн дэд бүс тус бүрт барилгажилтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн 2-3 секторын ялгаа илэрч байгаа ба тэдгээр секторуудыг дараах зарчмаар бүлэглэн үзлээ. Үүнд:

1. Тухайн дэд бүсийг бүрдүүлж байгаа уулсын тогтолцооны захын болон салбар нуруудын сектор. Энэ секторт газар хөдлөлийн балл 8-9, олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттай, гадаргын хэрчигдлийн шигүү ойролцоогоор  $4 \text{ км/км}^2$ , налуу  $6-12^0$ , ихэнх хот суурингууд нь голын хөндийд байршдгийг тооцвол үерийн нөлөө хот байгуулалтад багагүй бэрхшээл учруулж болох талтай юм. Уур амьсгалын хувьд өвөлдөө хүйтэн чийглэгүүдээс хүйтэн хуурайдуу, агаарын температурын тонгоруугийн нөлөө хүчтэй илрэх учир агаар бохирдох магадлал өндөр байна. Ихэнх суурин газрууд нь усан хангамжийн найдвартай эх сурвалжаар хангагдсан байна.

2. Дундаж өндөр уулсын сектор. Энд Хангай, Хөвсгөлийн дундаж уулс, Монгол-Алтай, Говь-Алтайн салбар уулс зарим нэг талаар хамрагдах бөгөөд барилгажилтад нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл харьцангуй хүчтэй илэрдэг байна. Тухайлбал газар хөдлөлийн балл 9, гадаргын хэвгий  $12-20^0\text{C}$ , хэсэгчлэлийн шигүү  $5-6 \text{ км/км}^2$ , олон жилийн цэвдэг чулуулаг элбэг ба алаг цоог тархалттай, тооцооны температур  $-30-40^0\text{C}$ , харьцах чийгийн жилийн дундаж  $65.0-70.0$  хувь байгаа нь барилгажилт, хот байгуулалтын тохиромжгүй нөхцөлтэйг харуулж байна.

3. Өндөр Хангай, Хөвсгөлийн өндөр уулсын сектор. Газар хөдлөлийн балл 9-өөс дээш, олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн тархалттай, гадаргын хэвгий  $20^0$ -аас их, хэсэгчлэлийн шигүү  $8 \text{ км/км}^2$  хүртэл ихэсч, хахир хүйтэн чийглэг ба



чийглэгдүү байгаа зэргээс үзэхэд хот байгуулалт, барилгажилтад нэн тохиромжгүй нөхцөлтэй болно.

**Дөрөв. Хот байгуулалтад нөлөөлөх, байгалийн цэвэрших чадавхийн сулавтар потенциалтай бүс.** Энэ бүсэд Хангайн бүстэй шүтэлцээтэй Төв Монголын тал, нууруудын хөндийг хамааруулж үзсэн бөгөөд агаарын цэвэрших чадавхид нөлөөлөх гол хүчин зүйлсийн утга хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ба бусад хүчин зүйлс нь манай орны дундаж үзүүлэлттэй ойролцоо буюу түүнээс доогуур, тухайлбал хур тунадас харьцангуй бага, хүчтэй салхитай болон гангын давтагдал харьцангуй (Дорнод талтай харьцуулбал) их байгаа учир агаарын цэвэрших чадавхийн дунд зэргийн потенциалтай бүс юм.

Гадаргын усны цэвэрших чадавхийн хувьд сулаас маш сул потенциалтай гэсэн ангилалд хамрагдах бөгөөд хөрс нь эвдрэл аюултайгаас эвдрэх маш их аюултай бүсийн шинжийг илтгэж байна. Ийм ч учраас эдгээр нутгуудыг нэгтгээд байгалийн цэвэрших чадавхийн сулавтар потенциалтай бүсийн ангилалд хамруулж үзэв.

Энэ бүс нь дотроо төв монголын тал, нууруудын хөндий гэсэн 2 дэд бүсэд хамрагдах бөгөөд дэд бүсийн дотоод дахь секторуудын ялгаа нь умардын хуурай хээрээс говь хүртэлх нарийн зурвас бүслэг ялгаагаар тодорхойлогдож байна. Барилгажилтад нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн үнэлгээгээр секторууд нь бага зэрэг ялгаатай. Энэхүү бүсэд барилгажилтад зориулсан байгалийн хүчин зүйлсүүд нь: газар хөдлөлийн балл 6-7, олон жилийн цэвдгийн тархалт ховор, гадаргын хэвгий  $1-6^0$ , хэрчигдлийн шигүү  $1-3 \text{ км/км}^2$ , гүний түвшин доор, уур амьсгалын хувь хүйтэн хуурайдуу зэргээс үзэхэд инженерийн барилга байгууламжид байгалийн хүчин зүйлсийн нөлөөлөл таатайгаас нэн таатай гэсэн үнэлгээтэй байна. Гэхдээ усан хангамжийн найдвартай эх сурвалж нутаг дэсгэрээр жигд биш, ялангуяа энэ бүсийн өмнөд хэсгээр ундны усны гачаалалтай байх нөхцөл нэлээд хэдэн сууринд тохиолдож байна.



**Тав. Хот байгуулалтад нөлөөлөх, байгалийн цэвэрших чадавхийн сул потенциалтай бүс:** Энэ бүсэд Хангайн бүстэй Алтай өвөр говь шууд шүтэлцээтэй Дорнод муж хамрагдана. Агаарын цэвэрших чадавхид нөлөөлөгч гол хүчин зүйлс болон нийлбэр цацраг, жилийн (49, 50, 51 дүгээр зураг) дундаж температур зэрэг үзүүлэлтүүд эерэг нөлөөллийн өндөр үзүүлэлттэй боловч хур тунадас хамгийн бага, ган болон хүчтэй шороон шуурганы давтагдал олон зэрэг экстрималь хүчин зүйлсүүдийн нөлөөллөөс агаарын цэвэрших чадавхи сулавтар потенциалтай гэсэн ангилалд багтаж байна. Гадаргын усны цэвэрших чадавхи маш сул, хөрсний эвдрэл маш их аюултай бүлэгт хамрагдаж байгаагаас энэхүү бүсийн байгалийн цэвэрших чадавхи сул потенциалтай байх нөхцөл бүрдэж байна.


Энэ бүсийг бүрдүүлж буй 2 дэд бүс нь тус бүрдээ хоёр хоёр секторт хуваагдаж нэгтгээд үзвэл барилгажилтад нөлөөлөх байгалийн хүчин зүйлс дараах онцлогтой байна. Газар хөдлөлийн балл 6-7, олон жилийн цэвдэг үндсэндээ байхгүй, гүний усны түвшин доор, гадаргын хэсэгчлэлийн шигүү 1-3 км/км<sup>2</sup>, гадаргын налуу 1-6<sup>0</sup> байгаа нь хот байгуулалтад таатай нөлөө үзүүлэх боловч энэ бүсэд говь, цөлийн эмзэг, эвдрэх онцгой аюултай хөрс зонхилж, элсэн талбай хуримтлал их зэрэг нь хөрс хийсэх, элсний нүүлт үүсэх, шороон шуурганы голомт бүрэлдэх сөрөг нөлөөллийг нөхцөлдүүлж байна. Усны найдвартай эх сурвалж хомс байгаа нь хот суурин газар үүсэж хөгжих бас нэг сөрөг хүчин зүйл болно.

Ер нь дээр дурьдсан бүс, дэд бүс, сектор тус бүр нь Хангайн бүсийн барилга, хот байгуулалтын (23 дугаар хүснэгт) нутаг дэвсгэрийн тодорхой ялгаанууд бөгөөд манай улсын архитектур, хот байгуулалтын үндэсний хөтөлбөр, бодлого, боловсруулахад зайлшгүй харгалзан үзэх нэгэн чухал үндэслэл гэдгийг онцгойлон тэмдэглэж байна. Ер нь хот байгуулалтын судалгааны арга зүйн үүднээс үзэхэд түүний нийгмийн хүчин зүйлүүд 40.0 хувь, байгаль-экологийн хүчин зүйлсүүд 40,0 хувь, архитектур, ландшафтын таатай байдлын хүчин зүйлсүүд 20.0 хувь орчим байх бөгөөд эндээс үзсэн ч хот байгуулалтад нөлөөлөх байгаль-экологийн хүчин зүйлсийн нөлөөллийг хот байгуулалт, төлөвлөлтийн практиктай холбож тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс шийдэж байх ёстой гэж үзэх нь зүй ёсны юм.



ХАНГАЙН БҮС, ХҮЧТЭЙ САЛХИТЭЙ ( 15 м/с ) ӨДРИЙН ТОО, ЖИЛ

M1:4500000








ХАНГАЙН БҮС, ХАМГИЙН ХҮЙТЭН НЭГ, ТАВ ХОНОГИЙН ТООЦООНЫ ТЕМПЕРАТУР

M1:4500000








ХАНГАЙН БҮС, БАРИЛГЫН ТӨЛӨВЛӨЛТӨНД ЗОРИУЛСАН УУР АМЬСГАЛЫН БҮСЧЛЭЛ

M1:4500000





**Хот байгуулалтад нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн үнэлгээг  
Хангайн бүсийн хот суурингуудын харъяалах байдал**

23 дугаар хүснэгт

Хот байгуулалтад нөлөөлөх байгалийн өөрийгөө цэвэршүүлэх чадавхийн бүс	Дэд бүс	Улсын чанартай хот	Орон нутгийн чанартай хот	Бусад жижиг суурин, тосгон
Харьцангуй өндөр чадавхитай бүс	Орхон-Сэлэнгийн	Эрдэнэт Дархан		Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Их-Уул, Тосонцэнгэл, Тариалан, Архангай аймгийн Цэцэрлэг, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал, Өлгий нуур, Хашаат, Өвөрхангай аймгийн Хархорин, Бүрд, Булган аймгийн бүх сумын төв, суурин, Орхон аймгийн бүх сумын төв, суурин.
Дунд зэрэг чадавхитай	Монгол – Алтай			
				Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баянговь, Баянлиг, Өвөрхангай аймгийн Богд, Өмнөговь аймгийн Булган, Сэрвэй, Ханхонгор сумын төв
				Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Их Уул, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Архангай аймгийн Хангай, Цахиур, Тариат, Чулуут, Өндөр-улаан, Их тамир, Батцэнгэл, Цэнхэр, Булган, Түвшрүүлэх, Хотонт, Өвөрхангай аймгийн Хужирт, Бат-Элзийт, Уянга, Хайрхандулаан, Зүүнбаян-Улаан, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баацагаан, заг, Жаргалант, Байдраг, Гурван булаг, Галуут, Баянбулаг
	Хөвсгөлийн		Хатгал	Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Баянзүрх, рэнчин Лхүмба, Цагаан нуур, Халх, Чнадмань-Өндөр, Түнэл
Сулавтар чадавхитай бүс	Төв монголын өндөрлөг талын		Арвайхээр	Өвөрхангай аймгийн тарагт, Өлзийт, Есөнзүйл, Баян-Өндөр, Сант, Баянгол, Төгрөг
	Нууруудын хөндий			Баянхонгор аймгийн Хүрээ марал, Бууцагаан, Баян-Овоо, Баацагаан, Өлзийт, Жинст, Богд, Өвөрхангай аймгийн Нарийн тээл, Баруун Баян-Улаан, Гучин –Ус сумын төв
Сул чадавхитай бүс	Алтайн өвөр говийн			



## **ГУРАВ. ХАНГАЙН БҮСИЙН ХОТ БАЙГУУЛАЛТАНД НӨЛӨӨЛӨХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ**

### **II.3.1 Эдийн засгийн чадавхиар нь Хангайн бүсийн хотуудыг ангилах:**

Хот суурин болгон өөрийн хөгжлийг тэтгэх өөрийн мэдлийн эх үүсвэртэй байх учиртай бөгөөд иймээс энд Хангайн бүсийн хот суурингуудыг эдийн засгийн бааз суурь, нийгмийн хангамж үйлчилгээ зэрэг үзүүлэлтээр үнэлж ангилах оролдлого хийлээ.

Хангайн бүсийн хот суурингуудын эдийн засгийн хөгжилд түлхэц болохоор нөлөө үзүүлэх гол салбарууд болох мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үр тарианы үйлдвэрлэл, хөнгөн хүнсний үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл, модон бүтээгдэхүүний, барилгын материалын үйлдвэрлэлийн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээг харгалзан улсын чанартай хот, орон нутгийн чанартай хот суурин, эдгээрт дэвших магадлалтай суурингуудаар авч, дүн шинжилгээ хийн нийлбэрлэх замаар эдийн засгийн (24 дүгээр хүснэгт) потенциалар нь ангилж үзлээ. Үүнээс үзэхэд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний ихэнхийг Хангайн бүсийн хуучин аймгийн төв, суурингууд буюу орон нутгийн чанартай хотуудад байгаа нь тодорхой байна. Голлох үзүүлэлт болгон авсан дээрхи үзүүлэлтүүдээс хүн амын тоо аж үйлдвэрийн салбарын бүтэц, үйлдвэрлэлийн хэмжээ, үйлдвэрлэлийн дэд бүтцийн хангамж, нөөцийн потенциал зэрэг нь тухайн хот суурингийн хот бүрдүүлэгч үүргийг тодорхойлж байгаа учир үндсэн үзүүлэлт болгон авсан юм. Харин үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд, түргэн гэмтэж, муудах өндөг мэтийн бүтээгдэхүүний хангамжийн үзүүлэлтүүд нь хотын үйлчлэгч үүргийг гүйцэтгэж байна хэмээн авч үзэж, туслах үзүүлэлт болгон тооцов.

Хангайн бүсийн хот суурингийн хөгжил, үйлчилгээий үндсэн цар хүрээг илтгэх гол үзүүлэлтүүдийн нэг бол хөнгөн, хүнсний үйлдвэр, түүний үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ билээ. Энэ үзүүлэлтээр Хангайн бүсийн хотуудыг бүлэглэж үзэхэд улсын чанартай хотын ангилалд Хангайн бүсээс, Эрдэнэт, улсын чанартай хотод дэвших магадлалтай бүлэгт Харин Хангайн бүсийн Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай орон нутгийн чанартай хотуудад Архангай, Баянхонгор, орон нутгийн чанартайд дэвших магадалтай бүлэгт хамруулан үзэж болохоор байна. Энэ



үзүүлэлтийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эрэмбээр Архангай аймгийн тосгон суурингууд хамрагдаж байна. Үүнээс үзэхэд Хангайн бүсийн дотоодын үйлдвэрлэлийн ихэнхи нь зөвхөн улсын болон орон нутгийн чанартай сум, суурингуудад үйлдвэрлэдгийг харуулж байна.

Харин үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээг авч үзэхэд энд голлож хэдхэн сууринд төвлөрсөн байдал ажиглагдаж байна. Үйлдвэрлэлийн хэмжээгээр бүлэглэж үзэхэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ хэмжээгээр Дархан, Хөвсгөл аймгуудын төв суурингууд орж байна. Уул уурхайн үйлдвэрлэлд хар төмөрлөг, нүүрс олборлолт, газрын тосны үйлдвэрлэл зэрэг үзүүлэлтүүдийг хамааруулан авч үзсэн болно.

Уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээгээр бүлэглэхэд төмрийн хүдэр олборлолтоороо Эрдэнэт, Өвөрхангай хангаж болох Дархан аймгууд тэргүүлж, дараахи бүлэгт нь Баянхонгор, Хөвсгөл аймгууд орж байгаа юм.

Нүүрс олборлолтын үзүүлэлтийг авч үзэхэд энэ бүсэд нүүрсний хэд хэдэн бүлэглэлүүд үүсч болох байна. Үүнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ хэмжээгээр 1-р бүлэгт Дархан, дараах бүлэгт Хөвсгөл, Өвөрхангай орж байна. Харин орон нутгийн чанартай хотод дэвших магадлалтай сум сууринд Баянхонгор, аймгийн төв суурингууд эцсийн бүлэгт хамрагдаж байгаа нь энэ бүсийн хот суурингууд тодорхой нүүрсний нөөцөд татагдаж буй бөгөөд энэ үзүүлэлтээр эрчим хүч, дулаанаараа өөрийгөө хангах потенциалтай болох юм гэж үзэж болох байна.

Модон эдлэл, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ Булган аймаг тэргүүлж, ойролцоох хот Дархан удаалж байна. Дараагийн бүлэгт Өвөрхангай аймгийн төв суурингууд орж, дээрх бүлэгт дэвшиж болох суурингуудад Хөвсгөл, Архангай аймгуудын хот суурингууд жижиг хотын ангилалд хамрагдаж байна.



**Хангайн бүсийн хот суурины эдийн засгийн потенциалархи үнэлгээ**

24 дүгээр хүснэгт

Суурингийн ангилал	Хүн амын тоогоор		Махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Үр тарианы үйлдвэрлэл	Хүнсний үйлдвэрлэлт	Уул уурхайн		Модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Барилгын материалын үйлдвэрлэл	Мал аж ахуй
	I хувилбар	II хувилбар				Төмрийн хүдэр	Нүүрс олборлолт			
Улсын чанартай хот	Дархан Эрдэнэт	Орхон Дархан-уул	Дархан		Дархан Эрдэнэт	Дархан Эрдэнэт Өвөрхангай	Дархан	Булган	Дархан	
Улсын чанартай хотод дэвших				Хөвгөл Булган	Хөвгөл Баянхонгор ор Өвөрхангайн	Баянхонгор Хөвсгөл	Хөвгөл Өвөрхангайн	Дархан		Баянхонгор
Орон нутгийн чанартай хот	Мөрөн Баянхонгор Ахвайхээр Булган				Архангай			Өвөрхангай	Архангай	
Орон нутгийн чанартайд дэвших		Булган					Булган Баянхонгор	Орхон Хөвсгөл		Булган Арвайхээр





Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед энэ бүсэд хэд хэдэн сум сууринд модны үйлдвэрлэл явагдаж байсан ч нэлээд цагийн аясыг даалгүй хаагдаж, нөгөөтэйгүүр түүхий эдийн хомсдол бий болж байгаа нь харагдаж байна.

Дээрхи үзүүлэлтийн нэгтгэн үзэхэд Хангайн бүсийн эдийн засгийн потенциалтай хот сууринд, Эрдэнэт хот орж, харин дараахи бүлэгт орон нутгаа тэтгэх Мөрөн, Баянхонгор, зэрэг хотууд нь улсын чанартайд дэвших магадлалтай болж байна. Орон нутгийн чанартай хотод Цэцэрлэг хот орж байна. Сулавтар потенциалтай хотдуу өөрөө хэлбэл, орон нутгийн чанартай хотод дэвших хот, сууринд Булган хотын төв суурингууд орж байна.

Эдийн засгийн потенциалын орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэрүүдийг тооцож үзвэл орон нутгийн төсөвт нөлөө өгөхүйц том үйлдвэрүүдийг байгуулж ашиглах, үүсч хөгжиж буй хоршоо, компанийг дэмжин хөгжүүлэх, газар нутгийн үнэлгээг бий болгож, ашигт малтмал ашигласны болон газрын төлбөрөөс үүсэх орлогыг нэмэгдүүлж болохоор байна.

Хот, суурингийн эдийн засгийн хөгжлийг тэтгэх хүчин зүйлсүүд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хөгжил, түүнчлэн дэд бүтцийн хөгжил, түүний дотор зам харилцаа, эрчим хүчний хангамж хүрэлцээг багтаан авч үзэж, хотуудын эдийн засгийн потенциалыг тодорхойлох үндсэн хүчин зүйл нь аж үйлдвэрийн хөгжлийг тэтгэх, хот суурины орчимд орших ашигт малтмалын орд, тэдгээрийн нөөцийн судалгаа гэж үзэж дараах үнэлгээг гаргаж байна.

Эдийн засгийн хөгжлийн чадавхийг тодорхойлохдоо Хангайн бүсийн хот, суурингуудад хамрах тэнд оршиж байгаа ашигт /25 дугаар хүснэгт/ малтмалын орд газрын байрлал, түүний нөөц дээр тулгуурлан, уг суурингаас хамаарах таталцлын хүрээг 50.0 км-ээр авч, энэ хүрээлэлд орших бүх төрлийн ашигт малтмалын ордыг бүлэглэж үзлээ. Үүнд:

- I. Олон бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй
- II. Дунд зэргийн бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй
- III. Цөөн бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй.



IV. Эрчим хүчний эх үүсвэрийн нөөцтэй зэргээр ангилж, тус бүрд хамаарагдах Хангайн бүсийн суурингуудыг ялган тогтоолоо.

**Хангайн бүсийн ашигт малтмалын нөөцийг потенциалар нь аниласан үзүүлэлт**

25 дугаар хүснэгт

№	Ангилал	Олон бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй	Дунд зэрэг бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй	Цөөн бүрдэлтэй ашигт малтмалын нөөцтэй	Эрчим хүчний нөөцтэй
	Томоохон хотууд				
0	А	1	2	3	4
1	Эрдэнэт	1, 8, 3			+
2	Арвайхээр			+	
3	Баянхонгор			1, 6	
4	Булган				+

Хангайн бүсийн ихэнхи хот суурингууд тухайн нутаг дэвсгэрийнхээ нөөцийг зөв үнэлж, ашиглаагүйгээс өнөөдөр нэлээд нь зөвхөн улсын татаас дээр тулгуурлаж, улс орны эдийн засагт хүндрэл учруулж байна. “Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөл” мөн Завхан-Хөвсгөлийн бүс нутгуудыг хөгжүүлэх төсөлд ашигт малтмалын нөөцийг үнэлэн хот байгуулалтын хөгжилд ашиглах саналыг дэвшүүлж байна. Судалгаагаар М1:1500000 бүхий эрдэс түүхий эдийн зурагт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дээрх ангиллыг тогтоосон байна. Энэхүү ангилал дээр тулгуурлан нөөц бололцоогоо зөв тодорхойлж чадвал тухайн суурин өөрийгөө даан хөгжих эдийн засгийн потенциалтай гэж үзэж байна. Гэхдээ энэхүү потенциалыг бүрдүүлэх бусад дагавар хүчин зүйлс байх нь гарцаагүй юм. Үүнд:

**1.Олон бүрдэлттэй ашигт малтмалын нөөцтэй.** Ашигт малтмалын зураг дээрх нөөц нь тогтоогдсон ордын хот, сууринд татагдах хүрээг харгалзан Эрдэнэтийн тухайд бүрээр тодорхойлоход тухайн суурины хөгжлийг тэтгэх алт,



мөнгө, өнгөт металл, нүүрс, нефть зэрэг олон ашигт малтмалууд тухайн хүрээлэлд хамрагдаж байгаа нь тодорхой байна. Монгол улсын хот байгуулалтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн нэгдсэн цогцолбор үнэлгээг хийхэд нийслэл Улаанбаатар хоттой дүйцэх, түүнтэй өрсөлдөх хот суурин хүн амаараа ч, үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээ зэрэг үзүүлэлтээрээ хараахан дөхөж очоогүй нь батлагдаж байна. Зөвхөн экологи-байгалийн хүчин зүйлийн хувьд харьцангуй дорой байж болох талтай ч байгалийн бохирдлын өөрийгөө цэвэршүүлэх чадавхиар тийм ч сул биш ажээ. Олон бүрдэлттэй ашигт малтмалын нөөцтэй Хангайн бүсийн хотод Эрдэнэт хот хамрагдаж байна. Иймээс Хангайн бүсийн Эрдэнэт хот ямарваа ашигт малтмалын 2-3 орд, нөөцийг ашиглахад түүнд тулгуурлан хөгжих эдийн засгийн потенциалтай гэсэн хэрэг. Эрдэнэт хот баллын үнэлгээгээр тооцож үзэхэд мөн энэ ангиллаа алдахгүй нь нотлогдож байна.

Эрдэнэт хотын нөөц нь тогтоогдсон бүх ашигт малтмалыг нэгтгэн дүгнэхэд төвөгтэй учраас ашигт малтмалуудыг төрлөөр нь бүлэглэж (26 дугаар хүснэгт) тодорхой нэрийн ашигт малтмалуудад “код” өгөн үнэлгээний хүснэгтэд оруулсан болно.

Эрдэнэт нь үйлдвэржилтийн хувьд харьцангуй өндөр хөгжилтэй хот суурингуудын тоонд багтаж байна.

## ***2. Дунд зэрэг бүрдэлттэй ашигт малтмалын нөөцтэй хот сууринд.***

Хөвсгөл аймгийн Мөрөн, хот хамрагдана. Энэ бүлгийн онцлог нь ихэвчлэн 1-2 ордын ашигт малтмалын нөөцөд тулгуурлан хөгжих боломжтой юм. Мөрөн хотоор жишээ аваад үзэхэд хүрэн нүүрс фосфорит зэрэг ашигт малтмалын нөөцөд түшиглэн хөгжих бололцоотой нь харагдаж байна. Мөрөн хот нь нийслэл Улаанбаатар хотоос хэт алслагдсан суурингууд байгаа нь ажиглагдахаас гадна ашигт малтмалын нөөцийн хувьд харьцангуй бага судлагдсан нь ч тогтоогдож байна.

**Эрдэнэт үйлдвэрийг ашигт малтмалыг нөөцөөр нь ангилсан байдал**

26 дугаар хүснэгт

№	Эрдэс, ашигт малтмалын нэрс	Код
1	Алт	1
2	Мөнгө	2
3	Өнгөт металл	3
4	Түлшний ашигт малтмал	4
5	Нефть	5
6	Нүүрс	6
7	Фосфорит	7
8	Зэс молебдин	8
9	Полиметалл	9
10	Шатах занар	10

**3. Цөөн бүрдэлттэй ашигт малтмалын нөөцтэй.** Энэ бүлгийн хот суурингуудад Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянхонгор аймгийн Баянхонгор, Архангай аймгийн Цэцэрлэг, Булган аймгийн Булган, зэрэг хот, суурингууд хамрагдаж байна. Эдгээр нь ихэвчлэн үндсэн нэг төрлийн ашигт малтмалын нөөцөөр голлон тэжээгдэх суурингууд юм. Судалгаагаар улс орны хөгжлийн сүүлийн хагас зуун жилд уламжлалт мал аж ахуйн зэрэгцээ байгалийн нөөцөд тулгуурласан аж үйлдвэрийн салбар, ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, барилгын материалын болон мод бэлтгэх боловсруулах үйлдвэр, мөн түүнчлэн газар тариалан зэрэг эдийн засгийн хөгжилд ихээхэн өөрчлөлт оруулж, орчныг доройтуулахад нөлөөлж байна. Улмаар улс орон 1990-ээд оноос хойш зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаатай уялдан үйлдвэржилт, хотжилтын цар хүрээ тэлж, байгалийн нөөцөд түшиглэсэн салбарын эдийн засагт эзлэх хувь хэмжээ энэ бүсэд өсөн нэмэгдэх хандлагатай байна.



Байгалийн нөөц баялагийг аж ахуйн нэгж байгууллагууд явцуу ашгийн үүднээс хайр гамгүй ашиглах болсноос байгалийн баялагийн нөөц нь хомсдож байгаль орчны чанарыг доройтуулж улмаар экологийн тэнцлийг алдагдуулахад хүргэж байна. Бидний зорилго бол ирээдүйд Хангайн бүсийн хаана хот байгуулж болох нутаг орныг тогтоох. Ер нь Монгол орны орчин үеийн хот байгуулалт, суурьшилт экспортын чиглэлтэй ашигт малтмалын ордуудтай холбоотойгоор хөгжинө гэж үзэж байна. Монгол орон тогтвортой хөгжлийн замд орохдоо дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай экспортыг нэмэгдүүлдэг ашигт малтмалын ордууд дээр тулгуурлан хөгжих ёстой. Энэ үүднээс экспортын чанартай гэж үзэх ашигт малтмалын голлох судлууд /Жоншны, Зэс-Алтны, Зэсийн, фосфоритын, Нүүрсний/ судлуудыг райончлон авч үзэж 1:3000 000 масштабтай зургийг зохиосон байна. Энэ нь Хангайн бүсийн потенциалыг тодорхойлох үндэслэл болж байгаа юм.

Үүнээс үзэхэд хот суурин байгуулахад нэн тохиромжтой нутгуудын гадаргын хэвгийн зонхилох өнцөг  $3-6^{\circ}$ , хэрчигдлийн шигүү 4000 метрээс дээш, хэрчигдлийн гүн 200-600м, гадаргын болон гүний усны чөлөөт нөөцтэй байгаа нь тодорхой байна.

Хот суурин байгуулах боломжтой гэсэн ангилалд орж байгаа Хангайн бүсийн гадаргын хэвгийн зонхилох өнцөг  $12-20^{\circ}$ , хэрчигдлийн шигүү 2000-40000м, гүн 800-1800м, усны боломжийн нөөцтэй гэсэн үзүүлэлтүүдийг нь харгалзан үзсэн болно.

Хот суурин байгуулахад боломж багатай Хангайн бүсийн нутгуудад нь гадаргын хэвгийн зонхилох өнцөг  $20^{\circ}$ -аас дээш, хэрчигдлийн шигүү 500-1000м, гүн 1800м-ээс дээш, усны чөлөөт нөөцгүй нутгууд хамрагдаж байна.

Нэн боломжтой нутгуудад Хангайн бүсийн Орхон-Туулын сав, Хангайн гол нурууны өмнөд хэсэг, хамарсан голлон жоншны судал дагасан нутгууд энд хамрагдаж байна.

Боломжтой нутгуудад Хангайн бүсэд нөлөөтэй Монгол Алтайн нурууны ар бэл, Баянхонгорын хил хүртэлх зурвас нутаг хамарч байна.





Боломж багатай нутгууд нь хэдийгээр ашигт малтмал нөөцийн хувьд боломжтой бусад дээрх үзүүлэлтүүдээрээ боломж багатай нутгууд багтаж байна. Тухайлбал: Хөвсгөл орчмын нутаг, фосфоритын нөөцийг аваад үзэхэд ашигтай ч түүнийг ашиглах явдал нэмэгдэх нь хүснэгтээс харагдаж байна. Энэхүү үнэлгээ нь нэг талаас тухайн хот суурин өөрийгөө даан хөгжих боломж суурийг нь гаргах зорилготой ч, нөгөө талаас хүн ам оршин амьдрах эрүүл ахуй орчны талаас бас голлож анхаарсан хэрэг. Тэгээд ч Монгол улсын Үндсэн хуулинд хүн аюулгүй эрүүл орчинд амьдрах ёстой гэсэн заалт бий билээ. Жижиг суурин ч бай, томоохон хот ч ялгаагүй тодорхой хэмжээгээр агаар орчин бохирддог. Өөрөөр хэлбэл байгаль орчинг бохирдуулах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах гол эх сурвалж нь хот, суурин газрууд байдаг ажээ. Хот суурин яаж үүсэх вэ гэвэл аж үйлдвэрийн чиглэлтэй үйлдвэр хөгжих боломжтой, түүнийг даган хүн ам оршин суурьших зэрэг үйл явцаас үүдэн бий болдог байна.

**II.3.2 Хангайн бүсийн хот байгуулалтад нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлийн үнэлгээ.** Энэ бүлэгт хот байгуулалтад нөлөөлөх нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийг их дээд сургууль, соёлын байгууллага, эрүүл мэндийн байгууллага зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлж 5 үндсэн бүлэгт хуваалаа.

Зах зээл хөгжиж буй нөхцөлд газар, орон сууц хувийн өмчид очсоноор үл хөдлөх хөрөнгийн орлого сүүлийн үед нэмэгдэх хандлагатай болж байна. Мөн зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад малаас гарах ашиг шимийн нөөцийг бүрэн гүйцэд ашиглах нь чухал юм.

Нийгмийн хүчин зүйлсийн хувьд боловсрол, шинжлэх ухаан, эмнэлэг, хүн амын соёл ахуйн үйлчилгээ, орон сууцны хангамж зэрэг салбаруудыг хамруулан зарлагыг багасгахын тулд боловсролын байгууллагад гадаадын төслийг нэмэгдүүлэн хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн тусламжийг зөв зохистой ашиглах, эдгээр салбарын зардлын дийлэнх хувийг эзэлж буй байр, уур, ус, халаалтын зардлыг багасгах бололцоо боломжийг эрж хайх, гэрээгээр ажиллах хэлбэрийг дэлгэрүүлэх, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийг дэмжин, төр өөрийн гүйцэтгэх зарим үүргийг төрийн бус байгууллагаар дамжуулан гүйцэтгэх



зэргээр удирдлагын зардлыг хэмнэх явдал чухлаар тавигдаж байна. Дээрхи үзүүлэлтээр анализ хийсний үндсэн дээр хангайн бүсийн хот, сууринг нийгмийн үзүүлэлтээр нь улсын чанартай хот, улсын чанартай хотод дэвших суурин, орон нутгийн чанартай хот суурин, орон нутгийн чанартай хот сууринд дэвших магадлалтай суурин, хөдөөгийн буюу 15,0 мянгаас цөөн оршин суугчидтай суурингууд гэсэн дараах 5 бүлэгт (27 дугаар хүснэгт) ангилан үзэж байна.

**1. Улсын чанартай хот суурин.** Энэ бүлэгт эдийн засгийн чадавхи, дэд бүтэц, үйлдвэржилтээр харьцангуй давуу, нийгмийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээгээр бүсийнхээ хувьд өндөр үзүүлэлттэй хот суурингууд хамрагдаж байна. Энэ үүднээс үзвэл улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэтгэх төмөр зам, авто замын дагуу улсын Хангайн бүсийн Эрдэнэт хот байрлаж байна. Хөдөлмөрийн нөөц харьцангуй сайтай, орон сууц, соёл, ахуй үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллагуудын үндсэн чадавхи энд төвлөрсөн, соёл урлаг, шинжилгээ судалгаа, мэдээллийн өргөн цар хүрээ, оюуны сан төвлөрсөн байна.

### Хангайн бүсийн хот суурины нийгмийн потенциалын үнэлгээ

27 дугаар хүснэгт

	Улсын их, дээд сургууль	Коллеж	Хот, аймгийн чанартай эмнэлэг	Шинжлэх ухааны байгууллагууд
0	1	2	3	4
Улсын чанартай хот	Эрдэнэт			
Улсын чанартай хотод дэвших				
Орон нутгийн чанартай хот		Цэцэрлэг Арвайхээр	Цэцэрлэг Арвайхээр	
Орон нутгийн чанартай хотод дэвших		Өндөрхаан Мөрөн	Өндөрхаан Мөрөн	
Бусад				



Эрдэнэт хот нь ОХУ, Хятад улсаар дамжин Европ-Ази тивийн улсуудтай харьцах, хөрш их гүрнүүдийн зах зээлд гарах зам харилцааны давуутай боломжтой, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц харьцангуй сайн судлагдсан улсын хэмжээний газар тариалангийн үйлдвэрлэлийн зохих хувийг эзэлдэг, үйлдвэрлэл, дэд бүтэц илүү хөгжсөн зэргээр илэрч байна.

Үүний зэрэгцээ зарим нэгэн сөрөг тал бий. Тухайлбал: Нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл бий болсон, энэ төвлөрөл хүн амын шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлэн механик өсөлтийг бий болгосон бөгөөд үүнээс үүдэлтэй хүн амын амьжиргааны түвшин харилцан адилгүй Эрдэнэт мэтийн томоохон хотуудын агаар усны бохирдол, хөрсний элэгдэл, эвдрэлтэй бэлчээрийн доройтолтой байна. Энэ үүднээс үзвэл Улсын болон бүс нутгийн эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой үйлдвэрүүдийн уналтыг зогсоох, үйлдвэрүүдийг сургээх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинэ технологи нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний чанарыг дэлхийн зах зээлд өрсөлдөх түвшинд хүргэх, импортоор авч байгаа зарим материал, түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэх явдал нь үйлдвэрийн салбарын тавигдаж буй томоохон зорилт болно.

**2. Улсын чанартай хотод дэвших магадлалтай хот, суурингууд.** Энэ бүлэгт Хангайн бүсийн Арвайхээр, Цэцэрлэг, Булган, Мөрөн зэрэг хотууд орж байна. Байгалийн төрх байдал, байгалийн баялаг, төмөр замын үндсэн 2 тэнхлэг дээр Арвайхээрээс, бусад нь оршиж байна. Бэлчээр, тариалан болон бусад зориулалтаар ашиглах бололцоотой эдэлбэр газрын нөөц их, Дулааны цахилгаан станц, ашигт малтмалын нөөцтэй зэрэг нь давуу тал болж байна.

Хөгжлийн сул дорой, газарзүйн байрлалын ашиггүй тал нь нэгдгээр бүлгийн үйлдвэрийн төвүүдээс алслагдсан, эдийн засгийн чадавхи багатай, эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломж багатай, түшиглэх гол үйлдвэрүүд нь зогсонги байдалд орсон, зах зээл эрчимтэй хөгжиж чадаагүй, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны зарим байгууллага, соёл үйлчилгээний газрууд тэр бүр төвлөрөөгүй болно.



Өөрийнхөө үндсэн бодит нөхцөл байдлыг зөв дүгнэн хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхойлж чадвал байгаа хүч бололцоон дээрээ оршин тогтнож хөгжих боломж бий. Түүнчлэн орон нутгийн хүн амын өсөн нэмэгдэж байгаа зах зээлийн хэрэгцээг хангах зорилгоор жижиг дунд үйлдвэрийг зах зээлийн өөрийн багтаамж дээр тулгуурлан хөгжүүлэх, тухайн суурингуудын хөгжлийг дэмжих чухал хөшүүрэг байх учиртай. Манай орны хувьд улсын чанартай гэгдэх хотуудаас бусад хөгжлийн гарааны ижил нөхцөлтэй гэж үзэх үндэслэлтэй.

**3.Орон нутгийн чанартай хот, суурин.** Энэ бүлэгт ихэнхдээ Хангайн бүсийн аймгийн төв суурингууд багтах бөгөөд эдгээрийн онцлог нь тухайн орон нутагтай харьцангуй давуу хөгжилтэй, нийгмийн ахуйн наад захын үйлчилгээтэй суурингууд юм. Хөгжлийн сул тал нь гол түшиг тулгуур болсон үйлдвэр аж ахуйн газрууд, ихэнхдээ сул зогссон, нийгмийн үйлчилгээний зарим үзүүлэлт туйлын хангалтгүй байгаа болно.

Улсын чанартай их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллага тэр бүр байхгүй, зөвхөн аймаг, орон нутгийн чанартай коллеж, хувийн ганц нэг сургуулиар хязгаарлагдаж байна. Эдгээр суурингуудын өмнө тулгараад буй зорилтууд юу болохыг тодорхойлбол, жижиг үйлдвэрүүдийг юуны өмнө микро эдийн засгийн түвшинд хөгжүүлэх нь хэрэглэгчдийн ойр үйлдвэрлэл явагдаж, хэрэглээний зах зээлийг тогтворжуулах явдал юм.

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтыг хамгийн ойр цэгт эхлэн боловсруулж, улмаар дараагийн шатуудад бүрэн боловсруулалт хийснээр орон нутгийн орлогод зохих хэмжээний хөрөнгө оруулалтыг оруулж болох юм. Орон нутгийн чанартай хот, суурингуудыг дараах үндсэн үзүүлэлтүүдээр авч ангилсан болно. **Үүнд:** Хүн амын тоогоор улсын болон орон нутгийн чанартай зам тээврийн үзүүлэлтээр, эрчим хүчний эх үүсвэр, хангамжаар, газар тариалан, мал аж ахуйн байршил, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байдлаар, мах комбинат, хөнгөн үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, уул уурхайн үйлдвэрүүд, металл боловсруулах үйлдвэрүүд, мод боловсруулах үйлдвэр гэсэн аж үйлдвэрийн үндсэн үзүүлэлт; боловсрол, эрүүл маэнд, сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол зэрэг нийгмийн дэд бүтцийн



үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж үзэхэд энэ бүлэгт багтах суурингууд ихэнх үзүүлэлтээр давхацсан буюу ойролцоо үзүүлэлттэй гарч байна.

**Эрчим хүчний эх үүсвэр, хангамж:** энэ бүлэгт багтаж буй Хангайн бүсийн суурингуудын нэлээд нь Төвийн эрчим хүчний системд, нөгөө хэсэг нь дизель, Дулааны цахилгаан станцууд байгаа болно.

**4.Орон нутгийн чанартай төвийн хэмжээнд дэвших магадлалтай хөдөөгийн суурингууд.** Энэ бүлэгт тус бүсийн сумын төв суурингууд, тэгэхдээ их замын тэнхлэг дайрсан Хангайн бүсийн сум дундын эмнэлэг болон сургуультай, эдийн засаг, нийгмийн зохих бололцоотой суурингууд хамрагдаж байна. Гэвч аймаг, сум, орон нутгийн чанартай, үйлдвэр, аж ахуйн газар, дизель цахилгаан станцууд нь улирлын чанартайгаар ажиллаж, зарим нэгэн салбар бүрэн зогссон зэрэг зах зээлийн хүндрэлүүд тохиолдож буй суурингууд юм.

Хүнийг бүх талаар хөгжүүлэгч анхдагч нөхцлийн нэг нь хүн амын хоол хүнс, тэжээлийн хангалуун байдал, орон сууцны хангамж юм. Энэ бүлэгт багтах Хангайн бүсийн нийт аймгийн суурингууд нь Монгол хүний уламжлалт сууц болох гэрээр бүрэн хангагдсан байдаг. Харин хөдөө орон нутагт хүн амын хоол хүнсэнд байх “калори”-ийн хэмжээ олон дахин дутмаг байгаа нь зайлшгүй хөгжлийн цаашдын асуудалтай холбоотой. Эдгээр сум аж ахуйн үйлдвэрийн салбарын хөгжлийг тэтгэхэд түүхий эдэд түшиглэх, дэд бүтцийг бий болгоход чухалчлан анхаарч үйлдвэрийн зохистой хүчин чадлыг хангах нь чухал юм. Жижиг дунд үйлдвэрийг бусад салбаруудтай нягт уялдуулан хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбараас авах ашиг нэмэгдүүлэн, хүн амын наад захын хэрэгцээг хангах шаардалагатай болно.

Томоохон хотууд руу шилжин суурьших явдлыг багасгахын тулд хөдөө дэх суурингуудын хүн амын амьжиргааны нөхцлийг сайжруулах, ажлын байр бий болгон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, орон сууны хангамжийг сайжруулж, үйлчилгээний түвшинг дээшлүүлж, засаг захиргааны хуваариас үйлчилгээний таталцалд шилжүүлэх шаардалагатай.

Энэ бүлгийн суурингуудын давуу тал нь сум болон хөдөөгийн суурингаас иргэдэд наанадаж нэг удаа, соёл, ахуйн үйлчилгээг шуурхай үзүүлж байх





чадавхитай байх явдал юм. Нөгөө талаар цаашид хот суурингуудад хөдөө аж ахуй, газар тариалан, ойн чиглэл, говийг усжуулах, элсний нүүлтээс хамгаалах зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээний газруудыг орон нутгийн шаардлагын үүднээс байгуулан ажиллуулах нь зүйтэй. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хүн амыг мэдээллээр хангах, цаг үеэ зөв мэдрэх зах зээлийн үйл ажиллагаанд суралцуулах талаар байнгын болон түр сургалтыг зохион байгуулж, сургалтын бааз бий болгон сургууль завсардалт зэрэг үзэгдлийг арилгах нь өнөө цагийн шаардлагаас зүй ёсоор урган гарч байна.

**5. 15,0 мянгаас доош оршин суугчидтай хөдөөгийн суурин.** Дүн шинжилгээнээс үзвэл Хангайн бүсийн бүх аймгуудын нийт сумуудын дийлэнх энэ бүлэгт орж байна. Сумын эмнэлгийн орон тоо, сургуулийн хүүхдийн тоо, тухайн сумын эрхэлдэг гол аж ахуй зэрэг үзүүлэлтэд дүгнэлт хийхэд зах зээлийн тогтолцооны өнөө үед тун хүндэвтэр байгаа суурингууд болно. Жишээлбэл: Газар тариалан эрхэлдэг бол тэр нь тодорхой хэмжээгээр уналтын байдалд орсон. Мал аж ахуй хувьчлагдан малчдын гар дээр очсон гэх авч, тодорхой жижиг аж ахуйн хэмжээнд өсөн хөгжиж чадахгүй, сумын төвийн төсвийн хэдхэн байгууллагаас бусад нь үнэн хэрэг дээрээ ажилгүй байгаа зэргээр тодорч байна. Үндсэндээ бүх сумууд нь өөрийгөө тэтгэх нийгмийн потенциал байхгүй, түүнийг бий болгох талаар дорвитой санал санаачилга гарахгүй байгаа зэрэг нь Монголын хөдөө дэх нийгмийн хоцрогдол болж байна.

Энэ нь нэг талаар зах зээлийн аясыг даагаагүй, нөгөөтэйгүүр засаг захиргааны нэгж жижгэрсэн явдал нь ийм байдалд хүргэх гол түлхэц болжээ. Улсын хэмжээний 108,0 мянган ардын аж ахуйтан өрхийн 10,0 хүрэхгүй хувь нь товаарын аж ахуйн шинжтэй байгаа нь нэлээд хүнд үзүүлэлт болно. Энэ бүхнээс үзэхэд энэ бүлэгт хамаарч байгаа Хангайн бүсийн суурингуудад уламжлалт болоод ямар нэгэн аж ахуйн хоршил холбоо туйлаас чухал болох нь харагдаж байна.

### **II.3.3. Төв байршлын хүрээллээр Хангайн бүсийн хот сууринг ангилах.**

Хангайн бүсийн хот суурингийн хөгжил байршилд нийгэм эдийн загсийн олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд эдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг тооцох, хөгжил




байршлын нийгэм эдийн засгийн потенциалыг үнэлж гаргах арга зүйн 2 үндсэн чиглэл байдаг ажээ. Эдгээрээс Хангайн бүсийн тухайд бид хоёрдох чиглэлийг судалгаандаа голлон баримталсан бөгөөд энэ арга зүйн тухай бага зэрэг дэлгэрүүлэн танилцуулъя. Одоогоос зуу гаруй жилийн тэртээ өмнөд Германы төв суурингуудын орон зохион байгуулалт, байршлын зүй тогтлыг судлан төв байршлын онолыг үндэслэсэн Немцийн эрдэмтэн Вальтер Кристаллер Төв байршлын маркетингийн, тээвэр газарзүйн, засаг захиргааны гэсэн гурван зарчмыг үндэслэжээ.

**1.Маркетингийн зарчим буюу 3-ын дүрэм.** Энэхүү зарчмын үндэс нь үйлдвэрлэл үйлчилгээний аль болох цөөн тооны төвөөр зах зээлийг жигд хуваан хамрах ингэснээр үйлдвэрлэгч хэрэглэгчдийн аль алиных нь эрх ашигт нийцсэн орон зайн зохион байгуулалт бүрдүүлэх явдал ажээ.

Энэхүү зарчимд үндэслэсэн хот суурингийн орон зайн зохион байгуулалт нь хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээ төвлөрсөн хот суурингийн нягтшил ихтэй улс орон бүс нутгуудад голлон илрэх бөгөөд энэхүү (, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59 дүгээр зураг) зүй тогтол нь аль нэг том эрэмбийн төв /хот суурин/ нь өөрөөсөө бага эрэмбийн 6-н төвийн /үүнийг тойрон орших/ зах зээлийг /үйлдвэрлэлийн болон үйлчилгээний бүхий л /гуравны нэг гэсэн харьцаагаар татан захирч ингэснээр тэрхүү жижиг эрэмбийн хоёр төвийн / $6 \cdot 1/3 = 2$ / бүтэн зах зээлтэй эквивалент зах зээлийг эзэмшихийн зэрэгцээ уг том эрэмбийн төвд дор хаяж нэг жижиг эрэмбийн төв бүтнээрээ багталцаж байдгийг нэмж үзвэл бүхэлдээ гурван жижиг эрэмбийн төвийн зах зээлийг бүрэн захирч байх зүй тогтолтой учир төв байршлын 3-ын дүрэм гэж томъёолжээ.




**ШИНЭ ХОТЫН ДАГУУЛ ТОСГОНЫ ХОТ  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН БҮТЦИЙН ЗАРЧИМ**



52 дугаар зураг.

**ТӨВ БАЙРШЛЫН ХҮРЭЭЛЛИЙН  
ЗАРЧИМ ( 1 )**



53 дугаар зураг


**ТӨВ БАЙРШЛЫН ХҮРЭЭЛЛИЙН  
ЗАРЧИМ ( 2 )**



54 дүгээр зураг




**ТӨВ БАЙРШЛЫН ХҮРЭЭЛЛИЙН  
ЗАРЧИМ ( 3 )**




55 дугаар зураг

**ТӨВ БАЙРШЛЫН ХҮРЭЭЛЛИЙН  
ЗАРЧИМ ( 7 )**



56 дүгээр зураг

**ТӨВ БАЙРШЛЫН ХҮРЭЭЛЭЛД ХАМРАГДАХ 2-3 РАДИУСЫН  
СУУРЬШЛЫН ЦЭГИЙН БАЙРШИЛ**




57 дугаар зураг






**ЗАСАГ ЗАХИРГААНЫ 2-3 ТӨВИЙГ  
ХОЛБОСОН ЭРЭМБИЙН ЗАРЧИМ**



58 дугаар зураг



59 дүгээр зураг






**2. Тээврийн зарчим буюу 4-ын дүрэм.** Том эрэмбийн хоёр төвийг холбосон тэнхлэг дээрх дундаж цэг нь дараагийн жижиг эрэмбийн /наад зах нь/ төв байршил үүсэх потенциалт цэг бөгөөд ихэвчлэн эдгээр цэгүүд дээр оршиж байгаа жижиг суурингуудын зах зээлийн талбайн тэрхүү хоёр төвд хоёрны нэгээр хуваагдан захирагдах шинжтэй байдгаас аль нэг том эрэмбийн төвийг тойрч байрших жижиг эрэмбийн 6 төв нь /Кристаллерийн 6 өнцөгтийн онолоор үүнийг тайлбарлаж байна/ уг том төвд хоёрны нэгээр ( 60 дугаар зураг) татагдах учир нэг том төв жижиг эрэмбийн 3-н төвийн зах зээлтэй эквивалент  $1/6 \cdot 1/2 = 2/$  түүн дээр өөрт нь багталцан буй нэг жижиг төвийн бүтэн зах зээлийг нэмж нийтдээ жижиг дөрвөн зах зээлийг захирах зүй тогтолтой учраас дүрэм гэж энэхүү зүй тогтлыг нэрлэжээ.

**3. Засаг захиргааны зарчим буюу 7-ийн дүрэм.** Засаг захиргааны нэг том төвийг тойрсон 6-н жижиг эрэмбийн төв бүгд 7 жижиг эрэмбийн төв нь уг том эрэмбийн төв бусдад хуваагдан захирагдахгүйгээр (61 дүгээр зураг) дангаар захирагдах учраас төв байршлын энэхүү зүй эдүгээ хүртэлх хугацаанд орон зайн зохион байгуулалтын зүй тогтлыг судлах талбарт хүчээ сорьсон судлаачид /А.Лёш, Изард, Давидович .В гэх мэт/ Кристаллерийн онолын олон тооны шинэчилсэн хувилбар нутаг орон бүрт анхдагч онол өнөө хир ач холбогдлоо алдаагүй гэдэг нь тодорхой байна.


Ийм ч учраас бид Хангайн бүсийн хот суурин газруудын хөгжил байршлын нийгэм эдийн засгийн потенциалыг тодорхойлох судалгаандаа Кристаллер ба түүнийг залгамжлагчдын ямар нэгэн хэмжээгээр сайжруулсан төв байршлын онол арга зүйг ашигласан болно. Ингэснээр өнөөдөр Хангайн бүсэд оршин буй... хот суурингийн эрэмбийг тодорхойлох тэдгээрийн харилцан захирагдах зүй тогтол /иерхи/-ыг илрүүлэхэд баримтлах шинжлэх ухааны үүднээс хийгдсэн цэгцтэй ангилал бүлэглэл алга байгааг харгалзан өнөөдөр мөрдөгдөж буй баримт бичиг болох “Монгол улсын хот тосгодын эрх зүйн байдлын тухай хууль”, “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-д заасан ангилал үндэслэлийг баримтлахаас өөр аргагүй байсныг тэмдэглэе.



**ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГ ТОМ ЭРЭМБИЙН  
ТӨВИЙН ТАТАЛЦЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ**



60 дугаар зураг



61 дүгээр зураг



Манай орны одоогийн хот суурин газрууд нь тус улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж удирдлагын бүтцийн өөрчлөлтийг даган хөгжил, байршил нь түүхэн үеүүдэд хувьсан өөрчлөгдсөөр өнөөг хүрч иржээ. 1931 оноос эхэлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлтөөс эхлээд 1942 он гэхэд тус улсын 18 аймаг байгуулагдаж энэ явцад тэдгээр аймгийн төвүүд одоогийн хуулиар орон нутгийн шинжтэй хотууд байршлаа олж хөгжиж эхэлсэн байна. Мөн 1960-аад он гэхэд тус улсад нэгдэлжих хөдөлгөөн дуусаж 300 гаруй сум, нэгдэл, сангийн аж ахуй байгуулагдсан нь сумын төв хэмээх жижиг суурин тосгодын үндэс суурь болжээ. 1970, 1980-аад онуудад тус орны үйлдвэржих хөгжилд олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжсөнийг дагаад үйлдвэрлэлийн чиглэлтэй /АҮ-ийн төв, зангилаа уул уурхайн үйлдвэрийн суурингууд/ Дархан, Эрдэнэт хот суурингууд байгуулагджээ.

Хангайн бүсийн хот суурингийн сүлжээ түүний үүрэг бүтцийн тогтолцоог авч үзвэл үндсэндээ төв байршлын засаг захиргааны зарчимд үндэслэсэн шатлан захирагдах /бие биендээ шатлан захирагдах/ нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай болох нь тодорхой байна. Энэ тогтолцоо бол, аймгийн төв, сумын төв, багийн төв гэсэн хот, суурин, тосгодын шатлан захирах, захирагдах засаг захиргааны зарчимд үндэслэж нэг том эрэмбийн төвд захирагдах жижиг эрэмбийн төвүүдийн харьцааг авч үзвэл дараах байдалтай байна.

1. Хангайн бүсийн 6 аймгийн төв буюу орон нутгийн чанартай хот
2. Хангайн бүсийн аймгийн төвүүдэд захирагдах сумын төвүүдийн харьцааг 3 бүлэг болгож үзэж болох бөгөөд үүнд 15-аас доош, 16-20, 21-ээс дээш гэж болох байна.
3. Нэг сумын төв түүнд ногдох багийн төв 4-өөс доош, 4-8, 8-аас дээш гэсэн 3 бүлэгт хуваагдах тогтолцоотой байна.

Эндээс үзвэл Хангайн бүсийн хүн ам, нутаг дэвсгэрийг засаг захиргааны удирдлагаар жигд хангах хамгийн хэмнэлттэй гэж үзэгдэж болох зохион байгуулалт өнгөрсөн засаг захиргааны хуваарийн үед бүрэлдсэн гэж дүгнэх бүрэн үндэстэй байна. Энэ утгаараа онолын талаас нь авч үзвэл 3, 4, 7-ийн дүрэмтэй



агуулга нэг юм. Хангайн бүсийн аймгийн төвүүдийн бүтцийг аваад үзсэн ч хүнс болон хөнгөн үйлдвэрийн зарим нэг жижиг салбарууд хүн амыг үйлчлэхтэй холбогдсон нийгмийн зохих шатны дэд бүтэц бүрэлдэж гол нь засаг захиргааны үүрэг давамгайлсан нэг үгээр хэлбэл орон нутагт үйлчлэх ойр зуурын эрэлт хэрэгцээг хангасан үйлчилгээний төвийн үүрэгтэй хөгжиж ирсэн нь хэнд ч тодорхой билээ. Мөн Хангайн бүсийн сумын төвүүд нь үйлдвэр үйлчилгээний хамгийн наад захын /доод шатны/ дэд бүтэц бүрэлдэн засаг захиргааны үүрэгтэй ихэвчлэн хүн амтай жижиг суурингууд болно.

Хангайн бүсийн аймгийн төвүүд болон сумын төвүүд нь социализмын үед нэг загвараар төлөвлөгдөж баригдсан архитектур хот байгуулалтын хувьд ч тэр, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин тэр ч бүү хэл хүн амын тоогоор ч тус бүрдээ хоорондоо ойролцоо /аль нэг хот сууринд үүссэн ямар нэгэн үйлдвэрийг эс тооцвол/ суурингууд болно. Ийм ч учраас аймгийн төвүүд нь хот байгуулалтын хөгжлийн нийгэм эдийн засаг болон түүхэн хүчин зүйлсийн нөлөөллөөр төстэй хөгжлийн гарааны ижил нөхцөлд байгаа гэж үзэх боломжтой.

Жижиг суурин тосгодын ангилалд багтаж байгаа Хангайн бүсийн сумын төв, жижиг суурин газрууд нь мөн л хот суурингийн хөгжлийн гарааны ижил доод түвшинд байгаа юм. Энэ бүгдийг дурьддагийн учир нь Хангайн бүсийн хот суурингийн үндсэн дийлэнх хувийг эзэлж /тооны хувьд/ эдгээр төв суурингуудыг үйлдвэржилтийн бааз, чиглэл, хэмжээ, дэд бүтцийн хэмжээ, төрөл зэрэг нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлсийн тус бүрд нь нарийвчлан үзэх онцын шаардлагагүй гэдгийг харуулахын зэрэгцээ статистик хомсыг харгалзан тийм нүсэр анализ хийхээс зайлсхийснийг тэмдэглэж байгаа юм.

Хангайн бүсийн аймгийн төв тус бүрийг үйлчилгээний хүрээний 50, 100, 150 км-ын радиусаар ялган эдгээр хүрээнд хамрагдах жижиг суурингуудын төвд таталцах таталцааны төрөл эрчмийг ялган үзэхэд 50 км-ын радиусын бүс нь /1 цагийн зай/ таталцлын төрлөөрөө нийгэм эдийн засгийн өдөр тутмын буюу байнгын, түүнчлэн улирлын шинжтэй үйлчилгээнд хамрагдаж байх онцлогтой байхад 50-100 км-ын радиус дахь бүс нь /2 цагийн зай/ ихэвчлэн улирлын шинжтэй төвийн үйлчилгээнд хамрагдаж байх онцлогтой байна. Харин 100-150 км-ын



түүнээс цааш радиуст алслагдсан суурингууд нь төвд хүрэлцэх орон зай эсэргүүцлийнхээс шалтгаалан таталцлын хүч султай засаг захиргааны мөн эдийн засгийн алдаг оног үйлчилгээнд өртөгдөж байдаг ажээ.

Бид аймгийн төв тус бүрийн хүн ам дээр 50 км-ын радиуст хамрагдах жижиг суурингуудын хүн амыг нэмж ийнхүү том төв ба түүний эрчимтэй таталцлын хүрээн дэх хүн амын тооны потенциалыг гаргаж энэ үзүүлэлтээр аймгуудыг бүлэглэж үзэхэд 20-30 мянган хүн ам бүхий потенциалтай бүлэгт Хангайн бүсээс Булган, харин 30-40 мянган хүн ам бүхий потенциалтай бүлэгт Хангайн бүсээс хот суурин байгаагүй бөгөөд хэт дээгүүр бүлэглэлтэй Орхон-Уул, аймаг байгаа нь эдгээр хот суурингууд орон нутгийн гэхээсээ улсын чанартай хот суурингууд болохыг гэрчилж байна. Энэ үзүүлэлт өндөр байх тусам мэдээж утгаараа тухайн суурин цаашид үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрүүлэн мөн ч хүн амын шилжих хөдөлгөөнийг өөртөө татах харьцангуй өндөр потенциалтай байгаа гэдэг нь ойлгомжтой юм.

Бидний энэхүү анализын дүнд гарсан төв түүний эрчимтэй таталцлын бүс дэх хүн амын потенциал гэсэн үзүүлэлтийн утга өндөр гарсан суурингууд нь бусад суурингуудаасаа хөгжлийн нэг эерэг хүчин зүйлсээр давуутай гэсэн үзлийг энд баримталсан болно. Ингэхлээр төвийн таталцлын 2 болоод 3-р радиуст хамрагдаж байгаа суурингуудын энэхүү үзүүлэлтийн эерэг нөлөөллийн утга шат дараалан буурч байна гэсэн үг болно. Үүнээс гадна хоёр болоод түүнээс олон төвүүдийн таталцлын янз бүрийн радиуст бүсүүд хоорондоо давхцах энэ утгаараа тэр давхцлын жижиг бүс дэх суурингууд нь хэд хэдэн төвийн ямар нэгэн нөлөөлөлд өртөгдөх боломжтой дараах хувилбарууд байна. Үүнд:

1. Хоёр том төвийн 1-р радиусын бүсүүд давхцан огтлолцсон сегментүүд дэх жижиг суурингууд үндсэндээ төв байршлын 4-ийн дүрэмд захирагдсан байршлын онцлогтой болно. Жишээ нь Эрдэнэт-Булганы 1-р радиусын бүсүүд хоорондоо давхцаж давхцлын сегментэд нь нэгээс хоёр жижиг суурин хамрагдан хоёр том төвдөө нийгэм эдийн засгийн хувьд тэнцүү хүчтэй татагдах зүй тогтол ажиглагдаж байна.





2. Үүнээс гадна аль нэг төвийн нэгдүгээр радиус нь нөгөө төвийн 3 болон 2-р радиустай огтлолцож байгаа хувилбар байгаа бөгөөд эдгээрээс 1, 2-р радиусын огтлолцлын сегмент дэх жижиг суурингууд нь нийгэм эдийн засгийн хувьд 1-р радиусаар хамарч байгаа төв рүүгээ харьцангуй илүү татагдах, нөгөө талаар 2 радиус руу хамарч байгаа төв рүүгээ холбогдох харьцангуй давуу байдалд оршиж байна. Тухайлбал, Эрдэнэт-Булганы, Дархан-Эрдэнэтийн гэх мэт

3. Хоёр болоод түүнээс дээш төвүүдийн 2-р радиусууд давхцсан сегмент дэх жижиг суурингууд нь 4 болон 3-ын дүрмийн зүй тогтолд захирагдсан байршилтай байгаа бөгөөд таталцлын хувьд аль аль төв рүүгээ сул тэнцүү татагдах /нийгэм эдийн засгийн хувьд/ онцлогтой байна.

4. Зөвхөн 3-р радиус болон 2, 3-р радиусуудын давхцал дээр үүссэн сегментүүд байрлах нийгэм эдийн засгийн таталцлын хувьд нэлээд сул аль хүчтэйгээр аль аль төвүүд лүү хандах чиглэлтэй байна.

5. Орон нутгийн чанартай хотын түвшингийн төвүүдийн 3-р радиусад хамрагдаагүй өөрөөр хэлбэл орон нутгийн төвүүдээс нэн алслагдсан жижиг суурингууд нь нийгэм эдийн засгийн төдийгүй засаг захиргааны удирдлагын хувьд ч ихээхэн алс зэлүүд шинжтэй байгаа ба үүнд Хангайн бүсийн Баянхонгор, Ховд, аймгийн нэлээд олон сум хамрагдаж байна. Энэхүү таван бүлэг хамрагдаж байгаа жижиг суурин тосгодууд нь харьцангуй том төвийн /аймгийн төв, улсын чанартай хот суурин/ нөлөөллийг хүртэх потенциалаар ялгаатай энэ ч утгаараа нийгэм эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлсийн эерэг нөлөөллөөр ялгаатай байгаа учир эхний хоёр бүлэгт хамрагдах суурингууд давуу бололцоотой бусад нь ийм боломжоор дутмаг байгаа нь тодорхой байна.

Хангайн бүсийн хот сууринаас таталцалын ерөнхий бодит байдлыг авч үзэхэд ийм байна.



## **ДӨРӨВ. ХАНГАЙН БҮСИЙН ХОТ СУУРИНЫ ЭДЭЛБЭР ГАЗРЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ ХӨРСНИЙ ШИНЖ ЧАНАР.**

**II.4.1 Хангайн бүсийн хот суурины инженер геологийн нөхцөл.** Хангайн бүсэд манай улсын зургаан аймаг, 112 сум хамрагдах бөгөөд улсын нийт хүн амын 22% буюу 560 гаруй мянган хүн ам оршин суурьшдаг. Хангайн бүс улсын нийт нутаг дэвсгэрийн 25,6%, ойн нөөцийн 40,0%, гадаргын усны 35,2%, ашиглаж болох боломжтой газар доорхи усны 50,5% нь ноогддог. Усны нөөцийн хувьд Архангай, Хөвсгөл, аймгууд их байхад Баянхонгор, Өвөрхангай аймгуудад нөөц багатайд тооцогддог.

Хангайн бүсэд манай улсын нийт ойн сангийн 47,8% нь ногдож байгаагаас гадна 4760,2 мян.га талбайг эзэлсэн 11 тусгай хамгаалалттай газар нутаг байдаг ба энэ нь хангайн бүсийн нийт нутаг дэвсгэрийн 12,4%-ийг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 23,3%-ийг тус тус эзэлдэг Хөвсгөл, Булган аймаг ойн нөөцөөр хангалттай юм.

Хангайн бүс нь байгаль цаг уур, газарзүйн тааламжтай нөхцөлд оршдог бөгөөд ургамал, амьтны аймгаар баялаг. Хүн амын олонтой, төвлөрөл ихтэй тул хүний сөрөг үйл ажиллагаанаас, шалтгаалж амьтан ургамлал устгах бэлчээр талхлагдах, гол ус ширгэж, бохирдох, хөрсний эвдрэл гэмтэл нэмэгдэх, цөлжих үзэгдэл үйл явц идэвхжих зэрэг олон сөрөг нөлөө сүүлийн үед ажиглагдах болсон.

Хангайн бүс байгалийн нөөц баялаг ихтэй бүсийн хэмжээнд 150 төрлийн орд илэрцүүд байгаа бөгөөд Тавтын алтны, Сайхан голын төмөр-магний, Бүрэнхааны фосфоритын, Дөшийн гол, Өвөр мараатын хөнгөн цагааны, Эрдэнэтийн зэс-молибдений томоохон ордуудад орж байна.

Хангайн бүсийн нутаг дэвсгэр гидрогеологийн мужлалаар Увс нуурын, Хөвсгөл орчмын, Хангайн, Сэлэнгийн, Нууруудын хөндийн мужуудыг дамнан байрладаг. Инженер-геологийн хувьд Хөвсгөл-Сэлэнгийн, Их уулын, Булнайн, Хангайн-Тарвагатайн, Орхон-Сэлэнгийн, Өндөршилийн мужуудад багтдаг ажээ.




Бүсийн хэмжээнд дээд палеозой, доод мезозойн настай базальт, трахи-базальт, трахи-андезит зэрэг бялхмал чулуулгын төрөл, мөн насны гранит, лейкограни, гранодиорит, сиенит зэрэг гүний чулуулагууд түгээмэл тархалттай байна.

Олон жилийн цэвдэгийн хувьд үргэлжилсэн ба тасалданги, элбэг болон ховор алаг цоог тархалттай хөрс зонхилно. Эдгээр хөрс нь уулын ар хажуу, гол мөрний хөндий ёроол орчмоор 100-500м-ийн зузаантай, 1,5-3,5 град, уул нуруудын хөндий хонхор хотосуудаар дунджаар 50-100 м зарим хэсэгтээ 400-800м-ийн зузаантай 0,5-/-1,5/ град-ын температуртай байдаг байна.

**Нутаг дэвсгэрийн хурдас, чулуулгийн геотехникийн шинж чанар.**

**Байран /элювий/ хурдас.** Энэ ул хөрс нь Хөвсгөл, Хэнтийн шовх оройтой уул нуруудын орой, бэлийн хэсгээр ихэвчлэн 2,0-2,5 м, Хангай нуруу болон бусад нутгийн хавтгай оройтой уул нуруудаар (62 дугаар зураг) хурдасны зузаан 3,5-5,0 м хүрдэг байна. Эдгээр хурдас чигжээсгүй, хайр хайрга, сул хаднаас тогтдог ажээ. Том хэмхдэсийн агуулга, тэдгээрийн хэмжээ зүсэлтийн гүн хэсэгтээ нэмэгдэж үндсэн чулуулгад ажимдаа шилждэг байна. Байран хурдас нь Хангайн бүсэд бүх төрлийн чигжээстэй том хэмхдэст хөрсний төрлөөр зонхилон илэрдэг.



**62 дугаар зураг**



Байран хурдасны найрлага дахь хэмхдэс материалын өгөршлийн зэрэг ихэвчлэн 0,55-0,95, хөрсний сүвшлийн илтгэлцүүр 0,55-0,95, эзэлхүүний масс  $2,38 \text{ г/см}^3$ - $2,71 \text{ г/см}^3$  хам байдал 0-0,65, чийгшлийн зэрэг 0,2-0,8 хэмжээнд хэлбэлздэг байна.

**Бэл, хормойн /Делюви, пролюви/ хурдас.** Хангайн бүсийн уулын бэл, хормойн хурдасны хэмхдэс материалын агуулга, хэмхдэсийн диаметрийн хэмжээ хурдасны дээд хэсгээс гүн уруугаа аажим ихсэх байдлаар илэрч хөрсний бүтцэд хэмхдэсийн хэмжээ 50%-90% -д хүрдэг байна. Бэл хормойн хурдасны зузаан ихэвчлэн тухайн бүсэд 3-9 м-ийн зузаантай байх боловч өндөр уул нуруудын хормойн хэсэг голын хөндий болон талархаг газартаа 7-9,5 м, зарим хэсэгтээ бүр 15м зузаантай тохиолддог байна.

Бэлийн гаралтай хөрс ихэвчлэн том хэмхдэст хөрсний нэр төрөл, ангиллаар илэрдэг байна. Хэмхдэс материал нь голдуу хайр, хайрга, заримдаа үхэр чулуу /глыб/ багавтар хэмжээгээр агуулсан байна. Энэ хурдас нь боржин чулуулагаас үүссэн модгүй уулын бэлээр өргөн талбайг эзлэн тохиолдох бөгөөд бат бэх чанар сайтай, ихэвчлэн 2-6м, түүнээс их зузаантай тохиолдох нь элбэг ажээ.

Хормойн гаралтай ул хөрс бусад гарал үүслийн хурдаснаасаа хэмхдэс материалын ялгарал муутай, хэмхдэсүүд нь муу мөлгөржсөн, талбайн болон гүний тархалтаараа найрлага, шинж чанар нь тогтворгүй, огцом өөрчлөгддөг, линз маягийн хэвтэй үелэл бүхий тогтоцтой зэрэг онцлогуудтай байна. Хэмхдэс материалуудын зөөгдөх үйл ажиллагаа нь урсацын хэлбэр далайцаас хамаарч тухайн гарал үүсэлтэй хөрсний найрлага, шинж чанар, бат бэхийн үзүүлэлтүүд нь хоорондоо ихээхэн ялгавартай тогтоогдсон байна.

Хангайн бүсийн бэл хормойн хурдсанд бат бэх шинж чанартай элсэнцэр шавранцар, элсэн хөрс зонхилно. Уг хөрсний зузаан уулс хоорондын хотгор, хонхор хэсгээр байрлаж буй хот суурин газруудын нутаг дэвсгэрт 15-30м, бусад газруудад байрлаж буй хот суурин газруудын нутаг дэвсгэрт 10-20 метрийн зузаантай илэрч байна.



**Алювийн гаралтай том хэмхдэст хөрс.** Гол мөрний гаралтай том хэмхдэст хурдас нь Хангайн бүсийн аймгуудын нутаг дэвсгэрт байгаа томоохон голуудын сав, хөндий, дэнж, татмын хэсгээр түгээмэл тархалттай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 50 орчим хувийн эзлэн тархсан байна.

Судалгаанаас үзэхэд уг хөрсний дундаж зузаан 8-11 м орчим, ерөнхий зузаалиг нь гол мөрний дэнжийн хэсгээр 25-45 м түүнээс ч их зузаантай илэрэх боловч голын дэнж нь өндөр уул нуруудын бэл, хормойд шилжих заагаар зузаалиг нь багасаж 3-6 м болдог бөгөөд мөн хэсгээр дээд хэсгээрээ үл ялиг зузаантай бэл хормойн хурдасаар хучигдсан тогтоцтой байна.

Энэ хөрс нь Хангайн бүсийн томоохон гол, мөрөн нуурын эрэг, дэнж дэхь хот суурины нутаг дэвсгэрт хийсэн судалгаанаас үзэхэд тухайн гаралтай үл хөрсний физик шинж чанар нь хөрсний эзлэхүүний массын хувьд  $1,95-0,25 \text{ г/см}^3$ , хэмхдэст материалын агуулга 50-95%, байгалийн чийг 0,095-0,25, хэмхдэст материалын өгөршилтийн зэрэг 0,05-0,15 байна. Энэ үзүүлэлтийг барилга байгууламжид тооцож ашиглах учиртай.

**II.4.2 Хангайн бүийн нутгийн газар хөдлөлийн үйлчлэл ба геотехникийн нөхцөл.** Хангайн бүсийн хот суурингууд нь Монгол орны газар хөдлөлтийн идэвхтэй хэсэгт буюу 7-10 баллын бүсэд байрладаг. Нийт сум суурины 19 нь буюу 20,9% нь 7 баллын бүсэд, 41 нь буюу 47,2 % нь 8 баллын бүсэд, 27 нь буюу 29,7% нь 9 баллын бүсэд, 2 нь буюу 2,2% нь 8-10 баллын бүсэд оршино.

Хангайн бүсийн хот, бусад олон сум, суурин газрын олон жилийн цэвдэг болон овойлттой хөрс тархсан газарт байрласан тул геотехникийн хүндрэлтэй нөхцлийг дараах байдлаар тайлбарлаж байна. Үүнд:


**Нэг.** Архангайн аймгийн нутаг дэвсгэрт хөрсний ус 1.2-1.3 м-ийн гүнээс илэрдэг. Газар хөдлөлтийн 8, 9 баллын бүсэд оршдог. Хүчтэй овойлт үүсгэх шаварлаг хөрс зонхилон тархсан (63 дүгээр зураг). Төвийн зарим хэсгээр намагжих процесс идэвхитэй явагдаж байгаа онцлогтой. **Хоёр.** Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр нь: Олон жилийн цэвдэг хөрс 1.5-1.8, 2.4-2.8-3.0 м-ийн гүнээс илэрч тэр нь 170-200 м-ийн зузаантай тохиолдоно цэвдгийн дээр устай. Мөсжилт ихтэй тул хүчтэй суулт





үүсгэдэг. Газар хөдлөлтийн 8-9 баллын бүсэд оршино. Гэсгээхгүй зарчмаар барилга барих нь илүү тохиромжтой. Шаварлаг хөрс тархсан газраар хүчтэй овойлт үүсгэдэг. Хадан хөрс гадаргууд ойр илрэх тул жигд бус суулт үүсгэх магадлалтай. **Гурав.** Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт олон жилийн цэвдэг хөрс 2.2-2.4 3.1-3.6 (64, 65, 66 дугаар зураг )м-ийн гүнээс илэрч 120-250 м-ийн зузаантай тархсан. Зарим тохиолдолд 40 м-ийн зузаантай тархсан байдаг. Цэвдгийн дээр устай. Мөсжилт ихтэй тул хүчтэй суулт үүсгэдэг. Гэсгээхгүй зарчмаар барилга барих нь илүү тохиромжтой. Шаварлаг хөрс тархсан газраар хүчтэй овойлт үүсгэнэ. Гэсгээхгүй зарчмаар барилга барих нь илүү тохиромжтой.


Монгол орны хөөлтэй хөрсний мужлалын зураг



63 дугаар зураг




МОНГОЛ ОРНЫ ОЛОН ЖИЛИЙН ЦЭВДЭГ ХӨРСНИЙ ТАРХАЛТЫН КАРТ



64 дүгээр зураг


МОНГОЛ ОРНЫ ОЛОН ЖИЛИЙН ЦЭВДЭГ ХӨРСТЭЙ БҮС НУТАГТ  
БАРИЛГА БАРИХ ЗАРЧМИЙН СОНГОЛТ ХИЙХ КАРТ



65 дугаар зураг



МОНГОЛ ОРНЫ СУУМТГАЙ УЛ ХӨРСНИЙ ТАРХАЛТЫН КАРТ



66 дугаар зураг

**II.4.3 Хангайн бүсийн хот, суурины инженер геологийн нөхцөл, ул хөрсний геотехникийн шинж чанар: Баянхонгор хот.** Баянхонгор хот нь Монгол орны физик газарзүйн муж мужлалаар говийн Их мужийн Алтан ар говийн хэсгийн хангайн өмнөд тойрогт багтаж, Хангайн нурууны өвөр хажуугаас эх авдаг Түйн голын татмын дэнж дээр буюу Номгон уулын баруун хойно байрладаг.

Хотын эргэн тойронд 2041-2300 метрийн үнэмлэхүй өндөртэй, хүчтэй хэрчигдэлд орсон уул нурууд орших бөгөөд хот байрлах орчины голын хөндийн хэсэгийн далайн төвшингөөс дээшхи үнэмлэхүй өндөртэй нь 893-1857 м гэж тооцогддог.

Хотыг хүрээлж буй эдгээр уул нуруудын эдгээр системд морфологийн 2 үндсэн хэв шинж зонхилно. Үүнд:

-Дунд зэргийн өндөртэй, хавтгай дуу оройтой, хэрчигдэлд идэвхитэй орсон 2040-2200 м-ийн үнэмлэхүй өндөртэй уул нуруудын төрөл.




-Дунд зэргийн өндөртэй, хавтгай оройтой, хэрчигдэлд багавтар хэмжээгээр орсон, 2200-2400 м-ийн үнэмлэхүй өндөртэй, морфологийн хувьд тэгш хэм байдалтай уул нуруудын төрөл.

Баянхонгор хот нь байрлаж буй Түйн голын татам, татмын дээрхи дэнж нь харьцангуй тэгш байдалтай, усны урсгалаар хэрчигдэж үүссэн 0.5-2.0 м-ийн гүнтэй өргөн нь 2.0 м хүрдэг олон (67 дүгээр зураг) тооны хуурай сайруудтай юм. Татмын дээрхи дэнж нь хойноосоо урагшаа хэвгий тогтоцтой далайн түвшинээс дээш 1870-1890 м-ийн өндөртэй. Аймгийн төвийн дэргэдүүр Хангай нуруунаас эх авсан, гадагшаа урсацгүй ай савд багтдаг, 243 км урттай Түйн гол урсаж Орго нуурт цутгана. Голын хөндийн үндсэн тогтолцоо нь хайрцага хэлбэртэй бөгөөд гол нь 2.3 км урттай. Голын ус цуглуулах нийт талбай 4110 км<sup>2</sup> бөгөөд хотын ойролцоо усан сүлжээний нягтшил 0.021км/м<sup>2</sup> болж доошлохдоо аажмаар буурна. Голын усны уналтын урт 1700 м бөгөөд голын гүн нь дунджаар 0.5-1.5 м, хамгийн гүн хэсэгтээ 3.0 м хүрнэ. Гол ерөнхийдөө цэнгэг устай тул бүх зориулалтаар ашиглах боломжтой.





**ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН КАРТ**  
Баянхонгор хот



**Таних тэмдэг**

- Литологийн ил хил зааг
- Литологийн далд хил зааг
- 2,3-р үеийн Литологийн багана
- Сайр /Pk=5000-7500 о.м.м/
- Элсээр чигжигдсэн сайр /Pk=1500-3200 о.м.м/
- Үндсэн чулууны өгөршлийн бүс /Pk=1000-1200 о.м.м/
- Хайр, хайрга агуулсан элсэндэр /Pk=280-500 о.м.м/
- Сайр, сайрга агуулсан тосорхог элс /Pk=460-850 о.м.м/
- Элсэндэрээр чигжигдсэн сайр /Pk=500-1400 о.м.м/
- Ул хөрс /Pk=120-400 о.м.м/

67 дугаар зураг





Хотын нутаг дэвсгэрт силур, Девоны настай төрөл бүрийн занар, элсэн чулуу, алеролит, аргиллит болон Дөрөвдөгчийн настай аллюви, аллюви-пролюви, элюви-делювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасууд тархсан байдаг.

Дунд-дээд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас нь Түйн голын татам, татмын дээрхи дэнжээр элсээр чигжигдсэн том хэмхдэст хөрсний төрлөөр илрэх бөгөөд 30.0-50.0 м-ийн дундаж зузаантай илэрдэг ажээ.

Аллюви-пролювийн хурдас голын дэнжийн хэсэг, Номгон уулын хормой хэсгээр 0.5-1.0 м орчим зузаантай илэрдэг элсэнцэр хөрсний нимгэн үеүд агуулсан төрөл бүрийн элсэн болон хйаргархаг элсэн хөрсний төрлөөр илэрдэг. Тухайн хурдасны нийт зузаан 8.0-15.0 м байдаг.

Элюви-делювийн хурдас нь уул толгодын орой хажуугаар 1.0-2.0 м-ийн зузаантайгаар саарал өнгийн элсэнцрээр чигжигдсэн хайрган хөрсний төрлөөр илэрдэг байна.

Хотын нутаг дэвсгэрт орчин үеийн дөрөвдөгчийн, дунд-дээд дөрөвдөгчийн хурдас болон янз бүрийн насны тунамал хувирмал чулуулгын ан цавын гэсэн 4 төрлийн уст үе илэрдэг.

Орчин үеийн дөрөвдөгчийн хурдасны уст үе нь хотын нутаг дэвсгэрт тархсан газар доорхи усны ихэнх хэсэг нь болох бөгөөд хур тунадасны болон Түйн голын усаар тэжээгдэнэ. Энэ төрлийн усанд Түйн голын татам хэсгээр хэд хэдэн булаг үүсгэх хэлбэрээр газрын гадаргууд илэрч гардаг бөгөөд тэдгээр нь дунджаар 0.5-0.4 м/сек ундратай, цэвэр, цэнгэг ус байдаг ажээ.

Дунд-дээд дөрөвдөгчийн хурдасны уст үе нь Түйн голын дэнжээр тархана. Хур тунадас, Түйн голын ус, мөн тектоник хагарлын ан цавын усаар тэжээгддэг ажээ. Газрын гадаргуугаас ихэнхдээ 2.0-3.5 м-ийн гүнээс илэрдэг, 1.3-1.4 м/сек-ийн ундратай.

Дунд девоны настай тунамал чулуулгын ан цавын ус нь хотын хойд хэсгээр аллювийн хурдасны доороос хоёр уст үе хэлбэрээр илэрдэг бөгөөд ус агуулагч



чулуулаг нь элсэн чулуу, алеролит, аргиллит байдаг. Уг ус нь 1.2-1.5 л/сек-ийн ундрагатай, гидрокарбонат-кальцийн төрлийн найрлагатай гэж тогтоогдсон.

Доод силурын настай ан цавын ус нь хотын төв болон баруун, баруун өмнөд хэсгээр тархах бөгөөд ус агуулагч чулуулаг нь ногоон саарал өнгийн занар, полимект элсэн чулуу байдаг. Усны ундрага нь 0.5-1.5 л/сек, гидрокарбонатай-кальцийн төрлийн найрлагатай.

Хотын нутаг дэвсгэрт тектоник-элэгдлийн, хуримтлалын, элэгдэл-хуримтлалын гэсэн рельефийн 3 төрөл байдаг, Тектоник-элэгдлийг гадаргууд хэрчигдэл, идэгдэлд бага орсон, хавтгайдуу оройтой, 2041-2203 м-ийн өндөртэй уул нурууд, уулс хоорондын хуримтлалын гадаргууд тэгш тал, толгодорхог хэлбэрийн 1852-1960 м-ийн харьцангуй өндөртэй уулс хоорондын хотгор, элэгдэл-хуримтлалын гадаргуйд Түйн голын татам, татмын дээрхи дэнж тус тус хамаарагдана.

**II.4.4 Хангайн бүс нутгийн геотехникийн нөхцөл.** Геофизикийн судалгаагаар Хангайн бүсийн нутаг дэвсгэрт элсээр чигжигдсэн сайрган хөрс өргөн тархалттай бөгөөд 3-7 м-ийн дундаж зузаантай байдаг. Хотын эдэлбэр газрын өмнөд ба төв хэсгээр 1,9-10,0 м-ийн гүнээс илэрч 4,0-10,0 м-ийн зузаантай байдаг. Харин элсэнцэрээр чигжигдсэн сайрган хөрс хотын төв ба баруун хэсгээр элсээр чигжигдсэн сайргархаг хөрсний доороос илэрч 0,5-2,5 м-ийн зузаантай, тогтсон бол хайргархаг элсэн хөрс нь хотын баруун ба баруун хойд хэсгээр үндсэн чулуулаг болон элсээр чигжигдсэн сайрган хөрсний дээр 1,0-5,0 м-ийн зузаантай, тоосорог элсэн хөрс нь хотын баруун хойд хэсгээр ихэвчлэн өнгөн хөрсний доороос илэрч 1,5-3,0 м-ийн зузаантай байдаг ажээ.

Элсээр чигжигдсэн сайрган хөрсний чигжээсэнд шүүрэлтийн итгэлцүүр 0,75 м/хоног, байгалийн нөхцөлдөө 63 м/хоног, байгалийн нуралтын өнцөг хуурай нөхцөлдөө 27 град, усан дотор 30 град, хайргархаг элсэн хөрсөнд шүүрэлтийн коэф 0,5 м-ээс жижиг хэсгийн агууллаганд 1,0 м/хоног, байгалийн нөхцөлдөө 43 м/хоног, байгалийн нуралтын өнцөг хуурай нөхцөлдөө 35 град, усан дотор 35 град, чийг багтаамж 15,3 хувь байдаг нь судалгаагаар тогтоогджээ.



**Баянхонгор хотын геотехникийн тогтолцоо:** Хотын нутаг дэвсгэрийг үндсэндээ инженер-геологийн энгийн нөхцөлтэй. Элсээр чигжигдсэн сайрган хөрс, хайргархаг элсэн хөрс, тоосорхог элсэн хөрс, элсэнцэрээр чигжигдсэн сайрган хөрс байгалийн нөхцөлдөө овойлтгүй тогтолцоотой юм.

Хөрсний ус голын татмын хэсгээр 0,5-2,0 м, хотын төв хэсгээр 2,0-5,0 м, төвийн хойд болон өмнөд хэсгээр 5,0 м-ээс доош гүнд тус тус илрэх бөгөөд энэхүү түвшингөөсөө 0,3-0,5 м-ээр тус тус дээшилдэг ажээ. Хөрсний улирлын хөлдөлтийн гүн 3,4-3,9 м-ийн гүнд явагдадаг байна.

**Эрдэнэт хотын инженер-геологийн нөхцөл ул хөрсний геотехникийн шинж чанар.** Эрдэнэт хот нь Хангайн Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужид хамаарагдах Орхон голын хойт талын бэсрэг уулсын дүүрэгт байрладаг. Хот байрлаж байгаа уулс хоорондын хөндийн өргөн дунджаар 1-2 км бөгөөд хотын орчимд буюу голын уулзварын бэлчир орчмоор 4-5 км болж өргөсөнө.

Хотын орчмын хамгийн өндөр цэг нь Хэнтий нурууны хойт хэсэг болох Согоот уулын оргил бөгөөд 1711 м, хамгийн нам дор цэг нь хотын зүүн хойт хэсэг буюу Хангалын голын хөндийд 1146,5 м байна. Голын хөндийгөөс уулын орой хүртэл харьцах өндрийн зөрүү 400-600 м байдаг. Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаргуугын үнэмлэхүй өндөржилт 1510-1190 метрийн хооронд хэлбэлзэдэг.

Хотын нутаг дэвсгэрт гүний усны нөөц харьцангуй бага боловч Хангал, Эрдэнэт, Говил, Зуны гол зэрэг жижиг гол, горхинууд элбэгтэй. Эдгээрээс хамгийн том нь буюу хотын хэрэгцээнд хамгийн их ашиглагдаг нь Хангал, Эрэднэтийн голууд юм. Хангалын голын ус цуглуулах талбай 268 км<sup>2</sup>, голын нийт урт 55,9 км, гульдрилын өргөн хотын орчимд 15-20 м, татмын өргөн 150-300 м, эргийн өндөр 0,5-1,0 м, гүн нь 0,3-0,8 м, урсгалын хурд 0,4-1,0 м/сек байдаг.

Эрдэнэт голын ус цуглуулах талбай 99 км<sup>2</sup>, голын нийт урт 7,5 км, голын дундаж хэвгий 6,2%, гульдрилын өргөн 1,0-4,0 м, эргийн өндөр 1,0-1,5 м, усны урсгалын дундаж хурд 0,2-0,5 м/сек, гүн нь 0,2-0,5 м байна. Дээрхи голуудын ус химийн найрлагын хувьд гидрокарбонат-сульфатын төрөлд хамаарагдана. Хотын



нутаг дэвсгэрийн хэмжээнд (68 дугаар зураг) дараах төрлийн ул хөрс түгээмэл тархалттай байна. Үүнд:

-Ангилалдаагүй дөрөвдөгчийн настай байран хурдас энэ хөрс Баян-өндөр, Эрдэнэт, Говилын уулуудын оройн хэсгээр харьцангуй өргөн тархана. Найрлагын хувьд хэмхдэс материал их хэмжээгээр агуулсан шаварлаг төрлийн хурдас байх бөгөөд дунджаар 0,5-5,0 м-ийн зузаантай илэрнэ.

-Дунд дөрөвдөгчийн настай аллюви, аллюви-пролювийн хурдас энэ хөрс Эрдэнэт, Говил, Хангалын голын хөндий, татам, дэнжийн хэсгээр бул чулуу агуулсан шаварлаг материалаар чигжигдсэн том хэмхдэст хөрсний төрлөөр илэрч 15-25 м-ийн зузаантай тохиолдоно.

-Дээд орчин үеийн дөрөвдөгчийн настай делюви, пролювийн хурдас энэ хөрс Эрдэнэт, Баянөндөр, Согоот уулын бэл, хормой, Эрдэнэт болон Хангалын голын дэнжийн хэсгээр хэмхдэс материал их хэмжээгээр агуулсан элсэнцэр шавранцар хөрсний төрлөөр 10-20 м-ийн зузаантай тохиолдоно.

-Орчин үеийн настай пролювийн хурдас энэ хөрс голуудын хөндий, уул нуруудын хормойд шилжих хэсгээр хушуурсан туугдас хэлбэрээр, хэмхэс материал багавтар хэмжээгээр агуулсан элсэнцэр шавранцар хөрсний төрлөөр илэрч 2-10 м хүртэл зузаантай тохиолдоно.








# ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛИЙН ЗУРАГ

## Эрдэнэт хот

Зураг 68

### ТАНИХ ТЭМДЭГ

Хөрсний хөрсний тэмдэглэгээ	Экзоген үзэгдэл, үйл явц	Таних тэмдэг	Тайлбар
	Хөрсний 1-р үе		Талбайн угаалт, а. хүчтэй б. дунд в. сулавтар
	Хөрсний 1,2-р үе		Хөрсний овойлт
	Хөрсний 1,2,3-р үе		Улирлын дов сондуул
	Хөрсний 1,2,3,4-р үе		Голын эрози/эргийн идэгдэл
	Хөрсний 1,2,3,4,5-р үе		Гулсалт
	Хөрсний 1,2,3, N <sub>2</sub>		Эрчимтэй хөгжиж буй жалга
			Газар чичирхийллийн балл
			Хөгжил нь зогссон жалга
			Олон жилийн цэвдэг хөрсний тархилтын хил
			Нуранги, асгадас
			Шинээр үүсч буй хошуурсан туугдас
			Хөрсний суулт
			Хөрсний хөөлт
			Голын мөрөгцөг







-Орчин үеийн настай намгийн хурдас энэ хөрс Зуны, Эрдэнэтийн, Говилын голын нам татмаар хайргархаг элсэнцэр, шавранцар хөрсний төрлөөр илэрч 2-3 м-ийн зузаантай тохиолдоно. Уг хурдас нь хүлэржсэн, найрлагандаа 10% хүртэл органик бодис агуулсан нь химийн шинжилгээгээр тогтоогдсон байна.

-Орчин үеийн техноген хурдас хотын төв хэсэг, гэр болон орон сууцны хорооллуудын орчмоор илэрч хотын төв хэсгээр 6-10 м, үйлдвэрийн орчинд 10-15 м, Уулын баяжуулах үйлдвэрийн орчимд 100 м хүртэл зузаантай байгааг уг судалгаагаар тогтоосон байна.

-Эрдэнэт хот нь далайн түвшинээс дээш 1600-1700 м өргөгдсөн дунд өндөрлөг ууларахг гадаргуутай, харьцангуй өнөржилт нь нутаг дэвсгэрийн хэмжээнд 400-500 м байна.

-Хотын нутаг дэвсгэрийн гадаргуугын хэлбэр төрхийг гарал үүслээр нь 3 ангилан үздэг. Үүнд:

-Денудаци, денудаци-тектоникийн гадаргууд д.т.д 1350-1700 м өндөр өргөгдсөн дунд өндөрлөгтэй, дундаас хүчтэй хэрчигдсэн Согоот, Эрдэнэт, Баянөндөр уулын тэгшивтэр гадаргуутай оройн. Хэсэг, 15-20 градус, зарим үед 20 градусаас дээш налуутай бэлийн хэсгүүд хамаарагдана.

-Денудаци, денудаци-хуримтлалын гадаргууд голуудын хөндийн 2 талаар орших 1-10 градус хүртэл налуутай дунд зэргийн өндөртэй уул нуруудын хормойн хэсгүүд, хушуурсан туугдасуудад тохиолдно.

-Хуримтлалын гадаргууд 1-5 хүртэл градусын налуутай голын татам, татмын дээрхий дэнжийн гадаргуу, уулс хоорондын хөндий болон уулын хормойн хэсгүүд хамаарагдана.

Хотын нутаг дэвсгэрт тархсан хөрс, чулуулагын усыг байршлын төрлөөр нь Дөрөвдөгчийн настай голын хөндийн татам, дэнжийн хэсгээр тархсан уст үе, дөрөвдөгчийн настай бэл хормойн хурдасанд тархсан уст үе, үндсэн чулуулагын ан цаваар тархсан уст үе гэж 3 ангилан үздэг байна.



Хөрсний усны байрлалын гүнээс хамаарч голуудын хөндий, татмын хэсгээр өвлийн улиралд халиа тошин үүсдэг бөгөөд голуудын татам, дэнжийн хэсгээр байрлаж буй хөрсний ус нь чөлөөт гадаргуутай, хур тундасны усаар тэжээгдэж голуудынхаа устай гидравлик холбоотойгоор байгалийн даралтгүй орчинд оршдог. Бэл, хормойн хэсгээр байрлаж буй ус нь 14-15 м-ээс доош гүнд орших нөхцөлдөө даралттай усны төрлөөр илэрдэг. Даралтын өгсөх хэмжээ 12,6 м хүрдэг байна. Үндсэн чулуулагын ан цавын ус нь газар доорх бүх уст талбайн 60 орчим хувийг эзэлдэг. Ус агуулагч чулуулаг нь галт уулын, тунамал, хувирмал, гүний зэрэг чулуулагын бараг бүх төрлөөр илэрдэг байна.

Эрдэнэт хотын нутаг дэвсгэрт 1-5 градусын налуутай, гадаргуу нь хэрчигдэлгүйгээс баг хэрчигдэлтэй гэж нормчлогдсон голуудын болон уулс хоорондын хөндийд төрөл бүрийн чиглэлээр төлөвлөлт хийх, барилга байгууламж барихад тохиромжтой. 5-8 градусын налуутай гадаргуу нь багаас дунд зэрэг хэрчигдэлтэй гэж нормчлогдсон уулын хормойн хэсгээр төрөл бүрийн чиглэлээр төлөвлөлт хийх, барилга байгууламж барихад харьцангуй тохиромжтой боловч газар шорооны ажлын хэмжээ 1.1.2 дахин нэмэгдэх ерөнхий тооцоо гарч байна. 8-15 градусын налуутай гадаргуу нь дундаас их хэрчиглэлтэй гэж нормчлогдсон уулын орой бэлийн хэсгээр төрөл бүрийн чиглэлээр төлөвлөлт хийх, барилга байгууламж барихад тохиромжгүй, газар шорооны ажлын хэмжээ 2,5-3,0 дахин нэмэгдэх, үүнтэй уялдаж барилга, байгууламжийн өртөг зардал үлэмж нэмэгддэг байна.

Хөрсний ус голуудын татам болон. Дэнжийн хэсгээр 0,5-15 м-ийн гүнээс, уулсын бэл хормойн хэсгээр 14-15 м-ийн гүнээс, үндсэн чулуулагын ан цавын ус 100-120 м орчим гүнээс тус тус илэрдэг байна.

Сэвсгэр хурдасанд агуулагдаж байгаа хөрсний ус нь гидрокарбонат-натри-калийн төрлийн ус бөгөөд усны орчин  $P_n=7,3-7,5$ , ерөнхий хатуулаг  $H=18,4-25,7$  мг/л байна. Ус агуулагч үндсэн хөрсний үе давхрагуудын шүүрэлтийн итгэлцүүр сайр, сайрган хөрсөнд 50-280 м/хоног, шавранцар хөрсөнд 0,37-1,0 м/хоног, хайргархаг элсэн хөрсөнд 13,0 м/хоног байна.



Үндсэн чулуулагад агуулагдаж байгаа уст үеийн зузаан ойролцоогоор 120 м-ээс тогтоогдсон бөгөөд булаг шандын хэлбэрээр илэрч байгаа усны ундрага нь 1,0-3,0 л/сек. Химийн нарлагаараа ердийн хүчиллэг, шүлтлэг, сульфатын төрлийн, ундны хэрэгцээнд тохиромжтой цэнгэг ус юм.

Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн цэвдэг хөрс уулын бэл хормойн хэсгээр хязгаарлагдмал байдлаар багаахан талбайд том хэмхдэст хөрсний төрлөөр илэрдэг. Цэдэг хөрсний 10 м-ийн гүний температур -0,5 град С бөгөөд Мөсжилт Лв=0,1-0,3 байна.

Хотын зарим хэсгээр багавтар талбайд тархсан хадан хөрсний эзэлхүүний масс 2,41-2,71 г/см<sup>3</sup>, өгөршлийн зэрэг Кв=0,89 буюу өгөршсөн хөрсөнд хамаарагдаж байна. Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл 5-15 МПа болно.

Цайвар саарал өнгөтэй, нүх сүвэрхэг шинж чанартай шавранцар хөрс устай үйлчилэлцэхдээ суулт үүсгэнэ. Уг ул хөрс суулттай хөрсний 1-р төрөлд хамаарагдах бөгөөд багаахан хэмжээний талбайг хамаран 5-6 м-ийн зузаантай тархдаг. Суултын үзүүлт нь

28 дугаар хүснэгт

Даралт МПа	0,1	0,2	0,3
Харьцангуй суулт	0,001-0,050	0,002-0,090	0,002-0,112

Усаар ханасан үедээ: Зууралдлын хүч 0,022 МПа, Дотоод үрэлтийн өнцөг 12 град, Хэв гажилтын модуль 9,0 МПа тус тус байна.

**Эрдэнэт хотын геотехникийн нөхцөл:** Хотын нутаг дэвсгэрт тархсан хайргархаг элсэнцэр, шавранцар, сайргархаг элсэнцэр, сайргархаг шавранцар ул хөрснүүд нь сулавтар, хайргархаг шавранцар, хайргархаг элсэнцэр ул хөрс сулавтараас хүчтэй, шавар хөрс дунд зэргийн овойлт үүсгэнэ. Үүнд:

-Улирлын хөлдөлтийн гүн ул хөрсний найрлагаас хамаарч 2,8-3,8 м-ийн гүнд явагдана.



-Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн цэвдэг хөрс уулын бэл хормойн хэсгээр хязгаарлагдмал байдлаар багаахан талбайд илэрнэ.

-Хотын зарим хэсэгт сүвэрхэг шинж чанартай шавранцар хөрс устай үйлчилэлцэхдээ нэмэлт суулт үүсгэнэ.


**Булган хотын инженер-геологийн нөхцөл ул хөрсний геотехникийн шинж чанар.** Булган хот нь Хангайн, Хэнтийн уулт өндөрлөгийн хойт талын дунд өндөрлөгтэй Булган уулсаас салбарласан жижиг уул нуруудын дунд Ачуут, Майдарын болон Зүүнтүрүүний голуудын хөндийд байрладаг.

Хотын нутаг дэвсгэрт Денудацийн, Тектоник-денудацийн, Денудаци-элэгдлийн, Денудаци-хуримтлалын, Хуримтлалын хэв шинжит гадаргуу илэрдэг.




Хотын хэмжээнд доод пермийн настай вулканоген тунамал хурдас, дунд-дээд дөрөвдөгчийн элюви, делюви-пролювийн дээд (69 дүгээр зураг) дөрөвдөгчийн аллювийн хурдасууд байдаг.

Усан сүлжээ сайн хөгжсөн, хөрсний болон гүний усны нөөц сайтай. Вулканоген чулуулагын ан цавын ус, орчин үеийн дөрөвдөгчийн гэсэн 2 уст үе илэрдэг. Өвлийн улиралд гол хөлдөхдөө халиа их хэмжээгээр үүсгэдэг. Мөн урсгал усны эргээ эвдэх үйл ажиллагаа, гадаргуугын шугамын угаадал эрчимтэй явагддаг тул хур бороо элбэгтэй жил гудамж талбай усанд автах үзэгдэл нэлээд байдаг ажээ.





Булган хотын төв далайн түвшинээс дээш 1190,1240 метрийн өндөрт өргөгдсөн бөгөөд хотын төв хэсэг буюу барилгажсан талбай нь хойноосоо урагшаа 0,04-4 градын, Зүүн түрүүний голын хэсэг баруун тийшээ буюу гол уруугаа 0,04-5 градын, хойд энгэрийн гэр хорооллын. Орчимд 0,6-0,8 град-ын тус тус налуутай. Иймд хот төлөвлөлтийн үнэлгээгээр хотын нийт нутаг дэвсгэр газрын гадаргын налуугийн хувьд барилга, байгууламж барих, зам талбай засаж тохижуулахад тохиромжтой гэж үзэж болхоор байна.



I УЛ ХӨРСНИЙ ДАВХАРГЫГ ДҮРСЛЭХ ИНЬ

-   $Q_{1-2}$  Ул хөрсний 1-р үе
-   $Q_{1-2-3}$  Ул хөрсний 1,2-р үе
-   $Q_{1-2-3-4}$  Ул хөрсний 1,2,3-р үе

II ГИДРОГЕОЛОГИ

-  Гидроизогипс (Олон жилийн дундаг түвшнээр)
-  Ул хөрсний усны химийн найрлага  
R - Усны орчин  
H - Усны хатуулаг  
S - Усны идэмхий шинж чанар
-  Цооногт илэрсэн ул хөрсний усны түвшин
-  Намаг

69 дүгээр зураг





**Булган хотын геотехникийн нөхцлийн онцлог:** Булган хотын нийт нутаг дэвсгэр газрын гадаргын налуугийн хувьд барилга, байгууламж барих, зам талбай засаж тохижуулахад тохромжтой

-Элсэнцэр, хайргаар чигжигдсэн элсэнцэр, шавранцар зэрэг шаварлаг хөрс түгээмэл тархсан.

-Бүх төрлийн хөрс давжилтгүй, хүлэржилтгүй бөгөөд хар металл эдлэлд бага зэрэг зэврэлт үзүүлнэ.

-Хөрсний нэр төрлөөс хамарч улирлын хөлдөлтийн гүн 2,8-4,3 м-т явагдана.

**Хархорин хотын инженер-геологийн нөхцөл ул хөрсний геотехникийн шинж чанар.** Хархорин хот газар зүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг Их мужийн Сэлэнгэ-Орхоны сав дахь бэсрэг уулын дэд мужид хамрагддаг бөгөөд Их Өндөр, Сантын нурууны уулс дунд далайн түвшнөөс дээш 1450-1500 метрийн өндөрт, Орхон, Хөгшин Орхон голуудын бэлчирт барладаг.


Хархорин хотын төвлөрч буй газарт элэгдэл зөөгдлийн, хуримтлалын гэсэн гадаргуугын 2 хэв шинж илэрнэ. Элэгдэл зөөгдлийн гадаргууд дунд зэргийн налуутай чулуулагын гарш бүхий бэсрэг уулын хажуу бэл, хормойн хэсгүүд, хуримтлалын гадаргууд Орхон голын татам, татмын дээрхи 1-р дэнж, татмын дээрхи 2-р дэнж, Шанх уулын бэл хормойн хэсгүүд хамаарна. Орхон голын 1-р дэнж 0,4-0,9 м, 2-р дэнж 2,0-6,8 м өндөртэй. Төвийн хэмжээнд гадаргуугийн өндөржилт 987,4-1010,25 буюу 22,8 м-ийн зөрүүтэй байдаг.

Төвд доод болон дунд палеозойн настай хувирмал занар, кварц, хлориттой занар, биотит-хлориттой занар, элсэн (70 дугаар зураг) чулуулаг, кварцит, конгломерат, девоны настай бялхмал чулуулаг, кварцит, порпир тэдгээрийн туф, дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдасууд тархдаг. Дөрөвдөгчийн сэвсгэр хурдасыг гарал үүсэл, шинж чанараар 2 хувааж болно.

**Хар хорин хотын нутаг дэвсгэрлэх дунд болон дээд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас.** Уг хурдас нь Орхон. Сайран голын татам, тамын дэнжид тохиолдох бөгөөд голдуу элсэн чигжээстэй том хэмхдэст хөрсний төрлөөр,



хааяа сайр, сайрга агуулсан шавранцар хөрсний төрлөөр илэрдэг. Аллювийн хурдасны зузаан 15-30 м орчим байна.



70 дугаар зураг

**Уулын бэл хормойн хурдас.** Уг хурдас нь уулын бэл хормойн хэсгээр буюу аллювийн гаралтай хурдасыг багавтар зузаантайгаар хучиж тогтоно. Зузаан нь дунджаар 1,0-5,0 м бөгөөд хамгийн зузаан газартаа 10 м орчмоор тогтоогдсон байна.

Хотын төвийн баруун талаар 2 км орчим газраар Орхон голын салаа Сайрын гол урсдаг. Голын өргөн төвийн ойролцоо 75-85 м, гүн нь 1,2-4,0 м, урсгалын хурд нь 1,4-1,5 м/сек байв. Сайрын гол Орхон голын устай гидравлик холбоотой. Хур тундас багатай жил ус татран газар доогуур шурган орж хуурай сайр байдалтай болдог.

Орхон гол нь Хангайн нурууны салбар Суварга хайрхан уулаас эх авч 1120 км орчим урсаад Сэлэнэг мөрөнд цутгана. Ус цуглуулах нийт талбайн хэмжээ 130



мян/км<sup>2</sup> бөгөөд алс хол газрыг туулан урсах тул хөндийн хэлбэр төрх, өргөн нарийн гүний хувьд янз бүр болдог. Голын тэжээгдлийн 75-90% нь хур тундасны ус байдаг. Голын өргөн эхэн хэсэгтээ 10-60 м, бөгөөд адаг хэсэгтээ 150 орчим метр болдог. Голын усны зонхилох гүн 0,5-1,50 м, гүнзгий цээл газартаа 2,5-4,0 м, харгиа боргио газартаа 0,5 м орчим байдаг. Орхон голд цутгадаг томоохон цутгалууд нь Улаан, Хужирт, Хойт, урд Тамир, Хөгшин Орхон, Туул, Хараа, Ерөө, Шарын голууд юм. Ус нь цэнгэг тул хүн малын ундаа, ахуйн хэрэгцээнд тохиромжтой.

Хөгшин Орхон гол нь Сар Хайрхан уулнаас эх авсан Ээлтийн гол, Сайрын голууд нийлж Хөгшин Орхон голыг үүсгэх ба 200 орчим км урсаад Хархорины орчимд Орхон голын баруун гарт цутгадаг. Голын гольдролын өргөн голын эхэн хэсэгтээ 5 м орчим адаг хэсэгтээ задгайрч өргөсөн зарим газраараа намаг үүсгэсэн байдаг.

Голын татмын хэсгээр хөрсний ус 0,6-1,2 м-т, татмын 1-р дэнжид 2,1-4,5 м-т татмын 2-р дэнжээр 8,0 м-ээс доош гүнд тус тус илэрдэг. Хөрсний ус нь өнгө, үнэр амтгүй тунгалаг шинж чанартай, гидрокарбонат кальци, кали-натри, магни төрлийн усанд хамаарна. Ердийн портланд цементээр хийсэн бетон эдлэлд идэмхий чанар үзүүлэхгүй сайн талтай юм.

**Хархорин хотын геотехникийн нөхцлийн онцлог.** Хархорин хот газар хөдлөлтийн 9 баллын бүсэд хамаарагдана. Элсээр чигжигдсэн сайрган хөрс сайргархаг элсэн хөрс овойлт үүсгэхгүй тоосорхог элс болон шавранцар хөрс сулавтар овойлттой. Хөрсний төрөл найрлагаасхамаарч улирлын хөлдөлтийн гүн 2,9 м, байдаг.

Мөрөн хотын төв далайн түвшинөөс дээш 1283 м-ийн өндөрт өргөгдсөн бөгөөд газрын гадаргуугын хувьд зүүн хойноосоо баруун урагш чиглэлд 5-8 градусын налуутай.

Дэлгэр мөрөн нь Улаан тайгын нуруунаас эх аван тус хотын дэргэдүүр урсдаг бөгөөд хотын хүн ам, үйлдвэрийг усаар хангах гадаргуугын усны гол эх үүсвэр нь болдог. Голын нийт урт 445 км, ус хураах талбай нь 26640 км<sup>2</sup>, усны



унал 2200 бөгөөд голын хөндий ерөнхийдөө давчуу, голын өргөн эхэн хэсэгтээ 25-40 м, адаг хэсэгтээ 50-100 м болдог. Усны гүн 0,5-2,5 м, урсгалын хурд 0,2-2,0 м/сек, жилд 126-173 хоног мөсөөр хучигдана. Урсгал хурдтай учраас хөлдөлт харьцангуй удаан явагддаг.

**Мөрөн хотын инженер геологийн нөхцөл.** Мөрөн хотын нутаг дэвсгэрт хэмхдэс материал янз бүрийн хэмжээтэй агуулсан элсэн төрлийн болон сайргархаг шавранцар гэсэн 2 төрлийн ул хөрс тохиолддог. Тэдгээрээс шавранцар чигжээстэй сайрган ул хөрс дунд зэргийн бусад ул хөрс овойлт, суулт, хөөлт үзүүлэхгүй. Элсээр чигжигдсэн сайрга болон сайргархаг элсэн ул хөрс уулын хормой хэсгээр 5-6 м, голын сав газраар 15-21 м хүртэл зузаантай жигд тархсан байдаг. Сайргархаг шавранцар ул хөрс нь уулын бэл, хормой хэсгээр дээр дурьдсан ул хөрсний доороос илэрнэ.

Хотын нутаг дэвсгэрт хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэн ул хөрсний мишил үеүд багавтар хэмжээгээр тохиолдох боловч тэдгээрийн геотехникийн шинж чанар, норматив үзүүлэлтүүд өөр хоорондоо онцын ялгаагүйн гадна барилга, байгууламжийн суурь суух гүнд нөлөөлөх сөрөг нөлөөлөл бага байдаг нэгтгэн авч үзлээ.

**Мөрөн хотын геотехникийн нөхцөлийн онцлог:** Мөрөн хот инженер-геологийн хувьд энгийн нөхцөлтэй. Ул хөрс нь хэмхдэс материал янз бүрийн хэмжээтэй агуулсан элсэн болон сайргархаг шавранцар гэсэн 2 төрлийн ул хөрс тохиолддог, Мөрөн хот нь олон жилийн цэвдэг ул хөрс үргэлжлэн болон алаг цоог тархсан бүс нутагт хамаарах боловч тухайн хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн цэвдэг ул хөрс илрээгүй, Бүх төрлийн хөрс давсжилтгүй, хүлэржилтгүй бөгөөд хар металл эдлэлд бага зэрэг зэврэлт үзүүлдэг, Хөрсний нэр төрлөөс хамаарч улирлын хөлдөлтийн гүн 2.8-4.3 м-т явагддаг, Хөрсний ус талбайн хэмжээнд 4.0 м орчимоос илэрч 3.5 орчим гүнд тогтдог бөгөөд бут бетон болон портланд цементэн эдлэлд идэмхий шинж чанар үзүүлдэггүй.

**Цэцэрлэг хотын инженер-геологийн нөхцөл ул хөрсний геотехникийн шинж чанар.** Цэцэрлэг хот нь Монгол орны нутаг дэвсгэрийн төв



хэсэгт буюу Монгол орны физик газарзүйн мужаар Хангай-Хэнтийн уулархаг Их мужийн Хангайн мужийн Сэлэнгэ Орхоны сав дахь бэсрэг уулсын тойрогт хамаарагдан Булнай нурууны өмнөт төгсгөл, Тарвагатайн нурууны зүүн төгсгөл хэсэгт Булган, Жамганы уулсаар хүрээлэгдэн далайн түвшинээс дээш 1691 м-ийн өндөрт оршдог.

Геоморфологийн мужлалаар Хангайн их мужийн Тарвагатай, Хануйн голын мужид, Инженер-геологийн мужлалаар Хангай, Тарвагатайн мужид, гидрогеологийн мужлалаар Хангайн мужид, тектоникийн мужлалаар Монгол-Байгалийн атираат системийн Хангайн геосинклиналь бүсийн Хангайн дэд бүсэд тус тус хамаарагдана.

Архангай аймгийн нутагт Өгий, Тэрхийн цагаан нуур болон Чулуут, Хануй, Хүнүй, Суман, Чичгэнэ, Хойд Тамир, Урд Тамир, Цэнхэрийн гол түүнчлэн Өлзийт, Өгийнуур, Хохонт, Хашаат сумдын нутгийг дамжин урсдаг Орхон голын салаа Хөгшин Орхон зэрэг томоохон гол мөрөн нуурууд байх боловч эдгээр нь Цэцэрлэг хотын усан хангамж, хурдас чулуулагын үүсэл, бүрдэлд төдийлөн нөлөөлдөггүй. Харин Булган уулын сугаас эх авсан Ганц модны булаг, Жамганы уулаас эх авсан Жамганы булагууд хотын нутаг дэвсгэр дээгүүр урсах боловч эдгээр нь тогтмол устай бус, хур тунадас багатай жил ширгэж хуурайшдаг. Иймд хот нь гадаргуугын усны нөөц багатай. Гүний усны нөөц сайтай бөгөөд хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2 томоохон уст комплекс, 5 уст горизонт тогтоогдсон байдаг. Гүний усны эдгээр төрлүүд нь Гидрокорбанатын төрлийн цэнгэг ус бөгөөд хотын хүн ам, ахуйн хэрэгцээний эх үүсвэрийг хангаж байдаг.

Аймгийн төвд хамгийн ойролцоо орших томоохон гол нь Тамирын гол бөгөөд уг гол нь Хангайн нурууны Суварга хайрхан уулнаас эх авч Орхон голоор дамжин Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Голын нийт урт 1124 км, ус цуглуулах талбай 132835 км<sup>2</sup>, голын өргөн харилцан адилгүй бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэр дээгүүр урсан өнгөрөхдөө дунджаар 10-60 м хүрдэг. Голын дундаж гүн аймгийн төвийн ойролцоо 0.5-1.2 м байдаг. Жилийн бүх тэжээгдлийнхээ 50-60%-ийг бороо, 15-20%-ийг хөрсний усаар, мөн тийм хэмжээний тэжээгдлийг цасны усаар авдаг ажээ.





Геологийн тогтоцыг доод карбон, пермийн настай гүний болон тунамал чулуулагууд, дээд орчин үетйн дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдасны төрлүүд бүрдүүлдэг. Мөн Неогены настай шавар хөрс багавтар хэмжээний талбайг эзлэн тархсан байдаг.

**Цэцэрлэг хотын нутаг дэвсгэр дэх онцлог шинж:** Байран гаралтай хурдас хайргархаг элс болон хайргархаг шавранцар хөрсний төрлөөр хотын баруун өмнөд хэсгээр буюу үйлдвэрийн районд багаахан талбайд 2-5 м-ийн зузаантай илэрдэг.

Баянбулаг голын адаг орчмоор буюу Тамирын голтой нийлэх заагаар намагжих үйл явц багаахан талбайд явагдаж байгаа бөгөөд мөн тэнд 1.5-10.0 орчим зузаантай олон жилийн цэвдэг шаварлаг ул хөрс илэрсэн байна.

- Хөрсний ус Номгоны ганц модны булангийн орчим, Тамирын голд ойртож очих нам дор газруудаар 2.0-2.5 м орчим гүнээс, төвийн хэсгээр 5.5-6.5 м орчим гүнээс бусад хэсгээс 8.0 м-ээс доош гүнд илэрдэг. Хөрсний усны түвшин хур тунадасны хэмжээ болон улирлын байдлаас хамаарч 1.5-2.0 м-ээр хэлбэлзэнэ. Хөрсний ус нь химийн найрлагын хувьд гидрокорбонат, магни, кальци натри, калийн төрлийн усанд хамаарна. Ус агуулагч зонхилох хөрсний шүүрэлтийн коэффициент-5-10 л/сек байна.

**Цэцэрлэг хотын геотехникийн нөхцөлийн онцлог:** Хотын нутаг дэвсгэрт тархсан элсээр чигжигдсэн хайргархаг хөрс болон жижиг ширхэглэлтэй элс, тоосорхог элсэн хөрснүүд овойлт үүсгэхгүй, элсэнцэр, шавранцараар чигжигдсэн хайрган хөрс сулавтараас сулавтар, хайргархаг шавранцар, хайргархаг элсэнцэр, хөрснүүд дунд зэргийн, шавранцар шавар хөрснүүд дундаас хүчтэй овойлт үүсгэнэ, Бүх төрлийн хөрс давсжилтгүй, хүлэржилтгүй бөгөөд хар металл эдлэлд бага зэрэг зэврэлт үзүүлнэ. Хөрсний нэр төрлөөс хамаарч улирлын хөлдөлтийн гүн 2.8-3.6 м-т явагдана, Хотын нутаг дэвсгэрт тархсан бэлийн хурдас нь хотын баруун хойт болон зүүн хэсгээр дунджаар 4-9 м-ийн зузаантай илэрнэ. Бэл хормойн гаралтай хурдас хотын хэмжээнд зонхилон тархах бөгөөд барилга, байгууламжийн суурь суух үндсэн хөрс болно.



**Арвайхээр хотын инженер-геологийн нөхцөл ул хөрсний геотехникийн шинж чанар.** Арвайхээр хот нь Монгол орны нутаг дэвсгэрийн төв хэсэгт буюу Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг Их мужийн Хангайн мужийн Сэлэнгэ Орхоны сав дахь бэсрэг уулсын тойрогт, геоморфологийн мужлалаар төв болон хойд хэсэгт нь Хангай Хэнтийн уулт өндөрлөг, өмнөд хэсэг нь Алтайн ар говийн цав толгодын мужид, инженер-геологийн (71 дүгээр зураг) мужлалаар Баянхонгор, Орхон-Сэлэнгэ, Өндөр шилийн мужид тус тус хамаарагдана. Аймгийн нутаг дэвсгэрийн баруун хойд, хойд хэсгээрээ Хангайн нурууны өмнөт төгсгөл болох далайн түвшинээс дээш 3000 орчим метрийн өндөртэй Хан Хөгшин уул, Хайрхан Дулаан уул, 2408 м-ийн өндөртэй Зүүн Хайрхан уул, баруун өмнөд болон өмнөд хэсгээрээ Алтайн нурууны өмнөд төгсгөл болох далайн түвшинээс дээш 2477 м өндөртэй Арц Богд, 3590 м-ийн Бага Богд зэрэг уулсаар хүрээлэгдэнэ. Хойд хэсгээр нь Орхон, Хөгшин Орхон, төв хэсгээр нь Онги, баруун талаар нь Таац, Өмнөд хэсгээр нь Хар Агуйт зэрэг томоохон голууд урсдаг. Тус хот нь Онгийн голоос 5 км зайд байрладаг.

Таацын гол нь Азийн гадагш гарах урсгалгүй голуудын ай савд багтах бөгөөд Хангайн нурууны өвөр хажуугаас эх авч 200 км-ийн урттай нууруудын хөндийд сэвсгэр хурдсанд шингэж замхардаг. Ус цуглуулах талбайн хэмжээ 9190 км<sup>2</sup>, унал нь нийт уртдаа 1300 м, дундаж налуу 0,006 байна. Голын хөндийн дундаж өргөн 1-3 м, урсгалын хурд нь дунджаар 0.8-1.2 м/сек, ихэнх нь өвөл ёроолгүй хөлдөж голын эхэн хэсгээр халиа үүсдэг. Цэвэр тунгалаг устай хүн малын унд, ахуй хэрэглээнд тохиромжтой. Хотын төв хэсгээр нь Дэлгэрэх гол урсдаг боловч хур тунадасны байдалтай уялдаж зарим жил ширгэж тасардаг.

Тус аймгийн баруун хойд, хойд нутгуудыг хамран Орхон, Онгийн голын бэлчир газраар алаг цоог, ховор алаг цоог төрлийн олон жилийн цэвдэг хөрс тохиолдоно. Цэвдэг хөрсний зузаан ихэнх тохиолдолд 5.0-50.0 м бөгөөд дундаж температур нь 1-2 градус орчим, Бат-Өлзийт, Уянга сумын нутгаар халиа, тошин элбэг тохиолдоно.



## АРВАЙХЭЭР ХОТЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН КАРТ



71 дүгээр зураг





## Дүгнэлт

1. XXI зуунд уур амьсгалын дулааралт дэлхийн ойн нөөцийн гуравны нэг орчимд хүчтэй нөлөөлж ойн төрөл зүйлд үндсэн өөрчлөлт гарах хандлагтай бөгөөд судалгаагаар ургамлын янз бүрийн төрөл зүйл илүү тохиромжтой нутаг руу нэг жилд 0,04-2 км хүртэл зайд нүүн шилжих нь харагдаж байгаагаас гадна. Гэвч илүү хурдан (жилд 1,5-5,5 км хүртэл) нүүн шилжихийг шаардаж байна. Иймээс олон төрөл зүйлийн ургамал ийм хурдан нүүн шилжиж чадахгүй мөхөж болзошгүй байна.

2. Орчин үеийн шинжлэх ухааны үнэлгээгээр XXI зуунд уур амьсгалын дулааралт хугацаа хойшлох тутам улам эрчимжиж нийт нутаг дэвсгэр дээр энэ зууны эхний 25 жилд жилийн дундаж температур 1,8-2,8<sup>0</sup>C-ээр, үүнээс өвлийн улиралд 1,4-3,6<sup>0</sup>C-ээр, зундаа 1,0-3,0<sup>0</sup>C-ээр дулаарах ба дараагийн 25 жилд дулааралтын эрчим бараг хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна. Хур тунадасны хэмжээ жилийн дүнгээр онц өөрчлөгдөхгүй (-4%-иас +8,1%) боловч өвлийн улиралд бараг 2 дахин ихсэж зуны улиралд агаарын температур 2<sup>0</sup>C орчмоор нэмэгдэхэд ургамлын ууршицыг 100-110 мм-ээр нэмэгдэхээр байгаа учир XXI зууны эхний 25-50 жилд Монгол нутагт хуурайшилт улам эрчимжинэ гэж үзэж байна. Иймээс Монгол Улсын хот суурин байгуулалт, барилга байгууламж барихад уур амьсгалын энэ онцлогыг заавал тооцох учиртай.

3. Хангайн бүсэд манай улсын зургаан аймаг, 112 сум хамрагдах бөгөөд улсын нийт хүн амын 22% буюу 560 гаруй мянган хүн ам оршин суурьшдаг ажээ. Хангайн бүс улсын нийт нутаг дэвсгэрийн 25,6%, ойн нөөцийн 40,0%, гадаргын усны 35,2%, ашиглаж болох боломжтой газар доорхи усны 50,5% нь ноогддог. Усны нөөцийн хувьд Архангай, Хөвсгөл, аймгууд их байхад Баянхонгор, Өвөрхангай аймгуудад нөөц багатайд тооцогддог байна.

4. Хангайн бүсэд манай улсын нийт ойн сангийн 47,8% нь ногдож байгаагаас гадна 4760,2 мян.га талбайг эзэлсэн 11 тусгай хамгаалалттай газар нутаг байдаг ба энэ нь хангайн бүсийн нийт нутаг дэвсгэрийн 12,4%-ийг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 23,3%-ийг тус тус эзэлдэг Хөвсгөл, Булган аймаг ойн нөөцөөр хангалттай байна.



5. Хангайн бүс байгалийн нөөц баялаг ихтэй бөгөөд 150 төрлийн орд илэрцүүд байгаагаас Тавтын алтны, Сайхан голын төмөр-магний, Бүрэнхааны фосфоритын, Дөшийн гол, Өвөр мараатын хөнгөн цагааны, Эрдэнэтийн зэс-молибдений томоохон ордуудад орж байна.

6. Хангайн бүсийн нутаг дэвсгэр гидрогеологийн мужлалаар Увс нуурын, Хөвсгөл орчмын, Хангайн, Сэлэнгийн, Нууруудын хөндийн мужуудыг дамнан байрладаг, Инженер-геологийн хувьд Хөвсгөл-Сэлэнгийн, Их уулын, Булнайн, Хангайн-Тарвагатайн, Орхон-Сэлэнгийн, Өндөршилийн мужуудад багтдаг ажээ.

7. Хангайн бүсийн Хөвсгөл, Хэнтийн шовх оройтой уул нуруудын орой, бэлийн хэсгээр хурдас чулуулаг геотехникийн болон байран хурдас ихэвчлэн 2,0-2,5 м, Хангай нуруу болон бусад нутгийн хавтгай оройтой уул нуруудаар хурдасны зузаан 3,5-5,0 м хүрдэг байна. Эдгээр хурдас чигжээсгүй, хайр хайрга, сул хаднаас тогтдог ажээ. Том хэмхдэсийн агуулга, тэдгээрийн хэмжээ зүсэлтийн гүн хэсэгтээ нэмэгдэж үндсэн чулуулгад ажимдаа шилждэг ажээ. Байран хурдас нь Хангайн бүсэд бүх төрлийн чигжээстэй том хэмхдэст хөрсний төрлөөр зонхилон илэрдэг байна.

8. Хангайн бүсийн хот суурингууд нь Монгол орны газар хөдлөлтийн идэвхтэй хэсэгт буюу 7-10 баллын бүсэд байрладаг бөгөөд нийт сум суурины 19 нь буюу 20,9% нь 7 баллын бүсэд, 41 нь буюу 47,2 % нь 8 баллын бүсэд, 27 нь буюу 29,7% нь 9 баллын бүсэд, 2нь буюу 2,2% нь 8-10 баллын бүсэд оршидог байна.

Хангайн бүсийн хот, бусад олон сум, суурин газрын олон жилийн цэвдэг болон овойлттой хөрс тархсан байна. Тухайлбал: **Нэг.** Архангайн аймгийн нутаг дэвсгэрт хөрсний ус 1.2-1.3 м-ийн гүнээс илэрдэг. Газар хөдлөлтийн 8, 9 баллын бүсэд оршдог энд хүчтэй овойлт үүсгэх шаварлаг хөрс зонхилон тархсан. Төвийн зарим хэсгээр намагжих процесс идэвхитэй явагдаж байгаа онцлогтой. **Хоёр.** Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр нь: Олон жилийн цэвдэг хөрс 1.5-1.8, 2.4-2.8-3.0 м-ийн гүнээс илэрч тэр нь 170-200 м-ийн зузаантай тохиолдоно цэвдгийн дээр устай. Мөсжилт ихтэй тул хүчтэй суулт үүсгэдэг. Газар хөдлөлтийн 8-9 баллын бүсэд оршино. Иймд гэсгээхгүй зарчмаар барилга барих нь илүү тохиромжтой. **Гурав.** Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт олон жилийн цэвдэг хөрс 2.2-2.4 3.1-3.6 м-





ийн гүнээс илэрч 120-250 м-ийн зузаантай тархсан. Зарим тохиолдолд 40 м-ийн зузаантай тархсан байдаг байна. Цэвдгийн дээр устай. Мөсжилт ихтэй тул хүчтэй суулт үүсгэдэг ажээ. Иймд гэсгээхгүй зарчмаар барилга барих нь илүү тохиромжтой ажээ.

Хангайн бүсийн нутаг дэвсгэрт элсээр чигжигдсэн сайрган хөрс өргөн тархалттай бөгөөд 3-7 м-ийн дундаж зузаантай байдаг. Харин элсэнцэрээр чигжигдсэн сайрган хөрс хотын төв ба баруун хэсгээр элсээр чигжигдсэн сайргархаг хөрсний доороос илэрч 0,5-2,5 м-ийн зузаантай, тогтсон бол хайргархаг элсэн хөрс нь хотын баруун ба баруун хойд хэсгээр үндсэн чулуулаг болон элсээр чигжигдсэн сайрган хөрсний дээр 1,0-5,0 м-ийн зузаантай, тоосорог элсэн хөрс нь хотын баруун хойд хэсгээр ихэвчлэн өнгөн хөрсний доороос илэрч 1,5-3,0 м-ийн зузаантай байдаг байна.



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАНГАЙН БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ ХОТЫН АРХИТЕКТУР, ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ

### НЭГ. ХАР ХОРИН ХОТЫГ ХӨГЖҮҮЛЖ, ШИНЭ ХОТ БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ.

**III.1 Бүсийн тулгуур төв хот байгуулах үндэслэл.** Сүүлийн жилүүдэд хүн ам зүйн бодлого алдагдсанаас томхон хотууд ачааллаа дийлхээ больж дэд бүтэц, инженерийн хангамж хүрэлцэхгүйд хүрч, замын түгжрэл хирээс хэтэрч, ундны усны хомсдолд орж, байгаль орчины даац дутагдан хүн ам аюулгүй тохьтой орчинд амьдрах үндсэн хуулийн заалт ноцтой зөрчигдөхөд хүрсээр байна. Энэ нь нутаг дэвсгэрийн бүсчилсэн бодлогын хүрээнд хот сууринг жигд тэнцвэртэй хөгжүүлэх асуудалд арга буюу хөтлөн оруулж байгаа юм. Үүний тулд Шинэ хот байгуулах хуучин хот сууринаа шинэчлэн хөгжүүлэх гээд хот байгуулалтын олон олон асуудалтай уялдуулан хот байгуулалтын шинэ бодлого боловсруулж тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Иймээс энэ бодлогын нэгэн хэсэг болох Хангайн бүсийн орхоны хөндийд орших Монгол Улсын төв цэгийн орчим Шинэ хот барих архитектурыг энэ төсөлийн хүрээнд бичиж боловсрууллаа.


Манай оронд хүн амын нутагшилт, хот байгуулалт бүрэлдэн тогтсон үйл явц нь нүүдлийн соёл иргэншилтэй уялдан (1, 2, 3, 4, 5 дугаар зураг) өвөрмөц, өөрийн өнгө, төрхтэйгээр хөгжиж ирсэн нь суурин соёл иргэншилтэй бусад улс орноос ялгагдах онцлог аргагүй мөн.

1930 аад оноос манай улсад суурин соёл иргэншил хэв шинжээ олж хотжих процесс эрчимтэй явагдаж ирлээ.

Хүн амын нутагшилт, хот байгуулалтын төлөв байдал нь байгаль, газарзүйн онцлогоос шууд бус, түүхэн уламжлал, аж амдралын хэвшил, тухайн үеийн эдийн засгийн чадавхи, хүн амын тоо, төр засгийн явуулж буй бодлогоос ихээхэн хамааралтай байжээ.




НҮҮДЭЛЧДИЙН СУУЦНЫ ОРОН ЗАЙН  
ТЕКТОНИК ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ



1 дүгээр зураг.


ГАНДАНТЭГЧИЛЭН ХИЙДИЙН БАЙРШИЛ,ХОТ БАЙГУУЛАЛТ



2 дугаар зураг.




**МОНГОЛЫН ЛОНХОН ХЭЛБЭРИЙН СҮМ ДУГАНЫ  
ЦОГЦОЛБОРЫН БАЙРШИЛ ХОТ БАЙГУУЛАЛТ**



3 дугаар зураг

**ЗАЯЫН ХҮРЭЭ ХИЙДИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ ХОТ БАЙГУУЛАЛТ**




4 дүгээр зураг





**МОНГОЛЫН БАГА ОВРЫН СУМ ХИЙДИЙН  
БАЙРШИЛ ХОТ БАЙГУУЛАЛТ**



*Ба дугаар зураг*

**ӨНДӨР ЖАНРАЙСАГ**



*56 дүгээр зураг*





Монгол орны нутагшилт, хот байгуулалтын өнөөгийн дүр төрхөөс хот, тосгон суурины болон хөдөөгийн нутагшилтын хөгжлийн ямар нэг зөрөөтэй байдлыг олж харж болох бөгөөд энэ нь төр засгаас тухайн үед явуулж байсан бодлогын алдаа, дутагдал, бусад суурин соёл, иргэншилтэй орны хот байгуулалт, төлөвлөлтийн практикийг өөрийн орны онцлог нөхцөлд зохицуулахгүйгээр хуулбарлан ирсэн, хот байгуулалт, төлөвлөлтийн үндэсний боловсон хүчин харьцангуй хожуу бэлтгэгдсэн, хотжих үйл явц сүүлийн 50 гаруйхан жилийн дотор эрчимтэй явагдаж эхэлсэн, хот байгуулалт, төлөвлөлтийн томоохон төслүүдийг гадаад орны мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд өөрсдийн /социалист хэлбэрийн/ хот байгуулалтын онол, зарчим, арга зүй, норм дүрмийг баримтлан боловсруулж ирсэнтэй холбоотой юм.


Улсын хэмжээнд 1970 аад оноос хүн амын шилжин суурьшсан үйл явц улам бүр идэвхжиж Олон улсын хэллэгээр технополис хэлбэрээр Сүхбаатар, Замын-Үүдийн төмөр замын дагуу Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сүхбаатар, Зүүнхараа, Налайх, Чойр, Сайншанд, Замын үүд зэрэг хот тосгон төвлөрөн, шинээр суурьшлын төвүүд үүссэн (6, 7, 8, 9, 10, 11, 12, дугаар зураг) ялангуяа төвийн бүсийн Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд түлхүү хөгжсөнтэй шууд холбоотой байжээ.

Үүний нэг бодитой жишээ нь Нийслэл Улаанбаатар хотод улсын хүн амын 42,7% буюу нэг сая гаруй хүн оршин сууж, улсын хэмжээний аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 33,3%, барилга угсралт, засварын ажлын 75,4%, цахилгаан үйлдвэрлэлийн 76,7%, дулаан үйлдвэрлэлийн 70,5%, хөрөнгө оруулалтын 51,3% ногдож байгаагаар илэрч байна. Гэтэл энэ нь улсын нийт нутаг дэвсгэрийн 0,3% буюу 4,7 мян. км<sup>2</sup> газар нутгийг эзэлж байна.

Ингэж улсын хөгжлийг нэг төвт тогтолцоогоор зохицуулж өөр өөр хэлбэр Улаанбаатарт бүх асуудлыг төвлөрүүлж байснаас Монгол улсын томоохон үйлдвэр, аж ахуй, Шинжлэх ухаан, соёл боловсролын байгууллага, цэргийн анги нэгтгэлүүд, Нийслэл хотод төвлөрч байгаа нь улс орны болон Нийслэл хотын тогтвортой хөгжил, хотын хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлсээр байна.




**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХОТ  
СУУРИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ**




6 дугаар зураг

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл болох хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо, бүс нутгаар хөгжүүлэх зарчим, хөгжлийн тэргүүлэх болон тулгуур төвүүд, зам тээвэр, инженерийн дэд бүтцийн гол тэнхлэгүүд өнөөдрийг хүртэл бүрэн утгаараа бүрэлдэн тогтоогүй, байгаа нь хот суурины цаашдын хөгжлийн нөхцөл байдлыг хүндрүүлэх шалтгаан болсоор байна.



7 дугаар зураг




8 дугаар зураг






ЭРДЭНЭТ ХОТ



9 дүгээр зураг

ЧОЙР ХОТ



10 дугаар зураг



Өнөөгийн нийгэм эдийн засгийн шинэ нөхцөлд байдалд хотуудын хөгжлийн асуудлыг зөвхөн дэвсгэр нутгийн нь хүрээнд бус, улсын нийт хүн амын нутагшилт, суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, төлөвлөлтийн хүрээнд бүс нутгаар харьцангуй бие дааж хөгжих, өөрөө өөрийгөө тэтгэж, өрсөлдөх чадвар бүх нутаг дэвсгэр, орон зайн нэгдмэл бүтэцтэйгээр төлөвлөх шаардлага зайлшгүй болж байна.


Өнөөдрийн байдлаар Нийслэл Улаанбаатар хот нь зөвхөн Монгол улсын нийслэлийн үүрэг, функцийг төдийгүй, улсын эдийн засаг, үйлдвэр, соёл, шинжлэх ухаан, батлан хамгаалах, боловсролын салбарын бүх л (13 дугаар зураг) үүрэг ачааллыг өөртөө үүрч, төвлөрүүлсээр байна. Үүнийг эхний ээлжинд ядаж бүс нутгуудын төвдүүдэд жигд шилжүүлэх шаардлагатай байна.

Шинэ хотын төлөвлөлтийн зорилт нь улсын тодорхой дэмжлэг ба хотын зохион байгуулалтын дотоод нөөц боломжид тулгуурласан хот байгуулалт, төлөвлөлтийн шинэ бодлогод шилжиж, хот байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааны хүрээнд одоо байгаагаас эрс ялгаатай нийгэм эдийн засагтаа зохицсон төлөвлөлтийн шинэ зарчмыг бий болгож, хэрэгжүүлэх явдал юм.


Энэ төслийн үндсэн агуулга нь бидний мэддэг, ойлгодог, ойлгож дассан, урьд нь хийгдэж байсан хот төлөвлөлтийн ерөнхий төсөл биш бөгөөд агуулга, хэлбэрээ үндсээр нь өөрчилсөн, нийгэм, эдийн засгийн цоо шинэ нөхцөл, хотын бүтцийн өөрчлөлт зохион байгуулалтад зохицсон, Хот байгуулалтын тухай, Газрын тухай болон холбогдох бусад хууль эрхийн актуудтай нийцсэн, хот суурины хөгжлийн зах зээлийн бодит хуулийг дагасанд оршино.

Энэ төслийг хотын олон төрлийн нарийн нийлмэл үйл ажиллагааг нэгэн цогц нэгдмэл систем болгож, хэвийн үр ашигтай ажиллагааг нь хангахуйц хотын бүтцийн элементүүдийг бий болгон зохион байгуулах, хотын бүтцийн чанартай олон нийт, үйлчилгээ, зам тээвэр, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, хөгжүүлэх, тэдгээрийг сайжруулах, газар ашиглалтыг оновчтой, зүй зохистой болгох баримт бичиг гэж ойлгоно.





11 дүгээр зураг



12 дугаар зураг



13 дугаар зураг

Иймээс ч энэ зорилтын хүрээнд шинэ хоттой уялдаатай дараах үндсэн зарчмыг дэвшүүлж байна.

**Нэгдүгээрт:** Шинэ хот байгуулах газар нутгийн хот байгуулалтын бүсчлэлийн тогтолцоог оновчтой болгож төлөвлөлтийг шинэ арга технологээр шийдэх.

**Хоёрдугаарт:** Шинэ хотын онцлог тохирсон газар ашиглалтын одоогийн системчлэлийг улам боловсронгуй болгох.

**Гуравдугаарт:** Хотын бүтцийн бүрэлдэхүүнд багтах хотын чанартай олон нийт, үйлчилгээ, зам тээвэр, нийгэм эдийн засгийг барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн шаардлагатай газар, талбай байршлыг сонгон тогтоох, хангах, хадгалах, хамгаалах зарчмуудыг тодорхойлох.

**Дөрөвдүгээрт:** Хот байгуулалт, төлөвлөлтийн арга хэрэгсэл технологийн зах зээлийн нийгмийн бодлогтой уялдуулах замаар шинэ хотын архитектурыг хамгийн оновчтой түвшинд шийдвэрлэх.



**Шинэ хот байгуулах ач холбогдол.** Бүсийн тулгуур төв Шинэ хот байгуулалтын үзэл баримтлал нь Монгол улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудад нийцүүлэн тэнд амьдрах иргэдийн язгуур ашиг сонирхлыг хангах цогц илэрхийлэл болох.

Монгол улсын Үндсэн хуулийн "...хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, амрах эрхтэй..." гэсэн заалтыг хот байгуулалтын үзэл баримтлалын тулгуур зарчим болгож хот байгуулалтын цэгцтэй бодлогоор хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжтай орчныг газар нутаг, уур амьсгал, хүн ам, улс орны хөгжлийн хандлагатай уялдуулан бүрдүүлж, нийгмийн дэвшилд идэвхтэй нөлөөлнө.

Шинэ хотын хөгжлийн хандлага нь дэлхий дахины хот байгуулалтын түгээмэл зүй тогтол, шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэд ололтод түшиглэн тив-бүсийн нийтлэг үзэл баримтлал, тухайлбал: Ази-Номхон далайн бүс нутгийн хот байгуулалтын нэгдмэл бодлогын хүрээнд Монгол улсын хүн амын нутагшил, суурьшлын бүтэц, зохион байгуулалттай уялдуулан уламжлалт нүүдлийн болон суурин соёл иргэншлийн зохистой хослол бүхий нутаг дэвсгэрийн оновчтой тогтолцоог бүрдүүлж үндэсний архитектур, хот байгуулалтын дэвшилтэт уламжлалыг тусгасан олон улс гүрний тэргүүлэх хотуудтай энэ тэнцэхүйц үзэмж төгс, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн хувьд шударга, экологийн бүрэн баталгаатай, соёлын хангалуун нөхцлийг бий болгоно.

**Шинэ хот байгуулалтын харьцангуй давуу, болон сөрөг нөлөөллүүд.** Шинэ хотын нийгмийн дэвшилтэд нөлөөлөх харьцангуй давуу талууд нь Хангайн бүсийн өргөн уудам газар нутаг, онгон байгаль, эх газрын дөрвөн улиралтай уур амьсгал, байгалийн нөөц баялаг, хүн амын өсөлт, хөдөлмөрийн насны хүмүүсийн нөхөн сэргээх чадавхи, хүн амын дийлэнх хувь нь залуучууд байгаад оршино.

Шинэ хот бий болход үүсэх харьцангуй сөрөг талууд нь хүн амын нягтрал сийрэг, Хангайн бүсийн нутагт одоогийн хот суурин нь таруу байршсан, хүн амын





нилээд хувь нь нийслэлрүүгээ нүүсэн, хот байгуулалтын хөгжлийн тулгуур хүчин зүйл болох зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний найдвартай сүлжээ зэрэг дэд бүтэц сул хөгжсөн. Мөн шинэ хот байрлах газар инженер-геологийн нөхцлийн хувьд мөнх цэвдэг хөрс зохих хэмжээ тархсан, газар чичирхийллийн өндөр баллтай, усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн олдоц тийм элбэг биш.

Шинэ хот байгуулах харьцангуй эерэг нөлөөлөл нь шинэ хотоос бусад Хангайн бүсийн нийт хот суурин газрууд ерөнхий төлөвлөгөөтэй, хот байгуулалтын чиглэлээр улсын нийт нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн инженер-геологи газрын зураглалын баялаг материалтай.

Бүсийн тулгуур төв хот нь улсын төр, засаглал, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл, боловсролын төвлөрөл түүнчлэн оюуны чадавхи, мэдээллийн багтаамжаараа нийгмийн дэвшил, төрийн хот байгуулалтын бодлогод зохих түвшинд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж. Улс орны болон Хангайн бүсийн нийгмийн дэвшилд идэвхтэй нөлөөлж, улс орны нийгмийн хөгжил, эдийн засаг, соёлын түвшинг илэрхийлэх олон улсын жишиг болж болох тул агуулгаараа хот байгуулалтын бодлогод бодитой нэмэр хандив болно.

**Хот байгуулахад анхаарах асуудалууд.** Монголын газар нутаг, байгалийн нөхцөл, Монгол хүний байгаль орчноо дээдлэх түүхэн уламжлалтай нягт уялдаатайгаар хот айл, цэргийн хуаран, сүм хийдийн байршил тэдгээрийн төлөвлөлт, зохиомж, орон зайн харьцаа, зохион байгуулалтад мөрдөж хэвшсэн хот байгуулалтын үндсэн зарчмуудыг орчин цагийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад зохицуулах.

Шинэ хот байгуулалтын цогцолбор асуудлуудыг хот байгуулалтын нэгдсэн бодлогын хүрээнд Монгол орны нийт нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хүн амын нутагшил, суурьшлын тогтолцоо түүнчлэн харьцангуй бие дааж хөгжих Хангайн бүс нутгийн тулгуур төвийн хөгжлийн чиг хандлагатай харилцан уялдаатай авч үзэх

Шинэ хотын нийгмийн дэвшилд нөлөөлөх харьцангуй давуу, харьцангуй сөрөг нөлөөллүүдийг тооцсоны үндсэнд шинэ хотыг тэргүүлэх онцгой үүрэгтэй



гэж үзэн хотын архитектур, гоо зүйн түвшинг илэрхийлэх, нийгмийн сэтгэлгээ, оюун санааны өсөлт, таашаалд нийцүүлэн мөнхийн дурсгал болохуйц бүтээлийн түвшинд туурвих.

Шинэ хотын орон зайг Монголын хот байгуулалтын туулсан түүхэн замнал, нутаг дэвсгэрийн байршлаар нөхцөлдөн цогцлон бүрдсэн архитектур, хот байгуулалтын Европ-Азийн хослол шинжтэй хэв маягийг үндэсний агуулгаар баяжуулж, дүр төрх, зохиомж, орон зайн харьцаа хэмнэлээрээ монголын гэгдэх ялгарах онцлогтой, амьдралд хэрэгжих бодит тусгалаараа оршин суугчдын аж төрөх, хөдөлмөрлөх, соёлын хэрэгцээг нөхцлийг хангах хүмүүнлэг энэрэнгүй бичил орчныг цогцлон бүрдүүлэх

Хангайн бүс нутгийн түвшинд хүн ам, газар нутаг, уур амьсгал, байгалийн баялаг, ашигт малтмал эрдэс түүхий эдийн нөөц, зам, тээвэр, харилцаа холбоо, ус, дулаан, эрчим хүчний хангамж, хүрээлэн буй орчны тэнцвэр, нөхөн сэргэх чадвар, экологийн үр дагавар, нийгмийн салбаруудын хөгжлийн харилцан уялдаа, нүүдлийн болон суурин хэвшлийн зохистой харьцаа хот байгуулалтын даацад иж бүрэн үнэлгээ өгч газар зохион байгуулалт, зориулалт, эзэмшлийн чиглэлүүдийг тодорхойлж, Хангайн бүсийн нутаг дэвсгэрийн орон зайн, оновчтой бүтцийг бүрдүүлэх

Шинэ хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлэлтэд тулгуурлан бүсийн хөгжлийг тэтгэх зам тээвэр, харилцаа холбоо, орчин цагийн мэдээлэл, эрчим хүчний оновчтой сүлжээний тогтолцоог зохистой бүрдүүлсний үндсэн дээр дэд бүтцийн гол тэнхлэгүүдийг түшиглэн Хангайн бүсийн хот суурин газруудыг байршуулж, бусад чөлөөт нутаг дэвсгэрийг хөдөө аж ахуй, газар тариалан, амралт аялал жуулчлал, дархан газар, үндэсний парк зэрэг тогтсон чиглэл, тодорхой зориулалтаар эзэмших алс хэтийн хараатай бодлогоор зохицуулах

Нийгмийн хөгжлийг хангах тулгуур хүчин зүйлүүдийг Хангайн бүсийн түвшинд тодорхойлсны үндсэн дээр хүн төрөлхтөний соёл иргэншлийн түгээмэл зүй тогтлоор цогцлон бүрдсэн зохиомол орчин, байгаль орчны харилцан





шүтэлцээг зохицуулах шалгууруудыг шинэ хот байгуулалтын бодлогын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох

Шинэ хот байгуулах газрын харилцааг бүхэлд нь боловсронгуй болгож, шинэ хот болон дагуул хот суурингуудын нутгийн цэсийг шинэчлэн эдэлбэр газрын үнэлгээг зохих түвшинд боловсруулж, газартай харьцах өмчийн олон хэлбэрийн үйл ажиллагааг хот байгуулалтын бодлогоор зохицуулах хөшүүрэг бий болгох.

Шинэ хот байгуулалтын эдийн засгийн гол зорилт нь нийгмийн хөгжлийг хангах зорилготой нягт уялдаатайгаар бүс нутаг, хот орчмын бүс, хотын эдэлбэр газрын түвшинд цогц шинжтэй, харилцан шүтэлцээтэй харьцангуй бие дааж хөгжихөд чиглэсэн нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтворжуулах, сэргээн шинэчлэх замаар шинэ хотын тэргүүлэх болон онцгой үүргийн хүрээнд дэлхийн хотуудын жишигт хүрэх үндсийг бүрдүүлэхэд оршино гэдэгийг анхаарах.

Нийгэм эдийн засгийн цогц үр дүн нь хүн, газар, эрүүл саруул, орон зайн харилцан шүтэлцээг хот байгуулалтын цэгцтэй бодлогоор цогцлон бүрдүүлж, хэрэгжүүлэх дэс дараалал, арга замыг бодитойгоор тодорхойлох.

**Шинэ хотын нутаг дэвсгэрийн онцлог.** Бүсийн тулгуур төв шинэ хот байгуулахаар төлөвлөж байгаа Орхоны хөндий болох энэ нутаг орон маань төв Азийн цээжинд нутагтай малаа даган нүүдэллэдэг Монголчуудын эртний нийслэл Хар Хорум хотын туурын ойролцоо орон нутгийн байгаль, түүхийн онцлог шинжийг өөртөө бүрэн шингээсэн, ирээдүйд хүний ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн хот байгуулалтын чиг хандлагад нийцсэн нутаг дэвсгэр билээ.

Шинэ хот байгуулах энэ газар нутаг маань Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хар хорин, Архангай аймгийн Хотонт, Хашаат сумуудын нутаг дэвсгэрийг хамарсан Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газар бөгөөд Төв Азийн нүүдэлчид түүний дотор монгол үндэстний буй болгосон нүүдлийн соёл иргэншил, түүний гарал үүсэл, хөгжлийн археологи, түүх соёлын баялаг дурсгалтайг нотлон харуулж байгаа дэлхийд данстай гайхамшигт түүхэн нутаг юм.



Шинэ хот байгуулах Орхоны хөндийн нутаг дэвсгэрийн  
бодит байдал


Хангайн бүсийн тулгуур төв хот







Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотыг байршуулах нутаг дэвсгэрийн тогтолоцоо





Хархорин сум байрласан Орхоны хөндий гэдэг нутаг маань Мойлтын ам, Орхоны долоогийн бууцан дахь хуучин чулуун болон хүрэл, төмрийн зэвсгийн үеийн эртний хүмүүсийн оромж, хот суурины балгас, Түрэгийн үеийн хаадын тахил шүтээний алдарт гэрэлт хөшөөнүүд, Уйгарын эзэнт гүрний нийслэл Хар балгас хотын туйр, Чингис хааны 1220 онд үндэслэсэн Монгол эзэнт гүрний нийслэл Хар Хорум хотын туйр, Монгол дахь Бурханы шашны болон Уламжлалт анагаах ухааны төв болсон Эрдэнэ-Зуу, Төвхөн хийд, Шанхийн их номын баруун хүрээ зэрэг түүх, соёлын хөшөө дурсгал, байгалийн үзэгслэнт газруудыг хамарсан 120 гаруй мянган га өргөн уудам газар нутаг дэвсгэр билээ. Иймээс ч энэ утгаар нь Юнеско эдгээр дурсгалт газруудыг дэлхийн соёлын өвд бүртгэн авч баталгаажуулсан юм. Тэгэхээр Хар хорин сумыг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа энэ төслийн хүрээнд дэвшигдэж буй хотын байршлын асуудлыг Орхоны хөндийтэй уялдуулан (14, 15, 16 дугаар зураг) улам нарийвчлан авч үзэх шаардлагатай болсон.


Иймээс одоогийн Хар хорин сумын төвийг өргөтгөн Хангайн бүсийн тулгуур төв болгон хөгжүүлэх хот байгуулалт, төлөвлөлтийн төслийн хүрээнд сонгон авсан нутаг дэвсгэрийг тэлж, “Орхоны хөндий” гэж төсөлд тусгагдсан нэрээр нэрлэж байгаа хэрэг.

Одоогийн Хархорин сумын төв байгаа газар нь Орхоны хөндийн түүхийн дурсгалт газрын дэлхийн өвд бүртгэлтэй хамгаалалтын бүсээр хүрээлэгдсэн учир энэ газарт ирээдүйд том хот байгуулан өргөжин тэлэх орон зай, талбай муутай юм. Тэхээр шинэ хот байгуулах нутаг дэвсгэрийг сумын төвөөс 20-иод км-ийн зайд орших Хөгшин Орхон голын хөндийн тэгшивтэр талбайг сонгон тогтоох болсон юм. Энэ утгаараа Орхоны хөндийтэй холбох шаардлагын үндэслэл болж байгаа билээ. Энэ нь ч оновчтой сонголт болж байгаа хэрэг. Харин одоогийн Хархорин сумын барилга байгууламж архитектурыг нь хэвээр хадгалах замаар сумын төвийн нутаг дэвсгэрийг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх шийдэлд хүрч улмаар шинээр байгуулах хотын дагавар хот маягаар түүхийн дурсгал, , байгалийн музейн цогцолбор, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх нь хамгийн зохимжтой гэж үзсэн.





ХОТЫН БАЙРШИЛ, ОРЧНЫ ТОЙМ



**Эрдэнэзуу хийд**  
 Монгол оронд түүхийн Бурханы шашин дэлгэрэж байгаад, Анхны буддын сүм, 16-р зууны эхээр Орхон хөндийг шашны төв болгох зорилгоор Чингис хааны алтан урт Алтай сайн хаан Бурхан шашны Эрдэнэзуу хийдийн суурийг тавьжээ. Энэ хийд нь дэлхийн голлох шашнуудын нэг болох бурханы шашны соёл, уламжлал, сүм дуганы уран барилгын тод жишээ юм. Уг сүмийн зарим хэсгийг коммунист дэглэмийн үед 1930-1940 оны үед устгасан байна.

**Хөшөө Цайдмын бунхант булш.**  
 Хашаат сумын нутаг, Хөгшин Орхон голын зүүн эрэгт Цайдам нуурын баруун урд Эрдэнэ зуу хийдээс зүүн хойш 47 км зайтай газарт хоорондоо холгүй эртний бунхант булш хоёр байдаг хийгээд ал газар Хөшөө Цайдам ажээж ажгуу. Энэжүү хөшөө дурсгал нь Монголын түүхэнд хожуу үеийн Дорнод Түрэлжин хаант улсын (690-745) цэргийн гарамгай жанжин Кул-Тегин, түүний ах Улсын их Хаан Могилын буюу Билгэ-д зориулан босгосон тахил шүтээний цогцолбор болмуу.

**Хар Балгас**  
 8-р зууны үеийн Уйгурын эзэнт улсын нийслэл хот. Ордон, сүм, дуган, дэлгүүр г.м маш олон тооны сүрлэг байгууламжуудтай. 50 хавтгайдөрвөлжин км нутаг дэвсгэрийг хамран оршиж байна. Хот нь 5x10км, ордон нь 412x91м

**Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын түүрэг**

**ТАНИХ ТЭМДЭГ**

**ТӨВ СУУРИН**

- Бүсийн тулгуур төв
- Бүлэг суурингийн төв
- Сумын төв

Төлөвлөж буй хотоос 20-50км-ийн зайд байрлах суурингуудын зайн хэмжээ

**ҮНДСЭН ТЭНХЛЭГ**


- Хэвтээ тэнхлэг мянганы зам
- Хатуу хучилттай зам зам
- Шороон зам

**ХИЛ**


- Аймгийн хил
- Сумын хил
- Одоо байгаа нисэх онгоцны буудал
- Дурсгалт газрууд
- Өгий нуур
- Орхон гол

**Зураг 14**





15 дугаар зураг



16 дугаар зураг


Шинэ байршил нь Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгалаа олон улсын хөгжлийн гол хэвтээ тэнхлэг болох Мянганы зам болон Хангайн бүсийн хөгжлийн босоо тэнхлэгтэй (17 дугаар зураг) огтлолцох стратегийн чухал ач холбогдолтой цэгт ойрхон очиж энэ утгаараа ч улс орны нийгэм эдийн засгийн зүй ёсны шаардлагатай нийцэж байгаа юм.

Шинэ хотын хот байгуулалтын төслийг боловсруулахдаа нутаг дэвсгэрийнх нь байгаль, экологийн даацын судалгаа шинжилгээ хийх, хот байгуулалтын урьдчилсан үнэлгээ гаргах, зориулалтын бүсчлэл, архитектур төлөвлөлт, барилгажилт, зам тээврийн сүлжээ, инженерийн дэд бүтцийн хангамж, ландшафт төлөвлөлт зэрэг монголын уламжлалт хот төлөвлөлтийн арга хэрэгслүүдийг авч



хэрэгжүүлснээс гадна олон улсын хот байгуулалтын практикт түгээмэл хэрэглэж байгаа төлөвлөлтийн зарим чиг хандлага, барилга-хот байгуулалтын уламжлалт бус арга технологи, стандартыг тооцож хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Тухайлбал нийгмийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах үүднээс жишиг хотын гудамж, замуудыг урсгал тусгаарласан тусгай зорчих зурвастай байхаар төлөвлөх, чөлөөт орон зай сайтай гудамж замын норм стандартыг бий болгох, суурьшлын бүсийн зохистой байршлуудыг тодорхойлох нийтийн болон тусгай зориулалттай түр зуурын хийгээд удаан хугацааны авто машины зогсоолуудыг төлөвлөх, цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийг нормын түвшинд байлгах зэрэг хот байгуулалтын олон улсын болон үндэсний норм дүрмийн шаардлагуудыг хот байгуулах төсөлийн шатанд аль болохоор түлхүү тусгаж өгөхийг хичээсэн. Энэ ч утгаараа шинээр гарч буй орон сууцны болон хот төлөвлөлтийн норм дүрэм боловсруулах нэг талын тулгуур материал болж байгаа юм.

### МЯНГАНЫ ЗАМ БОЛОН БОСОО ТЭНХЛЭГИЙН ДАГУУХ ШИНЭ ХОТЫН БАЙРШИЛ



17 дугаар зураг

Ер нь хотжих үйл явц дэлхий нийтийн соёл иргэншлийн орчин үеийн түгээмэл хандлага боллоо. Хотын хүн амын өсөлт, байгаль орчинд үзүүлэх сөрөг



нөлөө урьд үзэгдээгүй түвшинд хүрч, цаашид хотын хөгжлийг зүй зохистойгоор залах асуудал олон улсын хэмжээний тулгамдсан зорилтын нэг болоод байна.

Хотжих үйл явц нь нийгэм эдийн засгийн хөгжлийн хурдац, шинжлэх ухаан техник, технологийн дэвшил, орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч хот байгуулалтын харилцан уялдаатай олон талын асуудлыг хэтийн хараатай чиглэсэн бодлогоор зохицуулагдах бол ямар сөрөг үр дагавар гардгийг дэлхийн олон улс орон хүлээн зөвшөөрч хот байгуулалтын оновчтой бодлого, үндэсний чиг баримтлал боловсруулж хэрэгжүүлэх талаар ихээхэн анхаарч байна. Хот байгуулалтын зөв бодлогод тухайн улс, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогт нийцүүлэн зохицуулах асуудлын гол нь амьдралын зохиомол орчин болон байгаль орчны харилцан шүтэлцээ, хотжих үйл явцаас үүсэх үр дагавар, үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлахад оршино гэж үзэж байна. Энэ чиглэлээр олон улсын хэмжээнд тухайлбал НҮБ-ын шугамаар түүнчлэн тив, бүсийн нутгийн түвшинд ихээхэн анхаарч олон чухал баримт бичиг гарсныг аль ч улс орон төрийн бодлогын түвшинд авч үзэж Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлдэг түгээмэл хандлагад ороод байна.

**III.1.2 Шинэ хотын архитектур хот төлөвлөлтийг шийдэхэд баримталсан тулгуур зарчим.** Шинэ хотын орон зайн төлөвлөлт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, архитектурын хөгжлийн чиг хандлагыг хот байгуулалтын онол арга зүйн дараах үндсэн зарчмуудыг үндэслэн тогтоов. Үүнд:

-Улсын түвшинд бүсүүдийн тулгуур төв хотуудыг жигд хөгжүүлж, тухайн бүс нутгийг нь стратегийн томоохон орд газрууд болон аж үйлдвэрийн цогцолборуудын хөгжлийг дагасан хүн амын шилжилт, суурьшлыг оновчтой түвшинд барих,

-Аливаа хөгжилтэй хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах үүднээс Шинэ хотын дагуул хот, тосгон, суурингуудыг үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлээр жигд тэнцүү түлхүү хөгжүүлэх орон зайн орчин бүрдсэн хилийн цэсийг тогтоох,



-Хотын хүн амын хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээний нийлүүлэлтийн найдвартай орон зайн орчин бүрдсэн бичил бүсүүдийг нийгэм-эдийн засгийн чиг үүрэгтэйгээр төрөлжүүлэн хөгжүүлэх,

-Хүн амын механик өсөлт, хотын хэт төвлөрлийг сааруулах бодлогын хүрэнд оршин суугчдын амьдралын эрэлт хэрэгцээ, тэдний ажиллаж, амьдрах тохилог орон зайн орчин бүрдүүлэх,

-Хүн амын бүхий л хэрэгцээт эрүүл мэнд, төрийн зохицуулалт, боловсрол, нийгмийн, эдийн засгийн шаардлага, худалдаа, үйлчилгээний орон зайн нэгдсэн систем бий болгох,

-Шинээр байгуулах хотыг төлөвлөлтийн орчин үеийн шинэ технологи бүтэц загвараар тооцож төлөвлөх,

-Хотын архитектур, хот зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн онцлог, шаардлагад нийцсэн нормативын ногоон байгууламжийн цогц системийг бий болгох,

-Хотын суурьшлын бүсийг нам давхрын барилга, өндөр барилга, үйлдвэр хөдөө аж ахуйн ажил эрхлэлтийн хороолол, гэр, жижиг байшин хороолол гэсэн бүтэц хэв шинжтэй төлөвлөх,

-Хотын суурьшлын бүс нь хотын төвийн, бусад төвүүдийн, хотын захын гэсэн суурьшлын хэв шинжтэй байж тэдгээр нь дэд бүтэц, инженерийн системээр бүрэн хангагдсан байх,

-Хотын суурьшлын бүсийн нягтралыг байршилтай нь уялдуулан 20-45 хүн/га болгох.

-Хотын хаяа, дагуул хот, тосгодыг үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, иргэд ажиллаж, амьдрах тохилог орчин бүрдсэн хот, хоторхуу тосгон болгон үе шаттай хөгжүүлэх нөхцлийг хангах,



-Шинэ хотын хаяа, дагуул хот, тосгодод хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэх нөхцлийг бүрдүүлж ажлын байр олноор бий болгож хүн амьдрах таатай тохилог орчин бүрдүүлэх,

-Шинэ хотын орон зайн орчны хөгжлийг тэнцвэржүүлэх зорилгоор олон төвт хот болон хөгжүүлэх,

-Хотын нутаг дэвсгэрийг орон зайн бүтцийн хувьд хот төлөвлөлтийн жигд тархсан бүсүүдээр хуваан хөгжүүлэх,

-Хотын нутаг дэвсгэрийг суурьшилд тохиромжтой, байгалийн гамшигт, аюулд өртөх магадлал багатай хэсгүүд болгон ангилаж хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх,

-Гэр хорооллыг төвийн, дундын, захын гэж ангилан орон сууцны хорооллын зарчмаар хөгжүүлэх,

-Суурьшлын бүсийг өндөр, дунд, бага нягтралтай буюу амины орон сууцны, гэр хорооллын гэсэн ангилалтай хөгжүүлж түүнийг орчных нь архитектурын дурсгалт байгууламжуудтай орон зайн хувьд уялдуулан төлөвлөх,

-Хотын эдэлбэр газрын ашиглалт, хот төлөвлөлтийн бүсчлэлийн тогтолцоог шинэ технологээр шийдвэрлэлэх,

-Хотын нутаг дэвсгэр газар ашиглалт, барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг тодорхой болгосон бүсчлэлийн нэгдсэн тогтолцоонд оруулах,

-Хотын гудамж замын сүлжээнд метро, тусгай замын автобус нийтийн тээврийг өргөн ашигласан, өндөр ашигтай, гудамж замын нэгдсэн цогц сүлжээг бий болгох,

-Хотын орон зайн зохимжинд нийцсэн нийгмийн болон инженерийн дэд бүтцийг системтэй хөгжүүлж, орон сууцны нам давхар, өндөр давхар, тусгай сууцны хэв шинж бүхий хорооллуудыг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хамт цогцоор нь барьж байгуулах,





**Шинэ хотын орон зайн хөгжлийн үндсэн чиглэл:** Хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хотын хөгжилд нөлөөлөх нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, ашиглалтыг боловсронгуй болгох, бүлэг суурингуудын хөгжсөн системийг бүрдүүлэн дагуул хот суурингуудыг (4 дүгээр зураг) бүх талаар эрчимтэй хөгжүүлэх, хот байгуулалтын зохистой орчин, нутаг дэвсгэрийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хотын газар нутгийн үүрэг зориулалт ба хот байгуулалтын бүсчлэлийн системийг тогтоох.

-Хотын хүрээлэн буй орчин, экологийн хувьд: Агаар, ус хөрсний бохирдлоос хамгаалах, ногоон байгууламжтай байх, усны эх үүсвэр болон нөөц газар, хотын ногоон бүсийг хамгаалах замаар экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, зэрэг менежментийн зарчмыг төлөвлөлтөнд тусгах.

-Хотын орон зайн төлөвлөлтийн шийдэл нь урьд өмнө хийгдэж байсан төлөвлөлтийн агуулга, шийдэлтэй харьцуулахад агуулга, хэлбэр дүрсээ үндсээр нь өөрчилсөн, зах зээлийн улс орнуудын хотын бүтэц, зохион байгуулалтанд зохицсон, хот байгуулалтын болон холбогдох бусад хууль эрх зүйн орчинд нийцсэн, хотын хөгжлийн жам ёсыг дагасан байх.

-Хотын олон талт үүргийн нэгдмэл систем бүрдүүлэх замаар үйл ажиллагааг нь жигд хангахуйц хотын бүтцийг бий болгох, цаашид боловсронгуй болгон зохион байгуулах, хотын чанартай олон нийт, үйлчилгээ, зам тээвэр, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг хөгжүүлэх бодлогод зохицсон байх.

-Оршин суугчдын тухайн үеийн болон ирээдүйн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн, шинэ нөхцөлд хотын тогтвортой хөгжлийг дэмжих үндсэн чиг хандлагуудыг тогтоож өгөх.

-Байгалийн үзэсгэлэнт газар буюу байгалийн цогцолборт газруудын тэнцвэрт байдал, хүний үйл ажиллагаанаас үүдсэн хүрээлэн буй орчны экологийн аюулгүй байдлыг хангах.



-Хот төлөвлөлтийн уламжлалт аргуудыг ашиглан нутаг дэвсгэрийн уялдаа холбоо, орон зай, гоо сайхны иж бүрэн зохицол бүхий таатай орчин бүрдүүлэх.

-Тээвэр, инженерийн дэд бүтцийн аюулгүй байдлын шаардлагуудыг хангах.

-Хотын үйлдвэрийн бүсчлэлийн тогтолцоог боловсронгуй болгож, газар ашиглалтыг сайжруулах.

-Худалдаа, амралт, аялал жуулчлал, төрөл бүрийн үйлчилгээг олон улсын түвшинд шийдвэрлэх.

-Иргэдийн зорчих хөдөлгөөнийг саадгүй болгохын тулд нийтийн тээврийн үндсэн тэнхлэгүүдэд хүч хөдөлмөр, цаг хугацаа хэмнэсэн үр ашигтай **нийтийн тээврийн тогтолцоог** бүрдүүлэх.

**III.1.3 Шинэ хотын архитектур, орон зайн төлөвлөлтийн үндсэн зарчим.** Шинэ хотын нутаг дэвсгэрийг ашиглалтын зориулалтаар нь суурьшлын, үйлдвэрийн, амралт зугаалгын, хот орчмын гэж үүргийн бүсчлэлээр нь ангилан боловсруулалтын түвшинд архитектур, нутаг дэвсгэр орон зайн төлөвлөлтийн нэгдмэл байдалын зарчмыг баримталлаа.

Энэхүү ангиллын эдэлбэр газар бүр орон сууцны, олон нийтийн, төвийн, үйлдвэрийн, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуйн, агуулахын, зам тээврийн, олон нийтийн амралт зугаалгын, амралт-сувилалын, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангасан үүрэг зориулалтын бүсчлэлтэй (18 дугаар зураг) байна.

Шинэ хотын төлөвлөлтөд хот төлөвлөлтийн хамгийн оновчтой хэлбэр болох дөрвөлжин төлөвлөлтийн зарчмыг сонгон авч зах зээлийн шинэ эдийн засаг дээр тулгуурласан хот болгож хөгжүүлэх нь зүйтэй гэж тооцсон. Энэ тооцоо хэрэгжинэ гэдгийг барууны хотууд шинэ нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан хот төлөвлөлтийн шинэ арга болох дөрвөлжин төлөвлөлтийг үндэслэн хөгжиж ирснээр тайлбарлаж болно. Бүсийн тулгуур төв энэ хотын нутаг дэвсгэрийг дөрвөлжин төлөвлөлтийн зарчмаар шийдэснээр газрын үнэ, газар зохион байгуулалтын шинэ шаардлагуудад бүрэн нийцэж байгаа хэрэг. Ингэснээр газрын хамгийн зөв





ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:25000

Зураг 18









зохистой ашиглалт тэнд бий болж хотын гэрэл гэгээтэй орон зайн бодитой орчин үүснэ. Ер нь дэлхий нийтээрээ хот төлөвлөлтийн чиглэл урсгалуудыг үндсэнд нь **1. Классицизм, 2. Функционализм буюу модернизм, 3. Урбанизмын сэргэн мандалтын үе** гэж 3 том бүлэгт хувааж үздэг.

Хот төлөвлөлтийн (Хелсинк хот, Стокгольм хот) дээрхи бүхий л чиглэл урсгалууд өмнөд болон баруун Европоор дамжин Хойд Европын орнуудад нөлөөлсөн түүхтэй. Харин эдгээр урсгалууд Монголд тун багаар нэвтэрсэн. Гэхдээ Монголд функционализм буюу модернист урсгал нь тодорхой хэмжээгээр хэрэгжсэн ч 3 дахь чиглэл буюу урбанизмын сэргэн мандалт хараахан хэрэгжиж амжаагүй байна. Иймээс бид шинэ хотын архитектур хот төлөвлөлтийн энэ имижийг бий болгох зорилт тавьсан юм. Дөрвөлжин төлөвлөлт нь функционализмийн эхэн үе болох 1930-аад оноос 1970-аад оны хооронд хот төлөвлөлтийн хэлбэр агуулгаа алдсан гэж үздэг

### ЕВРОПИЙН ОРНУУДАД НЭВТЭРСЭН ХОТЫН ДӨРВӨЛЖИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



Функционализмын урсгал нь бидний үзэж байсан капиталист нийгэмд тулгуурласан хүчтэй эдийн засаг гэхээсээ илүү хүн амд эрүүл агаар, хүрэлцээтэй орон зай, их хэмжээгээр бүтээн босгох боломжийг тооцсон урсгал байв. 1970-аад оноос энэ төлөвлөлтийн урсгалд баруун Европ болон хойд Европын орнууд шүүмжлэлтэйгээр хандаж хотын үндсэн бүтэц болох дөрвөлжин төлөвлөлтийг шинэ шатанд гаргах, хүний масштабтай хотын орон зайн шийдлийг бий болгох зорилт дэвшүүлж хэрэгжүүлж эхэлсэн. Энэ үеэс хотын барилга байгууламжийн тооноос чанарт шилжих шинэ үе эхэлсэн гэж үзэж болох талтай. Өөрөөр хэлбэл



хот төлөвлөлтөнд хамгийн их нөлөөлөгч хүчин зүйл болох орон сууцны хорооллын төлөвлөлт нь хот төлөвлөлтийн шинэ элементүүдээр баяжих боломж бүрдэж байгаа хэрэг. Ингэж Урбанизмын сэргэн мандалтын төлөвлөлтийн шинэ чиглэл урсгал хэрэгжиж эхэлсэн байна. Шинэ хотын төлөвлөлтийг ийм зарчмаар шийдэснээр газар зохион байгуулалтын оновчтой төлөвлөлт хийх, барилгажих талбайг зөв шийдэх боломж бүрдэж байгаа юм.

Хотын нутаг дэвсгэр, орон зайн энэхүү шинэ бүтцийг хэрэгжүүлснээр эдийн засаг, санхүүгийн хувьд ашигтай болох боломж бий. Шинэ автозамын бүтэц бий болгосноор хотын төвийн “А” зэрэглэлийн нутаг дэвсгэрийн үнэлэмж, үнэ эрс өснө. Замаа дагасан газрын нийт талбайн хэмжээ 4-6 дахин нэмэгдэнэ.

Хотын шинээр барилгажих нутаг дэвсгэр орон зай нь Хотын гол төв, хотын бусад төв, олон нийтийн төв, ажил хэргийн төв, хотын хөгжлийн тэнхлэг, орон сууцны хороолол, өндөр технологийн төв, ложистик төв, холимог үйл ажиллагааны хэсэг, үйлдвэр агуулах, аж ахуйн хэсэг, инженерийн барилга байгууламж, (төлөвлөлтийн үндсэн зарчим 19 дүгээр зураг) тусгай зориулалтын бүс, ногоон байгууламж, хамгаалалтын ногоон зурвас, гудамж замын улаан шугам зэрэг үндсэн хэсгээс бүрдсэн хот байгуулалтын олон төвт систем үүснэ.


Хотын төв, бусад төвүүдийн орчимд Улс, Хотын төр захиргаа, яам тамгын газрууд, олон нийт худалдаа, үзвэр үйлчилгээ, дээд боловсрол, улсын чанартай томоохон эмнэлгүүд, олон улсын байгууллагууд хэт төвлөрөн байрлаж үйл ажиллагаа явуулдагаас ажиллах хүн амын урсгалыг (төлөвлөлтийн үндсэн зарчим 20 дугаар зураг) хотын захаас төв рүү татсан төвлөрлийг бий болгодог төлөвлөлтийн нэг төвт зарчимтай өмнөх дутагдлыг арилгахад чиглэгдсэнээрээ Шинэ хотын Архитектур орон зайн төлөвлөлт онцлогтой болсон юм.







### ОЛОН ТӨВТ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТАЛЖ ИРСЭН ҮНДСЭН ЗАРЧИМ



20 дугаар зураг

Ингэснээр хотын орон зайн зохиомжийг бүрдүүлэгч үндсэн элементүүд болох хотын төв, бусад туслах төвүүдэд дараах давуу байдлыг бий болгоно. Үүнд:

- Суурьшлын бүс нормативын хүрээнд тогтоогдоно.
- Эдийн засгийн хямд өртөгтэй дэд бүтэц бий болж шийдэгдэнэ.
- Гудамж замын хөдөлгөөний бөглөрөл, түгжрэл арилах нөхцөл бүрдэнэ.
- Нийтийн тээврийн зорчилтын хугацаа богинсоно.
- Зам тээврийн осол, гэмтлийн өсөлт буурах боломжтой болно.



- Бараа түүхий эдийн тээвэрлэлтийн өндөр өртөг, зардал багасах нөхцөл бүрдэнэ.
- Агаар, дуу чимээний бохирдол үндсэндээ үгүй болох сайн талууд бий болно.

Үүний үр дүнд нь хотын доторх ажил үйлчилгээний хэт төвлөрөл арилж, хүн амын урсгал, хөдөлгөөнийг хэд хэдэн чиглэл болон нутагшилт суурьшлын 8 тэнхлэгт байрласан 10 төвд жигд тараан байрлуулах боломж бүрдэнэ. Энэ утгаараа хот байгуулалтын оновчтой шийдэл болж байгаа юм.

Хотжих үйл явцад газар ашиглалтын менежментийг хувьд ямар ч бодлогогүй шийдэх юм бол, аль ч хотын хувьд хяналтгүй тэлэлт болж бололцоотой бүх л газрыг замбараагүй бүрхэх болно. Хотын нутаг дэвсгэр дээр ямар ч зохицуулалтгүй эмх замбараагүй хөдөлгөөн үргэлжилбэл хотыг гамшгийн түвшинд хүргэж, хотын эдийн засгийн өгөөжийг бууруулна. Иймээс хотын энэхүү өсөлтийг хотын эдийн засгийн хөгжилтэй зохицуулах асуудал зайлшгүйчухал гэж үзлээ. Энэ үүднээс шинэ хотын төлөвлөлтөд хэд хэдэн шинэ суурьшлыг зэрэгцүүлэн бий болгох замаар хотыг хяналттайгаар тэлэх хэв маягийг санал болгож байна. Энэхүү тооцоо шинэ хотын газар ашиглалт болон барилгажилтыг нягтрал сайтай орон зайн оновчтой зохиомжоор шийдэх боломж олгосон.

Шинэ хотын төлөвлөлтөд ашигласан өөр нэг хувилбар бол хотын өсөлтийг залж чиглүүлэх боломж бүрдэж хотын хяналтгүй тэлэлтийг зогсоож Нягт суурьшилтай цэгцтэй хотыг бий болгох нөхцөл бүрдсэн.

Үүний үр дүнд шинэ хот үндсэндээ нягт суурьшилтай цомхон байна. Ингэснээр дор дурдсан шаардлагад нийцсэн байгаа юм. үүнд: Суурьшил нь нягтрал сайтай, автомашины хамаарал багатай, зэрэгцээх нутаг дэвсгэрээс тодорхой хилээр зааглагдсан, газар ашиглалтын зориулал нь үүргийн бүсчлэлээр зохицсон, нийгмийн шударга ёс төлөвшсөн, өдөр тутмын амьдралын бие даасан байдал хангагдсан байх болно.

Энэ бүгд эцэстээ шинэ хот Нягт суурьшилтай цомхон болсноор хотын хүн ам огцом өсөх тохиолдолд хотын байгаль орчны тогтвортой тогтолцоо болон



эрчим хүчний хэмнэлттэй хотын бүтцийг бий болгох төлөвлөлтийн оновчтой шийдэл болж байгаа юм. Үүнээс гадна Нягт суурьшилтай хот нь: төлөвлөлтийн дараах давуу байдлыг бий болгоно. Үүнд:

1. Өндөр нягтралтай суурьшил ба худалдаа арилжаа бизнесийн чиглэлээр газрыг эрчимтэй ашиглах нөхцөл бүрдэнэ.
2. Эрчим хүч хэмнэхэд үр дүнтэй ашиглахад мөн нөөцийг дахин ашиглахад чиглэсэн хотын тогтолцоог бий болгоно.

Өөр нэг давуу тал нь хотын барилгажсан хэсэгт шинээр нүүдэллэн ирэгсдийг яаж нягт суурьшуулах боломжтой болон бодит нөхцөлд нягтралыг хэрхэн нэмэгдүүлэхийг тогтооно. Тэгээд зогсохгүй хотыг дахин хөгжүүлэх, шинэчлэн зохион байгуулахад хялбар болгох урьдчилсан нөхцөл болно.

Шинээр төлөвлөж буй нягт суурьшилтай энэ хотын хүн амын дундаж нягтрал 85 хүн/ га байна. Энэхүү үзүүлэлтээс харахад нягт суурьшилтай хот нь хотын төв хэсгийн нягтралыг илүү нэмэгдүүлэх замаар хотын захын хэсгийн тэлэлтийг хянах боломж бүрдэнэ. Иймээс нягт суурьшилтай хотын давуу талууд нь илүү үр ашигтай тээвэр, иргэдийн зорчилт нэмэгдэх, үр дүнтэй дэд бүтцийн сүлжээ, өртөг хэмнэх, хотын хэмжээнд учрах хүрээлэн буй орчны ачааллыг багасгах бололцоог олгож байгаа юм.

Бүсийн тулгуур төв энэхүү шинэ хотын нутаг дэвсгэрийн ашиглалт зориулалтын бүсчлэлийг нормативын шаардлагад нийцүүлэн тогтооход анхаарч эдгээр бүсүүд нь хоорондоо болон хотын чанартай олон нийт, нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжийн архитектур, тээврийн болон инженерийн дэд бүтэцтэй оновчтой зохицсон, ялангуяа хотын архитектур-орон зайн тогтолцооны нэгдмэл зарчим байгаль, цаг уур, физик газар зүй, газар хөдлөлийн тогтолцоо, инженер-геологи, экологи, хүрээлэн буй орчны нөхцөл, орчны ландшафтын онцлогуудтай уялдсан байхаар тооцов.

Шинэ хотын нутаг дэвсгэрийн газар доорхи ойролцоогоор 1200 га талбайд орон зайд хотын тээвэр, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний болон





агуулахын барилга байгууламж, үзвэрийн ба спортын тухайлсан байгууламж, инженерийн тоног төхөөрөмжийг байршуулахаар тооцлоо.

Хотын бүтээн байгуулалтыг 2040 оны үед гэж тооцож байгаа бөгөөд тэр үед энэ хот 1000000 орчим хүн амтай байна гэж үзлээ. Төлөвлөлтөөр шинэ хотын нутаг дэвсгэр нь дагуул аймаг, сум, хот тосгодын (төлөвлөлтийн үндсэн зарчим 21 дүгээр зураг) нутаг дэвсгэрийн хамт нийтдээ 60 орчим мянган га нутаг дэвсгэрийн хүрээлэлд хөгжинө.

Хотын орон зайн тогтолцоо нь байгаль экологид хоргүй, оюуны өндөр багтаамжтай үйлдвэрлэл, шинжлэх ухаан, мэдээллийн өндөр технологийн парк, банк, санхүү, бизнес, худалдаа үйлчилгээ, соёл боловсрол, жижиг дунд үйлдвэрлэл давамгайлсан олон үүрэгт орчин үеийн хотын түвшинд байна. Мөн хотын орон зайд ложисткийн систем бүхий хотын үйлдвэрийн дүүрэг өөрийн зориулалтаар байхаас гадна сургалтын цогцолборууд, оюутны хотхон, ногоон байгууламжийн иж бүрэн систем зэрэг хот бүрдүүлэгч элементүүд бие даасан байдлаар байрлана.

Барилгажих нутаг дэвсгэрт дагуул хот тосгодын дундуур урссан Орхон голын хамгаалалтын нийт 30 мянган га газар нутагтай хотын хилийн цэсийн доторхи барилгажилтын бүсийн 15 мянган га нутаг дэвсгэр нь энэ бүсэд хамрагдана. Хилийн гадна барилгажилтыг хязгаарлаж, тухайн нутаг дэвсгэрийг хотын ногоон бүсэд хамруулахаар тооцлоо. Хилийн цэсийн гадна байрлах ногоон бүсийг тусад нь хамгаалалтын захиргаа, бусад холбогдох нэгжүүдтэй нь хамт байршуулан хөгжүүлнэ. Ирээдүйд барилгажилтын нутаг дэвсгэрт хот байгуулалтын бүсчлэлийн тогтолцоог шинээр боловсруулж хэрэгжүүлнэ.

**Хотын эдэлбэр газрын үүргийн бүсчлэл.** хотын нутаг дэвсгэрийг хотжилт барилгажилтыг хязгаарлах нутаг дэвсгэр болон барилгажих нутаг дэвсгэр гэж хоёр ангилна. Хотжилтыг хязгаарлах нутаг дэвсгэрт гамшгийн аюулд нэрвэгдэж болзошгүй газар, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, бэлчээрийн газар, ойн сан болон усны нөөц газрууд хамрагдана. Улсын тусгай хамгаалалтын газар нутаг хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлан хориглох нутаг дэвсгэр хамрагдана.





Хотын барилгажих нутаг дэвсгэрийг байгаль хамгаалах бүсчлэл цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолбор, иргэдийн амралт жуулчлалын бүстэй уялдуулан төлөвлөнө. Барилгажих нутаг дэвсгэрийн гудамж замын дагуу, хүүхдийн парк, сургууль, эмнэлэг болон нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламж барьж байгуулна.


Хотжилт барилгажилтыг хязгаарлах нутаг дэвсгэр нь байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшгаас сэргийлэх хязгаарлалтын бүсийн үүрэг гүйцэтгэнэ. Энэ бүсэд мод ургамал тарьж ургуулах, ургамал амьтны аймгийн өсч үржих нөхцлийг хангах байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалан үлдээх нутаг дэвсгэр хамрагдана.

Хотын үндсэн болон туслах төвүүдийг хурдны зам, нисэх буудал болон төмөр зам руу нэвтрэх замууд зэрэг гол замуудтай зохистой орон зайд холбож төлөвлөнө. Хотоос 90 км-ийн зайд шинээр барих олон улсын шинэ нисэх буудал нь аялал жуулчлалыг дэмжих орон зайд байгуулагдана. Энэхүү шинэ нисэх буудал нь одоогийн нисэх буудлаас 5 дахин том, 3200 метр урт хөөрөх, буух зурвас, терминалын байгууламжуудтай, жилд дунджаар 1,9 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай байна.



Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал




21 дүгээр зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал



22 дугаар зураг





Нисэх буудлын хотхоны олон улсын орц гарцын давуу байрлалд нь тулгуурлан эдийн засгийн болон бизнесийн цогц үйл ажиллагаа хөгжүүлэх орон зайн зохион байгуулалттай байна. Нийсэх буудлын хотхонд дөрвөн төрлийн бизнес эрхлэх боломж бүрдүүлнэ. Үүнд:

- Аялал жуулчлал болон аялал жуулчлалтай холбоотой үйлдвэр, үйлчилгээ
- Нисэх онгоцны засварын газар, агаарын ачаа тээврийн төв, онгоцны сэлбэг түгээх төв, нийтийн хоолны газар
- Мэдлэгт суурилсан бизнес үйлчилгээ
- Жижиг дунд үйлдвэрлэлийн бизнес эрхлэх үйлчилгээ зэрэг зохион байгуулалт, хот байгуулалтын тогтолцоотой байна.

Бүсийн тулгуур төв хотын давуу тал нь: **а.** Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн, нийгмийн сайн сайхан амьдралыг цогцлуулсан, дэвшилтэт орчин бүрдсэн хот байх. **б.** Олон нийтийн оролцоо, хувийн хэвшлийг төрийн үйлчилгээнд татан оролцуулдаг, ажлын үр дүнг нийтэд тайлагнадаг үр ашигтай төрийн удирдлагатай хот байх. **в.** Олон улсын хэмжээний аялал жуулчлалын төв хот байх зэрэг давуу талтай байна.


Энэ утгаараа Шинэ хотын архитектур орон зайн зохиомжийн агуулга нь орчин үеийн хот төлөвлөлтийн технологээр (төлөвлөлтийн үндсэн зарчим 22, 23, 24а, 24б, 24в дүгээр зураг) шийдэгдсэн орон зайн баримжээ (29 дүгээр хүснэгт) загвар болж байгаа юм.

**Хотын нутаг дэвсгэрийн орон зайн бүсчлэл.** Монголчууд хотын төвийг орон зайн зохиомжийн хувьд өмнө зүг талруугаа нээлттэй байхаар харуулан төлөвлөж байсан нь хот сууринг Монгол орны өргөн уудам нутаг хот сууринг хүрээлэн байгаа байгаль цаг уурын онцлог, нүүдлийн соёл иргэншлийн ёс заншилтай нь уялдуулж ирсэн Монгол уламжлалыг тооцсон өвөрмөц шийдэл болдог байжээ.



Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал



23 дугаар зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал




24а дугаар зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал



246 дүгээр зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Засаг захиргааны төв





Хотын нутаг дэвсгэр нь нийгмийн үйлдвэрлэл үйлчилгээний иж бүрэн барилга байгууламжаар жигд барилгажсан цогцолбор суурьшлын зарчимтай зам харилцаа, ногоон байгууламж усан толь бүхий нутаг дэвсгэрийн 8 тэнхлэгт байрлаж хотын үндсэн төвөөс гадна тэнцүү хөгжлийг олсон арван төвтэйгөөр хот төлөвлөлтийн Монгол Уламжлалыг хадгалан Өмнө зүгрүү (төлөвлөлтийн үндсэн зарчим 25 дугаар зураг) нээлттэй орон зай үүсгэн тогтсон жижиг дунд хил хязгаарын хүрээнд байна.

### Хот байгуулалтын хуулийн дагуу тогтоож буй бүсчлэлийн тогтолцооны загварчлал

29 дүгээр хүснэгт


Хот байгуулалтын хуулинд заасан бүсчлэл	Бүсчлэлийн хэлбэр	
	Бүсчлэлийн ангилал	Тогтолцооны хэв шинж
Орон сууц, олон нийтийн бүс	Нягтрал багатай нам давхрын орон сууцны бүс	Нийтийн эзэмшлийн талбай бүхий нягтрал багатай орон сууцны хороолол
	Орон сууц, олон нийтийн байгууллага бүхий холимог суурьшлын бүс	Худалдаа үйлчилгээтэй орон сууцны хороолол
	Нягтрал ихтэй өндөр давхарын орон сууцны бүс	Дунд болон өндөр давхрын орон сууц бүхий орон сууцны хороолол.
	Хорооллын худалдаа үйлчилгээний бүс	Хорооллын чанартай худалдаа, үйлчилгээ бизнесийн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах бүс.
	Худалдаа, бизнесийн бүс	Өндөр зэрэглэлийн худалдаа, бизнесийн үйлчилгээний төв, дэд төвүүдийн бүс.
Үйлдвэрлэлийн бүс	Үйлдвэрлэл, орон сууцны холимог бүс	Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, бараа хуваарилах түгээх байгууламж, засварын газрууд бүхий суурьшлын бүс
	Үйлдвэрлэлийн бүс	Томхон үйлвэр аж ахуйн барилга байгууламжууд байршсан бүс.
Ногоон байгууламж, амралт аялал жуулчлалын бүс	Ой, нийтийн эзэмшлийн талбай, хамгаалалтын бүс	Нийтийн зориулалттай барилга байгууламж бүхий суурьшлын бүс.
	Ногоон байгууламж, амралт аялал жуулчлалын бүс	Иргэдийн амралт, аялал жуулчлалд зоиулсан ландшафт, цэцэрлэгт хүрээлэн бүхий бүс.
ХАА-н бүс	ХАА-н бүс	Иргэдийн хүнсний зориулалттай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бэлдэх бүс
Тусгай зориулалтын бүс	Тусгай зориулалтын бүс	Оршуулгын газар, батлан хамгаалах зориулалттай үйл ажиллагаа явуулах барилга байгууламж бүхий бүс





Хангайн бүсийн тулгуур төв хот

Харагдах байдал



25 дугаар зураг





Хотын дотор орон зайг бүрдүүлэгч үндсэн элементүүдийг нормативын түвшинд шийдсэн гудамж замын сүлжээ, давхар замууд, гүүрийн байгууламжаар холбоно. Эдгээр гудамж замын сүлжээний үндсэн хэсэг нь нийтдээ 1500 гаруй км урт байна. Хотын хилийн зэсийн гадна орчинд буюу хотын баруун, зүүн, хойд, урд хэсгээр хурдны авто зам сүлжээ бүхий, тээврийн хэрэгслийн дамжин нэвтрүүлэх болон хотын тээврийн хөдөлгөөнийг зохицуулах удирдлагын барилга, байгууламж хамтдаа байрлана. Хот иж бүрэн үйлчилгээ бүхий метротой байна метроны урт эхний ээлжинд 120 км байна. Хотын гол гудамж замын дагуу худалдаа үйлчилгээ бүхий хөгжлийн тэнхлэгүүдийг үүсгэн хөгжүүлнэ.

Хотыг гадаад, дотоодтой холбосон Олон Улс, Улсын чанартай төмөр зам болон авто замын хотын нэгдсэн сүлжээ нь Улсын нутаг дэвсгэрийн баруун, зүүн хязгаарыг холбосон мянганы зам болон бусад босоо тэнхлэгүүдтэй шууд холбогдно. Хотын замын сүлжээний холбогдох барилга байгууламж нь хотын захад (төлөвлөлтийн үндсэн зарчим 26 дугаар зураг) байршина. Хотын орон зайн бүтцэд нийтдээ том жижиг нийлсэн 30-35 авто вокзал, төмөр замын 20-27 вокзал байрлана.

Хотын агаарын гол хаалга болох олон улсын нисэх онгоцны буудлыг үйлчилгээний хотхоных нь хамт хотоос 80-90 км зайд байршуулна. Хотод нийтдээ Олон Улсын чанартай болон дотоодын үйлчилгээний гэсэн (төлөвлөлтийн үндсэн зарчим 27 дугаар зураг) онгоцны нийт 3 буудал байна. Нисэх буудлыг хоттой хурдны авто замаар холбоно. (Энд: нисэх буудлыг Чингис Хаан Олон Улсын нисэх онгоцны буудлаар төлөөлүүлэн үзүүлэв).

Хотын байршлын эдэлбэр газар 6000 орчим га бөгөөд газар нутгийн гадаргуугийн байдал, байгаль экологийн хүчин зүйлс хүн амын суурьшил, зам харгуй зэрэг хот төлөвлөлтөд нөлөөлөх бодит хүчин зүйлсийг тооцож тогтоосон хил хязгаар тэг гортигтой байна.

Хотын нутаг дэвсгэр, орон зайд байх үүргийн бүсүүд, хот бүрдүүлэгч үндсэн элементүүдийн архитектурын онцлого түүний хөгжлийн төлөв дараах байдлаар тодорхойлогдно.





**Хотын нутаг дэвсгэрийн орон зайн бүсчлэл.** Хотын орон зайн төлөвлөлтийн хувьд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Оршин суугчдын тухайн үеийн болон ирээдүйн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн, шинэ нөхцөлд хотын тогтвортой хөгжлийг дэмжих үндсэн чиг хандлагуудыг тогтоож өгнө.

Орхоны хөндийн байгалийн үзэсгэлэнт газар буюу байгалийн цогцолборт газруудын тэнцвэрт байдал, хүний үйл ажиллагаанаас үүдсэн хүрээлэн буй орчны экологийн аюулгүй байдлыг хангана.

Иргэдийн ирээдүйн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, нийгэм эдийн засгийн шинэ нөхцөлд хотын тогтвортой хөгжлийг дэмжих үндсэн хандлагуудыг тогтооно.

Байгалийн цогцолбор газруудын тэнцвэрт байдал, хүний үйл ажиллагаанаас үүдсэн хүрээлэн буй орчны экологийн аюулгүй байдлыг хадгална.

Хот төлөвлөлтийн уламжлалт аргуудыг ашиглан нутаг дэвсгэрийн уялдаа холбоо, орон зай, гоо сайхны иж бүрэн зохицол бүхий таатай орчин бүрдүүлнэ.

Тээвэр, инженерийн дэд бүтцийн аюулгүй байдлын шаардлагууд хангагдана.

Үйлдвэрийн бүсчлэлийн тогтолцоог боловсронгуй болгож, газар ашиглалтыг сайжруулна.

Олон нийтийн төвүүдийг байгуулж, нийгмийн дэд бүтцийн хангамжийн түвшин дээшлэнэ.

Худалдаа, амралт, аялал жуулчлал, төрөл бүрийн үйлчилгээг олон улсын чанартай төв болох бизнесийн төв дүүрэгт хөгжүүлнэ.

Иргэдийн зорчих хөдөлгөөнийг саадгүй болгохын тулд нийтийн тээврийн үндсэн тэнхлэгүүдэд хүч хөдөлмөр, цаг хугацаа хэмнэсэн үр ашигтай **нийтийн тээврийн тогтолцоог** бүрдүүлнэ.



Шинэ хотын орон зайг нутаг дэвсгэрийн хувьд найм хувааж олон төвт (төлөвлөлтийн үндсэн зарчим 28 дугаар зураг) хот төлөвлөлтийн зарчмаар хөгжүүлэхээр зохион байгуулна. Үүнд:

Хот бүрдүүлэх 10 төвийг тогтоохдоо барилгажилтын хил хязгаар, нутаг дэвсгэрийн хэмжээг тодорхой болгож хооронд нь орон зайн гэрэл гэгээтэй оновчтой бүтэц үүсгэн зохион байгуулна.

Хотын нутаг дэвсгэр орон зайн орчныг бүрдүүлэгч төвүүдийн талбайн хэмжээ хязгаарыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- Хотын төв	800 га
- 1 дүгээр дэд төв	600 га
- 2 дугаар дэд төв	600 га
- 3 дугаар дэд төв	600 га
- 4 дүгээр дэд төв	600 га
- 5 дугаар дэд төв	600 га
- 6 дугаар дэд төв	600 га
- 7 дугаар дэд төв	800 га
- 8 дүгээр дэд төв	600 га
- 9 дүгээр дэд төв	600 га
- 10 дугаар дэд төв	600 га
- Тусгай хамгаалалтын Ногоон бүс	4000 га
- Нийт	11000 га

Шинэ хотыг бүрдүүлэгч үндсэн элемент болох хотын төв бусад төвүүдийг хотын орон зайн зохион байгуулалтын хувьд бүсийн зарчмаар хөгжүүлэх бөгөөд энэ нь дараах бүтэцтэй байхаар төсөөлж байна.





**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ  
(ЗАГВАР БОЛГОЖ АВАВ.)**



27 дугаар зураг

**ОЛОН ТӨВТ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ**



28 дугаар зураг



**Төвийн бүс.** Төвийн бүс нь хотын орон сууц, олон нийтийн төвүүд нягт барилгажсан, амрах зугаалгын бүс, түүх соёлын дурсгалт газрууд, архитектурын дурсгал бүхий барилга байгууламж олонтой хэсэг байна. Төвийн бүсийн орон зайн төлөвлөлтийг 29а, 29б, 29в дүгээр зурагт үзүүлсэн онол арга зүйн зарчмыг баримтлан гүйцэтгэнэ. Төвийн бүс нь 600.0 га нутаг дэвсгэрийг хамрах ба 2040 онд 200,0 мянга орчим хүн ажиллаж амьдарч оршин сууна. Төвийн бүсэд зайлшгүй байх ёстой төрийн эрх барих дээд байгууллагууд, төрийн яамд, тусгай газрууд, хот дүүргийн засаг захиргаа гэх мэт орон нутгийн захиргааны байгууллагууд болон худалдаа, үйлчилгээ бизнесийн байгууллагууд байрлах тул, газрын үнэлгээний А зэрэглэлийн ангилалд хамрагдна. Хотын А зэрэглэлийн бүсийн хил хязгаар хотын төв цэгээс 20 км орчим радиуст байна.


Хотын төв гудамжны хоёр талаарх орчныг цогц цэцэрлэгжүүлэн, зам дагуух орон сууцны барилгуудын 1-2 давхруудад нийгэм эдийн засгийн чиглэл бүхий төрөл бүрийн худалдаа, үйлчилгээ байна.

Шинэ хотын төв талбай нь Монгол орны төв цэг байх ба талбайн газар доогуур явган гарц, бүхий худалдаа үйлчилгээний цогцолбор байгууламж барьж тохижуулна. Талбайн хоёр талын гудамжны дагуу оффис, худалдаа, үйлчилгээний өндөр барилгууд бүхий бизнесийн байгууламжууд байрлана. Талбайн газар доор автозогсоол, цэцэрлэгт хүрээлэн үйлчилгээний нэгдсэн төв байна.

Хотын дундуур урсах Орхон голын эргийн даланг тохижуулж цэцэрлэгжүүлэн, эргийн дагуух архитектурын өнгө үзэмжийг зохистой шийднэ. Далангийн дотор хэсэгт мод тарьж цэцэрлэгжүүлэн, усан толио, фонтан зэрэг усны барилга байгууламж барина. Голын эрэг орчныг далан барих, автозам тавих зэргээр тохижуулан эргийн дагуу барилгажуулан гудамжны өнгө үзэмжийг орчинтой нь зохицуулан шийднэ. Тохижилтын үндсэн шийдлийг 30 дугаар зурагт заасан арга зүй аргачлалын зарчмаар гүйцэтгэв үзүүлэв.




## ХОТЫН ТӨВИЙН ҮҮРГИЙН БҮСЧЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ШИЙДЭХЭД БАРИМТАЛСАН ҮНДСЭН ЗАРЧИМ



29а дугаар зураг

Хангайн бүсийн тулгуур төв хот

Засаг захиргааны төв




29б дүгээр зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Засаг захиргааны төв









Хангайн бүсийн тулгуур төв хот

Засаг захиргааны төв





## ХОТЫН ДУНДУУР УРСАХ ГОЛЫН ЭРГИЙН ТОХИЖОЛТЫН ҮНДСЭН ЗАРЧИМ



30 дугаар зураг

Хотын төвийн бүсийн орчинд зан үйлийн хотхон байдлаар тохижуулсан эдэлбэр газартай, нам давхрын үйлчилгээтэй орон сууц, түүх дурсгалт, байгууламж, соёл урлаг, шашны үйл ажиллагаа бүхий барилга байгууламжтай байхаар тооцож барилгажуулна түүний орчныг нь амралт зугаалгын байдлаар ашиглаж цэцэрлэгжүүлж тохижуулна.

Хотын өмнөт хэсэгт төвөөс 30 км зайд хотыг тодотгосон довцог толгой байгуулж толгойн оройд Бурхан багшийн цогцолбор байна. Толгойн эргэн тойрны хэсгийг холбосон явган гүүр, явган зам талбай, болон орчны барилга байгууламжтай нь уялдуулан архитектурын орон (төлөвлөлтийн үндсэн зарчим 31 дүгээр зураг) зайн тохитой цогц орчин болгон тохижуулж барилгажуулна.





Хангайн бүсийн тулгуур төв хот

Авто замын сүлжээ (загвар болгож авав)



31 дүгээр зураг



Хотын төвийн хэсгийг нийт 600,0 га нутаг дэвсгэртэй, 60,0 мянган орчим өрхийн 200,0 мянган оршин суугчидтай байхаар төлөвлөснийг дээр дурьдсан. Төвийн бүсийн хүрээнд орон сууц, олон нийт, холимог суурьшил бүхий 6 хороололтой суурьшлын нэгжүүд хамрагдана.

Бүсийн нутаг дэвсгэрийн хүрээлэлд хотын шинээр төлөвлөж буй 2-3 төвүүд байрлаж төвлөрлийг сарниулахад чухал ач холбогдолтой, орон сууц, олон нийт, байгаль орчинд халгүй, хүнс, хөнгөн, болон төрөл бүрийн жижиг дунд үйлдвэр бүхий холимог хорооллуудаас бүрдсэн бүс байна.

Төвийн бүсийг тохилог нийтийн орон сууц, нам давхрын орон сууцны гэсэн сууцны фонд бүхий олон нийт, нийгмийн дэд бүтцийн хангамжтай, хөнгөн хүнсний болон төрөл бүрийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээ хөгжсөн, хотын нэг хэсэг болгоно. Нутаг дэвсгэрийн байрлал, онцлогоосоо шалтгаалж суурьшлын бүсийг төвлөрсөн ба бие даасан эх үүсвэр бүхий хэсэгчилсэн шугам сүлжээний хангамжтай байна.

Бүсийн нутаг дэвсгэрийн газар ашиглалт, архитектур орон зайн бүтэц нь орчин үеийн инженерийн дэд бүтэцтэй орон сууц, олон нийтийн барилга бүхий суурьшил байна. Төвийн гол гудамж нь дагуудаа төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон барилга байгууламж бүхий тэнхлэгийн үүрэг гүйцэтгэнэ. Тус бүсэд нэлээд хэмжээний талбайг хэтийн ирээдүйд барилгажуулах нөөц талбай болгон үлдээнэ.

Гол гудамж замын дагуу, хотын архитектурын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор цогц үйлчилгээ бүхий дунд болон олон давхар орон сууц бизнес үйлчилгээ болон олон нийтийн барилгаар барилгажуулна. Орон сууц нь өндөр болон дунд давхрын тохилог нийтийн орон сууцны, нам давхрын амины орон сууцны хороолол, бичил хороолол байдлаар нийгмийн дэд бүтэц, худалдаа үйлчилгээний хангамж, нийтийн эзэмшлийн газар, талбай, хорооллын доторх ногоон байгууламжтай цогц байдлаар байна. Хотыг бүрдүүлэх төвүүдийн архитектур, орон зайн зохион байгуулалт нь дараах зарчмаар төлөвлөгдөнө. Хотын төв хотын бусад төвүүд бичил хорооллын, мөн тусгай төвүүдтэй, хотын





доторхи гудамж замын сүлжээгээр холбогдоно. Хотын төвд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байрлана. Үүнд:

-Төрийн төв захиргааны байгууллагууд /Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол Улсын Засгийн Газар, Улсын Их Хурлын ордон, төрийн яам, агентлагууд/

-Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухааны байгууллагууд, Олон нийтийн байгууллагууд, Бизнесийн болон бусад байгууллагууд, Худалдаа үйлчилгээний томоохон байгууллагууд, Зарим томоохон эмнэлгийн цогцолбор, Орон сууц бүхий худалдаа үйлчилгээ, Худалдаа үйлчилгээний бие даасан томоохон байгууллагууд, боловсролын байгууллагууд гэх мэт.

**Хотын нэгдүгээр төв.** Тус төв 600,0 га эдэлбэр газартай 15 мянган өрхийн 50 гаруй мянган оршин суугчтай байна. Төвийг нам давхрын сууцны хороолол бүхий суурьшилын бүс (төлөвлөлтийн үндсэн зарчим 32 дугаар зураг) байхаар төлөвлөж байна. Гол зам дагуух архитектурын шийдэл, өнгө үзэмжийг сонирхолтой болгох зорилгоор гудамж зам дагуу байрлах сууцны хорооллыг бие даасан, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээнд холбож өндөр болон нам давхрын хороолол хосолсон холимог суурьшлын бүс байхаар хөгжүүлнэ. Зам дагуу байрлах нам давхрын блокчилсон сууцнуудын доод давхрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглах боломжтой байна.


Сууцны хорооллын зарим хэсгийг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд: Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн тохилог орон сууц байх, Оршин суугчдын тоо, байршлаас шалтгаалж олон нийтийн төвд, хүүхдийн сургууль, цэцэрлэг, халуун ус, угаалгын газар, худалдаа үйлчилгээний цогцолбор барьж байгуулна.



Хангайн бүсийн тулгуур төв хот

Спорт цогцолбор




**ХОТЫН 1 ДҮГЭЭР ТӨВИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ**

32 дугаар зураг

Энэ төвд соёл, урлаг, спорт, боловсрол шинжлэх ухааны дараах байгууллагууд байрлана. Үүнд: Олон нийтийн байгууллагууд, Худалдаа үйлчилгээний байгууллагууд, Нам давхар сууц бүхий суурьшилтай худалдаа үйлчилгээ, боловсролын байгууллагууд, Эмнэлэг үйлчилгээний төрөлжсөн цогцолборууд, өндөр, дунд давхрын орон сууц бүхий худалдаа үйлчилгээний байгууллагууд, Орон нутгийн дүүрэг хороодын төр захиргааны байгууллагууд, Бизнес худалдааны төв болон үйлчилгээний байгууллагууд байрлана.

**Хотын хоёрдугаар төв** Энэ төвийн нутаг дэвсгэрт, хот болон дүүргийн чанартай олон нийт, үйлчилгээ, соёл боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, орон сууцны барилгуудтай байна. Тус төв 600,0 га нутаг дэвсгэртэй 19 мянган өрхийн 70 орчим мянган оршин суугчтай байна. Төвийн гол гудамжны дагуу, худалдаа үйлчилгээ бүхий барилга байгууламжтай тэнхлэг үүснэ. Төвийн хэсэгт ирээдүйд барилгажуулах сул чөлөөтэй эдэлбэр газар үлдээнэ. Төвийн суурьшлын нягтрал 45 хүн/га байх ба (төлөвлөлтийн үндсэн зарчим 33 дугаар зураг) гол төлөв дунд, өндөр давхруудын орчин үеийн нийтийн орон сууцны хороолол, олон давхар хотын архитектурын өнгө үзэмжид нөлөө үзүүлэх олон нийтийн барилга









байгууламж, оршин суугчидын 75 хувийг хангасан газар доор автомашины зогсоол, тээврийн зангилааг тус тус барьж байгуулна. Төвийг орчных нь төмөр замын байгууламжаас ногоон зурвасаар тусгаарлана. Төв хотын төвлөрсөн инженерийн хангамжтай байна.

### ХОТЫН 2 ДУГААР ТӨВИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ



33 дугаар зураг

**Хотын гуравдугаар төв.** Энэ төвд хотын төр захиргааны болон харьяа зарим байгууллагууд нь байрлана. Энэ төв нь сүүлийн үеийн архитектур орон зайн төлөвлөлтөөр баригдана. Шинэ хотод дунд, өндөр давхрын нийтийн орон сууцны бичил хорооллууд нийгмийн дэд бүтцийн хамт баригдана.

Төвийн хойд хэсэгт хотын засаг захиргаа, бизнес, худалдаа, үйлчилгээ, театр, спортын ордон стадион бүхий амралт зугаалгын задгай талбайн хамт байрлана. Мөн хотын чанартай соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулагдана. Тус хүрээлэн нь гадаад, дотоодын жуулчид, хотын оршин суугчдын амралт чөлөө





Хангайн бүсийн тулгуур төв хот


Авто замын сүлжээ





цагийг сонирхолтой ая тухтай өнгөрөөх бүхий л нөхцөл бололцоог хангасан ландшафтын архитектурын төлөвлөлт, тохижилттой байна. Энэ төвийн эргэн тойроныг хамгаалалтын ногоон (төлөвлөлтийн үндсэн зарчим 34 дүгээр зураг) байгууламжаар тусгаарлагдана.

### ХОТЫН 3 ДУГААР ТӨВИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ



34 дүгээр зураг

Суурьшлын доторх гудамж зам дагуух, цэцэрлэгт талбай бүхий ногоон байгууламжтай байх ба хотын бусад хэсэгтэй метро авто зам нийтийн тээврээр холбогдсон байна. Шинэ хотын худалдаа үйлчилгээ, соёл амралтын хүрээлэнгийн орчинд газар доорх болон ил авто зогсоолууд байна. Энэ төв төвлөрсөн инженерийн хангамжтай байна.

Төвийн гол хэсгийг нам, дунд, өндөр давхрын орон сууцны хороолол маягаар хөгжүүлнэ. Мөн холбогдох нийгмийн дэд бүтцийн болон худалдаа үйлчилгээний барилга байгууламжтай байна. Зам дагуу худалдаа үйлчилгээ, өндөр, дунд давхрын нийтийн орон сууцууд байрлана. Орон сууцны хороолол доторх орц замууд байх ба нийтийн амралтын цэцэрлэгт хүрээлэн спортын барилга байгууламжууд байна. Тус хороолол нь төвлөрсөн инженерийн хангамжид





холбогдоно. Хотын бусад хэсгүүдтэй метро, сайн чанарын авто зам, нийтийн тээврээр холбогдоно. Тус төвд 15,0 мянган өрхийн 60,0 мянган хүн оршин сууна.

Энэ төвд Шинэ хотын төр захиргааны харъяа байгууллагууд болох соёл, урлаг, спорт, аялал жуулчлал худалдаа үйлчилгээний байгууллагууд, Бизнес үйлчилгээ худалдааны байгууллагууд, Банк санхүү даатгал, олон Улсын худалдаа үйлчилгээний байгууллагууд, Эмнэлэг үйлчилгээний цогцолбор зэрэг байгууламжууд байрлана.

**Хотын дөрөвдүгээр төв.** Хотын энэ төв нь нийт 600,0 га нутаг дэвсгэртэй, 25,0 мянган өрхийн 100,0 мянган хүн амтай, нам давхрын орон сууцны хороолол болно. Тус бүс нь гурван нэгж хороолоос бүрдэнэ. Энэ бүсийн нутагт хотын бусад төв, болон олон нийтийн (төлөвлөлтийн үндсэн зарчим 35 дугаар зураг) төв байрлана. Энэ төвийг бие даасан эх үүсвэртэй, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээнд холбоно.

Хотын засаг захиргаа, сургууль цэцэрлэг, худалдаа үйлчилгээ, соёл, боловсрол, спортын барилга байгууламжууд байх ба бүсийн оршин суугчдыг ажлын байраар хангах үүднээс гадны хөрөнгө оруулалттай бизнесийн байгууллагууд болон жижиг дунд үйлдвэрлэл түлхүү хөгжинө.

Бүсийн оршин суугчдын амралт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх боломжтой дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай, спортын цогцолбор байна. Хотын бусад хэсгүүдтэй метро, хатуу хучилттай авто зам, нийтийн тээврээр холбогдоно.

Энэ төвд олон нийтийн байгууллагууд, дунд зэрэглэлийн бизнес, худалдаа үйлчилгээний цогцолбор, Орон сууц худалдаа үйлчилгээ, нийгэм хангамжийн байгууллагууд, соёл, урлаг, спортын байгууллагууд, Эмнэлэг үйлчилгээний цогцолбор, Банк санхүү бизнесийн байгууллагууд байрлана.





Хангайн бүсийн тулгуур төв хот  
Хотын захиргаа








Хангайн бүсийн тулгуур төв хот  
Бөхийн өргөө



**ХОТЫН 4 ДҮГЭЭР ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ***35 дугаар зураг*

**Хотын тавдугаар төв.** Хотын 5 дугаар төв нь иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах хамгийн таатай нөхцлийг бүрдүүлсэн, боловсрол, мэдээлэл, технологийн өндөр түвшинд хүрсэн олон давхар барилгуудтай олон улсын бизнесийн болон засаг захиргааны төв бүхий хотын байгуулагууд байрлан. Мөн олон нийт, орон сууцны хорооллуудаас бүрдсэн дээд зэрэглэлийн суурьшлын бүс байна. Тус бүсэд 2-3 нэгж хорооллууд байх ба нийт 600,0 га нутаг дэвсгэрийг хамарч, 18,0 мянган өрхийн 95,0 мянган хүн ам оршин сууна.

Энэ төв нь хотын (төлөвлөлтийн үндсэн зарчим 36 дугаар зураг) бусад орчинтой метро авто замууд болон хурдны зам, босоо тэнхлэгийн дөрвөн авто замаар холбогдоно. Энэ төвд орон сууц, олон нийтийн барилгаар барилгажиж нягтрал сайтай 50 хүн/га бүхий суурьшил бий болно. Энэ суурьшилд цаашдаа хотын шинэ төв, бизнесийн шинэ дүүрэг болж хөгжинө. Хотын энэ төвд гол төлөв худалдаа үйлчилгээ, соёл урлаг, спортын зэрэг олон нийтийн барилга байгууламж байна. Хотын энэ төвийн Барилгажилтын дундаж давхар 9-25 байна.





Хангайн бүсийн тулгуур төв хот

Амины орон сууцны хороолол








Энэ төвийн оршин суугчид ажиллагсадын бүхийл хэрэгцээг тус төвд байрлах соёл, боловсрол худалдаа ахуй үйлчилгээний цогцолборууд. Спорт, худалдаа, үйлчилгээ, эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээний цогцолборууд, Банк санхүү даатгал, зочид буудал бизнес үйлчилгээний төвүүд нь өөрсдийн үйлчилгээгээр бүрэн хангахаар тооцогдсон болно.

### ХОТЫН 5 ДУГААР ТӨВИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ



36 дугаар зураг

**Хотын зургаадугаар төв.** Энэ төв 600.0 га нутаг дэвсгэртэй байна. Энэ төвд 20 мянган өрхийн 80 орчим мянган хүн амьдарна. Энд Олон Улсын бизнес худалдааны зонхилох төв байгууллагууд байрлана. Тус төвд гол төлөв гадаад, дотоодын худалдаа, үйлчилгээ, (төлөвлөлтийн үндсэн зарчим 37 дугаар зураг) банк, санхүү, даатгалын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг компанийн офис, үзэсгэлэнгийн танхим, конференц заал, өндөр зэрэглэлийн зочид буудал, түрээсийн орон сууц зэрэг орчин үеийн архитектур, технологийн шаардлага хангасан олон давхар барилга байгууламжууд байна. Эдгээр барилгуудын газар доорх орон зайг худалдаа үйлчилгээ, метро нийтийн тээврийн терминал, авто зогсоолд бүрэн ашиглана.



Энэ төвд Олон Улсын элчин сайдын яамдын хороолол, Худалдаа үйлчилгээ, соёл, спорт, аялал жуулчлалын байгууллагууд, томхон зочид буудлууд Дунд дээд давхрын орон сууц бүхий худалдаа үйлчилгээ, спорт, соёл, боловсролын байгууллагууд, Банк санхүү бизнесийн байгууллагууд байрлана. Энэ төвийн оршин суугчид нийгмийн үйлчилгээгээр төвдөө бүрэн хангагдна.

### ХОТЫН 6 ДУГААР ТӨВИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ



37а дугаар зураг

**Хотын долдугаар төв.** Хотын 7 дугаар төвийн нутаг дэвсгэрт хотын үйлдвэрлэл, инженерийн хангамжийн эх (төлөвлөлтий үндсэн зарчим 38 дугаар зураг) үүсвэрүүд байрлаж, голлох үйлдвэрийн бүс байх ба нийт 600,0 га нутаг дэвсгэр бүхий 60 мянган өрхийн 240 мянган хүн амтай байна.


Бүс дотроо 4-5 нэгж хорооллуудад хуваагдана. Хотын инженерийн хангамжийн гол эх үүсвэрүүд болон дулаан цахилгааны станцууд, төв цэвэрлэх байгууламж, төрөл бүрийн голлох томоохон үйлдвэр аж ахуйн газрууд тус бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулна. Хөгжлийн чиг хандлагаар энэ бүсийг аж үйлдвэр, суурьшлын бүс байдлаар архитектур орон зайн төлөвлөлтийг шийднэ.





Хангайн бүсийн тулгуур төв хот

Олон улсын бизнес худалдааны төв





## ХОТЫН 6 ДУГААР ТӨВИЙН ОГТЛОЛ




376 дүгээр зураг

Үйлдвэрлэлийг үндсэн, туслах , жижиг дунд үйлдвэрлэл гэж гурав ангилан, үйлдвэрлэлийн чиглэлээр төрөлжүүлж хөгжүүлэхээр тооцож байршуулна. Үйлдвэрийн бүс нь дараах байдлаар байршина. Үүнд:

- Үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийг төрөлжсөн үйлдвэрийн зангилаа /парк/ байдлаар байрлах.
- Байгаль орчинг бохирдуулахгүй, дуу чимээ багатай, малын түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрүүдийг хотын доторх экологийн тэнцвэрт байдлыг хангах түвшинд байхаар тооцож байрлуулна.
- Үйлдвэрийн бүсийн эдэлбэр газруудыг үйлдвэрийн парк, суурьшил болгон хөгжүүлж ашиглалт, нягтрал нь өндөр байхаар тооцно.
- Хөрс, агаар бохирдуулахгүй, хөрсний эвдрэл үүсгэхгүй газар нь тэгшхэн эрүүл байгаль экологид хор нөлөө багатай үйлдвэрлэл, ногоон байгууламж бүхий суурьшил болгон байршуулна.







Энэ төвд үйлдвэрт ажиллагсадын орон сууцны хороолол бүхий соёл, боловсрол, худалдаа үйлчилгээний цогцолборууд байрлана. Үүнд: Олон нийтийн байгууллагууд, Бизнес, худалдаа үйлчилгээний цогцолбор, Олон Улсын байгууллагууд, Орон сууц худалдаа үйлчилгээ нийтийн дэд бүтэц, соёл, урлаг, спортын байгууллагууд, Эмнэлэг үйлчилгээний цогцолбор, Банк санхүү бизнесийн байгууллагууд байна.

### ХОТЫН 7 ДУГААР ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



38 дугаар зураг

**Хотын наймдугаар төв.** Төв нь 600.0 га нутаг дэвсгэртэй 60 мянган ерхийн 240 мянган хүн амтай байна. Хотын 8 дугаар төвийн бүсийн нутаг дэвсгэрт орших гэр хороолол нь гол төлөв бүсийн нутаг дэвсгэрийн захын хэсгээр, газрын гадаргуугийн налуугийн тохиромжгүй талбайд байрлана. Хэсэгчилсэн ерөнхий





Хангайн бүсийн тулгуур төв хот


Өндөр орон сууцны хороолол





төлөвлөгөө боловсруулж төвийн архитектур орон зайн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлнэ Тус төвд дүүрэг хороод нутгийн засаг захиргаа, орон сууц, худалдаа үйлчилгээ, эрүүл мэнд, соёл боловсрол спортын байгууллагууд (төлөвлөлтийн үндсэн зарчим 39 дүгээр зураг) төвлөрөн үйл ажиллагаа явуулна. Мөн хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн байх ба хотын доторх болон хот хоорондын нийтийн тээврийн сүлжээтэй холбогдоно. Төвийн барилга байгууламжууд хотын төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд хэсэгчилсэн байдлаар холбогдоно.

### ХОТЫН 8 ДУГААР ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ




39 дүгээр зураг

Энэ төвд спорт, худалдаа, үйлчилгээ, эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээний цогцолборууд, Төр захиргаа үйлчилгээний цогцолборууд, Банк санхүү даатгал, зочид буудал бизнес үйлчилгээний төв, Гэр хороолол, худалдаа, ахуй үйлчилгээний төв байрлана.






Хотын 8 дугаар төвийн харагдах байдал





**Хотын есдүгээр төв.** Хотын 9 дүгээр төв нь гэр, нам давхрын сууцны хорооллуудаас бүрднэ. Энэ төв тохилог амины орон сууцны хорооллын бүс байна. Тус бүсэд хотын амьны сууцны нэгж хорооллууд багтана. Бүс нь гэр хорооллын нутаг дэвсгэрийг хамрах ба нийт 600,0 га нутаг дэвсгэртэй, 63,0 мянган өрхийн 270,0 мянган орчим хүн (төлөвлөлтий үндсэн зарчим 40 дүгээр зураг) байнга оршин суурьшина. Мөн энэ төв буюу хотын бусад төв, гэр хорооллын олон нийтийн төвүүдэд үйлчилэх хотын чанартай амралт зугаалгын бүс, ногоон байгууламжийг хотын дундуур урсах голын дагуу байрлахаар төлөвлөлтөд тусгана.

### ХОТЫН 9 ДҮГЭЭР ТӨВИЙН НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



40 дүгээр зураг





Хангайн бүсийн тулгуур төв хот

Олон улсын бизнес худалдааны төв





Тус төв өөрийн хүрээлэлд үйлчилэх сургууль, цэцэрлэг, клуб, худалдааны төв, спортын танхим, төр захиргааны байгууллагууд, жижиг дунд үйлдвэр зэрэг олон нийтийн барилга байгууламж, амралт зугаалгын зориулалт бүхий бичил цэцэрлэг, спортын задгай талбайтай байна. Энэ төв нь өөрийн хэрэгцээний уурын зуух, цэвэрлэх байгууламж, усан сан гэх мэт бие даасан инженерийн дэд бүтцийн хангамжтай байна.

**Хотын аравдугаар төв.** Энэ төв нь суурьшлын салшгүй нэг хэсэг бөгөөд хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийн хангамж бүхий нам давхар амьны орон сууцны хороололтой байна. Хорооллын барилжилт нь 1-3 давхар бие даасан эдэлбэр газартай, блокчилсон эдэлбэр газартай, эдэлбэр газаргүй зэрэг орон сууцанд нь нийгмийн дэд бүтэц, худалдаа үйлчилгээний цэг салбар байрласан байна. Хороолол нь нийтийн ногоон байгууламж, амралт зугаалгын бүс, тоглоомын талбай, авто машины зогсоолтой, хатуу хучилттай орц замуудтай байна. Төв нь 600.0 га нутаг дэвсгэртэй байна. Энэ төвд гэр сууцны хороолол буюу хотын захын гэр хороолол мөн хамрагдна. Энэ хороололыг хэсэгчилсэн инженерийн шугамд холбох, гудамжийг тохижуулж гэрэлтүүлэг, (төлөвлөлтийн үндсэн зарчим 41 дүгээр зураг) хатуу хучилттай зам тавих зэрэг иргэдийн амьдралын тохитой нөхцлийг нь хангана. Оршин суугчидын амьдралын орчныг тав тухтай аятай болгох үүднээс төрөл бүрийн нийгмийн үйлчилгээ бүхий бие даасан инженерийн дэд бүтцийн хангамжтай олон нийтийн төвүүдийг хүчин чадалд нь тохируулан байрлуулна. Олон нийтийн төвүүд нь хотын төв, бусад төвүүдтэй өөр хоорондоо нийтийн тээврийн сүлжээгээр холбогдоно. Гэр хорооллын өрхийн тоо багтаамжаас шалтгаалж төвийн хүчин чадал харилцан адилгүй байна.

Төлөвлөлтийн эдгээр 10 төв нь хотын нутаг дэвсгэрийн хэвтээ босоо найман тэнхлэгт жигд хуваагдан нутагших бөгөөд төвүүдийн барилга байгууламж, суурьшлын бүсүүд нь эдгээр тэнхлэгүүдээ даган байрлана.


Суурьшлын үйлдвэрлэл нийгмийн үйлчилгээний эдгээр төвүүд өөр хоорондоо метро гудамж замын, сүлжээгээр холбогдож. Бүхэлдээ оршин суугчдын амьдралын ая тухтай орчин бүрдсэн хотын нутаг дэвсгэр, орон зайн нэгдсэн цогц систем үүсгэнэ.





**III.1.4. Хотын суурьшлын бүсийн төлөвлөлт.** Шинэ хотын суурьшлын бүсийн бүтцийг тогтоохдоо нэг маягийн барилгажилт, нийтийн орон сууцны төлөвлөлтөөс аль болох татгалзах, өөрийн гэсэн өнгө төрхтэй, бие даасан бичил орчин үүсгэх олон хэвшлийн хувийн орон сууцны хороолол хэлбэрээр барилгажуулах зарчим баримтлах, хороолол болгонд амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх парк, цэцэрлэг бүхий эрүүлжүүлэх, бялдаржуулах төвүүдийг байршуулах, хорооллын болон (төлөвлөлтий үндсэн зарчим 42 дугаар зураг) дүүргийн чанартай худалдаа, үйлчилгээний газруудыг суурьшлын бүсэд ойр, орон сууцны хорооллоос тусд нь иж бүрэн үйлчилгээний төв маягаар төлөвлөх зэрэг хот байгуулалтын үндсэн чиг үүрэгт нийцүүлэх чиглэл баримтлав.

**ХОТЫН 10 ДУГААР ТӨВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ**




41 дүгээр зураг



Энэ бүс нь агуулга бүтцийн хувьд хэд хэдэн үндсэн зарчимтай байна. Үүнд: **Нэгд.** Үйлчилгээний зохистой хүрээ бүхий орон сууцны хороолол, түүнийг бүрдүүлэгч элементүүд нь архитектурын хувьд өвөрмөц, төгс зохиомжтой дээд зэрэглэлийн түвшинд шийдэгдсэн, **Хоёрт.** Инженерийн бүрэн болон хэсэгчилсэн хангамжтай жижиг сууцны хороолол хэлбэртэй тэр нь жижиг сууц, жижиг, дунд үйлдвэрлэл-үйлчилгээ хосолсон сууцны бүлэглэлээс тогтсон байна.

### ХОТЫН ОРОН ЗАЙН БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАГВАРЧЛАЛ



42 дугаар зураг

Сууцны эдгээр хороолол бүр хүн амын өдөр тутмын хэрэгцээний соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборууд, ариун цэвэр-эрүүл ахуйн хувьд байгаль орчинд халгүй жижиг, дунд үйлдвэр зэрэг нь хот төлөвлөлтийн үндэслэлтэй тооцоонд шийдэгдсэн олон нийтийн үйлчилгээний газар, нийтийн



хэрэгцээний цэцэрлэгт хүрээлэн, нормд зохицсон зам талбай, спортын байгууламж, инженерийн дэд бүтцийн байгууламж бүхий цогц шийдэлтэй байна.

Хотын суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн орон зай нь хотын архитектур-орон зайн төлөвшсөн залгамж чанарыг хадгалсан инженерийн дэд бүтэц нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээгээ нь хамт иж бүрэнээр шийдэгдсэн, орчныхоо байгалийн тогтолцоотой нягт уялдсан, нийтийн үйлчилгээний газар, зах зээлийн элементүүд нь байршлаа олсон, суурьшлын орчинд нь цэцэрлэгжилтийн нэгдсэн систем үүссэн, иргэд чөлөөт цагаа ашигтай өнгөрүүлэх бүрэн боломжтой эрүүл аюулгүй орчинд амьдрах нутаг дэвсгэр, архитектур-орон зайн хамгийн тохитой орчин байна.

Суурьшлын бүсийн орон зайд шаардагдах дэвсгэр газрын хэрэгцээг 1000 хүн тутамд ногдох талбайгаар нь тооцож тодрхойлох зарчмыг баримтлав. Гэхдээ энэ бүсэд байрлах орон сууцны барилгын дундаж дэвхар нь 3 хүртэл бол эдэлбэр газар нь 10 га, эдэлбэр газартай бол 15 га, барилгын давхар нь 4-8 давхар барилгад 8 га, 9 ба түүнээс дээш давхартай бол 7 га байхаар тооцлоо.

Суурьшлын бүсийн нутаг дэвсгэр нь 250 га-гаас ихгүй талбайтай бол хоорондоо 100 м-ээс багагүй өргөнтэй, төв зам буюу ногоон зурвасаар тусгаарлагдсан хэд хэдэн хорооллуудаас бүрдэнэ.

Суурьшлын бүсийг баруун хойноосоо чиглэлтэй зонхилох салхины эхэнд, үйлдвэр аж ахуйн бүс, амралт зугаалгын бүс болон зам тээврийн сүлжээтэй нь уялдуулан байрлуулж харин үйлдвэр, аж ахуйн бүсийг нь салхиных нь дор байрлуулдаг төлөвлөлтийн зарчим баримтлав.

Суурьшлын бүсийн нэг өрхийн эдэлбэр газрын хэмжээ нь 0,7 га-даа тохирсон байна. Суурьшлын бүсэд барих сууцны барилгынх нь хэв шинж, шинээр барих сууцны нийт хэрэгцээ, өрхийн гишүүдийн тооны дундаж үзүүлэлтийг үндэслэн төлөвлөлтийн заримыг нь тогтоов. Харин суурьшлын бүсэд байх нам давхар сууцны хорооллыг дараах зарчмаар байрлуулахаар тооцов. Үүнд:



Хотын бие даасан төвийн нутаг дэвсгэр нь 250 га хүртэлх эдэлбэр газартай нөхцөлд суурьшлын бүс нь үйлчилгээний зохистой хүрээ бүхий орон сууцны хорооллоос бүрдсэн худалдаа, үйлчилгээ амралт зугаалгын бүс, цэцэрлэгт хүрээлэн, соёл, спорт, олон нийтийн байгууламж бүхий архитектур-орон зайн нэгдсэн чуулбар хэлбэрээр барилгажина.

Суурьшлын бүсийн орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбайг тэнд байрлах ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилгын эдэлбэр газрыг тооцохгүйгээр 10 м<sup>2</sup>-аас багагүй байх зарчим баримтлана.

Суурьшлын бүс дэх нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн зогсоолын хоорондох зай 400 м-ээс багагүй, харин буухиалан явах нийтийн тээврийн хэрэгслийн тухайд энэ зай 1000 м-ээс багагүй байна.

Суурьшлын нутаг дэвсгэрт байх орон сууцны барилгын хэрэгцээг тухайн орон нутгийн хүн амын тоо, өрхийн дундаж үзүүлэлтийг харгалзан тогтооно.

Байгалийн хүрээлэнгийн энэхүү нутаг дэвсгэрийн архитектурын орон зайн зохион байгуулалтыг шинжлэх ухаан, соёл судлалын, дархан цаазат-амралтын, жирийн амралтын болон дархан цаазат хэсгийн аж ахуйн бүс гэж дотор нь ангилан үзэв.

Шинэ хотын 6, 7, 9 дүгээр төвийн суурьшлын бүсийн нутаг дэвсгэрт байх олон нийт, иргэний зориулалттай барилга байгууламжууд тухайлбал, засаг захиргаа соёл, урлаг, худалдаа үйлчилгээ, Олон улсын бизнес үйлчилгээ, нийтийн аж ахуйн, спортын байгууламж гэсэн зориулалтаар ангилж үйлчилгээний хүртээмжийг нь тооцсоны үндсэнд бие даасан олон нийтийн үйлчилгээний тусдаа бүстэй байхаар тооцож төлөвлөнө.

Хотын олон нийт үйлчилгээний нэгдсэн төвийг нь хотын төвийн хэсэгт зам тээврийн үндсэн сүлжээ ногоон байгууламжийн бүс, суурьшлын бүс, үйлдвэрийн бүс, гэр хороололуудтай уялдуулан хоорондоо аль болох зохистой үйлчилгээний хүрээнд байршихаар тооцлоо. Гэхдээ энэхүү  $\text{íéèðéúā} \text{ } \text{¿éè÷èèāúíèé} \text{ } \text{öíäöíèáíðýg}$





áĵđäĵĵëэх үндсэн үеáíáíòĵĵä íü °ð õġđííáġĩ āóääìæ çàìààð õíëáíāāñíí íóðää äýâñāýðèéí çġõèíí áàéāóóéàèòòàé, ðàðèèöòàí òàòàèöñàí íðíí çàég үүсгэнэ.

**Хотын суурьшлын тогтолцооны онцлог.** Хангайн бүсийн нутаг дэвсгэрт 2040 оны үед нийт нэг сая хүн оршин суух хот бий болж хөгжинө. Эдгээр хүн ам нь Шинэ хот болон түүний дагуул хот тосгодод тархан байрлана. Дагуул хот тосгод, нь тодорхой үүрэг чиглэлтэй үйлдвэр, худалдаа үйлчилгээ, дагнан тэнцвэртэй хөгжсөн, оршин суугчдын амьдралын ая тухтай орчин бүрдсэн хот суурингууд байна. Эдгээр суурингууд нь аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл бүхий бие биенээ харилцан тэтгэсэн, суурьшлын тогтолцоог үүсгэн, хөгжинө. Энэ нь улс орны эдийн засагт чухал байр эзэлж, өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэгцээг хангаж, өнөөдрийх шиг хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн үгүй болж хот болон хот орчмын байгаль экологийн тэнцвэртэй байдалыг жигд хангана.

**Суурьшлын бүс буюу суурьшлын орчин.** “Суурьшлын орчин” гэдэг нь тодорхой орон сууцны хороололын орчинд цэцэрлэг, сургууль ба парк зэрэг олон нийтийн байгууламжуудыг байршуулсан хот бүрдүүлэгч үндсэн нэгж юм. Шинэ хотын тухайд нэг сургуулийн үйлчилгээний хамрах хүрээг нэг үндсэн нэгж гэж үзсэн ба энэ нь 6000-8000 хүн амыг хамарна. Шинэ хотын тухайд “Суурьшлын орчин”-ны төлөвлөлтийг захын хорооллын амьдралын нөхцлийг сайжруулахад чиглэсэн хот бүрдүүлэлтийн төлөвлөлтөнд ашиглахаар тооцсон ба үүний үр дүнд оршин суугчид нийтийн эзэмшлийн байгууламжууд болон нийтийн амрах тав тухтай орчинг ашиглах мөн сургууль төвтэй суурьшлын бүсийн хөгжлийг дэмжих алхам болно. Хотын бүрэн дунд цогцолбор сургуулийн хүчин чадлын тооцоо нь ойролцоогоор 100 га /1 км х 1 км/-болж байгаа бөгөөд тэнд амьдрах 18000-20000 хүн ам буюу суурьшлын нэг орчны 1 га-д 180-200 хүн байрших нягтралтай суурьшлын дундаж орчин болж байна. Энэхүү орчны төв бйагууламж нь ерөнхий боловсролын сургууль байх ба түүний үйлчилгээ хамрах хүрээ нь 500 м буюу сурагчид сургуульдаа явганаар хүрэх бололцоотой байна.

Суурьшлын бүс нь тохилог нийтийн орон сууц давамгайлсан орон сууц, олон нийтийн барилга бүхий хорооллуудаас бүрдэнэ. Суурьшлын онцлогийг харгалзан гол гудамж зам дагуу, дороо худалдаа үйлчилгээ бүхий орон сууц, олон



нийтийн барилгаар барилгажуулна. Төлөвлөгдөж буй хорооллууд нь төрөл бүрийн худалдаа үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл бүхий төвүүдтэй байна. Мөн амралт, зугаалгын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хамт төлөвлөгдөнө. Суурьшлын бүсийг үүсгэж байгаа эдгээр орон сууцны хорооллуудыг гол төлөв өндөр болон дунд давхрын, зарим газарт төлөвлөлтийн онцлогоос шалтгаалж нам давхрын орон сууцаар барилгажуулна.

**Хотын орон сууцны төлөвлөлт.** Хотын сууцны фондод тохилог орон сууцны эзлэх хувь өндөр байна.

Хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх энэ төсөлд тохилог орон сууцны хангамж 65% ,2050 онд 90,0% байх бөгөөд орон сууц нь төвийн төвлөрсөн инженерийн шугамд холбогдсон тохилог тухайлсан болон нийтийн орон сууц байна.

Хотын хөгжлийн төслөөр хотын хүн амыг орон сууцны нийт 35 хорооллоор хангахаар тооцоо гарч байгаа бөгөөд орон сууцны хороолол нь, орон сууц, олон нийтийн барилга байгууламж хосолсон орон сууц, түүх соёлын дурсгалт газар бүхий гэсэн үндсэн 3 хэв шинжтэй байна.

Орон сууцны хороолол дотроо төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон нийтийн орон сууцны, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээнд холбогдсон нам давхрын орон сууцны хороолол гэж хоёр ангилагдана.

Суурьшлын бүсэд орон сууцыг хороолол, бичил хороолол байдлаар худалдаа үйлчилгээ, нийгмийн дэд бүтцийн хангамжтай, хорооллын доторх ногоон байгууламжтай, цогцолбор байдлаар барьж байгуулна. Хорооллын, байршил, хэрэгцээнээс хамаарч барилгын давхартай нягтралыг тооцохоос гадна газар доорх автомашины зогсоолын хүчин чадал нь нийт оршин суугчдын 50% хангахаар тооцож байрлуулна.

**Нам давхар орон сууцны хороолол.** Нам давхрын орон сууцны хороолол нь гол төлөв инженерийн хангамжийн төвлөрсөн эх үүсвэрээс зайтай, өөрийн хэсэгчилсэн бие даасан эх үүсвэртэй байхаар төлөвлөлтөд тусгагдана.



Амины орон сууцны барилгын дундаж давхар 1-3 давхар байх ба эдэлбэр газартай блокчилсон нийтийн эдэлбэр газартай, эдэлбэр газартай коттедж хэлбэрийн, нийтийн сууцны гэсэн 3-4 төрөл байна.

Нам давхрын орон сууцны хороолол нь өөрийн гэсэн үйлчилгээний төвүүдтэй, хатуу хучилт бүхий гудамж замын сүлжээгээр холбогдсон ногоон байгууламж тохижилт сайтай бичил хороолол байдлаар байршина. Зам дагуу байрлах нам давхрын сууцнуудын нэгдүгээр давхруудыг худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглахаар тооцно.

**Нийтийн орон сууц.** Нийтийн орон сууц нь хороолол, бичил хороолол байдлаар төлөвлөгддөг уламжлалт системийг хадгалагдан үлдэх ба цаашид иж бүрнээр нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн хамт төлөвлөнө. Нийтийн орон сууцны хорооллыг (төлөвлөлтийн үндсэн зарчим 43а дугаар зураг) нам давхарын /1-3 давхар/, цөөн давхрын /4-6 давхар/, өндөр давхрын /7-оос дээш давхар/, буюу нягтрал сайтай өндөр давхар гэж 3 ангилан үзнэ.

Шинээр төлөвлөж буй орон сууцны хороололд, худалдаа үйлчилгээ, нийгмийн дэд бүтцийн болон амралтын ногоон байгууламжууд, авто зогсоолын хамт хүн амын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тооцож төлөвлөнө.

Хотын төвийн хэсгийн орон сууц, олон нийтийн барилгуудыг 60-70 жил тутамд буулгаж шинээр дахин төлөвлөж орон сууц, олон нийтийн барилга, ногоон байгууламж болон газар доорх байгууламжийн хамт байгуулж байхаар тооцов.

Хотын төвийн орчмын амины сууцны хорооллын нутаг дэвсгэрийг инженерийн дэд бүтэц бүхий орон сууцны хороолол хэлбэрээр барилгажуулна. Хотын төвийн хэсэг, гол гудамж замын дагуу байрлах хэсгүүдэд дороо үйлчилгээ бүхий өндөр зэрэглэлийн нягтрал сайтай орон сууцнууд баригдана.

Архитектур, түүх, соёлын дурсгалт орон сууцны барилгын үнэ цэнийг нь алдагдуулахгүйгээр шинээр барьж байгуулна.



**Хотын гэр хороолол.** Шинэ хотод гэр хороолол нь хот байгуулагдан иж бүрэн төлөвшлийг олтол хотын сууцны фондын нэг төрөл байна гэж үзэж байна. Гэр хороолол нь уламжлалт суурьшлын нэг хэлбэр боловч орчин үеийн хотын амьдралд зохицолдолгоо муутай, байгаль экологи, хөрс, агаарын бохирдлын гол эх үүсвэр болдог өнөөгийн дутагдалыг арилгахаар тооцож төлөвлөнө. Үүнийг инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжтай байхаар тооцож шийдвэрлэнэ.

Ер нь хотын гэр хорооллыг байршлыг нь харгалзан хотын төвийн, дундын, захын гэж гурав ангилан үзнэ.

Энэ төслөөр хотын дунд болон захын хэсгээр гэр сууцны хороолол байхаар тооцлоо. Цаашид хотын гэр хорооллыг дунд болон түүнээс дээш давхар тохилог нийтийн орон сууцны, дунд хэсгийн гэр хорооллыг нам давхрын орон сууцны хороолол болгохоор төлөвлөнө. Хотын төвийн гэр хороолол нь төвийн инженерийн хангамжтай, дунд хэсгийн гэр хороолол нь хэсэгчилсэн инженерийн хангамжтай байна. Шинэ хотод нийт гэр сууцны 3-4 хороолол байх ба тэнд 300.0 орчим мянган хүн амьдрана. Гэр сууцны (төлөвлөлтийн үндсэн зарчим 43б дүгээр зураг) хорооллыг зориулалтаар нь гэр сууцны, гэр сууц, нам давхрын, гэр сууц, олон нийт, нам давхар хосолсон гэж ангилна.

Төсөлд туссанаар гол замын дагуу нам давхрын сууц байрлана. Суурьшил нь төрөл бүрийн үйлчилгээ, амралтын ногоон байгууламж бүхий олон нийтийн төвтэй, хорооллын чанартай хатуу хучилттай гудамж замын сүлжээтэй, хотын бусад хэсгүүдтэй метро, автозам, нийтийн тээврээр холбогдоно. Олон нийтийн төв, түүний ойр орчинд байрлах нам давхрын орон сууцны хэсэг нь бие даасан эх үүсвэр бүхий хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээнд холбогдоно.

**Гэр хорооллын олон нийтийн төв.** Гэр хорооллын оршин суугчдын амьдралын нөхцлийг сайжруулах, гэр хорооллын оршин суугчдад төрөл бүрийн үйлчилгээг ойроос авах боломжийг бий болгох зорилгоор гэр хорооллын олон нийтийн төвийг тухайн хороололд нь төлөвлөнө. Олон нийтийн төвийг гэр хорооллын хүн амд худалдаа үйлчилгээ, нийгмийн дэд бүтцийг хамгийн ойроос хүргэх зорилгоор гэр хорооллын барилгажсан суурьшлыг түшиглэн байгуулна.





Гэр хорооллын Олон нийтийн төвийн бүтцэд гэр хорооллын иргэдийн амьдрах орчинг бүрдүүлэхэд шаардлагатай дараах байгууллагууд байрлана. Үүнд:

- Хороо захиргаа, олон нийтийн байгууллагууд
- Төрөл бүрийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарын хамт
- Худалдаа, нийгмийн үйлчилгээ /хүнс барааны дэлгүүр, ахуйн үйлчилгээ, халуун ус/
- Шуудан холбоо, банкны салбар
- Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцийн байгууллагууд
- Бичил бизнесийн байгууллагууд
- Дунд болон бага давхрын нийтийн орон сууц
- Уурын зуух, цэвэрлэх байгууламж, цахилгааны дэд өртөө зэрэг инженерийн хангамжийн эх үүсвэр
- Амралт зугаалгын бүс цэцэрлэгт талбай гэх мэт.

Төлөвлөлтөөр гэр хорооллын төвүүдийг гол төлөв 5-15 мянган орчим хүнд үйлчлэхээр тооцож хүчин чадлыг нь тогтоож төлөвлөнө. Төвүүдийн байрлал үйлчилгээний хүрээг тооцож, хот төлөвлөлтийн норм дүрмийн хязгаарт багтааж төлөвлөнө.

Гэр сууцны хорооллыг хотын бодлогын хүрээнд дараах байдлаар дэмжиж ажиллана. Гэр хороололд оршин суугчдад худалдаа, үйлчилгээг ойртуулах зорилгоор хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийн хангамжтай, нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжууд, жижиг дунд үйлдвэрлэл, нийтийн орон сууц бүхий олон нийтийн төв байршуулах, Оршин суугч айл өрхүүдийг бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдох боломжийг бий болгох, Оршин суугчид бие даан амьдралын орчин нөхцлөө сайжруулахад төр засгийн дэмжлэг үзүүлэх, Гэр хорооллын амьдрах орчны стандартыг тогтоож хэрэгжүүлэх.



Гэр хорооллыг **1.** Хотын төвийн орчмын гэр хороолол энэ нь дунд, дундаас дээш давхар орон сууцтай. **2.** Хотын дундын гэр хороолол энэ нь нам давхарын орон сууцтай. **3.** Ердийн гэр сууцнуудтай захын гэр хороолол гэж тус тус ангилаж хөгжүүлнэ.

### ӨНДӨР ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ



43а дугаар зураг





## НАМ ДАВХАР ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ




436 дүгээр зураг

**Хотын олон нийт, иргэний барилга байгууламжийн төлөвлөлтийн онцлог.** Шинэ хотын орон зайг бүрдүүлж буй олон нийт, иргэний барилга байгууламжийг хотын гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилтийн бүс, суурьшлын бүс, үйлдвэрийн бүстэй уялдуулан байршил нь хоорондоо аль болохоор орон зайн зохистой үйлчилгээний хүрээнд байхаар тооцлоо. Олон нийт, иргэний барилга байгууламжийн орон зайн дотор орчинд зорчих аливаа хөдөлгөөний зарцуулах хугацааг 30-40 минут байна гэж үзлээ.





Хангайн бүсийн тулгуур төв хот  
Гэр хороолол








Хангайн бүсийн тулгуур төв хот

Дундаж давхартай орон сууцны хороолол





Шинэ хотын соёл, урлаг боловсрол, олон нийт, нийгмийн үйлчилгээ, эрүүл мэнд, биеийн тамир, спортын барилга байгууламжийн эдэлбэр газрыг барилга байгууламжийх нь онцлогтой нь уялдуулж нэг хүнд ноогдох эдэлбэр газрын хэмжээг нь одоо мөрдөж буй нормын үзүүлэлтээр тогтоолоо.

Шинэ хотын олон нийт, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын бүтцэд хүүхдийн ордон, залуу техникчдын ордон, залуу байгалчдын ордон, хүүхдийн урлагийн болон уран сайхны сургууль, дуу хөгжмийн сургууль, идэрчүүдийн биеийн тамир, спорт, бялдаржуулах, эрүүлжүүлэх ордон хотын соёлын төв, театр, кинотеатр, музей, үзэсгэлэнгийн танхим, хурлын танхимууд зэрэг барилга байгууламжууд хамрагдахаар тооцлоо.

Хотод байрлах их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, сургалт үйлдвэрлэлийн бааз, автодром, тариа ногооны талбай, авто вокзал, төмөр замын вокзалыг бие даасан бүсчлэл бүхий эдэлбэр газартай байхаар тооцлоо.

Хот орчмын бүсэд байх эрүүл мэнд эмнэлгийн чиглэлийн халдварт, хавдар судлал, сүрьеэ, сэтгэл судлал, төрөх газар, нөхөн сэргээх эмчилгээний барилга байгууламжуудын эдэлбэр газрын норматив хэмжээг зайлшгүй шаардлагын үүднээс одоо мөрдөж байгаа норм дүрэмд заасан хэмжээнээс нэмэгдүүлэн эрүүл ахуй ариун цэврийн тогтсон нормын бүсчлэлд байрлуулан төлөвлөнө гэж үзлээ.

**Суурьшлын бүсийн олон нийтийн төв.** Энэ төв нь аливаа төвд амьдрах иргэд оршин суугчдын амьдралын ая тухтай нөхцлийг хангах, тэдэнд бүх төрлийн нийгэм эдийн засгийн үйлчилгээг ойртуулах, хүн амын хөдөлгөөний чиглэл, урсгал нягтралыг зохицуулах төр захиргаа, түүний харьяа байгууллагууд, олон нийтийн байгууллагуудыг төвүүдэд жигд тараан байрлуулах, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдсэн, ажлын байр олноор бий болгох онцлогтой байна.

Суурьшлын бүсийн олон нийтийн төвийн барилга байгууламж нь байрлаж буй эдэлбэр газрын талбайн онцлогтой уялдсан өвөрмөц архитектур орон зайн төлөвлөлттийн шийдэлтэй байна.





Хангайн бүсийн тулгуур төв хот

Өндөр орон сууцны хороолол





Архитектур орон зайн төлөвлөлтийн нарийвчилсан шийдлийг төлөвлөлтийн үе шат болох хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шатанд гаргана. Төлөвлөж буй олон нийтийн төвүүд нь хотын бусад төвүүдтэй хатуу хучилттай замаар холбогдох ба метро нийтийн тээврийн хэрэгслийн цогц сүлжээгээр хангагдана.

Энэ төв нь олон чиг үүрэгтэй байх ба төр захиргаа, олон нийтийн байгууллагуудыг тараан байрлуулах, худалдаа үйлчилгээ бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Хотын иргэд, оршин суугаа газрын ойролцоо төрөл бүрийн үйлчилгээ авах болон үйлчилгээ эрхлэх боломж сонголт нэмэгдэж хүн амын хөдөлгөөний чиглэл, урсгал нягтрал сайжирч, ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг дээшлүүлнэ. Эдгээр төвүүд нь орчин үеийн хот байгуулалтын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон архитектур орон зайн төлөвлөлтийн өвөрмөц шийдэлтэй байна. Олон нийтийн төвүүд нь үйлчлэх хүрээ, хүчин чадал хэмжээ ач холбогдлоороо дараах байдлаар ангилагдана. Үүнд: Хот дүүргийн олон нийтийн төв, хорооллын болон бичил хорооллын төв, гэр хорооллын олон нийтийн төв.

Хотын нутаг дэвсгэрийн тогтоцын онцлогоос нь шалтгаалж хотын төвүүд дараах үндсэн элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

- **Төвийн хамгаалалтын зурвас.** Төвийн эдэлбэр газарын хамгаалалтын нутаг дэвсгэр, барилгажих бүсийн нутаг дэвсгэрийг хамгаалах зурвастай байна.
- **Төвийн барилгажих хэсэг.** Бүтэцэд нь орон сууц, олон нийт, соёл боловсрол, бизнес төв, спортын болон эрүүл мэндийн, худалдаа үйлчилгээний барилга байгууламжууд, байна. Засаг захиргаа, олон нийтийн төв. Хотын төв, дэд төв болон олон нийтийн төвүүд шинээр бүрэлдэн бий болж орон зайд нь зохицсон суурьшлын бүсүүд байгуулагдана.
- **Төвийн барилгажилтын нягтрал.** Шинэ хотын суурьшлын бүс, төвийн барилгажилтын дундаж давхрыг 5-7, хүн амын нягтралыг 30-50 хүн/га байхаар тооцно. Архитектур орон зайн төлөвлөлт нь олон нийтийн төв, орон сууц, гэр хороолол, шинэ суурьшил, үйлдвэрийн район гэсэн үндсэн





хэсгүүдэд хуваагдаж хөгжинө. Төлөвлөлтийн хугацаанд хотын нийт оршин суугчдын 90.0 %-г инженерийн хангамж бүхий тохилог орон сууцаар хангах, гэр хорооллын өрх бүр бие даасан инженерийн хангамжтай, тохилог амины орон сууцтай, нийгмийн дэд бүтцийн хангамжтай байна.

- **Төвийн нам давхрын барилгын бүс болон гэр хороолол.** Төвийн нутаг дэвсгэр, орон зайд байх нам давхрын барилгатай болон гэрээс бүрдсэн хорооллуудыг өнөөдрийн адилаар хэвээр хадгалан хөгжүүлнэ.
- **Төвийн үйлдвэр, агуулах, аж ахуйн хэсэг.** Төвүүдийн нутаг дэвсгэрт байх ердийн үйлдвэр агуулахын бүсийн үйл ажиллагаа уламжлалт ёсоор хэвээр явагдах ба цаашид хөгжүүлэх тухайд дахин төлөвлөлтөд хамруулан шийдвэрлэж байхаар тооцов.

**Суурьшлын эдэлбэр газарт байх үйлдвэрийн бүс.** Энэ бүсэд хотод зайлшгүй байх шаардлагатай үйлдвэр аж ахуйн газрууд үйлдвэрийн парк, ложистикийн төвүүд болон инженерийн байгууламжууд эдгээрийн технологийн барилга байгууламжууд байна.

**Суурьшлын бүсийн газар доорхи орон зайн төлөвлөлт.** Суурьшлын бүсийн төвийн газар доорх орон зайг бүрэн дүүрэн ашиглаж худалдаа, үйлчилгээ, нийтийн тээврийн зангилаа, автомашины граж, авто болон нийтийн тээврийн дамжин өнгөрөх зогсоолын зориулалтаар ашиглах архитектур орон зайн төлөвлөлт хийгдэнэ.

**Хотын төвийн суурьшлын бүсийн орон зайд.** Энэ бүсэд Засгийн газар, зарим чиглэлийн яамдууд, тусгай газруудын барилга байгууламжууд болон орон нутгийн засаг захиргааны газрууд, худалдаа үйлчилгээ бүхий орон сууцны хороолол, улсын чанартай музей, театр, үндэсний уран сайхны галарей зэрэг соёл урлагийн байгууллагууд төвлөрнө. Мөн хотын оршин суугчдад хүргэх боломжтой төрийн болон бизнес худалдаа үйлчилгээний соёл боловсрол, спорт, эмчлэн сэргийлэх нийгмийн үйлчилгээ, амралт зугаалга, цэцэрлэгт байгууламж зэргийг иж бүрэн цогцоор нь үзүүлэх үйлчилгээтэй байхаар тооцож төлөвлөнө. Хотын төвийн



суурьшлын бүс нь хотын доторх нутаг дэвсгэрийн бүсчлэлийн үүргийг давхар гүйцэтгэнэ.

**Суурьшлын бүсийн хорооллын төв.** Энэ төв нь хотын суурьшлын бүсэд байрлах ба үүнийг жижиг хороолол гэж үзнэ. Эдгээр төвүүд нь хотын төвүүдтэй болон хоорондоо метро хатуу хучилттай зам, нийтийн тээврийн сүлжээгээр холбогдоно. Хорооллын төвд Хороо захиргаа, олон нийтийн байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээ, /хүнс барааны дэлгүүр, ахуйн үйлчилгээ, халуун ус/, банкны салбар, нийгмийн дэд бүтцийн байгууллагууд /сургууль, цэцэрлэг, эмнэлэг/, бичил бизнес, дунд давхрын нийтийн орон сууц, инженерийн хангамжийн эх үүсвэр /уурын зуух, цэвэрлэх байгууламж, цахилгааны дэд өртөө/, амралт зугаалгын цэцэрлэгт талбай зэрэг байгууламжууд байна.

**Суурьшлын бүсийн гэр хороололын олон нийтийн төв.** Суурьшлын бүсэд байрлах гэр хорооллын олон нийтийн төвд иргэдийн амьдрах орчинг бүрдүүлэхэд шаардлагатай орон сууц, худалдаа үйлчилгээ, соёл урлаг, спортын болон нийгмийн дэд бүтэцийн байгууллагууд байх бөгөөд энэ тухайн суурьшлын бүсийн хөгжлийн тэнхлэг болно.

Суурьшлын бүсийн гэр хорооллын төвүүдийн үйлчлэх хүрээг тооцон, гол төлөв дунджаар 10-13 мянган хүнд үйлчлэхээр хүчин чадлыг нь тогтоож хот төлөвлөлтийн норм дүрмийн хязгаарт багтааж төлөвлөө.

**Хотын бизнесийн төв.** Бизнесийн хэсэгт хотын чанартай бизнесийн үйл ажиллагаа явагдана. Энд олон улсын чанартай банк санхүүгийн бизнесийн гол үйл ажиллагаа явагдах тул олон давхар өндөр зэрэглэлийн оффис, зочид буудал, худалдаа үйлчилгээ, үзэсгэлэн, соёлын төвүүд, задгай амралт зугаалгын парк, цэцэрлэг, өндөр зэрэглэлийн орон сууцны барилга байгууламжууд төвлөрнө. Тус төвд олон улсад нэрд гарсан банк, санхүү, бизнесийн гадны компаниудын салбарууд болон дотоодын томоохон аж ахуйн нэгжүүдийн оффисууд байрлана.

Бизнес төвийн газар доорх хэсэгт худалдаа үйлчилгээ, спортын томоохон байгууламжууд, авто зогсоол, нийтийн тээврийн зогсоол, терминал болон инженерийн байгууламжууд байрлана.



**Хотын холимог үйл ажиллагаа явуулах хэсэг.** Хотын суурьшлын бүсийн архитектур орон зайн төлөвлөлтийн нэг салшгүй хэсэг нь нийгэмийн олон төрлийн үйл ажиллагаа бүхий хэсэг байдаг. Холимог үйл ажиллагааны хэсэгт зонхилон орон сууц, олон нийт, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа хослон явагдахаар зохион байгуулагдана.

**Хотын бөөний худалдааны төв.** Хотын чанартай бөөний худалдааны нэгдсэн төвийг хотын захруу байрлалтай төлөвлөнө. Уг төвд хүнс, аж үйлдвэрийн бараа, цахилгаан бараа, тоног төхөөрөмжийн худалдааны томоохон төвүүд байгуулагдаж үйл ажиллагаа явуулна.

Эдгээр төвүүд нь жижиглэнгийн худалдаа үйлчилгээг түүхий эд, бараа, материалаар хангах үндсэн зориулалттай, төмөр зам, авто замаар терминал, хангамжийн агуулах, нийлүүлэгчтэй, хэрэглэгчтэй гудамж, замын найдвартай сүлжээгээр хотын худалдаа үйлчилгээний байгууллагуудтай найдвартай холбогдоно

**Хотын нийтийн аж ахуй агуулахын бүс.** Энэ бүс хотын захад байрлана. Энэ бүсэд хотын хангамжийн томоохон агуулахын аж ахуй үйл ажиллагаа явагдах тул худалдаа, үйлчилгээ, аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг том аж ахуйн нэгжүүд хамрагдана. Тухайлбайл:

-Улсын болон хотын хэмжээний ач холбогдол бүхий хүнсний томоохон үйлдвэрлэгч болох мах, сүү боловсруулах, гурил, талх чихрийн томоохон үйлдвэр аж ахуйн нэгжүүд, орчин үеийн шаардлагад нийцсэн технологийн шинэчлэл хийгдсэн барилгын материалын /ханын материалын үйлдвэр гэх мэт / төвлөрсөн томоохон үйлдвэрийн газрууд,

-Хотын нөөцийн агуулах, нэгдүгээр группийн нефть болон нефтийн бүтээгдэхүүний дамжлага бааз, шингэн хийн агуулах, шатах дэлбэрэх материалын агуулах, хүчтэй хорт бодисуудын суурь агуулах, хүнсний бүтээгдэхүүний суурь агуулах, бордоо ба үйлдвэрийн түүхий эд, ойн болон барилгын агуулахууд,



-Хотын хөдөө аж ахуйн үйлдвэрийн барилга байгууламжийн байршлыг эрүүл ахуйн, мал эмнэлзүйн болон галын аюулгүйн шаардлага, технологийн шаардлагын дагуу тогтооно. Харин цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам болон бусад орон нутгийн зориулалттай шугамуудыг зам дагуулж, тариан талбай, ойн зурвасын хил дагуу аль болохоор хөдөө аж ахуйн эдэлбэр газар дундуур дайрахгүй нутаг дэвсгэрт байрлуулна. Эдгээр байгууламжуудыг эрүүл ахуй, гал түймрийн аюулгүй байдлын шаардлагын дагуу төмөр зам болон хот хоорондын зайд ойр байрлуулна.

**Инженерийн хангамж.** Хотын инженерийн хангамжийг орчин үеийн техникийн дэвшил, технологийг ашиглан хөгжүүлнэ. Тус байгууламжид цэвэрлэгдсэн саарал усыг техникийн зориулалтаар эргүүлж ашиглах шугам сүлжээний байгууламжийг барьж байгуулна. Цахилгаан хангамж нь цахилгаан хангамжийн хуваарилах байгууламжууд, цахилгаан дамжуулах өндөр хүчдлийн агаарын шугамууд хамгаалалтын зурвас зэргээс бүрдэнэ.

Мөн уг бүсийн нутаг дэвсгэрт хотын чанартай ложистик, тээвэр, агуулах аж ахуйн газрууд төвлөрч үйл ажиллагаа явуулна.

**Ложистикийн төв.** Шинэ хотын баруун хэсэгт 40.0 га талбайд хотын ложистикийн төв байрлана. Ложистик нь байрлал, тээврийн төрөл, ачаа тээврийн онцлогоос шалтгаалж хоёр байрлалд төвлөрч үйл ажиллагаа явуулна. Нисэхийн ложистик нь хотын захын орчинд дагнан үйл ажиллагаа явуулах ба үндсэн ложистикийн төв нь хотын төвийн нутаг дэвсгэрт байрлана.

Ложистик байрлах нутаг дэвсгэрт инженерийн бэлтгэл арга хэмжээ авч авто зам, төмөр замын салаа оруулах ба төвлөрсөн инженерийн хангамжтай төрөл бүрийн оффис, агуулахын барилга байгууламжуудыг барина. Ложистикийн төвийн нутаг дэвсгэрийг тохижуулж, эдэлбэр газрын 60 хувьд нь ногоон байгууламж цэцэлэгт талбай, гудамж зам, тээврийн сүлжээ байхаар төлөвлөнө.

Хотоос 80-90 км зайд байрлах олон улсын шинэ нисэх онгоцны буудалын орчимд сургалт, тусгай үйлчилгээний зориулалттай хотхон байх бөгөөд тэнд мөн нисэхийн ложистик төв байна. Нисэх буудлын орчныг хотын бусад хэсгүүдтэй





холбоо, мэдээлэл, гудамж зам тээврийн сүлжээгээр холбоно. Уг ложистик нь овор багатай өртөг өндөртэй барааны түгээлтийг дагнаж үйлчилгээ явуулах боломжтой байна.

**Өндөр технологийн төв.** Хотын үйлдвэрийн бүсэд өндөр технологийн төв байрлана. Хотын 2040 оны хөгжлийн чиг хандлагад тодохойлсны дагуу хотын өмнөд хэсэгт оюуны багтаамжтай, өндөр технологийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ. Өндөр технологийн төв нь 20 га талбайд байрлана. Уг төвд мэдлэг шаардсан мэдээлэл технологийн парк гэх мэт байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл дагнан байрлана. Эргэн тойрондоо суурьшлаас ногоон байгууламжаар тусгаарлагдана. Төвийн хэсэгт ажиллагсдын орон сууцны хороолол нийгмийн дэд бүтэц, олон нийтийн барилга байгууламжийн хамт байрлана.

Шинэ хотын дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, монгол хүний оюуны нөөц бололцоог (үйлдвэрийн бүс төлөвлөх үндсэн зарчим 44 дүгээр зураг) дайчлан баялаг бүтээх зорилгоор мэдээлэл технологийн паркийг шинээр хотын баруун захын орчинд байгуулна. Тус төв нь оюуны багтаамжтай үйлдвэрлэл явуулах тул их сургуулийн хотхон, эрдэм шинжилгээ, судалгааны төвүүд зэрэг өндөр мэдлэг шаардсан салбар байх юм.


Багш, оюутан сурагчдын орон сууц, дотуур байр, төрөл бүрийн худалдаа үйлчилгээний барилга байгууламжууд, гудамж замын сүлжээ ногоон байгууламжийн хамт баригдана. Тус төвийн нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрүүдийг өндөр технологийн түвшинд шийднэ.

**Хотын тусгай зориулалтын нутаг дэвсгэр.** Шинэ хотын 2040 оны хөгжлийн чиг хандлагаар, тусгай зориулалтаар ашиглагдах нутаг дэвсгэрийн зориулалтыг дараах байдлаар шийднэ. Үүнд: Цэргийн анги, Хогийн цэг, Оршуулгын газар, Хорих газар, Цэргийн ангийг хотын нутаг дэвсгэр дээр байрлуулж ногоон байгууламжаар суурьшлаас тусгаарлана. Мөн тусгай зориулалтын төвийг олон нийтийн төвөөс гадна тодорхой төрөлжсөн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тухайлбал клиникийн нэгдсэн эмнэлгүүдийг түшиглэн эмчилгээ, оношлогоо, эдэм судлалын үйл ажиллагаа явуулах цогцолборууд болон



том хэмжээний төрөлжсөн бөөний худалдааны төвүүд, спорт цогцолборууд, сургалт, эрдэм шинжилгээ, их дээд сургууль, судалгааны төвүүд зэрэг цогцолбор байгууламжууд байхаар тооцно. Эдгээр төвүүдийг зонхилон дараах чиглэлээр хөгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Эмчилгээ оношлогооны төв, Бөөний худалдааны төв, Амралт, аялал жуулчлалын төв, Спортын цогцолбор, Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн төв, Оюутны хотхон байхаар тооцож байна.



44 дүгээр зураг

**Хотын хогийн цэг.** Хотын нутаг дэвсгрийн хилийн цэсийн гадна талд хогийн цэгүүд байрлана. Хогийн цэгийг түшиглэн, орчин үеийн өндөр технологийн аргаар хогийг гүн боловсруулж, агаар, хөрсний бохирдлоос хамгаалсан шинэ технологи ашиглан булшлах үйлдвэр байгуулах ба орчныг нь цэцэрлэгжүүлж тохижуулна. Аюултай хог хаягдлыг зөөж хотын нутаг дэвсгэрээс гаргаж, бүсийн хилийн дотор тохиромжтой цэгт байгаль экологид аюулгүй байдлыг хангасан технологээр булшилна.

**Оршуулгын газар.** Хотын эдэлбэр газрын эргэн тойронд хотын чанартай оршуулгын газар үүнд цогцос чандарлах болон оршуулгын эдэлбэр газар байх ба энэ эдэлбэр газрыг үйл ажиллагаа нь цаашид үргэлжлүүлэх, үйл ажиллагаа



хаагдах гэж 2 ангилна. Ер нь оршуулгын газруудын орчныг автомашины зам, зогсоол байгуулах, гэрэлтүүлэг тавих хашаажуулах зэргээр тохижуулж, цэцэрлэгжүүлнэ.

**Хорих газар.** Шинэ байрлах хорих ангиудыг хотоос 30-40 кмт байрлуулахаар тооцож төлөвлөв.

**Амралт, аялал жуулчлал спорт үйлчилгээний төв.** Хотын хүн амын амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилготой амралт, аялал жуулчлалын газруудыг дэд бүтцийг түшиглэн шинээр байгуулна. Энэ бүсэд хотын чанартай өвөл зуны спортын цогцолбор барилга байгууламжийг харъяа жижиг спортын төвүүдийн хамт байгуулна. Ингэснээр хотын оршин суугчдын амралт чөлөө цагаа ая тухтай өнгөрөөх цогц бололцоогоор хангагдана.

**III.1.5 Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэр архитектур төлөвлөлт.** Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн 60-аас доошгүй хувьд үйлдвэр, үйлдвэрлэлийн зориулалттай нийгмийн үйлчилгээний болон туслах барилга байгууламж байна. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийг тухайн үйлдвэртэй холбоотой барилга байгууламжийн эдэлбэр газар, төмөр замын өртөөний эдэлбэр газартай нь хамт тооцож эдэлбэр газрынх нь норматив хэмжээг тогтооно.

Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрийн цогцолбороосоо гадна хотын нийтийн аж ахуйн агуулахын зориулалттай барилга байгууламж, тэдгээрийн туслах барилга байгууламж, ажиллагсадын (үйлдвэрийн бүсчлэл төлөвлөх загварчлал 45 дугаар зураг) соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжтай байхын зэрэгцээ зам тээврийн үйлчилгээ, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний цогц байгууламжууд байна.

Хотын үйлдвэрийн болон хот нийтийн аж ахуйн агуулахын бүсийн орон зайг үйлдвэрийн болон нийтийн аж ахуйн агуулахын барилга, туслах барилга байгууламж, инженерийн байгууламжтай нь уялдуулан нутаг дэвсгэрийг нь үйлдвэрийн технологи, ариун цэвэр-эрүүл ахуйн, галын шаардлагынх нь дагуу бүсчилж улмаар ажиллагсдынх нь ажиллах, амрах чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн байхаар тооцлоо.



Шинэ хотын үйлдвэрийн ба суурьшлын бүсийн хоорондын уялдааг хангахад анхаарч үйлдвэрийн ажилчид ажилдаа хамгийн бага хугацаа зарцуулж ирэх хүрээлэлд байхаар тооцсоны зэрэгцээ үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг тухайн бүсийн хотын орон зайн бүтэц дэх байршлын онцлог, түүний газар нутгийнх нь байршлын үнэ цэнэтэй уялдуулан төлөвлөхөөр тооцож уг бүсийн газар доорхи орон зайг нь хамгийн оновчтой ашиглахаар төлөвлөнө.

Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, зохион байгуулалтыг үйлдвэрийн технологид нь тохируулан үндсэн болон туслах үйлдвэрлэлийн ашиглалт, зориулалтанд нь зохицсон байхаар тооцож, байршлыг нь эрүүл ахуй-ариун цэврийн хамгаалалтын бүс, гал түймрийн аюулаас хамгаалах шаардлага, ачаа тээврийн эргэлтийн хэмжээтэй уялдуулан тогтооно.

Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн 60-аас доошгүй хувьд үйлдвэр, үйлдвэрлэлийн бүс дэх нийгмийн үйлчилгээний болон туслах барилга байгууламж байна. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийг тухайн үйлдвэртэй холбоотой барилга байгууламжийн эдэлбэр газар, төмөр замын өртөөний эдэлбэр газартай нь хамт тооцож эдэлбэр газрынх нь норматив хэмжээг тогтооно.

**Хотын үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрт:** Тухайн үйлдвэрийн үйл ажиллагааны онцлог, хүчин чадалтай нь уялдсан шинжлэх ухаан, туршилт-үйлдвэрлэлийн бүс байна. Энэ бүсэд шинжлэх ухаан, туршилт-үйлдвэрлэлийн барилга байгууламж, тухайн үйлдвэртэй холбоотой дээд, дунд сургууль, үйлчилгээний байгууллага, туршилтын үйлдвэрүүд, эдгээрт нь тохирсон инженерийн шугам сүлжээ болон тээврийн байгууламжууд байрлана.







0.14-0.2м<sup>2</sup>, 0.1-0.12м<sup>2</sup> шинжлэх ухаанд оногдохоор тооцно.

Үйлдвэрийн бүсийн төлөвлөлтийн шийдэл. Үйлдвэрийн бүсэд байх хотын төвлөрсөн инженерийн хангамжийн эх үүсвэрүүдийг орчин үеийн үйлдвэрлэлийн дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх замаар шийдвэрлэнэ.

Дулаан цахилгааны станцуудыг технологийн өндөр түвшинд шийдэж улмаар атомын цахилгаан станц барина. Дулаан хангамжийн болон уурын шугамуудыг газар доогуур хонгилын системээр төлөвлөнө.

Хотын төв цэвэрлэх байгууламжийг орчин үеийн техник, технологээр шийдэж усыг техникийн зориулалтаар эргүүлж ашиглах технологи бүхий инженерийн байгууламж, шугам сүлжээг барьж байгуулна. Цэвэрлэх байгууламжийн орчны талбайг цэцэрлэгжүүлж мод тарьж зүлэгжүүлнэ.

Бүс доторх гудамж замын сүлжээг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагагатай гудамж зам, ногоон байгууламжийн сүлжээтэй нь нэгдсэн орон зайд хамруулан төлөвлөнө. Үйлдвэрийн бүсэд ложисткийн нэгдсэн төв байгуулна. Хотын үйлдвэрийн бүсийн түүхий эдийн хангамжийг төмөр замаар хангахаар тооцно.

Ер нь Шинэ хотын үйлдвэрийн хөгжилд уламжлалт зарчим хэвээр хадгалагдахын зэрэгцээ экспортын чиглэлтэй, өндөр технологи үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Хотын иргэдийн амьдралд зайлшгүй хэрэгцээ шаардлагагатай хүнс, хөнгөн үйлдвэрүүд хуучин хэвээр үйл ажиллагаа явуулах ба өнөөгийн ажиглагдаж байгаа үйлдвэрүүдийн техник технологийг шинэчлэлт хийх замаар үйлдвэрлэлээ өргөтгөж үргэлжлүүлэн ашиглана гэж үзлээ.

Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрүүд болон зарим төрлийн хүнд болон барилгын материалын үйлдвэрүүд, агуулахын аж ахуйг хотоос гадагү дагуул хот тосгодод байрлуулахаар тооцов.

Хөгжлийн чиг хандлагаар Шинэ хот нь Үйлдвэрийн 7 нэгж хорооллоос бүрдэнэ. Үүнээс өндөр технологийн 2, үйлдвэрлэлийн паркийн зохион



байгуулалттай 4, агаарын тээвэр зонхилсон ложисткийн үйлчилгээний 1 гэсэн бүтэцтэй байхаар тооцно.

Шинэ хотын үйлдвэрийн бүсийг, аж үйлдвэрийн парк байдлаар төрөлжүүлж хөгжүүлнэ. Аж үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийг үйлдвэрлэл технологийн парк байдлаар төлөвлөнө. Үйлдвэрийн бүс нь дараах технологийн зарчмаар байрлана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн паркийг үндсэн, туслах, жижиг гэсэн байдлаар ангилж байршуулах
- Уламжлалт үйлдвэрийн газруудын байршлыг аль болох хэвээр хадгалана.
- Жижиг дунд үйлдвэрийн технологийн паркийг тусад нь төлөвлөнө.
- Үйлдвэр, суурьшил, үйлчилгээний холимог бүстэй төлөвлөх.
- Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрт хамгаалалтын ногоон зурвас байгуулана.
- Үйлдвэрийн ажилчдад зориулсан худалдаа үйлчилгээ, спортын цогцолборууд, ногоон байгууламжуудыг төлөвлөнө.

Үйлдвэрийн бүс нь сайн чанарын гудамж замын сүлжээгээр хотын нийт орон зайд холбогдож нийтийн эзэмшлийн ногоон байгууламжаар бүрэн хангагдсан байна.

Өндөр технологи, мэдээллийн технологийн үйлдвэрлэлүүдийг заавал үйлдвэрийн районд байрлуулах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь

Шинэ хотын эдэлбэр газрын хилийн цэсээс гаднах орчинд нөөц нутаг дэвсгэрт хотын нийгмийн хангамж, дэд бүтцийн болон тээхэд эмзэг хүнсний бүтээгдэхүүн, жимс, жимсгэнийн үйлдвэр ХАА-н цогцолборууд суурьшсан дагуул хот, тосгон байрлахаар тооцов. Мөн энэ бүс нь хотын хүн амын түр хугацааны амралт-зугаалгын газар, хүүхдийн зуслан, хотын бичил уур амьсгалыг сайжруулах нөлөө бүхий усан сан, ногоон байгууламж парк бүхий цэцэрлэгжүүлсэн талбайтай байна. Ингэснээр хот орчмын бүсийн эдгээр дагуул хот, бүлэг суурин хоорондын харилцан таталцлын оновчтой хүрээ тогтож хот нутаг дэвсгэрийн хувьд бүхэлдээ орон зайн нэгдсэн орчин болж хөгжих боломж бүрдэнэ.



Шинэ хотын нийт нутаг дэвсгэрийн орон зайд хамаарах захын нөөц нутаг дэвсгэр буюу хотын төвөөс тээврийн хэрэгсэлээр 30-40 мин хүртэлх хугацаанд зорчин очих дагуул тосгон суурины нутаг дэвсгэрт инженерийн төвлөрсөн хангамжтай, өдөр тутмын нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай орон сууц, олон нийт, үйлдвэрлэл үйлчилгээний иж бүрэн барилга байгууламж байна.

**Мөн хот орчмын нутаг дэвсгэрт.** Дагуул тосгон суурин, нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, зуслан, амралт-сувилалын газар, хотын чанартай агуулах, зоорь, хог хаягдлын цэг, шарилын газар, унд, ахуйн усны эх үүсвэрийн худгууд, цэвэрлэх байгууламж, газар тариалан, фермерийн аж ахуй зэрэг бусад туслах чанарын аж ахуй байгууламжууд баригдана.

Хот орчмын бүсийн төлөвлөлтийн хязгаарыг дагуул хот, бүлэг суурингийн хоорондын харилцан таталцлын оновчтой хүрээг тогтоон тооцсоны үндсэн дээр цогц байдлаар төлөвлөхөөр тооцлоо.

Хотын онгоцны буудлын эдэлбэр газрыг дотор нь буудлын бүс, аюулгүйн бүс ба ашиглалтын бүс гэж гурван бүсэд хувааж, аэродромыг төв цэгээр нь тооцож, аэродромоо тойруулан 3км-ийн радиустай тойрог зурвас талбай, мөн 10 км-ийн радиустай аюулгүйн талбай, 10 км-ээс дээш радиустай барилга байгууламжууд байрлах талбай гэж тус тус ангилан төлөвлөнө.

Хотын нисэх онгоцны буудлыг дагуул хотын түвшинд тооцож, орон сууц, олон нийт, эрүүл мэнд, соёл ахуйн ахуйн үйлчилгээний нэгдсэн төвтэй байхаар тооцно.

Шинэ хот нь худалдаа үйлчилгээ давамгайлсан дагуул хот тосгон бүхий олон үүрэгт хот болж байна. Энэ үүднээс нь экспортын чиглэлтэй, өндөр технологи үйлдвэрлэлийг хөгжүүлэх үзэл баримтлалыг хадгалж, цаашид хөгжүүлэхээр тооцож төлөвлөсөн болно. Шинэ хотын дагуул хот суурингуудад дараах чиглэлийн үйлдвэрүүдийг байрлуулахаар тооцлоо. Үүнд:





Хотын нийгмийн хэрэгцээг иж бүрэн хангах хөнгөн хүнсний иж бүрэн төрөлжсөн үйлдвэрүүд.

- Арьс шир, ноос ноолуурын анхан шатны иж бүрэн боловсруулах үйлдвэрүүд,
- Хотыг бүхэлд нь хангах барилгын материалын үйлдвэрүүд,
- Хүнс, хөдөө аж ахуйн цогцолбор үйлдвэрүүд,
- Химийн хорт бодис ялгаруулдаг үйлдвэрүүд,
- Химийн хорт бодисын агуулахууд,
- Шатах тослох материалын агуулах,
- Мод боловсруулах үйлдвэр,
- Элс, хайрганы орд газрын ашиглалт, олборлолт,
- Мал нядалгааны газрууд,
- Өлөн гэдэс, яс боловсруулах үйлдвэр,
- Малын хоёрдогч түүхий эдийн агуулах, боловсруулах үйлдвэр,
- Нефть, нефтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл агуулах
- Хотын инженерийн дэд бүтцийн хангамжийн иж бүрэн үйлдвэрүүд

Дагуул хот тосгонд хотын амьдралд зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хүнс, хөнгөн үйлдвэрүүд өнөөдрийн адилаар хэвээр үйл ажиллагаа явуулах ба үйлдвэр нь орчин үеийн техник технологийн хангалттай байгаль экологид ээлтэй үйлдвэрлэл болж өргөжин хөгжинө.

Ийнхүү шинэ хотын нутаг дэвсгэрийн бүсийн хүрээнд хаяа дагуул хот тосгодыг жигд тэнцвэртэй эрчимтэй хөгжүүлж, хөгжлийн шинэ төвүүд үүсгэх ба эдгээр дагуул хот тосгод нь хүн амыг жигд тэнцүү байршуулахаас гадна боловсруулах, чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ төрөлжсөн хотыг хэрэгцээт төрлийн нийгмийн бүх л бүтээгдэхүүнээр хангах чиг үүрэгтэй байна. 2040 онд бүсийн хот тосгодын хүн ам болон жижиг тосгодын нийт хүн ам 1000,0 мянга үүн дээр дагуул, хаяа хот тосгодын хүн ам нь ойролцоогоор 250,0 мянга байна. Энэ тооцоо нь Шинэ хотын хүн ам тогтворт байдлаа хадгалан хөгжих нөхцөл бүрдүүлнэ.



**III.1.6 Дагуул хот, тосгодын хөгжлийн төсөөлөл.** Шинээр барьж байгуулах хотын хилийн зэст багтаж буй Өгийнуур, Хашаат, Хархорин, Хужирт, Бат-Өлзийт, Хотонт Хужирт, зэрэг сум сууринг Шинэ хотын хангамжийн асуудлыг эрхлэх үүрэг бүхий суурин болгож хөгжүүлнэ. Үүнд:

**Өгийнуур тосгон.** Энэ тосгон Шинэ хотын хөгжлийн чиг хандлагаар аж үйлдвэр, аялал жуулчлал, соёл боловсрол эрчимтэй хөгжсөн дагуул тосгоны үүргийг гүйцэтгэж хөгжинө.

Төлөвлөлтийн хугацаанд Өгийнуур тосгон нь 23 орчим мянган оршин суугчтай, 2000,0 га нутаг дэвсгэр бүхий үйлдвэрлэлийн томоохон төв, суурьшлын бүс болсон байна. Тосгоны хүн амын дундаж нягтрал (төлөвлөлтийн үндсэн зарчим 46 дугаар зураг) 2040 онд 12 хүн/ га, 2050 онд 15 хүн/га байна.

Тус тосгонд дараах чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ түлхүү хөгжиж, Шинэ хотын хүн амын цаашдын механик өсөлтийг сааруулахад тодорхой үүрэг хүлээнэ. Үүнд:

- **Өрхийн аж ахуй бүхий жижиг дунд үйлдвэрлэл**
- **Шинэ технологи нутагшуулах парк**
- **Аялал жуулчлалын салбар**
- **Тээвэр ложистик.**
- **Хүнс, хөнгөн үйлдвэрлэл. /Шинэ хотын хэрэгцээг бүрэн хангах /**
- **Барилгын материалын үйлдвэрлэл,**
- **Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв**
- **Улсын чанартай томоохон эмнэлгийн цогцолбор**
- **Шинэ технологи нутагшуулах төв.**


Өгийнуур тосгон нь хөгжлийн шинэ ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжинө. Өгийнуур-тосгоны төвийн авто зам дагуух газарт шинээр нам, дунд давхрын орон сууцны хороолол бүхий суурьшилын бүс байна. Эдгээр хорооллууд нь нийгмийн дэд бүтэц, хэсэгчилсэн инженерийн дэд бүтэцтэй байхаар баригдана. Өгийнуур тосгонд авто, төмөр замын терминал, түлш шатахууны агуулахууд төрөл бүрийн бөөний худалдаа бүхий ложистикийн төв байрлана.



**Өгийнуур тосгон.** Шинэ хоттой төмөр замаар холбогдоно. Шинээр байгуулагдах хотын үйлдвэр, ложистик, агуулахын аж ахуй хөгжсөн, ачаа тээврийн терминаль бүхий дагуул хот маягийн тосгон болж хөгжинө. Өгийнуур тосгон 5 дэд төвтэй байна. Хүн амын дундаж нягтрал 4 хүн/га байна.

Өгийнуурт үйлдвэрлэл, суурьшлыг дэмжих зорилгоор арьс ширний болон ноос ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрийг байгуулна. Мөн шинэ хотод байх шаардлагагүй үйлдвэрүүдийг барьж байрлуулна. Энэ тосгонд шатах тослох материалын агуулахууд, малын гаралтай түүхийн эдийн агуулах, боловсруулах үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлчилгээ хөгжихөөс гадна бараа түүхий эдийн төв бирж үйл ажиллагаа явуулна.

### ӨГИЙНУУР ТОСГОНЫ НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



46 дугаар зураг



Хөгжлийн чиг хандлагаар Өгийнуур тосгон харъяа хэд хэдэн дэд суурингаас бүрдэх ба эдгээр төвүүдэд хотын хэрэгцээг хангах дараах чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээний салбар хөгжинө. Үүнд:

**Нэг дэх дэд төв: Ноос ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэрлэл**

- Тээвэр ложистик
- Бөөний худалдаа
- Хөнгөн, хүнсний жижиг дунд үйлдвэрлэл
- Хүнсний үйлдвэрлэл, фермерийн аж ахуй
- Аялал жуулчлал
- Олон төрлийн жижиг дунд үйлдвэрүүд

Шинээр байгуулах эдгээр тосгон суурин нь бие даасан инженерийн шугам сүлжээ, эх үүсвэрүүдтэй байх юм. Мөн авто зам, нийтийн тээвэр сайн хөгжсөн сүлжээтэй байна.

**Хоёр дэхь дэд төв: Газар нутгийн байршлын /Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс / онцлогоос шалтгаалж цаашид энэ сум тосгоны статусаар хөгжинө. Энэ тосгон нь 10,00 мянган хүн ам бүхий дагуул хот маягийн тосгон байдлаар хөгжинө.**

Тосгоны нутаг дэвсгэрийг газар нутгийн онцлогийг харгалзан 0.8 га болгон тогтоох ба хүн амын нягтрал 6 хүн/га байхаар тооцож төлөвлөв. Энэ тосгоныг дараах үйл ажиллагааны чиглэлээр хөгжүүлнэ. Үүнд:

- Амралт зугаалга
- Улаанбаатар хотын иргэдийн зуслан /түр суурьшил/
- Байгалийн аялал жуулчлал

Голын хамгаалалтын зурваст орсон голын эргийн дагуух суурьшлыг хязгаарлах арга хэмжээ авч ашиглалтын горим тогтооно.





**Гурав дахь дэд төв:** Энэ төвийг 5,0 мянган хүн амтай, 09 га нутаг дэвсгэрт Шинэ хотын дагуул хот маягийн тосгон болгон хөгжүүлнэ. Хүн амын дундаж нягтралыг 5 хүн/га байхаар тооцон төлөвлөж байна. Тосгоныг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, түүний дагуу инженерийн дэд бүтэц, гудамж замын сүлжээ бүхий орчин үеийн суурьшлыг бий болгоно.

Энэ тосгоныг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ түлхүү хөгжсөн Шинэ хотын дагуул тосгон болгон хөгжүүлнэ. Үүнд:

- Төмс хүнсний ногоо
- Жимс жимсгэнэ
- Хүнсний нарийн ногооны хүлэмжийн аж ахуй
- Хүнсний жижиг дунд үйлдвэрлэл
- Өрхийн аж ахуй
- Хотын иргэдийн зуслан, амралт зугаалга

Шинэ хоттой энэ тосгон авто зам, төмөр замын нийтийн тээврээр холбогдоно.

**Дөрөв дахь дэд төв:** Энэ төв 6000 хүн амтай. 07 га нутаг дэвсгэртэй байна. Тус тосгонд уламжлалт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл зонхилон хөгжүүлэхээс гадна сав баглаа боодол, агуулахын аж ахуй, хөдөө аж ахуйн боловсруулах дараах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Үүнд:

- Гахай, шувууны эрчимжсэн аж ахуй
- Хүнсний нарийн ногооны хүлэмжийн аж ахуй
- Сав баглаа боодлын үйлчилгээ
- Хүнсний бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр
- Хүнсний бүтээгдэхүүний хөргөгчтэй агуулах, бөөний худалдаа
- Өрхийн үйлдвэрлэл
- Хүнсний жижиг дунд үйлдвэрлэл



**Тав дахь дэд төв:** 8000 хүн амтай, 09 га нутаг дэвсгэр бүхий хотын дагуул тосгон болгон хөгжинө. Тус тосгонд дараах чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлнэ . Үүнд:

- **Малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл /хими, биобэлдмэл/**
- **Амралт сувилал**
- **Нано- биотехнологи**
- **Хүнсний жижиг дунд үйлдвэрлэл**
- **Сүү, сүү боловсруулах үйлдвэр**
- **Мах, мах боловсруулах үйлдвэр**
- **Хүнсний жижиг дунд үйлдвэр тус тус хөгжихөөр тооцно.**

Эдгээр суурин тосгодыг Шинэ хотын хүн амыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах бүс болгон хөгжүүлнэ. Үүний тулд нарийн ногооны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, нарийн ногоог дарж савлах, боловсруулах зэрэг хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дагнан хөгжүүлэхээр төлөвлөв.

Эдгээр тосгон суурингуудыг эхний ээлжинд улс, Шинэ хотын хөрөнгө оруулалтаар авто зам, бие даасан инженерийн дэд бүтэц барьж байгуулна. Шинэ хоттой нийтийн тээвэр, орчин үеийн холбоо, мэдээллийн найдвартай сүлжээгээр холбоно.

**Хашаат тосгон.** Энэ тосгон нь 2040 оны оны хөгжлийн чиг хандлагаар 25.0 орчим мянган хүн амтай уул уурхай, эрчим хүч, хими технологи, барилгын материалын үйлдвэрлэл түлхүү хөгжсөн аж үйлдвэрийн жижиг хот, төв болгохоор төлөвлөж байна.

Тосгоны нутаг дэвсгэрийг төлөвлөлтийн (төлөвлөлтийн үндсэн зарчим 47 дугаар зураг) хугацаанд 80000 хүн амтай, нутаг дэвсгэр нь 5000.0 га , хүн амын дундаж нягтралыг 2040 онд 8 хүн/га /2050 онд 9 хүн/га/ байхаар тооцов.

Энэ тосгон нь Шинэ хоттой автозам, төмөр замаар холбогдоно. Энэ тосгонд дараах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ. Үүнд:



- Түлш эрчим хүчний үйлдвэрлэл
- Нүүрс боловсруулах / баяжуулах /, утаагүй түлшний үйлдвэрлэл
- Шатдаг хий, шингэрүүлсэн түлшний үйлдвэрлэл
- Бордооны үйлдвэрлэл /ургамлын бордоо, газар тариалан, зүлэгжүүлэх г.м/
- Химийн үйлдвэрийн түүхий эд, анхан шатны бүтээгдэхүүн болох давирхай гаргах
- Шүүлтүүрийн нүүрсний үйлдвэрлэл
- Барилгын ханын материалын үйлдвэрлэл /хөнгөн блок/ болон түүхий эдийн үйлдвэрлэл / хайрга ангилан ялгах /
- Төмөрлөгийн үйлдвэрлэл / төрөл бүрийн арматур /
- Нано-биотехнологийн үйлдвэрлэл
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж, экспортын баримжаатай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Шинэ хотын хүнд болон боловсруулах үйлдвэрүүдийг энд байрлуулна. Энэ утгаараа Шинэ хотын дагуул аж үйлдвэр хөгжсөн тосгон болж хөгжинө.

**Хашаат тосгон дэд төв.** Шинэ хотын, 2040 оны хөгжлийн чиг хандлагаар энэ дэд төвийг 9 орчим мянган хүн амтай дүүргийн төв, үйлдвэрлэл худалдаа хөгжсөн дагуул тосгон болгон хөгжүүлнэ. Нутаг дэвсгэрийг 1000.0 га, хүн амын дундаж нягтрал 0.5 хүн/га /2040 онд 2 хүн/га/ болно.

Хөгжлийн чиг хандлагаар тус тосгоны хүн амын өсөлтийг Шинэ хот, бүсийн нутаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг суурьших нөхцлийг бүрдүүлэх замаар суурьшлын бүсүүд төлөвлөнө. Тус дэд төв нь мах боловсруулах үйлдвэр, нүүрс, барилгын материалын эрдэс түүхийн эдийн нөөцтэй, дэд бүтцийн харьцангуй сайн хөгжсөн байхаар тооцож үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлнэ. Үүнд:

- Бөөний худалдаа
- Хүнс хөнгөн үйлдвэрлэл



- Малын түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл
- Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл
- Тэсрэх аюултай бодисын агуулах
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Төрөл бүрийн үйлдвэрлэлийн чиглэл бүхий жижиг дунд үйлдвэрүүд
- Фермерийн аж ахуй
- Хүнс ногооны агуулах, зоорь

### ХАШААТ ТОСГОНЫ НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



47 дугаар зураг





Энэ тосгон дэд төв нь Шинэ хот, бүсийн бусад хот, тосгодтой засмал зам төмөр замаар холбогдож авто тээврийн нэгдсэн вокзал, терминаль автот ээврийн зангилаа болж хөгжинө. Үйлдвэрлэлийн салбарыг Шинэ хотод аль болохоор байлгахгүй байх бодлого баримтална.

**Хотонт тосгон.** Энэ тосгон нь 2040 оны оны хөгжлийн чиг хандлагаар 21.0 орчим мянган хүн амтай уул уурхай, эрчим хүч, хими технологи, барилгын материалын үйлдвэрлэл түлхүү хөгжсөн аж үйлдвэрийн жижиг хот, төв болгохоор төлөвлөж байна.

Тосгоны нутаг дэвсгэрийг төлөвлөлтийн хугацаанд 80000 хүн амтай, нутаг дэвсгэр нь 5000.0 га , хүн амын дундаж нягтралыг 2040 онд 8 хүн/га /2050 онд 9 хүн/га/ байхаар тооцов.

Энэ тосгон нь Шинэ хоттой автозам, төмөр замаар холбогдоно. Энэ тосгонд дараах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ. Үүнд:

- Түлш эрчим хүчний үйлдвэрлэл
- Нүүрс боловсруулах / баяжуулах /, утаагүй түлшний үйлдвэрлэл
- Шатдаг хий, шингэрүүлсэн түлшний үйлдвэрлэл
- Бордооны үйлдвэрлэл /ургамлын бордоо, газар тариалан, зүлэгжүүлэх г.м/
- Химийн үйлдвэрийн түүхий эд, анхан шатны бүтээгдэхүүн болох давирхай гаргах
- Шүүлтүүрийн нүүрсний үйлдвэрлэл
- Барилгын ханын материалын үйлдвэрлэл /хөнгөн блок/ болон түүхий эдийн үйлдвэрлэл / хайрга ангилан ялгах /
- Төмөрлөгийн үйлдвэрлэл / төрөл бүрийн арматур /
- Нано-биотехнологийн үйлдвэрлэл
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж, экспортын баримжаатай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл



Шинэ хотын хүнд болон боловсруулах үйлдвэрүүдийг энд байрлуулна. Энэ утгаараа Шинэ хотын дагуул аж үйлдвэр хөгжсөн тосгон болж хөгжинө.

**Хотонт тосгон дэд төв.** Шинэ хотын, 2040 оны хөгжлийн чиг хандлагаар энэ тосгоныг 12 орчим мянган хүн амтай дүүргийн төв, үйлдвэрлэл худалдаа хөгжсөн дагуул тосгон болгон хөгжүүлнэ. Нутаг дэвсгэрийг 3000.0 га, (төлөвлөлтийн үндсэн зарчим 48 дугаар зураг) хүн амын дундаж нягтрал 0.5 хүн/га /2040 онд 2 хүн/га/ болно.

Хөгжлийн чиг хандлагаар тус төвийн хүн амын өсөлтийг Шинэ хот, бүсийн нутаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг суурьших нөхцлийг бүрдүүлэх замаар суурьшлын бүсүүд төлөвлөнө.

Тус тосгон нь мах боловсруулах үйлдвэр, нүүрс, барилгын материалын эрдэс түүхийн эдийн нөөцтэй, дэд бүтцийн харьцангуй сайн хөгжсөн байхаар тооцож үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлнэ. Үүнд:

- **Хүнс хөнгөн үйлдвэрлэл**
- **Малын түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл**
- **Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл**
- **Тэсрэх аюултай бодисын агуулах**
- **Барилгын материалын үйлдвэрлэл**
- **Төрөл бүрийн үйлдвэрлэлийн чиглэл бүхий жижиг дунд үйлдвэрүүд**
- **Фермерийн аж ахуй**
- **Хүнс ногооны агуулах, зоорь**


Шинэ хот, бүсийн бусад хот, тосгодтой засмал зам төмөр замаар холбогдог авто тээврийн нэгдсэн вокзал, терминаль авто тээврийн зангилаа болж хөгжинө.

**Бат-Өлзийт тосгон.** Шинэ хотын, хөгжлийн чиг хандлагаар энэ тосгоныг 20 орчим мянган хүн амтай дагуул тосгон, үйлдвэрлэл худалдаа хөгжсөн дагуул



тосгон болгон хөгжүүлнэ. Нутаг дэвсгэрийг 1000.0 га, хүн амын дундаж нягтрал 0.5 хүн/га /2040 онд 2 хүн/га/ болно.

### ХОТОНТ ТОСГОНЫ ТӨВИЙН ОРЧНЫ НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



48 дугаар зураг

Хөгжлийн чиг хандлагаар тус тосгоны хүн амын өсөлтийг Шинэ хот, бүсийн нутаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг суурьших нөхцлийг бүрдүүлэх замаар суурьшлын бүсүүд төлөвлөнө.

Тус тосгон нь мах боловсруулах үйлдвэр, нүүрс, барилгын материалын эрдэс түүхийн эдийн нөөцтэй, дэд бүтцийн харьцангуй сайн хөгжсөн байхаар тооцож үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлнэ. Үүнд:

- Тээвэр ложистик
- Бөөний худалдаа
- Хүнс хөнгөн үйлдвэрлэл
- Хүнд үйлдвэрлэл



- **Малын түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл**
- **Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл**
- **Тэсрэх аюултай бодисын агуулах**
- **Барилгын материалын үйлдвэрлэл**
- **Төрөл бүрийн үйлдвэрлэлийн чиглэл бүхий жижиг дунд үйлдвэрүүд**
- **Фермерийн аж ахуй**
- **Хүнс ногооны агуулах, зоорь**

Шинэ хот, бүсийн бусад хот, тосгодтой засмал зам төмөр замаар холбогдог авто тээврийн нэгдсэн вокзал, терминаль авто тээврийн зангилаа болж хөгжинө.

**Бат-Өлзийт тосгоны дэд төв.** Шинэ хотын, хөгжлийн чиг хандлагаар энэ төвийг 12 орчим мянган хүн амтай дүүргийн төв, үйлдвэрлэл худалдаа хөгжсөн дагуул тосгон болгон хөгжүүлнэ. Нутаг дэвсгэрийг 800.0 га, хүн амын дундаж нягтрал 0.5 хүн/га /2040 онд 2 хүн/га/ болно.

Хөгжлийн чиг хандлагаар тус тосгоны хүн амын өсөлтийг Шинэ хот, бүсийн нутаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг (төлөвлөлтийн үндсэн зарчим 49 дүгээр зураг) суурьших нөхцлийг бүрдүүлэх замаар суурьшлын бүсүүд төлөвлөнө.

Тус тосгон нь мах боловсруулах үйлдвэр, нүүрс, барилгын материалын эрдэс түүхийн эдийн нөөцтэй, дэд бүтцийн харьцангуй сайн хөгжсөн байхаар тооцож үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлнэ. Үүнд:

- **Тээвэр ложистик**
- **Бөөний худалдаа**
- **Хүнс хөнгөн үйлдвэрлэл**
- **Хүнд үйлдвэрлэл**
- **Малын түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл**
- **Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл**
- **Тэсрэх аюултай бодисын агуулах**






- Барилгын материалын үйлдвэрлэл
- Төрөл бүрийн үйлдвэрлэлийн чиглэл бүхий жижиг дунд үйлдвэрүүд
- Фермерийн аж ахуй
- Хүнс ногооны агуулах, зоорь

Шинэ хот, бүсийн бусад хот, тосгодтой засмал зам төмөр замаар холбогдог авто тээврийн нэгдсэн вокзал, терминаль автотээврийн зангилаа болж хөгжинө. Тус тосгонд хүнд үйлдвэрлэлийн салбарыг Шинэ хотод аль болхоор байлгахгүй байх бодлого баримтална.

### БАТ-ӨЛЗИЙТ ТОСГОНЫ НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



49 дүгээр зураг

**Хужирт тосгон.** Шинэ хотын, хөгжлийн чиг хандлагаар энэ тосгоныг 30 орчим мянган хүн амтай дүүргийн төв, үйлдвэрлэл худалдаа эмчилгээ сувилгаа хөгжсөн дагуул тосгон болгон хөгжүүлнэ. Нутаг дэвсгэрийг 1500.0 га, хүн амын дундаж нягтрал 0.5 хүн/га /2040 онд 2 хүн/га/ болно.



Хөгжлийн чиг хандлагаар тус тосгоны (төлөвлөлтийн үндсэн зарчим 50 дугаар зураг) хүн амын өсөлтийг Шинэ хот, бүсийн нутаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийг суурьших нөхцлийг бүрдүүлэх замаар суурьшлын бүсүүд төлөвлөнө.

Тус тосгон нь мах боловсруулах үйлдвэр, нүүрс, барилгын материалын эрдэс түүхийн эдийн нөөцтэй, дэд бүтцийн харьцангуй сайн хөгжсөн байхаар тооцож үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлнэ. Үүнд:


- **Эмнэлэг сувилалын цогцолбор**
- **Тээвэр ложистик**
- **Бөөний худалдаа**
- **Хүнс хөнгөн үйлдвэрлэл**
- **Хүнд үйлдвэрлэл**
- **Малын түүхий эдийн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл**
- **Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэл**
- **Тэсрэх аюултай бодисын агуулах**
- **Барилгын материалын үйлдвэрлэл**
- **Төрөл бүрийн үйлдвэрлэлийн чиглэл бүхий жижиг дунд үйлдвэрүүд**
- **Фермерийн аж ахуй**
- **Хүнс ногооны агуулах, зоорь**

Шинэ хот, бүсийн бусад хот, тосгодтой засмал зам төмөр замаар холбогдог авто тээврийн нэгдсэн вокзал, терминаль автотээврийн зангилаа болж хөгжинө. Үйлдвэрлэлийн салбарыг Шинэ хотод аль болхоор байлгахгүй байх бодлого баримтална.

**Хар хорин хот.** Энэхүү төсөлд Хархорин хотыг аялал жуулчлалын хот болгон хөгжүүлэхээр төлөвлөв. Хархорин хотыг Хужирт, Бат-Өлзийт, Хотонт, Хашаат, Өгийнуур сумдтай хоршуулан аялал жуулчлалын нэгдсэн систем маягаар хөгжүүлнэ.



## ХУЖИРТ ТОСГОНЫ НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



50 дугаар зураг

Иймд шинэ хот байгуулахтай уялдуулан Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт газрын болон Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хүрээнд, Дэлхийн өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын нутаг дэвсгэрт аялал жуулчлал хөгжүүлэх, Хүрээлэн буй орчны орчныг нь хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бэхжүүлэх, түүх, соёлын дурсгалуудын хадгалалт, хамгааллыг сайжруулах, зарим түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсийг тогтоон баталгаажуулах, нүүдлийн соёлын үнэт зүйлсийг хадгалан хамгаалж, нүүдлийн соёлын зан үйлийг сэргээх арга хэмжээ авахаар тооцож байна.

Хархорин орчмын бүс нутаг нь UNESCO-ийн Дэлхийн-Өвд бүртгэсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, хангайн нурууны байгалийн цогцолбор газар зэрэг олон төрлийн тусгай хамгаалалттай газрын огтлол дээр байрладаг.

Энэ бүс нутагт багтах Улаан цутгалан, Төвхөн хийд, Хөшөө цайдам, Өгийнуур, Хар балгас, Хархорин хотын туурь, Эрдэнэзуу (төлөвлөлтийн үндсэн зарчим 51 дүгээр зураг) хийд, Хужиртын халуун рашаан, Хятрууны халуун рашаан



, Шанхын баруун хүрээ хийд, Орхон гол зэрэг гадаад, дотоодын аялал жуулчлалын үндсэн бүрэлдэхүүн бүс болгон цогцоор нь хөгжүүлнэ.

Хархорин орчмын энэ үзэсгэлэнт нутаг дэвсгэр нь хүн төрөлхтөний түүхэн дэх соёл иргэншлийн үүслийн нэг зангилаа төв нь байсан бөгөөд иймд төв Азийн нүүдэлчдийн өлгий болох Хархорин бүс нутгийг Орхоны хөндийн соёлын биет өвийн, түүхэн үе үеийн бүхий л дурсгалуудыг цогцолбороор нь хамгаалж, сэргээн босгож, соёлын биет бус өвийг уламжлан хадгалсны үндсэн дээр олон улсын жуулчид сонирхон зорьж ирэх газар болгон хөгжүүлнэ.

Хархорин, Эрдэнэзуу хот орчмыг байгальд ээлтэй, оюуны багтаамж өндөртэй үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн, нүүдлийн соёлын өв уламжлалыг орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулан хөгжсөн Монгол үндэсний өвөрмөц дүр төрх бүхий жуулчдын төв бүс нутаг болгох асуудлыг Шинэ хотын бодлоготой уялдуулан авч үзлээ.


Хархорин аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, хот суурингуудийг хөгжүүлэх зорилтын хүрээнд, Хархорин хотын орон зайг шинэчлэн хөгжүүлэх аялал жуулчлалын болон байгаль-экологи, өв соёлын хамгаалалтын бүсийг тодорхой гаргаж Монгол үндэсний өвөрмөц дүр төрх бүхий хот, суурин болгон хөгжүүлэх арга хэмжээ авна. Үүний тулд Хархорин бүсийн түүх соёлын дурсгалт газрууд, байгалийн үзэсгэлэнт газруудыг сэргээн засварлах, тохижуулах, түүх. Соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулах, үзмэр, үзүүлбэр бий болгох, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын амьд тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хархорин хотод аялал жуулчин, зочдыг хүлээн авах төв, зочид буудлын цогцолбор, олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулах, аялал жуулчлалын үндсэн маршрутын болон туслах маршрутын дагуух замуудыг сайжруулах, зам дагуу барилгажуулах болон аялал жуулчлалын хослох бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх талаар дэмжин хөгжүүлнэ.





## ХАРХОРИН ХОТЫН НУТАГ ДЭВСГЭР ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



51 дүгээр зураг

**III.1.7 Хотын тээврийн хэтийн нөхцөл байдал.** Шинэ хотын тээврийн нийт эрэлт нь явган зорчилтыг оруулан тооцоход 3,6 сая зорчилт байгаа ба явган зорчилтыг хасаж тооцоход 2,3 зорчилт байна. Харин “зорчилтын хувь” буюу нэг хүний өдөрт хийх зорчилтын тоо нь явган зорчигчдыг оруулж тооцоход 4,3 ба явган зорчигчдыг хасаж тооцоход 2,7 байна. үүнээс үзэхэд зорчилтын хувь нь бусад хотуудтай харьцуулахад харьцангуй их байна. Шинэ Хотын оршин суугчдын зорчилтын хувь их байгаа шалтгааныг оновчтой тодорхойлох боломжгүй боловч энэ нь нэг талаас нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан нөгөө талаас газар ашиглалт, нийтийн үйлчилгээний байршлын бүтцээс шалтгаалан хэрэгцээт үйлчилгээндээ хүрэхийн тулд илүү зорчилт хийх шаардлага үүсгэж байгаатай холбоотой гэж тооцож байна.



Хотын нийт тээврийн эрэлтийн арай их хувийг явган зорчилт, дараагийхийг авто машин, такси харин багавтар хэсгийг, автобус, бусад төрөл эзэлж байна харин явган зорчилтыг оруулахгүй тохиолдолд нь авто машин, арай их такси, дунд зэрэг автобус болон бусад тээврийн хэрэгсэл багавтар хувийг эзлэнэ. Бусад тээврийн хэрэгсэл гэдэг төрлийн сонголтын шинж чанаруудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хувьдаа тээврийн хэрэгсэлгүй, авто машингүй хүмүүсийн хувьд такси болон нийтийн тээврийн төрлийг голчлон сонгоно.
- Авто машин эзэмшдэг өрхүүдтэй харьцуулахад хувьдаа тээврийн хэрэгсэлгүй авто машингүй иргэд явган явдаг зорчигчид давамгайлна.
- Авто машинтай өрөх бараг бүгд авто машинаар хөдөлгөөнд оролцдог ба харин энэ үзүүлэлт хувийн авто машингүй өрхийн хувьд харьцангуй бага байна. Авто машингүй боловч автомашинаар хөдөлгөөнд оролцогчид тодорхой хувийг эзлэх ёстой.
- Нийтийн тээврийн хэрэглээ нийт өрхийн хувьд өндөр байна. Автомашингүй хүмүүсийн нийтийн тээврийн хэрэглээ өндөр харин автомашинтай хүмүүсийн нийтийн тээврийн хэрэглээ мөн тодорхой хувиар байх ёстой.
- Дугуй, мотоцикл ашиглах, байгууллагын болон сургуулийн автобус зэрэг хувийн автобусаар үйлчлүүлэх явдал мөн зохих хэмжээгээр гэхдээ түгээмэл биш байна.
- Таксигаар зорчих нь бүх өрхүүдийн хувьд түгээмэл байдаг.
- Зорчилтын зорилгоос хамаарч иргэдийн тээврийн хэрэгслийн төрлийн хэрэглээ өөр өөр байна. Иргэд ажилдаа явахдаа авто машин гол хэрэглээ нь болдог бол хүүхдүүд сургуульдаа явах зорчилтын тухайд автобус, явган бусад төрлийн автомашинаар зонхилон зорчино гэж тооцож байна.
- Өглөө 7:00-8:00, өдөр 12:00-13:00, орой 17:00-18:00 цагийн хоронд хөдөлгөөний оргил ачааллын үе байна гэж тооцлоо.



**Шинэ хотын гудамж, замын сүлжээний төлөвлөлт.** Шинэ хотын гудамж замын сүлжээ нь хотын нутаг дэвсгэрийн үүргийн бүсүүдийн хоорондын уялдаа, тэдгээрийн харилцан таталцлын үндсэн тэнхлэг болж, орон зайн зохион байгуулалтын нэгдсэн системийг үүсгэсэн цогц систем байхаар тооцож, улмаар хот, дагуул тосгоны орон зайн тогтолцоо, хүн амын өсөлт, дугуйтай болон явган зорчигч, тээврийн хөдөлгөөний эрчим, зэрэгтэй нягт уялдсан байна.

Шинэ хотын гудамж, замын сүлжээ нь замыг бүрдүүлэгч үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, дугуйн зам, хөдөлгөөн тусгаарлах зурвас, (төлөвлөлтийн үндсэн зарчим 52 дугаар зураг) аюулгүйн тойрог, ногоон байгууламж, тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарц, газар доорхи инженерийн байгууламж, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламжийн бүрдэлтэй байна.

Хотын авто тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдыг тусгаарлах, аюулгүй байдлын үүднээс нэвт өнгөрөх тээврийн хөдөлгөөнийг суурьшлын бүсээс тусгаарлахад замын шаталсан тогтолцоо чухал ач холбогдолтой гэж тооцлоо. Хотын үндсэн тэнхлэгийн авто замууд /22м орчим өргөн/ суурьшлын бүсийг багтаасан хүрээг үүсгэх бөгөөд энэ орон зайгаар нэвт өнгөрөх тээврийн хэрэгслүүд зорчино. Суурьшлын бүс дотор гол замаас салаалсан замууд /12м орчим өргөн/ болон явган зорчигчидод зориулсан холбоос зам/хамгийн бага нь 6м өргөн/-ийн сүлжээг байхаар төлөвлөв. Энэ замын өргөнийг тухайн барилгажуулах нутаг дэвсгэрийн хэмжээ болон газар ашиглалттай нь уялдуулан тогтооно.

Хотын авто замын сүлжээг шийдэхдээ дэд бүтцийн төлөвлөлттэй уялдуулаж зам болон дэд бүтцийн нэгдмэл байдлыг хангах шаардлагатай. Хотын замын сүлжээтэй хамтатган ус хангамж, ариутгах татуурга, дулааны шугам зэрэг дэд бүтэц, нийтийн аж ахуйн байгууламжийг газар доогуур байгуулна.

Гудамж замын сүлжээ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, иргэд богино хугацаанд хүрэх газраа тохь тухтай зорчиж хүрэх шаардлагад нийцсэн байна. Харин орон зайн хувьд суурьшлын бүсээс хотын



нэгдсэн үйлчилгээний төв хүртэл нийтийн тээврийн хэрэгслээр зорчих гол үйлчилгээний хугацаа 30 минут, байхаар тооцно.

Шинэ хотын гадна тээврийн замын сүлжээг бүрдүүлэгч төмөр зам, авто зам, агаарын тээврийн зорчигчдын буудал нь хотын төв, суурьшлын болон үйлдвэрийн бүстэй тээврийн нэгдсэн сүлжээгээр холбогдоно.

Хотын төмөр замын ачаа тээш ангилж, ялган хуваарилах станцыг хотын дэвсгэр нутгийн гадна байрлуулахаар тооцов. Харин төмөр замын болон авто замын тээврийн зорчигчдын техникийн станц, нөөц хөдөлгүүрийн парк, ачаа тээшийн станц, чингэлэгийн талбайг суурьшлын бүсийн ойролцоо гаднах талбайд байршуулна.

Орон сууцны хорооллын эдэлбэр газраас төмөр зам хүртэлх ариун цэврийн хамгаалалтын бүсийн 60 хүртэл хувь нь зүлэгжсэн байна.

Шинэ хотын гудамж замын сүлжээг, тээврийн хэрэгслэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөний эрчимжилт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, архитектуртай нь уялдуулан хотын орон зайд нэгдсэн систем байхаар тооцлоо. Гол гудамж, замын зорчих хэсгийн ирмэгээс барилгажилт хүртэлх зай 50 м-ээс багагүй байна.






Хотын гудамж замыг дотор нь I, II III зэрэглэлийн гэж ангилан, I зэрэглэлийн гол гудамж, замыг хотын төв, томоохон үйлдвэрийн газар зэрэг хүн амын хөдөлгөөн ихтэй орчин болон хотын төвийн замтай уялдуулан авч үзлээ. Харин II зэрэглэлийн гол гудамж зам нь бусад замтай огтлолцсон зам байхаар тооцлоо.





ХОТЫН ГУДАМЖ ЗАМЫН СҮЛЖЭЭ М1:25000

Зураг 52





Барилга байгууламжийг зонхилон хотын гол гудамж, замын дагуу байрлуулах бөгөөд эдгээрийн тээврийн үйлчилгээнд зориулж хоёр урсгалтай зам төлөвлөв. Мөн II зэрэглэлийн гол гудамж, замын дагуу дугуйтай хүн зорчих тусгай зурвас зам байхаар тооцлоо.

Барилгажих орчны гол гудамж, замын нэг түвшинд байх явган хүний гарцын хоорондын зай 200м-ээс багагүй, харин өөр өөр төвшин дэх явган хүний гарцын хоорондын зай хурдны зам, төмөр замд 400м-ээс багагүй, I зэрэглэлийн гол гудамж, замд энэ зай 300м-ээс багагүй зайтай байна.

**Хотын нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн гудамж, замын сүлжээний төлөвлөлт.** Шинэ хотын дотор орон зайд нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын буудлын  $1\text{м}^2$  талбайд 4 хүн, хот хоорондын хурдан тээврийн хэрэгслээр зорчигчдын буудлын  $1\text{м}^2$  талбайд 3 хүн ногдохоор тус тус тооцож гудамж, замын нэвтрүүлэх чадвар хязгаарлагдмал хэсэгт нь давхар зам буюу газрын түвшнээс доогуур хонгилон замтай байхаар төсөлд тусгалаа.

Хотын үүргийн бүсүүдийн нутаг дэвсгэрийн нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн гудамж, замын нягтралыг зорчигч тээврийн эргэлтийн эрчимжилт, ашиглалтын ажиллагаатай нь уялдуулан тооцов. Гэхдээ нягтралын хязгаар  $1,5\text{ км/км}^2$  –аас багагүй байна. Харин суурьшлын нягтрал өндөртэй нутаг дэвсгэрт энэ хэмжээг  $4,5\text{ км/км}^2$  хүртэл нэмэгдүүлэхээр төсөлд тусгав. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн буудал хүртэл явганаар хүрэлцэн очих зайг 300м-ээс багагүй байна. Харин энэ зай хотын (төлөвлөлтийн үндсэн зарчим 53 дугаар зураг) төвийн олон хүн цуглардаг объектоос 300м-ээс ихгүй, олон нийтийн амралт ба биеийн тамир, спортын бүсэд 800м-ээс ихгүй, үйлдвэр аж ахуйн ба нийтийн агуулахын бүсэд 400м-ээс ихгүй байхаар орон зайн төлөвлөлттэй байна.

Шинэ хот байгуулагдсанаар хотжилтын үйл явц эрчимтэй явагдна гэж үзэн тээврийн хэрэгцээ өсөн нэмэгдэхээр тооцлоо. Шинэ хотын хүн амын тоо өнөөгийн Улаанбаатарын хүн амын тоотой ойролцоо боловч хотын нийт орлог 2 дахин, автомашин эзэмшигч эзлэх өрхийн эзлэх хувь одоогийнхоос 20-25% өсөх төлөвтэй



байгаа нь тооцоот судалгаагаар мэдрэгдэж байна. Хотын эдийн засгийн бүтэц, хүмүүсийн амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орхоор байна. Тээврийн салбарч ийм динамик өөрчлөлтөд дасан зохицож, хотын нийгэм эдийн засгийн байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах шаардлага гарч байна.

Тэр үед хотын тогтвортой өсөлт хөгжилд тээврийн үзүүлэх нөлөө өндөр байх тул Шинэ хотын тээвэр гудамж замын сүлжээг ойрын болон урт хугацааны зорилтын хүрээнд хөгжүүлэхээр тооцов.

**Хотын тээврийн хөгжлийн зорилт.** Шинэ хотын хөгжлийн чиг хандлагаар байгаль орчинд ээлтэй, нягт суурьшилтай орчин үеийн гэхдээ үндэсний хот болох зорилтын хүрээнд хөгжинө. Иймээс энэ зорилгыг хангах үүднээс хотжилттой, тээврийн салбарыг уялдуулан хөгжүүлэхээр тооцлоо. Тухайлбал:

- Нийтийн тээвэрт тулгуурласан хотын хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадвар бүхий нийтийн тээврийн тогтолцоог бүрдүүлэх
- Автомашины хэрэгцээг үр дүнтэй болгох
- Чанартай тээврийн дэд бүтцийг бий болгох: Авто зам нь хотын тээврийн үйлчилгээний үндсэн гол орон зайг эзлэх тул чанар сайтай авто замыг иж бүрнээр нь явган зам, ногоон байгууламжийн хамт барьж байгуулах.
- Бүс нутгийн, хотын тээвэр болон авто зам, төмөр зам, агаарын тээврийн хоорондын үр ашигтай холбоог хөгжүүлэх:
- Хотын тээврийн хөгжил, менежментийг боловсронгуй болгож хөгжүүлэх оновчтой бүтцийг бий болгох.


**Хотын автозамын төлөвлөлт.** Өнөөдрийн байдлаар Монгол улсын нийт замын сүлжээний урт 67170 км, үүнээс 14150 км нь улсын чанартай, зам байна. Зэрэгцээх аймаг хот дагуул хот суурингуудыг хоттой холбосон авто замын сүлжээг 1.2.3 дугаар зэрэглэлийн хурдны замуудаар холбоно. Мөн хотыг шинэ





нисэх онгоцны буудалтай холбох гол замтай байна. Хурдын замын нэвтрүүлэх хүчин чадал нь дээд зэрэглэлийн байна.

### ХОТЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОГСООЛЫГ ТӨЛӨВЛӨХ ҮНДСЭН ЗАРЧИМ



53 дугаар зураг

Шинэ хотын дагуул хот суурингуудыг хооронд нь хатуу хучилттай авто замаар холбоно. Замууд нь бие даасан байдлыг нэмэгдүүлж, зорчигч, ачаа тээврийн урсгалыг хурдан шуурхай болгох шаардлагад нийцсэн байна.

Эдгээр хот тосгодыг холбосон авто замын ангилал зэрэглэлийг тогтоож хотын хүрээлэлээр гарсан хурдны замыг хотын замтай паралель байхаар тооцсон болно. Шинэ хотыг дагуул хот, тосгодтой метро болон нийтийн тээврийн сүлжээгээр холбоно. Хотын төвүүдэд орчин үеийн авто вокзал, ачаа тээврийн шинэ технологи бүхий ложистик төв болон терминалуудыг байгуулна.

Шинэ хотын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, ачааллыг зохицуулж






сарниулах, гудамж замын нэвтрүүлэх чадварыг өнөөгийн Улаанбаатартай харьцуулахад нэмэгдүүлэх, шаардлагатай гэж тооцлоо.

Шинэ хотын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох ажлын хүрээнд гудамж замын сүлжээний нягтралыг эрс сайжруулж, гудамж замын уртыг 70000 км болгож нэгдсэн цогц хотын гудамж замын сүлжээг бий болгохоор төлөвлөлтөнд тусгасан болно.

Хотын замын бүтэц хурдны зам, 1-р зэргийн гол зам, 2-р зэргийн гол зам, 1-р зэргийн туслах зам, 2-р зэргийн туслах замуудаас бүрдэх бөгөөд үүнтэй хамт автомашины гүүрэн гарц, олон давхар уулзвар, автомашины нүхэн гарц, явган хүний нүхэн гарц, автомашины зогсоол зэрэг элементүүдээс бүрднэ. Хотод байх авто замуудын төрөл хэв шинж бүтцийг (төлөвлөлтийн үндэслэл 54, 55, дугаар зурагт) үзүүлэв.

### ХОТЫН ДОТОРХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТ



54 дүгээр зураг



Төслөөр шинэ хотын гудамж замын төлөвлөлтийг хэвтээ чиглэл, төвийн хэсэгт цагираг, босоо чиглэлд хотын урд хойд хэсгийг холбосон гол гудамж зам, бусад хэсгүүдэд туслах гудамж зам байхаар тооцоолж байна. Хотын баруун, урд хэсгүүдэд улс, хотын чанартай босоо болон хэвтээ чиглэлийн хурдны автозамууд байна.

Шинэ хотын гудамж замын сүлжээ нь хотыг нийтэд нь боловсронгуй хатуу хучилттай гудамж замаар холбосон тогтолцоог бий болгоно.

**Хотын гудамж замын ангилал.** Хотын гудамж замыг гүйцэтгэх үүрэг, зориулалтаар нь мөрдөгдөж буй хот төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу дараах байдлаар 4 ангилна. Үүнд:

- Хотын чанартай хурдны зам
- Гол гудамж зам
- Туслах гудамж зам
- Нутаг дэвсгэрийн зам

Шинээр төлөвлөж буй гудамж замын эгнээний өргөнийг хурдны , гол гудамж замуудад 3,75м, туслах, нутаг дэвсгэрийн замуудад 3,50 м байхаар төлөвлөв. Эгнээний тоог нормативын хүрээнд тооцов.


**Гудамж замын уулзвар.** Шинэ хотын гудамж замын уулзваруудыг нэг түвшингийн зохицуулалттай, (төлөвлөлтийн үндсэн зарчим 56 дугаар зураг) олон түвшингийн огтлолцлолтой гэж үндсэн хоёр ангилж төлөвлөсөн болно.

**Нэг түвшингийн уулзвар.** Нэг түвшингийн уулзваруудыг гол төлөв 2-р зэргийн гол замыг туслах гудамж замуудтай, туслах гудамж замуудын хоорондох огтлолцлолыг нэг түвшинд, зохицуулалттай /гэрлэн дохиолол/ болон зохицуулалтгүй хэлбэрээр төлөвлөв.




### ХОТЫН ГУДАМЖ ЗАМЫН ТӨРӨЛ, ХЭВ ШИНЖ


**Хотын гол гудамж**  
1-р зэрэглэл, 2 урсгалтай 8 эгнээ зам  
Огтлол 1-1




**Хотын гол гудамж**  
2-р зэрэглэл, 2 урсгалтай 6 эгнээ гол зам  
Огтлол 2-2




**Хотын туслах гудамж**  
1-р зэрэглэл, 2 урсгалтай 6 эгнээ зам  
Огтлол 3-3



**Хотын туслах гудамж**  
2-р зэрэглэл, 2 урсгалтай 4 эгнээ зам  
Огтлол 4-4



**Сууцны хороололын гудамж**  
2 урсгалтай 4 эгнээ зам  
Огтлол 5-5



**Хурдны болон хот хоорондын зам**  
2 урсгалтай 6 эгнээ зам  
Огтлол 6-6





*Олон түвшингийн уулзвар.* Хотын гудамж замын сүлжээний шаардлагатай хэсгүүдэд, гудамж замын ангиллаас хамаарч хурдны зам, 1-р зэргийн гол замуудадын тооцоо судалааг үндэслэн төмөр замтай огтлолцож буй замын олон түвшний уулзваруудыг байрлал, зориулалтаас нь хамааруулж зангилаа, гүүрэн болон туннель бүхий олон түвшний огтлолцолуудтай байхаар төлөвлөж байна. Гудамж замын төмөр замтай огтлолцох хэсгүүдэд зонхилон туннель төлөвлөнө.

**ХОТЫН ГУДАМ, ЗАМЫН УУЛЗВАРУУДЫГ  
ТӨЛӨВЛӨСӨН ҮНДСЭН ЗАРЧИМ**

I-I	I-I	I-II	II-II	II-II	III-III	II-II	IV-IV
4600-5000	4200-5000	4200-4600	2800-4200	3800-4200	1400-2800	3600-3800	800-1400
3000-3000	3000-3000	3000-3000	2000-3000	3000-3000	800-2000	3000-3000	400-800
800-1200	600-1200	600-800	400-600	400-600	300-400	300-400	200-300

56 дугаар зураг

Мөн замын хөдөлгөөний ачаалал ихтэй цэгүүдэд /худалдаа үйлчилгээ төвлөрсөн хэсгүүдэд/ явган хүний гүүрэн болон нүхэн гарцууд төлөвлөв.

**Авто зогсоол.** Шинэ хотод тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж , авто зогсоол ихээхэн шаардлагатай болно гэж үзэж байна. Иймд хөгжлийн чиг хандлагад нэгж хорооллууд, хотын төв, дэд төвүүд, олон нийтийн төвүүд болон хүн амын төвлөрөл ихтэй газруудад газар доор, ил, олон давхар зогсоолуудыг олноор төлөвлөх нь зүйтэй гэж үзлээ.





**Ил авто зогсоол.** Шинээр төлөвлөгдөж байгаа хотын замын дагуу орон сууц, худалдаа, үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламжийн ойролцоо, төлөвлөлтийн норм, стандартын дагуу ил зогсоолууд байршуулна.

**Газар доорх авто зогсоол.** Шинээр баригдах олон нийт, үйлчилгээний барилга байгууламжууд, орон сууцны хорооллуудын нийтийн эзэмшлийн зам талбайн газар доорхи орон зайд нэгдсэн авто зогсоолуудыг төлөвлөнө.

**Газар дээрх давхар зогсоол.** Олон давхар барилгад байрлах гараж нь 2 ба түүнээс дээш давхар орчин үеийн шаардлага норм дүрэмд нийцсэн барилга байгууламж байх ба байршлын онцлогоос шалтгаалж уг барилгад цахилгаан шаттай, замтай, өргөдөг тавцантай тэр нь механик ажиллагаа бүхий техникийн шийдэлтэй байна.

**Хотын нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлт.** Хотын нийтийн тээврийн иж бүрэн хөгжил. Иргэдийг хэрэгцээтэй үйлчилгээнд нь хүргэх, бараа тээвэрлэлтийг саадгүй явуулах боломжоор хангах үүднээс хотын өрсөлдөх, өөрийгөө тэтгэх чадварыг бүрдүүлдэг тул тээвэр хотын амьдралын амин чухал хэсэг нь болно гэж тооцлоо. Тиймээс бидний төлөвлөж буй хотын тээвэр, хотын нийгэм эдийн засгийн үйл ажиллагаа, амьдралын чанарт чухал нөлөөтэй нь тодорхой. Туршлагаас харахад хотжилтын явцад тээвэр ба газар ашиглалтын хоорондын харилцан нөлөөллөөр дамжин хот бүрэлдэх үйл явц, хотын өсөлт хөгжилтэй тээвэр нягт холбоотой нь харагдаж байна. Иймд хотын тогтвортой өсөлт хөгжилд тээврийн үзүүлэх нөлөөг урт болон ойрын хугацааны хэмжүүрийн аль алианаар нь авч үзэх шаардлагатай гэж бид үзлээ.

Хотын тээвэрлэлтийн чанарыг дараах гурван үзүүлэлтээр тодорхойллоо. Үүнд: 1. Дэд бүтцийн хангамж, 2. Дэд бүтцийн менежмент ба засвар арчлалт, 3. Дэд бүтцийг ашиглах талаарх иргэдийн ойлголт байдаг. Өнөөдрийн манай том хотуудад эдгээр гурван хүчин зүйлсийн аль аль нь асуудалтай байгаагаас замын хөдөлгөөний түгжрэл, зам тээврийн осол, агаарын бохирдол, нийтийн тээврийн чанар хангалтгүй, явганаар зорчих нөхцөл муу, тээврийн хүртээмж хангалтгүй, авто зогсоолын хүндрэл зэрэг ноцтой асуудлыг үүсгэж байна. Иймд шинэ хотын



төлөвлөлтөд иж бүрнээр, олон талаас нь авч үзэн маргаантай асуудлуудыг шийдвэрлэх гэж оролдлоо.

Шинэ хотын хүн амын тоо одоогийн нийслэлтэй адил боловч авто машин эзэмшигч өрхийн эзлэх хувь одоогийн 20%-иас 40% болж өсөх төлөвтэй байна. Хотын эдийн засгийн бүтэц, хүмүүсийн амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орох хандлагатай байна. Иймд шинэ хотын тээврийн салбар энэхүү динамик өөрчлөлтөд зохицож, хотын нийгэм эдийн засгийн байдлыг тогтворжуулахад нөлөө үзүүлнэ гэж тооцлоо. Үүнд:

Авто зам бол хотын хэв шинжийг тодорхойлох анхдагч хүчин зүйл болохын зэрэгцээ газар ашиглалтад нөлөөлнө гэж тооцлоо. Хотын гол хэсгийг хамарсан баруун-зүүн чиглэлийн гол зам болон хойд-урд чиглэлийг холбох замууд нь авто зам, тээврийн терминалууд болон бусад байгууламжууд зэрэг нэмэлт дэд бүтцийг байгуулж нягт суурьшилтай цомхон зөв үйлчилгээний системийн үндэс суурь болж чадна гэж тооцож байна.

Хотын аж үйлдвэрийн бүс, нисэх буудлын орчим, захууд болон бусад суурьшлын бүсүүдэд ашиглалт муутай газар байхгүй байх, иймд тээврийг цогцоор хөгжүүлэх замаар хотын тээврийн нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг сайжруулах боломжийг эдгээр бүсүүд бий болгохоор тооцлоо.

Тээврийн хөгжилд авто зам хамгийн чухал хүчин зүйл байдаг тул авто замын асуудлыг зохистойгоор шийдэх нь чухал гэж үзлээ. Замын сүлжээнд өнөөг хүртэл олон саад тотгор оршсоор байгаа ба тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг чөлөөтэй нэвтрүүлэх, явган зорчигчдын аюлгүй байдлыг хангахад шаардлагатай байгууламжуудыг оновчтой байршуулна гэж үзлээ.

Авто замын засвар арчлалтыг зохистой шийдэж зорчиход аюултай бөгөөд тээвэр ашиглалтын зардлыг өндөрсгөж байга өнөөгийн дутагдлыг тооцож тусгалаа. Шинэ зам, гүүрэн гарцуудыг орон зайн зөв шийдэлтэй болгож замд ямар нэгэн саад тотгор байхгүй бахаар авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайн байхаар тооцлоо.



**Замын хөдөлгөөний менежментийг сайжруулах:** Хотын замын хөдөлгөөний менежментийг дөрвөлжин төлөвлөлтөөр хамгийн зөв шийдлээ. Ингэснээр тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдын аюулгүй зорчих боломжийг бүрдүүлж хөдөлгөөний түгжрэл, авто зогсоолын замбараагүй байдал гарахааргүй болсон болно.

Нийтийн тээврийн үйлчилгээний хөгжил: Нийтийн тээврийн үйлчилгээ чанарыг зохих түвшинд байхаар тооцож автобусны буудал хүртэлх зай хүрэхэд бэрхшээлтэй, удаан хүлээлгэдэг асуудал гарахааргүй болсон. Ингэснээр иргэдийн хувийн авто машин ашиглах асуудал энэ хотод багасна гэж үзэж байна.

Хотын ирээдүйн зам тээврийн хөдөлгөөний эрэлт өндөр байх болно. Зорчилтын тооны хувьд нийт эрэлт өнөөдрийн манай бодит байдлаас 2,0 дахин өснө. Ийнхүү өсөх боловч авто замын ачаалалд үзүүлэх нөлөө нь хавьгүй өндөр байна. Хотын хөдөлгөөний эрчим одоогийнхоос үзүүлэлтээрээ 3 дахин, зарцуулах цаг 5 дахин өндөр байх магадлал байгаа нь хөдөлгөөний эрчмийн дүн шинжилгээ харуулж байна. Энэ нь шинэ хотын тухайд зорчих дундаж хурд 2040 онд 80 км/цаг болно гэж тооцож байна.

Шинэ хотын өсөн нэмэгдэх эрэлтийг хотын нийтийн тээвэрт нөлөөлөх нөлөөлөлд нягтралтай газар ашиглалтын хэв шинж зонхилно гэж үзэж байна. Тухайлбал: “Нягт суурьшилтай дөрвөлжин төлөвлөлттэй хот”-ын хувилбараар хийсэн судалгаанаас үзэхэд хөдөлгөөний эрчмийн үзүүлэлтийн зарцуулах цаг 17%-иар сайжрах байдалтай харагдаж байна. Үүний үр дүнд зорчилтын дундаж хурд 18%-иар нэмэгдэнэ гэж тооцож байна.

Эдийн засгийн үзүүлэлтийн хувьд “Нягт суурьшилтай хот”-ын тээвэр ашиглалтын зардал, зорчих хугацааны зардлаас бүрддэг тээвэрлэлтийн зардал 12%-иар буурахаар байна.

Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн хувьд Ерөнхий урсгалаараа тэлэх хувилбартай үзүүлэлтээс “Нягт суурьшилтай хот”-ын хувилбар илүү дэвшилттэй буюу хотын бохирдлыг даруй 15%-иар буурууладаг тооцоо байдаг.



Хот нь өндөр хөгжсөн нийтийн тээвэр ашигласан хот байна. Нийтийн тээврийн хэрэгсэлд одоогийн ашиглагдаж буй автобус, троллейбус, такси зэргийг үргэлжлүүлэн ашиглах ба шинээр багтаамж ихтэй нийтийн тээвэр болох тусгай замын автобус, хөнгөн галт тэрэг, метро зэрэг техник хэрэгсэлийг өргөн ашиглана.

Шинэ хотын доторх нийтийн зорчигч тээвэрлэлтийг хамгийн орчин үеийн технологтой байхаар төлөвлөв. Шинэ хотыг бүсийн доторх бусад хот суурингуудтай нийтийн тээврийн сүлжээгээр холбоно.

Хотоос бүсийн доторх дагуул хаяа хот суурингууд руу оршин суугчдын үйлчилгээнд зориулан экспресс автобус, экспресс микроавтобус болон галт тэрэг зэрэг тээврийн хэрэгслүүдийг ашиглахаар тооцов. Нийтийн тээвэр нь тодорхой хугацаа давтамжтайгаар тасралтгүй үйлчилнэ.

Шинэ хотын баруун, зүүн орчинд хотын доторх нийтийн тээврийн сүлжээтэй холбогдсон нийтийн зорчигч тээврийн томоохон терминал, нийтийн тээврийн удирдлагын төв, бусад шаардлагатай дэд бүтцийн хамт ашиглагдна. Мөн хаяа, дагуул хот суурингуудад тээврийн үйлчилгээний терминалуудыг байгуулах ба тэдгээрийг хооронд нь болон Шинэ хоттой холбооны систем, мэдээллийн сүлжээгээр холбоно.

Шинэ хотын дагуул хот тосгон Өгийнуур Хашаат, Хархорин, Хужирт, Бат-Өлзийт, Хотонд гэх мэт хот суурингууд нь авто болон төмөр замын нийтийн тээврээр Шинэ хоттой холбогдоно.

Хотын орон зайн үйлчилгэнд нийтийн тээврийг хөгжүүлэх дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- Нийтийн тээврийн сүлжээний оновчтой шийдэлтэй байх,
- Нийтийн тээвэрт өндөр багтаамж ихтэй нийтийн тээврийн төрлийг өргөн нэвтрүүлэх,
- Нийтийн тээвэрт дэвшилтэт мэдээллийн технологийг нэвтрүүлэх,
- Өндөр менежменттэй нийтийн тээврийн байгууллагуудыг ажиллуулах,





- Хотын оршин суугч, иргэдийг хүссэн газартаа бүх л төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг ашиглан богино хугацаанд хурдан хүрэх нөхцлийг бүрдүүлэх,
- Замын хөдөлгөөний менежментийг сайжруулах, гудамж замын сүлжээг нэмэгдүүлэснээр нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг бууруулж шуурхай байдлыг хангах,

**Багтаамж ихтэй нийтийн тээвэр ашиглах.** Шинэ хотын замын сүлжээнд багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх бүрэн боломжтой. Нийтийн тээврийн үндсэн тэнхлэгийг хотын төвүүд бусад тэнхлэгүүдтэй нь холбоно. Шинээр нэвтрүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн төрлөөр тусгай замын автобус, төмөр замын хөнгөн тээвэрийг тооцдог. Иймд багтаамж ихтэй нийтийн тээврийг дараах чиглэлээр нэвтрүүлнэ.

- Хөнгөн галт тэрэгийг дагуул хот тосгод болох Өгийнуур, Хашаат, Хужирт, Хотонт, Хархорин, Бат-Өлзийтийн чиглэлд болон хотын босоо тэнхлэгүүдэд ашиглах,
- Багтаамж ихтэй тусгай замын автозамын автобусыг 22 чиглэлийн тэнхлэгт ашиглах,

Метро буюу хөнгөн гал тэрэгний тээвэрийг газар доогуур тавигдах хувилбараар тооцон төлөвлөж болно.


Шинэ хотыг тойруулан төмөр зам тавьж хотын дотор орон зайн болон дагуул хотуудтай холбосон галт тэрэгний, нийтийн тээврийн үйлчилгээг бий болгоно. Галт тэрэгний зогсоолуудыг дэд төвүүдэд байхаар төлөвлөнө.

**Хөдөлгөөний менежмент, хэтийн төлөвлөлт.** Шинэ хотын замын сүлжээг төлөвлөхдөө замын хөдөлгөөний бөглөрөл, түгжрэлийг арилгах. Хотын хүн ам олноор цуглардаг байгууллагууд хотын төвд төвлөрсөн, замын сүлжээний хүрэлцээ хангалтгүй байдлыг шийдэх замын нэвтрүүлэх чадварыг анхаарч үзэв.



Үүний тулд хөдөлгөөний хэтийн төлөвийг зөв тодорхойлох, хөдөлгөөний менежментийн бодлогыг автозамын үндсэн сүлжээг төлөвлөхөд харилцан уялдуулж, хотын хөгжлийн чиг хандлага, (төлөвлөлтийн загварчлал 57 дугаар зураг) ерөнхий төсөлд дараах байдлаар тусгасан болно. Үүнд:

- Хотын төв, дэд төвүүд хороолол, бичил хорооллын олон нийтийн төвүүдийг төлөвлөж тэдгээрийг хооронд нь хөдөлгөөний аюулгүй байдал, тасралтгүй урсгалыг бүрэн хангасан гудамж замын нэгдмэл сүлжээг бий болгох
- Хөдөлгөөний ачаалалыг нэвтрүүлэх чадвартай, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан төвийн хөдөлгөөнөөс тусгаарлагдсан хурдны авто зам төлөвлөх
- Хотын хөдөлгөөний хөгжлийн хэтийн төлөв, гудамж замын үндсэн сүлжээ, тухайн замаар нэвтрэх хөдөлгөөний ачааллыг тооцож уялдуулах
- Автомашины хувийн хэрэглээг аль болох тохиромжтой хэмжээнд байлгах, хэрэглээнээс зайлсхийх боломжийг бүрдүүлэхийн тулд нийтийн тээврийн үйлчилгээний хэрэглээг олон улсын жишигт нийцүүлэх
- Хэт их хөдөлгөөнийг бууруулах, хотын ложистикийн бодлого стратегийг бусад хөгжилтэй орны туршлагад тулгуурлан боловсруулах
- Хотын олон нийтийн төвүүдэд автозогсоолууд төлөвлөх, менежментийн бодлого боловсруулах, төлбөртэй авто зогсоолуудыг бий болгох.
- Шинээр төлөвлөгдөж буй олон нийтийн төвүүдэд автомашингүй бүс төлөвлөх, ингэснээр иргэдэд ая тухтай орчин бүрдүүлэх
- Хөдөлгөөнд оролцож буй авто машинуудыг ашиглалтын хугацаанаас шалтгаалах, татварын бодлого боловсруулж хэрэгжүүлэх



57 дугаар зураг

**Хотын гадна тээврийн сүлжээ.** Шинэ хот нь Монгол улсын эдийн засаг, улс төр нийгмийн гол төвүүдийн нэг болох тул хотын дотор болон дагуул хот суурингууд бүсийн тулгуур төв хотууд Монгол орны нийт нутаг дэвсгэрт болон дэлхийн зах зээлд хүргэх боломжтой тээврийн нэгдсэн сүлжээгээр холбогдоно. Эдгээр тээврийн сүлжээд нь агаарын зам, метро, төмөр зам, авто замууд багтана.

**Хотын төмөр замын тээвэр.** Төмөр замын нийт урт улсынхаа хүрээнд 2630 орчим км, байна Монгол улсын хойд-урд хилийг 4-5 чиглэлээр холбохоор тооцож төлөвлөсөн гол шугам бүр зэрэгцээ үндсэн 2 шугамаас бүрдэнэ. Төмөр зам нь 1,520 мм-н өргөн цариг дан замтай байх бөгөөд Монгол, Орос, Хятадын хооронд хийх тээвэрлэлтэд 8-10 боомтод ачаа шилжүүлэх шаардлагатай гэж тооцов. Төмөр замын гол шугамын нэвтрүүлэх чадварыг ачаа, зорчигч тээврийн ажилтай оновчтой уяалдулан тооцож төлөвлөсөн дагуул хот тосгодтой байх бөгөөд тэдгээр нь хоорондоо төмөр замаар холбогдоно.

Шинэ төмөр зам шинэ хотыг тойрон өнгөрөх 185 км-ийн урт төмөр зам байна. Шинэ замыг нисэх буудлаар дайран өнгөрүүлэхээр барьж байгуулна. Төмөр



замын депо болон буудлуудыг хотын баруун зүүн хойр талд барих бөгөөд энэ нь хотын доторхи замтайгаа нийлэх салах цэг болно.

Ирээдүйд ихээхэн өсөх хандлагатай байгаа ачаа тээврийн коридорыг шилжүүлэх нь туйлын чухал бөгөөд ялангуяа Хятад, Европын Холбоо (ЕХ) /ОХУ-ын хооронд хийх ачаа тээвэр мөн өсөх төлөвтэй байгаа нь хүн ам шигүү суурьшсан хот суурин газруудад тээврийн зөрчил үүсгэх, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтайг сайтар тооцлоо. Нөгөөтэйгүүр олон улс, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээний шугамуудыг зохистой байдлаар шийдэх алхам болж байгаа хэрэг.

Байнга өсөн нэмэгдэж буй экспорт, дамжин өнгөрөх ачааг сааталгүй шуурхай нэвтрүүлэх зорилгоор олон улсын ач холбогдол бүхий төмөр замын 3-4 шинэ шугам байгуулна. Энэ шугам нь Монгол Улсыг дэлхийн улс гүрэнтэй холбоно. Шинэ төмөр замыг гол шугамаас салаалуулж зэрэгцээх аймгын төв хотоор дамжин нэвтрэхээр төлөвлөлөө. Уг төмөр замын уртыг 6000 км байхаар тооцож байна.

Ирээдүйд ихээхэн нэмэгдэх хандлагатай байгаа ачаа тээврийн коридорыг Шинэ хотын дундуур гарахгүй байхаар тооцож Ази тив, Хятад, Европийн Холбоо, ОХУ-ын хооронд хийх ачаа тээврийг нэмэгдүүлэх аль болохоор хотын хүн амын аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөнөөс сэргийлсэн байхаар төлөвлөлтийг тооцлоо.

Шинэ төмөр зам байгуулснаар дараах хэд, хэдэн үр дүнг өгнө гэж тооцлоо.

Үүнд:

- Улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах, төмөр замын дэд бүтцийг сайжруулж, олон улсын тээврийн шинэ орц, гарц бүрдэх,
- Ашигт малтмал, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх, олон улсын зах зээлтэй холбох бололцоо нэмэгдэх.
- Орон нутгийн тээврийн харилцааг төмөр замаар бүрэн хангах.





- Шинэ хотын зам тээврийн ачааллыг хөнгөлж, замын түгжрэлийг арилгах, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах.
- Замын хөдөлгөөнөөс үүсэх гудамж замын хөдөлгөөний дуу чимээг арилгах иргэдийн амьдралын ая тухтай орчин бүрдэх нөхцлийг хангах,
- Хот дундуур тээвэрлэж буй аюултай ачаанаас үүсэх өнөөдрийн эрсдэл үгүй болох.
- Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах технологийн шийдэл нэвтрүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой байхаар тооцож байна.

**Ачаа тээврийн Ложистикийн төв. /Ачаа тээврийн терминаль / Шинэ хот, бүс нутгийн ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, хотын зам тээврийн ачааллыг бууруулах байгаль экологид хортой үйлдвэр аж ахуйн газруудыг Шинэ хотод аль болох барихгүй байх зэрэг нөхцөл шаардлагаас төмөр зам дагасан дагуул хот сууринг түшиглэн шинэ хэд хэдэн ложистикийн төвүүдийг Шинэ хотын баруун болон зүүн өмнө болон хойд орчинд байгуулна. Эдгээр ложистикийн төв буюу терминалиуд нь дараах зорилтуудыг шийдвэрлэнэ. Үүнд:**

- Шинэ хотод олон улсын тээвэр ложистикийн үйлчилгээнд холбогдсон иж бүрэн үйлчилгээтэй нэгдсэн терминаль, тээвэр агуулахын иж бүрэн цогцолбор болох.
- Олон улсын тээвэр ложистикийн үйлчилгээ явуулдаг, энэ төрлийн үйлчилгээг шууд болон шууд бусаар ашигладаг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зам харилцаа, тээвэрлэлттэй холбоотой орчин үеийн шинэ техник технологи, программ хангамж, хүний нөөц, удирдлага зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх боломжтой болгох.
- Аюултай, хортой, тээвэрлэлт, хадгалалтын онцгой горим шаардах, бараа бүтээгдэхүүнийг хүн амын төвлөрлөөс зайдуу, аюулгүй ажиллагааны шаардлага, технологийн дагуу хадгалах, тээвэрлэх нөхцөл бүрдүүлэх.



- Тээвэрлэлтийн зохион байгуулалт, технологи ажиллагааны үр ашгийг сайжруулах, тээвэр агуулахын цогцолборын орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглож ажиглалтын таатай нөхцөл бүрдүүлэх.
- Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн түгээлтийг Шинэ хотын гадна хийж, хотын доторх замд хүнд даацын автомашин, механнизмын хөдөлгөөнийг нэвтэрхээргүй байхаар тооцож, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.
- Шинэ хотын дагуул хот, суурингуудыг өөр хоорондын болон хотын төв, зэрэгцээх хот сууринтай авто замын сүлжээгээр холбох,

Шинэ хотын ачаа тээврийг хэрэгцээг хангасан, өргөн царигийн хос шугмыг холбогдох байгууламжийн хамт барихаар тооцов. Уг салаанаас хотын үйлдвэрийн район, шинэ ложижсткийн төвүүд рүү салаалж, хотын ачаа тээврийн хэрэгцээг хангана. Үйлдвэрийн бүсийн салаа төмөр замыг тавьснаар хотын дундуурх гол замаар, ачаа тээвэрлэлтийг зогсоож, зөвхөн зорчигч тээврийн зориулалтаар ашиглах боломжтой төмөр замын сүлжээ үүснэ.

Шинэ хотын дундуур гарч буй гол шугмыг хос болгож, олон улсын болон орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглахаар тооцов. Үүнтэй уялдуулан хотын төвүүдэд нормативт шаардлагын хүрээнд Төв вокзал, туслах өртөөнүүдийг байгуулж, орчин үеийн зорчигч тээврийн терминаль байхаар тооцоололт хийв.

**Шинэ хотын агаарын тээвэр.** Агаарын тээврийг хотын эдийн засаг, хүмүүсийн амьдралд чухал ач холбогдол бүхий нэг үндсэн төрөл гэж үзлээ. Улс орон хөгжин нээлттэй болохын хирээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн урсгал ихээхэн нэмэгдэж байна. Цаашид манай оронд, Шинээр байгуулагдах хотын бүсэд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлснээр жуулчны тоо нэмэгдэж, манай оронд ирэх зорчигч тээврийн урсгал нэмэгдэнэ энэ бүсийн тулгуур төв Шинэ хот эхний ээлжинд хамрагдана гэж тооцож байна. Одоогийн байдлаар гадаад дотоодын нислэгийг хэд хэдэн үндэсний аж ахуйн нэгжүүд гүйцэтгэж байна үүнийг улам өргөжүүлнэ.



Өнөөдрийн байдлаар манай орон ХБНГУ, Япон, Хятад, ОХУ, БНСУ дэлхийн таван улс руу шууд нислэг үйлдэж байгаа боловч аялал жуулчлал, бизнес, үйлдвэрлэл хөгжснөөр, агаарын зорчигч тээврийн урсгал нэмэгдэж цаашид шууд нислэгийн тоо дэлхийн олон улс оронтой шууд харьцах болж чиглэл нь өснө гэж тооцлоо.

Шинээр байгуулах хотын бүсийн 2040 оны хөгжлийн чиг хандлагаар Шинээр байгуулах хотын нутаг дэвсгэрт 2-оос доошгүй олон улсын ангиллын нисэх онгоцны буудалтай байхаар төлөвлөж байна.

**Шинэ хотын онгоцны буудал /Аэро сити/** Шинээр барих хотын төвөөс 80-90 км зайд олон улсын чанартай дээд зэрэглэлийн нисэх онгоцны буудал баригдана. Энэ онгоцны буудал нь Монгол улсын болон Шинэ хотыг гадаад дотоодтой холбосон гол орц, гарц болно. Шинээр баригдах олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн шинээр 6000.0 орчим мянган хүн амтай, 1000,0 га дэвсгэр нутагтай хот байгуулагдана. Тус хотын хүн амын дундаж нягтрал 20 хүн/га байна. Уг хот олон улсын нисэх онгоцны буудлын хэрэгцээг дагнан хариуцна.

Онгоцны энэ буудал нь шинээр төлөвлөгдөж буй хоттой зэрэгцэн хөгжинө. Шинээр бий болох хотын онгоцны буудал дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна.

- **Агаарын тээвэр түүнийг дагалдах иж бүрэн засвар үйлчилгээ**
- **Мэдээлэл технологи**
- **Худалдаа бизнес**
- **Ложистик**

Төлөвлөгдөж буй олон улсын нисэх буудлын хүчин чадал нь өнөөдөр Улаанбаатарт ашиглагдаж буй буудлаас 5 дахин их 5-10 минут дутамд нэг онгоц хүлээн авах чадалтай 3200 м урт хөөрөх, буух зурвастай, бусад шаардлага бүхий байгууламжтай, жилд 1,9 сая зорчигч хүлээн авах хүчин чадалтай байна гэдэгийг



дээр өгүүлсэн. Нисэх буудлыг түшиглэн бий болох хоттой төмөр зам, хурдны автозам, нийтийн тээврээр Шинэ хоттой холбогдоно.

**Хоны хоёрдугаар онгоцны буудал.** Шинээр байгуулах хоёрдугаар онгоцны буудал нь дотоодын нислэгийн үйл ажиллагааг хангахаас гадна олон улсын нислэгийн онгоц буух зурвастай тусгай зориулалт болон бизнес ангилал, ачаа тээвэр, сургалтын болон нисэхийн ачаа тээврийн терминалийн зориулалтаар Олон Улсын түвшинд ашиглах боломжтой байна.

Нисэх буудлуудын орчны талбайд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий барилга байгууламжтай сургалтын төв, офис, нисэх клуб, агуулахын байгууламж бүхий ачаа тээврийн терминалийг байгуулна.

**Нисэх буудлуудын терминал** Энэ хоёр Нисэх онгоцны буудлуудыг түшиглэн өндөр өртөгтэй, хувийн жин багатай, хурдан гэмтэх, богино хугацаанд хэрэглэгчид хүргэх бараа бүтээгдэхүүний тээвэрлэх нисэхийн терминалийг байгуулна.

Уг терминал нь дараах тээвэрлэлтийн технологи ажиллагаатай байна.

- Терминалд ачаа оруулах, зөөх
- Ачааны боловсруулалт хийх
- Илгээлтийн болон хүлээн авах терминалийн хооронд шугамын тээвэрлэлт гүйцэтгэх

Уг терминал нь ачаа хүлээн авах, илгээх, ачааг нисэх онгоцноос авто тээврийн хэрэгсэлд шилжүүлэх, уг ачааг тохируулах, ачиж буулгах үйлчилгээ, ачааг түр болон удаан хугацаар хадгалах, ачааг бүрдүүлэх, иж бүрдэл болгох, түгээх, сав баглаа боодлын үйлчилгээ, үйлчлүүлэгчид агуулах, талбай түрээслүүлэх, тээврийн болон ачааны явалтын мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээг үзүүлнэ.

Одоо ашиглагдаж буй Хархорин Хужиртын хуучин нисэх онгоцны буудлуудыг сэргээн засварлаж, зориулалтыг нь бизнес, үйлчилгээний зориулалт бүхий жижиг онгоцны нисэхийн үйлчилгээ үзүүлдэг буудал болгон хөгжүүлнэ.





**III.1.8 Хотын ногоон байгууламжийн төлөвлөлт.** Ногоон байгууламж нь хот суурины байгаль орчны чанар ба амьдрах орчныг дээшлүүлэх хот байгуулалтын чухал элемент болдог. Иймээс хотын ногоон байгууламжийн онолыг баримтлан Шинэ хотын газар зүйн байршлын онцлогийг харгалзан хот бүрдүүлэгч үүргийн бүсүүд суурьшлын бүсүүд болон хотын дундуур урсах голын ай сав, түүнд цутгах бусад жижиг голуудын хөндийг хамруулсан ногоон байгууламжийн сүлжээ байхаар төлөвлөлтөд тусгав. Гол усны сав, (төлөвлөлтийн үндсэн зарчим 58 дугаар зураг) барилга барихад тохиромжгүй дов толгод, хотын барилгажсан хэсэгт байрлах нийтийн эзэмшлийн цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн, гудамж замын дагуух ногоон байгууламжийг байгалийн задгай ногоон байгууламжтай нягт уялдууллаа.

Шинэ хотын архитектурын үзэмж, гоо сайханы соёлыг дээшлүүлэх, оршин суугчдын ажиллаж амьдрах орон зайн эрүүл, тохилог орчныг бүрдүүлэх, цэцэрлэгжсэн талбай болон нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг 20 м<sup>2</sup> хүргэхээр тооцов.

Хотын ногоон байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд төлөвлөлтөөр гол төлөв нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн сүлжээг бий болгож хөгжүүлнэ. Үүнд: Хотын үүргийн бүсүүдийн гудамж замын дагуух (төлөвлөлтийн үндсэн зарчим 59 дүгээр зураг) цэцэрлэгжилтийг өргөн хүрээтэй төлөвлөж, гудамж замыг мод тарьж зүлэгжүүлнэ. Хотын амралт зугаалга, спортын зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбайг нормативт хүргэн байгуулах. Голын сав газар, үерийн аюултай гуу жалгыг цэцэрлэгжүүлэх.

Хотын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг гудамж зам дагуух ногоон байгууламж, парк, цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж, орон сууц олон нийтийн нутаг доторх ногоон байгууламж гэсэн байдлаар байгуулж хөгжүүлнэ.

Төслийн хүрээнд ногоон байгууламжийн хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг хийж, хот цэцэрлэгжүүлэлтийн менежментийг шинэ шатанд гаргана.



ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ М1:25000

Зураг 58




ТАНИХ ТЭМДЭГ

- ТУСГАЙ ЗОРИУЛАЛТАЙ НОГООН БАЙГУУЛАМЖ
- НИЙТИЙН ЭЗЭМШИЛИЙН НОГООН БАЙГУУЛАМЖ
- ХЯЗГААРЛАДМАЛ ЗОРИУЛАЛТАЙ НОГООН БАЙГУУЛАМЖ
- ГОЛЫН ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС





### ХОТЫН ҮҮРГИЙН БҮСИЙН НОГООН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ




59 дүгээр зураг

**Гудамж замын дагуух ногоон байгууламж.** Хотын гол гудамж замуудын хоёр талаар мод тарьж, зүлэгжүүлэх замаар ногоон байгууламжийг байгуулахаар төлөвлөх. Гудамж замын дагуух ногоон зурвасын өргөнийг гол төлөв, байрлал, гудамж замын ангиллаас шалтгаалж 4.0-6.0 м хүртэл өргөнтэй байхаар тооцно. Модны төрлийг орон нутагт нь тохирсон байхаар, гудамж бүрийг өөрийн ландшафтын архитектурын төлөвлөлтийн шийдэлтэй байхаар суулгац нь 2,5 м өндрөөс багагүй байхаар тооцож суулгана. Зүлэгжүүлсэн (төлөвлөлтийн үндсэн зарчим 60 дугаар зураг) талбайд хотын байгаль орчинд амьдрах чадвартай, түргэн ургадаг шаардлага хангасан олон наст ургамлыг өргөнөөр ашиглана. Хотын



хэмжээнд нийт **240,5 га** талбайд гол гудамж дагуу ногоон байгууламжтай болсон байхаар тооцож байна.

### ХОТЫН СУУРЬШЛЫН БҮСИЙН НОГООН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ



60 дугаар зураг

Хотын ногоон байгууламжийг байгалийн унаган төрхтэй нягт уялдуулж барилгажих орчны тэнцвэртэй байдлыг хангах, байгалийн нөөцийг хамгаалах, экологийн системийг хамгаалж сайжруулах, амралт, аялал жуулчлалын байгууламжуудыг барьж байгуулах асуудалд хотын ногоон байгууламжийн систем чухал үүрэг гүйцэтгэнэ гэж тооцлоо. Энэ зорилгоор усны эх үүсвэрийг хамгаалах бүс, ойн сан, хотын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан ногоон байгууламжийн цогц систем байхаар төлөвлөв. Хотын ногоон байгууламжийн системийг дараах зарчмаар хөгжүүлнэ:

**Нэг.** Хотыг дайран урсдаг голуудыг ногоон байгууламжийн сүлжээний системд гол түшиц болгон ашиглахаар тооцно. Ингэснээр ургамал амьтны аймгийн нутаглах чухал орчинг бүрдүүлэх ба байгалийн тансаг орчинг бүрдүүлсэн нутаг болно.

Эдгээр голуудын эрэг, сав газруудыг тусгай хамгаалалтад авч үйлдвэр, ахуйн хаягдал, хяналтгүй барилгажилт, суурьшлын бүс болголгүй төлөвлөснөөр бохирдлын эсрэг арга хэмжээ болж нийтийн эзэмшлийн амралт зугаалгын цэцэлэгт хүрээлэн, тохилог орчин бүрдсэн талбай бүхий ногоон байгууламжийн орон зайн нэгдсэн систем болно.





**Хоёр.** Ногоон байгууламжийн сүлжээг гамшгийн менежментийн арга хэмжээтэй цогц байдлаар хөгжүүлнэ. Тухайлбал гал, ус, газар хөдлөлийн гамшгийн нөхцөлд хотын хүн амын тодорхой хэсгийг нүүлгэн шилжүүлж тараан байрлуулахад ногоон байгууламжийн задгай талбайг ашиглана.

**Гурав.** Хотын хилийн зэст хамаарах уул нурууд толгодын орчинд байгаль хамгаалал болон аялал жуулчлалыг тэнцвэртэй хөгжүүлнэ. Шинэ хот байрлах газар нутаг нь байгалийн үнэлж баршгүй нөөц, баялаг ойн сантай бөгөөд хотын төвөөс хялбар хүрч очих боломжтой аялал жуулчлал зугаалгын бүс болгох тохиромжтой нутаг дэвсгэр юм. Иймд энэ үзэсгэлэнт уулын нутаг дэвсгэрийг цаашид унаган төрхөөр нь хадгалж аялал жуулчлалыг тэнцвэртэй хөгжүүлнэ.

**Дөрөв.** Нийтийн эзэмшлийн талбай бүхий ногоон бүсийг хамгаалалтын тусгаарлах зурвас болгон тогтооно. Барилгажсан хэсэг болон байгалийн төрхөөр байгаа газрын хооронд тусгаарлах зурвас болгон задгай талбай бүхий ногоон байгууламжийг байгуулж ашиглана.

**Тав.** Барилгажилт үргэлжлэх суурьшлын бүсүүдийн хооронд тусгаарлах ногоон зурвас төлөвлөв. Усны нөөцийг хамгаалах зорилгоор голын эрэг дагуу задгай талбай бүхий ногоон байгууламж байгууллаа.

**Зургаа.** Уул толгодын энгэрийг цэцэрлэгжүүлнэ. Үерийн улмаас хөрсний гулсалт үүсэхээс сэргийлж уул толгодын ар өврийг цэцэрлэгжүүлнэ. Ингэснээр хотын доторхи ногоон байгууламжийн системийг хотын барилгажилтын хилийн гадна орших ойн бүстэй холбох арга хэмжээ болж байна.

**Долоо.** Үйлдвэрийн бүс, үйлдвэр аж ахуйн газрын орчинг цэцэрлэгжүүлнэ. Ингэснээр орчны бохирдол, дуу чимээ агаарын бохирдлыг бууруулах шийдэл болж үйлдвэрийн болон инженерийн байгууламжийн бүсийн орчныг цэцэрлэгжүүлж тохижуулна.

Хотын орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчинг бүрдүүлэх, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур орон зайн зохиомжийг сайжруулах



зорилгоор хотын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн норм, стандартын дагуу төлөвлөв.

**Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж.** Хотын хүн амын тав тухтай ажиллаж амьдрах, орон зайн орчны чанарыг хангахуйц, амралт зугаалга, спорт, соёлын байгууламжууд бүхий орчин үеийн, ландшафтны архитектурын шийдэл бүхий төлөвлөлт байх юм. Хотод төв, дүүрэг, хорооллын чанартай нийт **2050,5 га** талбайг хамарсан **57 ш.** парк цэцэрлэгийг байгуулахаар тусгасан. Эдгээр парк цэцэрлэгүүд нь усан толь, фонтан, (дагуул хот, төвийн бүсийн ногоон байгууламж 61 дүгээр зураг) бассейн, амралтын, хүүхдийн тоглоомын болон төрөл бүрийн биеийн тамирын задгай талбай, стадион, спортын барилга байгууламжтай байхаар төлөвлөгдөнө. Хот нь өөрийн гэсэн 450 га-д Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй байна. Мөн 1800 га талбайд хотын чанартай 22 ш. ногоон байгууламж бий болно. Төв, Дүүргийн чанартай ногоон байгууламжийг 830 гаруй га талбайд 18 ш -г байгуулна. Төв, хорооллын чанартай ногоон байгууламжийг хотын захаар төлөвлөнө. Үүнд:

1. Шинээр барьж байгуулах хотын гудамж замын дагуу мод тарьж зүлэгжүүлэн цэцэрлэгжүүлнэ.
2. Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай хотын нутаг дэвсгэрт 40 хувийг хамрана.
3. Орон сууцны хорооллуудын доторх ногоон байгууламжийг нормын дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.


Төлөвлөлтийн хугацаанд хотод хийгдэх цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийг дүүрэг бүрт 2-4 бичил цэцэрлэг, цэцэрлэгт талбай байгуулах, сул чөлөөтэй талбайг байшин барилга барихад биш, цэцэрлэг ногоон байгууламж барихад зориулах дурсгалт байгууламжуудад зориулан хүндэтгэлийн дурсгалын парк байгуулах;

Шинэ хотын баруун хойт талд салхины дээр хэсэгт шороон шуурганаас хамгаалсан ногоон зурвас байгуулж, зүлэгжүүлэх; хот дотор буй орон сууцны



орчмын талбайг зүлэгжүүлэх орон сууцны бичил хорооллыг хүмүүсийн урсгал хөдөлгөөнд нийцүүлж, өндөржилт, хайс хамгаалалт бүхий ногоон байгууламж бий болгох;

#### ХОТЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, ПАРКИЙГ ТӨЛӨВЛӨХ ҮНДСЭН ЗАРЧИМ



61 дүгээр зураг

Хотын дундууд урсаж буй голуудын хөндийд таримал ногоон төгөл, шугуй бий болгон, хотын оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлэх

Төлөвлөлтөөр Шинэ хотын ногоон байгууламжийг дотор нь нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гудамж зам дагуух ногоон байгууламж байхаар тооцсон болно. Цаашдаа барилгажихад тохиромжгүй талбайг цэцэрлэгжүүлэн, хотын ногоон байгууламжийг байнга нэмэгдүүлнэ.

Хотын ногоон байгууламжийг гамшгийн үед хүн амыг цуглуулах, түр тараан байршуулах талбай болгон ашиглана. Орон сууц, олон нийтийн орчны цэцэрлэгжилт ногоон байгууламж. Төлөвлөгдөж буй орон сууц олон нийтийн бүс, хотын төв, дэд төвүүдийн орчинд **550,0 га** талбайд, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу оршин суугчдын тав тухтай ажиллаж амьдрах орон зайн, орчин бүрдүүлсэн цэцэрлэгт талбай, бичил цэцэрлэг, төгөл, бүхий амралт, тоглоомын болон спортын талбай бүхий тохижилт, цэцэрлэгжилтийг хийнэ. Төслийн дагуу хотод нийт **3568,9 га** талбайд ногоон байгууламж бий болно.



**Ландшафт-амралтын нутаг дэвсгэр нь:** Хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт сувиллын газар, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, цэнгэлдэх хүрээлэн, спортын цогцолбор бүхий орон зайн чөлөөтэй орчин байна.

Шинэ хотын ландшафт-рекреацийн нутаг дэвсгэр цэцэрлэгжүүлэлтийг дотор нь нийтийн хэрэгцээний, хязгаарлагдмал зориулалттай, тусгай зориулалттай гэж ангилан ангиллын дагуу иргэдийн ажиллаж амьдрахад тохиромжтой ариун цэвэр-эрүүл ахуйн нөхцлийг хангасан, хотын орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчин бүрдсэн хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, нутаг дэвсгэр архитектур-орон зайн таатай орчин байхаар тооцлоо.

Шинэ хотын нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт төгөл, орон сууц, үйлдвэрлэлийн чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж, модот гудамж болон зүлэгжүүлсэн гудамжууд нь хотын нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн үүрэг гүйцэтгэхээр тооцлоо.

Сургууль цэцэрлэг, ясли, эмнэлгийн байгууллага, авто болон төмөр замын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас, иргэн, олон нийтийн барилгын эдэлбэр газрын цэцэрлэгжүүлэлт болон ботаник, цэцэрлэг, орон сууцны хорооллын хамгаалалтын бүс, гудамж замын цэцэрлэгжүүлэлт, хөрсний эвдрэл, элсний нүүлтээс хамгаалсан ногоон суулгамал, гол горхи, нуур цөөрмийн эргийн хамгаалалтын зурвас, хүчтэй салхи, элс, цасны хунгарлалтаас хамгаалсан ногоон байгууламжийг хязгаарлагдмал зориулалттай хотын цэцэрлэгжсэн орчин болгож ашиглахаар тооцлоо.

Хотын нутаг дэвсгэрт тухайлбал, хотын бие даасан төв тус бүрд цэцэрлэгжүүлсэн болон ногоон байгууламж бүхий задгай орон зай хоршсон цогцолбор бүс байна. Хотын барилгажсан нийт талбайн 40%-иас багагүй нь, сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн 30%-иас багагүй нь цэцэрлэгжүүлсэн нутаг дэвсгэр байна.

Шинэ хотын цэцэрлэгжүүлэх нийт нутаг дэвсгэрийн 10%-иас багагүй газар нь 0,5 км өргөнтэй цэцэрлэгт хүрээлэн ойн парк байна.





Шинэ хот бие даасан цэцэрлэгт хүрээлэнтэй байна. Хүрээлэн дотроо хүүхдийн, биеийн тамирын, спортын, үзэсгэлэнгийн, ан амьтны ба бусад хүрээлэн, ботаникийн цэцэрлэг гэсэн төрөлжсөн байдалтай байна. Спортын байгууламжийг оролцуулан тооцсон хүүхдийн цэцэрлэгт хүрээлэнгийн нэг хүнд ногдох талбайн хэмжээг 0,8 м<sup>2</sup>-аас багагүй байхаар төлөвлөнө.

Шинэ хот байгуулах орчмын байгалийн ландшафтыг хэвээр хадгалах төлөвлөлтийн зарчим баримталж түүнийг үндэсний ба байгалийн хүрээлэн болгож ашиглахаар тооцлоо.

**Хотын ногоон байгууламжийн төлөвлөлт.** Шинэ хотын хөгжлийн чиг хандлагад хотын ногоон байгууламжийн сүлжээг одоо мөрдөж буй нормоос 70 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

**Хотын амралт зугаалгын бүсийн төлөвлөлт.** Шинэ хотын иргэдийн амралт зугаалгын бүсийг нийтийн тээврийн хэрэгслээр 1,5 цагаас илүүгүй хугацаа зарцуулан очих зайд байрлуулна. Нэг амрагчид ногдох амралт зугаалгын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг 500-1000 м<sup>2</sup> байхаар тооцлоо. Амралт зугаалгын бүсийг дотор нь амралт, рашаан сувилал, хүүхдийн зуслан сургуулийн өмнөх насны хүүхдийн сувилал, ногоон багууламж гэж ангилан түүнийг хотын чанартай авто зам, төмөр замаас 500 м-ээс багагүй, амралтын газраас 300 м-ээс багагүй зайд байрлуулахаар тооцлоо.

**Шинэ хотын дэргэдэх оюутны хотхон.** Оюутны хотхоныг хоёр хэлбэрээр байгуулахаар төлөвлөж байна. Үүнд:

- Шинээр бие даасан оюутны хотхон байгуулах
- Дагуул хотуудыг түшиглэн оюутны Шинэ хотхон байгуулах

Шинээр байгуулах оюутны хотхон нь 80,0 мянган хүн амтай, 12000 га нутаг дэвсгэртэй байна. Хүн амын дундаж нягтрал 10 хүн/га байна. Шинэ хотын оюутны хотхонд ШУТИС, УБИСургууль холбогдох дагвар сургуулиудын хамт байрлана. Бусад их дээд сургуулиуд хуучин Улаанбаатар хотод байрлана.



Шинээр байгуулах оюутны хотхоныг ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Ерөнхий төлөвлөгөөнд тус хотхон бие даасан инженерийн хангамжтай, түгээх шугам бүхий инженерийн болон зам тээврийн дэд бүтэцтэй, байна.

Хотхоны гол үүрэг зориулалт нь сургалт, боловсрол туршилтын үйлдвэр үйлчилгээтэй байх тул сургалтын болон амьдралын тохилог орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хотхонд сурч боловсрох болон оюутны амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх барилга байгууламжууд байх ба хотын төлөвлөрсөн болон бие даасан инженерийн хангамжтай байна.

Энэ хотхонд шинэ хотод үйл ажиллагаа явуулах шаардлагатай олон хэвшлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд материаллаг баазын хамт байрлана.

**Оюутны хотхонд байрлах их дээд сургуулиудыг** “Шинжлэх ухаан технологийн хотхон” ба “Мэдлэгийн хотхон” болгон байршуулж шинжилгээ, судалгаа эрдэм шинжилгээний байгууллагуудыг хөгжүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлэх хэмжээнд зохион байгуулна. Үүний үр дүнд их, дээд сургуулиудын оюутнууд замын хөдөлгөөнд оролцох нь эрс багасч замын хөдөлгөөний нөхцөл байдал ч сайжирна.

Хотын баруун болон баруун өмнөд тэнхлэгүүдийн дагуу хоёр чиглэлд төмөр замд суурилсан нийтийн тээврийн тогтолцоог бүрдүүлнэ. Нэг дэх чиглэл нь хотын нийтийн тээврийн хэрэгсэлийн эцсийн буудлаас хотын өргөн чөлөөгөөр хотын төвийг дайран өнгөрч “Мэдлэгийн” шинэ хотхон хүрнэ. Хоёр дахь чиглэл нь хотын төвийг дайран “Шинжлэх ухаан технологийн” шинэ хотхон хүртэл тавигдана. Хоёр шугамын хотын төвөөр дайран өнгөрөх хэсэг нь газар доогуурх байгууламж байна. /ойролцоогоор 5км/. Эдгээр нийтийн тээврийн шинэ тогтолцоог **“Хотын метро-транзит систем** гэж нэрлэж байна. Газар доорхи худалдааны төвүүдийг хотын төв талбай, төвүүдийн худалдаа үйлчилгээ, бизнесийн төвүүдийн дор байгуулна. Газар доорх худалдааны төвүүд нь өвлийн хүйтэн улиралд иргэд, оршин суугчид хорогдох уулзаж цугларах газрын нэг болох боломжтой гэж тооцлоо.



**Шинэ хотын зуслангийн бүс.** Шинэ хотын хилийн цэсийн /төлөвлөж буй/ гадна талд зуслангийн түр суурьшлын буюу зуслангийн бүс байгуулна. Зуслан нь Шинэ хотын оршин суугчдын амралтын ногоон бүс байх ба бүсийн хөгжлийн чиг хандлагаар 2040 онд зуслангийн бүсэд 0.8 мянган хүн байнга оршин амьдарна.

Бүсийн суурьшлыг 6000.0 га талбайд байршуулах ба хөдөлмөрчдийн амьдралын ая тухтай нөхцлийг хангах зорилгоор гудамж замын сүлжээ, худалдаа үйлчилгээ, хэсэгчилсэн инженерийн хангамжтай байна. Энэ бүсэд хог хаягдал, ус хангамж, ариутгах татүүргын менежментийг боловсронгуй болгож хөгжүүлнэ.

Байгаль экологийн эмзэг байдал, түүнийг хүний үйл ажллагааны сөрөг үр дагавраас хамгаалж зуслангийн бүсэд ногоон бүсийн иж бүрэн систем төлөвлөнө.

Зуслангийн бүсэд ойн хамгаалалтын, усны хамгаалалтын болон суурьшихад тохиромжгүй, аюулгүй бүсүүдийн хил хязгаарыг тогтоож, суурьшлыг хязгаарлана зуслангийн бүсийн нутаг дэвсгэрт байх голуудын хамгаалалтын зурвасын дагуу ногоон байгууламж, нийтийн амралтын парк цэцэрлэг бүхий экосистемийг байгуулна.

**Шинэ хотын экосистем.** Шинэ хотын орчмын бүс нутагийг эдийн засгийн чөлөөт бүс болгон хөгжүүлэх, энэ асуудлыг ирээдүйд гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх замаар шийдвэрлэхэд нэн тохиромжтой гэж тооцсон. Ингэснээр хот орчмын бүс нутгийн ашиглалт, төлөвлөлтөд нөлөөлөхөөс гадна хот өөрийг бие даан хөгжүүлэх эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ. Гадаадын хөрөнгө оруулалтын үр дүнд хамтын үйлдвэрийн газрууд, олон улсын зочид буудал, аялал жуулчлалын цогцолборууд, бизнесийн төв, мэдээллийн төвийг байгуулан, газрын түрээсийн асуудлыг оновчтой шийдвэрлэн гадаад, дотоод зам харилцаагаа оновчтой хөгжүүлснээр эдийн засгийн Хангайн бүсэд энэхүү шинэ хотын эзлэх байр суурь нэмэгдэнэ. Шинэ хот орчмын дагуул хот маягтай хотожсон бүс нутаг бий болж томоохон үйлдвэрийн газруудыг байршуулах, хотын хүн амыг тараан суурьшуулах боломжийг бүрдүүлнэ. Харин аж үйлдвэрийн цогцолборыг нэг хонхорт төвлөрүүлэх биш хот орчмын бүс нутаг



байгаль хүрээлэн буй орчинд эсрэг нөлөө үзүүлэхгүйгээр оновчтой байгуулж тэнд дагавар хот байршуулах асуудал юм.

Мөн аж үйлдвэрийн болон хүнс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ харилцан борлуулах, хотууд бие биедээ тэтгэх, газар нутгаа хамтран ашиглах механизм эдийн засгийн онолоор бодитой хэрэгжинэ. Орчин үед хотууд хоорондоо харилцан шүтэлцээтэйгээр үйл ажиллагаа явуулах нь зах зээлийн хот байгуулалтын зарчмын зайлашгүй асуудал юм. Учир нь үүнд: **Бүс нутгийн хотууд хоорондоо:** Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний нөөцийг харилцан ашиглах, соёл боловсрол, амралт сувилал, аялал жуулчлалыг зохион байгуулах, хотын хөдөлмөрчдийн чөлөөт цагийг хэрхэн өнгөрүүлэх, санхүү эдийн засгийн зээл олгох, хувьцаа эзэмших, мөнгөн хадгаламжийн эрх зүйн орчин нэмэгдэх. **Хот хөдөө аж ахуйн бүс нутагтай:** нутаг дэвсгэрээ харилцан эзэмших, хотын иргэд туслах аж ахуй эрхлэх, өрх гэрийн үйлдвэрлэл явуулах, малын бэлчээр, тэжээлийн аж ахуй зохион байгуулах. **Худалдааны:** хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хотын иргэдийг хангах, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, өргөн хэрэгцээний бараагаар хөдөөгийн иргэдийг хангах зэрэг болно.

Бүсийн хотууд өөр хоорондоо том хот хөдөө аж ахуйн бүс нутагтай харилцан шүтэлцээтэй хөгжих нь хүн ам, аж үйлдвэр нэг дор хэт төвлөрч хот эрчимтэй хөгжиж томорсоор байгаль орчин хэрээс хэтэрсэн хэмжээнд бохирдож сөрөг нөлөө үзүүлэхгүй, хөдөөгийн хүн ам цөөрч уналтад орохгүй байх нөхцөл бүрдэх ба том хот ойр орчмын жижиг хотоо өөртөө нэгтгэн залгихаас урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Хотуудын хоорондын шүтэлцээ хотуудын сүлжээний бүтцийг бий болгохыг шаардана. Шинэ хотын хэтийн хөгжил нь Хархорин, Булган, Дархан, Эрдэнэт гэсэн хүн амын нутагшлын “Экосистем” бүрэлдэн тогтоход нөлөө бүхий ба энэ хэсэгт хүн амын нягтрал ихтэй хотожсон районы бүрэлдэн тогтох боломж бүрдэнэ.





## НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн ойрын хугацааны стратегид тодорхойлсноор Хангайн бүсийн нийгэм эдийн засгийн өнөөгийн хөгжил нь тус улсын нутаг дэвсгэрийн нийгэм, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн нөхцлийг бүрдүүлэх үндсэн дээр үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх зорилгод нийцэж байна. Энэхүү зорилгын хүрээнд дараах үндэсний болон бүсийн давуу талууд, нөөц боломж нийтлэг ач холбогдол оршиж байна гэж үзлээ. Үүнд:

-Бүсийн хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны доройтлыг хязгаарлах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах,

-Байгаль орчинд зохицон дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн хөгжих ирээдүйтэй тэргүүлэх салбарыг бүсийн хүрээнд тогтоож, бусад бүсүүдтэй үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт, дагналтыг бий болгож хөгжүүлэх,

-Бусад бүсүүдтэй болон гадаад зэх зээлтэй зохистой холбож чадахуйц хот байгуулалт, дэд бүтцийн тогтолцоог бүрдүүлэх,

-Бүсийн эдийн засгийг тэтгэх чадвартай хувийн хэвшлийн түшиц компани, хоршоо, хөгжлийн бүс нутгийг тогтоон хөгжүүлэх,

-Бүс нутгийн цогцолбор хөгжлийг тэтгэх эдийн засаг, санхүүгийн чадавхи буюу дотоодын хуримтлалыг бий болгох,

-Бүсийн түвшинд гадаадын шууд хөрөнгө оруулалт “байрших” боломжийг нэмэгдүүлэх,

-Бүсийн хүн амын нутагшилт, суурьшлыг зохистой болгох нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний харьцангуй жигд нөхцлийг бүрдүүлэх,

-Хангайн Хөвсгөлийн уулархаг ойт хээрийн бүс зонхилсон, хүн ам амьдран суурьшихад харьцангуй тохиромжтой өргөн уудам газар нутаг,



-Зохистой ашиглах боломжтой ой, ус, ан агнуур, байгалийн дагалдах баялагийн нөөц,

-Дэлхийн болон бүс нутгийн зах зээлд чухал нөлөө бүхий эрэдс түүхий эд ялан гуяа зэс, фосфор, цэнгэг ус, аялал жуулчлалын арвин нөөц,

-Боловсруулах үйлдвэрийн түүхий эд болох ноос, ноолуур, мах, сүү, арьс шир, ангийн үс зэрэг түүхий эдийн нөөц,

-Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймагт үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, бүсийн дотоод хэрэгцээг хангах бүрэн боломж,

-Сүү махны чиглэлийн Сэлэнгэ үхэр, Хангайн бор сарлаг, Уянгын үхэр, ширүүвтэр ноосны Байдраг, нарийн, нарийвтар ноосны Орхон, хангай мах-ноосны Дархад хонь, нутгийн шилмэл омгийн ноолуурын ямаа зэрэг шилмэл омгийн цөм сүгийг бүрдүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх боломж,

-Цэцэрлэг-Хархорин, Ханх, Мөрөн-Эрдэнэт, Бага илбэнх-Булган, Хархорин-Арвайхээр, Баянхонгор-Шивээхүрэнгийн чиглэлээр бүсийн эдийн засгийг гадаад дотоодын зах зээлтэй холбох дэд бүтцийн сүлжээний бүрдэлт зэрэг болно. **Энэ үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг хийж байна.**

1. Монгол оронд хүн амын нутагшилт, хот байгуулалт бүрэлдэн тогтсох үйл явц нь нүүдлийн соёл иргэншилтэй уялдан өвөрмөц, өөрийн өнгө, төрхтэйгээр хөгжиж ирсэн нь суурин соёл иргэншилтэй бусад улс орноос ялгагдах гол онцлогтой бөгөөд сүүлийн 50 гаруйхан жилийн дотор манай улсад суурин соёл иргэншил гүнзгий нэвтэрч, хотжих процесс эрчимтэй явагдаж иржээ.

2. Монгол орны нутагшилт, хот байгуулалтын өнөөгийн дүр төрхөөс хотын, тосгон суурины болон хөдөөгийн нутагшилтын хөгжил ялгаатай байгаа нь төр засгаас явуулж ирсэн бодлогын алдаа, дутагдал, бусад суурин соёл, иргэншилтэй орны хот байгуулалт, төлөвлөлтийн практикийг өөрийн орны онцлог нөхцөлд зохицуулахгүйгээр хуулбарлан ирсэн, хотжих үйл явц сүүлчийн 50 гаруйхан



жилийн дотор эрчимтэй явагдаж эхэлсэн. Манай хот байгуулалт, төлөвлөлтөд гадаад орны хот байгуулалтын онол, зарчим, арга зүй, норм дүрмийг шууд баримтлан боловсруулж ирсэнтэй холбоотой байна.

3. Улсын хөгжлийг хот байгуулалтын нэг төвт тогтолцоогоор зохицуулж байснаас Монгол улсын томоохон үйлдвэр, аж ахуй, Шинжлэх ухаан, соёл боловсролын байгууллага, цэргийн анги нэгтгэлүүд хүн амын 50 гаруй хувь улсын хэмжээний аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 50 шахам хувь, барилга угсралт, засварын ажлын 70 шахам хувь, цахилгаан үйлдэврлэлийн 80,0% дулаан үйлдэврлэлийн 75,0% хөрөнгө оруулалтын 65,0% 4,7 мян.км<sup>2</sup> газар нутагтай нийслэл хотод төвлөрч ирсэн нь улс орны хотуудын тогтвортой хөгжил, хотын байгаль орчин экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх үндэслэл болжээ.

4. Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл болох хот байгуулалт, хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоо, бүс нутгаар хөгжүүлэх зарчим, хөгжлийн тэргүүлэх болон тулгуур төвүүд, зам тээвэр, инженерийн дэд бүтцийн гол тэнхлэгүүд өнөөдрийг хүртэл бүрэн утгаараа бүрэлдэн тогтоогүй байгаагаас тухайн үеийн эдийн засгийн чадавхи, хүн амын тоо, төр засгийн явуулж буй бодлогоос шууд хамааралтай байсанаас хөгжлийн нөхцөл байдлыг хүндрүүлсээр иржээ.

5. Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл байдалд хотуудын хөгжлийн асуудлыг зөвхөн дэвсгэр нутгийг нь хүрээнд бус, улсын нийт хүн амын нутагшилт, суурьшил, газар нутгийн зохион байгуулалтын хүрээнд өөрөө өөрийгөө тэтгэж, өрсөлдөх чадвар бүхий нутаг дэвсгэр, орон зайн нэгдмэл бүтэцтэйгээр бүс нутгаар бие дааж хөгжих түвшинд төлөвлөх шаардлагатай байна.

6. Хүн амын шилжин суурьших үйл явц Сүхбаатар-Замын-Үүдийн төмөр замын дагуу Улаанбаатар, Төв, Дархан, Сүхбаатар, Зүүнхараа, Налайх зэрэг хот тосгон төвлөрсөн Олон улсын хэллэгээр “технополис” хэлбэрийн суурьшлын шинэ төвүүдэд түлхүү явагдаж ирснийг бүсийн тулгуур төв хотуудад шилжүүлэн нутагшуулах шаардлагатай болжээ.



7. Хангайн бүсийн хүн амын нутагшилтын бодит тогтолцоо нь: Хангайн бүсийн хүн амын нутагшилт, хот байгуулалтын бодлогын хэрэгжилт, Хангайн бүсийн хүн амын нутагшилт, хот байгуулалтын үндсэн зарчим, бүс нутаг төлөвлөлт, газар ашиглалт, хот суурин байгуулалт, байгаль газарзүйн онцлог, барилгын материал, түүхий эд улс орны нийгэм эдийн засгийн хөгжил зэргээс шууд хамааралтайгаар биелэлээ олж хөгжинө гэж тооцлоо.

8. Хангайн бүсийн хүн амын нутагшилт нь: Бүсийн газар нутаг, байгалийн нөхцөл, нөөцийг бүрэн тооцсоны үндсэнд газрын харилцааг бүхэлд нь боловсронгуй болгох замаар газар ашиглалт сайжиран, хүний ажиллах амьдрах хэвийн орчин бүрдсэн хүн амын уламжлалт нүүдлийн болон суурин соёл иргэншлийн хэвшлийн амьдралын зохистой харьцаа бүхий бүс нутаг, хот суурингаас бүрдэнэ гэж тооцлоо.

9. Хангайн бүсийн хот байгуулалтын бодлогын үндсэн чиглэл нь: **Нэгд.** Бүсийн хот суурин ангиллыг үндэслэн хүн амын нутагшлын үндсэн хэв шинж, төрөл, бүтэц, нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн чиглэл, хүн амын бүтцийн үзүүлэлт, шилжилт хөдөлгөөний шинж чанарыг тогтоож, үнэлгээ хийх. **Хоёрт.** Хүн амын нутагшилтын системийн үндсэн элемент болох бүсийн хот суурины нэгдсэн сүлжээг нутаг дэвсгэрийн зөв зохион байгуулалттай бүс нутгийн хүрээнд хөгжүүлж, хот суурин байрлах нутаг дэвсгэр, орон зайн бүтцийн бодит хэв шинжийг тодорхойлж, дэд бүтцийн оновчтой тэнхлэгүүдийг хөгжүүлэх үндэслэлийг тогтоох. **Гуравт.** Бүсийн хүн амын оршин суугаа суурин газрын хөдөлмөрийн нөөц, нутаг дэвсгэр-үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчин, зах зээл, хүн амын ахуй, нийгэм соёлын хоорондын тогтвортой харилцан үйлчлэлийг интеграцийн онолын нэгдсэн системээр хөгжүүлэх архитектур-хот төлөвлөлтийн үндэсний (стратегийн) загвар боловсруулах гэж үзлээ.

10. Хангайн бүсийн хүн амын нутагшилтын хэв шинж хоёр үндсэн хэлбэртэй байхаар тооцлоо. Үүнд: **Нэгд. Нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн тогтолцоо;** (Энэ бүс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн (фермерийн аж ахуй) цогцолбор, ХАА, үйлдвэрийн нэгдсэн цогцолбор, Нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн цогцолбортой байна.)





**Хоёрт.** Бүсийн хот суурин газрын хүн амын өсөлт, бууралт, шилжих хөдөлгөөн, ажиллах хүчний хөдөлмөрийн балансад эзлэх хувийг тодорхойлж, хот суурины нэгдсэн сүлжээнд хамрагдаж байгаа нийт суурин газрын хүн амын тоо, үйл ажиллагааны зориулалт, үүргээр нь **суурьшмал хот суурин, хагас суурьшмал, нүүдлийн буюу зөөврийн суурин гэсэн тогтолцоотой байна.**

11. Хангайн бүсийн хот, тосгоны хөгжлийг удирдах ерөнхий үндсэн чиг хандлагыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд: **Нэгд.** Бүсийн хүн амын нутагшил, хот, тосгон, хөдөө аж ахуйн суурингуудын хөгжлийг боловсронгуй болгох; **Хоёрт.** Хот суурин хөгжүүлэх бодит нөхцөл байдалыг бий болгох; **Гуравт.** Хөгжлийн эрэмбэ өөрчлөгдөх үе шатуудыг тогтоох; **Дөрөвт.** Хөгжилтэй холбогдон өөрчлөх үндсэн объектуудыг гарган тавих; **Тавд.** Хүн амын нутагшлын өөрчлөгдөх хандлагаыг боловсруулах; **Зургаад.** Хүн амын нутагшлын нутаг дэвсгэрийн бүтцийг хэлбэршүүлэх үндсэн зарчмуудыг хангах.

12. Хархорин сумын байгалийн нөхцөл нөөц, эдийн засаг, нийгмийн болон барилгажилт тохижилт, дэд бүтцийн хангамж, байгаль орчны хамгаалал, түүх соёлын дурсгалын чиглэлээр тогтсон одоогийн бүтэц, сумын зам тээврийн сүлжээний өнөөгийн тогтолцоо нь шинээр байгуулах хотын хүн амын өсөлт, эдэлбэр газрын өргөжин тэлэх хэрэгцээ, шаардлагатай зохицохгүй байгаа. Сумын нутаг дэвсгэр нь нягтрал багатай. Өнөөдөр бидний мөрдөж буй хот төлөвлөлтийн нормоор нутаг дэвсгэр дэхь хүн амын нягтралыг 450 хүн/га-аас хэтрүүлэхгүй гэж заасан тогтолцоо зөрчигдөж зарим суурьшлын нутаг дэвсгэрийн нягтрал, хэт бага тул шинэ хот байгуулах нутаг дэвсгэрийг Орхоны хөндийд шилжүүлэн нутагшуулах нь зүйтэй гэж үзлээ.

13. Өнөөгийн манай хот суурины гол гудамж замын сүлжээний хамрах хүрээ хотын үндсэн бүтцэд орж байгаа соёл ахуйн болон олон нийтийн барилга байгууламжуудын нутаг дэвсгэрийн нэгдмэл байдалыг хангаж чадахгүй байгаа нь хотын оршин суугчдад хамгийн дөхөмт байдлаар жигд тэнцүү үйлчлэх орон зайн орчин бүрдээгүй сумын суурьшлын бүсийн барилгажсан нутаг дэвсгэрийг бичил хороолол хэмээн механикаар жижиглэн, түүний үйлчилгээг нь ялгаварлан шаталж



байршуулан үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь хотын хүн амын үйлчилгээнд төвөгшил учирч амьдрах орчны нөхцөлийг бий болгож байна.

14. Монголын хот сууринд байгаль уур амьсгалын эрс тэрс нөхцөлд зохицсон жижиг үйлдвэрлэл – суурьшлын өвөрмөц бүс, нутаг дэвсгэрийн цогцолборууд бий болоогүй байгаа нь хотын нийгэм-эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж чадахгүй байна. Нөгөө талаар энэ бүгдийг уялдуулан зохицуулах зам харилцаа инженерийн шугам сүлжээ нь нутаг дэвсгэрийн хүрээнд бүрэн гүйцэд хэлбэршээгүй байгаагаас хотын оршин суугчдын хөдөлмөр эрхлэх болон соёл ахуйн үйлчилгээ амралт, чөлөөт цагийн нөөц нэмэгдэж, ая тухтай аж төрөх, нийгмийн бодит бололцоог хангаж чадахгүй байна.

15. Хархорин сум хэдийгээр бүс нутгийн төв болж байгаач Хангайн бүсийн аймгуудын хүн ам төврүү тэмүүлсэн хэвээрээ байна. Тус бүс нутагт тэр бүр ажлын байр бий болж чадахгүй байгаагаас хүн амын орлого бодитой нэмэгдэж, амьдрал нь сайжирч чадахгүй байна. Энэ бодит байдлаас үзэхэд Хархорин сум бүхэлдээ архитектур орон зайн нэгдмэл орчин болж чадаагүй, нутаг дэвсгэр нь нягтрал багтай хот бүрдүүлэгч үндсэн элементүүд нь тархай бутархай байрласан байгаа нь хот байгуулалтын хувьд нийгэм эдийн засгийн шаардлагыг хангахгүй байна.

16. Хархорин сум нь Хангайн бүсийн авто замын сүлжээ нь бүхэлдээ сумын орон зайд байршиж байгаа элементүүдийг холбосон нэгдсэн сүлжээ болж чадахгүй зам тээврийн тухайн сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зочих хэсэг, явган хүний зам, нийтийн тэврийн хэрэгслийн зогсоол, дугуйн зам, хөдөлгөөн тусгаарлах зурвас, аюулгүйн тойрог, ногоон байгууламж, тээврийн хэрэгслэлийн зогсоол, явган хүний гарц, газар доорхи инженерийн байгууламж, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламжийг хамарсан цогц систем болоогүй. Сумын нутаг дэвсгэрийн үүргийн бүсүүдийн хоорондын уялдаа, тэдгээрийн харилцан таталцлын үндсэн тэнхлэг болж, орон зайн зохион байгуулалтын нэгдсэн системийн түвшинд хүрээгүй байна. Иймээс сумын орон зайн тогтолцоо, хүн амын өсөлт, дугуйтай болон явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, тэдгээрийн байнга өсөн тэлж байгаа үйл явцтай зохицохгүй байна.



17. Сумын төвд орон сууцны хороолол, үйлдвэр, амралт зугаалгын бүсүүд болон худалдаа, соёл олон нийтийн төвүүдээс бүрдсэн хотын засаг захиргаа – олон нийт соёл – амралт худалдаа – ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байхгүй байна. Уг сум нь улс орны болон бүс нутаг олон улсын түвшинд өнөөгийн байдлаар бүсийн тулгуур төвийн үүрэг хүлээж байгаа ч бодит агууллагдаа хүрч төлөвшин тогтоогүй байна.

18. Сумын орчмын нутаг дэвсгэрт оршин суугчидын хүнс хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах үйлдвэр ХАА-н үйлдвэрлэл аж үйлдвэрийн цогцолборууд биелэлээ олж хэлбэршээгүйгээс сумын хүн амын механик шилжилтийг тогтоон барьж хязгаарлах, хүн амын ажилгүйдлийг багасгах, хүн амын өдөр дутмын соёл боловсрол ахуйн болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг зохицуулах боломжгүй байна.

19. Сумын төвийн суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн 1000 хүнд ногдох томсгосон үзүүлэлтүүд дундчаар эдлэн газаргүй 3 хүртлэх давхар сууцны барилгажилтанд 7 га, эдлэн газартай сууцны барилгажилтанд 12 га, 4-ээс дээш давхар сууцны барилгажилтанд 6 га талбай 9 ба түүнээс дээш давхар барилгад 6 га тус тус ногдож байна. Энэ нь суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт – орон зайн бүтэц зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

20. Сумын суурьшлын бүсийн нутаг дэвсгэр архитектур-орон зайн оновчтой бүтэц бүрэлдэн тогтоогүй, залгамж чанар нь алдагдсан, инженерийн дэд бүтэц хэвшиж биелэлээ олоогүй, нийгмийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх боломж тааруухан, цэцэрлэгжилтийн нэгдсэн систем байхгүй, иргэд чөлөөт цагаа эрүүл аюулгүй орчинд тав тухтай өнгөрүүлэх нутаг дэвсгэр, архитектур-орон зайн орчин бүрэлдэн тогтоогүй байна.

21. Хот суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн Архитектур-орон зайн бүтэц бүхэлдээ дизайнын хувьд Олон улсын болон бүсийн тулгуур төвийн хотын шаардлагыг хангасан орчин үеийн хотын түвшинд байх ёстой. Энэ шаардлагыг хангахгүй байна. Үүний нэг уршиг нь суурьшлын бүсийн үйлчилгээний төвүүдийг үйлчилгээнийх нь хувьд ялгаварлан шаталж байршуулснаас хотын хүн амын



чирэгдүүлж байна. Суурьшлын бүс дэх орон сууцны хорооллын ахуй үйлчилгээ, соёл олон нийтийн төвийн үйлчлэх радиус нь: гэр хороололд 2,5 км, сууцны 1-2 дан барилгатай нутаг дэвсгэрт 1.5-2.5 км, 3, 4, 5 давхар барилгажилттай хороололд 2-2.5 км байна. Энэ байдал суурьшлын бүс дэх орон сууцны хорооллын дотоод орон зай зөв зохион байгуулалтад ороогүй, зам тээврийн харилцаа ялангуяа явган хөдөлгөөнийг зохицуулж чадахгүй байна.

22. Шинэ хотын суурьшлын бүсийн орон сууцны эдлэн газрын хэмжээг тодорхойлохдоо хотын зэрэглэл шинээр барих орон сууцны барилгын хэв шинж, сууцны нутаг дэвсгэрийн хэлбэршиж тогтсон орон зайн болон зам харилцааны өнөөгийн систем, хотын ерөнхий бүтэц дэх барилга байгууламжийн байршил хот байгуулалтын онцлог нөхцөл байдлуудыг харгалзан сууцны эдэлбэр газрын хэмжээ 175-200 м<sup>2</sup> байна гэж тооцлоо.

23. Шинэ хотын үйлдвэрийн бүсийг хотын нутаг дэвсгэрт байршуулахдаа хүн амын суурьшлын бүс дэх орон сууцны хороололтой зам тээврийн сүлжээгээр харилцан нягт холбогдсон байдлаар тооцож тээврийн хэрэгслээр болон явганаар зорчин очих цаг хугацаа орон зайн хэмжээг нормын дагуу төлөвлөж хотын үйлдвэрийн болон хот нийтийн аж ахуйн агуулахын бүсийн орон зайн бүтцэд хамрагдах үйлдвэрийн болон нийтийн аж ахуйн агуулахын барилга, туслах барилгын үүрэг зориулалт, хүчин чадал нь хэрэгцээ шаардлагатайгаар уялдаж хотын дэд бүтэц, инженерийн байгууламжтай нягт уялдаж, нутаг дэвсгэрийг нь технологи, ариун цэвэр – эрүүл ахуйн, галын шаардлагын дагуу ажиллагсадын ажиллах, амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчин болж бүрэлдэн тогтохоор шийдлээ.

24. Шинэ хотын нутаг дэвсгэрт амралт зугаалгын зориулалттай цэцэрлэгт хүрээлэн бичил уур амьсгалын тааламжтай орчин бүрдсэн ариун цэвэр – эрүүл ахуйн бүс цэцэрлэгжүүлсэн болон задгай орон зай хоршсон цогцолбор бүс байхаас гадна хотын барилгажсан нийт талбайн 0.8 орчим хувь цэцэрлэгжсэн, сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн 0.5 хувь нь цэцэрлэгжсэн байна.





25. Шинэ хот орчмын байгалийн нөхцөл нөөц, эдийн засаг, нийгмийн болон барилгажилт тохижилт, дэд бүтцийн хангамж, байгаль орчны хамгаалал, түүх соёлын дурсгалт нутаг дэвсгэрийн бүтэц хотын зам тээврийн сүжээний тогтолцоо хотын хүн амын өсөлт, эдэлбэр газрын өргөжин тэлэх хэрэгцээ, шаардлага, зориулалт тэдгээрийн харилцан уялдааг тооцож хотын нутаг дэвсгэрийн үүрэг зориулалтын бүсчлэлийг “Хотын төвийн хэсэг”, “Суурьшлын бүс”, “Үйлдвэр аж ахуйн бүс”, “Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалалтын бүс”, “Спорт, амралт, зугаалга, нийтийн хэрэгцээний болон хамгаалалтын ногоон бүс” гэж ангилан үзлээ.

26. Шинэ хотын нутаг дэвсгэрийг тэгш өнцөгт дөрвөлжин төлөвлөлтийн системээр төлөвлөснөөр хот бүрдүүлэгч үндсэн элементүүдийг нутаг дэвсгэрийн хувьд ойлгомжтой хувиарлах, тээврийн хэрэгсэлд ногдох автозамын хэмжээ ихсэж гудамж замын түгжрэл багасах, нийгмийн үйлчилгээний урсгал нэвтрэх боломжийг эрс нэмэгдүүлнэ. Хөдөлгөөний зохицуулалт сайжирч, зорчих сонголт өргөжинө. Гудамж замын тоо нэмэгдэж, хүн ам зорьсон газраа хамгийн дөтөөр хүрнэ. Хотын доторхи гудамж замыг олон улсын жишгээр тэмдэгжүүлж, барилга байгууламжийн хаяг байршлыг гудамжаар нэрлэх хот байгуулалтын зөв шийдэлд хүрнэ. Хотын орон зайн төлөвлөлтийн ийм бүтэцтэй болгосноор нягтрал өндөртөй суурьшилтын бүс бий болж хооронд нь холбох авто замын сүлжээг оновчлох, тэгснээр зорчих хугацааг хэмнэх, шатахуун зарцуулалтыг багасгах, агаарын бохирдлыг бууруулах, дөтлөн хүрэх ачаа тээвэрлэлтийн шинэ шугам гаргах зэрэг хот байгуулалтын урбанизмын онол бодит байдлаар төлөвшин хэлбэршинэ.

27. Хотын хүн ам суурьшсан нутаг дэвсгэрийн төлөвлөлт, орон зайн үндсэн бүтэц нь: орон сууцны хороолол, худалдаа, соёл, олон нийтийн төв, нийтийн ногоон бүс, гудамж замын сүлжээ, орчиндоо хорт нөлөөгүй үйлдвэр, үйлчилгээ болон улс бүс нутгийн чанартай улс төр, бизнесийн барилга байгууламж зэрэг хот бүрдүүлэгч зайлашгүй элементүүдээс бүрдэж хотын гол гудамж болох автозамын сүлжээ нь хотын үндсэн бүтцэд орж байгаа соёл ахуйн болон олон нийтийн барилга байгууламжуудын нутаг дэвсгэрийн нэгдмэл байдлыг зохицуулан агуулах бөгөөд хотын оршин суугчдад хамгийн дөхөмт байдлаар жигд тэнцүү үйлчлэх орон зайн орчин байна.



28. Бүсийн тулгуур төв хот нь манай улсын зам харилцааны чухал зангилаа, хилийн боомт хот өөрөөр хэлбэл агаарын тээвэр, усан зам болон төмөр зам, авто замын сүлжээ бүхий зам тээврийн зангилаа хот байна. Энэ утгаараа манай улсын хүн амын нутагшил суурьшлын системийн онцгой идэвхижилийн бүсэд хамаарна.

29. Хотын гудамж, замын сүлжээ нь зам тээврийн сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний гарц, газар доорхи инженерийн байгууламж, гадаргуугийн улсыг зайлуулж, дамжуулах байгууламжийн хамт иж бүрэн шийдэгдэнэ. Ингэснээр хотын авто замын үндсэн сүлжээ нь хотынхоо урдуур сунаж тогтсон төв зам энэ замтай босоо тэнхлэгээр огтлолцсон 6 замын тогтолцооноос бүрднэ. Энэ нь хот байгуулалтын үндсэн тэнхлэг болно. Өнөөгийн энэ замын сүлжээг түшиглэн хотын ирээдүйн авто замын сүлжээ нь тэгш өнцөгт дөрвөлжин тогтоцтой байна. Хотын зам тээврийн сүлжээний энэ дөрвөлжин тогтолцоо нь хэвтээ чиглэлд 500-700 м, босоо чиглэлд 400 м-ийн алгасалтай байна. Хотын захын болон гэр хороололд үйлчлэх замын сүлжээг үйлчлэх хүрээ болон чанарын хувьд үндсэн ахиц өөрчлөлт хийх үүднээс (хорооллын ба хороолол доторхи зам) хотын хойд талын гэр хороололд 500-600 м-т, бусад орчны гэр хороололд 400-600 м-ийн алгасалтай байна.

30. Шинэ хотын гол гудамжууд, соёл олон нийтийн барилга байгууламж, үйлдвэр суурьшлын бүс, цэцэрлэгт хүрээлэнгийн органик чанарыг нь алдагдуулахгүй орчин үеийн арга хэлбэрээр хотын хамгийн үнэ цэнэтэй хэсэг болгон хөгжүүлэхээр тооцож хотын орон зайн хамгийн хүндэтгэлтэй, сонирхолтой орчин болгоно. Хотын орон зайн болон эзэлхүүн төлөвлөлтийн хувьд нягт уялдсан байхаар төлөвлөлтийн хувьд нягт уялдсан байхаар төлөвлөлтийн үндсэн санааг төлөвлөлөө.

31. Шинэ хот нь Хангайн бүсийн төр, захиргаа, мэдээллийн төв, түүнийг дагасан орон сууц, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээ, инженерийн дэд бүтцийн байгууламжууд бүхий орчин үеийн хот байх бөгөөд Орхоны тэгш тал хөндийн дагууд өргөжин тэлж, хөгжнө. Хотын гол гудамж замын дагуу тасралтгүй үргэлжлэх, хоёр талаар өндөр барилгууд сүндэрлэн боссоноор газар ашиглалт, инженерийн болон замын сүлжээ нь жигд тэгш хуваалттай болно. Хотын гол



тэнхлэгийн дагууд соёл үйлчилгээ цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, музей, үзмэр, зугаалга эдгээрт зориулсан үйлчилгээний байгууламжууд байх бөгөөд суурьшлын бүс нь энэхүү хэсгээр босоо тэнхлэгийн зарчмаар хуваагдаж байрлана. Тус тэнхлэгийг тодотгосон 6 босоо тэнхлэгийг үүсгэж байгаа замын дагууд мэдээлэл үйлчилгээ, аялал жуулчлал, банк санхүү, бизнесийн байгууллагууд, зочид буудал, ахуйн үйлчилгээ, аялал жуулчлалын компаниудын зориулалттай оффисын барилга цэгэн хэлбэрийн 60 хүртэл давхар өндөр барилгууд баригдаж орон зайн төлөвлөлтийн шийдлийг үүсгэнэ.

32. Орон сууцны хорооллын эдэлбэр газраас төмөр зам хүртлэх ариун цэврийн хамгаалалтын бүсийн өргөн 50 м хүртэл байна. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн эдэлбэр газрын 50-иас багагүй хувь нь зүлэгжсэн байна. Ачаа тээш ангилж, ялган буулгах өртөөнөөс сууцны барилга байгууламж хүртэлх зайн хэмжээг ачаа эргэлтийн хэмжээ, ачааны тэсэрч дэлбэрэх аюул, галын аюулгүй байдал болон бусад онцлог шинж чанартай нь уялдуулан тооцож тогтооно. Ариун цэврийн хамгаалалтын бүс дэх төмөр замын ус зайлуулах зурвасын гадна автозам, гараж, автомашины зогсоол, агуулах, нийтийн аж ахуйн объектууд байгуулна. Тээврийн хэрэгслийн дуу чимээнээс тусгаарлах зорилгоор эдгээр замын дагуу 10 м-ээс багагүй өргөнтэй ногоон зурвас байна. Шинэ хот нь бүхэлдээ орон сууцны хороолол, үйлдвэр, амралт зугаалгын бүсүүд болон худалдаа, соёл олон нийтийн төвүүдээс гадна олон улс, бүс нутгийн чанартай үйлчилгээ явуулах төрөлжсөн 8 тэнхлэгт байрласан 10 төвийг хамарсан хотын засаг захиргаа – олон нийт соёл – амралт худалдаа – ахуйн үйлчилгээ бүхий архитектур орон зайн нэгдсэн систем байна.

33. Хотын төв нь улс орны болон бүс нутаг олон улсын түвшинд тэргүүлэх үүрэг, хөгжлийн цар хүрээг илэрхийлэх бөгөөд Орхоны хөндийн тэгш талын байгалийн үзэсгэлэн төгөлдөр нутаг, түүх соёл, архитектур, хот байгуулалтын уламжлалын баялагаараа манай улсын соёл боловсрол, шинжлэх ухаан технологи үйлдвэрийн томоохон төв болно. Энэ утгаараа тус хотын төв нь үндэсний бахархалаа хадгалсан үлэмж баялаг агуулгатай, орчин цагийн шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг бүрэн шингээсэн шинэ хот болон хөгжинө.



34. Төв нь хотын олон нийт, иргэний барилга байгууамж, гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилтийн бүс, суурьшлын бүс үйлдвэрийн бүстэй уялдсан хоорондоо аль болохоор зохистой үйлчилгээний хүрээнд байна. Төвийг хотын олон нийт, иргэний барилга байгууламжийн тоо, хүчин чадал болон зэргэлдээ хот, суурингаас эдгээр объектуудад хүрэлцэн ирэх боломжтой хүмүүс, тухайн хотод түр оршин сууж байгаа хүмүүс, жуулчид бусад хүмүүсийг хамруулан тооцож төлөвлөнө. Энэ төврүү ердийн хөсөг, тээврийн хэрэгсэл, явганаар хүрэлцэн очих хугацаа 30 минутаас ихгүй байна.

35. Хотын нэгдсэн төвийн хүчин чадал, түүний сүлжээнд хамрагдах 10 төвийн үйл ажиллагааны зориулалт, байршил нь хотын нутаг дэвсгэр, хүн амын тоо, хүн амын нутагшил суурьшлын системд эзлэх хотын статус, тэнд оролцож байгаа үүрэг, нутаг дэвсгэр – орон зайн зохион байгуулалт, төлөвлөлт – зам харилцааны бүтцээс хамааралтай тогтоогдно.

36. Шинэ хотын хот орчмын нутаг дэвсгэрт ХАА-н үйлдвэрлэл, ялангуяа тахиа, гахай шувууны аж ахуй, суурин мал маллагааны буюу ХАА, аж үйлдвэрийн цогцолборуудыг байгуулах, улмаар Хангайн бүсийн хотын хүн амын механик шилжилтийг тогтоон барьж хязгаарлах, хүн амын ажилгүйдлийг багасган, шинжлэх ухаан, техник мэдээллийн шуурхай холбоо, хүн амын өдөр дутмын соёл боловсрол ахуйн болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг хангасан бүхэлдээ бүсийн нутаг дэвсгэрийг хамарсан орон зайн орчин болно. Бүсийн тулгуур төв хотын суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хэрэгцээг тодорхойлохдоо 1000 хүнд ногдох томсгосон доод үзүүлэлтүүдийг үндэслэн эдлэн газаргүй 3 хүртлэх давхар сууцны барилгажилтанд 10 га, эдлэн газартай сууцны барилгажилтанд 20 га, 4-ээс дээш давхар сууцны барилгажилтанд 8 га талбай 9 ба түүнээс дээш давхар барилгад 7 га тус тус ногдохоор тооцож төлөвлөлөө.

Суурьшлын бүсэд нэг загварын барилгажилт, нийтийн орон сууцны барилгын зохистой харьцааг тогтоох, өөрийн гэсэн өнгө төрхтэй, бие даасан бичил орчин үүсгэх, хувийн орон сууцны төрлийг түлхүү байрлуулах, хороолол бүрт амралт, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх парк, цэцэрлэгт хүрээлэн, эрүүлжүүлэх бялдаржуулах төвүүд байрлахаар тооцлоо.





37. Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн Архитектур-орон зайн бүтцийг бүхэлд нь дизайнын хувьд Олон улсын болон бүсийн тулгуур төвийн хотын шаардлагыг хангасан орчин үеийн хотын түвшинд төлөвлөнө. Суурьшлын бүсийн барилгажсан нутаг дэвсгэрийг хотын төв болон гол гудамж замын хүрээгээр хязгаарласан орон сууцны иж бүрдэл бүхий цогцолбор хорооллоор барилгажуулна.

38. Суурьшлын бүсийн орон зайн төлөвлөлтийн хоёр дахь зарчим нь орон сууцны барилгажилт, төлөвлөлт-орон зайн бүтэц, нутаг дэвсгэр зохион байгуулалтын хувьд бие даасан бичил хорооллын зарчмаар барилгажина. Ингэснээр Орчиндоо хортой нөлөөгүй жижиг дунд үйлдвэрүүдийг суурьшлын бүсийн хорооллуудтай зэрэгцүүлэн байрлуулж, үйлдвэрлэл-суурьшлын нэгдсэн орчин бий болно. Суурьшлын бүсийн архитектурын энэ орчин хотын бусад төвтэй хосолж, архитектур орон зайн нэгдсэн чуулбар үүсгэнэ.

39. Суурьшлын бүсийн эдэлбэр газарт нэвтрэх тээврийн хэрэгслийн орц, үргэлжилсэн барилгын доогуур гарах нэвт гарцын хоорондын зай 300 м-ээс ихгүй байна. Эдгээр орцын зам нь хөдөлгөөний зориулалттай гол гудамж, замын зорчих хэсэгтээ огтлолцохдоо замын уулзварын тээврийн хэрэгсэл зогсох тэмдгээс 50 м-ээс багагүй, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолоос 20 м-ээс багагүй зайд огтолцоно. Орон сууцны хорооллын эдэлбэр газарт 2 зурвастай зам төлөвлөнө. Барилгын орцны орчинд замын өргөн 5.5 м-ээс багагүй байна.

40. Суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээ, амьдрах хүн амын тоо тэдний эрхэлж байгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрөл чиглэлээр хотын сууцны хорооллуудыг зохион байгуулж, хүн амын соёл-олон нийт, ахуй үйлчилгээний иж бүрэн цогцолборын хамт сууцны нутаг дэвсгэрийн нэгдсэн нэг хорооллын бүтцэд оруулж суурьшлын нутаг дэвсгэрийн цомхон систем үүсгэж хөгжүүлнэ. Үүний тулд орчиндоо хортой нөлөөгүй жижиг дунд үйлдвэрүүдийг суурьшлын бүстэй нэгтгэн зохион байгуулж, үйлдвэрлэл – суурьшлын нэгдсэн бүс болгох замаар шийдвэрлэнэ. Энэ бүс нутгийг 800-1200 м-ийн радиусын хүрээнд байгаа суурьшлын бүсэд бүслүүртэй нь уялдуулан хөгжүүлнэ. Ингэснээр “орон сууцны нутаг дэвсгэрийн цогцолбор” гэсэн төлөвлөлтийн шинэ хэлбэрт шилжинэ.



41. Суурьшлын бүсийн орон сууцны эдлэн газрын хэмжээг тодорхойлохдоо хотын зэрэглэл, шинээр барих орон сууцны барилгын хэв шинж, сууцны нутаг дэвсгэрийн хэлбэршиж тогтсон орон зайн болон зам харилцааны өнөөгийн систем, хотын ерөнхий бүтэц дэх барилга байгууламжийн байршил хот байгуулалтын онцлог нөхцөл байдлуудыг үндэслэнэ. Сууцны эдэлбэр газрын хэмжээ доод хязгаар 400 м<sup>2</sup> байна. Тухайлбал: Эдэлбэр газартай сууцны 1, 2, айлын 1-2 давхар барилгыг цөөн хүн амтай хотын нөөц нутаг дэвсгэр, захын бүсэд байрлуулна. Орон сууцны 200-400 м<sup>2</sup> эдэлбэр газрын талбайтай 1, 2, 4 айлын 1-2 давхар барилгыг хотын захын бүс, нөөц бүсэнд болон хотын алслагдсан бүсэнд байрлуулна. Энэ бүсэд тээврийн хэрэгслээр 30-40 минут зорчин очно.

42. Орон сууцны 60-100 м<sup>2</sup> эдэлбэр газартай 1, 2, 3 давхар олон айлын сууцыг блокчилсон хэв шинжийн барилгаар эсвэл эзэлхүүн орон зайн бүтцийн хувьд ярвигтай сууцны хэв шинжээр нутаг дэвсгэрийн өндөр нягтралтай барилгажуулж, хотын гэр хороололд 1 өрхөд ногдож байгаа эдэлбэр газрыг дунджаар доод хязгаарыг 80 м<sup>2</sup> –д хүргэнэ.

43. Шинэ хотын үйлдвэрийн болон хотын нийтийн аж ахуйн агуулахын бүсийн орон зайн зохиомжийг үйлдвэрийн болон нийтийн аж ахуйн агуулахын барилга, туслах барилгын үүрэг зориулалт, хүчин чадлыг нарийвчлан тогтоож, цаашид хөгжүүлж, өөрчлөн байгуулах шинэ хандлагыг дэд бүтэц, инженерийн байгууламжтай нь уялдуулан нутаг дэвсгэрийг технологи, ариун цэвэр – эрүүл ахуйн, галын шаардлагын дагуу бүсчилж, ажиллагсадын ажиллах, амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлэх асуудлыг иж бүрэн авч үзэж төлөвлөлөө. Үйлдвэрийн ба суурьшлын бүсийн хоорондын уялдааг үйлдвэрийн ажилчид хамгийн бага хугацаа зарцуулан ирэх оновчтой хүрээлэлд байхаар тооцлоо. Үүнийг үйлдвэрийн ажилчдын орон сууц барих замаар шийдвэрлэнэ. Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг тогтоох, түүнийг эрчимтэй ашиглах тухайн бүсийн хотын орон зайн бүтэц дэх байршлын онцлог, түүний газар нутгийн хот байгуулалтын үнэ цэнэтэй уялдуулан үйлдвэрийн барилгын хэтийн хөгжлийг тооцож газар доорхи орон зайг ашиглах асуудлыг хамтад нь шийднэ.



44. Хотын үйлдвэрийн бүс нь эрхлэх үйлдвэрлэлээсээ шалтгаалан хотын соёл олон нийтийн төвд сууцны барилгажсан нутаг дэвсгэрийн хязгаараас дундажаар 900-1200 м зайнд алслагдах бөгөөд хотын гол гудамж зам нь үйлдвэрийн районыг дайран гарна. Хотын үйлдвэр олноор төвлөрч байрласан бүс нь суурьшлын бүс, хотын төвөөс агаарын зайн шулуунаар 3.2 км замын сүлжээгээр 3.8 км, зайгаар алслагдах бөгөөд явганаар 40 мин, тээврийн хэрэгслээр 15 минут зорчиж очихоор байна. Мөн үйлдвэрийн бүсийг өргөжүүлэн хөгжүүлэх хэтийн чиглэлийг нэг мөр тооцож хотын төвөөс 2.5 км зайтай байрлуулна. Тэнд тээврийн хэрэгслээр 10-15 минут явганаар 30-35 мин зорчин очихоор байна.

45. Нийтийн хэрэгцээний энэ ногоон бүсийн нутаг дэвсгэрийг усан оргилуур, усан сан, шат, налуу зам, саравч, гэрэлтүүлэг цэцгийн мандал зэрэг архитектурын жижиг хэлбэрээр тоноглож тохижуулна. Хотын амралт зугаалгын бүсийн үүргийн энэ цэцэрлэгт хүрээлэн гүйцэтгэнэ. Амралтын бүсийн замын сүлжээ, явган замын хөдөлгөөний чиглэлийн дагуу байхаар тооцож, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, тоглоомын болон спортын талбайд хамгийн дөт зайнд явж хүрэхээр байна. Нэг хүнд ногдох явган зам бүрийн өргөний доод хэмжээ 0.75 м байна.

46. Хот төлөвлөлт, байгуулалт, хүн амын нутагшил суурьшил суурьшлын уялдааны асуудал бол аль ч улс оронд онцгой ач холбогдолтой байдаг. Нүүдэлчин удам угсаатай бидний цөөхөн хэдхэн монголчуудын хувьд хот суурин барьж байгуулж сууршин амьдрах асуудал тийм ч хялбар амар биш байсан бөгөөд энэ талаар алдаж онож будилж байсан түүхийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ Монголын маань хот тосгоны хөгжлийн түүх үнэхээр арвин гэдгийг дараагийн хэд хэдэн үеийн ангиллаас мэдэрч болно. Туахйлбал хувьсгалын өмнөх Монгол оронд “шашин”, худалдаа арилжааны, цэрэг хамгаалалтын, нийгэм улс төрийн үүрэг зориулалттай хот тосгон архитектурын байгууламж зонхилж байсан бол хувьсгалын дараахан үеэс 1960-аад оныг хүртэл Зөвлөлт холбоот улсад баригдаж байсан архитектуртай барилга байгууламж зонхилон баригдаж байсан түүхтэй. Харин 1960-аад оноос социалист системийн гэгддэг өөрөөр хэлбэл СЭВ-ийн орнуудад баригдаж байсан үйлдвэр олон нийтийн эдийн засаг ханхалсан архитектурын байгууламжууд баригдаж байжээ.







## НОМ ЗҮЙ

### НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ ХӨГЖЛИЙН ЗАРИМ ТУЛГУУР БАРИМТ БИЧИГ

1. Монгол Улсын үндсэн хууль УБ;1992.
2. Хот байгуулалтын тухай хууль
3. Барилгын тухай хууль
4. Орон сууцны тухай хууль
5. **“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”**. УИХ-ын 56 дугаар тогтоол; “Төрийн мэдээлэл” сэтгүүл. УБ; 1994, №9
6. **“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”**. УБ; 1994
7. **“Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”**. УИХ-ын 26 дугаар тогтоол, УБ. 1996.05.03
8. **“Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл”**. УБ; 2004
9. **“Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”**. УБ;1999
10. **“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”**. “Төрийн мэдээлэл” сэтгүүл 2001. №28(215)
11. **“Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стартеги”** (2010 он хүртэл), Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ; 2003. Хууд 51-120
12. **“Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай”** Монгол улсын хууль. Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ; 2003, Хууд. 39-49
13. **“Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай”** УИХ-ын тогтоол. Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ; 2003. Хууд 38
14. **“Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”**, УИХ-ын 54 дүгээр тогтоол. УБ; 2003
15. **“Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн үзэл баримтлал”**. УБ; 1999
16. Монгол Улсын Засгийн газрын **“Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”**-ийн бодлого баримт бичиг. УБ; 2001
17. **“Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги”**-ийн баримт бичиг. УБ, 2003



## **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ХОЛБООТОЙ ТӨРӨЛЖСӨН ЗАРИМ ХӨТӨЛБӨР**

18. “Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр” УБ; 1998
19. “Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”. УБ; 1998
20. “Эрдэс баялаг хөтөлбөр”. УБ; 1998
21. “Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр”. УБ; 1998
22. “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”. УБ; 2001
23. “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр”. УБ; 2001
24. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үндэсний хөтөлбөр”. УБ; 2001
25. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр”. УБ; 2002
26. “Орон сууц үндэсний хөтөлбөр”. УБ; 2002

## **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

27. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшин” судалгаа 2000. ҮСГ, УБ; 2001
28. “Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо” ҮСГ, УБ; 2002
29. “Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд” ҮСГ, УБ; 2003
30. “Монгол Улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалт”-ын асуудал. УБ; 2001
31. “Тогтвортой хөгжил” дэлхийн баримт бичгүүд. УБ; 2002
32. “Монгол Улсын XXI зууны хөгжлийн язгуур шинж” УБ, 2002
33. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” Үндэсний хөгжлийн хүрээлэн. УБ; 2003
34. “Монголын хүний хөгжлийн илтгэл” 2003. НҮБХХ. УБ; 2003
35. “Монгол орны байгаль орчин”. УБ; 1996
36. Guidelines for integrating women’s concerns into development planning in Asia and The Pacific. Economic and Social Commission for Asia and The Pacific. United Nations , New York, 1991
37. Training Module on Integrated Population and Planning Philippine, 1993. Manila
38. Mark blang Economic theory in retrospect. Cambridge. 1997
39. World Bank “RMSM modules guideline’s. 1998



40. "A New Strategy for the Environment" Policy Brief, OECD, Observer, July 2001
41. World Economic and Financial Surveys 3World economic outlook-May 2001". The information Tehnology Revolution-International Monetary Fund
42. UNDP Report Office on Human Development (march 2001), "UNDP Corporate Policy on NHDRs".
43. UNESCAP (2001), "Reducing Disparities : Balanced Development of Urban and Rural Areas and Regions Within The Countries of Asia and The Pacific.
44. The World Bank (2001), "Chapter 2: Rural-Urban and Regional Disparities"
45. World Development Indicators-2001. World Bank
46. Fundamental issues affecting sustainability of the Mongolian Khangai. IISNC Ulaanbaatar, 2002

**ДӨРӨВ. ТӨР БОДЛОГО, УЛС ТӨРЧИД, ЭРДЭМТЭД СУДЛААЧДЫН  
ТУУРВИСАН ЗАРИМ БҮТЭЭЛ (МОНГОЛ, АНГЛИ ХЭЛ ДЭЭР)**

47. Багабанди Н. Шинэ зууны өмнөх бодлого, зорилт. УБ;1998
48. Дагвадорж Д., Цэдэндамба Л., **"Баруун бүсийн тогтвортой хөгжлийн технологи 2002"** сэдэвт онол практикийн бага хурлын материалын эмхэтгэл. УБ; 2002
49. Дагвадорж Д., **"Тулхтай хөгжил-Монголын ирээдүй"**. УБ; 2002
50. Доржнамжаа Д., Будням С., Хаумдас А., **"Эрдэс түхий эдийн нөөц баялаг, чадамж тогтвортой хөгжилд нөлөөлөх үндэс мөн"**. "Монгол улсын хөгжлийн судалгаа" сэтгүүл, 2002, №1
51. Жаргалсайхан Ж. Макро эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа. **"Монгол улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө"** сэдэвт онол практикийн бага хуралд тавьсан илтгэл. Уб, 2002
52. Лувсандорж П., бусад Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага. УБ; Манчестер. 1999
53. Нямзагд С. Үндэсний эдийн засгийн стратегийн удирдлага. I-лiбoть, УБ; 2001
54. Насанжаргал Д. **"Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн асуудлууд, цаашдын хандлага"**. "Монгол улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө" сэдэвт онол практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ; 2002



55. Очирбат П. **“Үнэт эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи”**. УБ; 2000
56. Очирбат П. **Эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи**. УБ; 1998
57. Ринчинбазар Р. **“Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд”**. УБ; 2004
58. Хаумдас А. **“Монгол орны уул уурхай, металлургийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал ба түүний ирээдүй”**. Монгол Улсын хөгжлийн судалгаа сэтгүүл. 2002, №1
59. Цэдэндамба Л., Тэрбиш Д., Бүсчилсэн хөгжлийн бодлого ба засаг захиргаанутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлийн асуудлууд. Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль, УБ; 2005, хуудас 145-158
60. Цэдэндамба Л., Жаргалсайхан Ж., Бадарч Д., Баярхүү Ц. **“Оюу толгойн зэс, алт, мөнгөний холимог ордыг ашигласнаар Монгол Улсын болон бүс нутаг, орон нутгийн эдийн засгийн хөгжилд гарах өөрчлөлт, шууд болон шууд бус нөлөөллийн үнэлгээ”** (Эрдэм шинжилгээний ажлын тайлан). УБ; 2004
61. Цэдэндамба Л. Бусад. **“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал ба бүс нутгийн хөгжил.”** Монгол УЛсын хөгжлийн судалгаа сэтгүүл 2003, №1, УБ;
62. Цэдэндамба Л., Ринчинбазар Р. **“Бүс нутгууд дэхь ядуурлын асуудлууд”**. Монгол Улсын хөгжлийн судалгаа сэтгүүл 2003, №1. УБ; 2003
63. Цэдэндамба Л., Гансэлэм Д. **“Эдийн засгийн бүсүүдийн мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн чадавхи (потенциаль)-ийн үнэлгээ”**. Монгол Улсын хөгжлийн судалгаа сэтгүүл, 2003, №1. УБ; 2003
64. Цэдэндамба Л. Гансэлэм Д. **“Эдийн засгийн бүсүүдийн үйлдвэрлэлийн дэд бүтэц”** (төрөл бүрийн зам, эрчим хүч, харилцаа холбоо)-ийн хөгжлийн өнөөгийн байдал, үнэлгээ. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл. 2003, №1. УБ; 2003
65. Цэдэндамба Л., Хайсамбуу Д. бусад. **“Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийн төв (хот суурин газар)-ын хөгжлийг төрөөс дэмжих онолын**





- үндэслэл, арга зам**” сэдэвт шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд явуулсан судалгаа шинжилгээний ажлын урьдчилсан тайлан. Үндэсний хөгжлийн хүрээлэн. УБ; 2003
66. Цэдэндамба Л., Ринчинбазар Р. Ядуурлыг бууруулах стратегид Монгол Улсын бүс нутгуудын ядуурлын асуудлуудыг оновчтой тусгах шаардлага, зарим арга зам, Дэлхийн банкнаас “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг” боловсруулж байгаа орнуудад зориулан зохион байгуулсан видео хуралд тавьсан илтгэл. УБ; 2002
67. Цэдэндамба Л., Хайсамбуу Д., Намжилмаа С. **“Монгол улсад бүс нутгийн хот суурин газруудын ангилал, зэрэглэл боловсруулах арга зүйн асуудалд”**. БАК-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2001/1. х175-187
68. Цэдэндамба Л. “Бүсчилсэн хөгжлийн онол практикийн асуудлууд”. Монгол Улсын өрнөд бүс ном. УБ; 1999. Х8-72
69. Цэдэндамба Л. **“Бүсчилэн хөгжүүлж амжилт олсон орнууд бий, тэднээс сурцгаая”**. Өнөөдөр сонин. 1999.05.03 №101 (65)
70. Чадраа Б., Цэдэндамба Л. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн шинжлэх ухааны үндэслэл” товхимол. УБ; 2001
71. Чинзориг С. **“Монгол Улсын Засгийн газраас хүн амын ядуурлыг бууруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт”**. Монгол Улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө сэдэвт онол практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ; 2002
72. Allen G. Noble., Frank J. Costa., and others. **Regional Development and Planning for the 21 st century**. UK, 2000
73. Benjamin Higgins., Donald J. Savoie. **Regional development theories and their application USA**, 1995, world bank
74. **Cadman Atta, Mills Ray Nallar Analytical approaches to stabilization and adjustment programs** World bank. 1995
75. Dennis A. Rondinelli. **“Applied methods of regional analysis: The spatial dimensions of development policy”**. USA, 1985
76. Daniel Felsenstein., Ronald McQuaid., and others. Public investment and regional economic development .UK, 2001



77. Handbook of Development Economics, volume 16 Elsever 2002

**ТАВ. ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, АРХИТЕКТУРЫН БАРИМТ БИЧИГ**

78. Хайсамбуу Д. нар **”Монголын хот төлөвлөлтийн үндсэн зарчим, хэтийн төлөв үндэсний хөтөлбөр”** тайлан. УБ; 2009 он
79. **”Хотжилт ба бага орлоготой иргэдийн орон сууцны хэрэгцээ”**. Үндэсний хэлэлцүүлэг, 2005. УБ; МУЗГазар, МУБ-ын АН. ДБЭЗНК
80. **”Монголын Архитектурын Эвлэл”**. УБ; 2011,
81. Майдар Д. **”Монголын архитектур ба хот байгуулалт тойм”**. УБ; 1972.
82. Дашжамц Д., Зулзагабаатар Ж., Намхайжанцан Г., Биндэрьяа З., **”Монгол орны геотехникийн нөхцөл инженерийн лавлах”**. УБ; 2001, (II бүлэг 4 дүгээр хэсэг)
83. Н.М. Сноляр. Канд. Арх. **”Генеральные планы новых городов” /методические пособие по проектированию/** Москва; 2003.
84. Н.В. Баранов. **”Композиция центра города”** Доктор архитектуры Москва; 2004.
85. Авдотьев Л.Н., проф. Арх. Амракетов Д.П., проф. док. арх. Бархин Б.Г. проф. док. арх. **”Архитектурное проектирование общественных зданий и сооружение”**. Москва; 2005.
86. Градов Г.А., док. арх. проф. **”Город быт” /Системы и типов общественных зданий/** Москва; 1998.
87. Шквариков В.А., док. арх. проф.. Колла Н.Я., док. арх. проф., Лавров В.А., док. арх. проф. Хауке М.О., док. арх. проф., **Градостроительство. СССР. Том I, II,** Москва; 1997.
88. Майдар Д., **”Монголын их барилга”** УБ. 1972.
89. Иодо Н.А. **”Основы градостроительство /теория методология”/** Минск; 2003г.
90. Бранов Н., док. арх. проф., Шквариков В., док. арх. проф., Градов Г., док. арх. проф., Кулага Л., док. арх. проф., **”Основы советского градостроительство”** Москва; 1997.



91. Майдар Д., док., Пюрвеев О., док. **“От кочевой мобильной архитектуры”** Москва; 1980.
92. Залеская Л.С., канд. Арх., **“Ландшафтная архитектуры”** Москва; 1963.
93. **“Architecture and Cosociety”**. Болгария. София; 1998.
94. МУЗГазар. **“Баруун бүсийн хөгжил шинжлэх ухаан технологи”** /Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/ УБ. 2010.
95. Алесеев. док. арх. проф., **“История архитектуры градостроительство и дизайна”** Москва; 2004.
96. ШУАкадеми. **“Монгол Улсын Өрнөд бүс”** /Бүсчилсэн хөгжлийн онол, практикийн асуудлууд/ УБ; 1999.
97. **Architecture Asia**. /ARCASIA/ 2011.
98. **Architecture Asia**. /ARCASIA/ 2012.
99. **Architecture Asia**. /ARCASIA/ 2013.
100. “Кензэдо Танге” **Архитектура Японии /традиция и современность**. Изд. Прогресс. Москва; 1975.
101. Алвар Аалто **“Архитектура и гуманизм”** Москва; 1978.
102. **“Architecture explained”**. Hond Kong; 2012.
103. Ранпапорт А.Г., док. арх., Сомов Г.Ю. док. арх., **“Форма в архитектуре”** /проблемы теории и методологии/ Москва; 1999.
104. Нестеров В.А., док. арх., Калмыков И.Г., док. арх. **“Архитектура”** Москва; 1995.
105. Былинкина Н., док. арх., Володина П., док. арх., Минервана Г., док. арх. **“Вопросы теории архитектуры”** Москва; 1958.
106. Шевдова К.К., /канд. тех. наук. проф./ **“Архитектура гражданских и промышленных зданий”** /том I, II, III./ Москва; 1993.
107. Майдар Д., Окладников А.П., **“Монголын түүх соёлын дурсгалт зүйлс”** Москва; 1981.
108. Хайсамбуу Д. **“Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт сургууль, сурагчдын дотуур байрын зураг төсөл боловсруулах үндэсний норм, дүрэм”** (ном). БНБД-65-79”, (10х/х). Хишигт А.



109. Хайсамбуу Д.нар. **“Сургалт, хүмүүжлийн барилга байгууламжийг 1980-1990 онд төлөвлөх норматив үзүүлэлтүүд, байршлын схем, хэв шинжийн нэр төрлүүд, 5 жилийн төлөвлөлтийн үндсэн баримт бичиг”.**, (ТОВХИМОЛ). УБ; 1980.
110. Хайсамбуу Д.нар. **“Номенклатура типов общественных зданий для городского и сельского строительства (для типового проектирования на период 1980-1985 и 1986-1990г.г), 1981г.г, 1984г., раздел – номенклатура типов учебно-воспитательных зданий”.** УБ; 1980.
111. Хайсамбуу Д.нар **“Монгол улсад 1980-2000 онд барих ерөнхий боловсролын сургуулийн барилгын нэр төрөл, өрөө, тасалгааны бүтэц, зохион байгуулалт, архитектур төлөвлөлтийн үндсэн зарчим”.**, (НОМ), АБЯ. УБЗТИ.УТКомисс.
112. **“Принципы организаций сети и новые типы сельских школ в МНР”.** 18.00.02 Диссертации на соискание ученой степени кандидата архитектуры., Москва 1983 г, 2-х томах. 20 п.л
113. Хайсамбуу Д. **“Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан ерөнхий боловсролын сургуулийн барилгын архитектур төлөвлөлтийг өргөтгөн сайжруулах 8 хэв шинжийн өргөтгөлийн барилгын техникийн болон зураг төслийн даалгавар, архитектур, хэв шинж төлөвлөлтийн онолын үндэслэл төлөвлөлтийн схем, эскизүүд”.**, (НОМ). 21х.х УБЗТИ. Улаанбаатар.
114. Хайсамбуу Д., Арх. Литов Б., Хишигт А., **“Ерөнхий боловсролын сургууль дотуур байрт сургууль, дотуур байрын барилгын төлөвлөлтийн нормали элементүүд”.**, ТН-II-2.2-85. Улаанбаатар 1985. (15х/х) (НОМ).
115. Хайсамбуу Д., Бычков Л. М., **“Задание на проектирование ясли – сад на 320 мест и общеобразовательной школы на 16-22 классов с техническими средствами обучения для строительства в Армении”.** Утверждено Госстроем Монголии, 1987 г. (здания построены) Уланбатор.





116. Хайсамбуу Д., Цытович Г., Горнец А., Степанов А. **“Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн төлөвлөлтийн үндэсний нэгдсэн норм ба дүрэм”** БНБД II-66-88. /хүүхдийн ясли цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, тусгай мэргэжлийн болон их дээд сургуулийг хамарсан/ Улан-батора-Москва; 1998,
117. Хайсамбуу Д., **“Монголын архитектур”** Ном 11х.х. УБ; 1999.
118. , Батчимэг Р. нар. **“Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх үндэсний норм ба дүрэм”** БНБД 31.01.01. /үндэсний норматив баримт бичиг/ УБ; 2001. 18х.х.
119. Хайсамбуу Д. **“Олон нийтийн барилгын зураг төсөл төлөвлөлтийн үндэсний норм ба дүрэм”**. БНБД31.03.03. инженерийн байгууламжийн хэсгийг (2х.х) Р.Батчимэг нар. УБ; 2002.
120. **“Захиргаа ба аж ахуйн барилгын зураг төсөл төлөвлөх үндэсний норм ба дүрэм”**. БНБД31.04.03, (үндэсний норматив баримт бичиг), 10х.х. УБ; 2002.
121. Хайсамбуу Д. **“Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал” төлөвлөлтийн үндэсний норм ба дүрэм.** БНБД 21-01-02. (үндэсний норматив баримт бичиг), 15х.х. инженер К.Султанкарим. УБ; 2002.
122. Хайсамбуу Д. **“Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын үндэсний норм ба дүрэм”** БНБД30.01.03, УБ;. 2003. 25 х.х (үндэсний норматив баримт бичиг), (3х.х) инженерийн байгууламжийн хэсгийг (23х.х) Батчимэг П., Өүлэн А., Батчимэг Р.,УБ; 2003.
123. Хайсамбуу Д., Цэдэндамба Г., **“Монгол Улсын Эдийн засгийн бүсийн тулгуур төв хотуудын архитектур төлөвлөлтийн үндэс”** (хүн амын нутагшилт, судалгааны хэсэг) Эрдэм шинжилгээний тайлан. (20х.х)
124. Хайсамбуу Д., Цэдэндамба Г. **“Эдийн засгийн төвийн бүсийн хөгжлийн стратеги, төлөвлөлт”** Эрдэмдийн багийг удирдаж гүйцэтгэгчээр ажилласан. нарын хамт. товхимол 20х.х УБ; 2004



125. Хайсамбуу Д., Лхагваа Б.нар **“Барилгын эрдэм судлалын 40 жилд”** УБ; 2005. 12х.х
126. Хайсамбуу Д. нар **“Монголын Архитектур Хот төлөвлөлтийн үндэсний хөтөлбөр”**. 2006. (товхимол).
127. **“Монгол Архитектурын чимэг”**.2007. Ном. 9х.х. УБ; Хайсамбуу Д.,Адьяа Б.
128. Хайсамбуу Д.нар. “The Survey report of the Study of the living environment of The Ger Area in Ulaanbaatar Mongolia”. (20х.х0)
129. Хайсамбуу Д. Даажав Б., “Монголын уран барилгын нийллэг шинж”, “Гэр Монголын уран барилгын үндэс болох нь”, “Монголын архитектурын чимэг”, “Эрдэнэ зуу хийд”, “Да хүрээ”, “Шашин шүтлэгийн барилгын тэг зураглал”, “Монгол хүний биеийн харьцааны тухай” нэг сэдэвт цуврал 6 бүтээл. ном 901х.х
130. Хайсамбуу Д. нар. **“Барилга, Архитектур, Хот байгуулалтын шинжлэх ухаан 80 жил”** ном
131. Хайсамбуу Д.нар. **“Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх үндэсний норм ба дүрэм”** БНБД31.01.10. (үндэсний норматив баримт бичиг). УБ; 2010.
132. Хайсамбуу Д., Эрдэнэ-Очир Ч. Арх. **“Монголын архитектурын түүх”** /ном/ 25х.х. УБ; 2011.
133. Хайсамбуу Д. нар “Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмжийн нэр төрөл” УБ; УБЗТН, УТК
134. Хайсамбуу Д., Горобец Г. “Изменения в условиях Монголии к главе СНиП-II.65-73 общеобразовательные школы интернаты” /редактор, разработчики архитектурно-тинологических положений документы/ УБ; 1986,
135. **“Проблемы архитектуры и направления преобразования системы и типов учебно-воспитательных зданий Монголии до 2010 года”**.



(особенности формирования и перспективы развития). Диссертация на соискания ученой степени доктора архитектуры. Москва; 1993. 2-х томах.

136. Хайсамбуу Д., Намжилмаа С. **“Дорноговь аймгийн Сайншанд хотын архитектур хот байгуулалтын үндэсний загвар”**. УБ; 1996.
137. Хайсамбуу Д., Энэбиш Т., Цэдэндамбаа Г., Батцэрэг С.нар. **“Монгол улсын бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал”** УИХуралд өргөн барьсан баримт бичиг.







# ХАВСРАЛТУУД





## АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

Архангай аймгийн тогтвортой хөгжлийн эрхэм зорилго, стратегийн зорилт нь экологийн даацын хүрээнд байгалийн нөөц, баялагийг зүй зохистой ашиглан, эдийн засгаа тогтворжуулан хөгжүүлж, бие даан хөгжих үндэс суурийг тавьснаар хүн ард нь эрүүл энх, эрдэм боловсролтой, тансаг хангалуун амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэх ажээ.



62 дугаар зураг

Архангай аймаг Монгол улсын төв хэсэгт Баянхонгор, Хөвсгөл, Завхан, Булган, Өвөрхангай аймагтай хил залгаа оршдог. Өндөр уул, ой, тал хээр хосолсон, 55,3 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй. Нийт нутаг дэвсгэр нь далайн төвшинөөс 1100-3600 метрт өргөгдсөн, Суварга Хайрхан, Баянзүрх, Дулаанхаан, Ноёнхангай, Халзан бүргэдтэйн өндөр уулс, Ар, Өвөр Жаргалант, Бугат,



Бөхөншар, Булганы үзэсгэлэнт уул нурууд, галт уулын дэлбэрэлтээс үүсэж тогтсон Хорго, Сэнжид цохио, Уранмандал, Баян уулын гойд сонин байгаль, Хөх нуур, Гурван тамирын хөндий, Тоглох, Хонгорж, Бургалдайн өргөн талуудтай билээ.

Хангайн нуруунаас эх авсан хойд, урд Тамир, Тэрх, Суман, Гэгчэнэ, Чулуут, Хануй, Хүнүй, Орхон голууд аймгийн нутаг дэвсгэрээр нийтдээ 250-350 км урсахдаа олон гол, голууд ай савандаа нэгтгэж, бэлчээр, хадлан, тариалангийн талбайг тэтгэдэг байна. Тэрхийн Цагаан, Өгий, Дөрөө, Айраг зэрэг 188 нуур, цөөрөм, 674 булаг, шанд, 844 гол, горхи, эмчилгээ, сувиллын ач холбогдол бүхий Ноён-Хангай, Мухар-хужирт, Шивэрт, Хадат, Бор тал, Цагаан сүм, Хануй, Улаан эргийн 50 гаруй халуун, хүйтэн рашаантай юм аймаг юм.

Аймаг 98.4 мянган хүн амтай. Хүн амын 82.2 хувийг хүүхэд, залуучууд, 50.3 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Аймгийн төв – Цэцэрлэг хот 20 гаруй мянган хүн амтай. Архангай аймаг засаг захиргааны 19 сум, 99 багт хуваагддаг, хамгийн ойр сумын төв Цэцэрлэг хотоос 25 км, холынх нь 256 км-т оршдог, аймгийн төв нийслэлээсээ 521 км алсдагдсан аймаг юм.

Эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэл зонхилно. 200,0 орчин мянган малтай, мал сүргийн 20.0 хувь нь үхэр, 46.0 хувь нь хонь юм. Адуу, үхрийн тоогоор аймгуудын дунд гуравдугаарт ордог байна. Мал сүргийн 98.6 хувь нь хувийн аж ахуйн мэдэлд байдаг. Хүнс-Архангай, Элч-Архангай, Авто зам, Шинэ-Өргөө, Тансагтрейд, Бээт, Хас-у-мандал зэрэг хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний болон худалдаа арилжааны 600 гаруй аж ахуйн нэгж, ерөнхий боловсролын 32 сургууль, соёл, урлагийн 40 шахам цэг, салбар, Гэлэг хувийн дээд сургууль, багшийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв үйлчлэн, сум дундын эмнэлэг 2, сумын эмнэлэг 15, төрөлжсөн эмнэлэг 1 ажиллаж байна. Тус аймгийн нийгэм эдийн засгийн байдлын одоо ирээдүйн талаархи судалга үнэлгээ.

**Нэг. Хүн амын өсөлт, хөгжил.** Хүн амын тухайд 5 жилийн өмнөх оны эцэст аймгийн хүн ам 98441 болж 1990 оноос 11087 хүнээр нэмэгдэж, 1995 оноос 2401 хүнээр буурчээ. Хүн амын 50.3 хувь нь эмэгтэй, 39.9 хувь нь аймаг, сумын





төвд, 60.1 хувь нь хөдөөд амьдардаг ажээ. Аймгийн хэмжээгээр 24.5 мянган өрх байгаагийн 18.6 хувь буюу 4.7 мянган өрх аймгийн төвд суурьшдаг. Хүн амын цэвэр өсөлтийг сүүлийн 7 жилийн дунджаар авч үзвэл 2.1 хувь байжээ.

Олон улсын хүн ам зүйн үзүүлэлтээр цэвэр өсөлтийн хувь 0.1-0.5 хувь байвал өсөлт удааширсан, 0.6-0.1 байвал хүн ам дунд зэрэг өсч байгаа, 1.1-2.0 байвал хүн ам хурдан өсч байна гэж үздэг ажээ. Эндээс харвал аймгийн хүн ам түргэн өсөлттэй байна. 1996 оны статистикийн мэдээгээр цэвэр өсөлтийн дундаж улсынх 1.6, аймгийнх 1.8 хувь болсон нь хүн амын өсөлт өндөр хурдацтай байна.

НҮБ-ын Хүн амын сангийн эксперт, судлаачдын гаргасан судалгаагаар хүн амын цэвэр өсөлт ойрын 10 жилд 2.2 хувь, төрөх насны эмэгтэйчүүдийн тоо жил бүр 3.2-3.5 хувиар өсөхөөр тооцогдсон нь хүн амын тоо өсөх хандлагатай байна гэж үзжээ.

Хүн амын тогтвор сууьшлын тухайд сүүлийн 3-5 жилийн оны байдлаар 990 хүн шилжин явсныг насны бүлгээр авч үзэхэд 26.6 хувь нь 0-15 насны хүүхэд, 61.3 хувь нь хөдөлмөрийн насны, 12.1 хувь нь өндөр настан байжээ. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай 47.3 мянган хүн байгаагийн 39.7 мянга нь хөдөлмөр эрхэлж, 6.1 мянга нь хөдөлмөр эрхлээгүй, үлдсэн хэсэг нь хөдөлмөрийн нөөц ашиглалтын 1996 оны тайлангаар хөдөлмөрийн биржид бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж байгаа 2257 хүний 54.3% нь мэргэжилгүй, 15.2% нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн болон богино хугацааны дамжаагаар мэргэжил эзэмшсэн, ажлын дадлага, туршлагагүй залуучууд, үүний 51.1% нь эмэгтэйчүүд байжээ. Ажилгүйдлийн түвшин 5.2% болсон байна.

Сүүлийн 3 жилийн судалгаагаар ажил идэвхтэй эрж байгаа 2257 хүний 35 нь дээд боловсролтой, 158 нь тусгай дунд боловсролтой, 56 нь коллеж, 1370 нь ерөнхий боловсролтой сургууль, 285 нь мэргэжлийн сургалт, үйлдвэрийн сургууль төгссөн, 353 нь мэргэжилгүй хүмүүс байна. Ажилгүйчүүдийн 61.8% нь аймгийн төвд, жил бүр хөдөлмөрийн насанд орж байгаа 800 гаруй залуучуудын 70 шахам хувь нь тухайн жилдээ ажил, сургуульд хамрагдаж чадахгүй байгаа нь судалгаагаар тогтоогджээ.



**Хоёр. Хүн амын хэрэлээний бүтцийн өөрчлөлт.** Хот суурингийн иргэд хүнсэндээ ихэвчлэн 8 төрлийн бүтээгдэхүүн хэрэглэж байхад хөдөөгийн хүн амын цахилгаан, дулааны хэрэглээ хязгаарлагдмал, малчид бол бараг ийм төрлийн хэрэглээгүй, төвийн эрчим хүчний системд холбоогүй сумдын төвийн хүн ам цахилгааны байнгын гачигдалд байдаг байна.

**Гурав. Ядуурлын асуудал.** Аймгийн хүн амын 27.9% буюу 27900 орчим хүн ядуу, үүний 24.1% буюу 6700 хүн нэн ядуу, нийт өрхийн 25.8% буюу 6601 өрх ядуу, үүний 24.6% буюу 1620 өрх нэн ядуу байна. Ядуу өрхийн 855-ыг эмэгтэйчүүд толгойлж байгаагын 50.9% нь нэн ядуу байна. Ядуу бүх өрхийн 50.7% нь 2-5 ам бүлтэй, 32.6% нь 8 хүртэл ам бүлтэй байгаагын сацуу ажил эрхэлдэггүй өрх нийт өрхийн 22.3%-ийг эзлэж байна. Ядуу нийт өрхийн 20.5% нь 0-15 насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, амьдралын ядуу зүдүү байдлаас үүдэн 468 хүүхэд сургууль завсардажээ. Ядуу өрхийн нэг хүнд ногдох орлогоор нь авч үзвэл сарын 1000 хүртэл төгрөгийн орлоготой өрх 1440 байгаа нь нэн ядуу амьдралгүй өрхийн тоо нэмэгдэснийг харуулж байна. Ядуу амьдралтай өрхийн 914 нь малгүй, 89 өрх нь орох оронгүй байна. Ядуу хүмүүсийн ихэнхи нь тэтгэврийн насны болон ямар нэг ажил хийдэг боловч орлого нь бага хүмүүс байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа 1990 оноос өмнө зогссон, түүхий эд материал, хөрөнхө, санхүүгийн байдлаас шалтгаалж аж ахуйн нэгжүүд улирлын чанартай ажиллах болж, хөдөлмөрийн хөлсний хэмжээ бууран, хүнсний болон өргөн хэрэглээний барааны нийлүүлэлт эрэлтээс хоцорч, үнэ, тариф өсөн, ажилгүйчүүдийн тоо эрс нэмэгдэж, мөнгөний худалдан авах чадвар доройтож, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ хямд, малчдын зах зээлийн харилцааны мэдлэг хомс, мэдээлэл үгүйлэгдэж, зам, харилцаа холбоо муу хөгжсөн зэрэг нийгмийн болон хувь хүний амьдралын олон хүчин зүйл ядууралд хүн амын бараг 1/3 буюу үндсэндээ нийгмээрээ ороход хүргэжээ.

**Дөрөв. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах.** Нийгмийн эрүүл мэндийн төвийн харьяа нэгдсэн эмнэлэг, 19 сумын эмнэлэг, 71 багийн эмч, 22 эмийн сан, 9 хувийн хэвшлийн эмнэлэг, үйлчилгээний цэгүүд эрүүл мэндийн анхан шатны халамж, үйлчилгээ үзүүлдэг байна. Эдгээр байгууллагад 155 их эмч, 470 гаруй



эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж, 805 ортой байгаа ба 10000 хүнд 15.7 их эмч, 47.7 эмнэлгийн дунд мэргэжилтэн, 87.7 эмнэлгийн ор ногдож байна. Сумын эмнэлгүүд 2-7 их эмч, эмнэлгийн ор ногддог байна. Сумын эмнэлгүүд 2-7 их эмчтэй төдийгүй, эмнэлгийн ор, дээд, дунд мэргэжилтний хүрэлцээ бусад аймгаас дээгүүр юм.

Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, түргэн тусламжийн унаа, эмийн бэлэн лабораторийн урвалж, бодисын хангамж доройтсоноос эмчилгээ, оношлогоо саатаж, гэрийн төрөлт, эхийн эндэгдэл нэмэгдэж, хувийн болон хот, суурин газрын ариун ариун цэвэр муу байгаагаас өвчлөл ихсжээ. Импортын болон дотоодын үйлдвэрийн хүсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйд тавих хяналт суларснаас хоол боловсруулах замын болон бусад эрхтэн, системийн өвчлөл нэмэгдэжээ. Хүн амын дунд амьсгалын зам, цусны эргэлтийн систем, хоол боловсруулах систем, шээс, бэлгийнзамын эрхтэн, сэтгэцийн эмгэгийн өвчлөл их байгаа нь газар нутаг өндөрлөг, уулархаг, эрс тэс уур амьсгалтай, хэрэглэж байгаа хоол, хүнс нь тослог өөх, давс ихтэй, ногоо бараг хэрэглэдэггүйтэй холбоотой ажээ.

Эх, хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэд, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн гишүүдэд зэрэг нийгмийн эмзэг бүлэг, хөдөөгийн хүн ам, ялангуяа малчид, тариаланчдын эрүүл мэндийг онцгойлон анхаарах асуудал эдүгээ урьд урьдынхаасаа илүү хурц тавигдах болжээ. Тус аймгийн хүн амын 48.9%-ийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлдэг байна.

Ерөнхий боловсролын сургуулийг жил бүр дунджаар 1400 хүүхэд төгсөж, ихэнхи нь ажилгүйчүүдийн эгнээнд шилждэг ажээ. Хүн амын эмзэг хэсгийн хамрах хүрээ өргөжиж, хүүхэд, эхийн эрүүл мэндийн асуудал гол төлөв эрүүл мэндийн байгууллагын хариуцах мэргэжлийн ажил мэт буруу ойлголт газар авснаас хүмүүсийн аж амьдралын түвшин, аж төрөх ёс, хоол, хүнс, ухамсар, мэдлэг, чөлөөт цаг, ахуй орчин, хувь хүний анхаарал халамж зэрэг эх, хүүхдийн эрүүл мэндэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх олон хүчин зүйлийг дутуу үнэлж ирсэн нь эл асуудлыг ул суурьтай шийдвэрлэхэд үлэмж бэрхшээл учруулж байгаа ажээ.



**Тав. Хүн амын нутагшилт суурьшил.** Аймгийн газрын гадаргуу, уур амьсгал, ой, ургамалын бүрхэвчийн хувьд нутгийн баруун өмнө хэсгийн 3000 м – ээс дээш өргөгдсөн хэсэг нь аж ахуй эрхлэхэд тохиромжгүй, 2500-3000 м өндөрт өргөгдсөн мужид нь мал аж ахуй эрхлэхэд хязгаарлагдмал, амралт, жуулчлал, барилга байгууламж барьж байгуулахад тохиромжгүй, нутгийн бусад хэсэг нь мал аж ахуй, барилга байгууламж, амралт, жуулчлалд тохиромжгүй гэж үздэг ажээ.

Тус аймаг нь засаг захиргааны хувиараар 1 хот, 18 сумтай, сумдын төвийн 70 гаруй хувийг цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбосон нь хүн амын нутагшил, суурьшилд эерэг нөлөөтэй байгаа боловч зах зээлээс алслагдсан, дулаан хангамжийн төвлөрсөн системгүй нь эмнэлэг, сургууль, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд бэрхшээл учруулж улмаар хүн амын нутагшил, суурьшил сөргөөр нөлөөлдөг ажээ.

Аймгийн төвөөс хамгийн их алслагдсан сумын төв 238 км, багийн төв 300 гаруй км-т байгаа бөгөөд хүн амын дийлэнх нь эмнэлэг, соёл, урлаг зэрэг нийгмийн төдийгүй худалдааны үйлчилгээнээс хэт холдож, зах зээлээс алслагдмал байдалтай байна. Сум, аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн ойролцоо шилжин суурьших нь сүүлийн жилд нэлээд нэмэгдэжээ.

Аймаг, сумын төвд нийт хүн амын 40% оршин суудаг байна. Ихтамир, Хайрхан, Эрдэнэмандал, Тариат, Хотонт, Цэнхэр сумдад хүн ам илүү суурьшсан байна. Нийт нутаг дэвсгэр хүн ам байрших, хот байгуулалтанд тохиромжтой, 1000 хүнд 14 га талбай ногдож байгаа нь хүн амын төвлөрөл алслагдсан нутаг эзгүйрч, төв суурин газрын орчимд хүн ам, мал бөөгнөрч, ургамлын бүтцийг эвдэх болжээ. Энэ нь эмнэлгийн үйлчилгээ, Сургуульд ойр байх, малын хулгай, дээрэм тонуулаас болгоомжилсонтой холбоотой юм байна.

**Зургаа. Аймгийн хот төлөвлөлт, байгуулалт.** Цахираас бусад бүх суманд ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, инженерийн шугам сүлжээгээр хангагдсан байна. Хангай, Цахир, Өндөр-Улаан, Тариат сумдын төв нь мөнхийн цэвдэгтэй бүсэд оршдог учир хот байгуулалтад бэрхшээл учруулдаг ажээ. Бүх сумын төв төвлөрсөн ариутгал татуурга, цэвэрлэгээний байгууламжгүй, гэр





хорооллын айл өрхийн бохир усыг ямар ч цэвэрлэгээ, ариутгалгүйгээр орчиндоо ил задгай асгадаг байна. Ихэнхи сумын хүн ам булаг, шанд, гол, горхины усыг унд, ахуйн хэрэгцээнд шууд хэрэглэсээр байна.

Аймаг, сумын төвийг анх барьж байгуулахдаа хот байгуулалт, байгаль орчинд нөлөөлөх зэрэг сөрөг талыг нарийн төлөвлөгөөгүй орхигдуулжээ. Бүх сум төвлөрсөн уурын зуух, инженерийн шугам сүлжээгүйгээс агаар, хөрс бохирдсоор байна. Аймгийн төв, зарим сумын төвийн гэр хорооллын одоогийн зохион байгуулалт нь иргэдийн ая тохитой амьдрахад сөрөг нөлөө үзүүлдэг болжээ. Тухайлбал, Цэцэрлэг хотын гэр хорооллын зохион байгуулалт олон талын бэрхшээл учруулж байна.

Цэцэрлэг хот нь манай орны хангайн бүсэд хангайн нурууны салбар Тойны нурууны нэг салбар Булган уулын өвөрт байрладаг, эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн бөгөөд далайн түвшинээс дээш 1650 метр өргөгдсөн. Жилд дунджаар 346 мм хур тунадас унадаг ажээ. Агаарын харьцангуй чийглэг 55% байдаг. Салхи гол төлөв баруун хойноосоо секундэд 2.6 метрийн хурдтай үлээдэг байна. Цэцэрлэг хотын байгуулалт 1963 онд боловсруулсан тойм зургийн дагуу эхэлсэн бөгөөд 1984 оноос 2005 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг суурьшлын, үйлдвэрлэлийн, амралт зугаалгын гэсэн 3 бүсээр төлөвлөж зохион байгуулсан боловч төлөвлөсөн ёсоор барилга байгууламжийг хугацаанд нь бариагүй, байршил нь өөрчлөгдсөнөөс гадна төлөвлөлт нь өнөөгийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн бодит байдал, бодлоготой нийцэхгүй болжээ.

Цэцэрлэг хот эргэн тойрон уулаар хүрээлэгдэж, баруун хойноосоо зонхилон салхилах чиглэлийн дэд талд гэр хорооллын нэлээд хэсэг байрлаж байгаа нь хотод бохирдсон агаар хуримтлагдах нөхцөл бүрдүүлдэг ажээ. Хотын орон сууц, албан байгуулагад бага хүчин чадлын 10 гаруй зуухнаас халаалт, хэрэглээний ус өгдөг байна. Энэ нь дулаан хангамжийн хувьд найдвар муутай, түлш, эрчим хүчний зарцуулалт ихтэй, ажиллах орон тоо, зардал өндөр байдгаас гадна хотыг бохирдуулж, өнгө үзэмжийг доройтуулж байгаа ажээ. Хотын халаалт, цэвэр усны шугам нь жигд бус ажиллагаатай, зарим газраа угсралтын ажил шаардлагын дагуу хийгдээгүйгээс ашиглалтын явцад жил бүр засвар шаардагдан, хотын дотор ухсан



нүх, шуудуу, овоолсон шороо бий болгож, газрын хөрс, зарим байгууламжийг эвдэхэд хүрдэг байна.

Хотын дундуур усргаж буй гол, горхио бороо хур элбэгшсэн улиралд ихээхэн шавар шалбааг үүсгэн, эргэн тойрны уулнаас үерийн ус их хэмжээтэй бууж хот усанд автах бодит аюул учарч болхоор байна. Хотын орчимд үерийн хамгаалалт байгуулаагүйгээс төв болон баруун, зүүн дэнжэд газрын хөрс эвдэрч гуу жалга үүсэн, тэнд бий болсон хог хотын төвийн зам, талбайд бөөгнөрч, түүнийг зайлуулахад нэлээд хөрөнгө зарцуулдаг байна.

**Долоо. Тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн бодлого.** Архангай аймагт үйлдвэрлэл, үйлчилгээний 700 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн төсвийн зарлага 1996 оны байдлаар 1937.2 сая төгрөг болж, үүний 14.2% буюу 276 сая төгрөгийг орон нутгийн орлогоор, 85.8%-ийг улсын төсвөөс татаасаар санхүүжүүлж байна. Аймгийн нутагт нүүрсний уурхайгүйгээс 400 гаруй км зайтай орших Баянтээгийн уурхайн нэг тонн нүүрс 30 гаруй мянган төгрөгөөр хэрэглэгчдэд очдогоос гадна сумдын дулааны зуухны хүчин чадал өндөр, түүний ашиглалтын түвшин доогуур зэргээс шалтгаалан улсын төсвийн татаасны дөрөвний нэгийг халаалтын зардалд зориулдаг байна.

Аймгийн мал 1996 онд 1924.5 мянгад хүрч, таваарлаг чанар бүхий үхэр 21.4%-ийг, хонь 43.9%-ийг нь эзлэх болжээ. Мал сүрэг сүүлийн 6 жилд тогтвортой өсөж, бэлчээрийн даацад зохицож байна. Малчин нэг өрхийн жилийн орлого 154 мянган төгрөг бөгөөд түүний 46.8%-ийг нь мал, махнаас, 25.2%-ийг арьс ширнээс, 18.1%-ийг ноос, ноолуураас 8.4%-ийг сүү, сүүн бүтээгдэхүүнээс олж байна.

Тариаланг ойт болон тал хээрийн 13 сум эрхэлж, 1990 онд үр тариа, 1.2-1.9 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авч байснаа 1996 онд тариалсан талбай 15 мянган га болтлоо буурч, 4.4 мянган га-аас 1.4 мянган тонн үр тариа, 240 га-аас 0.9 мянган тонн төмс, 56 га-гаас 281 тонн хүнсний ногоо хураан авчээ. Тариалан голлон эрхэлдэг аж ахуйн нэгжүүд хөрөнгийн чадваргүй болж эдийн засгийн хувьд хүнд бэрхшээлд оржээ.



Аж үйлдвэрийн газрууд 1996 онд 869.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 72.4% нь хувийн хэвшилд ногдож байна. Эдгээр газрууд 361 тонн талх, 102.7 тонн нарийн боов, 31.4 мянган литр архи, 1.2 мянган тонн гурил, 3.4 мянган м<sup>3</sup> зүсмэл, 425 мянган м<sup>2</sup> эсгий үйлдвэрлэн, 948.3 сая төгрөгийн борлуулалт хийжээ. Барилга угсралт, материалын үйлдвэрлэлийн томоохон баазтай боловч хөрөнгө оруулалт багассантай уялдан жилийн ихэнхи хугацаанд сул зогсож, жилд дунджаар 491.2 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэх болжээ. Авто тээврийн байгууллага 100 гаруй мянган тонн ачаа, 23.5 мянган зорчигч тээвэрлэж, худалдааны чиглэлийн аж ахуйн нэгжүүд 1.1 тербум төгрөгийн бараа борлуулалт хийсэн байна.

Аймгийн эдийн засгийн байдал доройтсон байдалд нөлөөлсөн хүчин зүйл асуудал:

-Аймгийн нийт нутагт геологийн ерөнхий болон нарийвчилсан судалгаа зураглал хийгдээгүйгээс эдийн засагт нөлөө бүхий олборлох, боловсруулах үйлдвэрлэлгүй;

-Нүүрсний орд, уурхайгүйгээс дулааны эрчим хүчний хангалт өндөр зардалтай байдаг;

-Аймаг Монгол Улсын төвд оршдогоос хойд, урд хөрш орнуудын муж, аймаг, хязгаар, хошуу, хоттой шууд харилцахад газар зүйн хувьд гол, гадаад харилцаа бараг хөгжөөгүй;

-Газар тариаланд эрчимжсэн технологи нэвтрээгүйгээс байгаль, цаг уурын нөлөөллийн эрсдэлд их өртөмтгий;

-Дэд бүтэц ялангуяа зам, харилцаа холбоо, мэдээлэл сул хөгжсөн;

-Аж ахуй эрхлэх талаархи идэвхи харьцангуй сул, үүнээс үүдэн хүн амын амьжиргааны түвшин, худалдан авах чадвар доогуур;



-Аймгийн эдийн засагт дорвитой нөлөө үзүүлж чадах аж ахуйн томоохон нэгжгүй, хүнс, эсгий зэрэг нэлээд үйлдвэр сул зогсож, хүчин чадлаа бүрэн ашиглахгүй байгаа зэрэг болно.

**Найм. Аж үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжил.** Архангай аймагт улсын үйлдвэрийн газар 50 гаруй, компани 80 шахам, хоршоо 100 гаруй, нөхөрлөл 250 орчим үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хүнс, барилгын үйлдвэрлэл зонхилох хандлагатай байна. Түвшрүүлэх, Хайрхан саманд гурилын, Тариат суманд өнгөт чулууны, Их тамир суманд эсгийний үйлдвэр ажиллаж, гол төлөв хөдөөгийн малчдын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Аж ахуйн нэгжүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадвал аймгийн эрэлт, хэрэгцээг хангаад зогсохгүй, хөрш зэргэлдээ аймагт бүтээгдэхүүнээ бүтэц үндсэндээ хэвээр байна. Аж үйлдвэрт ашиглалтын зардал ихэсч, техник, технологи нь хуучран, бүтээгдэхүүнийх нь эрэлт багассан зэргээс шалтгаалан үйлдвэрүүд төслийнхөө хүчин чадлын дөнгөж 10-30 орчим хувийг ашиглаж байна. Аймгийн нутаг дэвсгэрт хийсэн эрэл, хайгуулын судалгаагаар 60 гаруй ашигт малтмал, эрдсийн орд, алтны 3 илэрцийг тогтоосон ч олборлох үүднээс нарийвчилсан хайгуул, судалгааг хийсэнгүйээ. Байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ихтэй, цэвэр, бохир усны байгууламжтай, аймаг, сумын төвүүд цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон зэрэг нь үйлдвэрлэл хөгжүүлэх нөхцөл бололцоотойг харуулж байна.

**Ес. Зам, тээвэр, холбооны салбарын тогтвортой хөгжил.** Архангай аймгийн тээврийн газар нь орон нутагт зорчигч, шуудангийн тээврийн үйлчилгээг долоо хоногт 1 удаа, аймгийн төв, нийслэлийн хооронд долоо хоногт 3 удаа, таксийн үйлчилгээг өдөр бүр үзүүлэх болжээ. Улаанбаатар-Архангай зүүн хойд чиглэлийн 9 сумын зорчигч тээврийн үйлчилгээг орон нутгийн хувийн хэвшлийн байгууллага, иргэд гүйцэтгэж байна.

Тээврийн байгууллагын техник хэрэгсэл, технологи хоцрогдож, шуудан, зорчигч тээврийн үйлчилгээнд шатахууны зарцуулалт ихтэй Газ-66, Газ-53, маркийн автомашин ашигладаг байна. Аймгийн төвд Ю-12, АН-24, АН-2, АН-30





онгоц, МИ-8 нисдэг тэргийг үйлчлэх зориулалт бүхий III зэрэглэлийн нисэх буудал ажилладаг бөгөөд мэргэжлийн боловсон хүчин, агаарын болон газрын холбоо, хэт богино долгионы удирдлагын холбоогоор найдвартай хангагдсан, долоо хоногт орон нутгийн зорчигч, шуудан тээврийн онгоц 2 удаа, Эрдэнэт-Цэцэрлэг чиглэлийн нислэгийг 383 км зам, 1027 уртааш метр гүүр, орон нутаг дахь 35 уртааш метр гүүрийг хариуцан засвар, үйлчилгээ хийдэг ба жилдээ 5-7 км сайжруулсан хайрган зам тавих, 30 орчим уртааш метр төмөр бетон, 50-60 уртааш метр модон гүүр барих, 4700-5000 м<sup>3</sup> халуун асфальт үйлдвэрлэх, 150 мянган тонн ачаа богины зайд тээвэрлэх, 20 хүртэлх машин, техникт дунд, усргал засвар хийх хүчин чадалтай ажээ.

Баруун чиглэлийн авто замыг өртөөчлөн засварлах, шинэчлэх зорилготой дистанц Тариат суманд ажилладаг байна. Монголын хөндлөн тэнхлэгийн гол замыг Архангай нутгаар өнгөрүүлэхээр тогтоосон нь аймгийн дэд бүтцийн хөгжилд чухал ач холбогдолтой юм байна.

Монголын цахилгаан холбоо компанийн харъяа аймгийн холбооны газар нь 19 суманд холбооны салбартай, хот хоорондын 428 км аналогийн технологийн, аймаг, сумдын 1600 км агаарын шугамтай, 1122 телефон цэгийг үйлчилдэг ажээ. Бусад аймгийн төв, хотуудтай 27 сувгаар харилцах боломжтой, ЕМ-48 автомат холболтын станцаар телефакс, электрон шуудангийн үйлчилгээ үзүүлдэг ажээ. Холбооны сүлжээний тоног төхөөрөмж хуучирч, техникийн алдаа их гарч байна. Тариат, Хангай, Цахир, Өндөр-Улаан, Чулуут сумын төвүүдийг цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбоогүй учир зарим улиралд радио, телевизийн үйлчилгээ үндсэндээ зогсонг байна.

**Арав. Эрчим хүчний тогтвортой үйлдвэрлэл, үйлчилгээ.** Аймгийн төвийг 1987 онд цахилгааны төвлөрсөн системд холбож, 110, 35, 10 кв-ын хуваарлих байгууламжийг ашиглан, аймгийн төв, 11 сумын төвийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Аймгийн төвд БЗЮ-100 м<sup>2</sup>, НР-18-53 м<sup>2</sup>, НР-18-27 м<sup>2</sup> маркийн тогоотой 12 зууж ажиллаж, цагт 14.7 Гкал үйлдвэрлэж байгаа нь одоогийн хэрэгцээнээсээ 1.3 Гкал/цаг дутагдаж буй юм. Мөн 17 сумын төвд БЗУЙ-100 м<sup>2</sup> НР-18-53 м<sup>2</sup>, НР-18-27 м<sup>2</sup> маркийн тогоо бүхий зуух ажилладаг байна. Цэцэрлэг,



Жаргалант, Өндөр-Улаан, Чулуут сумын төвийг цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбосноор төв, суурин газрын 78.8%-ийг эл сүлжээнд хамруулжээ.

Аймагт жилд нартай байх хугацаа 2800-2900 цаг, улирлаар авч үзвэл зундаа өдөрт 9.5 цаг, өвөлдөө 5.3 цаг, салхины дундаж хурд нь уулархаг нутгаар 2 м/сек, тал хээрт 4 м/сек байдаг нь нар, салхины эрчим хүчийг, ялангуяа малчдын цахилгаан хангамжид ашиглах боломжтойг харуулж байна. Хангай, Тариат, Цахир зэрэг сумын баг, хот айлд уулын түргэн усргалт усыг ашиглаж, бага, дунд оврын усан цахилгаан станцыг байгуулж болох ажээ. Судалгаанаас үзвэл хангайн бүсийн сумдад нэг өрх жилдээ 10-14 м<sup>3</sup> мод, 0.3-0.5 тонн аргал түлшинд хэрэглэдэг. Аймгийн хэмжээгээр жилдээ 35-40 мянган тонн нүүрс хэрэглэж байгаа бөгөөд үүний 22 хувь үнс болдог гэж тооцвол 7700-8800 тонн үнс гарч, агаар орчныг ихээр бохирдуулж байна. Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбосон сум, аймгийн төвийн дэд станцууд суурилагдсан хүчин чадлынхаа дөнгөж 30 орчим хувийг ашиглаж байна. Энэ нь төвлөрсөн хангамжид холбогдсон аймаг, сумын төвд үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэн явуулахад цахилгаан эрчим хүчний ихээхэн нөөцтэйг харуулж байна. Аймгийн төвд бага хүчин чадлын олон жижиг зуух нөөцтэйг харуулна. Аймгийн төвд бага хүчин чадлын олон жижиг зуух ажиллаж, байгаль орчин, агаар мандлыг бохирдуулан, ялангуяа өвлийн улиралд агаарт байх бохирдлын хэмжээг нэмэгдүүлдэг бөгөөд эдгээр зуух нь дулаан хангамжийн схемийн найдвар муутай, түлшний зарцуулалт ихтэй юм байна.

Аймгийн хэрэгцээт нүүрсийг хэдэн зуун км-ын холоос тээвэрлэж байгаагаас 1 тонн нүүрсний зардал 30 гаруй мянган төгрөг, 1 м<sup>3</sup> дулааных 286 төгрөгт хүрч, айл өрх, байгууллагад санхүүгийн хувьд дарамт болсноос сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн тоо цөөрчээ.

Аймгийн төвийн барилгын дулаан хадгалалт муу, дулааны шугам жигд биш ажиллагаатай, зарим газраа угсралтын ажлыг технологийн дагуу хийгээгүй нь ашиглалтад муугаар нөлөөлсөөр байна. Эрчим хүчний тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар, үйлчилгээ орхигдож, шугамын 30%-д их засвар хийх шаардлагатай болжээ. Усны хатуулаг их байгаагаас шугам сүлжээ цоорох, бөглөрөх, халаалтын горим алдагдах явдал олонтаа гарч байна. Өвөл, хаврын



улиралд хөрсний усны түвшин доошилдгоос цэвэр усны ундарга багасч, орон сууцанд оршин суугчдын ахуйн хэрэгцээний хүйтэн усыг цагаар, халуун усыг 7 хоногт нэг удаа түгээдэг нь газрын гүний усны ундарга хүрэлцээгүй, зарим ундаргын ус бохирдсон, инженерийн шугам сүлжээний техник, технологи хоцрогдсон, 1 м<sup>3</sup> усны үнэ өндөржсөнтэй холбоотой байна. Суурин газрын дизель станцаас хүрч, хэрэглэгчдэд санхүүгийн хүндрэл учруулан улмаар хэрэглэгчийн тоо цөөрөхөд хүргэжээ.

**Арван нэг. Агаар мандлыг хамгаалах асуудал.** Аймгийн газар нутгийн хотгор, гүдгэрийн их ялгаа нь уур амьсгалыг улам эрс тэс болгодог байна. Хур тунадас, агаарын хэмээр аймгийн нутгийг дараах 4 үндсэн мужид хувааж үздэг байна. Үүнд: чийглэг хүйтэн, чийглэгдүү сэрүүн, хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар. Эдийн засгийн үндсэн салбар – хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд уур амьсгалын нөхцөл нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэг бтул цаг уур, уур амьсгалын нөлөөллийг бүс нутгаар нарийвчлан тогтоож, аймгийн уур амьсгалын үзүүлэлтийг гаргасан хэдий ч үйлдвэрлэл эрхлэгчид тэр болгон үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглахгүй байдаг байна. Уур амьсгалын үзүүлэлтийг тус аймагт ажиллаж буй цаг уурын шинжилгээний 18 салбарын олон жилийн ажиглалтын материалд тулгуурлан, 40 гаруй нэр төрлийн үзүүлэлтийн математик боловсруулалт хийж, цаг уурын элемент, үзэгдлийн дундаж, хамгийн их, бага утга, давтагдал хангамж зэргийг тодорхойлсон байна. Энэ судалгаа нь аймгийн нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцлийг зөв үнэлж, аж ахуйн үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах, ялангуяа байгаль, цаг уурын хүнд нөхцлийг хохирол багатай давах бололцоо олгоход тусалах учиртай. Аймгийн уур амьсгалын талаар хийсэн судалгаанаас үзэхэд:

-Газар нутаг нь хотгор, гүдгэрийн ялгаа ихтэй, уур амьсгалын эрс тэс, ширүүн нөхцөлтэй;

-Чийг хангамжтай нутагт дулаан, дулаан хангамжтай нутагт чийг дутагдалтай;



-Хавар, намрын улиралд салхины хүч ширүүсч байдгаас өгөршүүллийн нөлөө ихтэй;

-Хур тунадас зун их унадаг. Эдгээр нь хүн амын нутагшил, суурьшил, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн цаг үеийн хадлан хадах, тэжээл бэлтгэх, мал сүрэг оторлуулж таргалуулах ажилд зохисгүй нөлөө үзүүлдэг ажээ.

Аймагт агаарын бохирдлыг хянах харуул 1986 онд байгуулагдан улмаар 1992 онд орчны шинжилгээний лаборатори болон өргөжиж, аймгийн нутгийн ус зүйн 9 харуулаас дээж авч, химийн найрлага, чанар, агаарын түгээмэл тархалттай бохирдуулагч бодис болох хүхэрлэг хий, түүнчлэн төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэлтийн гарц зэрэгт шинжилгээ хийж, хяналт тавьдаг байна. 1992-1996 оны шинжилгээний дүнгээр агаар дахь азотын давхар ислийн агууламж  $0.02\text{мг/м}^3$  болж ихэссэн нь аж ахуйн нэгж зардал хэмнэх зорилгоор халаалтаа нэгдсэн системээс салгаж, тус тусдаа уурын зуух барих, энгийн галлагаанд шилжиж, бохирдуулагч эх үүсвэрийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн төвд 11 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд агаар дахь азотын давхар ислийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давдаг нь төвийн айл өрх салхины дээд талд голдуу байрласан, өвлийн улиралд Цэцэрлэг хот байнгын инверсийн нөлөөнд ордог, уурын зуухны яндан цэвэрлэх шүүлтүүргүйтэй холбоотой байна. 1995 онд агаар бохирдуулагч эх үүсвэр 6782, үүнээс айл өрх болон галлагаатай байр 6166, уурын зуух 16, автомашин мотоцикл 600 орчим байна. Үнс, тоос барих, Цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэлт сүүлийн 4 жилийн дунджаар 46% байгаа нь шаардлага хангаагүй, 1996 оны 2 дугаар сард цэвэршүүлэлт дөнгөж 32% болсон тохиолдол ч байна.

Аймгийн төвийн уурын зуухны нүүрс, үнс, айл өрхийн хуурай хог, хаягдал гудамж, талбайгаа ил, задгай хөглөрч, замын аж ахуй нефть бүтээгдэхүүнийг ил шатаан боловсруулж буй зэргээр агаар дахь бохирдуулагч бодисыг улам нэмэгдүүлэх болжээ. Тээврийн хэрэгсэл олширсон нь үүнд бас нөлөөлж байна. Үйлдвэржилт, хотжилт багатай ч гэсэн дээр дурдсанаар тус аймгийн хувьд байгаль орчныг бохирдуулах, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэж,





бохирдлын үзүүлэлт олон тохиолдолд зөвшөөрөгдөх хэмжээнээс давж, зарим үед шүлтлэг, хүчинлэг орчин үүсдэг байна.

***Арван хоёр. Газарын, хэвлийн нөөц, түүнийг ашиглах асуудал.***

Аймгийн нутагт хээрийн хар шороон, уул хээрийн хүрэн хөрс зонхилдог бөгөөд агь болон үет ургамал хослон өтгөн шигүү ургадаг байна. Нийт нутаг дэвсгэрийн 77.2% нь бэлчээр байна. Хадлангийн 43.2 мянган га талбайгаас өндөр уулын бүсэд 38%, ойт хээрийн бүсэд 46%, хээрийн бүсэд 16% нь байдаг ажээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт орших хангайн нуруу нь геологчид, судлаачдын сонирхлыг олон жилийн турш татаж байсан боловч 1950-иад оныг хүртэл тодорхой зорилго, чиглэлтэй судалгааны ажил хийгдээгүй байна. 1954-1955 онуудад В.А.Амантов, В.И.Гольдинберг нарын арав гаруй судлаачид 1:500000-1:1000000-ын масштабтай, 1973-1990 онд Ц.Жамсранжав, П.Хосбаяр, С.Гүрцоо нарын судлаачид 1:200000 масштабтай геологийн зураглал, эрлийн ажлыг тал, хээрийн бүсийн сумдын нутаг дэвсгэрийг хамруулан боловсруулжээ.

Тус аймгийн Хотонт сумын нутаг Цагаан сүмийн гол орчим, Цагаан тугалганы шороон ордны агуулгтг  $78.4 \text{ г/м}^3$ , Хангайн Хэц дөрөлжийн гянт болдын уулын төмрийн нөөцийг / $\text{C}^2$  зэргээр/ 57-60 сая тонн гэж тогтоосон байна. Сүүлийн жилүүдэд Жаргалант, Өлзийт, Чулуут, Цэнхэр сумын нутагт 1:50000-ын масштабтай эрэл, зураглалын ижил гүйцэтгэн, Жаргалантын Их-Элэгдэйн сул шороон ордод / $\text{P}^2$  зэргээр/ 60 кг алтны нөөцийг баталж, Цэнхэрийн ордод нарийвчилсан эрэл, хайгуулын ажил хийж байна.

Тариат сумын гоёлын өнгөт чулууны ордны анар / $\text{C}^2$  зэргээр/ 144.7 мянган тонн, хризолит / $\text{C}^2$  зэргээр/ 24 мянган тонн, Ихтамирын Мөнгөтийн мөнгөний үндсэн орд / $\text{P}^2$  зэргээр/ 800 кг нөөцтэйг илрүүлжээ. Ихтамир сумын Баянцагааны нүүрсний ордод 1993 оноос явуулсан урьдчилсан хайгуулын дүнд тулгуурлан уулын малталт хийсэн нь үр дүнтэй болоогүй юм. Өгийнуур сумын нутагт нүүрс, каолины батлагдсан нөөцтэй ордууд байгаа ажээ. Аймгийн нутагт нөөц нь батлагдсан элс, шохойн чулуу, хайрга, галт уулын шарга зэргийг барилга, замын байгууллага ашиглаж байна.



**Арван гурав. Улсын тусгай хамгаалалтын нутаг дэвсгэр.** Монгол Улсын тогтвортой хөгжлийн нэг үндэс нь экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөц, баялагийг зүй зохистой ашиглах явдал юм. Аль ч улсын байгаль хамгаалах төрийн бодлогын цөмд газар нутгийг тусгайлан хамгаалах зарчим, чиглэл, арга хэмжээг багтааж, үүгээрээ улс орны байгалийн унаган төрх, соёл, иргэншлийн өвийг хадгалан хамгаалах хамгийн зохистой хэлбэр хэмээн дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

Аймгийн байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хангах, экологийн амин чухал үйл явцыг дэмжих, биологийн төрөл зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалан хамгаалах, сэргээх, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн иж бүрдлийг төлөөлсөн байдаг, Монгол Улсад төдийгүй дэлхийд ховор амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалтай, үзэсгэлэнт зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, үүнд аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7.8% буюу 433.2 мянган га талбай бүхий газар хамрагдаад байна.

Энэ бүс нутаг нь байгалийн төрөл бүрийн нөөц, баялаг харьцангуй их учраас хууль бусаар ан агнах, ногоон мод огтлох, сонгино, самар, жимсийг боловсроогүй үед, буруу аргаар түүж ашиглах гэх зэргээр байгальтайгаа зүй бусаар харьцах явдал түгээмэл болж, байгалийн баялагийн нөөц үтэр түргэн хомсдох, экологийн тэнцвэр алдагдах ноцтой эхлэл болжээ. Иймд улсын тусгай хамгаалалттай зарим газар болон орчны бүсэд мал хэт бөөгнөрүүлснээс бэлчээр талхлагдан, ургамал, хөрсний бүтэц төрхөө алдах болов.

Улсын тусгай хамгаалалттай газрын ой, ангийн нөөцийн талаар эрдэм шинжилгээний зарим судалгаа байдаг боловч эдгээр нутаг газрыг бүхэлд нь хамарсан цогцолбор суурь судалгаа, менежментийг нь боловсронгуй болгоход чиглэгдсэн олон төрлийн судалгаа үгүйлэгдэж байна.



## ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

### НЭГ. ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ОДОО ИРЭЭДҮЙН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ

*Нэг. Хөвсгөл аймгийн хөгжлийн өнөөгийн байдал:* Хөвсгөл аймаг 10062,9 мянган га нутаг дэвсгэртэй. 2007 оны эцсийн байдлаар 123,3 мянган суурин хүн амтай, засаг захиргааны 23 сум, 1 тосгон 126 баг, 3,4 сая толгой малтай болж, улсад хүн ам, малын тоогоор тэргүүлдэг ажээ.

Хүн амын 48,9 хувь нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн хөдөө, 51,1 хувь нь төв, суурин газарт амьдардаг байна. Нийт хүн амын 69,3 хувь нь 35-аас доош насны залуучууд байгаа нь хүн амын ихэнх нь хүүхэд, залуучууд эзэлсэн насжилт залуу байна.



63 дугаар зураг



Аймгийн газар нутаг нь байгалийн баялаг, ой, ашигт малтмалын нөөц, түүх, соёлын дурсгалт газар олонтой, газар зүйн байршил нь эх газрын өндөр уулын бүсэд багтдаг байна. Байгаль цаг уур эрс тэс, хөрс, ургамлын бүтэц эмзэг, цаг уурын бэрхшээлээс шууд хамааралтай ажээ.

Аймгийн эдийн засгийн 88,0 хувь нь байгаль цаг уураас шууд хамааралтай хөдөө аж ахуйн салбар эзэлж, үүний дотор мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэл зонхилдог байна.

Хөвсгөл аймгийн дэд бүтцийн салбар нь Монгол улсын стратегийн орд болох фосфоритын үйлдвэр байгуулахад хамт шийдэгдэхээр төлөвлөгдөж, уг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсноос тус аймагт 1980–аад оноос хөрөнгө оруулалт зогсож, зах зээлд бусад аймгаас хөгжлийн түвшингээр хоцорч байгаа юм байна.

Аймгийн нийт сумдын өнөөгийн түвшин зах зээл эхлэхээс өмнө эрхэлж байсан ажил үйлчилгээний хүрээ, ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадвар, одоогоор үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага, дэд бүтцийн асуудал шийдэгдсэн байдал, нутаг дэвсгэрийн байршлын хол, ойроос шалтгаалан харилцан адилгүй түвшинд байна.

Аймаг, сумдын хэмжээнд үйлдвэр, үйлчилгээ жигд хөгжүүлэх ажлыг байгаль орчны даац чадавхи, бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн хүн амын суурьшил, нүүдлийн хэв шинжийг урьдаас төлөвлөн, нутаг орны онцлогтой уялдуулан зохион байгуулж байгаагүйгээс хүний зохисгүй үйл ажиллагаа, дэлхийн цаг уурын дулаарал зэргээс ой, ус, бэлчээр, ургамал, амьтны нөөц хомсдож, цөлжилт явагдаж, байгаль орчин, нийгмийн хөгжлийн тэнцвэрзарим үзүүлэлтээр алдагдахад хүрсэн байна.

Ойрын 10 жилийн байдлаар байгалийн гамшиг тохиолдож, мал их хэмжээгээр хорогдож, түүнд нэрвэгдсэн малчид олноороо амьдралын эх үүсвэргүй болж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Мөрөн зэрэг суурин бүс





нутагт шилжин суурьшсанаас нийгмийн салбарын асуудлыг шийдвэрлэхэд зарим талаар хүндрэл учруулж, аймгийн хэмжээгээр ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, улмаар дорвитой буурахгүй, ялангуяа зарим төв, суурин газарт өсөх төлөвтэй болжээ.

Сүүлийн жилүүдэд дэд бүтцийн хөгжилд ялангуяа эрчим хүч, харилцаа холбоо, мэдээллийн салбарт ахиц өөрчлөлт гарч 11 сум цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт, 10 сум хөдөлгөөнт холбоонд холбогдож, улмаар 2008 онд багтаан бүх сум, тосгон цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр, хөдөлгөөнт холбоо үүрэн телефоноор хангагдах болж, төв суурин газрын хүн амын хөгжилд тодорхой өөрчлөлт гарч байна. Үүнтэй уялдаж, хүн амын шилжих хөдөлгөөн саарч, аймгийн төвөөс хөдөө суманд шилжиж, аймгаас гадагш шилжих хөдөлгөөний эрч сулрах хандлага ажиглагдах болжээ.

Эдийн засаг, нийгэм, байгаль орчины салбарын үйл ажиллагааг сайжруулахтай холбогдсон улсын 300 гаруй үүний аймаг орон нутагт хамааралтай, бүртгэлтэй 84, үүнтэй холбогдож гарсан аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөө батлагдан мөрдөгдөж байгаа гэх боловч түүний хэрэгжилт харилцан адилгүй, зарим хөтөлбөр төслийн хугацаа дуусч ач холбогдол буурч, одоогийн шаардлага, нөхцөл байдлаас хоцорсон байна.

Монгол улсад Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа идэвхжиж, Хөвсгөл аймаг Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх туршилтын аймгаар сонгогдсон зэрэг нь Хөвсгөл аймаг хөгжлийн зөв цэгцтэй, өнөөгийн шаардлагад нийцсэн хөгжлийн бодлого боловсруулан Мянганы хөгжлийн зорилтуудын зорилго, зорилт, үзүүлэлттэй уялдуулан баталж, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах шаардлагатай холбоотой ажээ.

**Хөвсгөл аймгийн эдийн засаг нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн зорилго нь: Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны харилцан уялдаа, өнөөгийн түвшин, суурь үзүүлэлтүүдийг**



**бодитоор тодорхойлж, хэтийн хандлагыг зөв тодорхойлоход оршино.**

**Хөвсгөл аймгийн хөгжлийн давуу талууд нь:** Хүн амын тоогоор бусад аймгуудаа тэргүүлдэг. Олон ястан үндэстэнтэй, хаана ч давтагдашгүй өв, соёлын уламжлал, хүн амын дотор залуучууд ихэнхийг эзэлдэг, хүн ард нь чадварлаг, бүтээлч, өвөрмөц, шинэлэг сэтгэлгээтэй.

Унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн байгалийн өвөрмөц тогтоц бүхий газар нутаг, амьтан, ургамал, биологийн төрөл зүйл, цаа буга, түүнд зохицсон нүүдлийн амьдралын өвөрмөц хэв шинжтэй.

Малын тоогоор улсад тэргүүлсэн, нутгийн омгийн тодорхой төрлийн малтай.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, өвөл зун жилийн 4 улиралд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бүрдсэн.

Ашигт малтмал, эрдэс түүхий эдийн олон төрлийн нөөцтэй.

Худалдаа, үйлчилгээний цэгүүд нэмэгдэж, өөрийн аймгийн төдийгүй, хил залгаа Архангай, Булган, Завхан болон бусад аймгийн түүхий эд цуглуулах, тэднийг бараа бүтээгдэхүүнээр хангадаг албан бус сүлжээг бий болгосон.

Хөдөө аж ахуйн салбарт шинэ технологи нэвтрүүлэх зорилготой нэгж байгуулагдан сум бүрт үйл ажиллагаа эрхэлж байгаа.

.Олон улсын урт хугацаатай төсөл, хөтөлбөрүүдийн нэгжүүд үйл ажиллагаагаа эхэлсэн.

**Харьцангуй сул тал:**

Хүн амын өсөлт удаан, дундаж наслалт богино, нас баралт ихтэй.

Ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр



Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 88,4 хувийг байгаль, цаг уурын бэрхшээлээс шууд хамааралтай, зохистой бүтэц хангаагүй мал аж ахуй, газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлдэг, эдийн засгийн салбарын өрөөсгөл бүтэцтэй, дэд бүтэц хангалттай хөгжөөгүй.

Эрс тэс уур амьсгалын өөрчлөлтөөс шууд хамааралтай эдийн засагтай.

Уул, уурхай болон хөгжилд шууд нөлөө үзүүлэх нарийн мэргэжлийн ур чадвар бүхий инженер, техникийн ажилтан, ажилчид дутагдалтай, энэ чиглэлийн чанартай, системтэй үйл ажиллагаа дутмаг,

Төрийн үйлчилгээ ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанарын түвшин доогуур,

Эрүүл мэнд, боловсрол, төрийн байгууллагуудын хөрөнгийн зарцуулалт зохион байгуулалт муутай,

Харьцангуй алслагдсан, дэд бүтэц муутай, хот суурин газар ерөнхий төлөвлөгөөгүй, дулаан хангамж болон инженерийн байгууламж сул хөгжсөн.

Мэдээ, мэдээллийн системийн нэгдсэн иж бүрэн системд ороогүй,

### **ХОЁР.ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ, ЭРХЭМ ЗОРИЛГО,**

***Хөвсгөл аймгийг хөгжүүлэхэд баримтлах зарчим, хөгжлийн тэргүүлэх чиглэл:*** Ардчилсан шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийн хангах, Аймгийнхаа хөгжилд иргэн бүр оролцож хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцөлийг бүрдүүлэх, Бодлого зорилгыг хэрэгжүүлэх бүх талын боломж, нөхцөлийг бүрдүүлэх, Зах зээлийн эдийн засагт суурилсан хөгжил, эрчимтэй, тогтвортой байх, Хөрөнгө оруулалтыг бодлогын тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээтэй уялдуулан хуваарилах, зарцуулалтыг хянаж, үр дүнтэй байхыг эрхэмлэх, Шинэчлэгдсэн нөхцөл байдалд уян хатан зохицох чадамжтай байх, Бүх шатанд хариуцлага хүлээх чадвартай, ил тод, шударга байж, хууль дээдлэх зэрэг ажээ.



**Хөвсгөл аймгийн эрхэм зорилго:** Монгол улсын үндсэн хуулийг мөрдлөг болгон хүн ам, нийгмийн хөгжлийн байгаа дотоод нөөц, боломжоо ашиглан бусадтай хамтран иргэдээ бүх талаар жигд хөгжүүлж, аймгийн эдийн засаг сайжруулахад нөлөө үзүүлэхүйц үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийг үе шаттай хөгжүүлж, байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалсан, гадаад, дотоодын зах зээл чөлөөтэй хөгжих нөхцөл бүрдүүлэх зэргээр эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах нь Хөвсгөл аймгийн эрхэм зорилго гэж тодорхойлжээ.

**Хөвсгөл аймгийн алсын хараа нь:** Монгол улсын хууль, тогтоомжийг баримтлах, Шударга төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж, иргэн нь шударга амьдарч, ажиллах, нийгмээ эвтэй, найртай байлгах, Бие хүн, нийгмийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж, хамтран ажиллаж бүтээн байгуулах, Аймаг, сумаа хөгжүүлэхэд иргэн бүр санаачлагатай оролцсоноор Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахад нөлөө үзүүлж, иргэддээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх алсын хараатай ажиллана гэж үзэжээ.

## **ГУРАВ.ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮНИЙ БОЛОН НИЙГМИЙН ХӨГЖИЛ**

Хөвсгөл аймгийн иргэдэд эрүүл, саруул аж төрөх, урт наслах, амар тайван, түүх, соёлоо хүндлэх, бүтээлчээр ажиллах, байнга суралцах, оюун ухаан, авъяас, чадвараа нээн хөгжүүлэх, өргөн сонголттой байх таатай орчныг бүрдүүлэн ард иргэдийн амьжиргааг тасралтгүй дээшлүүлж, хүний хөгжлийн индексийг 0,80-д хүргэнэ гэжээ.

Иргэдийн хөдөлмөр болон аж ахуй эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, гэр бүлийг бэхжүүлэх, амьжиргаагаа сайжруулах чадамжийг дээшлүүлэх, хүн амын нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах бодлого баримталах ажээ.





**Ядуурал, ажилгүйдлийн бодлого.** Аймгийн хэмжээгээр 2007 оны байдлаар нийт хүн амын гуравны нэг орчим нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой амьдарч байгаа нь 2000 онд болсон байгалын гамшгаар ихэнх малчид малаа хорогдуулж, амьжиргааны эх үүсвэрээ алдсанаас ихээхэн шалтгаалсан байна.

Ядууралд өрх толгойлсон эх, эцэг, ам бүл олонтой, цөөн малтай өрх, эмзэг бүлгийн иргэд их өртөж, ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн харагдаж байгаа ч аймаг, сумын хэмжээнд ажилгүйдэл, ядууралтай холбоотой мэдээллийн иж бүрэн сан, бодит судалгаа, тооцоо байхгүй, үүнифйг тооцох улсын хэмжээнд мөрдөж байгаа тогтсон аргачлал, стандартгүй байна.

Эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн, харьцангуй дунд давхаргыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг сүүлийн 3 жилийн түвшингээс 2015 онд 2 дахин бууруулна гэжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн насанд хүрсэн нэгээс доошгүй хүнийг ажилд хамруулах замаар 2009 оноос эхлэн жилд 2000-аас доошгүй ажлын байр бий болгож, 2015 он гэхэд 14000 хүнийг ажлын байртай болгохоор төлөвлөжээ.

Хувийн хэвшил, өрхийн үйлдвэрлэлийг дэмжихэд урт хугацаатай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг чиглүүлж, тэдний хүчийг төвлөрүүлэн хөтөлбөртэй уялдуулж, 2 жилд нэг удаа шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг хангуулахаар заажээ.

Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж, ажлын байр бий болгох нөхцөл боломжийг бүрдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3,1 хувиас ихгүй байлгаж, өрхийн сарын дундаж орлогыг 1,0 саяас доошгүй төгрөгт хүргэхээр төлөвлөжээ.

Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгож, ядуурлын түвшинг 2015 онд



2007 оныхоос 2 дахин бууруулахаар заажээ.

**Гэр бүлийн хөгжил, хүн амын бодлого.** Гэр бүл тогтвортой байх, үр хүүхэд аюулгүй орчинд бүх талаар эрүүл өсөж хөгжих, уламжлалт ёс заншлаа хүндлэх, байгаль орчиноо хайрлан хамгаалах, хог хаягдал хаяж бохирдуулахгүй байж, авъяасаа хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзлэлтэй, бүтээлч, хариуцлагатай, хувь заяандаа эзэн болсон иргэн болж төлөвших нөхцөлийг бүрдүүлж, хүн амаа өсгөх бодлого баримталах ажээ.

Өрх гэрийг уламжлалт соёл, ёс заншлын өвийг хадгалан хөгжүүлэх орчин болгож ядууралд орсон болон эмзэг бүлэгт хамрагдаж буй гэр бүлийн онцлогт тохирсон “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г тэдний өөрсдийн оролцоотойгоор боловсруулж, түүнд үндэслэн амьжиргааг дээшлүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх

Өрх бүр угийн бичгээ хөтөлж, удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалах бодлого хэрэгжүүлнэ гэжээ.

**Боловсролын хөгжлийн бодлого.** Хөвсгөл аймгийн ЕБС-ийн 35 сургуульд 27,0 мянга гаруй хүүхэд суралцаж, нийт 1859 ажиллагсад, үүний дотор 1096 багш ажилладаг. Сүүлийн гурван жилийн хичээлийн жилд суурь боловсролын хамран сургалт 92,8 хувь, бага боловсролын хамран сургалт 91,3 хувь, дунд боловсролын хамран сургалт 93,4 хувь байгаа нь суурь боловсрол болон бага боловсролын хамран сургалт дунд боловсролын хамран сургалтаас доогуур, бага боловсролын хамран сургалтын цэвэр жин улсын дунджаас доогуур байна. Энэ үзүүлэлт сум тус бүрт харилцан адилгүй, үүнээс Цагааннуурын цаатан иргэдийн хүүхдийн сургуульд хамрагдалт хангалтгүй байна.

Сургуулийн насны хүүхдийн дунд сургууль завсардалт, ялангуяа хөдөө сумдад нилээд байна. Сургууль завсардсан хүүхдийн тоо аймгийн БСГ-ын мэдээгээр 2004-2005 оны хичээлийн жилд 965, 2005-2006 оны хичээлийн жилд 1010 болж нэмэгдэн, 2006-2007 оны хичээлийн жилд 688 болж буурсан



харагдаж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчин чадал, материаллаг орчин, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн дутагдалтайгаас эмзэг бүлгийн болон малчин өрхийн хүүхэд сургуулийн өмнөх боловсролд тэгш хамрагдаж чаддаггүй.

Аймгийн хэмжээнд 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь 98,7-96,6 байна.

Боловсролын салбарт бодлого, төлөвлөлт, менежментийг үр дүнд чиглүүлж чанарыг эрхэмлэсэн шинэ зорилтыг оновчтой тодорхойлох, боловсролын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх дадлагажуулахад ахиц өөрчлөлт гаргах, сургуулийг удирдах хэрэгт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг боловсронгуй болгох, багш нарын ёс зүйд анхаарч, хүүхэд бүртээ жигд, тэгш харьцаж, сургах, сурлагын амжилтын үнэлгээг хүүхдийн сурах сонирхол, идэвхийг дэмжих, боловсролын стандарт, кинрикулиммын хэрэгжилтийг бодитоор үнэлэхэд чиглүүлэх, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, чанар хүртээмжийг ахиулах олон хувилбар, арга замыг хайж орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, бага боловсролын хамран сургалтын хувийг 100 хувьд хүргэж, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн гадна байгаа хүүхэд, залуучуудад албан бус боловсрол хүргэх тэгш боломжийг бий болгох, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, сургууль завсардалтыг арилгах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**Аймгийн иргэн бүрт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд чинээлэг сайхан амьдрахын тулд өөрийн чадавхийг бүрэн илрүүлэн хөгжих, асуудлыг шийдвэрлэх, бүтээлчээр хандахад нь шаардагдах мэдлэг, чадвар, технологи болон соёлын үнэт зүйлсийг эзэмших, сонгох тэгш боломж, таатай орчинг төлөвшүүлэн, байнга сайжруулахад чиглэсэн, хүртээмжтэй, чанартай, үр ашигтай, тогтвортой боловсролын үйлчилгээг үзүүлнэ гэж үзэжээ.**



Шаардлагатай сум, багт хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг нэмэгдүүлж, материаллаг баазаар хангаж, шинээр 4-өөс доошгүй цэцэрлэг шинээр барьж, 23 арилгад их засвюар хийж, хөдөөгийн сургуулийн өмнөх насны хүүхдийг 100 хувь нүүдлийн цэцэрлэгт хамруулна.

СӨБ-ийн байгууллагуудад сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, сургалтын арга зүйг шинэчилнэ гэж үзэжээ.

**Бага, дунд боловсролын сургалтыг сайжруулна.** Суралцах эрх нь зөрчигдөж байгаа хүүхдийн суралцах тэгш боломжийг бүрдүүлж, өрхийн амьжиргааны түвшин эзэмших боловсролын хэрэгцээний ялгааны хамааралыг багасгаж хамран сургалтын бохир жинг 2015 онд бага боловсролд 100, дунд боловсролд 100 хувьд хүргэнэ гэж үзэжээ.

Хичээлийн болон дотуур байрны барилга, сургалтын тоног төхөөрөмж, кабинет, лаборатори бусад хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага стандартыг хангаж, эрүүл ахуй, аюулгүй байдалд нийцсэн тохь тухтай, чанартай үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч, 10 хичээлийн байр шинээр барьж, 23 хичээлийн байрыг засварлаж өргөтгөн ээлж ашиглалтын коэффициентийг бууруулах талаар ажиллаж байна.

2008-2009 онд 6 настай хүүхдийг 100 хувь ерөнхий боловсролын сургалтад хамруулж, тэдний сурах, амьдрах таатай орчинг иж бүрэн бүрдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх ажил хийгдэж байна.

Дотуур байранд амьдрах хүсэлтэй хүүхдийг 100 хувь дотуур байраар хангаж, 7 дотуур байрны барилга шинээр барьж, 20 дотуур байрын барилгад өргөтгөл засвар хийж, сургууль завсардалтын бодит судалгааг 2008-онд багтаан гаргаж, албан бус сургалтад 100 хувь хамруулах ажил хийгэж байна.

Багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулж, мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож,





багшийн ажлын ачааллалыг оновчтой зохион байгуулж, багш нарын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, ёс зүйг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.

Сурагчдын мэдээлэл харилцааны технологи ашиглах боломжийг өргөтгөж, 2010-он гэхэд бүх сургуулийг интернетийн сүлжээнд холбож, интернет номын сантай болгох ажил хийгдэж байна.

Гоц авъяастай хүүхдийн судалгаа гаргаж, тэдний авъяасыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, 2009 оноос Мөрөн суманд бага ангийн сурагчдад зориулан өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулж байна.

**Мэргэжлийн ур чадварыг технологийн өндөр түвшинд эзэмшсэн, үндсэн ур чадварын болон ёс зүйн өндөр төлөвшилтэй мэргэжлийн ажилтан бэлтгэх ажил шат дараатай хийгдэж байна.**

Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамран сургалтыг 56,5 хувиар нэмэгдүүлж, аймгийн МСҮТ-ийн материаллаг баазыг орчин үеийн шаардлагын түвшинг хангаж, 2010 он гэхэд аймгийн МСҮТ-ийн сургалтын орчинг олон улсын мэргэжлийн сургуулийн жишигт хүртэл бэхжүүлж, МСҮТ 1-ийг шинээр байгуулжээ.

Зах зээлийн эрэлтэт нийцсэн нарийн мэргэжлийн багш, мэргэжилтнээр ангаж, багш нарын ур чадварыг дээшлүүлж, хувийн хэвшлийн мэргэжилтэй ажилтныг системтэй бэлтгэж, давтан сургаж, хүний нөөцийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах сургалтын байгууллага болгох талаар анхаарч ажиллаж байна.

Тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлийн боловсон хүчин бэлтгэх дээд сургууль байгуулахыг дэмжиж, уул уурхай, барилга, дулаан, сантехникийн зэрэг хөгжлийн бодлогод чиглэсэн ажил мэргэжлийн инженер, техникийн ажилтныг орон нутагт бэлтгэх үүсгэл санаачлагыг дэмжиж, орон нутгийн мэргэжилтний хэрэгцээг хангахад анхаарж ажиллаж байна.

Дээд боловсролын үйл ажиллагааг орон нутгийн бодлого, зах зээлийн



эрэлт хэрэгцээтэй нийцүүлж, сургалтын чанарын хяналтыг сайжруулах, чанараар өрсөлдөх орчинг бүрдүүлж, орон нутгийн онцлог, боловсон хүчний бодлогыг тухай бүр тодорхойлж аймаг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлсэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар ажил хийгдэж байна.

**Соёлын салбарын үйлчилгээний бодлого.** Орон нутгийн соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийн уламжлал, шинэчлэлтийг хадгалан хамгаалах, бататган хөгжүүлж, өвлөн уламжлуулах замаар үндэснийхээ соёлын өвийг хадгалж, соёл, урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлж, хойч үед эзэмшүүлэх ажил үе шатаар хийгдэж байна.

Үндэстэн, ястан, цаатан иргэдийн болон хүн ам зүйн янз бүрийн давхаргын оюуны хэрэгцээ, нөөцийг үе шаттай судлан, тэдгээрт тохирсон соёл, урлагийн үйлчилгээний төрөл, ашигтай арга хэлбэрийг сонгож хөгжүүлэх талаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, сумдын соёлын төвийн барилгуудыг шинэчлэн засварлаж, техник хэрэгслэлээр бүрэн хангаж, байнгын ажиллагаатай болгох талаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Аймаг, сумын номын сангийн фондыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж, 2010-онд багтаан сум бүрт интернет номын сан ажиллуулж байна.

Орон нутгийг судлах музейг аймаг, суманд байнга ажиллах боломжийг бүрдүүлж, музейн эд өлгийг арвижуулж, баяжуулан хамгаалах арга хэмжээ авч ардын урлаг, соёлыг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

**Эрүүл мэндийн хөгжлийн бодлого.** Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг-5, сумын эмнэлэг-18, өрхийн эмнэлэг-6, БГХӨСТөв, эм ханган нийлүүлэх байгууллага-6, эмийн



эргэлтийн сан-23, хувийн эмийн сан-22, хувийн ортой эмнэлэг 8 ажиллаж, 32098 өрхийн 123275 хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 1216 хүн ажиллаж байгаагаас их эмч 172, эм зүйч 11, бусад дээд мэргэжилтэн 18, бага эмч 149, үүнээс багийн бага эмч 100, эх баригч бага эмч 32, сувилагч 318, бусад тусгай мэргэжилтэн 118, үйлчилгээний ажиллагсад 398 байж, 10000 хүн амд их эмч 14, сувилагч 25,6 ногдож байна. 2007 оны байдлаар стандартын шаардлага хангасан зориулалтын байртай сум, өрхийн эмнэлэг 91,3, түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлт 100 хувь, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85, багаж тоног төхөөрөмжийн хангалт 47,8, сум, сум дундын эмнэлгийн их эмчийн хангалт 53,2, сувилагч, тусгай мэргэжилтний хангалт 93,4 байгаа ба Цагааннуур сум их эмчгүй, өрхийн эмчийн хангалт 85, аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалт 88,1 хувьтай байгаа боловч ерөнхий болон нарийн мэргэжлийн 53 их эмч, сувилагч 43 сувилагч тусгай мэргэжилтэн дутагдалтай байна.

Сүүлийн 5 жилийн дундажаар нийт эмч нарын 20,6, сувилагч тусгай мэргэжилтний 14,6 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, их эмч нарын 10,7, сувилагч тусгай мэргэжилтний 5,7 хувь нь мэргэжлийн зэрэгтэй болсон байгаа нь үйлчилгээний чанарын шаардлагаас хоцроход хүргэж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын өвчлөл, нас баралтад амьсгалын, шээс бэлгийн зам, хоол боловсруулах, цусны эргэлтийн болон, мэдрэлийн тогтолцооны өвчлөл, хүн амын нас баралтанд цусны эргэлтийн тогтолцоо, хорт хавдар, осол гэмтэл, хоол боловсруулах, амьсгалын тогтолцооны өвчлөл зонхилох шалтгаан болж байна.

Эхийн эндэгдэл жилээс жилд буурсан тоо байгаа хэдий ч тогтвортой буурахгүй байна. Энэ нь жирэмсний хяналтын чанар муу, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал сул дорой, эмэгтэйчүүд, эхчүүд өөртөө тавих хяналт



муу байгаа нь нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн төрөлт нэмэгдэж байна.

Хүүхдийн эндэгдэл буурсан харагдаж байгаа боловч энэ үзүүлэлт улс, аймгийн дундажаас өндөр, эндсэн хүүхдийн 80 хувь нь уушигны хатгалгаа, суулгалт өвчний улмаас эндэж, нийт эндэглийн 50 хувь гэрийн эндэгдэл эзэлж байгаа нь эмнэлгийн тусламжийн хүртээмж, эцэг эхийн хүүхэддээ тавих хяналт, асран хамгаалах мэдлэг дутмаг байгаатай холбоотой.

Хүн амын өвчлөл, нас баралтад ядуурал, ажилгүйдэл, иргэдийн эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, боловсрол хангалтгүй, эрүүл зан үйл төлөвшөөгүй, эрүүл мэнддээ тавих анхаарал муу, архи, тамхи, зохисгүй буруу хооллолт, буруу хувцаслалт, хүнсний аюулгүй байдал, хөдөлгөөний хомсдол, нийгмийн бухимдал, эрүүл мэндийн үйлчилгээний чанарын доголдол зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж, аймгийн хүн амын дундаж наслалт 2007 оны жилийн эцсийн байдлаар эмэгтэй 61, эрэгтэй 58 байгаа нь улсын дундажаас харьцангуй доогуур байна.

Цаашид бүх шатны эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн хангалт, чадавхи, хариуцлагыг өндөржүүлж, багаж тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтыг сайжруулж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг бууруулахад салбар дундын хамтын ажиллагааг бий болгож хүн амын дунд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд мэдээлэл, сургалт сурталчилгааг шинэ шатанд гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**Эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж, хүн ам, ялангуяа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ илүү шаардлагатай хэсэг болон ядууст нотолгоонд тулгуурласан, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш, чанартай тусламж, үйлчилгээ хүргэх замаар нийт хүн амын эрүүл мэндийг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэн МХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжин, ажилгүйдэл ядуурлыг**





**бууруулахад анхаарч ажиллана гэж үзэж байна.**

Эрүүл Монгол хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, 2009-оноос эхлэн иргэн бүрт жилд нэг удаа нарийн мэргэжлийн цогц үзлэг оношлогоог хийж, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах болно. **Энэ хүрээнд:**

Эхийн эндэгдлийг 100000 амьд төрөлтөд -20,0-д

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд -24,3,

Сүрьеэгийн тархалтыг 100000 хүнд оногдох хувийг 90,0 хувиар бууруулна.

Эмийн үйлдвэрүүдтэй хамтран ажиллаж, нэн шаардлагатай эм, био бэлдмэлийн хангалтыг 100 хувьд хүргэнэ гэж зорилт тавиж ажиллаж байна.

Алслагдсан сумд, хөдөө орон нутгийн хүн амд богино хугацаанд хүрч үйлчлэх түргэн тусламжийн үр дүнтэй үйлчилгээг хүргэх тогтолцоог нэвтрүүлж, гэрийн төрөлтийг арилгаж, нас баралтыг бууруулах талаар бодлогын хүрээнд ажиллаж байна.

Үйлчлэгчид ээлтэй, иргэдэд хүрч үйлчлэх тогтолцоог бүх эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлж, эрүүл мэндийн байгууллагын ажлын үр дүнгийн тайланг жил бүр харьяа сум, багийн иргэдэд сонсгож, тэдний сэтгэл ханамжийг 80- аас доошгүй хувьд хүргэж хэвшүүлэхэд чиглэгдэн ажил зохион байгуулж байна.

**Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай багцын дагуу сум, баг, өрхийн эмнэлгээр хүргэх анхан шатны болон ерөнхий мэргэжлийн чанартай тусламж үйлчилгээг бэхжүүлэхэд ажиллаж байна.**

Өрх, сум, багийн эмч нарын чадварыг сайжруулж, үйлчилгээний чанарт өөрчлөлт гаргах, ажлын үрдүнгийн шалгуурыг шинэчлэн үйлчлүүлэгчээр үнэлүүлэх системд шилжиж байна.

Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай багцийн дагуу өрх, сум,



багийн эмнэлгийн тусламж үйлчилгээний одоогийн хэв шинжийг өөрчлөн шинэчилж хүн амд тасралтгүй хүргэж байна.

***Хөвсгөл аймгийн уламжлалт эмчилгээг системтэй хөгжүүлнэ.***

Аймгийн эрүүл мэндийн газарт уламжлалт эмчилгээ хариуцсан ажилтантай болж, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, баг, сум, өрхийн эмнэлгүүдэд уламжлалт эмнэлгийн оношлогоо, эмчилгээний аргуудыг нэвтрүүлэх ажил зохион байгуулж байна.

Орон нутагт идээшин суурьшиж ирсэн ардын дадал заншил, онцлог, амьдралын орчинд тулгуурласан уламжлалт болон орчин үеийн анагаах аргуудын цогцолбор болох Уламжлалт анагаах ухааны төв байгуулж, үйлчилгээний хүрээг өргөтгөх. Уламжлалт эмчилгээний аргууд, эм, тан, байгалийн цэвэр хүнсний нэмэгдэл болох Хөвсгөлийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, нэр төрлийг олшруулан хэрэглээнд гаргахад дэмжлэг үзүүлэх талаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгож, нийгмийн асуудалд анхаарна гэж үзэжээ.

Хүний нөөцийн бодлого боловсруулан түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан мөрдөж, хүний нөөцийн хангалт ялангуяа их эмчийн хангалтыг нэмэгдүүлж, эмч мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах болон ажлын байран дахь тасралтгүй сургалтад хамруулж чадавхийг сайжруулах, сонгон шалгаруулж, чадваржуулах оновчтой тогтолцоог бий болгох талаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн удирдлага мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, мэдээлийн нэгдсэн сан байгуулж, ажлын чанар, хариуцлагыг шинэ түвшинд хүргэх талаар ажиллаж байна.

Аймаг, сумдын эмнэлгийн барилгын чанарыг сайжруулж, 7 сумын хүн эмнэлгийн барилга, Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга, Мөрөн суманд 50



ортой амаржих газрыг шинээр барьж, 14 сумын хүн эмнэлгийн барилгыг засварлаж, эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэлээр хангах ажил үе шатаар хийгдэж байна.

Орчин үеийн шаардлагад нийцсэн бие бялдар чийрэгжилтийн тоног төхөөрөмжөөр 2010 онд багтаан сумдын болон өрхийн эмнэлгийг бүрэн хангах ажил хийгдэж байна.

**Биеийн тамир, спортын хөгжлийн бодлого.** Аймаг, сумын хэмжээнд нийтийн биеийн тамирын арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулж, иргэдийн бие бялдарыг хөгжүүлэх материаллаг баазыг бэхжүүлж, иргэдийн эрүүл мэндийг сайжруулж, шилдэг тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ гэж үзэжээ.

Спортын цогцолборыг ашиглалтад оруулж, спортын бүх төрлийн үйлчилгээ явуулж, мэргэжилтэй ажилтан, зориулалтын техник хэрэгслэлээр хангаж, өсвөр үеийг хичээллүүлэх спортын мэргэжлийн сургуультай болох, бүх сумдыг спортын заалтай болгож, техник тоног төхөөрөмжөөр хангана, нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн гаднах болон доторхи тоног төхөөрөмжөөр хангаж, байнгын ажиллагаатай байлгах арга хэмжээ авах, улсын болон олон улсын тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах боломжийг бүх талаар бүрдүүлэх ажлууд үе шатаар хийгдэж байна.

**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого.** Хүн амын орлого багатай эмзэг хэсэгт түлхүү хандсан нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажээ. Нийгмийн хөгжлийн оновчтой бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийн аж амьдралын чанарыг сайжруулахаар тусгажээ. Үүний тулд:

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2007 оны эцэст хөдөлмөрийн насны 77365 хүний 5685 албан 48753 албан бус хөдөлмөр эрхэлж, 1924 хөдөлмөрийн биржид бүртгэлтэй боловч 10399 хүн тодорхой ажил, хөдөлмөр эрхлээгүй байна.



Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүргэх тогтолцоо бүрдүүнэ.

Хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хүн бүрт хүргэх арга хэмжээ авна гэж заажээ.

**Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэж үзэжээ.**

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нарийвчилсан судалгаа гаргаж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахаар ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулж, жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн бизнес инкубаторыг өргөтгөн хөгжүүлж, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ гэж заажээ. Үүний тулд:

Эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлнэ.





Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх санаачлага, шинэ санаа гаргагчид эдийн засаг, бизнесийн дэмжлэг үзүүлнэ.

Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, эцэг, эх, гэр бүлийн гишүүдийг нь ажлын байраар хангах зэргээр залуучуудын ажил эрхлэлттэй уялдуулан зохицуулна.

Аж ахуйгаа хөгжүүлж, ажлын байр бий болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж урамшуулна гэж тус тус заажээ.

### **ДӨРӨВ. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Аймгийн эдийн засгийн бодлогын гол зорилт нь 2008-2015 онд “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг жилд дундачаар 15,0 хувьд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 3,0 саяас доошгүй төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Үүний тулд:**

Хөрөнгө оруулалтын үр ашгийг тасралтгүй дээшлүүлж, чанарын удирдлагыг нэвтрүүлж, эхний үе шатанд хариуцлагатай уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгоход хувийн хэвшилд түшиглэсэн, өндөр технологит суурилсан, экспортын баримжаатай, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд. Аймаг доторх бүсүүдийн дэд бүтцийг жигд хөгжүүлж, төв хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасган бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, тэнцвэртэй хөгжүүлэх эдийн засгийн таатай орчинг бий болгохор ажиллаж байна.

**Хувийн хэвшлийн хөгжлийн бодлого. Зах зээлийн эдийн засгийн**



**зарчим, шударга өрсөлдөөнд суурилсан хувийн хэвшил нь аймгийн хөгжилд, түүний дотор ажлын байр шинээр бий болгох, иргэдийг орлогын ядуурлаас гаргахад гол нөлөө үзүүлнэ гэж заажээ. Үүний тулд:**

Хувийн хэвшлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, тэдгээрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх таатай орчин бүрдүүлэх.

Хувийн хэвшлийн үйл ажиллагаа ил тод, шударга явагдах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, дэмжлэг үзүүлэх чиглэлээр үе шаттай ажил зохион байгуулж байна.

**Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого.** Хөвсгөл аймгийн 2007 оны ДНБ-ийн дотор 88,0 хувийг хөдөө аж ахуйн салбар, түүний дотор мал аж ахуйн салбар голлож, бусад салбарын бүтцэд өсөлт удаантай, явцуу бүтэцтэй эдийн засагтай аймаг ажээ.

Аймгийн эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийг Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоход чиглүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлж, 2015 онд 20,0-иос доошгүй хувьд хүргэнэ гэж төлөвлөжээ.

**Хөдөө аж ахуйн салбарын хөгжил.** Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн салбарын зонхилох хэсгийг бэлчээрийн мал аж ахуй эзэлдэг. 2007 оны жилийн эцсээр 3425,2 мянган толгой малын сүргийн бүтэц, тэмээ 0,06, адуу 4,4, үхэр 9,4, хонь 42,1, ямаа 44,1 хувийг эзэлж байгаа нь сүргийн бүтэц, таваарлаг чанарын түвшин хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн хэмжээнд 2007 онд 7678 га-д үр тариа тарьж 7552 га талбайгаас 9586,4 ургац хураан авснаас улаан буудай 7639 га-д тарьж, хураан авсан ургацаар хүн амын гурилын хэрэгцээний дөнгөж 38,0 хувийг хангах боломж бүрдсэн. 247,3 га-д төмс тарьж 1730,2 тн ургац хураан авсан нь төмсний хэрэгцээний 34,3 хувь, 94.01 га-д хүнсний ногоо тарьж 723



тн ургац хураан авч хүн амын хэрэгцээт хүнсний ногооны 8,7 хувийг дотоодын үйлдвэрлэлтээр хангаж байна.

Хөдөө аж ахуй, хүнсний салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, нэгжийн гарцыг сайжруулж, хүн амын гурил, мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг аймгийн дотоодын үйлдвэрлэлээр 2015 онд багтаан бүрэн хангаж, хүртээмж, чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг сайжруулна гэж үзэжээ.

Мал аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлж, нийт мал сүрэгт өндөр ашиг шим бүхий цэвэр эрлийз малын эзлэх хувийн жинг 2010 онд 20 хувьд, 2015 онд 30 хувьд хүргэн малын үүлдэр угсааг сайжруулж, ямааны тоо толгойг бууруулан ялангуяа үхэр сүргийг түлхүү өсгөх зэрэг мал аж ахуйн салбарын бүтцийг сайжруулах хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 320-оос доошгүй худаг уст цэг гаргаж, 1,4 мян га талбайг усжуулж бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, усалгаатай газар тариалангийн хэмжээг нэмэгдүүлж, 2010 он гэхэд хүн амын хэрэгцээт гурилын 100,0 хувийг аймгийн дотоодын үйлдвэрлэлтээр хангах арга хэмжээ авч байна.

Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, хөдөө орон нутгийн онцлогт тохирсон хоршоолол, нөхөрлөлийг дэмжиж хэрэгжүүлж байна.

**Аж үйлдвэрийн бодлого.** Бизнес эрхлэх орчныг бүх талаар сайжруулж, өндөр технологт тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэн бүтцийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох санхүүгийн чадамж, хуримтлалыг бүрдүүлж, аймаг, сумдын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлдвэр, үйлдвэрлэл



**технологийн паркийг ашиглуулах, зээлээр хувьчлах замаар орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлнэ гэж үзэжээ.**

Хөвсгөл аймгийн хэмжээнд илэрсэн чулуун нүүрс, фосфорит, марганц, никель, алт, хаш, бал чулуу, шөрмөсөн чулуу нүүрсний орд зэрэг газруудад олборлолт явуулж, нүүрс боловсруулж, сумдын төсвийн байгууллагуудын халаалтын зуух, иргэдийн түлшний хэрэгцээг хангах. Нүүрсний ордыг түшиглэн хийн станц барих, нүүрсийг шингэрүүлж ашиглах бодлого хэрэгжүүлэх зэрэг ажлууд амжилттай хийгдэж байна.

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нутгийн иргэдийн хяналттай, дэвшилтэт технологиор, битүү циклтэй фосфоритын бордоо үйлдвэрлэж, гадаадын зах зээлд нийлүүлж, ашигт малтмалаа эргэлтэд оруулж байна.

Аймгийн газар нутгийн хэмжээнд судлагдаагүй нөөц, илэрцийг нарийвчлан 50000 мастабын зураглал хийлгэж судлах, улмаар ашиглах асуудлыг шийджэ барилгын материал болох цемент, шохой, ханын материал зэрэг орон нутгийн түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тусгажээ.

**Боловсруулах аж үйлдвэр /мал аж ахуйн бүтээгдэхүүн, мод модон бүтээгдэхүүн, байгалийн баялаг/ Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аймаг, сумын хөгжил, хүн амын хүнсний болон ахуйн хэрэгцээнд нөлөө үзүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, бүх талаар дэмжинэ гэж үзэжээ.**

Үндэслэл: 2007 оны жилийн эцсийн дотоодын нийт бүтээгдэхүүний дотор боловсруулах салбар 0,5 хувийг эзэлж байгаагийн дотор хүнсний үйлдвэрлэл голлож байна. Аймгийн хэмжээгээр томоохон эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц үйлдвэрлэл хөгжөөгүй байгааг анхаарч төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулж, ажлын байр шинээр бий болгох, боломжийг бүрдүүлэх ажээ.**





Боловсруулах үйлдвэрийн Хөвсгөл брэндийг буй болгож, мал аж ахуйн түүхий эд арьс шир, ноос, ноолуур, махыг 100 хувь хагас болон эцсийн бүтээгдэхүүн болгох зорилгоор энэ чиглэлийн үйлдвэрлэлийг өргөтгөх, шинэ техник, технологи нэвтрүүлэх мэргэжилтэй ажилчин, боловсон хүчин бэлтгэж, дотоодын үйлдвэрлэлийн мах, сүүний аймгийн хэрэгцээг бүрэн хангана гэж үзжээ.

Экспорт, импортын бүтээгдэхүүний тэнцвэртэй байдлыг хадгалж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж үндэсний тохирлын үнэлгээтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж байна.

**Аялал жуулчлал:** Үндэслэл:Хөвсгөл аймагт хоногт 1811 жуулчин хүлээн авах чадалтай 43 жуулчны бааз, 24 гэр буудал, 22 отог ажиллаж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд ирж байгаа жуулчдын тоо 2001 онтой харьцуулахад гадаадынх 3,4, дотоодынх 4,0 дахин нэмэгдсэн байна.

Дотоодын жуулчдын ихэнх нь автомашинаар ирж, зориулалтын газарт байрлахгүй, далайн зах, модны хаяагаар дур мэдэн буудаллаж ил задгай гал түлж, түлш бэлтгэх зэрэг эмх замбараагүй байдал бий болгодог. Одоо байгаа жуулчны баазуудын зарим хэсэг нь байрлал стандартын бус, хэтийн бодлого чиглэлгүй баригдаж, үйл ажиллагаа эрхэлж, аймгийн хөгжилд хувь нэмэр бага оруулж, байгаль орчныг их хэмжээгээр сүйтгэдэг ажээ.

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбар жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломж бүрдэжээ. Цаашид аялал жуулчлалын нөөц, эх үүсвэрүүдийг зохистой ашиглан, нутгийн иргэдийн хяналтын доор байгаль орчныг хамгаалахад чиглэсэн, өвөрмөц онцлог, шийдэлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, Хангайн бүсийн төдийгүй Монгол улсын тэргүүлэх салбар болгох зорилт тавьжээ.

“Аялал жуулчлалын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж, аялал жуулчлалын олон улсын маршрут, сүлжээтэй болох. Аялал



жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэж, хүний нөөцийг чадваржуулах. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг орон нутгийн удирдлагын мэдэлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлж, төсвийн орлогын бааз суурийг бүрдүүлж, тогтвортой аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, “Мөсний баяр”-ыг олон улсын хэмжээний аялал жуулчлалын томоохон брэнд болгох ажилууд амжилттай хийгдэж байна.

Хөвсгөл, Байгаль нуур орчмын аялал жуулчлалын баазуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, аялалын маршрутыг баталгаажуулан, жуулчны урсгал нэмэгдүүлэх арга хэмжээ авч. Нүүдэлч малчдын амьдрал ахуйн уламжлал, хэв маягийг сэргээж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, үнэлэмж, үнэ төлбөртэй болгох замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх орлогын өөр эх үүсвэртэй болгох, улирлын хамаарлыг багасгаж, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулж, үйлчилгээний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж жилд дундажаар 50000-60000 жуулчдыг хүлээж авах боломж нөхцөлийг бүрдүүлэх ажил хийгдэж байна.

***Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг хангах талаар.*** Хөдөө аж ахуйн салбарт сургалт, сурталчилгаа фермерийн аж ахуйг хөгжүүлэх зорилго бүхий Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төв бүх суманд үйл ажиллагаа явуулж, мал аж ахуй, газар тариалангийн экстэйшний сургалт, дадлагажуулах ажлыг зохион байгуулж байна.

Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр өгөөжийг дээшлүүлэхээр. Нүүрс боловсруулан шатдаг хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулж, аймгийн “Технологи” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэн мэдээллийг мэдлэг болгох суурийг бүрдүүлэхээр. Ашигт малтмалын нөөцийг эргэлтэд оруулан олборлох, үүний дотор өнгөт металл болох хөнгөн цагаан олборлох, баяжуулах салбарт нано-технологи нэвтрүүлэхээр тодорхой ажил зохион байгуулж байна.



**Дэд бүтцийн хөгжлийн бодлого.** Хувсгал аймаг дэд бүтцийн хувьд сул хөгжсөн. 2004 онд 5 сум ЦДАШ-д холбогдсон, 3 сум хөдөлгөөнт холбоотой байсан бол 2008 оны 5 дугаар сарын 1- ний байдлаар 12 сум ЦДАШ шугаманд холбогдож, 12 сум хөдөлгөөнт холбоотой, 23 сум, 1 тосгон 4 сувгийн телевизийн станцтай болж, улмаар 2008 оны эцэс гэхэд энэ үйлчилгээг бүх сум хүлээж авах боломжтой болж байна.

Цаашид дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчдийн болон эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх шаардлагатай ажээ.

**Зам, тээврийн хөгжлийн бодлого.** Аймгийн хэмжээнд замын салбарт дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, агаар, авто, усан замын тээврийн үйлчилгээг хөгжүүлж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, хариуцлагыг дээшлүүлж, ашиглалт үйлчилгээг сайжруулахаар тодорхой ажлууд хийж байна. Үүндий тулд:

Аймгийн хэмжээнд Мөрөн-Улаанбаатар, Мөрөн-Эрдэнэтийн хооронд автобус, пурган, сум хооронд суудлын автомашин, Мөрөн сумын төвд микро, таксигаар, агаараар Улаанбаатар-Мөрөн-Улаанбаатар, Улаанбаатар- Хатгал-Мөрөн-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдэж, Хатгал-Ханхын хооронд тогтмол бус усан замын тээвэр хийж байна.

Булганы Уньт-Мөрөнгийн, Мөрөн-Хатгалын хатуу хучилттай зам, Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн замд холбож, Эрдэнэт-Мөрөнгийн төмөр зам барьж, усан замын тээвэр хийж, Эрхүү-Мөрөнгийн олон улсын нислэг үйлдэж байна.

Аймгийн байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих Шинэ техник, технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг сайжруулах. Булганы Дашинчилэн-Архангайн Өлзийт-Хайрхан- Хөвсгөлийн Рашаант-Тосонцэнгэл-Мөрөнгийн замыг хатуу хучилттай болгож, Царам, Тариатын давааг засварлах. Аймгийн төв, сумдыг холбосон орон нутгийн



зам, даваа, гүүрийг ээлж дараалан засварлаж сайжруулах. Эрдэнэт-Мөрөнгийн төмөр зам барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, ажлыг 2015 онд багтаан эхлүүлэх ажил амжилттай эхлээд явж байна.

Аялал жуулчлалын олон улсын агаарын нислэгийн сүлжээнд нэгдэж, 2009 оноос эхлэн Эрхүү-Мөрөнгийн нислэгийг жигдрүүлж, Нисэх буудлыг олон улсын нислэг хүлээж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажил судлагдаж байна.

**Эрчим хүчний салбарын бодлого.** Хөвсгөл аймаг 2007 оны эцсийн байдлаар 11 сум цахилгаан дамжуулах агаарын шугамаар өндөр хүчдэлд холбогдож, 2005 онд Арбулаг, 2007 оноос Алаг- Эрдэнэ Хатгал, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Баянзүрх, Цагаан-Уул, Цэцэрлэг, Төмөрбулаг, Эрдэнэбулган сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажил хийгдэж эхлэн 2008 онд Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумд холбогдсоноор Хөвсгөл аймгийн сумдын төв 100 хувь цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдах боломж бүрдэжээ.

Хөвсгөл аймгийн багийн төв, малчдыг сэргээгдэх эрчим хүчийг ашиглах бодлого баримтлан эрчим хүчний найдвартай, хямд төсөр эх үүсвэрээр 2015 онд 100 хувь хангахаар. Эрчим хүчний системийн шугамын ба зүй бусын алдагдлыг багасган эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхээр ажиллаж байна.

**Түлш, дулаан хангамжийн салбарын хөгжлийн бодлого.** Нүүрс хийжүүлж, бага оврын халаалтын зуухуудыг түлшээр хангаж, ойг хамгаалах. Аймгийн хэмжээнд зөвхөн халаалтад зориулж жилд дундачаар 190,0 мянга гаруй м3 мод түлшинд хэрэглэж байгаа байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, Нүүрсийг хийжүүлж, түлшинд хэрэглэх санаачлагыг дэмжих, Аймаг, сумын халаалтын зуухны технологийг шинэчилэх, Мөрөн суманд Дулааны цахилгаан станц барьж ашиглалтад оруулах ажил хийгдэж байна.





**Дулаан хангамжийн бодлого.** Мөрөн сумын дулааны шугам сүлжээний шинэчлэлтийг дуусгаж, халаалт тавигдаагүй сумдын халаалтын систем, тоног төхөөрөмжийг шинэчилж, бага оврын Дулааны цахилгаан станц барьж, аймгийн төвийг төвлөрсөн халаалтын системд холбож, өвлийн улиралд утаа багасгаж, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламжийг 0.045 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн өвлийн хоногийн дундаж агууламжийг 0.016 мг/м<sup>3</sup> болгоход ажиллаж байна.

**Мэдээлэл, харилцаа холбооны технологи, шуудангийн хөгжлийн бодлого:** 2005 онд Булган-Мөрөн чиглэлийн 365 км урттай 12 шөрмөс бүхий Солонгос улсын Taihan компанийн шилэн кабель, түүний дамжуулах систем ашиглалтанд орсноор тухайн аймагт гар утас, өндөр хурдны интернет гэх мэт цахилгаан холбооны үйлчилгээ орох боломж нээгдсэн. Өнөөгийн байдлаар Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Шинэ-Идэр, Жаргалант сумд шилэн кабелийн сүлжээнд холбогдсон. 2007 оны 11 сараас Төмөрбулаг, Түнэл сумдад шилэн кабель суурилуултын ажил хийгдэж, тоног төхөөрөмж суурилагдаж, бусад 20 сум хуучны аналог системээр цахилгаан холбооны үйлчилгээ явуулдаг ажээ.

**Иймээс шилэн кабель болон тоон технологид холбогдоогүй сумдыг шинэ дэвшилтэт технологид суурилсан харилцаа холбоогоор холбоожуулж, 2010 гэхэд бүх сумд, боломжтой зарим багийг интернетэд холбохоор ажиллаж байна.**

Багийн төв, хөдөөгийн боломжтой өрхөд утасгүй интернетийн холбоогоор хангаж, хөдөөгийн иргэдийн хэрэглээг 50 хувьд хүргэх. Бүх сумдын шууданчдыг ажлын байраар 100 % хангаж, 2010 онд багтаан Хатгал, Улаан-Уул, Тариалан, Цагаан-Уул зэрэг 16 суманд электрон шуудан, нийтийн интернет, гидбрид шуудангийн үйлчилгээг нэвтрүүлэх ажил хийгдэж байна.

**Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого: Хүн амыг ая тухтай**



**суурьшин нутаглаж амьдрах зохистой, нөхцөлөөр хангахаар заажээ.**

**Үүний тулд:**

Мөрөн сум болон бусад сум, суурины хот байгуулалтын талаар ихээхэн зөрчил, гарч баригдаж байгаа барилга байгууламжийн архитектур, дизайны шийдэл, дотоод гадаад орон зай, ногоон байгууламж, зам талбайн төлөвлөлт нэгдсэн бодлогогүйгээс алдаа гарч, эмх цэгцгүй гудамж талбайтай болж, амин судас болсон инженерийн шугам сүлжээ, газар доорх байгууламжийн байдал хүндэрч байгааг нэгдсэн бодлогоор оруулах шаардлагатай байна.

**Мөрөн сумын ерөнхий төлөвлөгөөг бодит байдалд нийцүүлэн шинэчилэн баталж, бүх сумдыг сумын төвийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох асуудал хийгдэж байна.**

Барилга барих технологи, арга ажиллагаанд гарч байгаа өөрчлөлтөөс шалтгаалан аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн ажилтан бэлтгэх мэргэжлийн бүтэц, сургалтын чанарт оновчтой шинэчлэлт хийж, мэргэжлийн залуу ажилтныг тодорхой төлөвлөгөөтэй сургаж бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах ажлыг зохион байгуулах. Мөрөн суманд 2000 айлын орон сууц барьж, хувийн эдлэн газар байгуулах ажлууд эхлээд явагдаж байна.

**Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого.** Хөвсгөл аймаг Хангайн бүсэд аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуй, ашигт малтмал, эмийн ургамал тарих, тарьц суулгац нийлүүлэх чиглэлээр тэргүүлж, Хангайн бүсийг хөгжүүлэх хөтөлбөрийн 2015 онд хүрэх түвшинг хангахаар. Сумдын онцлог байдал, газар зүйн байршлын дагуу тогтоосон бүсчлэлийн дагуу жигд дэмжин хөгжүүлэхээр.

Иргэдэд хамгийн ойр төрийн үйлчилгээний нэгж болох багт байвал зохих эрүүл мэнд, боловсрол, соёл, хууль эрх зүйн чиглэлийн төрийн үйлчилгээг тогтмол чанартай явуулах нөхцөл, материаллаг баазыг бүрдүүлэхээр төлөвлөгөөтэй ажиллаж байна.



## **ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО:**

**Хөвсгөл аймгийн агаар мандал, газар, түүний хэвлийн баялаг, ус ой, ан амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, цөлжилт, гангийн нөлөөг бууруулах, химийн хорт бодис, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, байгаль экологийн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх бодлого баримталахаар ажиллаж байна.**

***Байгаль орчны бохирдол, доройтолыг бууруулах бодлого:***  
Сүүлийн жилүүдэд төв, суурин газарт хүн амын төвлөрөл жил ирэх тусам нэмэгдэж орчны агаар хөрс, усны бохирдол ихсэж байгалийн өөрөө цэвэрших чанар алдагдаж, аймгийн хэмжээнд хатуу хог хаягдлын 143,5 га талбай бүхий 24 цэгтэй, хөдөөгийн айл өрх хог хаягдлаа булж устгах цэггүй ил, задгай хаяж, байгаль орчныг бохирдуулдаг ажээ.

Хог хаягдлын цэгүүдийн ихэнх нь байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгүүлээгүй, хогийн цэгийн байршлыг буруу сонгосон, түүний хашилт хамгаалалт хангалтгүй зэргээс орчны хөрс, агаар цаашлаад усыг бохирдуулж, хүн малын халдварт өвчин дамжин тархах нөхцөл бүрдэж байгаатай уялдуулж дараах зорилтыг дэвшүүлж байна.

Хог хаягдлыг боловсруулах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулж, арилгах хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох арга хэмжээ авч байна.

***Газрын нөөц, ашиглалтын бодлого.*** Хөвсгөл аймаг 10062882 га нутагтай 5100079 га бэлчээртэй, бэлчээрийн хэв шинжээр өндөр уул, уулын ойт хээрийн бэлчээрт багтдаг нь уламжлалт, хөрсний бүтэцийн хувьд эмзэг, нилээд онцлогтой 3,5-4,0 сая хонь бэлчээх багтаамжтай, бэлчээрийн даацыг 5 жилийн давтамжтай тооцож үзэхэд 1 хонин толгойд ногдох бэлчээр байнга буурч, 2007 онд 0,9 га бэлчээр оногдож байгаа нь мал хэт ихээр олноор өсөж



бэлчээрийн даац багассаныг харуулж байна.

Сүүлийн гурван жилийн тайлангаар үр тарианы зориулалтаар 78 эзэмшигч 25742,4 га, төмс, хүнсний ногооны зориулалтаар 236 эзэмшигч 25742,4 га, төмс, хүнсний ногооны зориулалтаар 236 эзэмшигч 357,3 га газар эзэмшиж газрын төлбөрөөс 10,6 сая төгрөгийн орон нутгийн төсөвт оруулж байна. 17835,8 га атаршсан газар байдаг ба үүний 2732 га хүний болон байгалийн хүчин зүйлийн уршгаар хүчтэй элэгдэл оржээ.

Цэцэрлэг, Цагаан-уул, Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Жаргалант, Галт, Төмөрбулаг сумдын нутаг үлийн цагаан оготны тархалттай Ренчинлхүмбэ, Их-Уул, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Рашаант суманд элсний нүүлт ажиглагдаж байна.

Ашигт малтмалын ашиглалтаар 2087,8 га, хайгуулаар 2575705 га газар талбай хамарч байгаа нь нийт нутгийн 24,9 хувь лицензтэй байна. Ашигт малтмалын олборолтын явцад газарт учирсан хохирол харьцангуй бага байгаа ч цаашид хяналт тавих шаардлагатай болсныг харуулж байна.

Аймгийн газар нутгийн 15,1 хувь нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын сүлжээнд орсон. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт 112,5 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглагддаг байна.

***Усны нөөцийг сайжруулах бодлого: Усны нөхөн сэлбэгдэх нөөц баялагийн хэмжээгээр усыг ашиглах, усны нөөц горимыг зохицуулахад шийдвэрлэх нөлөө үзүүлэх, савгазрын байгалийн иж бүрдлийг хамгаалах арга хэмжээ авч 879 булаг шандыг тохижуулж зохистой тогтолцоог бүрдүүлэх ажээ.***

Сүүлийн жилүүдэд цаг уур дулаарч, хүний болон технологийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөр ундны цэвэр усны үндсэн баялаг болох гол горхи, булаг шанд, нуур цөөрөм хатаж ширгэж, гадаргын усны хэмжээ багасч нөхөн сэргээхэд хүндэрч байга. Аймгийн газар доорхи усны нөөц 6,95 км<sup>3</sup>, үүний ашиглаж болох боломжит нөөц 1,95 км<sup>3</sup> байдаг. Гадаргын усны





тооллогын дүнгээр тооллогод гол горхи 780, булаг шанд-879, нуур тойром-370, рашаан -50, худаг 412, усан цахилгаан станц -1 хамрагдсны 19 гол горхи, 86 булаг шанд ширгэсэн байгаа. Усны нөхөн сэлбэгдэх нөөц баялагийн хэмжээгээр усыг ашиглах, усны нөөц горимыг зохицуулахад шийдвэрлэх нөлөө үзүүлэх, сав газрын айгалийн иж бүрдлийг хамгаалах, нөхөн сэргээх эдийн засгийн зохистой тогтолцоо бүрдээгүй байгаа дутагдалуудыг засах арга хэмжээ авч байна.

Усны найдвартай эх үүсвэрээр хангагдаагүй сумдад усны нөөцийн хайгуул, судалгааны ажил хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээг үе шаттай авч усны нөөц, чанарын өөрчлөлтөнд байнгын хяналт тавьж, ус ашиглалтын тоо бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, электрон мэдээллийн санд оруулах ажил хийгдэж байна.

**Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодлого:** Нутаг дэвсгэрийн 40 орчим хувь нь тайгын бүслүүрт оршдог усан сүлжээний нягтшил, чийгийн хангамж сайтай, гангийн давтамж шороон шуургатай өдрийн тоо хуурай хээр, цөлөрхөг хээрийн бүслүүрт байдаг аймгуудаас цөөн давтагддаг зэрэг нь цөлжилтийг өдөөгч байгалийн хүчин зүйлсийн нөлөөлөл харьцангуй бага байдаг ажээ. Гэвч дэлхийн дулаарал, үүнээс үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлт, буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гол горхи, жижиг нуур, цөөрөм хатаж ширгэх, бэлчээрийн ургамлын гарц муудах, хөрсний үржил шим доройтон элэгдэлд орж элсжих, зарим газар элсний нүүлт нэмэгдэх хандлага илэрч, Мөрөн, Их-Уул сумдын төвийн эргэн тойрон, Ренчинлхүмбэ сумын Товгийн түрүү зэрэг газруудад, Түнэл, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Арбулаг, Жаргалант сумдад газрын доройтол нэмэгдэж байна.

Энэ нь 1990-ээд оноос Хөдөө аж ахуйн нэгдлүүд тарж, мал хувьд шилжсэнээр малын тоо толгой жилээс жилд өсөж, бэлчээрийг ээлжлэн ашиглах, отор нүүдэл хийх асуудал үндсэндээ орхигдон өвөлжөө, хаваржааны хооронд буурь сэлгэхээс хэтрэхгүй болж, ихэнх худаг эзэнгүйдэн эвдэрч, усан хангамж муудаж, нэг дор олон тооны мал бэлчээрлэн хөрс



ургамал талхлагдаж, төв суурин газрын ойролцоо мал бүхий иргэд бөөгнөрч байгаагаас ургамлын нөмрөг малхлагдан элсжилт жил бүр нэмэгдэж хүрээгээ тэлж байна. Мөн сүргийн бүтэц алдагдан ямааны тоо толгой давамгайлах болсноор бэлчээрийн ургамал дахин сэргэх боломж багасч бэлчээрийн доройтол жилээс жилд нэмэгдэж байна.

Мөрөн сумын эргэн тойрны 60 км орчмын доторхи ойн сан хүний буруутай үйл ажиллагаанаас болж гамшгийн хэмжээнд хүрч, налуу газар ялангуяа 30 хэмээс дээш газрын ойн модыг хавтгайруулан огтолсноос ус тогтоох, хөрс хамгаалах байгалийн зохицолдолгоо алдагдаж салхи, усны нөлөөгөөр хөрсний үржил шимт давхарга устаж, эвдрэл элэгдэлд орж жижиг гол, горхины усан хангамж дутагдан тасарч ширгэхэд хүрсэн байна. Энэ бэрхшээлийг арилгах зорилгоор:

**Байгаль, цаг уурын өөрчлөлт хүний хүчин зүйлийн нөлөөллийн сөрөг үр дагавар болох цөлжилт, элсжилтээс урьдчилан сэргийлэх, үүнээс үүсэх хор уршгийг багасгах, сааруулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авна. Үүнд:**

Элсжилт үүссэн голомт, шинээр үүсэж болзошгүй газруудын байршил, талбайн хэмжээг тогтоож, шалтгааныг тодорхойлох судалгаа хийж, үнэлгээ тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэй хэрэгжүүлнэ.

Экологийн тэнцлийг хангах шинэ менежмент нэвтрүүлж, цөлжилт ихтэй бүсийг ургамалжуулж, ойжуулах, усан сан байгуулах, баг бүрт худаг гаргах зэргээр усжуулах, бэлчээрийг сайжруулах цогц арга хэмжээ авч, Мөрөн сумын Экологийн карт боловсруулж мөрдүүлнэ.

Цөлжиж элсжиж байгаа газрыг нөхөн сэргээх практик арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг бүх талаар бүрдүүлнэ.

Цөлжилт элсжилттэй тэмцэх иргэд, аж ахуйн нэгж байгууллага, иргэний нийгмийн болон ТББ-ын үүсгэл, санаачлагыг бүх талаар дэмжиж, тэдний оролцох оролцоог нэмэгдүүлж, сургалт, сурталчилгааны хүрээг өргөжүүлэх



урамшууллын оновчтой механизмыг нэвтрүүлнэ.

Цөлжилтөөс хамгаалах аймаг, сумын хөтөлбөр боловсруулж, батлуулан мөрдөж, төв, суурин газрын цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх, мод, бут суулгах, салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Бэлчээрийн эдэлбэр газрыг сэлгэн ашиглах, өнжөөх, даац багтаамжид тохируулан ашиглах, бэлчээр хамгаалах иргэдийн нөхөрлөл байгуулах зэрэг уламжлалт болон дэвшилтэт арга туршлагад түшиглэсэн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.

**Агаарын бохирдолыг арилгах бодлого:** Хөвсгөл аймагт агаарын бохирдол аймгийн төв Мөрөн суманд илэрч байна. Агаарын бохирдлыг иж бүрэн хэмжих багаж хэрэгслэл байдаггүйгээс нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралтыг тооцдоггүй зөвхөн азотын эсэл, хүхрийн эслийг хэмждэг байна.

Жил бүрийн агаар дахь азотын давхар исэл, хүхэрлэг хийн өвлийн хоногийн дундаж агууламжийн үзүүлэлтийг зэрэгцүүлж үзэхэд: Агаар дахь хүхэрлэг хийн өвлийн хоногийн хамгийн өндөр байдаг дундаж агууламж сүүлийн жилүүдэд бага зэрэг буурсан байгаа нь агаарын бохирдолтод нүүрс, түлээний шаталтын нөлөөлөл их нэмэгдээгүй байгааг харуулж байна.

Агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж 2003 оноос өсч, сүүлийн 3 жилд 1990, 2000 оны түвшингээс 2,2-2,5 дахин өссөн байна. Энэ нь олон төрлийн хэт хуучирсан, бензин шатахууны алдагдал ихтэй машин, эмх замбраагүй баригдаж үйл ажиллагаа эрхэлж буй шатахуун түгээх станцуудын шатахууны алдагдлаас нөлөөлж, агаарын бохирдлоор өвлийн улиралд Монгол улсад Улаанбаатар хотын дараа орж байна. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд: Агаарын бохирдлыг хэмжих аргыг боловсронгуй болгож, багаж хэрэгслэлээр хангаж, бохирдлыг бууруулах арга хэмжээ авна. Үүнд:



Тээврийн хэрэгслэлийн чанарыг сайжруулж, утаа багатай тээврийн хэрэгслэлийг хөдөлгөөнд оролцуулж, ШТС-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж, шатахууны ууршилтыг зогсоох,

Агаарын бохирдлын элементийн хэмжилт хийж боловсруулалт, дамжуулалтыг боловсронгуй болгож, нүүрсийг хийжүүлэх, хагас кокс болгон боловсруулах ба байгалийн хийг хэрэглэх, гибрид болон бүрэн шаталттай түлш хэрэглэдэг автомаишны ашиглалтыг урамшуулах, гэр хороололын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авч Мөрөн суманд агаарын чанарын харуул шинээр нэмж байгуулан сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, Мөрөн сумын агаарын бохирдлыг арилгах.

Агаар, хөрсний чанарын төлөв байдлыг аймагтаа тодорхойлох боломжийг бүрдүүлж, хэвийн ажиллуулж, холбогдох арга хэмжээ авах.

Уурын зуухны болон айл өрхийн утаа ялгаралтыг багасгах оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

### **ЗУРГАА. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГОЛ ҮР ДҮН,ТҮҮНИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ**

**Хөвсгөл аймгийн Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтийн 2008-2015 онд хүрэх түвшин: Аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж, Хүний хөгжлийн индекс, Мянганы хөгжлийн түвшингээр Монгол улсад эхний 10 –т багтана. Энэ зорилтын хүрээнд:**

Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүх талаар бүрдүүлж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтлан, эдийн засгийн өсөлтийг хангаж, ажлын байр бий болгож, хүн амын ядуурлыг 2 дахин бууруулах;

Хүний хөгжлийн индекс 0,780 болох;





5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2007 оныхоос 28,3 хувиар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмолын халдварын тархалтыг зогсоох;

Жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх;

Сургуулийн насны хүүхдийг бага боловсролд бүрэн хамруулж, сургалтад хамрагдвал зохих хүүхдийг бүрэн хамруулж, сургалтын чанарыг стандартын түвшинд хүргэх;

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, сургалтын олон хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;

Эдийн засаг жилд дундажаар 15,0 -аас доошгүй өсч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 3,0 саяас доошгүй төгрөгт хүргэх;

Ашигт малтмалын олборлолтын хэмжээг нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувийн жинг 5,0 хувьд хүргэж, өндөр технологи нэвтрэн өрсөлдөх чадвар дээшлэх;

Нүүрсний илэрц, ордуудыг шинээр ашиглаж, ашиглалтын технологийг боловсронгуй болгож, дулааны хэрэгцээнд шингэн болон хийн түлш өргөнөөр хэрэглэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх;

Аялал жуулчлалын хүрээг өргөжүүлж, хугацааг уртасган, жилд 15,0-20,0 мянган жуулчин хүлээн авах;

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдүүлж, ажилгүйдлийг 2007 оныхоос 3 дахин буурах;

Аймгийн төвийн гэр хороололын 30,0-аас доошгүй өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, аймгийн хэмжээнд жилд дундажаар 250-иас доошгүй өрх орон сууцны нөхцөлөө сайжруулах;

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, чанарыг сайжруулж, үр



ашгийг дээшлүүлж, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирч, хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг аймаг дотооддоо бүрэн хангах,

Дэд бүтийн салбарт томоохон зорилтуудыг хэрэгжүүлж, хатуу хучилттай замын урт- 550-ас доошгүй км-т хүрч, Хангайн бүсийн хэвтээ босоо тэнхлэгийн замыг сайжруулж, Уньт-Мөрөнгийн хатуу хучилттай замыг 2010 онд багтаан ашиглалтад оруулж, олон улсын нислэг хүлээн авч, Эрдэнэт-Мөрөнгийн төмөр замыг барьж эхэлнэ,

Аймгийн бүх сум байнгын цахилгаантай болж, бүх баг, малчин өрх нар, салхины эрчим хүчээр бүрэн хангагдана,

Аймгийн дотоодын хөгжлийн бүсүүд болон сумдын хөгжил сайжирснаар аймгийн төвийн хүн амын төвлөрөл саарч, төв рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн багасах,

Гэр бүл бэхжиж, хүн амын тоо өсөх, гэр бүлийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

Хамран сургалтын бохир жин бага боловсролд-100, дунд ангид 100,0 суурь боловсролд 90,0 хувьд тус тус хүрэх,

Олон улсын жишигт нийцсэн болон түүнд ойртсон, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын загвар цогцолбор сургууль бий болгох,

Баг, өрхийн эмнэлгийн тогтолцоо бүрэн төлөвших,

Аймаг, сумын эмнэлгүүд 100 хувь эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр хангагдаж, сумдаас оношилгоо, эмчилгээнд гадагшаа зорчигдын тоо 50-иас доошгүй хувь буурах,

Үйлчлүүлэгчийн эрэлтэд нийцсэн Европ болон уламжлалт эмчилгээний цогцолбор төвийг байгуулан ажиллуулж, Улаанбаатар болон



гадаад явж эмчилгээ, оношилгооны үйлчилгээ авдаг иргэдийн тоог эрс бууруулах,

Өвчний түүхийг бүрэн цахим картад шилжүүлэх,

Мөрөн сумын агаарын бохирдлыг бүрэн арилгаж, хог хаягдлын цогц менежментийн үйл ажиллагааг аймгийн хэмжээгээр хэрэгжүүлэх замаар орчны бохирдлын эх үүсвэрийг багасгаж, ил задгай хоггүй аймаг сум, болох

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, 2015 он гэхэд нийт газар нутгийн 30 хүртэл улсын тусгай хамгаалатад, 57,0 хувь буюу 5,7 сая га газрыг орон нутгийн тусгай хамгаалатад авсан байх

Мөрөн сумын хүн амын 100, Хатгал тосгоны хүн амын 80,0, хөдөөгийн хүн амын 60,0 хувийн ундны усны хэрэгцээг гүний худаг, усан сангаар хангах

Газрын нөөцийн менежментийн боловсронгуй болгох тогтолцоо бүрдэж, хэвшсэн байх





## НЭГ. БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ ХОТ

### БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

**Нэг. Булган аймгийн хөгжлийн өнөөгийн байдал.** Булган аймаг Монгол орны хойд хэсэгт байрладаг, ОХУ, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Архангай аймгуудтай хиллэдэг, ойт хээр болон тал хээр хосолсон 48.7 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, нийт нутаг дэвсгэрийн 40 орчим хувийг шилмүүст болон навчит ой эзэлдэг бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай.



64 дүгээр зураг

Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 2009 оны байдлаар 23,6 мянган хүн, ажиллагчдын тоо 22.5 мянга, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2940, үүнээс эмэгтэй 1610, дээд боловсролтой 1200, тусгай дунд боловсролтой 40, мэргэжлийн анхан шатны боловсролтой 60, мэргэжилгүй 3 хүн байна.





Тус аймагт ажилгүйдлийн түвшин 2009 оны байдлаар 12.4 байгаа нь Хангайн бүсийн дунджаас 0,9 хувиар бага байна. Ажилгүйдэл, ядуурлыг багасгахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бусад аймагтай харьцуулахад эдийн засгийн салбарын бүтэц хоцрогдонгуй хэвээр байгаа бөгөөд бэлчээрийн мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуй голлох үүрэгтэй байна. Аймгийн эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч урт хугацааны хөгжлийн Бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлуудцөөнгүй хуримтлагджээ.

Орон нутгийн төсвийн орлого 4,4 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 4,6 тэрбум төгрөг байна.

Булган аймаг 2008 оны байдлаар оны үнээр 87724,4 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэн бөгөөд үүнийг 2005 оны үнээр авч үзвэл 94114,0 сая төгрөг болж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар ДНБ 21,4 хувиар, бодит ДНБ 20,6 хувиар өсчээ. 2000 оны сүүлийн 5 жилийн үнээр тооцсон үйлдвэрлэлийн хэмжээг салбаруудаар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарт 68000,0 сая төгрөг, аж үйлдвэр 8900,3 сая төгрөг, үүнээс олборлох салбар 1100,0 сая төгрөг, боловсруулах салбар 6400,0 сая төгрөг, эрчим хүч, дулааны салбар 1300,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Түүнчлэн барилгын салбар 1800,8 сая төгрөг, худалдаа 540,6 сая төгрөг, зочид буудал, зоогийн газар 60,6 сая төгрөг, тээвэр, холбоо 810,8 сая төгрөг, санхүү 3260,7 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө 220,2 сая төгрөг, төрийн удирдлага 2890,0 сая төгрөг, боловсрол 3440,6 сая төгрөг, эрүүл мэнд 3366,0 сая төгрөг, нийгэм хамт олон 543,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлжээ.

Хангайн бүсийн бусад аймгуудтай харьцуулбал, Булган аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин харьцангуй өндөр буюу аймгийн ДНБ-ий 76.0 хувийг эзэлж байна. Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү,



цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай ажээ.

Булган аймаг нь Хангайн бүсийн бусад аймгуудыг бодвол дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн, Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагтай засмал замаар холбогдсон байна.

Булган аймаг цаашид хөгжлийн нөөц, боломждоо тулгуурлан боловсруулах аж үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, зарим ашигт малтмалын олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлснээр аймгийн эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, аймаг өөрөө биеэ даан нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх чадвартай болох боломжтой гэж тооцож байна.

### ***Булган аймгийн хөгжлийн давуу болон сул талууд***

Булган аймгийг хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурьдсан давуу болон сул талуудыг тооцон үзэв. Үүнд:

#### ***Хөгжлийн давуу талууд:***

- Аймгийн бүх сумдууд төвийн эрчим хүчний системтэй холбогдсон;
- Булган хот нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хоттой хатуу хучилттай засмал замаар холбогдсон;
- Булган аймаг нь өндөр хурдны шилэн кабелиар Улаанбаатар-Дашинчилэн-Хишиг-Өндөр-Орхон-Булган-Эрдэнэт-Дархан-Улаанбаатар гэсэн битүү цагирган сүлжээ үүсгэн холбогдсон;
- Бүх сумын төв, зарим багийн малчид, иргэд хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамрагдсан;
- Газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц болон байгалийн дагалдах баялаг ихтэй;



- ОХУ-тай шууд хиллэдэг, хилийн боомт, бүс нутгийн болон олон улсын гол замын гарцтай, жил бүр “эв модны наадам”-аа хийдэг түүхэн уламжлалтай;
- Байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудад аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой;
- Булган аймаг байгаль газар зүйн байршлын хувьд сэргээгдэх эрчим хүч хөгжүүлэх, түүний дотор томоохон голууд дээр усан цахилгаан станц, усан сан барих, байгуулахад маш тохиромжтой байршилтай; Цэвэр усны ихээхэн нөөцтэй;
- Байгаль газар зүйн байршлын хувьд аймгийн нутаг дэвсгэр дотроо аж үйлдвэржсэн, хөгжингүй хот-аймагтайгаа нягт хамтран аж төрөх боломжтой;
- Ажиллах хүчний нөөцтэй зэрэг болно.

***Хөгжлийн сул талууд:***

- Эдийн засгийн салбарын бүтэц ихээхэн хоцрогдсон;
- Аймгийн эдийн засагт бэлчээрийн мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуйн салбар голлох үүрэгтэй;
- Мах, сүүний үйлдвэрлэлийн түүхий эдийг тасралтгүй нийлүүлэх эрчимжсэн аж ахуй сул хөгжсөн;
- Газар тариалангийн салбарын аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологи хоцрогдсон;
- Байгалийн дагалдах баялгийг ашиглах үйлдвэрлэл хөгжөөгүй;
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг агаарын байдлаас ихээхэн хамааралтай;
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн түвшин доогуур, энэ талын тулгамдсан олон асуудлууд хуримтлагдсан;
- Хүн амын тоо цөөн, өсөлт удаан, тархай бутархай байршилтай, ажилгүйдэл



ядуурлын түвшин өндөр зэрэг болно.

Булган аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх **алсын хараа нь** хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Монгол Улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий, мэдлэгт суурилсан эдийн засагтай Хангайн бүсийн цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино гэжээ.

***Булган аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд нь дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:***

- Мянганы хөгжлийн зорилтуудыг тус аймагт хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, түүний дотор хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан болгоно.
- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтэц, барилгыг эрчимтэй хөгжүүлж, хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.
- Аймгийн төв, бичил бүс, сумдын төв, суурингуудыг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бий болгон экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.



## ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ХҮНИЙ БОЛОН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого.** Булган аймгийн эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 23,6 мянга, ажиллагчдын тоо 22,5 мянга, бүртгэлтэй ажилгүйдлийн тоо 2945, ажилгүйдлийн түвшин 12,4 хувьтай байна.

Хангайн бүсийн хувьд амьжиргааны доод түвшинг нэг хүнд сард ногдохоор авч үзвэл 90600 төгрөг, ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, тухайлбал, ядуурлын хамралтын хүрээ 46,6 хувь, ядуурлын гүнзгийрэлт 13,6 хувь, ядуурлын мэдрэмж 5,3 хувьтай байна.

Хангайн бүсэд хөдөлмөр эрхэлж буй 238.5 мян.хүн байгаагийн 9.4 хувь нь буюу 22.5 мян.хүн нь тус аймагт ажиллаж байна.

Зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйдлийн эзлэх хувь өндөр, ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа урт, бодит ажилгүйдэл төдийлэн буурахгүй байгаа зэрэг нь тулгамдсан асуудал болж байна. Мөн иргэдэд бизнес эрхлэж бие даан амьдрах мэдлэг, дадлага, туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс түргэн салж чадахгүй байгаа зэргээс хамаарч ажилгүйдэл, ядуурал буурахгүй байгаа ажээ.

Ажилгүйдэл, ядуурлыг багасгахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай ажээ.

Аймгийн хэмжээнд амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрх нийт өрхийн 23.7 хувийг, дундаж орлоготой өрх 44.1 хувийг, чинээлэг болон боломжийн орлоготой өрх 32.2 хувийг тус тус эзэлж байна.

1. Хүний хөгжлийг бүх талаар дэмжиж, 1600-аас доошгүй ядуу өрхийн амьжиргааг тогтвортой дээшлүүлж, 8000-аас доошгүй байнгын болон улирлын ажлын байр бий болгож, ажилгүйдлийн түвшинг 6.0 хувь хүртэл бууруулж, нийгмийн баялгийг бүтээхэд оролцдог иргэдийн тоог өсгөнө гэж үзэж байна. Үүний





тулд:

Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 6.0-аас доошгүй хувиар бууруулах

Ядуу, бага орлоготой малчин өрхийг уламжлалт мал маллагааны арга барилд сургаж, малжуулах ажил хийгдэж байна;

Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ялангуяа хөдөөд өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуучлалын салбарт хөдөлмөр эрхлэлтийг амжилттай хөгжүүлж байна.

Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн сургалтыг өргөтгөх, ХАА-н мэргэжилтэй ажилчид бэлтгэх МСҮТ байгуулах, хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтыг дэмжих, хамтран сургалт зохион байгуулаж байна;

Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх, ойн зурвас байгуулах, хөрс, бэлчээрийг хамгаалах зэрэг нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр татан оролцуулжээ;

Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгох, тухайлбал, сум, багийн төвүүдэд халуун ус, үсчин, оёдол, гутал засвар зэрэг ахуй үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах, явуулын үйлчилгээ бий болгох замаар хөдөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байна;

Мал аж ахуй, газар тариалан, хадлан, тэжээл бэлтгэх болон үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр хоршоо, нөхөрлөл байгуулах замаар албан бус хэвшлийг хөгжүүлэж; өрх бүрийг үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих, гахай, тахиа үржүүлэх болон бусад чиглэлээр туслах аж ахуйд хамруулах ажлыг сум бүрт хэрэгжүүлэж байна;

"Эрдэнэт-Булган-Уньт" болон "Уньт-Хутаг-Өндөр-Мөрөн", "Булган-Орхон-Хишиг-Өндөр-Хархорин", "Хутаг-Өндөр-Тэшиг-Бага Илэнх" чиглэлийн зам, "Ногоон хэрэм", "100



мянган айлын орон сууц төсөл"-үүдийн хүрээнд төв, орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээр зуучлуулан ажлын түр болон байнгын байр бий болгож байна;

Амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зэрэг чиглэлээр бүх талаар дэмжих ажил амжилттай хийгдэж байна.

Ажлын байрны тоог нэмэгдүүлэх, орон нутгийн зах зээлийг өргөтгөх, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэж байна.

**Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлого.** Булган аймаг 16 сум, 74 багтай, суурин хүн ам 61.4 мянга, 1 км<sup>2</sup> нутагт 1.26 хүн ногддог. Хотод 25 хувь, хөдөөд 75 хувь нь оршин амьдардаг. Өрхийн тоо 16.1 мянга. Үүнээс 3.8 мянга нь хотод, 12.3 мянга нь хөдөөд амьдардаг.

Булган аймгийн хүний хөгжлийн индекс 0.716, хүн амын дундаж наслалтын индекс 0.726, хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс 0.904, нэг хүнд ногдох ДНБ-ний (валютын худалдан авах чадварын паритет ам.доллар) индекс 0.516 байна.

2009 оны байдлаар Булган аймгийн суурин хүн ам 58.8 мянга, 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш насны хүүхэдтэй өрхийн тоо 591, өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийн тоо 1682, төрөлт 1250, нас баралт 329, цэвэр өсөлт 921, гэрлэлт 604, цуцлалт 27, үрчлэгдсэн хүүхдийн тоо 43 байна. Аймгийн хувьд 1000 хүнд ногдох төрөлт 20.5, нас баралт 5.4, цэвэр өсөлт 15.1, гэрлэлт 16.0, цуцлалт 0.7, үрчлэлт 0.7 байна. Хүн амын дундаж наслалт 68.57 байна.

Хүн амын бодлогыг хүн амын төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг бууруулах замаар аймгийнхаа хүн амыг өсгөх таатай орчин бүрдүүлэх шаардлагатай ажээ.

Хүн амын жилийн дундаж өсөлтийг тууштай нэмэгдүүлж. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;



Аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусгаж; залуу гэр бүл болон шинээр төрсөн хүүхдийг дэмжих сан байгуулан ажиллуулан; аймгийн төв, сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар хүн ам өссөн, төрсөн нутагтаа тогтвор сууршилтай амьдрах, ажиллах нөхцөл бүрдүүлэх; Хүн амын дундаж наслалт 68 байгааг 69-д хүргэж, аймгийн хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулах ажил хийгдэж байна;

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн менежментыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, тэтгэвэрийн хуримтлалын санг зохицуулах, боловсронгуй болгох замаар ирээдүйн тэтгэвэр олгох хөрөнгийн эх үүсвэрийг арвижуулах ажил хийгдэж байна; Малчин бүрийг нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалтай болгох ажлыг эхлүүлэж; нийгмийн даатгалын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох;

Иргэдийн нэрийн дансны мөнгийг баталгаажуулах, тэдний нийгмийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мэдээллийг ил тод болгож, нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах ажил эрчимтэй хийгдэж байна.

Иргэд ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, хүний хөгжлийг бүх талаар хурдасгаж; аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг эрс бууруулж эхэллээ;

Төрөлтийг дэмжсэн Засгийн газрын бодлогыг орон нутгийн онцлогыг тусган хэрэгжүүлэж; хүн ажиллаж амьдрах нийгэм, эдийн засаг, ахуйн орчны таатай нөхцлийг бүрдүүлэж байна;

Мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, аймаг, сумдын түвшинд хүн амын орлогыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээг тууштай хэрэгжүүлж байна;

Үйлдвэрлэлийн салбарын бүтэц, өсөлттэй уялдуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог оновчтой болгож; нийт малчдыг зайны сургалтад хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгон нэвтрүүлэх;



Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бий болгох бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн олон эх үүсвэрийг бий болгож; эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг оновчтой болгох даатгалын хамрах хүрээг өргөтгөх, давхар даатгалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож байна;

Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл, эмэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн ажлын агуулга, арга зүйг боловсронгуй болгох;

Аймгийн хүн амын хөгжлийн суурь судалгааг шинэчлэн, мэргэжлийн баг ажиллуулж, хүн амын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Эдийн засгийн өсөлтийг хангаж, нийгмийн хөгжлийг дэмжсэн жендерийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

**Боловсрол, соёлын хөгжлийн бодлого.** Булган аймагт 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургуульд 10.7 мянган сурагч суралцаж байна. ЕБС-д 568 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 26.7 сурагч ногдож байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 91.9, бага боловсролынх 84.6, дунд боловсролынх 95.4 байна. Тус аймгийн 23 цэцэрлэгт 96 багш ажиллаж, цэцэрлэгт нийт 2,0 мянган хүүхэд, яслид 85 хүүхэд хүмүүжиж байна. ЕБС-ийг өдрөөр төгсөгчид 1200, нэгдүгээр ангид элсэгчид 1100, дотуур байранд амьдарч байгаа хүүхэд 1906, үүнээс малчин хүүхдийн тоо 1405, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид 381 байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвд 642 хүүхэд суралцаж байна.

Тус аймагт 437 суудал бүхий 17 нийтийн номын сан ажиллаж байгаа бөгөөд уншигчдын тоо 10026-д хүрчээ. Аймагт 135 мэргэжлийн урлагийн тоглолт явагдаж үзэгчдийн тоо 14700-д хүрчээ. Тус аймгийн музейн нийт үзмэр 3960 байгаа бөгөөд нийт үзэгчид 4600-д хүрчээ. Тус аймагт 2486 суудал бүхий 16 соёлын төв ажиллаж байна. Мөн 4 сүм хийд ажиллаж байгаагаас 3 нь буддагийн, 1 нь христийн сүм байна.

Соёл урлагийн байгууллагуудын хувьд урын санг баяжуулах, музей, номын санг төрөлжсөн эрдэм судлалын ажлын орон тооны бус судлаачдын багаар бүрдүүлэх,



иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, соёлын өв тээгчдийг сурталчлах, өвлөн авах, ЕБС-ийг түшиглэн ардын уламжлалт урлагийн сургалтуудыг нээн хичээллүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалах хамгаалах ажлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай гэжээ.

Сургалтын байгууллагын бүтэц хэв шинж, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгож, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэн үйлчилгээний чанарыг сайжруулаж; гүнзгийрүүлсэн сургалттай сургууль, ангийг дэмжих, улмаар нэмэгдүүлэж байна;

Сум бүрт сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд ойртуулах арга хэмжээ авч, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэж; ЕБС-д электрон номын сан, алсын зайны сургалт нэвтрүүлэх, ашиглах, ажиллуулах нөхцөл бүрдүүлэж эхэлж байна;

Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ эзэмших нөхцлийг бүрдүүлэх, хими, физик, гадаад хэлний төрөлжсөн кабинет байгуулаж байна;

Математик, гадаад хэлний сургалтыг хөгжүүлэх аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох;

Бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсролыг давхар эзэмшүүлэх арга хэмжээ авчээ;

Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийг аймаг, сумдын төвд байгуулан ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлэж байна;

Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой хэлбэр болох явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулаж байна;

Оюуны багтаамж ихтэй, өндөр технологи эзэмшүүлэх зорилгоор залуучуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургаж байна;

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургуультай хоршсон шинжилгээ





судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулаж байна;

Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацийг нэвтрүүлж; ХААИС-ийн салбарыг нээн ажиллуулснаар орон нутагт дээд боловсролтой хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэж эхэлжээ;

Өндөр мэргэжилтэй багш нарыг орон нутагт ажиллуулах талаар эдийн засгийн урамшууллын хөшүүрэг бий болгожээ;

Сургууль, албан бус сургалтын чанарыг сайжруулах, эцэг эх, байгууллага, олон нийтэд түшиглэсэн боловсролын олон хувилбарт сургалтыг дэмжих, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааг хэвшүүлж; багш нарын мэргэжлийг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, сургалтын техник хэрэгсэл, лабораторийн хүрэлцээг нэмэгдүүлж байна;

Бага сургууль, цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын материаллаг баазыг сайжруулаж байна;

Сургууль бүрийг хямд өртөгтэй, найдвартай ажиллагаа бүхий интернет номын сантай болгож, “Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлжээ;

Боловсролын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас дэмжлэг авах замаар боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлж байна;

Багш нарыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон нутгийн төсвөөс багш нарт зориулан орон сууц барихад хөрөнгө хувиарлах, хувиараа орон сууц барихыг дэмжин бага хүүтэй, урт хугацааны зээлд хамруулах амьдралыг нь дэмжих.

Соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлж; сумдад соёлын төв, аймгийн төвд мэргэжлийн урлаг соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагууд ажиллуулах замаар соёл урлагийн үйлчилгээний оновчтой тогтолцоо бүрдүүлэх;

Номын сан, музей, соёлын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлэн, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах;



Булган аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн геронтологи сэргээн засалтын төв байгуулах;

Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж; зарим сумдад оношлогоо, сувилгааны төв байгуулан хөдөөгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

### **ГУРАВ. БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 4800.5 мянган төгрөгт хүргэж. 2016-2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 6500.9 мянган төгрөгт хүргэж, мэдлэгт суурилсан, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгоно.

**Макро эдийн засгийн бодлого.** Булган аймаг улсын ДНБ-ний 1.43 хувийг, Хангайн бүсийн 5.04 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд 2008 онд 87724.4 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэснээс хөдөө аж ахуйн салбарт 76.0 хувь, аж үйлдвэр барилгын салбарт 2.5 хувь, үйлчилгээний салбарт 21.4 хувийг тус тус үйлдвэрлэжээ. 2008 оныг 2007 онтой харьцуулбал нэрлэсэн ДНБ 24.4 хувиар, бодит ДНБ 20.6 хувиар өсчээ.

Булган аймгийн нэг хүнд ногдох ДНБ сүүлийн 3 жилийн байдлаар 1130.5 мян.төг байсан бол 2010 онд 1420.7 мян.төг болж 20.5 хувиар өссөн нь улсын дүнгээс 1.6 дахин, Хангайн бүсээс 2.2 дахин, Улаанбаатараас 1.9 дахин, Орхон аймгаас 10.2 дахин тус тус бага байгаа бол, Баянхонгор, Өвөрхангай аймгаас 1.5 дахин их байна. Нэг хүнд ногдох нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 1.7 сая, үүнээс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 1.3 сая төгрөг байна.

Тус аймгийн зээлийн өрийн үлдэгдэл 17078.3 сая төгрөг, иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 5111.3 сая төгрөг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 463.5 сая төгрөг байна.

Булган аймгийн орон нутгийн төсвийн орлого 4403.3 сая төгрөг, орон



нутгийн төсвийн зарлага 4622.2 сая төгрөг, улсын төсвөөс орон нутагт олгосон санхүүгийн дэмжлэг 454.2 сая төгрөг байна. Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого 2.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 3.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд улсын төсвийн байгууллагын нийт зардал нь 18.4 тэрбум төгрөг байна. Үүнээс нийгмийн халамжийн тэтгэмж, тэтгэвэр, хөнгөлөлт, тусламж хэлбэрээр 3.6 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангаас 9 нэр төрлийн тэтгэвэр, тэтгэмжид 5.2 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

Аймгийн дотоодын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн барилга байгууламж, их засварын ажил 1349.0 сая төгрөг болжээ.

Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэр, барилгын салбарт өсөлт бий болгох боломжтой ажээ.

Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бичил бүсүүдийг эдийн засгийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлснээр **хойд бүсэд** газар тариалан, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэж, ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох, **урд бүсэд** Улаанбаатар хот болон томоохон суурин газрыг мах, сүүгээр хангахад чиглэгдсэн үйлдвэр хөгжүүлэх, Хангайн бүсийн болон төвийн аймгуудад малын тэжээл нийлүүлэх, **зүүн бүсэд** аймгийн болон хангайн бүсийн аймгуудыг гурилаар хангах, **төвийн бүсэд** Орхон аймаг болон аймгийн төвийг мах, сүү, төмс болон хүнсний ногоогоор хангах, барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлж байна.

Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн хүрээнд ОХУ-тай хил залгаа Тэшиг сумын Бага Илэнх-Айнекийн боомтыг байнгын ажиллагаатай болгож байна;

Мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавьжээ;



Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэн уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, уул уурхайн орчин үеийн техник, технологи нэвтрүүлжээ;

Түүхий эдийн арвин нөөцдөө тулгуурлан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулаж байна;

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна;

Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх салбар болгож байна;

Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, дотоод, гадаадын зах зээлд гарах таатай орчин бүрдүүлж байна;

Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж, зээлийн хүүг үе шаттайгаар бууруулах;

Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад учирч болох эрсдлийг бууруулах, арга хэмжээ авч байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн өндөр технологи, менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлэх ажил хийгдэж байна;

"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг сум бүрт өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий "брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд гаргах;

Арьс шир, ноос ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүний орчин үеийн техник, технологи бүхий үйлдвэрүүдийг хөгжүүлж байна;

Өндөр технологид тулгуурласан, экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж; уул уурхайн салбарт эрдэс баялагийг



боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх;

Аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгож; экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах;

Боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн үйлдвэрлэл давамгайлсан, эрчимжсэн хөдөө аж ахуй бүхий аялал жуулчлал, үйлчилгээний салбар хөгжсөн аймгийн эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох;

Хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж; нутгийн өөрөө удирдах байгууллагын эдийн засгийн зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөхөд анхаарч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

### **ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАНУУДЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого.** Сүүлийн жилүүдийн байдлаар Булган аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт борлуулалт 3214.5 сая төгрөг байжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 онд 2041.6 сая төгрөгт хүрч 2007 оны мөн үеийнхээс 10.8 хувиар буюу 247.0 сая төгрөгөөр, уул уурхайн олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэлт 10.8 хувиар буурч, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 7.5 хувиар, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 16.5 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт буурсан гол шалтгаан нь согтууруулах ундааны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тодорхой шалтгаанаар түр зогссон, мөн гурил, тэжээлийн үйлдвэрлэл оны эхний саруудад түүхий эдийн хомсдолоос болж түр зогссонтой холбоотой байна.

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн бүтцийг авч үзвэл оёдол, нэхмэлийн үйлдвэрлэл 31.8 хувиар, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл 14.0 хувиар, шахмал түлшний үйлдвэрлэл 9.1 дахин, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 41.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.





Аймгийн хэмжээнд 39.2 мян.тн сүү, 38.0 мян.тн мах үйлдвэрлэж байна. Мөн үр тариа, төмс хүнсний ногооны нөөц арвинтай. Энэ нөөцийг ашиглан боловсруулах чиглэлийн үйлдвэр хөгжих боломжтой ажээ.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, зайрмаг, амтат ундаа, монгол дээл, зүсмэл материал, төрөл бүрийн мод модон эдлэл, үртсэн шахмал түлшний үйлдвэрлэл биет хэмжээгээр өсч, харин нүүрс, гурил, хивэг, согтууруулах ундаа зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл биет хэмжээгээр буурчээ.

Булган аймгийн нутагт байгаа эрдсийн нөөцийн зарим хэсгийг ашиглаж байна. Нилээд их хэмжээний олборлоогүй эрдсийн нөөцүүд Булган аймгийн өмнөд хэсэг ба Эрдэнэт хотын ойр орчимд өргөн тархалттай байна. Эрдэнэт хотын орчимд зэс, молебдин болон барилгын материалын түүхий эд болох эрдэсийн арвин нөөцтэй ажээ. Булган аймгийн өмнөд хэсгээр элсэн чулуу ба шохойн чулууны нөөцийг ашиглаж байна.

Булган аймагт 1998 оны байдлаар нийт нутгийн 8.5 мянган кв.км талбайд буюу 19.3 хувьд 1:50000-ны геологийн зураглал, 7.6 мян.кв.км талбайд буюу 17.2 хувьд нь 1:50000-ны масштабын жишгийн эрлийн ажил хийгджээ.

Одоогийн байдлаар Булган аймгийн нутаг дэвсгэрт 39 орд 88 илрэл тогтоогдоод байна. Эрдэс баялгийн ордоос цаашид аймгийн хөгжлийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх боломжтой ордууд байгаа ажээ. Бүрэгхангай сумын Өлзийтийн овоогийн цинкийн орд газрын төмрийн нөөц 70 сая тн, цинкийн нөөц 320 мянган тн, зэсийн нөөц 45 мянган тн байна. Хутаг-Өндөр сумын Айрхан, Гурванбулаг сумын Цагааннуур, Зараа зэрэг газруудад давсны нөөц байгаа нь тогтоогдожээ. Эдгээр давсны нөөцийг боловсруулан аймгийн хүн болон малын хэрэгцээг хангах боломжтой ажээ.

Тус аймагт барилгын чулууны нөөц ордууд нилээд байна. Үүнээс 3.3 сая куб.метр нөөц бүхий “1200” маркийн бетон дүүргэгчид тохирох Дэлийн хошууны орд, 1.65 мян.куб.метр нөөцтэй “200” маркийн хөнгөн бетон хийцэд тохирох Сайхан сумын Тогоо уулын шаарганы орд, 1.2 сая.куб.метр нөөц бүхий “50,75,100,125” маркийн бетон хийцэд тохирох Бийрийн голын Хүрэн булгийн орд, 1.5 сая.куб.метр нөөц бүхий хөнгөн бетон хийцэд тохирох барилгын чулуутай Сайхан сумын Бага тогоо



уулын Сайханы орд, 2.8 сая.тн нөөцтэй “1200-1300” маркид тохирох Гурванбулаг сумын Бор хошуу уулын Цагаан толгой орд, 8600 мян.куб.метр шааргын нөөцтэй “200” маркийн хөнгөн бетон хийцэд тохирох Гурванбулаг сумын Улаантолгой уулын Улаантолгойн орд, 4 сая.куб.метр орчим нөөцтэй Бугат сумын Их залуугийн овоо уулын Бага залуугийн Овоотын барилгын чулууны орд, 1.4 сая.куб.метр нөөцтэй Сайхан сумын Урд номгоны барилгын чулууны нөөц тус тус илрээд байна.

Булган аймаг болон Монгол улсын хувьд ихээхэн ирээдүйтэй эрдэсийн хөвөнгийн нөөц ордууд байна. Тухайлбал 12 сая.тн баталгаат нөөц бүхий Хөхчулуут уулын Хайртын овоогийн эрдэсийн хөвөнгийн нөөцийг түшиглэн томоохон барилгын дулаалгын материалын үйлдвэр байгуулах боломж байгаа ажээ. 2 сая.куб.м нөөц бүхий элс хайрганы хольц бүхий Хангал сумын Цагаан чулууны орд, 90 мян.куб.метр нөөц бүхий “100” маркийн тоосгоны үйлдвэрт тохирох Бүрдийн голын тоосгоны шаврын орд, 200 мян.куб.метр нөөц бүхий Баян-Агт сумын Хүсэл Овоо уулын Хунт нуурын тоосгоны шаврын орд, 420 мян.куб.метр нөөц бүхий Гурванбулаг сумын Бага тогоо уулын Цагаан хотгорын тоосгоны шаврын орд, 0.4 сая.куб.метр нөөц бүхий “50,150” маркийн тоосгоны үйлдвэрт тохирох Орхон сумын Сээрийн голын тоосгоны шаврын орд илрээд байна.

Нэг сая.тн нөөцтэй Сайхан сумын Эрээний нүүрсний уурхайг өргөжүүлэн Булган суманд шинээр баригдах дулааны цахилгаан станцыг нүүрсээр хангах боломжтой ажээ.

Нийт ажиллагсдыг салбараар авч үзвэл хөдөө аж ахуй, ан, ойн аж ахуйд 13.7 мянга, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарт 1.4 мянга, боловсрол, соёлын салбарт 1.6 мянга, бусад салбарт 1.4 мянган хүн ажиллаж байна.

**Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого.** Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 11.9 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 77.3 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина гэж төлөвлөж байна.

Өндөр технологи нутагшуулах төв байгуулан аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулах, цемент, барилгын бетон хийц, тоосго, эрдэс



будаг зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулаж байна;

Булган, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Сэлэнгэ зэрэг сумдад махны чиглэлийн загвар аж ахуй байгуулж мал бордох, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор болгон өргөжүүлж байна; Орон нутгийн махны нөөцийн 300.0 сая төгрөг бүхий сан байгуулжээ;

Булган, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Орхон сумдын гурилын үйлдвэрүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж тоног төхөөрөмж, технологийг шинэчилэх, Бүрэгхангай, Тэшиг, Баян-Агт сумдад гурилын жижиг үйлдвэр байгуулах замаар аймгийн гурилын дотоодын хэрэгцээ болон хангайн бүсийн аймгуудыг гурилаар хангах.

Сайхан, Могод сумдад үйлдвэрлэгдсэн “Сайхан айраг” брэнд хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэн, орчин үеийн тоног төхөөрөмж, технологи бүхий борлуулалтын сүлжээ, бирж бий болгох боломжтой ажээ;

Хишиг-Өндөр, Орхон, Гурванбулаг, Бүрэгхангай, Бугат, Дашинчилэн сумдад сүү цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэр байгуулаж байна.

Тэшиг суманд сүү, сүүн бүтээгдэхүүн, цөцгийн тосны үйлдвэр байгуулах, Баяннуур, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Булган, Дашинчилэн сумдад хүнсний үйлдвэр болон жимс, жимсгэнэ, хүнсний ногоог дахин боловсруулах үйлдвэр байгуулаж байна;

Хялганат тосгонд цул хийцийн зүймэл модон хавтан үйлдвэрлэх, Тэшиг, Бугат, Орхон сумдад гэрийн модон эдлэлийн үйлдвэрлэл байгуулах;

**Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого.** Сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний салбар өргөжиж байгаа боловч үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй, үйлчилгээний үнэ буурахгүй байна. Иймээс энэ салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцлийг сайжруулах шаардлагатай ажээ. Иймд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд үргэлжлүүлэх хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэжээ.

Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын



нэг болгон худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна гэж үзэжээ. Үүний тулд:

Бөөний болон жижиглэн удалдаа, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээнд тэргүүний техник, өндөр технологи нэвтрүүлэж байна;

Дотоод, гадаадын жуулчид, иргэдийг хүлээн авах зочид буудлыг Хутаг-Өндөр суманд байгуулсан туршлагаар бусад сумдад байгуулаж байна;

Худалдаа, үйлчилгээний салбарт интернет худалдаа, төлбөр тооцоог картаар хийх үйлчилгээ нэвтрүүлэж; банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, түрээс зэрэг бизнесийн үйлчилгээний салбарт цахим үйлчилгээг ажиглаж байна;

Худалдаа, үйлчилгээний салбарт стандарт, норм, нормативыг мөрдүүлэж; худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийг татвар, зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогоор дэмжиж байна.

Худалдаа, үйлчилгээний салбарт өндөр бүтээмжтэй техник, технологийг тууштай нэвтрүүлэх;

Интернет худалдаа, цахим үйлчилгээг аймгийн иргэдийн өдөр тутмын хэрэгцээ болгож; иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн худалдаа, үйлчилгээний газруудыг хүчин чадал, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулах шаардлагатай ажээ.

**Дэд бүтцийн хөгжлийн бодлого.** Булган аймаг нь бусад аймагтай харьцуулахад дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн төмөр зам, агаарын болон авто замын улсын сүлжээнд ойр, хилийн боомттой зэрэг хөгжлийн давуу талтай ажээ.

Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээний хувьд Булган-Хархорины 110 кВ, Эрдэнэт-Хялганатын 35 кВ, Булган-Хутаг-Өндөрийн 35 кВ-ын шугамаар бүх сумын төв, Сайхан сумын Сайхан-Овоо, Хутаг-Өндөр сумын Уньт, Хонгор, Орхон сумын Сээрийн багууд 1980-1990 оны үед төвийн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд 1960-аад оны дизель станц байх үеийн 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хэвээр үлдэж одоо хүртэл бүрэн хэмжээний засвар хийгдээгүй байна.



Аймгийн нутаг дэвсгэр дээрхи цахилгаан эрчим хүчний асуудлыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани хариуцан ажилладаг ажээ. Үүнээс: Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгоны цахилгаан эрчим хүчний асуудлыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани, Гурванбулаг, Рашаант сумын цахилгаан эрчим хүчний асуудлыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Хархорин салбар, бусад 12 сумыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Булган салбар хариуцан ажилладаг ажээ.

Засгийн газрын Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Улаанбаатар Баяннуур Дашинчилэн Хишиг Өндөр Орхон Булган Уньт Хутаг Өндөр Тариалан чиглэлийн хот хоорондын 310 км, Дашинчилэн Гурванбулаг Рашаант чиглэлийн 130 км-ын цагирган сүлжээ, Уньт-Сайхан чиглэлийн 87 км, Булган Бугат Эрдэнэт чиглэлийн 80 км, Булганаас Радио Релейний 162-р станц хүртэл 7 км, нийт 614 км газрын дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилсэн байна.

Аймгийн төвд 2500 хосын 15500 метр кабель шугам, 17 албан газар шилэн кабелиар, сум суурин газарт 1080 хосын 44540 метр кабель шугамаар телефон болон интернетийн үйлчилгээ үзүүлж байна.

Тус аймгийн хэмжээнд шилэн кабель дайраагүй Баян-Агт, Бүрэгхангай, Могод, Тэшиг, Хангал, Сэлэнгэ зэрэг зургаан суманд 2010-2012 онд шилэн кабель оруулахаар төлөвлөн ажиллаж үндсэндээ дуусч байна.

Интернет кафе аймгийн холбооны төв дээр байрладаг. 11 суманд интернет, ашиглах боломжтой юм байна.

Утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, бүх суманд Мобиком, 8 суманд суманд Скайтель, Юнитель, Жи мобайлийн салбарууд ажиллаж, үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 30000 гаруй болжээ.

Булган, Хишиг-Өндөр, Орхон, Могод, Сайхан, Баян-Агт сумын холбооны телефон сүлжээг өргөтгөн орчин үеийн технологи бүхий утасгүй холбооны CDMA-2000 станцыг ашиглалтад оруулж, “F зоны үйлчилгээ”-г шинээр нээн үйл ажиллагаа





явуулж байна.

Аймгийн хэмжээнд улсын чанартай 532,7 км, аймаг, сум хоорондын сайжруулсан болон хөрсөн 1023 км, сум, баг хоорондын хөрсөн 1230 км, хатуу хучилттай 27.5 км авто замыг тээвэр, зорчигчдын үйлчилгээнд ашигладаг ажээ.

“Эрдэнэт-Булган-Уньт” чиглэлийн хатуу хучилттай зам барих төслийн ажил Кувейт сангийн зээлээр амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд тус аймаг нь Монгол улсын дэд бүтцийн хэвтээ, босоо тэнхлэгийн замд хамрагдсан цөөхөн аймгийн нэг ажээ.

Улсын чанартай Хангайн давааны Дашинчилэн чиглэлийн 82,6 км, Эрдэнэт-Булган Чачиртын гүүр чиглэлийн 82,2 км, Арвайхээрийн чиглэлийн 215 км авто замаас Рашаант сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх 35 км, Дашинчилэн-Өгийнуур чиглэлийн 109 км хатуу хучилттай замаас Могод сумын нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрч байгаа 7 км, орон нутгийн чанартай Булган хотын доторхи 9 км хатуу хучилттай авто замуудаар Улаанбаатар Рашаант, Улаанбаатар, Дашинчилэн, Эрдэнэт, Булган, Хөвсгөл 3 чиглэлээр улсын нийслэлтэй холбогдож, нийт 215.8 км хатуу хучилттай замтай болжээ.

“Эрдэнэт-Булган-Уньт” чиглэлийн хатуу хучилттай зам барих төслийн Чачирт Уньт, “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн Дашинчилэн-Өгийнуур чиглэлийн 109 км хатуу хучилттай авто зам ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Орон нутгийн чанартай 169 м гүүр, улсын чанартай 620.1 м гүүр, түүний дотор Орхон, Сэлэнгэ, Хануй, Эгийн голын төмөр бетон гүүрүүдийг ашиглаж байна.

Аймгийн Засаг дарга болон Авто тээврийн газартай байгуулсан гэрээний дагуу Улаанбаатар–Орхон–Булганы чиглэлд “Хараацайн жигүүр” ХХК, Баяннуур Гурванбулагийн чиглэлд “Шуудан Тээх” ХХК, Рашаант УБ чиглэлд “АРО” ХХК зэрэг газрууд хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ явуулж, үйл ажиллагаа нь тогтмолжиж байна.

Аймаг хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг “Алтан шар зам” хоршоо,



Булган хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээг “Булган хүрд” хоршоо тус тус хариуцан үйл ажиллагаа явуулж байна.

Эрдэнэт Булганы хатуу хучилттай зам ашиглалтад орсонтой холбогдуулан иргэдэд үйлчлэх үйлчилгээг хүртээмжтэй болгож, тээврийн тарифыг доод хэмжээнд тогтвортой байлгах зорилгоор Эрдэнэт-Булган чиглэлд бага болон том оврын автобусаар үйлчилж байна.

Булган аймаг өнөөдрийн байдлаар 5515 авто машинтай. Үүнээс: суудлын машин 1980, ачааны машин 1137, автобус 193, цистерн, тусгай зориулалтын машин 44, механик 535, мотоцикл 1332, чиргүүл 294 байна. Булган аймаг 2005 оны үнээр 186.6 сая төгрөгийн цахилгаан, дулаан үйлдвэрлэжээ. Мөн Булган аймгийн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1349.0 сая төгрөгт хүрчээ. Барилгын материалын үйлдвэрлэлийн түүхий эдийн арвин нөөцтэй ажээ.

**Зам, тээврийн хөгжлийн бодлого.** Аймгийн автозамын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх ажил хийгдэж байна;

Чачирт Уньтын чиглэлийн Уньт Хутаг Өндөр Мөрөнгийн чиглэлийн Тэшиг Закаменьскийн чиглэлийн авто замыг барих засаж сайжруулах ажил хийгдэж байна;

Орон нутгийн замуудыг сайжруулан зарим голд холимог хийцийн гүүр барих; бага Илэнхийн боомтоос Булган хүрэх босоо тэнхлэгийн зам Булган Хархорины 210 км замыг барьж ашиглалтад оруулах ажил хийгдэж байна;

Орхон голын Зүр хүзүүний гармаар гүүр тавих; Могод, Сайхан сумыг холбож Орхон гол дээр төмөр бетонон гүүр барих ажлууд хийгдэж байна.

**Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого.** Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 0.9 хувиар өсгөж, уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 7,9 хувьд хүргэх зорилт тавьж байна.

Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын



тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил хийгдэж байна;

Сайхан-Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг нь бүрэн ашиглаж, нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, экспортлох, химийн үйлдвэр байгуулах;

Орхон гол, Эгийн гол дээр төсөл нь нэгэнт боловсрогдсон, 100 мвт хүртэлх хүчин чадалтай “Орхон голын усан цахилгаан станц”, “Эгийн голын усан цахилгаан станц” байгуулах ажил хийгдэж байна;

Булган-Эрдэнэтийн хатуу хучилттай авто зам дагуу баригдах үйлчилгээний газруудыг эрчим хүчээр хангах хаалттай дэд станц, 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугмын хамт барих, Булган сумын 0,4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг бетонон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэх, Булган суманд 2 хаалттай дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугмын хамт барих, Хутаг-Өндөр сумын Хантай, Орхон сумын Халиун, Бугат сумын Ханжаргалант зэрэг 3 багт 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр барьж, төвийн эрчим хүчний системд холбох ажлууд хийгдэж байна.

Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Булган, Могод, Хишиг Өндөр суманд 250 кВт ын чадалтай 10/0,4 кВт-ын дэд станц тус бүр нэгийг барих, Тэшиг суманд 35/10 кВт-ын 1 дэд станц, 10/04 кВт-ын 2 дэд станц шинээр барих.

Аймгийн 35/10 кВт-ын дэд станцуудын тосон таслууруудыг элегаз таслуураар сольж, найдвартай ажиллагааг дээшлүүлэх ажил хийгдэж байна;

Баян-Агт сумыг Булган-Мөрөнгийн чиглэлийн өндөр хүчдэлийн шугамтай холбох, ажил хийгдэж байна.

Аймаг, сумдын дулааны хуучирсан шугам сүлжээг өргөтгөж; хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангаж; барилга байгууламжид өргөнөөр ашиглагдаж байгаа нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуунус болон бусад зориулалтаар өргөн



ашиглах арга хэмжээ авах;

**Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого.** Аймаг, сумдын төрийн болон төсөвт албан газар, байгууллага, төрийн албан хаагч бүрийг дотоод сүлжээ, интернетэд бүрэн холбох ажил хийгдэж байна;

Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулах, Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэглээ болгох; Бүх сумдад 10-аас доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх нөхцлийг бүрдүүлэх; Орон нутгийн телестудийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевизтэй болгох ажил хийгдэж байна.

Аймаг, сумын төвүүдэд мэдээлэл технологийн төв байгуулах; Сумдыг орчин үеийн АТС-ээр хангаж; Өндөр хурдны агаарын шилэн кабельд холбох ажил хийгдэж байна.

Сумын төвийн холбооны систем болон аймаг, сумын хооронд дамжуулах системүүдийг тоон сүлжээнд бүрэн нэвтрүүлэх; Хангал суманд аймгийн хойд бүсийн технологи дамжуулах мэдээлэл, технологийн төв байгуулах ажил амжилттай хийгдэж байна.

Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллага зарим сумдын төвийн эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбох ажил хийгдэж байна.

Электрон засаглал, электрон арилжаа, электрон үйлчилгээ, электрон гарын үсэг зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэж байна.

Хутаг-Өндөр-Тэшиг, Бугат-Сэлэнгэ, Хишиг-Өндөр-Могод, Сайхан-Баян-Агт чиглэлд шилэн кабелийн өндөр хурдны сүлжээг шинээр байгуулж, интернетэд холбох боломж бүрдүүлэж байна;

Аймгийн төв болон шилэн кабелийн гол трассын дагуу өндөр хурдны DWDM (Dense Wave Division Multiplexing) төхөөрөмж суурилуулах, сумдад шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж S-385, S-325 тавьснаар бүх сумдыг IP технологид холбох ажил хийгдэж байна.



## ТАВ. БАРИЛГЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ

*Булган аймгийн хөгжлийн 3 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахи стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.*

**Барилгын салбарын өнөөгийн байдал.** Булган аймгийн барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1349.0 сая төгрөгт хүрчээ. Барилгын материалын үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцтэй ажээ.

Барилгын ажил үйлчилгээг төрлөөр нь авч үзвэл барилгын их засварын ажил нийт гүйцэтгэлийн 45.9 хувийг, шинээр барьсан объект 4.9 хувийг, 49.2 хувийг бусад зам талбайн ажил болон инженерийн барилга байгууламж эзлэж байна. Мөн барилга угсралт их засварын ажлын 19.1 хувийг улсын барилгын байгууллага хийж гүйцэтгэжээ.

Булган хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэсэгчлэн төлөвлөлтөөр тодотгох ажлыг үе шаттайгаар хэрэгжиж байна;

Булган хот, төв суурин газрын барилга байгууламжуудын газар хөдлөлтийн нөхцлийн бат бэх байдлын нөлөөллийг тооцох ажил хийгдэжээ;

Аймгийн төв болон сум, томоохон суурингуудыг төвлөрсөн дулаан болон цэвэр усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох ажил хийгдэж байна;

Булган хотын дулааны хангамжийн нэгдсэн станц байгуулах ажлын зураг төслийг хийлгэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх;

Булган хотын бичил хороолалуудын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх ажил хийгдэж байна.

Булган хотын газар доорхи инженерийн байгууламжуудын техникийн зургийг үндэслэн кадастрын зураглал хийгдсэн байна;

Инженерийн байгууламжуудын хүчин чадлыг тооцож барилга байгууламжид техникийн нөхцөл олгох ажил хийгдэж байна;





Аймгийн хэмжээнд барилга, байгууламжуудын насжилтыг тодорхойлож; хот суурины хүн амын цэвэр усны хангамжийг сайжруулаж; Булган хотын гэр хорооллуудын ус түгээх цэгүүдийг төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд холбох ажил үндсэндээ хийгдэж байна;

**Барилгын материал.** Нөөц нь тогтоогдсон болон геологи, хайгуулын ажлын үр дүнд илэрсэн ордууд нь барилгын шинэ нэр төрлийн материалыг бий болгох болон шинэ техник-технологи ашиглах боломжтой нөхцөлд тухайн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж байна;

Орхон сумын Орхон голын зүүн эргийн базальтийн ордод түшиглсэн барилгын дулаалгын материалын шилэн хөвөнгийн үйлдвэр байгуулаж эхэллээ;

Хангал сумын Цагаан чулуутын ордыг түшиглэн элс, хайрга олборлох карьер байгуулан ажиллаж байна;

Бугат, Орхон сумын нутагт байрлах аймгийн төвийн ойролцоо орших шаврын ордуудад түшиглэсэн улаан тоосгоны үйлдвэрийг аймгийн төвд байгуулан ажиллуулж байна,

Чулууны карьер байгуулж сортиментийн хайрга гаргах, цементийн болон таваарын зуурмаг хийх үйлдвэрийн цехүүдийг байгуулах судалгаа хийж байна;

Булган суманд өнгөлгөөний тоосго болон улаан тоосгоны үйлдвэр байгуулах ажил хийгдэн эхэлж байна. Мөн хөнгөн блок, төмөр бетон ба хүрмэн блокийн цех буюу жижиг үйлдвэр байгуулах цаашилбал шөрмөсөн чулуу, шилэн хөвөн болон ноос ашиглаж дулаалгын материал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах.

100 мянган орон сууц хөтөлбөрийн хүрээнд Булган суманд 200 айлын орон сууц барих болон хотын нийтийн эзэмшлийн орон сууцны барилга байгууламжийн ашиглалтын нөхцлийг сайжруулах ажил эхлээд амжилттай явагдаж байна;

Сайхан сумын Тогоо уул болон Урд номгон, Орхон сумын Бийрийн голын Хүрэнбулаг, Сайхан сумын Бага тогоо уулын Сайхан, Гурванбулаг сумын



Борхошуу уулын Цагаан толгой, Улаантолгой, Бугат сумын Бага залуугийн овоо зэрэг барилгын чулууны ордод түшиглэн бетон дүүргэгч хөнгөн бетон хийцийн жижиг үйлдвэрүүдийг байгуулах судалгаа дуусч байна;

Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, газрыг иргэн бүрт үнэгүй өмчилж, эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

Газрын мэдээллийн үндэсний системийг бий болгох мөн газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж эвдэрч талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах ажилууд хийгдэж байна;

Аймгийн төв, төвлөрсөн суурингуудад орон нутгийн хямд чанартай материалыг ашиглан иргэд, оршин суугчид ая тухтай, ажиллаж амьдрах орчин, нөхцөл бүрдүүлсэн тохилог орон сууц барих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил хийгдэж эхэлж байна;

Орлого багатай буюу нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг орон сууцаар хангах, орон сууц барихад хувийн секторын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажил амжилттай хэрэгжин эхэлж байна;

### **ЗУРГАА. БУЛГАН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО**

**Байгаль орчны бодлого.** Булган аймгийн цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл, тунадас 344.2 мм, агаарын температур 1 дүгээр сард 20.5 хэм С<sup>0</sup>, 7 дугаар сард 16 хэм С<sup>0</sup>, 2008 оны байдлаар гарсан ойн түймэр 15, ойгоос бэлтгэсэн мод 70.2 мянган м<sup>3</sup>, гол горхи 469, булаг шанд 620, рашаан 59, нуур тойром 106 байна. Агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламж 0,011 мкг/м<sup>3</sup> байна.

Байгалийн гамшгийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохирлыг багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авч байгаагийн зэрэгцээ аймгийн хувьд



удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авч байна

Байгаль орчны доройтлыг сааруулна. Аймаг, сумдын байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан ирээдүйд бүрдүүлэх;

Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх; айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх; хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, байгальд халгүй аргаар устгах технологи, менежмент нэвтрүүлэх ажил хийгдэж байна;

Газар ашиглалтын мэдээллийг иргэдэд хүргэх тогтолцоо бүрдүүлэх байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, нэн ховор ан амьтан, ургамлын тархацтай нутаг, аялал жуулчлал болон эрчимжсэн мал аж ахуй хөгжсөн бүс нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авах арга хэмжээ авчаа;

Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайд олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх; Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах замаар бэлчээрийн усжуулалтын түвшинг дээшлүүлэх ажил хийгдэж байна;

Хүн амын ундны ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг сумдад түгээх замаар эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх; экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах ажил хийгдэж байна;

Усны хими, физик, биологийн судалгаа явуулж, геохими, гидрохимийн зураглал зохиох, чанарын үнэлгээ өгөх, усны нөөц, чанарын шалгуур тогтоох; Төв, суурин газрын ундны усны эх үүсвэрийг иоджуулах, цэнгэгжүүлэх, эрдэсжилтийг багасгах ажил хийгдэж байна;

Зүүнтүрүү, Ачуут, Дундат, Балиг, Баян, Үнэгт цагаан гол болон бусад жижиг голын урсацыг нэмэгдүүлэх; Усны чанар найрлагыг тодорхойлох нүүдлийн



лабораторитой болох ажил эхэлж байна.

Баяннуур, Гурван булаг, Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдад мод, сөөгний үр бэлтгэх, тарьц, суулгац ургуулах мод үржүүлэгийн газар байгуулах; Шилмүүст модны үржүүлгийн хүлэмжийг голын хөндий, ойн сан бүхий газруудыг түшиглэн байгуулах; Нойтон мод хэрэглэхийг бүрмөсөн зогсоох, ойн цэвэрлэгээнээс гарсан модыг түлшинд хэрэглэх ажиллууд хийгдэж байна;

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төв байгуулах; Мэргэжлийн хяналтын лабораториудыг орчин үеийн техник хэрэгслэлээр хангах, хүний нөөц бэлтгэх; Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; Ган, цөлжилтийн явц, орчны өөрчлөлтийн хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх зэрэг ажлууд хийгдэж байна.

Цаг уурын хэмжилтийн цэгийн нягтрал, тэдгээрийн хэмжилтийн тоо хэмжих элементүүдийг нэмэгдүүлж, чичирхийллийн станцуудад техникийн шинэчлэл хийж эхэлжээ.

**Аялал жуулчлалын хөгжлийн бодлого.** Тус аймаг нь түүх, соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газар олонтой. Цаашид аялал жуулчлалыг аймгийн үйлчилгээний салбарт өсөлт гаргах, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх шаардлагатай.

Газар зүйн байршлын хувьд ОХУ-тай хиллэдэг, Монгол орны аялал жуулчлалын үндсэн нутаг Төв, Сэлэнгэ. Хөвсгөл, Өвөрхангай, Орхон, Архангай аймгуудтай хил залгаа оршдог учир аялал жуулчлал хөгжихөд стратегийн чухал ач холбогдолтой байна.

Аймгийн нутаг дэвсгэр дээр 16 жуулчны бааз, 2 анчдын отог, 10 амралтын газар ажилладаг. Эдгээрээс 1 дүгээр зэрэглэлд “Хоёр загал” “Хөгнөговь”, “Хөгнөхаан”, “Эмт”, “Монгол-Алтай тур”, 2 дугаар зэрэглэлд “Тавьт”, “Эден тур”, “Бичигт хад”, 3 дугаар зэрэглэлд “Монгол хаад”, “Эм Жи Ти” жуулчны баазууд тус тус ордог. Жилд дунджаар 3000 орчим гадаадын жуулчид, 4000



гаруй дотоодын аялагчдад үйлчилдэг байна.

Булган аймгийн төвд Аялал жуулчлалын цогцолбор байгуулж, тур оператор ажиллуулах асуудыг судлаж байна;

Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, түр буудаллах дэн буудлын сүлжээ байгуулах; Хөвсгөл-Булган-Эрдэнэтийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн төмөр замын ажлыг эхлүүлэх судалгаа хийгдэж байна;

Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл аймгийн чэглэлийн босоо тэнхлэгийн дагуух авто замын аялал зохион байгуулах, маршрут гаргах; Хутаг-Өндөр суманд гадаадын жуулчдыг хүлээн авах зочид буудлын сүлжээ бий болгох; Жуулчны баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргах арга хэмжээ авах ажлууд хийгдэж байна;

Түүх, соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлал, үзмэрийн зориулалтаар бэлтгэх; Тэшиг сумыг аялал, жуулчлалын болон тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд хамруулж, Байгаль далай, Хөвсгөл нуурын улс хоорондын аялал жуулчлалын сүлжээнд оруулан хөгжүүлэх ажил эхлэх судалгаа хийгдэж байна.

Аялал жуулчлалын маршрутын дагуух түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах; Аймгийн орон нутгийн болон угсаатны зүйн музейг засварлах, музейн сан хөмрөгийг арвижуулах; Аймаг, сумдад аялал жуулчлалын менежментийн болон гадаад хэлний сургалтууд зохион явуулах; Байгальд халгүй эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны баазуудыг хангах ажлууд төлөвлөгөөний дагуу хийдсэн байна.





## **ДОЛОО. ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ҮНДСЭН ЗАРЧИМ**

**Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн.** Ойрын ирээдүйд бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирч, эрдэс баялгийн үйлдвэрүүд байгуулагдана гэж тооцож байна.

Аймгийн ДНБ-ний хэмжээ жилд дунджаар 9 хувиар өсч 2015 онд оны 2005 оны үнээр тооцвол 183616.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэнэ гэж үзэж байна. 2015 оны байдлаар ДНБ-ий жилийн өсөлт 6.9 хувьтай байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий бодит хэмжээ 2008 онд 1532.8 мянган төгрөг байсан бол 2015 онд 4823,5 мянган төгрөг болно гэж тооцожээ.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 13.9 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин 14.9 хувьд хүрэх ажээ.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 0.9 хувиар өсч, салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь 2015 онд 7.9-д хүрнэ гэж тооцож байна.

Барилгын салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 13.3 хувиар өсч, барилгын салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийн жин 2.58 хувьд хүрнэ гэж тооцожээ.

Ойрын ирээдүйд аймгийн эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өсөн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа үйл ажиллагаа явуулж эхлэх ажээ.

Энэ үе шатанд боловсруулах салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 6,3 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 11,05 хувийг үйлдвэрлэнэ.



Олборлох салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 7,1 хувиар өснө гэж тооцож байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 0.88 хувиар өснө. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2021 онд 5.7 хувьд хүрэх ажээ.

Барилгын салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 7.0 хувиар өсч, тус салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 2.78 хувьд хүрэх юм байна.

**I үе шат:** Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр);

**II үе шат:** Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр).

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна.

Аймгийн ДНБ-ий хэмжээ хөгжлийн хоёр дахь үе шатанд жилд дунджаар 5.6 хувийн өсөлттэй байх ба 2021 онд 2005 оны үнээр тооцвол 239000.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх боломжтой болох төдийгүй 2015 онтой харьцуулбал ДНБ-ий хэмжээ 1.4 дахин нэмэгдэх ажээ.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2021 онд 3785.6 мянган төгрөг болж 2015 оноос 1013.5 мянган төгрөгөөр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.



**Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн талаар.** Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2008 онд 9.5 хувь байсан бол 2015 онд 10.7 хувьд хүрнэ. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 10.9 хувь байх нь байна.

Мөн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт энэ үе шатанд 6.3 хувь байх ба ДНБ-д эзлэх хувийн жин 2021 онд 11.05 хувьд хүрэх ажээ.

**Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн талаар.** Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 11.9 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 77.3 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурь тавигдах ажээ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 6.5 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 78.7 хувийг үйлдвэрлэнэ гэж тооцож байна.

**Уул уурхай буюу олборлох салбарын үйлдвэрлэлийн тухайд.** Уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 13.9 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт уул уурхайн салбарын эзлэх хувийн жин 14.9 хувьд хүрнэ гэж тооцож байна.

Олборлох салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 7.1 хувиар өсч, АҮ-ийн салбарт уг салбарын эзлэх хувийн жин 15.6 хувьд хүрэх ажээ.

**Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн тухайд.** Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 0.9 хувиар өсч, уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь 2015 онд 7.9 хувьд хүрэх ажээ.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 0.88 хувиар өсч, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2021 онд 5.7 хувь болох ажээ.

**Барилгын салбарын үйлдвэрлэлийн тухайд.** Барилгын салбарын



Үйлдвэрлэл аймгийн ДНБ-д эзлэх хувь 2008 онд 1.98 хувь байсан бол 2015 онд 2.58 хувьд хүрч, жилийн дундаж өсөлт нь энэ үе шатанд 13.3 хувь болох нь байна.

Барилгын салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 7 хувиар өсч, уг салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 2.78 хувьд хүрэх ажээ.

**ХАА-н салбарын үйлдвэрлэлийн тухайд.** ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 8.99 хувиар өсч, тус салбарын үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь 2008 онд 72.4 хувь байсан бол 2015 онд 72.2 хувь болж өөрчлөгдөх ажээ.

ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 5.6 хувиар өсч, 2021 онд тус салбарын ДНБ-д эзлэх хувь 72.01 болох юм байна.

**Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн тухайд.** Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 7.5 хувиар өсч, уг салбарын ДНБ-д эзлэх хувь 14.6 болж салбарын бүтцэд нилээд өөрчлөлт гарах ажээ.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 5 хувиар өсч, тус салбарын ДНБ-д эзлэх жин 2021 онд 14.08 хувь болно. Үйлчилгээний салбарт худалдааны салбарын эзлэх хувийн жин 2.9 хувь, санхүүгийн салбарын эзлэх хувь 32.4-д тус тус хүргэхээр тооцожээ.








### ОРХОН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ ХОТ БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

**Нэг. Нийгэм эдийн засгийн хөгжил хөгжил.** Орхон аймагт Монгол улсын хүн амын 3.4 хувь, Хангайн бүсийн хүн амын 16 орчим хувь буюу 89.9 мянган хүн оршин сууж, 2 сум, 22 багт 23,7 мянган өрх амьдарч байна. Аймгийн 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлтийн хэмжээг улсын дундажтай үзүүлэлттэй харьцуулахад 0,4-1,8 функтээр өндөр /Зураг1/ байна.

65 дугаар зураг



Хүн амын дундаж наслалт 67.1 харин хүний хөгжлийн индексийн 0.848 нь улсын дундажаас 0,119 –аар өндөр /Зураг2/ байна.

66 дугаар зураг





**Ажилгүйдэл, ядуурал.** Хангайн бүсэд хөдөлмөр эрхэлж буй 249.4 мян.хүний 13.8 хувь буюу 34.4 мян.хүн Орхон аймагт ажиллаж байгаа бөгөөд хүн амын 38.3 хувийг эдийн засгийн идэвхитэй хүн ам эзэлж байна. Ажилгүйдлийн түвшин 2008 оныг 2005 онтой харьцуулбал 0.6 хувиар /Зураг 3./ өсч ажилгүйчүүдийн тоо 1755 болсны 26.9% дээд, 10.9% тусгай дунд, 7.4 хувийг бага боловсролтой хүмүүс эзэлж байна.

67 дугаар зураг



Ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 1.8 дахин өндөр байна. Аймгийн нийт хүн амын 32.3 хувь буюу 8674 өрхийн 29030 хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой ядуу амьдарч байна. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч ядуурал дорвитой буурахгүй байгаа нь зүй ёсоор анхаарал татаж байна.

**Хүнийг бүх талаар хөгжүүлэх, хүн амын ялангуяа эх нялхсын өвчлөл, нас баралтыг бууруулах, хүн амын наслалт, ажиллах чадварыг уртасгах, хүн амаа өсгөх бодлогыг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн төлөвлөлттэй уялдуулан халамжийн үйлчилгээг оновчтой тогтоох, үр ашгийг нь дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.**



**Боловсрол, соёл.** 2008-2009 оны хичээлийн жилд 21 цэцэрлэгт 4102 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх хамран сургалт 80,0 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 6-14 насны хүүхдийн хамран сургалт 99.0 хувьтай байна. Өнгөрсөн хичээлийн жилд 7764 хүүхэд бага, 8356 хүүхэд суурь, 3554 хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмшиж 99.4 хувь нь стандартын шаардлага хангажээ. Аймгийн хэмжээнд бичиг үсгийн сургалтанд 153, суурь боловсрол олгох сургалтанд 235 албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд нийт 388, мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн дадал, ур чадвар олгох сургалтанд 1975 хүнийг хамрууллаа.



*68 дугаар зураг*

2007-2008 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагсдын тоог 2008-2009 оныхтой харьцуулахад 465 хүүхдээр буюу 2.3 хувиар буурсан бөгөөд 16 сургуулийн 619 бүлэгт 19674 хүүхэд суралцаж байгаагийн 9945 нь буюу 50.5 хувь нь эмэгтэй, 743 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Дотуур байранд 187 хүүхэд амьдарч, нэг багшид ногдох сурагчдын тоо 31,8 байгаа нь улсын дундажаас илүү /Зураг4./ байна.



69 дугаар зураг



Дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд 2008-2009 оны хичээлийн жилд 3134 оюутан суралцаж, 727 оюутан шинээр элсэж, 494 оюутан төгссөн байгаа нь өмнөх жилээс 38-аар илүү, шинээр элсэгчдийн тоо 205 хүнээр цөөн байна.

Соёл урлагийн 7 байгууллага үйл ажиллагаагаа явуулж, 159 ажилтан, албан хаагч ажиллаж, соёл, урлагийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж байна. Боловсрол, соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулан/ сургуулийн тоог нэмэгдүүлэх/, багш, соёлын ажилтнуудыг давтан сургах ажлыг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, цалин урамшууллыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.

**Нийгэм-эдийн засгийн эрчимтэй хөгжлийн эрэлт шаардлагад нийцсэн бие бялдрын боловсролтой, оюунжсан бүтээлч, чадамжтай хүний нөөцийг бий болгох чиглэлээр бүх нийтийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх зорилт тавигдаж байгаа ажээ.**

**Эрүүл мэнд.** Орхон аймагт 2008 оны байдлаар нэгдсэн эмнэлэг 1, сумын эмнэлэг 1, өрхийн эмнэлэг 13, хувийн хэвшлийн эмнэлэг 42, 36 эмийн сан, их эмч 252, дунд мэргэжилтэн 489 ажиллаж хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, 10000 хүн амд 28 их эмч, 54 дунд мэргэжилтэн, 48 ор, нэг их эмчид 321 хүн ногдож, их эмчээр бүрэн хангагдсан байна. Аймагт 0-1 насны нялхасын эндэгдэл



17,8 промилль /улсынх 19,6/, 0-5 насны хүүхдийн эдэгдэл 18,3 промилль /улсынх 23,6/, эхийн эндэгдэл 0 промилль /улсынх 48,8 промилль/, ор хоног ашиглалт 84,7 хувь, дундаж ор хоног 8,2 , 0-3 сартай жирэмсний хяналт 84,9 хувь /улсынх 83,5 хувь/, халдварт өвчин 160,0 промилль /улсынх 118,8 промилль/ байна. "ДОХ/БЗДХ-ын сайн дурын зөвөлгөө, шинжилгээ өгөх төв", Сүрьеэгийн диспансер"-ийг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж ажилласнаар сүрьеэ өвчлөл буурч, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар сайжирчээ.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, эмчилгээ-оношлогооны чанар, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ сайжирч байгаа хэдий ч санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, сум болон өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж жигд бус байна. Амьдралын буруу дадал хэвшлээс үүдэлтэй зүрх судас, хавдар, хоол боловсруулах эрхтэн системийн өвчлөл нь хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэн, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, эмчилгээ оношлогооны чанарыг сайжруулснаар өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилт тавьж хүн амын эрүүл, урт наслах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзжээ.**

**Нийгмийн халамж анхаарал.** Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалд 882 аж ахуйн нэгж, байгууллагын 20822 хүн, сайн дурын даатгалд 1826 иргэн эрүүл мэндийн даатгалд нийт хүн амын 78.0 хувь нь хамрагдаж байна.

**Хоёр. Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал.** Орхон аймгийн ДНБ 2007 оны байдлаар оны үнээр 918.6 тэрбум.төг байсан бол 2008 онд 1195.7 тэрбум.төг болж 30.0 хувиар өсчээ. Орхон аймаг Монгол улсын ДНБ-ний 19.5 хувийг, Хангайн бүсийн ДНБ-ний 68.7 хувийг (Зураг 5) үйлдвэрлэж байна.






70 дугаар зураг



Орхон аймгийн нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 2008 онд 9255.4 мян.төг болж 2007 оноос 12 хувиар өсөж, улсын дүнгээс 4.0 дахин, Улаанбаатараас 3.3 дахин, Дархан-Уул аймгаас 7.9 дахин, Хангайн бүсээс 3.0 дахин, Зүүн бүсээс 5.5 дахин, Төвийн бүсээс 6,5 дахин, Баруун бүсээс 8.5 дахин их (Зураг 6) байна.

71 дүгээр зураг




Орхон аймгийн ДНБ-д салбаруудын эзлэх хувийг авч үзвэл, 2005 оны байдлаар хөдөө аж ахуй 1.4, аж үйлдвэр, барилга 93.5, үйлчилгээний салбар 5.1 хувийг тус тус эзэлж байсан бол 2008 онд хөдөө аж ахуй 0.9, аж үйлдвэр, барилга 95.4, үйлчилгээний салбар 3.8 хувийг (Зураг 7) эзлэх болжээ. Улсын хөдөө аж




ахуйн салбарын 0.9 хувийг, аж үйлдвэр барилгын салбарын 48.3 хувийг, үйлчилгээний салбарын 1.7 хувийг эзлэж байна.

72 дугаар зураг



Орхон аймгийн ДНБ-ий салбарын бүтцийг улсын болон бүс, бусад аймгуудтай харьцуулбал хөдөө аж ахуй, үйлчилгээ бага хувийг эзлэж, аж үйлдвэр, барилгын салбар илүү давамгайлж (Зураг 8) байна.

73 дугаар зураг



Орхон аймгийн төсвийн орлого 2008 онд 30856.7 сая.төгрөг, төсвийн зарлага 31043.6 сая.төгрөг болж өмнөх оныхоос 26,2-26.3 хувиар өсч, улсаас татаас авахгүй өөрийгөө бие даан санхүүжүүлж байна.



**“Эрдэнэт” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж, ашигт малтмал олборлох, боловсруулах, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэл, электроникийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох, бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн фермерийн аж ахуй, усалгаатай газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх чиглэлийг баримтлах шаардлагатай гэж үзжээ.**

**Аж үйлдвэр.** Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимтэй хөгжиж, байгалийн баялагтаа түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэл дахин сэргэж байна. Монгол Улсын хэмжээнд томд тооцогдох Эрдмин ХХК, Эрдэнэт хивс ХК, Хөхган ХХК, Шимтехнолоджи ХХК, Ора метал ХХК, “Металл Интустрал” ХХК, “Орхон хийц” ХХК, “Монгема” ХХК, “Эрдэнэт прогресс” ХХК зэрэг боловсруулах үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2008 онд 1084.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2007 оныхоос 10.6 хувиар, үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 6.3%-иар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 38.0%-иар буурч, цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 29.3%-иар өсч, нийт бүтээгдэхүүний 88.9 хувийг уул уурхайн олборлох салбарт, 10.1 хувийг боловсруулах салбарт, 1.0 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Нэр төрлөөр нь авч үзвэл ган бөмбөлөг, архи, ундаа, ариун цэврийн цаас, молибдений исэл, хөшиг, барилгын модон хаалга цонх, хайрга зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлт буурсан байна.


Шинээр байгуулах үйлдвэрүүдийн нөөц, зах зээлийн боломжийг авч үзвэл **Эрдэнэт хотод** цэвэр, бохир усны нэгдсэн систем байгуулах, Эрдэнэт үйлдвэр технологийн паркийг түшиглэсэн үйлдвэрлэлүүд, Эрдэнэт ХХК-ний импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, төмөр хийцийн үйлдвэрлэл, хуурай сүүний үйлдвэр, хүлэмжийн аж ахуй, тэжээлийн үйлдвэр, сүү, махны эрчимжсэн мал аж ахуй,



хаягдал боловсруулах үйлдвэр, **Жаргалант суманд**, хүнсний ногоо боловсруулах үйлдвэр, хүлэмж, хүнсний ногоо, үр, зоорийн аж ахуйнууд болон хүнсний ногооны агротехникийн парк байгуулах, шуудайны үйлдвэр, гурилын үйлдвэрлэл байгуулах зэрэг нь Орхон аймгийн хөгжлийг дунд болон урт хугацаанд түргэсгэх боломжтой ажээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын орлого 2008 оны байдлаар 1134.9 тэрбум.төгрөгт хүрсэн нь, Хангайн бүсийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын 98.8 хувь, улсын 48.3 хувийг (Зураг 9) эзэлж байна.

74 дүгээр зураг



**Үйлчилгээний салбар.** Аймгийн ДНБ-ний 3.8 хувийг үйлчилгээний салбарт үйлдвэрлэж байна. Сүүлийн жилүүдэд бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллгааны салбарт өсөлт гарч байна.

Зочид буудал, дэн буудлын үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь 200 хүн нэг дор хүлээн авах хүчин чадал бүхий ресторан, 50-80 хүний хурлын танхим, интернет, бизнес үйлчилгээ үзүүлэх төв, саун массаж, гоо сайхны үйлчилгээ, караоке, биллиард, фитнес заал зэрэг зочдын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх чиглэлээр нэмэлт үйлчилгээ үзүүлж байна.



Үйлчилгээний салбар өргөжин хөгжиж байгаа хэдий ч үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй, үйлчилгээний үнэ өндөр хэвээр байна. **Үүнтэй уялдан үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний соёл, стандарт хангалт, ажиллах орчин нөхцлийг сайжруулах шаардлагатай байгаа ажээ..**

**Хөдөө аж ахуй.** Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд газар тариалан хөгжүүлэх боломж багатай ч дэд бүтэц илүү хөгжсөн, шинжлэх ухааны байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах боломж илүү байдгаараа давуутай байгаа ажээ. Мал, түүхий эдийг хангайн бүс, баруун бүсийн аймгуудаас хангах боломжтой.ажээ.

Орхон аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 30 гаруй аж ахуй нэгж, 1,3 мянга гаруй өрх 5.6 мянган га орчим эргэлтийн талбайд тариалангийн үйл ажиллагаа эрхэлж байна. Атрын III аяны /2008 онд/ жил 5134,9 тн үр тариа, 5670,1 тн төмс, 4220,8 тн хүнсний ногоо хураасан байна. Аймгийн эдийн засагт мал аж ахуйн үйлдвэрлэл бага хувийг эзэлдэг хэдий ч нийт малын тоо 2008 оны эцсийн байдлаар 269.9 мянгад хүрч 87.1 мянган төл бойжуулсан байна. Аймагт 21 үүлдэр, омог, хэвшлийн 9 мянган толгой малыг үржлийн сайжруулагчаар ашиглаж байгаа нь нийт малын 4 орчим хувийг эзлэж байна. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний хувийн хэвшлийн 8 нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 нь зөвхөн мал эмнэлгийн эмийн сангийн, 2 нь мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг эрхлэн явуулж байна. Сүүлийн жилүүдэд боом, цусан халдварт, дуут, галзуу зэрэг байгалийн голомтод халдварт өвчнүүд нэмэгдэх хандлагатай байна.

Газрын нэгдмэл сангийн тайлангаар бэлчээрийн талбай 51140 га, хадлан 1400 га байна. Нэг хонин толгойд 0.10 га бэлчээр ногдож байгаагаас үзэхэд бэлчээрийн өвс, ургамлын хэнзлэлтийг оруулан тооцоход бэлчээрийн даац 11,5 дахин хэтэрч, жилд дунджаар 600 гаруй өрхийн 180.0 гаруй мянган толгой малыг өөр аймаг сумдын нутагт өвөлжүүлж, хаваржуулж байгаас хот орчмын бүсэд цөөн тооны мал бүхий эрчимжсэн суурин мал аж ахуйн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх явдал зайлшгүй шаардагдаж байгаа ажээ.





Жилд дундажаар 9000-10000 тн хадлан бэлтгэж байгаа нь хэрэгцээний 20хувийг хангаж байна.

Хүн амын мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээний 25.7 гаруй, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний 6.5 орчим, гурилын 9.5 гаруй хувийг, хүнсний ногооны хэрэгцээний 71,1 хувийг, төмсний хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангаж байна.

Малчдын хөдөлмөр зохион байгуулалтын оновчтой хэлбэр болох хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж байгаа ч түүний хэрэгжилтийн явц удаан, малчдын хөрөнгө хүч, хөдөлмөр тархай, аж ахуйг удирдах арга барил дутагдалтай хэвээр байна. Мал аж ахуйд үржлийн ажлыг гардан хэрэгжүүлэх мэргэжлийн үйлчилгээ дутагдаж, малчид малын чанар үржлийн ажлын үр нөлөөг дутуу үнэлэх болсон нь малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

**Орхон аймгийн хөдөө аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх бодлогыг Жаргалант суманд хэрэгжүүлэн хөдөө аж ахуйн салбарыг тус суманд тэргүүлэх чиглэл болгон услалтын системийг улам өргөжүүлэх, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, га-гийн ургацыг өсгөх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний суулгац үйлдвэрлэл, хамгаалагдсан хөрсний ногоо, жимсний аж ахуй, зоорийн аж ахуй, өрхийн тариалан, тэжээлийн үйлдвэрлэл хөгжүүлэх зорилт тавигдаж байгаа ажээ.**

**Аялал жуулчлал.** Эрдэнэт үйлдвэр ХХК, Баян-Өндөр уул, Эрдэнэт овоо, Бурханы сэрэг дүр, “Сэлэнгэ”, Тайхар, “Олимп” зэрэг амралтууд, цанын бааз, олон улсын төмөр замын болон Хөвсгөл чиглэлийн аялал жуулчлалын авто замын тэнхлэг дайран өнгөрдөг зэрэг нь түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон нөөцийг бүрдүүлж байгаа юм байна. Нийт нутаг дэвсгэрийн 1,6 хувь нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг. Бүсийн хэмжээнд аялал жуулчдын дамжин өнгөрөх гол төв болдог ажээ. Гэвч жуулчид хүлээн авах шаардлага хангасан зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, үзвэрийн газрууд хангалтгүй, үйлчилгээний чанар, нэр төрөл, мэргэжилтэй боловсон хүчний



хүрэлцээ, жуулчин хүлээн авах даац, сурталчилгаа дутмаг байгаа нь аялал жуулчлал хурдацтай хөгжихөд саад болж байна.

**Аймагт аялал жуулчлалыг 1) Байгаль экологийн аялал жуулчлал, 2) Дамжин өнгөрөх тур аялал жуулчлал, 3) Өвлийн улирлын аялал жуулчлал гэсэн хэд хэдэн чиглэлээр хөгжүүлэх зорилт, боломж байна гэж үзжээ.**

**Дэд бүтэц.** Орхон аймаг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр холбогдсон, төмөр болон авто замаар Улаанбаатар болон бусад томоохон хотууд улмаар ОХУ, БНХАУ-тай холбогдсон, өндөр хурдны шилэн кабель, интернет, суурин болон үүрэн телефоны үйлчилгээ бүрэн нэвтэрсэн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн аймаг юм.

Эрдэнэт хот нь нийслэл Улаанбаатар хотоос авто замаар 420 км, төмөр замаар 426 км зайд алслагдсан, хөрш аймгуудтай асфальтан замаар холбогдсон төмөр замын баруун зүгт чиглэсэн эцсийн терминал юм. Аймагт тусгайлан зассан 190 км авто зам байгаагаас 54 км нь хатуу хучилттай, 135 нь сайжруулсан шороон зам бөгөөд хотын төвөөс бусад хэсэгт замын байгууламж зогсоол байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт нэмэгдэж Эрдэнэт хот хүрээгээ тэлж, захын хорооллуудад авто замын сүлжээ хангалтгүй байна. Хот хоорондын зам Эрдэнэт хот дундуур дайран гарч байгаа нь байнгын ажиллагаатай “Эрдэнэт үйлдвэр”-ийн ажилчдын тээвэр, 10 гаруй мянган тээврийн хэрэгсэлтэй хотын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байгаа тул хот хоорондын замыг сууршлын бүсээс тойруулж барьж байгуулах ажлыг төлөвлөн шийдвэрлэх шаардлагатай.

Зорчигч, ачаа тээвэрлэлтийг аж ахуйн нэгжид тулгуурлан хувийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэж байгаа хэдий ч зорчигчдын ая тухтай зорчих нөхцөл, ачаа тээврийн найдвартай байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс хамгаалах аюулгүй тээврийг бий болгох асуудлыг шийдвэрлэх, улс орны гадаад харилцаа аялал жуулчлал хөгжиж байгаа болон цагийн үнэлэмж нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд агаарын тээврийг сэргээн хөгжүүлэх, эдийн засгийн үр ашигтай байгаль



орчинд хор хөнөөл багатай тээврийг дэмжих, шинэ үр ашиг өгөх техник технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

Аймгийн 2 сум төвийн цахилгаан эрчим хүчний системд холбогдсон, Баян-өндөр сум төвлөрсөн ус, дулааны хангамжтай, Жаргалант сум нам даралтын системтэй байна. Хүн амын нягтрал, үйлдвэрлэл үйлчилгээний хөгжил, хотын суурьшлын бүс нэмэгдэж байгаатай уялдан цахилгаан дулааны эрчим хүчээр найдвартай хангах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд инженерийн шугам сүлжээ ашиглалтын хугацаанаас хамаарч муудсан, техник технологийн хүчин чадал хүрэлцэхгүй болсон өнөөгийн нөхцөлд эрчим хүчний суурь баазыг өргөтгөх, шинэчлэн сайжруулах, шинээр байгуулах ажлыг тодорхой үе шаттайгаар хийж, хүн амын амьдарч ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа ажээ.

Эрдэнэт хот Монгол улсын мэдээлэл холбооны суурь сүлжээнд шилэн кабелиар холбогдон, улс, хот хоорондын телефон ярианы технологи тоон системд бүрэн шилжээд байна. Аймгийн бүх сумдад суурин болон үүрэн телефоны МЦХ ХК, Мобиком, Юнител, Скайтел, Ж-мобайл зэрэг оператор компаниудын үйлчилгээ нэвтэрч нийт хүн амын 52,6 хувь нь телефон хэрэглэгч болсон байна. Кабелийн 2 телевиз, орон нутгийн эфирийн 3 телевиз, 4-н FM радио үйл ажиллагаа явуулж байна. Цаашид холбооны суурь сүлжээг өргөтгөх, захын хороолол, суурьшлын шинэ бүсүүдэд холбооны дэд бүтцийг байгуулан хөгжүүлэх ажил хийгдэж байна.

**Гурав. Хот байгуулалт, барилгын салбарын өнөөгийн байдал.** Орхон аймгийн хүн амын 96 хувь хотод, 4.0 хувь нь хөдөөд амьдарч байна. Эрдэнэт хотын хүн амын 50 хувь нь гэр хороололд амьдарч байгаа нь агаарын бохирдол, хөрсний эвдрэлийг ихэсгэж байна. Иймд газар нутгийн онцлог, хүн амын хэрэгцээнд үндэслэн хүн амыг орон сууцжуулах, ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан газар зохион байгуулалт хийх, дэд бүтцийг байгуулах шаардлагатай байгаа ажээ.

**Дөрөв. Байгаль орчны өнөөгийн байдал.** Орхон (Эрдэнэт хот) аймаг нь Уул уурхайн үйлдвэрлэлийг дагаж бий болсноор 30 гаруй жилийн хөгжлийн явцад үйлдвэрлэл үйлчилгээний салбар улам бүр эрчимтэй хөгжиж, дэд бүтэц, амьдрах



эдийн засгийн орчноо дагаж хүн амын төвлөрөл бий болсон нь Байгаль орчин, экологид сөрөг нөлөөллийг улам ихээр үзүүлэх болжээ.

Хот төлөвлөлт, газар зүйн байршлаас хамаарч гэр хорооллын 14300 өрхийн 3430.7 га хөрсний эвдрэлд орж түүнээс гарах утаа, хог хаягдал, ДЦС, ААН, байгууллагын нам даралтын уурын зуухнууд Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын аж ахуйн цагаан элс (тоос), жил бүр өсөн нэмэгдэж байгаа тээврийн хэрэгсэлийн агаарт хаяж буй хатуу бодис, хорт хий нь агаар хөрсний болон гадаргын усны бохирдолтонд шууд нөлөөлж байгаа ажээ.

Эрдэнэт хотын цэвэр усыг 64 км газраас 4 шахах насосоор дамжуулан өндөр өртөг зардлаар нийлүүлдэг боловч зүй зохистой хэрэглээ, эдийн засгийн тооцоо, судалгаа муу байгаагаас усны алдагдал буурахгүй жилд дундажаар 4000.0 мянган шоо метр куб усны алдагдал хүлээж байна.

Мод, модон бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр ихсэж түүнийг орлуулах түүхий эдийн үйлдвэрлэл, технологи байхгүйгээс жилд дунджаар 100.0-110.0 мянган м<sup>3</sup> модыг түлшинд, 2000 м<sup>3</sup> мод, модон бүтээгдэхүүнийг ахуйн хэрэглээ буюу үйлдвэрлэлд хэрэглэж байгаа нь Эрдэнэт хот орчмын ойн ногоон бүс, ойн санд ихээхэн хохирол үзүүлж байна.

**Орчны бохирдолтыг бууруулах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой нөхөн сэргээлттэй нь ашиглах, иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох шаардлагатай байгаа тал байна.**

**Тав. Орхон аймгийн хөгжлийн давуу болон сул талууд:** Орхон аймгийг 2009-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурдсан давуу болон сул талуудыг тооцон үзжээ.

***Хөгжлийн давуу талууд:***

- Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр
- Хүн амын нягтрал сайн



- Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дэлхийн зах зээлд өрсөлдөхөд ашиглаж болох үйлдвэрлэлийн болон түүхий эдийн арвин нөөцтэй
- Эдийн засгийн чадавхи, уул уурхайн салбарын хөгжил илүү
- Эрдэс баялгийн нөөцөө ашиглаж уул уурхай, барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлэх боломжтой
- Дэд бүтэц, хотжилт сайтай Бүсийн тулгуур төв хот
- Гадаад дотоод зах зээлд илүү ойр Монгол улсын нийслэл, урд хойт хөрштэй дэд бүтцээр холбогдсон
- Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой
- Аймгийн дотоод зах зээлийн багтаамж сайн, Монгол Улсын нийслэл хотын болон Төвийн бүсийн томоохон зах зээлд ойр зэрэг байна.

**Хөгжлийн сул талууд:**

- Газар нутгийн талбай бага
- Ажилгүйдэл ядуурлын түвшин өндөр
- Ур чадвартай инженер техникийн ажилтан, ажилчид, зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтний Хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, тоо цөөн
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн түвшин доогуур, энэ талын тулгамдсан асуудлууд хуримтлагдсан
- Эдийн засгийн салбарын бүтэц нь томоохон цөөн үйлдвэр дээр тогтсон /“Эрдэнэт” УБҮ, Эрдмин, Эрдэнэт хивс гэх мэт/
- Цагаан тоосны сөрөг нөлөөлөл
- Агаар хөрс, гадаргын усны бохирдол их
- Ойрын усны эх үүсвэрийн хомсдол, усны эх үүсвэрийн алслагдсан байдал нь усны өөрийн өртөг болон алдагдалд нөлөөлдөг
- Гэр хорооллыг байрлалыг анхнаас нь буруу тогтоосон.
- Тээврийн хэрэгслийн тооны өсөлтөөс авто замын түгжрэл үүсэх, ачаалал хэтрэх хандлагатай





## **НЭГ. ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД**

### **Орхон аймгийн хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго**

**А) Орхон аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх алсын хараа нь** хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын хөгжилд тэргүүлэх байр суурь эзэлдэг, оновчтой бүтэцтэй, мэдлэгт суурилсан эдийн засагтай, цэцэглэн хөгжиж буй ёс суртахууны өндөр соёлтой загвар аймаг болоход оршино гэж үзжээ.

Орхон аймаг нь хүний хөгжлийн түвшингээрээ улсдаа тэргүүлсэн иргэдтэй, тогтвортой хөгжлийг хангасан бүсдээ тэргүүлсэн өндөр бүтээмж бүхий эдийн засагтай, амьдралын цэвэр таатай орчинг үлгэр жишээ бүрдүүлсэн, сайн засаглал бүхий аймаг болохыг эрхэм зорилгоо гэж тооцож байна.

### **Б) Орхон аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд**

**Орхон аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ: Үүнд:**

Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэн “Эрүүл хот” төслийг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх

Дэлхийн жишигт хүрсэн мэдлэг боловсрол олгох, сурч хүмүүжих нөхцлийг бүрэн хангаж боловсрол, ШУ-ны салбарыг хөгжүүлэх

Уул уурхайн олборлох үйлдвэрүүдэд тулгуурлан хуримтлал бий болгож, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн орчин үеийн салбарыг хөгжүүлэх

Олон улсын стандартад нийцэхүйц, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл, өндөр соёлтой үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг бэхжүүлэх



Дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.

Байгальд ээлтэй дэвшилтэт технологийг дэмжин, нэвтрүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

**Хүний хийгээд нийгмийн хөгжлийн бодлого ашиглалт.** Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэн бүрийн амьдралын чанарыг тасралтгүй дээшлүүлэх. Гэр бүлийг хөгжүүлж, хүн ам зүйн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, хүн амьдрах таатай орчинг бий болгон, боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 2015 он гэхэд мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлнэ гэж үзэж байна.

**Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлого.** Хүн амын өсөлтийг ханган, дундаж наслалтыг 68.3-д хүргэн тогтвор суурьшилтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүүхэд, өсвөр үе, залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад чиглэсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн ам эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьдрал ахуйгаа сайжруулах, нийгмийн амьдралд үр бүтээлтэй оролцох, хөгжих орчинг бүрдүүлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэр төрлийг олшруулж, үр өгөөжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний чанар хүртээмжийг өргөжүүлэх, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн хамрах хүрээг оновчтой тогтоож, чанар хүртээмжийг нь сайжруулах ажил хийж байна.

Хүн амын боловсролын түвшин, эрүүл мэндийн байдал, орон сууцны хүртээмж хангамж, ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлж, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлж, дундаж наслалтыг 69.8 хүргэх, ажилгүйдлийн түвшинг 3.0 хувиас хэтрүүлэхгүй байлгах зорилт тавьж байна.

Үйлдвэржсэн хот болох зорилттой уялдан үйлдвэр дээрхи сургалтаар олон улсын жишигт нийцсэн өндөр зэрэглэлийн нарийн мэргэжлийн ажилчид бэлтгэх,



нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, өөрсдийн сонголтонд түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор шийдвэрлэнэ гэж тооцож байна.

**Эрүүл мэндийн хөгжлийн бодлого.** Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, цахим сүлжээ, алсын зайн оношлогоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулахад иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэн, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх ажил хийгдэж байна.

Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, харшил, хордлого, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг өвчин, гэнэтийн аюул ослын үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох, арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөөц чадавхийг нэмэгдүүлэх, хүн амыг стандартын шаардлага хангасан аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг төрийн бодлого, зохицуулалтаар дэмжих ажлууд эхлээд явж байна.

**Боловсрол, соёлын хөгжлийн бодлого.** Сургууль, цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлж, сургалтын таатай орчныг жигд бүрдүүлж, хүүхэд бүр ижил нөхцөлд боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг 85.0, суурь боловсролын хамран сургалтыг 99.9 хувьд хүргэх ажил хийгдэж байна.

Мэргэжлийн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийг байгуулан, өргөжүүлж, МСҮТ болон их, дээд сургуулиудын үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх, боловсролын салбарт оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих ажил бодлогын хүрээнд хийгдэж байна.



Иргэдийн эх хэл, бичиг соёлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, төгс эзэмшихэд чиглэсэн сургалт явуулж зайны сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд чиглэсэн амьдрах ухааны зайны сургалтыг эрчимжүүлэх ажил амжилттай хэрэгжиж байна.

Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг хөгжингүй орнуудын нийтлэг жишигт хүргэх ёстой гэж үзжээ. Үүний тулд шинээр сургууль, цэцэрлэг барих замаар ээлжийн коэффициентийг 1.2-д хүргэх, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг 95.0 хувьд хүргэж, сургалтын шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй оронтой хамтран Уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх хамтарсан сургууль байгуулах, хангайн бүсийн “Багшийн мэргэжил дээшлүүлэх төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сургалт, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний цогцолбор төв байгуулах ажлууд амжилттай хэрэгжиж байна.

Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн виртуаль номын сангаар иргэдэд үйлчлэх, стандартын шаардлага хангасан киноны хүрээлэн, мэргэжлийн урлагийн театр байгуулах, хотын доторх хөшөө дурсгалын цогцолборыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

2009-2015 онд мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 12.5 сая төгрөг буюу 10,0 мянган ам. долларт хүргэнэ. 2016-2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 20 сая төгрөг буюу 16.0 мянган ам. Долларт хүргэж, мэдлэгт суурилсан, экспортын баримжаатай, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгоно гэж үзэж байна.

**Макро эдийн засгийн бодлого. Эдийн засгийг энэ үе шатанд жилд дундажаар 10 хувиар өсгөж, эдийн засгийн салбарын бүтцийг эрчимтэй шинэчлэн аймгийн ДНБ-ий 94 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 1 хувийг ХАА-н салбарт, 5 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ гэж**



**тооцжээ. Үүний тулд:** “Эрдэнэт” үйлдвэр технологийн парkyг байгуулан, эдийн засгийн чөлөөт бүсийн үндсийг тавьж үйлдвэржилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил эхэлж байна.

МАА-н түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүд болон экспортын баримжаатай үйлдвэрүүдийг байгуулж, “Эрдэнэт” үйлдвэр, “Эрдмин” ХХК, “Эрдэнэтийн Дулааны станц ТӨХК” болон бусад бололцоотой үйлдвэрүүдийг өргөжүүлэх ажил хийгдэж байна.

Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангадаг болгох зорилт хэрэгжиж байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхүйц салбар болгож зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, дотоод, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх ажил хийгдэж байна.

Банк, санхүү даатгалын үйлчилгээг боловсронгуй болгож, Эрдэнэт санг аймгийн хөгжлийг дэмжих сан болгон, хөрөнгийг нэмэгдүүлж үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлэн Үйлдвэр технологийн парkyн хүрээнд шинээр бий болох жижиг дунд үйлдвэр байгуулах ажил хийгдэж байна.

Өндөр технологид тулгуурласан, экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг байгуулж уул уурхайн салбарт эрдэс баялагийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох ажил эхэлж байна.

Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, Төвийн болон Хангайн бүсийн зах зээлд нийлүүлэх ажил амжилттай хөгжиж байна.

**Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого. Түүхий эдийн нөөц боломжид тулгуурласан боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлж, экспортын**





**баримжаатай, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин аймгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно гэж үзжээ.** Үүний тулд дотоодын эрэлт хэрэгцээ, түүхий эдэд түшиглэсэн орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий жижиг дунд үйлдвэрийн чиглэлийг дэмжин хөгжүүлэх, Эрдэнэт үйлдвэрлэл технологийн парк байгуулж импортыг орлох, экспортын баримжаатай өндөр технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, техник технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлж үйлдвэрүүдийн бүтээмжийг өсгөх, боловсруулалтын түвшинг ахиулах замаар эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр болон бусад томоохон үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг бий болгох замаар хорших, туслан гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэн жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх ажлуудыг хийнэ гэж үзжээ.

Эрдэнэт үйлдвэрлэл технологийн парк дахь үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар экспортын баримжаатай, өндөр технологид суурилсан өрсөлдөх чадвар бүхий жижиг, дунд үйлдвэрийг бүтээн байгуулах эхлэл тавигдаж байна.

**Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг шуурхай болгох зорилгоор** жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, ашиглалт үр өгөөжийг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх эдийн засгийн шинэ механизмыг нэвтрүүлэх, өндөр технологийг нутагшуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах, тэргүүний техник технологийг нэвтрүүлэх хөрөнгө оруулалтыг татах тогтолцоог бий болгох ажил эхэлж байна. Бизнесийг дэмжигч төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл хамтын ажиллагааг сайжруулж, төрийн байгууллагын зарим чиг үүргийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлж бизнес инкубаторын үр өгөөжийг дээшлүүлж, бойжигчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

**Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар** металл боловсруулах, металл хийцийн үйлдвэрүүдийг байгуулах, уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”, “Эрдмин”, “Шим



технолоджи”, “Хөх ган” зэрэг ашигт малтмалын баяжуулалт боловсруулалтын үйлдвэрүүдийг түшиглэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулах эхлэл тавигдав.

**Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулахын тулд** бүс нутаг, хил залгаа аймгуудын түүхий эдэд тулгууран, шинэ төрлийн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилга, барилгын материал, түүхий эдийн судалгааны Хангайн бүсийн төвийг байгуулах ажил эхэлж байна.

Бетон, төмөр бетон, дүүргэгч материал, тоосгоны үйлдвэрүүдийг сэргээн, технологийг боловсронгуй болгох, энгийн хялбар технологиор шохой, гөлтгөнө, эрдэс будаг, зам талбай, засал чимэглэл, тохижолтын жижиг бүтээц эдлэлийн үйлдвэрлэл эхэлж байна.

**Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулна гэж тооцоолсон. Үүний тулд** МАА-г эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, үүлдэр, омог, гойд ашиг шимт малыг богино хугацаанд өсгөхийн тулд биотехнологийг өргөн нэвтрүүлэх, мал аж ахуй, хосолсон эрчимжсэн фермерийг байгуулах, өргөтгөх санаачилгыг бүх талаар дэмжих бодлого барьж байна.

Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг боловсронгуй болгож, материалаг бааз, боловсон хүчний хангамжийг нь сайжруулж мал, амьтны усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд оновчтой хэлбэрээр эзэмшүүлэн мал, амьтны тэжээлийн үйлдвэр байгуулах ажил эхэлж байна.

**Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого. Аялал жуулчлалын салбарыг өөрийн аймгийн онцлог, бүтцэд тулгуурлан хөгжүүлнэ гэж тооцоолж байна. Иймээс** хангайн бүсийн хөгжлийн төвийн аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг байгуулах, бурхан багшийн сэрэг дүрийн иж



бүрэн цогцолборыг ашиглалтанд оруулж, түүнд тулгуурласан аялал жуулчлалын маршрут бий болгох ажил эхэлж байна.

Өвлийн спортын материаллаг баазыг бэхжүүлж, түүнийг хөгжүүлэх замаар дотоодын өвлийн аялал жуулчдын тоог нэмэгдүүлж Баян-Өндөр уулыг иргэдийн амралтын бүс, аялал жуулчлалын цогцолбор болгон хөгжүүлэх, музей, уран зургийн галерейн цогцолбор байгуулах эхлэл тавигдаж байна.

### **ГУРАВ. ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Эрдэнэт Хотын ерөнхий төлөвлөгөө, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хотыг хөгжүүлэн иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэх ажил хийгдэж байна. Үүний тулд дараах ажлуудыг дэс дараалалтай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: **Газрын харилцаа төлөвлөлтийн бодлого. Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, газрын кадастр, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгоно гэж үзэж байна.**

Үүний тулд кадастрын зураглал, газрын бүртгэл, мэдээллийг бүхэлд нь хамарсан мэдээллийн нэгдсэн системтэй болж, иргэд байгууллагад цахим хэлбэрээр шуурхай үйлчлэх нөхцлийг бүрдүүлж геодезе зураг зүй, кадастр зураглалын ажилд хиймэл дагуулын системээс авсан сансрын зураглалыг ашиглах ажил хийгдэж байна.

**Эрдэнэт Булганы хооронд шинээр сууршлын бүс байгуулах асуудлыг судлаж шийдвэрлүүлнэ. Үүний тулд:**

**Дэд бүтэцийн хөгжлийн бодлого. инженерийн шугам сүлжээний хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангахаар төлөвлөжээ. Иймээс** аймгийн эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид техникийн аудит, дулааны системийн горимын тооцоог хийлгэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон инженерийн шугам сүлжээг шинэчлэх өргөтгөх, хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг хийх ажлууд хийгдэж байна.



Эрчим хүчний зүй бус алдагдыг бууруулах, гэр хорооллын цахилгааны шугам, дэд станцуудыг байгуулах, суурьшлын шинэ бүсэд эрчим хүчний шугам сүлжээ, дэд станц, өргөх насос станцуудыг байгуулах, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхээр тус тус ажиллаж байна.

**Байгаль орчинд хөнөөл багатай эрчим хүчний шинэ техник, технологи нэвтрүүлэх асуудал.** Хөдөөгийн малчин болон гэр хорооллын айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах, нарны илчээр ус, агаар халаах технологи, тоног төхөөрөмжийг өргөн ашиглах ажил эхлэн хийгдэж байна.

**Мэдээлэл, харилцааны технологийн ололтыг нийгэм эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ гэж тооцоолж үүний тулд:** “Цахим Эрдэнэт” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, шилэн кабелийн сүлжээний боломж хэрэглээг нэмэгдүүлж, сүлжээний аюулгүй байдлыг хангах, шинэ технологийг нэвтрүүлэх, холбооны суурь сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, захын хороолол, шинэ суурьшлын бүсэд холбооны дэд бүтцийг байгуулах ажил эрхэлж байна. Орхон аймгийн интернетийн гарцыг өргөтгөн, нийт аж ахуйн нэгж, айл өрхөд хүртээмжтэй болгох, Жаргалант сумыг улсын шилэн кабелийн холбооны суурь сүлжээнд холбох, Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэглээг өргөжүүлэх, мэдээллийн технологийн аутсорсинг, программ хангамж, интернет, мультимедиа болон вебэд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг хөгжүүлэх ажил хийгдэж эхлээд байна.

**Тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд** аймгийн асфальтан замын сүлжээг өргөтгөж, шинэ суурьшлын бүсэд авто замын сүлжээг байгуулах, хот доторх ачаа болон нийтийн тээврийн үйлчилгээний шаардлагад нийцсэн замын байгууламжуудыг байгуулах, авто вокзалыг стандартын шаардлагад нийцүүлэн барьж байгуулан ашиглалтанд оруулах, Эрдэнэт хотоор дайран өнгөрөх хот хоорондын авто замыг хотын төвөөс тойруулан тавих барьж байгуулах ажил амжилттай хийгдэж байна.



**Агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах хүрээнд** нисэх буудал, нислэгийн зурвасыг ашиглалтанд оруулах, дотоод гадаадын нислэгийн үйлчилгээг бий болгох эхлэл тавигдаж байна.

**Хот байгуулалтын хөгжлийн бодлого.** Хангайн бүсийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн болон тодотгосон ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хот байгуулалтын кадастр, бүртгэлийн нэгдсэн сан бий болгох ажил хийгдэж байна. Эрдэнэт хотод шинээр сууршлын бүс бий болгон хэсэгчилсэн болон тодотгосон ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, энэ үндсэн дээр гэр хорооллыг инженерийн шугам сүлжээ болон бусад дэд бүтцээр хангаж хот байгуулалтад нийцсэн амины орон сууцны хороолол бий болгох бэлтгэл ажил хийгджээ. Нийгмийн хэрэглээ орон нутгийн хөгжилд шаардлагатай барилга байгууламжуудыг барьж байгуулан хуучин барилга байгууламжийг паспортжуулан чанарыг дээшлүүлж ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч байна.

**Хүн амын өсөлт, хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлэх зорилт тавьжээ.** Үүний тулд 100000 айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд орон сууцны шинэ хорооллуудыг барих, орон сууцны хороолол барих гадаад дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг татах бодлого явуулж хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан орон сууц барих, орон сууц сан бүрдүүлж залуу гэр бүл болон бага дунд орлоготой айл өрхийг орон сууцаар хангах ажлууд үе шаттай хийгдэж байна.

**Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах талаар агаар бохирдуулагч эх үүсвэрүүдээс хаягдах бохирдолтын хэмжээг технологийн өөрчлөлт, зохион байгуулалт хийх замаар бууруулна гэж үзэж байна.** Үүний тулд: Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдээс хаягдах хорт хий, хатуу хог хаягдалыг шинэ дэвшилтэт, техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэнээр 30 хүртэл хувиар бууруулах ажил эхлээд явж байна.

Бүрэн шаталттай түлшний үйлдвэрлэл байгуулах, шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг нэмэгдүүлсэнээр гэр хорооллын айл өрхийн түлшний бүтцэд өөрчлөлт хийх, гэр хорооллын айл өрхийг барилгажуулах, инженерийн шугам





сүлжээнд холбосноор агаарт хаягдах хаягдал, утааг бууруулах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гэр хорооллын айл өрхийн хашаанд мод бут тарих замаар "Ногоон хот -Эрдэнэт"- ийг бий болгох хөдөлгөөн өрнөж нийтийн тээврийн үйлчилгээнд хийн болон цахилгаан тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, "Цагаан тоос" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, цагаан тоосноос үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч байна.





**Үдсүй çîðëëäîï õýðýãæççëýõýä:**

- Íîíãîë Óëñóò òççõ, áàáäàëü, ñîñóò òàèëëí çýóò °ä, áàðàðòàõ юм арвинтай.
- Àëäèéè èðýãçéí òããæëèä ñóóäü äîëîõ áàáäàëëéè èë, äàìä àñàð èõ äàýëäãтай
- Íççæëëí ñîñóò èðäýíðëëéè °ä äîëîõíí áýë-ýýðëéè ìàë àæ äóóé;
- Өвөрхангайчууд Èõ Íîíãîë Óëñóò °ä äîëîõíí Õàðòîðóò òççéèä áçòýýí äîëîõíí äà òççéè çõ ñàà мөн;
- ¹ºãæëéè áàáäàëëéè àèä äýëäàð, îðóò ñàíàà, äîëîõííðîëóò òççëè õºãæëè äýäèëä òççýò îºò äîëîõæ ààëèä. Ýý äîëîõ áàáäàëëéè çýóò ççëè мөн гэж үзлээ.

**Õºãæëëéè äîëîõíí äîëîõííðîëóòàð ðàðìòàëñàí äàâóó òàë ðîëîí ñóë òàëóóä Үүнд: Давуу тал**

- Áàáäàëëü, äàçàð ççéí òààëàèòàëé îºòºè, áàáäàëëü ððäîä ;
- Õºãæëëéè ñóóäü îºòºè äîëîõíí äýä áçòýò, ýäàíäóòà ýð-èè òç-, õîëàí, çàì òàðëèëäàí òççýëýýý, òàíàèæëëí òãäüä áóñàä àëèáóóààñ òàðóòàíä çç äàáóò, òààðëä òëè °ðàºäºí ñàæðóóèä çàíàð àëèëëéè õºãæëèä òààòàë îºò ççççëëéè äîëîõííèé;
- Áàáäàëëëéè îºòºè, õºãºò àæ äóóéè çèëääýðëëëéè òóððëäää, ÷äääðëäää òóèáóóðëè õºãæëè;
- Óóè òóððàéè îëäèðëè, äîëîõííðîëóòàð çèëääýðëëéè õºãæççëëýò ýðäýñ äàýëëëéè îëè èëýð, îºòççä, òóòàéëää, çýóò, °¹ºò, õîìð äà òàð ìàðëè, íççð, çàíàð, áèðóò, áàðëëüè ìàððëëüè îºòýé;
- Àëèäèä áçòýëä ìü òàíàðíàí äýëä æóóë-èä, àðàèò ñàáèëäèè îñîòèäàðúä áàáäàëëëéè õºãæççëëýò äýýí îºò, äîëîõííèéäàëé;
- Õççéè äîëîõíí íýäýæëëýéè äîëîõíí òç-éè òàðóòàíä ÷àððàë íàºòýé. Сул тал çç:
- Àëèäèéè òããæëëëéè íýäýñ äîëîõíí äîëîõíí òàíàðóòè òóèä áçò èðäýæëëýò òç- äîëîõííèéä íýäèäýí ÷èëççè, äýíæëè òóíèä äîëîõíí ÷èëýýýý òèý-ýýí äîëîõííðîëóòàð;
- Àëèäèéè õºãæëëëéè °ºãæëëéè òàð äàää, çèëääýðëëëéè, çèë-èëäýýíéè íýð òºè õºò, ÷àíàð äîëîõíí, àæëèè äàðúò õîä íýýä ççççëëýò äîëîõíí õýçààðëäääàë, ÷àíàð äîëîõíí, àæëèè äàðúò õîä íýýä ççççëëýò äîëîõíí õýçààðëäääàë, ÷àíàð äîëîõíí, àæëèè äàðúò õîä íýýä ççççëëýò äîëîõíí õýçààðëäääàë,



èðãÿàèéí ìèÿÿä õóâü íü õàãàñ àæèèãçéäèèéí áàéääèðàé, èè, ààèä àæèèãçé÷ççäèéí òíí, àìüæèððààííü áàòàèãààæèð òçâøèíäÿÿñ äííãóóð ìðèíäíòíé °ððèéí òííã áóóðóóèàõ;

- Õçí àìüã ìðíí íóðããò òíãòãíð ñóóðüøèèðàé, çð áçòÿÿèòÿé àæèèóóèàõ í°õ°è áíèíæèéã áçðãççÿõ, èðãÿàèéã °ðñàèéã° ð°ãæççÿõ, øèíÿ ìÿðãÿæèè, ìÿäÿã ÿçÿìøèð çàìààð àìüãðàèàä äÿÿøèççèðèéã áçò òàèààð äÿìæèð ;

**Õí, ð. Àéíãèéí ð°ãæèèéí áíèíäííü òÿðãççÿõ ÷èèÿé:**

Òóñ àéíãèéí ÿàèéí çàñãèéí áçòÿõ íü ð°ãæèèéí øààðãèãããà ò°àèèé°í ìèèÿÿãçé áàéíà. Õóðàèéããè, àéíãèéí ÄÁ-íèé 70 ãàðóé õóãèéã äÿ÷ÿÿðèéí ìè àæ àðóéí áçòÿÿãÿõççí ÿçÿæ áàéãàà íü áàéãàèü, òãã àããàðüí íãè°í°ñ øóóã òàìààðããã, ÿðñäÿèòÿé ÿàèéí çàñãòàé áàéãàà ажээ. Ýíÿ áàéãèãããñ ãàðãòüí òòèä àéíãèéí ÿàèéí çàñãèéí òÿðãççÿõ ÷èèÿéççèéã ààðãàð áàéãèããàð òíäíðòíéèæ áàéíà. Çíèé òóèä:

- Àøèãò ìàèòìàèüíòàà í°õ°ã òòèãóóðèáí óóè óóððàéí ìèáíðèíò, áíèíäííüðóóèàõ çèèãÿðÿéè ð°ãæççÿõ;
- Äÿ÷ÿÿðèéí ìè àæ àðóéí ìãííãèéí òçâøèíä òãããàèæ, óèìààð çàò çÿÿèèéí ÿðÿèò òÿðãÿòÿÿíèè äããóó ÿð÷èìæñÿí ìè àæ àðóéã ò°ã ñóóðèí ãàçðüã äããóóèáí ð°ãæççÿõ;
- Óñãèããàòàé ãàçàð òàðèàèáíà òçèòççí ÿðèÿõ çàìààð, ãàçàð òàðèàèããèéí çèèãÿðÿéèèã ìÿìããççèíÿ;
- Áàðèèãã, áàðèèããüí ìàðãèèèüí çèèãÿðÿéèèã ñÿðãÿÿí ð°ãæççèè, áìòííäíü òÿðãÿòÿÿã хангах;
- Õ°ã°ò àæ àðóéí òççðèé ÿä, áàéãàèèèéí í°ò áàÿèããò òçøèèÿÿíÿí æèæèã, äóíã çèèãÿðÿéèèã ð°ãæççÿõ;
- Äÿèèè æóóè÷èèè, ðàøààí ñóãèèèèüã ÿð÷èòÿé ð°ãæççÿõ ;
- Èðãÿí áçðèéã ñóð÷ áíèíäííò í°òèèèã òáíãàæ, ÷àìàðàé áíèíäííè ÿçÿìøèççèè;
- Õçí áÿðèéã ÿðççè àæ òðãò í°òèèèã áçðãççèèè;



Х<sup>0</sup>аæèèéí эдгээр оүдã¿¿ëүө ÷èãëүë¿¿äèèã оүдýãæ¿¿ëүөèéí оóèä äàðããò çìðèèòóóãüã дэвшүүлжээ. <sup>-</sup> ¿íä:

- Íðíí íóðãèéí ò¿¿ðèéé ýä, í<sup>00</sup>ä<sup>00</sup> ò¿ðèãëýñýííí íëáíðèíò, áíëíãñðóóèãò ¿éèããýð, æèæèã, äóíä ¿éèããýðëýë, ¿éè÷èèãýãüã íëííð áàèããóóèáí ò<sup>0</sup>ãæ¿¿ëүө, èðãýäèéíòýý óóíííèé áíëíí áóñãã оүдýãëýýã <sup>00</sup>ðèéí ¿éèããýðëýëýýð á¿ðýí òáíããò, áíòíã, äããããããüí çãò çýýë, ýëñííðòíä ÷èãëýñýííí ¿éèããýðëýë, ¿éè÷èèãýãüã äýíæèí ò<sup>0</sup>ãæ¿¿ëүө, òóããðãã òðñ<sup>0</sup>èã<sup>00</sup>í àèé áíëíò í<sup>0</sup>ðèèèèã á¿ðä¿¿ëүө çàìããò ò<sup>0</sup>ãæèèéí áíãëíãíí оүдýãæ¿¿ëý.
- Ñóíäüã äè÷èé á¿ñýýð á¿ñ÷èéýí ò<sup>0</sup>ãæ¿¿ëүө òàèããò <sup>0</sup>í<sup>0</sup> òèèããñýí ò<sup>0</sup>ñ<sup>0</sup>è, ò<sup>0</sup>è<sup>0</sup>ãè<sup>00</sup>ã оүдýãæ¿¿ëæ àæèèèããíä
- Õàðòíðèí òíòüã Õáíããéí á¿ñèéí òóèããóóð ò<sup>0</sup>ã, Æðããèéóýýð òíòüã àéíãèéí ò<sup>0</sup>ãæèèéí òãã áíëãíí ò<sup>0</sup>ãæ¿¿ëý.
- Æðèãò íàèòíàèýíí íðã äãçðüã àðèèèãò èðýý¿¿éí òáíãèãããòàé оýèãóóèáí íãííæèéí äýã á¿òóýý <sup>0</sup>ðãæ¿¿ëүө, òèíýýð äýã á¿òýò àèé áíëãíò àñóóãèèüã ñóãèèáí òèèããýðëýý.
- Áéíãã, ñóíäüã ò<sup>0</sup>ãæ¿¿ëүө áíãííãüã оүдýãæ¿¿ëүöãýý äðã èðãýäèéíòýý èãýãðòóýé íðíèòííã ò¿ðèãëýí íóðãèéí <sup>00</sup>ð<sup>00</sup> óàèðããò ,ñíü áàèããóóèèããüí ýðò оýíæýýã íýíãã¿¿ëүө, èãýãðè ñáíãã÷èããüã òðí¿¿ëүө çàìããò òèèããýðëýý.

**Ãóðãã. Áéíãèéí ò<sup>0</sup>ãæèèéí çìðèèòóóã, оýããýýðèéí ¿íãýñëýë, оүдýãж¿¿ëүө ¿éè àæèèèããã**

**Нэгд.** *Áéíãèéí ýäèéí çãñèéí ¿íãñýííí ñàèããòóóãüí ò<sup>0</sup>ãæèèéí áíãëíãí.* Íýã ò¿íä ííããíò äíòííãüí íèèò á¿òýýããýð¿¿íèé оýíæýý <sup>ã</sup>ððáíããé àéíããò 2005 íü áàèèèããò 368.0 ìýíããí òããðãã áàèèããã íü óèñííí äóíãæããñ äííãóóðð áàèéã. Èéíä æèè áóð ò<sup>0</sup>ñèèèéí òóðäòüã 8 òóãèèñ äííðã¿é áàèèããò òãè<sup>0</sup>ãè<sup>00</sup>æ áàèèããã í<sup>0</sup>ðèèèèã àéíãèéí ò<sup>0</sup>ãæèèéí òóðäòüã èè¿¿ áíã<sup>0</sup>ð ò¿ãðèéã ò<sup>0</sup>è<sup>0</sup>ãè<sup>00</sup> òããðãèèããòàé áíëæ áàèéã. Иймээс х<sup>0</sup>аæèèéí í<sup>0</sup>ãò áíëíæ, äãããóò òàèèãã íííã÷òíè àðèèèããò çàìããò àéíãèéí ýäèéí çãñèèèãã æèè á¿ð 22.0 òóãèèãò ò<sup>0</sup>ñã<sup>00</sup>. <sup>ã</sup>ððáíããñ àéíãèéí íýã ò¿íä ííããíò ÁÍÁ-èèã óèñííí äóíãæãã оýíæýýã òàðüòóóèíããò 2010 ííä 61.4 òóããü, 2015 ííä 71.9 òóããü ò¿ðãýý.





- Ооё оодооаеі іеаідөіѳ, аіеіаіѳдөөао зееааыд, æææеа, аоіа зееааыд, аадееауі іаòадееаеуі зееааыд, ýд÷еіæһы іае аæ адооé, оіаеааòае ааçад оадеаеаі, аýеае æооé÷еае, аідәө нóaеаеаеуі зее÷ееаыа оаæееéі оýдә з з ёýѳ ÷еаеýе аýæ з çýí ò з өò з з оаæ з з еіу. ÷ з іеé з д а з іа аæ з еееааыд, аадееауі ñаеаадуі æееééі аоіааæ оñөдееа 2005 іііі 0.5-1 ооаеад оñах;
- Аеіаеéі оаæееéі аіаеіауа іуаоаы çіөөооөаò, нóaеаò, а з аіуо оýіаеò оааеò аæеуі аеауа аеіаеéі Çаіаа аадауі аýдәуа ааеаооөах;
- Адааеоыд, Оадоідеі оіоуа çаò çýуе оаæөднóí а з ñ іооаеéі оіііоіí оіò аіеаіѳ, ñоіауа ае÷еé а з ñуыд оаæ з з ёýѳ оñө з з аеéа оýдәуаæ з з еэх;
- Оаæееéі оýдә з з ёýѳ ÷еаеýе з з аыд аіòіа, ааааауі одóíа° ідооөаеòòае, аæ адооéі іуаæ з з аеéа ааеаооөах;
- Øеіуыд аеé аіеаіѳ з еееааыдөуе, з еé÷еэаыуіа ааеааеуі ід÷еіа ñдóа іөөа з з өòòа з з өòòа, оаоііеіае іуаòд з з ёуоуа оýіаеò оааеò ñаеаадуі аіеіí аеіаеéі оаіòадñаі оіаòіөоііа а з дә з з еэх;
- Аеіаеéі іоòаа ауаíаудò еуыдñы аөеаò іаеòіаеуі ідә ааçдооауі ееòаіçеéі оýіаеòòа аеіаеéі ÈÒ-уі іуауеа оааөд з з өæ, ідí іооаеéі уçуіөеé, ідíөоіíөіаíѳ аөеаеаò ідә ааçдооауі æааíааеòòа аадааіа.
- Оаæееéі оýдә з з ёýѳ ÷еаеýе з з аыд аіеіаіѳдөөñаі оñө, оòаеа°д з з аеéа İíаíе оеíаа оаіаеаеаа÷ауі çаæөеа°í, оаìòуі аæееааааíу аóíаа оіііоіí адаа оýіаууі з з ауа ааеіаа оаіеөооөаò адаа оýіауу ааах;
- Аæееаò о з ÷іеé і°ò аіеíí аууа ñóдаооөу, іуыаæееéі ñóдааеò з еееааыдөуеéі оаа аýеòауо аіеіаííí о з ÷іеé іуыаæееéі ÷еаеýеééа оаæееéі оýдә з з ёýѳ ÷еаеýеуыд ааеаооөаò аæ адооéі іуаæеа øаадаааааò удýө, çадеаеауі аааоó аýеòауу.
- Іуа ñоодéі іуа а з оууаауо з з í аýһы одеаòае аæееаæ, адыа а з оууаауо з з іеé ñаíòаé аіөгох;
- Ýеííдòуі аадеіааòае æææеа, аоіа з еееааыдөуеééа оаæ з з ёуоééа аіаеіаíѳд аýіаеèх;
- "Аеіаеéі оаæіеéí ñаí"-аеéі а з оуо, іаíаæіаíòеéі з еé аæееаааааа оаìòуі аæееааааíу ÷еаеýеуыд °д÷өí çіөеíí ааеаооөах;
- Аеçіаíеéі еіеóааòíдуа Адааеоыд, Оадоідеіа ааеаооөах;



**Хоёрт.** Ооё ооддөөиё иёаидёиё, аиёиандөөёоёо ёёёааюдёёёёёё ооаёёёёё, 2010 ийа аёиёёёи ААА-иёё 9.3 ооау, 2015 ийа 22.7 ооауа оёдөөх ажээ. Газрын баялгаас оиёа-оёиё, ёиёёёиё ааёёёаао аёёёёёё ё-ааааё аёиёёёи ооаёёёё оааоаё иёоо ёёёёёёёёё аёёёо иаёоиаёуи иоо ёооёё. Оооаёёёаё, оон аёиаао аёо, ёуи, оиёид аа оиёо иаоаёё, ааёёёуи иаоаёёёуи оёёёёё ёа, иёёёё, аоао иаоаёё ёуёа 33 ооёёёи аёёёо иаёоиаёуи 200 иё-ёи иёа, ёёуёо ааёёаа иу ноааёёааааао оиёоииёаиё аоооа оааёёё ёауёуё иёа, ёёуёоёёёё иаёёёё-ёёёиё ноааёёаа ёаооёё, иооёёё иу оиёоиё, ёуёёё, ёёуёуё ноддөөаёёи а- оиёаиёаиё аёёёё иёа ааёоооуа иуёи ёёёёёё ёаиаао оон аёиаао ооё ооддөөиё иёаидёиё, аиёиандөөёоёо нёёёаоуа ёё-ёиёёё ооаёёёёё аиёиё ааёёаа ёи.

Аёиёёёи ноаёёааааё оиёоииёаиё иёа, ёёуёоёёёё ёёуёё ооаёёё аёёёёааёё ааёёаа аааао ёооо аёоуи ёиёиё иёаиё иёаидёиёо оёёё ааёиё. Иёёо ноаёёаааи оиёоииёаиё иёа, ёёуёоёёи 20 иё-ёи ооаёёёо иу иоо, ё-аиёоуа ёуёёёи ааёиё. Ёауёуё ёуёёёаиё иёа, ёёуёоёёёё ёёуёё оуёуа иу аёоуи ёиёиё иёа, иёёёё, ааёёёуи иаоаёёёуи ёауёи оёёёёё ёаёёи иёа, ёёуёоёёёё ааёиё. Аооаа ёауёи, оёёёё ёаёёи ооауа ааиёиёёи ноаёёааа иу аиёаи аоуи оиёи ооаёёёоо ноаёёааиё ааёиё. Үүний тулд: Ноддөөаёёи а- оиёаиёаиё аёёёё аёёо иаёоиаёуи иёа ааёоооуа ёёуёуё иуёи ёёёёёё, ёаёёи оиёиёиё ёёуёоёёёё иооёёё оиёаиё ёёёёёуёуё аёёо иаёоиаёуи ёуёё оаёёооёуи аёёуа ёё-ёиёёёёё ажил хийж байна.

Ёуи, иёёёааи, ауёоаиёё, оооо, оаёёооо ёиё, аиёуи ё-ооо, ёаиао, ааёёёуи иаоаёёёуи иооёёи ёёуёуа оёёо оаёёооёуи аёёуа ёуёё ёуёёёа ёуёёё асуудал хөндөгдөж байна. Аауёуёаёёи иёёёиёё ооддөөиё аёёёёёоуи оё-ёи ё-аёуа иуёуааёёё, иёёёиёё ооддөөиё оёёёёуи иёёёёёё ааёёи аиёиандөөёоёо, аоиаё оёёёиё ёёёааюдёёёёё ааёёооёах ажил эхэлж байна.

И-ёН аоао иаоаёёё, ааёёёуи иаоаёёёуи ёёёааюдёёёёуёуё Оаиёаёи аёёёи оуёуаоууа оаиёао ёёёёёуёуё оиёёёи аёёёёёж, ёё ооддөөиё ёёёааюдёёёё ааёёёуи иё-ёиё оид ооооёёёё оаоииёиё ёуаодёёёё, баёёаёёёи иооёёё ёуёёёуёиё иди оооёёи найа аёё аиёаи, аёиёёи аауёёиёиёёи ноаёёааа оёёё, ноо, аауёёёёи аёо ооёёоо оуёуаёёё- иу ооёоо оооо оиёоёёоо аёё аиёаи хэрэг ажлууд амжилттай хийгдэж



байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.

**Гуравт.** Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд: Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.

Мөн үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.

Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.

Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна. Үүнийг хангайн бүсийн тулгуур төв хот болгон байгуулах ажиллагаа үе шатаар хийгдэж байна.



нààñóóëäà, ààäëàà àíñäëýí çéëäáýð ààéäóóëàõ, "Íýä ñóóðëí-íýä áçòýýäáýðççí" ò°ò°éá°ðëéä õýäýäæççëëõ, жëë áçð Óëààíáààòàð òìò, áçñëéí òëë çàëäàà àéíäóóäàä ççýñäýéýí òóààëäàà çíðëíí ààéäóóëæ жорилтоо амжилттай хэрэгжүүлж байна.

**Дөрөвт.** Ààðëëäýí àòàððëäëýí í°òä°ò òçòëäëýí áçñ íóòäëéí ààðëëäýí àòàððëäëýí õýäýäáýýä òàíäàò çíðëëäíð ýýý ñàëäàðýí çéëäáýððëýëëä ýð÷èòýé ò°æççëýð, àéíäëéí àíðñäýí íëëò áçòýýäáýðççíä ààðëëäýí ñàëäàðýí ýçëýð òóàëéí æëíä 2010 íä 2.8 òóäü, 2015 íä 5.8 òóäüä òçðäýð çíðëëò äýäççëæëë. Энэ нь тóñ àéíäàò ñççëéí æëëççäýä çàò çýýëéí ýðýèò õýðгцýý ãñ÷ ààëäàòäé òíëäíðíëäíð òññäí, àéíê, òààòàí, ìäíí àòàððëäë çéëäáýððëýäýä ààðëëäýí àòàððëäëýí æëæëä, áóíä çéëäáýð ààéäóóëäò òààðäëäàà àëé áíëæ ààéíä.

2005 íä 1106.9 ñàý ò°äð°äëéí ààðëëäà óäñòàëò, èð çàñààðýí àæëë òëëäñýíë 61,3 òóàëëä íü òóñ àéíäëéí ààðëëäýí÷ëäýëëéí àæ àðóéí íýäæççä äçëýòäýñýí ààéíä. Ààðëëäýí ýñ, ÷óëóó, °íä°éä°íëé ÷óëóó, ýñ, òàéðäà, ýðäñëéí áóàää, òíðíéí ÷óëóó, òññäííü òàààð, òààçàíäëéí òàààð çýäýä ààðëëäýí àòàððëäëýí 16 íä, 16 ëëðýé ààëäàà íü òóñ àéíäàò ýýý ñàëäàðýä ò°æççëýð °ð°í áíëñæ ààëäàà òàðóóëæ ààéíä. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд:

Àðäàëóýýð, Óàðòíðëí ñóíäàà òññäí, àéíê, ñóóðëéí òààòàí, òíðíü ýëóó, °íä°ò òààòàíäëéí çéëäáýð ààéäóóëàõ, ìíäíü í°ò áçòëé ñóíäüä òçòëäëýí ìä áíëñäñðóóëäò, òíð, òààëäà, òààñ, äññíä, òàíä, àðäàëëòëéí çéëäáýð ààéäóóëàõ, "Ä°÷èí íýíäáí àéëýí ìðíí ñóóò" ò°ò°éá°ðëéí òçðýýä àéíäëéí õýíæýýä òëíýýð ààðëò ìðíí ñóóòíü äýä òàò°éá°ð áíëñäñðóóëäí õýäýäæççëëõ ажил амжилттай хэрэгжиж байна.

**Тавд.** Óäà ñóóðëí äàçðýí ìð÷èä ýð÷èæñýí àëè àæ àðóéä òäæççëýð íü áóíä òóààòààíü äíë çíðëëò áíëæ äàéãàà æжэ. àëè àæ àðóéí ààðäëòäé áçòýýäáýðççíëé õýíæýýä òíàòäíðíëé íýíäáýðççëýð çàíäàð ýð÷èæñýí àëè àæ àðóéäààñ 2010 íä 3.7 òýäáóí ò°äð°äëéí, 2015 íä 6.9 òýäáóí ò°äð°äëéí áçòýýäáýðççí çéëäáýððëýýýð ò°è°äë°жэ.

Иймээс мæè àæ àðóé íü ä°ðòàíäàé àéíäëéí ýäëéí çàñäëéí äíë ñàëäàð á°ä°ä ÄÁÁ-íëé 3/4-ëéä çéëäáýððëýæ ààéíä. àëè àæ àðóéä íççëëéí äýë÷ýýðëéí àëè àæ àðóéí



àðãà òàðííëíãè çííðèèæ áàéíà. Àéíàèéí ýàèéí çàñààð ìàè àæ àðóé áíëèíò ççðýã  
ãóéöýòãýæ áàéãàà áíëíã÷ ìàè àæ àðóéí ãàðàèòàé òççðèé ýàèéã áíëíãñðóóèàð  
÷èãýýèéí çèèããýð ò°ãæ°ãçé, òçí àìííðàà ñçç, ñççí áçðýããýðççèéè òýðýãöýã  
áçðýí òáíãàæ ÷àããðãçé áàéíà.

Àéíàèéí áýè÷ýýðèéí àààòóã òííèí òíëãíéã òèèæççýýí òíííæ ççýöýã 2.3 ñàý  
òííèí òíëãíé áýè÷ýýðèéí àààòòàé áàéíà. 2005 ííý ýöýñò áàéãàà ìàèóí òíã òííèí òíëãíéã  
òèèæççéãýé 3.5 ñàý òííèí òíëãíé ìàè áàéíà. Ýíãýýñ ççýöýã áýè÷ýýðèéí àààò 1.2 ñàý  
òííèí òíëãíé áóðó 52.1 òóàèàð öýððýã áàéíà. Ççýýñ òàèòããàèáí áýè÷ýýð  
òàèòèãããààð, óèìààð áàéããàèý ìð-èíà íèíí ñ°ð°ã çð àããããàð ãàð÷ áàéíà. Бýè÷ýýðèéí  
ìàè àæ àðóéã òíííí ÷àìàðóí ççççýýèèéã ÷òàèè÷èáí ççýö, ççèãýð òáñààã  
ñàéæðóóèàð, íýã ìàèàñ àààò àøèã øèìèéã íýíýãççýýð òààðèèããàòàé áíëæ áàéãà  
ажээ.

Òààøèã àøèã øèì ñàéòàé íóòàèéí øèèýéè ìãèéí ìàèóí òíí òíëãíéã íøððóóèàð, íýã  
ìàèààñ àààò àøèã øèìèéã íýíýãççýýð çàìààð áýè÷ýýðèéí ìàè àæ àðóéããàà  
ò°ãæççýýð, òçí àì ò°ãèãðñí òíííòíí ò°ã, ñóóðèíãèéí ìð-èíà ýð-èìæñýí òàðííëíãèã  
òçøèãýýñýí òàðíãðèéí àæ àðóéã íèííð áàéãóóèáí òããæççýýð òààðèèããàòàé гэж  
үзжээ. Үүний тулд: Áýè÷ýýðèéí ìàè àæ àðóéã çàð çýýèéí ýðýèò öýðýãöýý, áçñ  
íóòàèéíòàà áàéããàèý ìð-èí, áýè÷ýýðèéí àààòãà òíðèððóóèáí çð àøèãòàé ýðèýýíò°èèãò,  
òãã ñóóðèí ãàçðóí áýðãýã ýð-èìæñýí ìàè àæ àðóé ýðèýýð àæèóã òð°æççèэх ажил  
хийгдэж байна.

Àðãàéöýýð, Õàðòíðèé, Õóæèðò, Õýíãà ñóíããà ò°ã° àæ àðóéí òíãòíéãíð àæ  
àðóé, òíðòíí, òãðíãðççèèã íèííð áàéãóóèã, Õàðòíðèé, Àðãàéöýýð ñóíãóí ìð-èíã  
ýð-èìæñýí ìàè àæ àðóéí áè-èè áçñ íóòàèéã áàéãóóèã, ìàðíý çððèéí çàããàð àæ  
àðóéã Õóæèðò, Çççíãýýí-Õèàáí, Õàðòíðèé ñóíããà áàéãóóèã, Мах, ñççèéè  
÷èãýýèéí áíã°ð àøèã øèìòýé ìàèààð íóòàèéí ççèãýð òáñààã ñàéæðóóèàð çðæèè  
ñàèèèèéí àæèóã ýãóóèæ, òíí ñçðãççèèã áèé áíëãíх ажил эхэлж байна.

°íã°ð àøèã øèìò áíëíí íóòàèéí øèèýéè ìãèéí öýýèòççýýã÷ ìàè, °ñã°ðãàòàé,  
°íã°ãèã÷ áíëæóóèáí èðãýã, àæ àðóéí íýãæççèèã òáíãàò àæ àðóéã áèé áíëãíх, х°ã°  
àæ àðóéí çèèããýðèý, çèè-èèãýýíèè òð°è, çèè àæèèèãããàíý ÷èãýýé áçðýýð









áéíäëéí ñγæýγā áàéãóóëæ óèìààð áçñèéí áíëíí íëíí óëñúí ñçëæýγóýé õíëáíæ  
эхэллээ.

Àéíäèéí àγèàè æóóë÷èàèúā õ°ãæççëýõ ìàñòàð ò°è°àè°ãããã áíëíâñðóóèàõ,  
Õàððîðèéí, Õóæèðò, Áíãã, Ààò-æççéé, Æñáíççéé, Æó÷èí-Õñ, ÁÁÓèààí çγðýã àè÷èè  
áçñççäèéã õíãõñð ìü õ°ãæççëæ, áíý õíãõíëáíðúí õçðýýíä Ýðäýíýçóó ðèéèèéã ñýðäýýí  
çàñààðèàõ, æóóë÷äúā õçëýýí àãàõ òàãèéã áàéãóóèàõ, ýðòíéé íèéñëýèéí óóóðü  
äýýð èè íóçáé, Õàððîðèéí íóçáéã áàéãóóèæ ажил хийгдэж байна.

Øàíõúí õçðýý, Õàãòáí ðèéã, °ãã°í ñóààðãà çγðýã òççò øàøéí, ñí,ëúí äóðñààèò  
ãàçðóóäúā òíðèæóóèæ, "Ìðã°èéí çàì" àγèàèúí ìàððóóòúā áçñèéí áíëíí íëíí óëñúí  
àγèàèúí ìàððóóòàé õíëáíæ, àγèàè æóóë÷èàèúí ààòí çàìúí áíëíí ýð÷èè õç÷, çí÷èè  
áóóääè, ççáýð, ìýäýýéý, õíëáííü ò°ð°æñ°í ñçëæýý áèé áíëáíæ, àγèàèúí ñçëæýýíéè  
ääãóó øèíýýð æóóë÷íü ààç áàéãóóèàõ, çí÷èèáóóäèúí ñçëæýýíä õíëáíãáíæ ажлууд  
хийгдэж байна.

Àγèàè æóóë÷èàèúí áçõ ò°ðèèéã õ°ãæççëæ, æóóë÷äúí ñííèððèèúā òàòàò ò°ðàè  
áçðèéí àðãà òγíæýý (ñàðèàãáí ñíëí, ìíðèí ñíëí, ì°ñ°í äýýðð øàãáéí òàðãàà, ìíðü, òγíýý,  
ñàðèãá óíàò, àãòíìàøèíààð àγèàò, óóèúí áàðòààò çàìààð äóãóéãààð àγèàò, àãààðúí  
áèíáèðð°ã°ð íèñýò, øçòðýýð áóóò, àãààðúí ÷°è°ò óíàèò, àãèüòíëáíààð íèñýò, çàäü,  
ñàèààð àγèàò, çãããñ áàðèò ä.ì)-íèé íýð ò°ðèèéã íèððóóèæ ажил тасралтгүй хийгдэж  
байна.

Æóóë÷äúā æèèéí ä°ðà°í óèèðàèä õçëýýí àãàò áíëíæòíé íëíí óëñúí æèøèã,  
ñòáíààðòàà íèéñýí áààçóóäúā áàéãóóèæ, °ãèèéí àγèàè æóóë÷èàèúā õ°ãæççëæ  
зорилт тавьжээ.

**Найм. Аймгийн дэд бүтцийн салбарын хөгжлийн бодлого**

Óëñúí áíëíí ìðíí íóòàèéí òýãàðèéí ñçëæýýã ñàéæðóóèæ, ìð÷èí çàèéí òçàøèá  
õçðäýýý гэж үзэж байна. Иймээс °ã°ðòàíãáé áèìààò ààòí òýãáýð áíëèíí õ°ãæñ°í, óñáí  
áíëíí òàì°ð çàì áàèõáç. Óèàáíààòàð-Àðãàèõýýð, Ýñýí òàñàðòàé Õàððîðèéí  
÷èèëýèéí òàòóó ðó÷èèòàé çàìòàé, Àðãàèõýýð-Áàýíòííáíðúí ÷èèëýèéí ñàéæðóóèñáí  
òàèðãáí çàìúā ààðüæ áàéíà. Ì°í Õàððîðèéí Õóæèðòúí ñàéæðóóèñáí çàì, Õàððîðèéí-









Öààøääà yáèéí çàñàèéä ýð÷èìòýé õããæóçÿýõýä õçí àìúí íãííãèéí ýçýìøñýí ÿýðãýæèè, ÿýðãýøèè òìðèðìæãçé áàéãää, çàð çýýèéí áããòààìæ áããàòàé áóðó òààøèä °ðãæèí òãæèð áíèìæ í°õ°è õýçãààððèããàìàè ñòì, ñóóðèíãèéí òíí òã°íãçé áàéãää ÿü ò°ñã, ò°ðãíã° ïðóóèàèòúí í°òèéã òàðàìààð, òãæèèä òààòàé í°è°è°õ õçí àì ççéí áíãèíãíã ñ°ðã°ð í°è°èæ áàéíà.

Àéìãèéí õçí àì ççéí áíãèíãíã òíãíðìéèæ, õçí àìúí äóíã áàéãää °í°ãèéí áýððøýýèòýé, òãæèèä ñààä áíèæ áóé àñóóäèóóãúã ííã÷òíé áàéãèààð øèããâýðýõ áíãèíãíã õýðýãæççèæ, эгèéí çàñàèéí òààøàúí °íã° ò°ñèòèéã òãíãæ, àæèúí áàéòúã òóóøàé ÿýýãççÿýõ çàìààð äããããø ÷èãýñýí øèèæèð òã°èã°íèéã áãããñãàíà. Идãýãèéí àæèèèæ, àìüäðàð òààòàé ïð÷èí í°õèèèã áçðãççÿýõýä òçèõççéí àíðààðàх ажил хийгдэж байна.

Àðãàéòýýð, Õàðòìðèí òìòúã òãæççÿýõ áð°íèèè ò°èããèèãã°ã øèý÷ÿýí ààòàèæ õýðýãæççèæ, бè÷èè áçñèéí ò°ã, òíííòíí ñòìúí ò°ãèéã òãæççÿýõ ò°è°ãèèã°ã áíèíãñðóóèì õýðýãæççèæ ажил үргэлжилж байна.

Õçí àìúí íóòããøèè, ñóóðìøèúí çíðèñòíé õýã çàããàðúã "Áçýã ñóóðèíãèéí òíãòíèèíã ñòìããàð çíðèíí áàéãóóèàð ò°ñ°è"-èéí äããóó çíðèíí áàéãóóèéì; "ã°ðòãíãèè àéìãèéí äàçàð çíðèíí áàéãóóèàèòúí áð°íèèè ò°è°ãèèã°ã"-ã áýýðò áçñ÷ÿýèòýé õýãóóèèì áíèíãñðóóèж байна. Õìò ñóóðèí äàçðúí ïð÷èí í°õèèèã ñàéæðóóèæ, äããàð, ò°ðñ òííúí àíðèðãíèãçé áàéèããð øàò äàðààèñàí àðãà õýìæýýã äà÷ õýðýãæççèж байна.

**Арав.** Áíèíãñðìèúí áçõ øàòìúí áàéãóóèèããóóãúí çèè àæèèèããàìúí øèý÷ÿýèèãã äçíçãèèðççÿýí ñóðãàèòúí ÷àìàðúã ñàéæðóóèæ, ìàðàðèàèèãã áààçúã ÿü áýðæççèæ, áíèíãñðìèúí ñàéãàðúí 2015 íí õçðòèýõ ìàñòàð ò°è°ãèèã°ã õýðýãæççÿýí гэж үзжээ. Үүнийг хэрэгжүүлэх үүднээс Áíèíãñðìèúí òíããíèèí ÿü ìèèãíèéí °í°ãèéí øààðãèããà, õýðýãòýýã òãíãæ ÷ààòãççé áàéгаа. Áíèíãñðìèúí ñàéãàðò áããà, äóíã áíèíãñðìè çíðèèæ áàéíà. Ñóðãóóèèòúí ñóðãàèòúí ìàðàðèàèèãã áààç òóó÷èð÷, áããø ìàðúí ÿýãýã, áíèíãñðìèúí òçãøèí °íã°ãèéí øààðãèèãããñ òíòìð÷ áàéгаа. Àèãàí áóñ áíèíãñðìèúí òíãòíèèí ò°èããø°ãçé áàéíà.



Ёеийгн оааөа аіііаңдіеуі нааааааа өеө өеіү÷еуеөеі ааеуі ааеаеөуі іуіуааггөүө өааааааааае ааагаа зэргийг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзжээ. Үүний тулд:

Оиііоіі оа, нóóөеіаóóааа огі аиіа оаааөдггөүө аіаеіаіоіеаіі оуеаооөаі ааөіөеө аіііаңдіеуі нóдāóóөү, оуөүдөуаггәәеі ааөдөөө, аггөү, оуа өеіаөеө өеіү÷еуі оіаааах, Ааөіөеө аіііаңдіеуі нóдāóóөеөа 12 аеөөеөі оіаоіөөііа аггөү өеөаггөөх, Ааөіөеө аіііаңдіеуі нóдāóóөеөі аиооод ааөдіу іоөөөөа нааааооөө, өө÷ууөөеі ааөд, аіаө оаіөөіуі оггөүөөү, нóóаеуі оііа іуіуааггөөх, Ааөіөеө аіііаңдіеуі нóдāóóөөү аііі өө аууа нóдāóóөөөауі өііүрөаааггөө, өіоаіааггө өіөаіх ажил хийгдэж байна.

Іүдāуаөөөөі нóдāаөөоае, нóдāаөөө гөөаауөдөуөөөі оаггә аггөөө аггөүі ооіа нóдāóóөөөауі аеө аіөаіө ааеуі хийж байна. Нóі аггөө нóдāóóөөөөі оіоө аіііаңдіеуі ууөаөөөі аггөү, гóіу нóдāаөөө уаооөаө, ауө оуөүдөуа ааөөөөоөөаө гүдүа ааеуі гíөөіі ааөаооөө, оггөдәөөөі оуөүдөуаө оаідāаааөөөуі іуіуааггөөж байна.

Оаоіөөөөөі аііі іүдāуаөөөөі нóдāаөөөуі ід÷іуā нааааооөө, нóдāаөөөуі оаоіөө өүдүаңөуөөөө өеіү÷еух, Оггөдәөөөі оіаааі ааууаң, аааоо оаеуі үдөіууң іууі өөдггөө өаааггөүө адāа оуіаууа өдāөдāөх, Іүдāуаөөөөі нóдāаөөөоае аөөаө нóдāóóөөөө аеө аіөаіө аіаөіауі оуіаууіа ауіаөөө ааөөөөаж байна.

Нóдāóóөөөөі оіоө аіііаңдіеуі ааөаооөөөауі гөө ааөөөөаааауі оггөүуа өдāөдāөө, оөө÷өөаууіөө ÷аіадүа аууөөггөүі оуөүдөуаө оаідāаааөөөуі 2015 ііа 90 ооауā оггөдāух ажил зохион байгуулж байна. Нїөүі ааөаооөөөааоооуі гөө÷өөаууіөө оад оггөүуа өдāөдāөө, нїі аууауудггөүө, оаіөі іуауөггөөі ÷өөөөөөөууөд өаааггөөөх ажил хийгдэж байна.

Аөіаөөөі оггөө нїөүі өаөөөі іадөөө÷өөнаі нóааөөааа уаооөө өөнүі аггөдāуө, іуаууөөөөөі наіа ідóолах, шааадāөөаааоаө іадөөөі іүдāуаөөөөі ÷өөөөөөүд аааааааа нóдāө, іүдāуаөөө аууөөггөүөөөө аггө оаөаад ауіаөөх, сóдāóóөө, оуөүдөуаггәауа нóааөөааа, оуіаөөө өөіаөөөөуу, гіуөаууіөө ааа аггөдәггөүі ааөөөөаоаа ауіаөөө ггггөөөх ажил хийгдэж байна.



**Арван нэг.** Үдгүжэ ййяаеэи ааеаооёеаааа гд аөеаòае лаааааааòеéиòìäòìеòïä аеé аиëаиæ, үдгүжэ ййяаеэи ааòаи аòаиòу аиëиì ааòеéи йүдäýæеéи оòñеааæ гее÷еëäýýä аýòæггëæ, òгì аиùи үдгүжэ ййяаеэи ааеааò äýäòггëñýи ййяааиò оëæеéи çìðеèòòóäеéä агдýи òýдýæггëйý гэж үзжээ. Үүний тулд: Аеиäаä үеéи çаñæеéи òóäüä аеä äааи оëæеéò аиëиæ агдäýýäггë ааеäааòае òìеäиìòìеäиìд үдгүжэ ййяаеэи аñóóäеüä агдýи өеéääýдëýò аиëиæ òýçааäðеääиäе äаéгаä.

Òгì аиùи äóíä òиìе òýæýýеéи òиìñäиëüи үиäýä аиëиì òäеääаäòуи äóñ äðòää äа÷еи äóóðäòäггë äаéгаä. Ìð÷иù аиòеääиë еò, äýд аггë, òóäü òгìеé äðеóи òýäýд иóó äаéäää иü òäеääаäò äа÷еòе òóóòòаé äóóðäòäггë äаéääää йýä и°òò°е аиëæ äаéгаä. Ñгдüäý, аýеäеéи çаиùи òäеääаäòòä÷еи, òаиíóó, äýäýñиëé òäеääаäòò äа÷еи ääð÷ äаéгаä. Òгì аиùи үиçýä òýñæеéиýдгүжэ ййяаеéä òаиäаäеäò ýäääé аиòäаäðäé òàòñаи аñóóääé аиëæ äаéгаä дутагдлуудыг арилгах талаар дараах арга хэмжээг авч байна. Үүнд:

**Òýдýæггëýò гее äæеéääää:**

Òäðòìðеи ñóиùи йýääñýи үиýеäеéä ìð÷еи гäеéи ииòеиäиì үи÷еëäýýиëé ääääæ òиìä ò°ò°ò°иæ°ò òаиäææ, òäеä äаääääò òóäааиüä ò°äæггëæх, 5000-äаñ äýýò òгì аиòäé ñóиùи үиýеäггëäеéи ииòеиäиì үи÷еëäýýиëé ÷ääääòеéä йýиýäггëæ, ñóи äóиäиùи үдгүжэ ййяаеéи гее÷еëäýýиëé äе÷еé ò°ä аиëиì òäæггëæх арга хэмжээ авч байна.

°òò, ñóиùи үиýеäггëäýä иéäиëéи үдгүжэ ййяаеéи оòñеааæ гее÷еëäýýä òггëòггë òäæггëýò үýеòýé ìð÷еиä агдäггëæх ажил хийгдэж байна. Çàðеи ñóи, ääæéи үиýеäггëäеéä °ðòеéи үиýеäеéи ÷ëäýýýд ò°äæггëæх, хгì аиùи äа÷еòе, æèдýиñиëé òгìäðýеéä үдò еèдггëýò, òóðäää÷еëñаи ииòеиäиìи ñггëеéи гäеéи äðää òäòиëиäеéä ñóи, ääæéи òгäòеиä йýäòдггëæ гее÷еëäýýä òóóðòаé аиëаиx, ÁÝÒäæéи үдäýи өеиæеëäý ñóääеääиùи ÷ääääòеéä äýýòггëæ, иìòеäиìиä ñóóðòеëñаи өеéääýд ääðäаи òýдýæггëæх ажил хийгдэж байна.

Òгì аиüä çàеéòäггë òääðäеäääòäé, ÷аиäòуи ääòäеäääòäé үйýд òаиääò, үиëéи и°òеéä агдäггëýò агòýò, çìðеиì äаéäóóеäеò, үдò çгëи ìð÷еиä çàò çýýеéи òääðäеääää иéèòггëýи аиëиäñòиìäóé аиëаиx, Äðäæéóýд ñóиäаä үдгүжэ ййяаеéä аýиæеò



ò°â áàéãóóèàí àæèèèóóèàð, эдгчгө иýиáýä èðãýäèéí îðíèõííã иýиãäççëýõ çíðèèãíð "Ýðççë äýð áçë" õ°ò°èääðèèã áíèíãñðóóèàí õýðýãжгүгээх ажил эхэлж байна.

Ýõ, õççõäýä ÷àíàððàé ýðççë иýиäèéí òõíèàìæ çéè÷èèãýý ççççëýõ, үèàíãóýà ýñýí иýиä àìàðæèðóé, õççõäèéí áâ÷íèé õíãõ ìáíãæìáì, õííè òýæýýèèèã ñàéæðóóèах, аéиäèéí ýðççë иýиäèéí ñàéààðúí õçíèé í°áòèèã õ°ãæèèéí áíèèíãñðóóèãæççëýí, çð äçíã õííõíæ òààøäúí ÷èèýýèèèã òíãíðõíèèох ажил хийгдэж байна.

Ýðççë иýиäèéí áàéãóóèèèãóóãúí иýäýýèèèéí иýããñýí ñçæýýã áèé áíèãíæ, òãõíèíãèéí äýãèèèèã áçðýí àøèãèèð, иýäýýèèèéí óàèðãèèãúí ÷ãããðèèèã áçõ òçâèèã ñàéæðóóèах, хóãèéí õýãèèèéí ýðççë иýиäèéí áàéãóóèèèãúí çéè àæèèèãããã äýìæéí °ðã°æççëэх эдгчгө иýиäèéí çàðèì òõíèàìæ çéè÷èèãýýã íèíí óèñúí áíèíí èðãýíèé íèèàìèéí áàéãóóèèèããããð äçéõýðãççëýõ òíãòíèèèã áèé áíèãíæх ажил хийгдэж байна.







**БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДЙИН ЗАСАГ, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ.**

**Баянхонгор аймгийн тогтвортой хөгжлийн байдал.** Баянхонгор аймагт 2008 оны эхэнд 21,5 мянган өрхөд 87,8 мянган хүн амьдарч, нэг өрхөд дунджаар 4 хүн байна. Нийт хүн амын 50,6 хувь буюу 44,4 мянга нь эмэгтэйчүүд, 41,4 хувь буюу 36,4 мянга нь 0-15 насны хүүхэд, 33,6 хувь буюу 29,5 мянга нь 35 хүртэлх насны залуучууд байна.



76 дугаар зураг



Хөдөлмөрийн чадвартай 45,4 мянган хүний 49,5 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд 6,6 хувийг ажилгүйчүүд эзэлж, эдийн засгийн идэвхтэй хүн амын 7,9 хувь болж байна. Энэ нь ажилгүйдэл цаашид өсөж, орон нутгийн ойрын 10-15 жилийн анхаарал татсан тулгамдсан асуудал болох төлөвтэй байна. Аймгийн хүн амын 38,4 хувь буюу 33,7 мянган хүн амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой, нийт ядуу өрхийн 34,6 хувь нь нэн ядуу түвшинд амьдарч байна. Сүүлийн 3 жилийн дунджаар 2500 эх амаржиж, 100 хүнд ногдох төрөлт 24,9, нас баралт 6,4, хүн амын цэвэр өсөлт 17,8 болж дундаж наслалт 62,3 болжээ.

Улсын дундажтай харьцуулахад хүн амын төрөлт бага, эх, эх нялхсын эндэгдэл их, дундаж наслалт бага байгаа нь орон нутгийн байгууллагын анхаарал татаж байна. Зах зээл, зам харилцааны хөгжил, үйлдвэрлэл, эдийн засгийн уналт, ажлын байр дутагдснаас шалтгаалан гарч байгаа хүн амын шилжилт хөдөлгөөнийг багасгах, оюуны хоцрогдлыг арилгах, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалахад анхаарах шаардлагатай байна. Хүн амын нягтрал бага, сийрэг суурьшилтай боловч аймгийн төв, сумаар ялгаа нэлээд их бөгөөд 1997 оны байдлаар нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0,8 хүн амьдарч байна. Сүүлийн 5 жилд дунджаар 1077 өрх байна.

**Эдийн засгийн өнөөгийн байдал.** Эдийн засгийн хөгжлөөр бусад аймагтай харьцуулбал дунд зэрэгт ордог, хөдөө аж ахуй зонхилсон, аж үйлдвэр сул хөгжсөн. Аж үйлдвэрт нүүрс, алт, хүнс, эрчим хүчний үйлдвэр голлон, барилгын үйлдвэрлэл зах зээлгүйгээс зогсонги байдалд оржээ. Аж үйлдвэрийн газрын ихэнх нь эдийн засгийн хувьд өндөр үр ашигтай биш, зардал ихтэй, технологийн хувьд хоцрогдолд орсон байна. Төсвийн зарлагад өөрийн орлого 2006 оны байдлаар 54,8 хувийг эзэлж, үлдсэнийг улсаар татаасаар авдаг ажээ. Эдийн засгийн бодлого нь нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчноо хамгаалахад бүрэн чиглэж чадаагүй байна. Аймгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн гол зорилго нь эдийн засгийн хувьд бие дааж урсгал зардлаа, өөрийнхөө орлогоор нөхдөг, улмаар нийгмийн болон экологийн асуудлаа шийдвэрлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болох явдал мөн. Үүний тулд:



Аймгийн төсөвт мэдэгдэхүйц орлого оруулдаг зүтгүүр аж ахуйн нэгжүүд, тухайлбал, алт болон бусад эрдсийн баялгийг олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай юм. Байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газраа түшиглэн, экологийн аялал, жуулчлалыг тэргүүлэх нэг чиглэл болгох хөгжүүлэх нь ач холбогдолтой. Эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхийн тулд банк, санхүү, даатгал, татварын тогтолцоог зөв төлөвшүүлж чадваржуулах шаардлагатай байна.

Төвлөрлийг аль болохоор сааруулж сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр эдийн засгийн хувьд харьцангуй бие дааж, ажиллаж чадвал эдийн засгийн хувьд харьцангуй бие дааж ажиллаж чадвал эдийн засгийн хөгжлийн зорилго хэрэгжих болно. Зээл, санхүү, даатгал, татварын бодлогыг ч үүнд чиглүүлэх хэрэгтэй байна. Төсвийн зарлагыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, үрэлгэн байдлыг зогсоох арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх, үүнд хөндлөнгийн хяналтын үйл ажиллагааг хүчтэй болговол зүйтэй.

Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, тариалан голлож, 1997 оны эцсээр 2427,9 мянган мал тоолуулсны 96,5 хувь буюу 2155 мянга нь хувийн хэвшилд байна. Малын өсөлтийн ихэнхийг буюу 70,7 хувийг ямаан сүрэг эзэлжээ. Нийт малын 1,6 хувь нь тэмээ, 6,1 хувь нь адуу, 35,3 хувь нь хонь, өсвөр мал 3,6 хувь, ажлын ба эр мал 28,6 хувь, хээлтэгч мал 41,6 хувь, хээлтүүлэгч 1 хувийг тус тус эзэлж байна.

1990 оноос үхэр 41,6 хувь, ямаа 92 хувь, адуу 35,5 хувь, хонь 5,9 хувиар өсөж, тэмээ 14,9 хувиар буурлаа. /Зураг 3/ Үхэр, ямааны өсөлт бусад төрлийн малаас 6,1-86,1 хувиар илүү байгаа нь ноолуур, сүүний эрэлт хэрэгцээтэй холбоотой ажээ.

Сүүлийн жилүүдэд мал өссөн нь сайн талтай боловч бэлчээрийн даац хомсдон, хөрсний элэгдэлд орж, ургамлын гарч муудаж байна. Тарийлангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээр эрхлүүлэх замаар дотоодын хэрэгцээгээ хангах боломжтой боловч газартай харьцах соёл дутагдаж байгаагаас хөрсний шим алдагдах, тариалангийн талбай атаршихад хүргэжээ. Бэлчээрийн



даац хүрэлцэхгүй байгаа учраас ногоон тэжээл тариалж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, талхлагдсан бэлчээрт олон наст ургамал тариалах, хуваарьтай ашиглах, хагалж сийрүүлэх зэргээр бэлчээрийн ашиглалтыг сайжруулах явдал юу юунаас чухал байна.

Байгаль орчны өнөөгийн байдал. Тус аймаг 11597,8 мянган га нутаг дэвсгэртэй, бүх нутгийн 18,2 хувийг ойт хээр, 30,3 хувийг тал хээр, 51,5 хувийг говийн бүс эзэлдэг ажээ. Нутаг дэвсгэрийн 74,7 хувийг бэлчээр, 0,1 хувийг тариалангийн талбай, 0,1 хувийг төв суурингийн эдэлбэр газар, 0,5 хувийг зам, шугам сүлжээ, ус бүхий газар эзэлдэг байна.

Бэлчээрийн 8,8 хувь нь улс, аймгийн тусгай хамгаалалтын газар байдаг байна. Эдэлбэр газрын 4,2 хувь буюу 425,6 мянган га талбай талхлагдаж, 3,2 хувь буюу 300 мянган га-д үлийн цагаан оготно тархаж, 0,5 хувь буюу 45,5 мянган га эвдрэлд орон, ахуйн хог, хаягдалд дарагдаж, бэлчээрийн талбай багассан байна. Тариалангийн талбайн 90 хувь нь атаршиж, 13 хувь тодорхой хэмжээгээр хөрсний элэгдэлд оржээ.

Газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, эрх зүйн үндэс бүрдээгүй, газар зохион байгуулалтын ажил хийгдээгүй, газрын нөөц, баялаг шавхагдашгүй гэсэн ойлголт нийтлэг болсноос бэлчээрийн даац хэтэрч талхлагдан, хог хаягдалд автсан, эвдрэлд орсон газрын хэмжээ нэмэгдэх хандлагатай болжээ. Газрыг ашиглуулах, эзэмшүүлэх ажлын явц удаашралтай газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажил, ашиглалтаас хоцрогдож уурхайн эдэлбэр болон хайгуулын талбайд сэргээлт хийх, хяналт тавих ажил хангалтгүй байна.

Алт олборлолтын ажлыг эдийн засгийн тэргүүлэх нэг салбар болгон хөгжүүлж, төсвийн орлогын 50 гаруй хувийг энэ салбараас олж байга боловч газар, түүний хэвлийг хамгаалах, сэргэх ажил шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Иймд байгаль орчинтой уялдан зохицсон, газрыг дэмжих, тэтгэхэд чиглэсэн экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд ашигтай газар ашиглалтын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тус аймгийн нутаг дэвсгэрийн 5,4 хувь буюу 621,1 мянган га талбайд 43 сая м<sup>3</sup> нөөц бүхий шинэст



болон заган ойтой ажээ. Сүүлийн 5 жилд 100 га талбайд шинэс, 80 га талбайд загийн ойжуулалт хийж, тарьсан ой 40-66 хувийн амжилттай ургаж жилд дунджаар 2,2 мянган м<sup>3</sup> мод бэлтгэсэн байна.

Аймгийн ойн нөөц нь монголын шилмүүст ойн урд хязгаар төдийгүй заган ойн хойд зах нь болдог тул, элсний нүүлт, шилжилт цөлжилтөөс хамгаалахад чухал ач холбогдолтой байдаг байна. Жижиг бут сөөг, төгөл ой зэрэг нь байгаль, экологийн бүрэлдэхүүн хэсэг болох төдийгүй байгалийн үзэсгэлэнт болон биологийн төрөл бүрийн зүйлээр нэн элбэг газарт ургадаг онцлогтой ажээ. Иймд ой бүхий талбайн 35,4 хувийг улс, аймгийн тусгай хамгаалалттай газарт хамруулж, үйлдвэрлэлийн зориулалтаар урга мод огтлохыг хязгаарлан, ойг цэвэрлэх, унанга модыг ашиглах бодлого баримталж байна.

Нийт нутгийн 39,7 хувь нь цөлжилтөд тодорхой хэмжээгээр орсон нь байгалийн нөөц, иж бүрдлийн судалгаа явуулаагүй, менежментийн төлөвлөгөө боловсруулаагүй, газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах, хагаалах ажил орхигдсонтой холбоотой юм. Аймгийн хэмжээгээр газрын үнэлгээ хийгдээгүй, газрын рентийн төлбөр, хэмжээ байхгүй, байгалийн нөөц, баялгийн үнэлгээг зөв тогтоогоогүй, тогтосныг хэрэгжүүлдэггүйгээс байгалийн баялаг маш их хомсдож байна. Ялангуяа эмийн ургамлын ашиглалт, олзворлолт нь говь нутгийн элсжилт, цөлжилтийн явцыг идэвхжүүлж эхэлжээ.

Үйлдвэрлэл, үйлчилгээний 20 гаруй салбарт түүхий эд болгон ашигладаг чихэр өвсний тархац, нөөцийн 80 гаруй хувь нь манай аймагт ургадаг бөгөөд, энэ үнэт урагмлыг ашиглах эрх зүйн үндэс цэгцрээгүйгээс гадаадад түүхийгээр гаргаж, Зуун модны баян бүрд орчимд их хэмжээгээр ургадаг басан эмийн ургамал болон таван салааг 1993-1994 онд үндэстэй нь түүснээс болж устаж үгүй болохд хүрсэн байна. Говийн зургаан сум жилдээ 1000-1500 тонн заг түлшинд хэрэглэж байгаа нь заган ойг 15-20 жилд устаж үгүй болох тооцоо гарчээ. Загийг тооцоо судалгаагүй авч хэрэглэснээс болж элсний нүүдэл хурдсаж, эрүүл хөрс багасжээ.

Зуун мод, Гурилын хоолой, Бүгийн хоолой, Монголын хоолойын загийг булгалан авч түлшинд хэрэглэснээс бэлчээр рүү шилжих элсний нүүдэл ихсэж,





бэлчээр төдийгүй авто зам боож, тээврийн хэрэгслэлд их саад учруулдаг болжээ. Заган ой байгалийн аясаар ургахаа больж, залуу ойн эзлэх талбай хорогдож байгаа нь ойг сүйтгэн, нягтралыг нь эвдэж, орчных нь агаарын чийглэгийг бууруулсан, говьд унах тундасны хэмжээ олон жилийн дунджаас багасч, ган, хуурайшилт болж, заган ойн өтгөрлийн түвшин доошилсонтой холбоотой байна.

**Нийгмийн хөгжлийн тогтвортой байдал.** Тус аймагт хүүхдийн 26 цэцэрлэг, ерөнхий боловсролын 25 сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, мэргэжил олгох хувийн дунд сургууль, албан бус сургалдтын алба, гэгээрлийн төвүүд сургалт хүмүүжлийн ажил явуулж, боловсролын тогтолцоо үндсэндээ бүрдсэн байна. Сургуулийн өмнөх насны 11440 хүүхдийн 26,6 хувь нь цэцэрлэгт хамрагдаж сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Сургуулийн насны 23123 хүүхдийн 64,6 хувь нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж, 1981 хүүхэд сургууль завсардсаны 45,2 хувь нь албан бус сургалтад хамрагдажээ.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд 230 хүүхэд, мэргэжил олгох хувийн дунд сургуульд 30 гаруй оюутан суралцаж байгаа ба насанд хүрэгчдийн 37,8 хувь нь албан бус сургалтад хамрагдаж байна. Боловсролын салбарт 1275 хүн ажиллаж байгаагийн 56,1 хувь нь багшлах боловсон хүчин байна. Сургалтын байгууллагын материаллаг бааз хуучирсан, хөрөнгө, санхүү хомс байдлаас шалтгаалж сургалтын үйл ажиллагаа доголдон, багш, боловсролын удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэхэд болон сургалтын тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх зэрэгт бэрхшээл гарч байна.

**Аймгийн хэрэглээний бүтцийн өөрчлөлт.** Аймаг 116 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, 2427,9 мянган малтай үүнээс тэмээ 38,7 мянга, адуу 140,8 мянга, үхэр 181,5 мянга, хонь 818,5 мянга, ямаа 1053,6 мянга байгаа нь хүн амын мах сүү, цагаан идээний хэрэгцээг хангаад, илүүдэр бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах боломжтой ажээ.

Сүүлийн жилүүдэд хурааж авсан ургац нь хүн амын хэрэгцээний дөнгөж 10-20 хувийг хангаж, аймгийн хэмжээнд үйлдвэрлэн борлуулж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 15,1 хувийг хүнсний бүтээгдэхүүн эзэлж байгаа нь хүн амын



хэрэгцээний 30-40 хувийг хангажжээ. Аймгийн төсвийн 1997 оны орлого 765,8 сая төгрөг, зарлага 2915,6 сая төгрөгт хүрч, орон нутгийн төсвийн орлого жилээс жилд нэмэгдэж байна.

Нэг өрхөд дунджаар 4 хүн амьдарч, өрхийн сарын дундаж мөнгөн орлого 56,4 мянга, зарлага 41,4 мянган төгрөг, хүнсний хэрэглээний зүйлд 78 орчим хувийг зарцуулжээ. Хүнсний зүйлийн хэрэглээний физиологийн зохистой нормоор нэг хүний хоногт хэрэглэх илчлэгийн хэмжээ 3261 ккал байхаас одоогийн байдлаар 2035-2767 ккал буюу нийт хэрэглэвэл зохих илчлэгийн 70 хувийг хэрэглэж байна.

Ядуу өрхийн ам бүлд 33,7 мянган хүн байгаагийн дотор 1606 нь өрх толгойлсон эмэгтэй байна. Хүн ам, аж ахуйн нэгж, байгууллага, бэлчээрийн усны хэрэгцээг гол, горхины ус, 4169 худгаас хангаж байгаа нь усны хэрэглээний нормоор үзвэл дөнгөж 70 орчим хувь болж байна. Дэд бүтцийн хөгжил бусад аймгаас харьцангуй доогуур байгаа нь эрчим хүчний төвлөрсөн системд холбоогүй, хатуу хучилттай автозамын асуудлыг шийдвэрлээгүйтэй холбоотой ажээ.

Арвайхээр-Баянхонгорын хооронд хатуу хучилттай зам барьж байгуулахаар төлөвлөсөн боловч, санхүүгийн эх үүсвэргүйгээс зөвхөн 20 гаруй км-т замын ажил хийжээ. Баянхонгор-Улаанбаатарын хооронд 7 хоногт 2 удаа агаарын тээврээр үйлчилж, зорчигч тээврийн үйлчилгээнд өдөр бүр олон авто машин тогтмол үйлчилж байна. Радио релейний шугамыг тоон ситемд шилжүүлэх, хотын доторхи аналогийн телефон станцыг тоон электрон станцаар сольж байна. Ингэснээр хэрэглэгчид хот хооронд болон олон улстай шууд харилцах нөхцөл бүрдэх байна.

Санхүүгийн бэрхшээлээс болж сумдын уурын зуух ажиллахгүй, цахилгаан эрчим хүчний үйлдвэрийн ашиглалтын зардал өндөр, технологийн хувьд хоцрогдсон байна. Өнгөрсөн онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт 1948,7 сая төгрөг, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлого 4143,5 сая төгрөгт хүрчээ. Ажлын байрны хомсдлоос шалтгаалан ядуурал бий болж, орлого багатай хүн ам, айл өрх шилжиж суурьших үзэгдэл ихсэж аймгийн төв, сумаас Улаанбаатар, бусад хот, суурин руу шилжих хөдөлгөөн ихэсжээ.



Үнийн өсөлт, мөнгөний ханшны уналт, ажилгүйдэл, хүн амын нэлээд хэсгийн дунд бэлэнчлэх, тэжээлгэх сэтгэлгээ түгээмэл байгаа нь ядуурлыг бий болгох хүчин зүйлс болж байна. Нөгөө талаар үйлдвэрлэл, үйлчилгээний сэргэлт хөгжил удаашралтай, ажлын байр олноор бий болж чадахгүй байгаа нь ажилгүйдлийг улам нэмэгдүүлжээ.

Тус аймагт сүүлийн жилд 570 хүн буюу 10000 хүний 84,4 нь ямар нэгэн халдварт өвчнөөр өвчилсөн байна. Хүн амын хэрэглээний хомсдол ихэсч, ялангуяа хүнсний хэрэглээ багассанаас хүн амын амьдралын доройтол, өвчлөл нэмэгдэж байна. Нэг хүний хэрэглэсэн гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг 1996 оны байдлаар авч үзэхэд жилд хэрэглэх нормоос сахарын зүйл 17 кг, амьтан ургамлын гаралтай тос 4,1 кг, хүнсний ногоо 33 кг, цөцгийн тос 3,6 кг, гурил, гурилан бүтээгдэхүүн 31 кг, сүү, цагаан идээ 57 кг, төрөл бүрийн будаа 5,4 кг, төмс 26 кг-аар тус тус дутуу байна.

Аймгийн хүн амын үйлдвэрлэл хэрэглээний зохистой харьцаа алдагдаж, өргөн хэрэглээний барааны 70-90 хувийг гаднаас авч байгаад дүгнэлт хийж хүнсний болон өргөн хэрэглээний бараанй наад захын хэрэглээг аймагтаа хангах зайлшгүй шаардлагатай. Орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж, хүн амын хэргэлээг хангах талаар холбогдох бүх арга хэмжээ авах асуудал хурцаар тавигдаж байна.

**Ядуурлын асуудал.** Эдийн засаг, нийгмийн хямрал, бэрхшээлтэй уялдан хүн амын амьжиргааны түвшин буурч байна. Үнийн өсөлт, мөнгөний ханшны уналт, ажилгүйдэл, хүн амын нэлээд хэсгийн дунд бэлэнчлэх, тэжээлгэх сэтгээ хүчтэй байгаа нь ядуурлыг тэтгэж байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний сэргэлт, хөгжилт удаашралтай, ажлын байр олноор бий болж чадахгүй байгаа нь ажилгүйдэл өсөн нэмэгдэхэд хүргэж байна. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 8078 өрхийн 33738 хүн ядуу амьралтай, 2793 өрхийн 13338 хүн нэн ядуу амьдралтай байгаа нь нийт өрхийн 37,5 хувь, хүн амын 38,4 хувийг хамарч байна.

Ядуурлын түвшинг тогтоохдоо өрхийн орлогоос гадна амьдралын чадавхийг харгалзаж байгаагийн зэрэгцээ бүтэн болон хагас өнчин хүүхэд, тахир дутуу



иргэд, харж хандах хүнгүй өндөр настан, насанд хүрээгүй олон хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүд, олон хүүхэдтэй бага орлоготой өрх, зарим жилгүйчүүдийг эмзэг бүлэгт хамааруулдаг ажээ. Ядуу иргэдийн хоол, тэжээлийн илчлэг дутагдсанаас эрүүл мэнд нь муудаж, элдэв өвчин эмгэгт нэрвэгдэх, оюуны хоосролд орох, хүүхэд нь сургуулиас завсардаж, ёс суртахууны доройтолд орох, гэмэт хэрэг өсөх зэрэг сөрөг үр дагавар бий болгож байна.

Хүн амын ядуурал одоогийн түвшинд байх эсвэл цаашид нэмэгдэх нь зах зээлийн харилцаанд шилжих үйл явцыг удаашруулж, шинэчлэлтийн бодлогод ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул ядуурал бий болох үндсийг арилгах, ядуурлыг бууруулах, ядуурлаас гарах оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлбэл зохионо. Ядуурлыг бууруулах өргөн хүрээтэй иж бүрэн арга хэмжээ хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа нь гол бэрхшээл юм. Өв залгамжилсан хөрөнгөгүй байсан иргэдэд хувийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сэтгэлгээ төвөлшөөгүй байна. Ядуурал нь нийгмийн шинэ үзэгдэл учраас нийгмийн хамгааллын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх туршлага дутаж, ядуурлыг бууруулах ажлыг зохицуулах арга ажиллагаа төлөвшиж чадаагүй байна.

**Хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудал.** Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх багийн эмнэлэг 64, сумын эмнэлэг 19, нийгмийн эрүүл мэндийн төв 1, эмийн сан 22, хувийн хэвшлийн эрүүл мэндийн 8 байгууллагад 905 их эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна. 1997 оны байдлаар 10000 хүн амд 13,3 их эмч, 45,7 дунд мэргэжилтэн, 71,6 ор ногдлоо.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар нэлээд арга хэмжээ авсан бөгөөд НҮБ болон олон улсын төрөлжсөн байгууллагын туслалцаа, дэмжлэг чухал ач холбогдолтой байв. Сүүлийн жилүүдэд байгаль, цаг уурын өөрчлөлт, ус, агаар, орчны бохирдол, хүнсний хангамж зэргээс шалтгаалсан амьсгалын зам, зүрх, судасны систем, халдварт өвчлөл ихсэх хандлагатай байна. Зах зээлийн харилцаанд шилжиж буй эхний жилүүдэд ядуурал бодитой зүйл болж, нийгмийн эмзэг бүлгийн хүн төдийгүй, төр, засаг онцгой анхаарах шаардлагатай байна.



Эх, нялхсын эндэгдэл тууштай буурахгүй байна. Хүний эрүүл мэндийг төрөөс дагнан хариуцаж байсан нь иргэн хүн эрүүл мэндийнхээ талар төдийлөн анхаарал тавьдаггүй сэтгэлгээг бий болгожээ. Хувийн хэвшлийн эмнэлгийг дэмжих, төрийн өмчийн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгох, ирэгдийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог төлөвшүүлж сайжруулах талаар эхний алхмууд хийнээ. Иргэдийг эрүүл мэндээ хамгаалах аргад сургах, анагаах ухааны уламжлалт аргыг эзэмших, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл орчин бий болгоход гол анхаарлыг хандуулах шаардлагтай байна.

**Хүн амын нутагшил, суурьшил, хот төлөвлөлт.** Ой, тал хээр, говь хосолсон нутаг дэвсгэрт хүн амын нутагшил, суурьшил харилцан адилгүй байдагш. Аймгийн хүн амын 41 хувь нь сум, аймгийн төвд, 59 хувь нь хөдөөд амьдарч байна. Үйлдвэрлэл, үйлчилгээ илүүтэй хөгжсөн төв, суурин газарт хүн амын суурьшил нягтарч байхад говийн суманд харьцангуй бага байна. Байгаль газарзүйн онцлогоос гол төлөв үүдэж, хангайн болон хээрийн суманд илүү төвлөрөлттэй, говийн суманд харьцангуй сийрэг нутагшилтай байдаг. 1997 оны байдлаар хангайн бүсийн суманд хүн амын 20,8 хувь нь амьдарч байхад говийн бүсийн 9 суманд 33,6 хувь амьдарч байна.

Аймгийн төв, суурин газрыг эрчим хүчний нэгдсэн системд холбоогүй. Улаанбаатар хотоос алслагдсан хатуу хучилттай замын асуудал шийдэгдээгүйгээс дэд бүтэц хөгжжөөгүй, түүнээ дагаж жижиг дунд үйлдвэр хөгжих нөхцөл бүрдээгүй байна. Хот байгуулалтын мэргэжлийн хүн дутагдаж байгаа нь орон нутгийн хотыг ирээдүйтэй хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Тус аймгийн хүн амын ихэнх нь гэрт амьдардаг бөгөөд 1997 онд 25918 өрхийн 102080 хүн гэрт, 2495 өрхийн 9481 хүн орон сууцанд амьдарч байна.

**Тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн бодлого, үндэслэл.** Аймгийн эдийн засагт мал аж ахуйн салбар голлож байна. Аж үйлдвэр, эрчим хүч, зам харилцааны хөгжил бүсийн аймгуудаас хоцрогдсон, нийслэл Улаанбаатар хотоос 620 км алслагдсан байна. Бэлчээрийн мал аж ахуй нь эдийн засгийн хувьд





үр ашиг багатай, маллах ашиг шимийг нь авахад зардал бага боловч ямаанаас бусад нь айл өрхийн болон сумынхаа орлогод маш бага нэмэр болж байна.

Тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж чадвал хүнсний ногооны зохих хэсгийг хангах боломжтой юм. Аж үйлдвэрийн салбарт нүүрс, алт, хүнс, эрчим хүч, барилгын үйлдвэр голлон ажиллаж байсан боловч зах зээл байхгүйгээс зогсонги байдалд оржээ. Дээрхи үйлдвэрийн ихэнх нь эдийн засгийн хувьд өндөр үр ашигтай биш, зардал ихтэй, техник технологинй хувьд хоцрогдсон юм. Орон нутгийн төсвийн орлого 1997 оны байдлаар 765,8 сая төгрөгт хүрч, зарлагын зөрүүг татаасаар нөхөж байна. Төсөвт их хэмжээний орлого оруулдаг алт болон эрдсийн бусад баялгийг ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газраа түшиглэн аялал, жуулчлалыг эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. аймгийн эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхийн тулд банк, санхүү, даатгал, татварын тогтолцоог зөв төлөвшүүлж чадваржуулах явдал чухал юм. Эдийн загийн талаар бие дааж хөгжих бодлогыг хэрэгжүүлэхдээ төвлөрлийг аль болохоор сааруулж, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр эдийн засгийн хувьд харьцангуй бие дааж ажиллах шаардлагатай байна. Зээл, санхүү, даатгал татварын бодлогыг ч үүнд чиглүүлэх хэрэгтэй.

**Аж үйлдвэр, тээвэр, холбооны салбарын тогтвортой хөгжил.** Аж үйлдвэр, тээвэр, холбооны салбарын эдийн засагт гүйцтгэх үүрэг нь жилээс жилд нэмэгдэж байна. Аймгийн хэмжээгээр аж үйлдвэр жилд дунджаар 1948,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж байгаагийн 51 хувь нь уул уурхайн салбарт, 15,1 хувь нь хүнсний салбарт, 231 хувь нь эрчим хүчний салбарт, 10,0 хувь нь өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбарт тус тус ногдож байна. 1990 оноос эхлэн алт олборлож эхэлсэнтэй холбогдож аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний бүтцэд өөрчлөлт гарч, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн голлох боллоо.



Засгийн газрын “Алт” хөтөлбөрийн хүрээндхүрээнд эрэл хайгуул явуулах, олборлох ажлыг эрчимтэй хийж байна. Жилд дунджаар 130-170 кг алт, 180 тонн талх, нарийн боов, 112 мянган литр архи, ундаа үйлдвэрлэж байгаа нь үйлдвэрлэлийн техник, технолог,и хоцрогдсон, санхүүгийн чадвар доройтсон, боловсон хүчний зах зэлийн мэдлэг, мэдээлэл дутагдсан зэрэг бэрхшээлээс шалтгаалж үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт 50 хувиас хэтрэхгүй байна.

Тээвэр холбооны салбарын эдийн засгийн үр ашиг муу байгаа нь техник технологийн хоцрогдолтой холбоотой ажээ. Аж үйлдвэр, тээврийн салбар хүчтэй хөгжөөгүй учраас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл одоогоор бага байна. Алт олборлолтыг эрчимтэй хөгжүүлэх хэрэгцээ, авто замын сүлжээ бий болоогүй зэрэг нь байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх хөрсний эвдрэлийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна. Аж үйлдвэр, тээвэр, холбооны салбарыг эрчимтэй хөгжүүлэх нь эдийн засгийн хувьд бие даах зорилтыг шийдвэрлэх малчдад хүрэх үйлчилгээг сайжруулах, тэднийг мэдээллээр хангахад ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

**Аж үйлдвэрийн салбарын бүтцийн шинэчлэл.** Аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтэц өөрчлөгдөж чадаагүй, орон нутгийн материал, түүхий эдийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэлийн хөгжил сул, ажиллаж байгаа үйлдвэрийн техник технологи хоцрогдсон учраас чанар муутай, үнэ өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Мэргэжлийн өндөр чадвартай ажилчид бараг байхгүй байна. Малын тоо, толгойгоор улсдаа дээгүүр байгаа боловч түүний түүхий эдийг боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлээгүй ажээ.

Аж үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэхийн тулд аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл хайгуулыг иж бүрэн хийж, эдийн засгийн хувьд ашигтай, байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байна. Аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт хийдээ уул уурхайн үйлдвэрийг цөөн тоогоор байгуулж, тэргүүлэх чиглэл болгох, иргэдийн хэрэгцээг хангах, ажлын байр бий болгоход чиглэсэн хөнгөн, хүнсний жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг баримталж байна. Энэ салбарт дотоод гадаадын хөрөнгө оруулалт хийх, техник, технологийг



шинэчлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх замаар тулгарсан бэрхшээлээс гарах ажээ.

***Тээвэр, холбооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих үндэслэл.***

Ачааны автомашины 80 хувь, суудлын автомашины 89 хувь, зорчигч тээврийн авто машины 70 хувь, тусгай зориулалтын авто машины 15 хувь нь хувийн хэвшилд хамрагдаж, төрийн болон хувийн өмчийн тээвэр зах зээлд өрсөлдөх боломж бүрднэ. Тээврийн салбарт 14,6 мянган тонн ачаа тээвэрлэж, 11,3 сая хүн/км-ийн ажил хийж, үйлчилгээ үзүүлж байна. Баянхонгор хотоос сум хүртэл зорчигчдыг шуудан болон таксийн тээврээр үйлчлэх, ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүд үүсч байна.

Агаарын тээврийн нислэлийг Баянхонгор-Улаанбаатарын хооронд 7 хоногт 2-3 удаа үйлдэж байна. БНХАУ-ын зарим аймаг, хоттой авто тээврийн харилцаа өргөжиж, Замын-Үүд, Гашуун сухайт, Шивээхүрэнгийн боомтоор жилд 168 тн ачаа экспортлож, 500 тн ачаа импортлож байна. Аймгийн хэмжээнд одоогийн ашиглаж буй авто тээврийн хэрэгслэл нь шатахууны зарцуулалт өндөр, эдэлгээний хугацаа, засвар, үйлчилгээний хоорондын гүйлт бага, техникийн болон найдварт ажиллагааны үзүүлэлт доогуур түвшинд байна. Зардал хямд, байгль орчинд сөрөг нөлөө багатай тээврийн хэрэгслийг ашиглах, зам харилцааны сүлжээг өргөжүүлэн, хүн амын тээврийн хэрэгцээг найдвартай хангах, зам харилцааг үр ашигтай ашиглах шаардлага өсөж байна.

Эдүгээ Баянхонгор аймаг нь Улаанбаатар хот, бусад аймаг, гадаад орнуудтай радио телефоны 60 сувгаар сумдтайгаа агаарын шугамаар харилцаж, аймгийн төвд 1050 хэрэглэгчийг үйлчлэх станц 9 суманд координат системийн станц ажиллаж иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид холбооны үйлчилгээ үзүүлж, аймаг сумдын төвд үндэсний телевизийн нэвтрүүлгийг АЗИАСАТ системээр, ОХУ-ын телевизийн нэвтрүүлгийг 1 квт-ын экран станцаар дамжуулж байна.

Аймгийн төвд 1,25 квт-ын өсгөгчөөр, Жаргалант суманд 0,25 квт-ын өсгөгчөөр шугамын радио нэвтрүүлэг дамжуулж байна. Тус аймагт ашиглаж буй холбооны эдгээр тоног төхөөрөмжийн ихэнх нь хоцрогдсон, ашиглалтын зардал



өндөртэй, цахилгаан энерги их хэрэглэдэг учир ашиглах боломж муутай юм. Тухайлбал өнгөрсөн жилд холбоо ашиглалтын орлого 32,5 сая төгрөг болж үүнээс хүн амаасорох орлого 42,5 хувийг эзэлж байгаа боловч жилд гарч байгаа зардлаа нөхөхийн тулд 100-гаад сая төгрөгийн татаас төв компианаас авчээ. Цаашид олон улсын жишигт хүрсэн, ашиглалтын зардал багатай төхөөрөмжөөр тоноглох шаардлагатай байна.

Аймгийн дэд бүтцийн авто замын сүлжээ хоцорч байна. Замын байгууллага жилд 60 км цардмал зам тавих, 200 гаруй км замыг засаж, арчлах хүчин чадалтай боловч жил бүрийн хөрөнгийн чадвараас шалтгаалж, хүчин чадлаа 30-40 хувиар ашигладаг. Авто замын сүлжээг хөгжүүлэх нь байгаль орчныг хамгаалах, хугацаа хэмнэх, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, зардал хэмнэх, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг бүх талын ач холбогдолтой учир авто замыг эрчимтэй хөгжүүлэх шаардлага улам бүр өссөөр байна.

**Эрчим хүчний тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээ.** Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарыг эдийн засгийн шинэ харилцааны нөхцөлд шилжүүлэх, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар нэлээд ажил хийжээ. Цахилгаан эрчим хүчний хэрэглээг аймгийн төвд ЗХУ болон Чехословак улсад үйлдвэрлэсэн, усан хөргөлттэй дизель станцаар, хөдөө сумдыг С-100, ДГА-60 маркийн дизелийн станцаар хангаж байна. Эдгээр станц нь айл өрх, албан байгууллагын хэрэгцээт эрчим хүчний дөнгөж 20-70 хувийг үйлдвэрлэж байна.

Төв, суурин газар болон хөдөөд амьдарч буй айл өрх нүүрс, мод, аргал, хөрзөнг түүлшинд хэрэглэдэг. Цахилгаан, дулааны эрчим хүчний үүсгүүрүүд байгаль орчныг хэр зэрэг бохирдуулж байгаад иж бүрэн судалгаа хийгдээгүй байна. Одоо ажиллаж байгаа дулааны эрчим хүчний системийн тоног төхөөрөмж технологийн хувьд хоцрогдсон, үнс, утаа нь байгаль орчныг бохирдуулж, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр байна. Эрчим хүчний үйлдвэрлэлээс хүрээлэн буй орчинд учруулах нөлөөллийн хэмжээнд хяналт тавих, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт дутагдалтай байна.



***Эрчим хүчний удирдлага, төлөвлөлт, хөгжлийг дэмжих үндэслэл.***

Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд санхүүгийн чадвар муугаас сэлбэг хэрэгслэл, нүүрс, нефтийн бүтээгдэхүүний үнийг төлж чадахгүйд хүрч үйлдвэрлэл зарим газарт ялангуяа дизель станц бүхий сумдад доголдож байсныг шийдвэрлэжээ. Цаашид эрчим хүчний үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлэх, үр ашгийг нь дээшлүүлэх шаардлага гарч байна.

АНУ-ын тусламжаар түлш бага зарцуулдаг катерфиллер маркийн 2 станцыг нэмж суурилуулснаар аймгийн төвийн цахилгаан эрчим хүчний хангалт сайжирчээ. Энэ салбарт өөрчлөлт хийж, эрчим хүчний найдвартай эх үүсвэр бий болгох, хэрэглээний өсөлтийг хангах, байгаль орчинд халгүй эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулж сумын төв, суурин газрын эрчим хүчний хангамжийг сайжруулах нь зүйтэй байна.

***Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, зүй зохистой ашиглах үндэслэл.*** Аймгийн бүх сумын төв бага чадлын дизель цахилгаан станцтай байна. Эдгээр дизель станцын цахилгааны өөрийн өртгийн 80 гауй хувийг түлшний зардал, үлдэх хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, цалин хөлс, сэлбэг хэрэгслэл болон бусад зардал эзэлж байна. Эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх эдийн засгийн хөшүүрэг сул, ялангуяа дулааны эрчим хүчний хувьд үгүйлэгдэж байгаа нь хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд саад болж байна. Хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангахад энэ салбарын санхүүгийн чадавхийг дээшлүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

***Шинэ болон сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах үндэслэл.***

Эрчим хүчний хангамж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн шаардлага сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь зайлшгүй чухал болохыг харууллаа. Хөдөөгийн зарим багийн төв, олон тооны малчид нар, салхины эрчим хүчийг ашиглаж байгаагаас гадна Шаргалжуутын халуун рашааныг дулааны зориулалтаар бага хэмжээгээр ашиглаж байна. Аймгийн нийт нутагт жилийн туршид 4-9 м/сек хурдтай салхитай байдаг ажээ. Ус, салхи, халуун рашааныг ашиглан эрчим хүч үйлвэрлэх судалгааны ажлыг хийж, эрчим хүчний асуудлыг шийдэх нь байгаль орчныг хамгаалахад ач холбогдолтой.





**Агаар мандлыг хамгаалах үндэслэл.** Аймгийн агаарын төлөв байдал, түүний бохирдлын хэмжээ бүрэн судлагдаагүй байна. Агаарын бохирдлын хэмжээ газарзүй, уур амьсгал, салхины горим, хөрс, агаарын бохирдол, хог хаягдлын байдлаас хамаарч газар бүр харилцан адилгүй байна. Төв, суурин газарт технологийн хувьд хоцрогдсон 60 гаруй уурын зуухны нүүрсний дутуу шаталтаас үүсч буй утаа, хог, хаягдал агаарыг үлэмж хэмжээгээр бохирдуулж байна.

Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ зохиох, горимын судалгааны ажил шаардлагын хэмжээнд явагдаж байгаа боловч мэдэлэл хүлээн авах, хэмжих, дамжуулах, техник төхөөрөмж хуучирч, хүчин чадал нь өнөөгийн шаардлагаас хоцорлоо Тус аймагт хүнд үйлдвэр хөгжөөгүй учир агаар мандалд үзүүлэх физик нөлөөлөл бага юм. Агаар дахь хүлэмжийн хийг багасгах арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Ойн нөөцийг ашиглах, хамгаалах үндэслэл.** 1980 оноос хойш ой зохион байгуулалтын ажил хийгдээгүй учир, ойг шинжлэх ухааны үндэслэлтэй нөхөн сэргээх, хамгаалах, ашиглах бодлого алдагдаж, хэрэгцээний хэрээр ашиглах хандлага ихсэж, нөөц хомсдоход хүрч байгаагаас гадна эдийн засгийн бэрхшээлээс шалтгаалан ойжуулалтын ажил ашиглалтаасаа ихээхэн хоцорлоо. Ойг хамгаалах хяналтын системийн бүтцийн өөрчлөлт, үйл ажиллагаанаас шалтгаалан ойн зөрчил ихсэх хандлагатай байгаа нь ойн нөөцийг хамгаалах, ашиглах бодлогыг тодорхой хөтөлбөртэйгээр хэрэгжүүлэхийн чухлыг харуулж байна.

**Цөлжилтөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх үндэслэл.** Монгол Улсын нутгийн нэгэн адил тус аймгийн нутгийн дийлэнх хэсэг цөлжилтөд өртөгдөхөд амархан эмзэг ажээ. Аймгийн ихэнх нутаг нь далайн төвшнөөс дээш 1200-1500 м-ээс дээш өргөгдсөн, салхи ихтэй байдгаас цөлжих, ургамлын нөмрөг сийрэгжих нь амархан байдаг байна. Бэлчээрийг зүй бусаар ашиглах, талхлах, байгаль цаг уурын үзэгдлийн нөлөөн дор бүс нутаг удаан хугацаагаар хуурайшилтай байх, элсний нүүлт хурдсах, тал хээр, говийн бут сөөгийг сүйтгэх, заган ойг устгах,



байгалийн хөрс дээгүүр олон салаа авто зам гаргах, төв суурин газрын ургамлын нөмрөгийг сүйтгэх зэрэг нь цөлжилт газар сайгүй нүүрлэх үндэс болж байна.

Монгол орны байгаль орчин үндсэндээ унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн гэж олон хүн үздэг ч үнэн хэргэтээ байдал их өөр юм. 20, 30 ч юм уу 50, 60 жилийн өмнөх унаган төрх нь ямар байсныг зөвхөн шинжлэх ухаан л тогтоодог. Шинжлэх ухааны нарийн судалгаа, шинжилгээ хийгээгүй, дүгнэлт нь гараагүй байхад унаган төрх нь үндсэндээ хадгалагдсан хэмээх дүгнэлт өгч болохгүй байна. Үүнийг Баянхонгорын жишээ ч нотолно. Олон жилийн ажиглалт эсвэл биологийн төрөл зүйлийн сүйрлийн ул мөрөөр унаган төрхийн байдалд дүгнэлт өгөх явдал бий. Үүнийг говийн заган ой дээр авч үзэж болно.

Аймгийн заган ой сүйрэл, устлын байдалд ороод байна. Заг нь говийг чимж өнгө төрхийг бүрдүүлэхээс гадна, газрын гүний усны түвшинг хадгалж, агаарыг зөөлрүүлдэг төдийгүй, элсэрхэг хөрсийг элэгдлээс хамгаалах, элсний нүүлтийг тогтоон барьж, усны горимыг зохицуулдаг гол ургамал гэж үздэг байна байна. Манай улсын хэмжээнд загийг үрээр тариалах агротехникийн арга ажиллагааг судалж, эрдэмтдийн бүтээл ч гарчээ. Ганцхүү загийг тариалах, заган ой сэргээх үйл ажиллагаа дутагдаж байна. Говийг цөлжилтөөс хамгаалах зорилгоор тариалж болох сухай, балгана, жигд, чихэр өвс, лидэр, харлаг, өмхий өвс зэрэг хэд хэдэн зүйлийн ургамлын биологи, тариалах аргачлал судлагджээ.

Эдгээр ургамлын судалгааны үр дүн, эрдэм шинжилгээний ажлын бүтээл байгаагүй байдаг. Харин байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа ажил үгүйлэгдэж байна. Говийн ойг сэргээх, ургамлын бүрхэвчийг сайжруулах нь говийг цөлжилтөөс хамгаалах үйлдвэрлэлийн ажлын үндэс болох байна. Иймээс говь нутгийг цөлжилтөөс хамгаалах талаар эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хүч тусалцаанд түшиглэн тодорхой ажил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэслэл.** Аймгийн газар нутгийн гадаргын байдал уур амьсгалын нөхцөлтэй уялдан хөрсний үржил шимт давхарга



хойноосоо урагшлах тутам нимгэрэх тул хойд хэсгээрээ уулын ба нугын хар хүрэн, хар шороон, элсэрхэг, говьдоо цайвар хүрэн, цөлөрхөг хүрэн хөрстэй байна.

Хөрсний энэ бүтцээс хамааран уулархаг нутгаар үет ба буурцагт, хээрийн бүсэд олон зүйлийн ургамал, говьдоо бутлаг ба сонгинолог ургамал голдуу ургана. Мөн чацаргана, аньс, юмдүүжин, гоёо, чихэр өвс, далуурын тарваган шийр, эмийн бамбай, өргөст нохойн хошуу, говийн ганга, лидэр зэрэг эмийн ургамал ургадаг төдийгүй Монголын улаан номонд орсон эмийн багваахай, үнэгэн сүүлтэй, лидэр, ягаан цээнэ, эгэл шагшурга зэрэг ургамал байдаг байна.

Байгалийн ерөнхий зүй тогтолтой уялдан тайга, ойт хээр, хээр, говь цөлийн нутгаар тархсан 72 зүйлийн хөхтөн амьтан, 110 зүйлийн шувуу, 21 зүйлийн загас, 5 зүйлийн мөлхөгч, 2 зүйлийн 2 нутагтан амьтан байдаг. Янгир тэх, аргаль угалз, буга согоо, хүдэр, бор гөрөөс, гахай, шилүүс, зэрэг ан амьтан элбэг бөгөөд ирвэс, хулан, хар сүүлт нь Улаан номонд орсон байна. Шонхор, хойлог, ятуу, сойр, бүргэд зэрэг ховор шувууд, ан агнуурын болон үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий тарвага, үнэг, хярс, цагаан зээрийн нөөцтэй байна.

1986 оноос хойш агнуур зохион байгуулалт, тооллого хийгдээгүй учир нөөц нь нарийвчлан тогтоогдоогүй байна. Ургамал амьтны аймгийн хувьд нэлээд баялагтай тус аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах нь Монгол улсын төв бүс нутгийн экологийн тогтолцооны тэнцлийг хадгалахад чухал ач холбогдолтой ажээ. Биологийн төрөл зүйлийг цогцоор нь судалсан материал хомс, ан амьтан, ургамлын ашиглалт нь түүнийг нөхөн сэргээх, хамгаалах жил нэн хоцрогдож байна. Биологийн төрөл зүйлийн бүх нөөц, баялгийг судлаж хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх талаар мэргэжлийн байгууллагын судалгаа, шинжилгээ, дүгнэлт нэн чухал шаардлагатай байна.

**Усны нөөцийг асуудал.** Аймгийн газар нутгийн гадаргуугийн усны жилийн дундаж нөөц 2188,8 сая м<sup>3</sup> бөгөөд том жижиг 26 гол, 460 орчим ширэгдэггүй булаг, шанд, 10-аад том жижиг нууртай юм. 1990, оноос өмнө хүн, малыг усаар хангах зориулалтаар 288 өрөмдмөл, 614 богино яндант, 622 бетон хашлагат, 337 усан сан, 1560 гаруй энгийн уурхайн худаг ашиглаж, нийт бэлчээрийн 72,9 хувь буюу



6548,3 мянган га-г усжуулж, төв суурингийн усан хангамжийн 80 орчим хувийг шийдвэрлэсэн байлаа.

Өмч хувьчлалын явцад инженерийн хийцтэй олон уст цэгийг тонож, хайхрах эзэнгүйгээс ашиглахгүй болсон байна. 1996 оны байдлаар инженерийн хийцтэй уст цэг 1851 байхаас 873 байгаагийн 326 нь эвдрэлтэй болжээ. Сүүлийн 5 жилд орсон тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 33,7 мм багассан нь гадаргын усны түвшин доошлох, хомсдоход нөлөөлжээ. Говийн бүсийн малчдын хэрэглэж байгаа ундны усны 60-70 хувь нь эрдэсжилт ихтэй, стандартад тохирдоггүй усан дахь ерөнхий хатуулгийн хэмжээ 40-41 мг/литр байна. Хатуулаг ихтэй ус говийн иргэдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж байгаагаас элэг цөс, ходоод дотрын өвчин элбэг тохиолдож байна.

**Тогтвортой хөгжлийн хэтийн зорилт.** Аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зорилт нь нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчинд зохицуулан экологийн тэтгэх даацын хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, тогтвортой хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход оршино. Энэхүү үзэл баримтлал нь ойрын ирээдүй буюу 2020 он хүртлэх хугацааны тогтвортой хөгжлийн бодлогыг томъёолсон баримт бичиг мөн.

Тогтвортой хөгжлийн гол зорилго нь хүнээ дээдэлж, хүн төвтэй хөгжлийг удирдлага болгон, ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хувьд биеэ дааж, иргэдийнхээ амьдралыг тэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхдээ байгаль орчноо унаган төрхөөр нь хадгалах, хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хөндөгдсөн байгалийг сэргээх, иргэн хүн ая тухтай амьдрах экологийн орчныг бүрдүүлэхэд оршино гэж үзэжээ.

**Нийгмийн тогтвортой хөгжлийн талаархи зорилт.** Хүнээ дээдлэн, хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгон иргэдийг элбэг хангалуун, эрүүл энх амьдрах, боловсрол, соёл эзэмших, нөхцлөөр хангахад нутгийн захиргааны бүхий л үйл ажиллагааг чиглүүлэх; Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, үүний тулд хүн амын жилийн дундаж өсөлтийг 1,8 хувиас бууруулахгүй



байх, эх нялхсын эндэгдлийг бууруулах үндэсний зорилтыг хэрэгжүүлэх; Хүн амын оюуны болон бие бялдрын чанарын асуудлыг онцгой анхаарч, оюун ухааны хомсдолтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны ажлыг хүчтэй болгох; Хүн амын тогтвортой өсөлттэй уялдуулан хүнсний хангамжийг сайжруулах, үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа бий болгох; Мах, сүү, гурил, хүнсний ногоогоор иргэдийн хэрэгцээг хангахуйц үйлдвэрлэл явуулах бодлогыг хэрэгжүүлэх; Байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглан, орон нутгийн нөөцийг сайтар судалсны үндсэн дээр түүнд зохицсон бодлого явуулж, ухаалаг тогтвортой хэрэглээний бүтцийг бий болгох; Хүн амын эмзэг хэсгийн хүнс, орон сууц, эрүүл мэнд, боловсролын наад захын хэрэгцээ, шаардлагыг хангах; Хүн амын дотор амьдрал доройтох үйл явцыг нарийн судалж, ядуурлыг бууруулах, хүн ам олноор ядууралд орохоос урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авах.

Хүн амын бэлэнчлэх сэтгэлгээг тууштай өөрчилж, хүн өөрөө өөрийнхөө хувь заяаны эзэн байх үзлийг төлөвшүүлэх; Ажлын байр олноор бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарыг дэмжих бодлого баримтлан, үйлдвэрлэл үйлчилгээг түлхүү хөгжүүлэх; Төмс, хүнсний ногоо тариалах, гахай, шувуу өсгөн үржүүлэх, ахуйн үйлчилгээ эрхлэх зэрэг өртөг зардал багатай ажлын байр бий болгох бодлогыг тууштай хэрэгжүүлж, ядуурлыг аажмаар бууруулах; Ядуурлыг бууруулах ажилд нутгийн иргэдийн санаачилгыг өрнүүлэх, төрийн бус байгууллага, ялангуяа эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоонд тулгуурлах бодлогыг хэрэгжүүлэх.

Ядуурлыг үндсэнд нь арилгасан сум баг, болох хөдөлгөөнийг өрнүшүлэхээс гадна иргэдийн дунд ядуурлаас гарах арга замын сурталчилгааг өргөн зохион байгуулах; Хүн өөрийнхөө эрүүл мэндийг хариуцдаг тогтолцоог төлөвшүүлэх; Дэлхийн уур амьсгалын харьцангуй түргэн өөрчлөлт нь хүн амын дотор амьсгалын замын болон цочмог халдварт өвчин ихэсгэж байгаад судалгаа, дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх арга ухаанд иргэдээ сургах; Жирэмсэн эхчүүд, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг бууруулах үндэсний зорилтыг хэрэгжүүлэх; Эмийн бус эмчилгээг өргөжүүлэх.





Хүн амыг ундны цэвэр усаар хангах, экологийн эрүүл орчин бүрдүүлэх, баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах бодлогыг хэрэгжүүлэн, эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлэх; Нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээний бүсийн төв байгуулж, эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх; Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах; Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын зохистой тогтолцоог төлөвшүүлж, худалдаа, ахуйн үйлчилгээг малчдад ойртуулах, хүн амын ундны усны хангамж, чанарыг сайжруулах замаар хүн амын нутагшил, суурьшлыг зохистой болгох; Аймаг, сумын төвийн хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх; Сум багийн төвийн иргэдийг найдвартай, хямд төсөр цахилгаан, дулааны эх үүсвэрээр хангаж, жижиг үйлдвэрлэл хөгжүүлэх замаар айл өрхийн орлогыг нэмэгдүүлэн хүн амын ядуурлыг бууруулах; Хөдөөд тогтвортой ажлын байр бий болгох замаар хүн ам төв рүү тэмүүлэх шилжих хөдөлгөөнийг саармагжуулах.

**Тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн зорилт.** Эдийн засгийн тогтвортой хөгжлийн гол зорилт нь эдийн засгийн өсөлтийг тогтворжуулан, иргэдийн нийгмийн хамгааллыг баталгаажуулахад чиглэнэ. Энэ зорилтыг ханган биелүүлэхийн тулд хөдөө аж ахуй зонхилсон эдийн засгийн бүтцийг өөрчилж, байгальд зохицсон, сөрөг нөлөө багатай үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ гэжээ.

Эдийн засгийн зорилт нь: Алт олборлох, аялал, жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх; Байгаль орчны өртгийг үйлдвэрлэгч, хэрэглэгч хариуцдаг тогтолцоог аж үйлдвэр, дэд бүтэц, үйлчилгээний салбарт нэвтрүүлж, хяналтыг хүчтэй болгох; Аймгийн эдийн засгийн хөгжлийн зүтгүүр аж ахуйн нэгжүүд, ажлын байр бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү хөгжүүлж, түүнд зээл дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлэх.

Бүс болон орон нутгийн хөгжлийг дэмжих банкны тогтолцоог бий болгох; Орон нутгийн татвар, хураамж, төсөв зэрэг зах зээлийн эдийн засгийн хөшүүргийг иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хувьд биеэ дааж, байгаль орчноо хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд бүрэн ашиглах; Бэлчээрийн даац хүрэлцээгүй байдлыг үндэс болгон байгалийн бэлчээрийг талхлагдахаас



хамгаалж, малын тоог одоогийн хэмжээнд тогтвортой байлгах, өндөр ашиг шимтэй мал сүргийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

Мал аж ахуй гаралтай түүхий эд боловсруулах жижиг джнд үйлдвэрийг мал сүргийн удамшин дассан нутагт нь байршуулан хөгжүүлэх бодлого баримтлах; Тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхдээ хөрсний үржил шим, нэгж га-гаас авах ургацыг нэмэгдүүлэх замаар жилд 10 мянгаас доошгүй тонн үр тариа хураан авах зорилтыг хэрэгжүүлж, иргэдийн гурилын хангамжийг нэмэгдүүлэх; Хүнсний ногооны үйлдвэрлэлийг хүн амын хэрэгцээг хангах хэмжээнд хүргэхийн тулд газрыг үр ашигтай эзэмших аргад иргэдийг сургах; Тариалангийн талбайг нэмэгдүүлэхгүй байх бодлого баримтлах; Жимс жимсгэний үйлдвэрлэл хөгжүүлэх; Хүнсний үйлдвэрлэлийн технологийг шинэчилж, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; Холбоо, тээвэр, замын салбарт тэргүүний технологи нэвтрүүлж, байгаль орчинд халгүй байх шаардлагыг өндөржүүлэх; Аймаг сумын төвийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, агаарын бохирдлыг багасгах; Дулааны системийг хурдан халдаг, бхирдол багатай технологиор шинэчлэх; Малчдыг эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр, мэдээллээр хангах ажлыг өргөжүүлэх.

**Байгаль орчныг хамгаалах зорилт.** Байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах талаар баримтлах зорилтыг хүний ажиллах, амьдрах, амрах экологийн таатай орчин бүрдүүлэх, экологийн тэнцвэрийг тогтвортой байлгах, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхдээ байгаль орчноо аль болохоор унаган төрхөөр нь хадгалах, сэргээх, байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэстэй ашиглахад чиглүүлэх; Үүнд:

Агаар мандалд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэх, бохирдуулах эх үүсвэрийг тоог цөөлөх, дэвшилт технологи нэвтрүүлэх, сөрөг нөлөөллийг багасгах эдийн засаг, эрх зүйн хөшүүргийг бий болгох; Газрын нөөц, чанарын үнэлгээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр зохистой ашиглах, тордож арчлах, хөрсний үржил шимийг сайжруулах зэргээр экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд газар ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх; Ойн нөөцийг



хамгаалах, төв, суурин, гол горхи, булаг шандын эхийг ойжуулах, ойг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх модыг түлшинд хэрэглэхийг багасгах, таримал ойг бий болгох урамшууллын арга хэмжээ авах; Цөлжилт үүсч байгаа газар нутгийн элсний нүүдлийг судлах, хянах мэдээллийн тогтолцоо бий болгож, цөлжихөөс хамгаалах; Заган ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зохион байгуулалтыг сайжруулах.

Уулархаг нутгийн мэдээллийн сан байгуулж, хөрс, ургамал, ой, ан амьтан, усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын байдалд үнэлгээ өгч, тодорхой бодлого хэрэгжүүлэх; Биологийн төрөл зүйлийн талаар мэдээллийн сан байгуулах үндсэн дээр өсгөн үржүүлэх, зохистой ашиглах орон нутгийн бодлогыг тодорхойлох; Байгаль, цаг уур, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс биологийн төрөл зүйлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдийг мэдлэг мэдээллээр хангах сургалт, сурталчилгааг зохион байгуулах; Төв суурин, ялангуяа гошвийн сумдын хүн ам, малын усан хангамжийг сайжруулах, усны хатуулгыг бууруулан чанарыг дээшлүүлэх, цас бороо, үерийн усыг хуримтлуулан нөөцлөх, ус хэмнэлттэй зарцуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгох; Гүний усыг ашиглах орчин үеийн технологийг нэвтрүүлэхэд ус ашиглалтын бодлогыг чиглүүлэх; Хот суурингийн хатуу хог, хаягдлыг зайлуулах, ялгах, дахин боловсруулах ажлыг боловсронгуй болгож, орчны эрүүл ахуйг сайжруулах.

Аймаг сумын төвийн бохир усны системийн ашиглалтыг сайжруулж, бохир усыг цэвэршүүлэх технологи нэвтрүүлэх; химийн хортой болон цацраг идэвхит бодисын ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг хүчтэй болгох; Байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдож болох аюулыг бууруулах, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, ард иргэдийн сонор сэрмжийг дээшлүүлэх, хүний үйл ажиллагаанаас үүсч болох гамшгийг аль болохоор багасгах; Нутгийн захиргаа, аж ахуйн удирдлагын чадавхийг улам дээшлүүлэх.

Орон нутгийн удирдлагын чадавхийг бүрдүүлэх талаар урт хугацааны бодлогыг үндэсний хөтөлбөртэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх; Засаг захиргааны байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхой болгох, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлах, ялангуяа хүлээх хариуцлагыг тодорхой заах, нийт албан хаагчдыг давтан бэлтгэх; Сум багийн захиргааг бэхжүүлэх, эрх, мэдэл,



үүрэг хариуцлагыг тодорхой болгож, аж ахуйн удирдлагын менежментийг сайжруулах, бэлтгэх, давтан бэлтгэх сургалт зохион байгуулах; Олон улсын байгууллагын техникийн хамтын ажиллагаанд оролцох, тэдгээрийн төсөл, зээл, тусламжийг үр дүнтэй ашиглах чадавхи бий болгох.